


# ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ТОВЧООН

Монгол Улсын Прокурорын байгууллагын
90 жилийн ойд зориулав

Улаанбаатар
2020 он

# ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ТОВЧООН

---


**Зохиогч:** Ширчингийн СҮХБААТАР
Хууль зүйн ухааны доктор

**Хянасан**: Максимын ЧИНБАТ
Мөнхөөгийн ГАНТУЛГА
Дашнямын ДАШМАА

**Зөвлөх:** Бат-Очирын ЦЭРЭНБАЛТАВ
Донровын ЦОГТБААТАР
Нанзадын СОСОРБАРАМ
Ерөөлтийн САГСАЙ
Рэнчингийн МӨНХТАРИА

**Редактор**: Цогсүрэнгийн ГАНБОЛД

**Эмхэтгэсэн**: Оюунцэцэгийн НАРАНХҮҮ
Намдагийн ЦЭНДСҮРЭН
Ганхуягийн ЖАРГАЛ
Оюунцэцэгийн ЦЭЦЭГСҮРЭН

**Дизайн**: О.Наранхүү

**Эх бэлтгэл**: Б.Данзансүрэн

**Зураг, чимэглэл**: British Library
Endangered Archives Programme
Үндэсний Төв архив
Эрүүгийн хэргийн Төв архив
Тагнуулын Ерөнхий газрын тусгай архив
Батлан хамгаалахын Төв архив
Prokuror.mn

Цаасны хэмжээ: 205x270 1/8
Хэвлэлийн хуудас: 48

“АДМОН ПРИНТ” ХХК-д хэвлэв. 2020 он

# МЭНДЧИЛГЭЭ



Та бүхэнд Прокурорын байгууллагын түүхэн товчоог хураангуйлан энэхүү бүтээлээр хүргэж байгаадаа таатай байна.

БНМАУ-ын VI Их хурлаас прокурорын албан тушаалыг бий болгох тухай түүхэн шийдвэр 1930 онд гарч Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 25 дугаар тогтоолоор “Улсын прокуроруудаас гүйцэтгэх эрх, үүргийн дүрэм”-ийг баталснаар Монгол Улсад Прокурорын байгууллага анх байгуулагдсан түүхтэй.

Ард нийтээр болон хэрэг маргааныг шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагууд хууль цаазыг хэрхэн дагаж, мөрдөж буйг төрийн нэрийн өмнөөс хянах чиг үүрэгтэйгээр Прокурорын байгууллагыг байгуулснаас хойш эдүгээ 90 жилийн ойтойгоо золгож байна.

Монгол Улсын түүхэн хөгжлийн үе шатуудад прокурорын байгууллага нь хуулиар хүлээсэн чиг үүргээ нэр төртэй хэрэгжүүлж, улсын тусгаар тогтнол, иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж ирснийг онцлон тэмдэглэж байна. Энэ бол үе үеийн прокурор та бидний хичээл зүтгэлийн үр дүн, хамтын амжилт юм. Цаашид ч энэ үүргээ амжилттай хэрэгжүүлнэ гэдэгт итгэл төгс байна.

Он цагийн хэлхээст түүхийн шаргал хуудсууд нэмэгдэх тусам алив зөв үйл хэргийн ач холбогдол нь тодорч, сургамж болон үлддэг билээ. Эрх зүйн шинэтгэлтэй уялдуулан прокурорын байгууллагын үйл ажиллагаа, хяналтын ажлын арга барилыг боловсронгуй болгоход түүхэн уламжлал, бүтээсэн ололт амжилт, өөрчлөлт шинэчлэлтийг илтгэн харуулсан энэхүү ном бодит хувь нэмрээ оруулна гэдэгт эргэлзэхгүй байна.

Прокурорын байгууллагын чиг үүргийг нэг мөр хэрэгжүүлэхэд хоёргүй сэтгэлээр зүтгэж, эрч хүч, эрдэм мэдлэгээ зориулсан үе үеийн прокурор, прокурорын байгууллагын ажилтан, алба хаагч та бүхэндээ Прокурорын байгууллагын түүхт 90 жилийн ойн баярын мэнд хүргэж, ажлын амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ
БАНЗРАГЧИЙН ЖАРГАЛСАЙХАН

# ӨМНӨТГӨЛ

Өнгөрсөн өвөл Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат “Манайхан 90 жилийн ойгоо угтаад ажил ихтэй байна. Та прокурорынхоо түүхэн замналаар ном бүтээж өгнө үү” гэсэн хүсэлтийг тулгав. Хэдийгээр хийх ажлын цар их, хоног хугацаа давчуу ч ажил, амьдралын маань анхны гараа болсон прокурорын байгууллагаа бодохоор цааргалах эрх байсангүй.

Нэрт сэтгүүлч Ц.Ганболд, сэтгүүлч, түүхч О.Наранхүү, сэтгүүлч Н.Цэндсүрэн, Г.Жаргал, судлаач О.Цэцэгсүрэн нартайгаа баг бүрдүүлж 1930 оноос хойшхи прокурорын байгууллагын үүсэл хөгжил, өнөөгийн өндөрлөгт хүрсэн түүхэн замналын мөрөөр Үндэсний төв архив, Эрүүгийн хэргийн төв архив, Батлан хамгаалахын Төв архив, байгууллагын архивын түүхэн баримтууд, үе үеийн прокурор, ажилтан, ажиллагсдын дурсамж дурдатгал, эх сурвалж, судалгааны баримтуудыг түшиглэн 90 жилийн түүхэн товчооныг ийнхүү бүтээлээ.

Прокурорын байгууллагын 90 жилийн хугацаанд 23 эрхэм хүмүүс Улсын Ерөнхий прокуророор томилогдож, төрийн өндөр хариуцлагатай албыг гүйцэтгэж ирсэн түүхийг энэхүү номоос унших болно. 1930-1940 оны хүнд хэцүү жилүүдэд БНМАУ-ын прокуророор ажилласан олон сайхан хүмүүс хууль ёсыг сахиулах байр суурин дээрээ бат зогсож байсны улмаас улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэн, амь насаараа хохирсон гашуун түүх прокурорын байгууллагыг тойрч гараагүй байна.

Прокуроруудын бүтээсэн түүхийг арав, арван жилээр багцалж, есөн бүлэгт хуваасан он цагийн товчооныг түүхэн баримтуудад тулгуурлан, баримтын эмхэтгэл бичих хандлага, арга хэлбэрт суурилан бүтээснийг дурдах хэрэгтэй.

Прокурорын байгууллага бахархан дурсагдах олон алдартнуудыг төрүүлсэн бөгөөд манай хамт олны дотроос Монгол Улсын гавьяат цолтон 26, Монгол Улсын Их Хурлын дарга 2, дэд дарга 1, Их хурлын гишүүн 7, Монгол Улсын Шадар сайд, сайд, орлогч сайд, дэд сайд 12, Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн дарга 2, Цэцийн гишүүн 4, Улсын Дээд Шүүхийн дарга 3, Улсын Дээд Шүүхийн гишүүн, шүүгч 15, Төрийн нарийн бичгийн дарга 1, генерал цолтон 6 төрснөөс гадна академич 1, хууль зүйн шинжлэх ухааны доктор 6, хууль зүйн ухааны

дэд эрдэмтэн, доктор 29 хүн байгаа нь энэ байгууллага ямар их чадварлаг хүмүүсийг төрд бэлтгэн гаргасан төдийгүй эрдэм судлалын их аяных нь гараа болж байсныг илтгэнэ.

Энэхүү бүтээлд номын зай талбайнаас шалтгаалж Монгол Улсын прокурорын үе үеийн түүхийг бүтээж ирсэн, бүтээсээр байгаа прокурорын удирдлагууд, энэ салбараас төрсөн алдар гавьяатнуудын түүх намтар, тухайн он цагт хамаарах хийж бүтээсэн ажил үйлс, гаргаж хэрэгжүүлсэн гол шийдвэрүүдийг голлон товч төдий оруулсан болно. Ингэхдээ орхиж ташаарсан зүйл байх аваас хүлцэл өчье.

Номыг бичихэд гүн туслалцаа үзүүлсэн Үндэсний төв архивын захирал Т.Сайнжаргал, Уншлагын танхимын ажилтан Ш.Нямрагчаа, ахмад прокурор Б.Цэрэнбалтав, Н.Сосорбарам, Е.Сагсай, Р.Мөнхтариа, Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, УЕПГ-ын ахлах прокурор М.Гантулга, Д.Дашмаа, хяналтын прокурор Ж.Ичинхорлоо, Эрүүгийн хэргийн төв архивын эрхлэгч Ж.Чимгээ, сан хөмрөгч Э.Майцэцэг, судлаач-архивч Д.Мөнххишиг, цахим хариуцсан гэрээт архивч Б.Ренчинханд, Батлан хамгаалахын Төв архив, Тагнуулын Төв газрын Тусгай архивын ажилтнууд болон бусад бүх хүмүүст талархсанаа илэрхийлье.

Номын цагаан буян хуртугай.

ХУУЛЬ ЦААЗЫН ИТГЭМЖИТ ЗӨВЛӨХ АСАН
ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР ШИРЧИНГИЙН СҮХБААТАР

2020 оны 7 дугаар сарын 25-ны өдөр

# ПРОКУРОРООС ТӨРСӨН АЛДАРТНУУД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

**Данзангийн Лүндээжанцан**
**Цэндийн Нямдорж**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

**Логийн Цог**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

**Данзангийн Лүндээжанцан**
**Жанлавын Бямбажав**
**Цэндийн Нямдорж**
**Содовсүрэнгийн Нарангэрэл**
**Банзрагчийн Дэлгэрмаа**
**Логийн Цог**
**Цэрэндашийн Оюунбаатар**

## ТӨРИЙН САЙД, ОРЛОГЧ САЙД, ДЭД САЙД

**Жарантайн Авхиа**
**Оргийн Жамбалдорж**
**Лувсандоржийн Рэнчин**
**Дамбийн Дорлигжав**
**Намсрайжавын Лувсанжав**
**Логийн Цог**
**Цэндийн Нямдорж**
**Цэрэндашийн Оюунбаатар**
**Цэндийн Лувсаншарав (орлогч сайд)**
**Дамирангийн Хорхой (орлогч сайд)**
**Даржаагийн Зундуй (орлогч сайд)**
**Ширчингийн Сүхбаатар (дэд сайд)**

## ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

**Гунгаагийн Баясгалан**

## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА

**Галдангийн Совд**
**Навааннэрэнлэйн Жанцан**

## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮН

**Жамцын Чойжанцан**
**Жавхлангийн Бямбаа**
**Жанлавын Бямбажав**
**Гунгаагийн Баясгалан**

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ДАРГА

**Равдангийн Гүнсэн**
**Гончигийн Иш**
**Лувсандоржийн Рэнчин**

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ГИШҮҮН, ШҮҮГЧ

**Түвшингийн Даваажав** 1954-1960 он
**Цэндийн Лувсаншарав** 1-р орлогч 1959-1974 он *(1941-1955 онд Бүх цэргийн прокурорт)*
**Галдангийн Совд** 1-р орлогч 1962-1964, 1974-1978 он
**Далхсүрэнгийн Цэрэнбалтав** 1973-1991 он *(1962-1965 онд УПГ-т шүүхийн хяналтын хэлтсийн дарга, 1965-1971 онд Улаанбаатар төмөр замын прокурор)*
**Даржаагийн Зундуй** 1-р орлогч, 1974-1985 он *(Дундговь, Өвөрхангай аймгийн прокурорт хэсгийн прокурор, туслах прокурор, УПГ-т хэлтсийн дарга)*
**Мянганы Дүнчинсүрэн** 1974-1985 он *(Улсын прокурорт хэлтсийн прокурор)*
**Нанзадын Ганбаяр** 1978-1984 он
**Цэрэнбалжирын Бүжинлхам** 1983-1993 он
**Д.Сандуйжав** 1985-1993 он (*Говь-Алтай аймгийн прокурор*)
**Мөнхнасангийн Дамирансүрэн** 1985-1988 он, 1993-2005 он *(1969-1974 онд Ховд аймгийн прокурорын орлогч, 1975-1979 онд УБТЗ-ын прокурорын мөрдөн байцаагч)*
**Сүрэнгийн Цэрэндорж** 1-р орлогч 1990-1993
**Дэмчигжавын Намсрайжав** 1990-1999 он *(1978-1990 онд УПГ-т хэлтсийн прокурор, хэлтсийн дарга)*
**Даваажавын Батсайхан** 1990-2013 он *(Өвөрхангай аймгийн прокурор)*
**Баасангийн Доржготов** 2001-2010 он
**Дамдины Эрдэнэбалсүрэн** 2016 оноос *(Ховд аймгийн болон УЕПГ-т прокурор)*

## ГЕНЕРАЛ ЦОЛТОН

**Ж.Авхиа** 1978 онд Хурандаа генерал
**Д.Ёндондүйчир** 1971 онд Дэслэгч генерал
**Ж.Балжинням** 1982 онд Дэслэгч генерал
**Р.Гүнсэн** 1965 онд Хошууч генерал
**С.Бүдрагчаа** 1971 онд Хошууч генерал
**Б.Даваасамбуу** 1976 он Хошууч генерал

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР

**Лхамсүрэнгийн Дэндэв** 1930 он
**Ламжавын Чулуунбат** 1930-1931 он
**Өлзийбүрэнгийн Пунцаг** 1931-1932 он
**Жамъянгийн Дэндэв** 1932 он
**Мөрдэндэвийн Ядамсүрэн** 1932-1934 он
**Чойжоогийн Чойдогсүрэн** 1935-1937 он
**Нэрэнхүүгийн Борхүү** 1937 он
**Сэрээтэрийн Пунцагдорж** 1937-1940 он
**Жигжжавын Банзрагч** 1940-1946 он
**Бат-Очирын Жамбалдорж** 1946-1957 он
**Сандагийн Чойжамц** 1957-1959 он
**Сампилын Жалан-Аажав** 1959-1960 он
**Дондовын Ёндондүйчир** 1960-1969 он
**Жарантайн Авхиа** 1969-1978 он
**Равдангийн Гүнсэн** 1978-1982 он
**Содномбалжирын Бүдрагчаа** 1982-1988
**Жүгдэрийн Балжинням** 1988-1990 он
**Гомбодоржийн Бахдал** 1990-1993 он.
**Нанзадын Ганбаяр** 1993-1999 он
**Монголын Алтанхуяг** 1999-2010 он
**Дамбийн Дорлигжав** 2010-2015 он
**Магваннoровын Энх-Амгалан** 2015-2019 он
**Банзрагчийн Жаргалсайхан** 2019 оноос

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ ПРОКУРОР

**Д.Хорхой** 1951-1954, 1980-1988 он
**Л.Цэнд** 1950-иад онд
**С.Батсүх** 1957-1960 он
**С.Баатар** 1960-1963 он
**Н.Цэдэнжав** 1963-1965 он
**Б.Жадамба** 1-р орлогч 1963-1968 он
**Ц.Загд** 1965-1971 он
**С.Бүдрагчаа** 1-р орлогч 1968-1969, 1979-1982
**Г.Иш** 1-р орлогч 1969-1978 он
**Ж.Балжинням** 1972-1980 он
**Б.Хатанбаатар** 1986-1990 он
**Б.Даваасамбуу** 1988-1990 он
**Ж.Бямбаа** 1-р орлогч 1988-1990 он
**О.Дагвадорж** 1988-1990 он
**М.Одонхүү** 1-р орлогч 1990-1993 он
**М.Алтанхуяг** 1990-1993 он
**Ж.Чойжанцан** 1993-1999 он
**Ж.Энхнасан** 1993-1996 он
**Б.Цэрэнбалтав** 1999-2010 он
**Ц.Жамъянсэнгээ** 1999-2005 он
**Ч.Мөнхбат** 2005-2012 он
**Ц.Бямбацогт** 2010-2016 он
**Г. Эрдэнэбат** 2013-2019 он
**Б.Амгаланбаатар** 2016-2019 он
**М.Чинбат** 2019 оноос
**С.Алиманцэцэг** 2019 оноос

## МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ ЦОЛТНУУД

**Гэндэнгийн Дамдинсүрэн** 1970 он
**Сэвжидийн Батсүх** 1970 он
**Ойдовийн Лхамсүрэн** 1971 он
**Мабушкийн Бадрах** 1977 он
**Дуламжавын Очирхуяг** 1977 он
**Хайргын Жамбал** 1980 он
**Балчингийн Дагвадорж** 1990 он
**Жарантайн Авхиа** 1998 он
**Пунсалын Дайрийжав** 2000 он
**Бадамын Дашням** 2004 он
**Монголын Алтанхуяг** 2009 он
**Бат-Очирын Цэрэнбалтав** 2010 он
**Түмэнгийн Жадамбаа** 2010 он
**Аюушийн Ядмаа** 2014 он
**Жигжидийн Гомбодорж** 2015 он
*нар прокурорын байгууллагаас Монгол Улсын Гавьяат хуульч цолоор шагнагджээ. Мөн прокурорын байгууллагад ажиллаж байсан доорхи хүмүүс Монгол Улсын Гавьяат хуульч цолны эзэд болоод байна.*
**Цэндийн Лувсаншарав** 1971 он
**Даржаагийн Зундуй** 2001 он
**Цэвэлмаагийн Содов** 1977 он
*(1962-1964 онд УПГ-т мөрдөн байцаагч)*
**Галдангийн Совд** 2005 он
**Лувсандоржийн Рэнчин** 2006 он
**Данзангийн Лүндээжанцан** 2006 он
**Цэндийн Нямдорж** 2009 он
**Нанзадын Ганбаяр** 2012 он
**Мөнхнасангийн Дамирансүрэн** 2013 он
**Намсрайжавын Лувсанжав** 2017 он

## ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН

**Содовсүрэнгийн Нарангэрэл** 2008 он

# ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГААС ТӨРСӨН ЭРДЭМТЭД

## АКАДЕМИЧ ЦОЛТОН

**Содовсүрэн Нарангэрэл 2000 он**
-1985-1988 онд Улаанбаатар хотын Ерөнхий прокурорын орлогч, 1988-1990 онд Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор

## ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР ЦОЛТОН

**Жарантайн Авхиа 1968 он**
-1969-1978 онд БНМАУ-ын прокурор

**Равдангийн Гүнсэн 1974 он**
-1978-1982 онд БНМАУ-ын прокурор

**Галдангийн Совд 1992 он**
-1954-1956 онд Увс аймгийн прокурорт мөрдөн байцаагч, 1978-1979 онд Улсын прокурорын нэгдүгээр орлогч

**Данзангийн Лүндээжанцан 2000 он**
-1985-1989 онд Улсын прокурорын газарт хэлтсийн прокурор, 1986-1989 онд Улсын Прокурорын туслах бөгөөд хэлтсийн дарга

**Содовсүрэнгийн Нарангэрэл 2000 он**

**Чимидийн Энхбаатар 2002 он**
-1972-1980 онд Улсын прокурорын газрын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, секторын эрхлэгч

## ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДЭД ЭРДЭМТЭН, ДОКТОР ЦОЛТОН

**Равдангийн Гүнсэн 1965 он**

**Эрэнцэнгийн Авирмэд 1970 он**
-1950-1951 онд Улсын прокурорын газарт хэлтсийн прокурор, 1951-1956 онд Ховд аймгийн прокурор

**Галдангийн Совд 1973 он**

**Лувааншавын Хүрлээ 1976 он**
-Говь-Алтай аймгийн прокурор 1959-1966

**Наваанпэрэнлэйн Жанцан 1981 он**
-1972-1987 онд Улсын прокурорын газарт хэлтсийн прокурор, Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнд секторын эрхлэгч, захирал

**Лувсандоржийн Рэнчин 1981 он**
-1966-1971 онд Сэлэнгэ аймгийн прокурорын газарт хэсгийн прокурор, аймгийн прокурорын туслах, 1971-1977 онд Улсын прокурорын газрын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнгийн орлогч захирал

**Оргийн Жамбалдорж 1981**
-1964-1965 онд БНМАУ-ын Прокурорын газрын чухал хэргийн мөрдөн байцаагч

**Каманы Тажебакед 1982 он**
-1973-1979 онд Улсын прокурорын газрын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнд ЭША, 1982-1983 онд Улсын прокурорын хэлтсийн прокурор

**Цэрэнбалжирын Бүжинлхам 1985 он**

-1963-1975 онд Улсын прокурорын газарт шүүхийн хяналтын хэлтсийн прокурор, хэлтсийн дарга, 1975-1983 онд Улсын прокурорын газрын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнд секторын эрхлэгч, орлогч захирал

**Найдангийн Баатаржав 1985 он**

-1996-1997 онд Нийслэлийн прокурорын орлогч прокурор

**Жавхлангийн Бямбаа 1988 он**

-1988-1990 онд Улсын Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогч прокурор

**Данзангийн Лүндээжанцан 1989 он**

**Содовсүрэнгийн Нарангэрэл 1989 он**

**Сүрэнгийн Цэрэндорж 1989 он**

-1977-1980 онд Улсын прокурорын газарт чухал хэргийн мөрдөн байцаагч, Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнгийн орлогч захирал, хэлтсийн дарга

**Санжаагийн Наранбулаг 1992 он**

-1979-1980 онд Улаанбаатар хотын прокурорт мөрдөн байцаагч, 1980-1983 онд Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан

**Должингийн Баярсайхан 1998 он**

-1984-1990 онд Булган аймгийн прокурорын орлогч прокурор, 1990-1992 онд Улаанбаатар хотын прокурорын орлогч прокурор, 1992-1993 онд Улсын прокурорын газрын хяналтын прокурор, тасгийн дарга

**Бирваагийн Мандахбилэг 1998 он**

-1988-1990 онд Улсын Ерөнхий прокурорын газарт нарийн бичгийн дарга

**Хаянхярваагийн Сэлэнгэ 2003 он**

-1981-1986 онд Дорноговь аймгийн прокурорын газарт хэсгийн прокурор, мөрдөн байцаах ажилд хяналт тавих туслах прокурор

**Гочоогийн Банзрагч 2007 он**

-1996-1999 онд Сэлэнгэ аймгийн прокурорын газарт хяналтын прокурор

**Пүрэвийн Оюунчимэг 2009 он**

-1993-1998 онд Баянзүрх дүүргийн прокурорын газарт Хяналтын прокурор, 1998-2001 онд Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокурор, 2001 онд Баянзүрх, Баянгол дүүргийн прокурорын газарт хяналтын прокурор

**Ланжийн Батдолгор 2009 он**

-1996-1999 онд Улсын Ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор

**Лхагваагийн Мөнхсайхан 2011 он**

-1994-1995 онд Баянзүрх дүүргийн прокурорын газарт хяналтын прокурор, 1995-1996 онд Улсын Ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, 2001-2005 онд Завхан аймгийн прокурор

**Ширчингийн Сүхбаатар 2011 он**

-1982-1986 онд Төв аймгийн прокурорын газарт хэсгийн прокурор, мөрдөн байцаагч, 1994-1996 онд Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор бөгөөд Хэрэг эрхлэх газрын дарга

**Цолмонгийн Цэлмэг 2012**

-1996-1999 онд Сэлэнгэ аймгийн Прокурорын газарт хяналтын прокурор

# ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГААС ТӨРСӨН ЭРДЭМТЭД

**Ганболдын Уганболор 2012 он**

- 2012 оноос Улсын Ерөнхий прокурорын газарт ахлах референт, хяналтын прокурор, Сургалт, судалгааны төвийн хяналтын прокурор

**Бямбажавын Өнөрмаа 2014 он**

-1998-1999 онд БЗД-ийн Прокурорын газарт мэргэжилтэн операторч, 1999-2002 онд СБД-ийн Прокурорын газарт хяналтын прокурор, 2002-2007 онд Нийслэлийн Прокурорын газарт хяналтын прокурор, 2010-2011 онд СБД-ийн Прокурорын газарт хяналтын прокурор, 2014 оноос Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалт, судалгааны төвийн ахлах, хяналтын прокурор

**Баасандэлгэрийн Дэлгэрмаа 2014 он**

-2014-2017 онд Улсын Ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, 2017 оноос Тээврийн прокурорын газарт хяналтын прокурор


**Пүрэвжавын Эрдэнэбат 2015 он**

-2000-2004 онд БЗД, СХД-ийн прокурорын газарт хяналтын прокурор, 2004-2008 онд ЧД-ийн прокурорын газарт орлогч прокурор, 2008-2010 онд БЗД-ийн прокурорын газарт хяналтын прокурор, 2011-2013 онд Говь-Алтай аймгийн прокурор, 2013-2014 онд Төв аймгийн прокурор, 2014-2015 онд Дүүргийн 2-р прокурорын газарт хяналтын прокурор, 2015-2017 онд ХУД-ийн прокурорын газарт туслах прокурор, Тамгын хэлтсийн дарга, 2017 оноос Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалт судалгааны төвийн хяналтын прокурор

**Мөнхөөгийн Гантулга 2017 он**


-1998-1999 онд Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газарт зааварлагч, 1999-2002 онд СХД, Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокурор, 2002-2005 онд СХД-ийн орлогч прокурор, 2005-2008 онд Чингэлтэй дүүргийн Ерөнхий прокурор, 2008-2009 онд Нийслэлийн орлогч прокурор, 2009-2017 онд Улсын Ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, 2017-2019 онд Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Сургалт, судалгааны төвийн дарга, 2020 оноос Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалтын албаны дарга, ахлах прокурор











# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: 1930-1939 ОН









# 1930

4 сард. БНМАУ-ын VI Их хурлаас түүхэн шийдвэр гарав.

7 сарын 24. Үйл ажиллагааны эрхзүйн үндсийг хуульчилсан анхны баримт бичгийг Засгийн газраас гаргав.

8 сарын 14. Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 25 дугаар тогтоолоор "Улсын прокуроруудаас гүйцэтгэх эрх, үүргүүдийн дүрэм"-ийг батлан гаргав.

-ЗХУ-ын мэргэжилтэн П.Т.Клопов прокурорын байгууллагын анхны зөвлөхөөр ажиллаж эхлэв.

## МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ ИЙНХҮҮ ЭХЛЭВ

1930 оны 4 дүгээр сард БНМАУ-ын VI Их хурлаар "Тус улсын прокурорын тушаалыг Төв ба аймгуудын зэрэг газруудад үүсгэн байгуулж, хянан байцаах эрх хэмжээг тодорхойлон тогтоовол зохино" гэсэн түүхэн шийдвэр гаргав.

Улмаар 7 дугаар сард нь Их хурлын шийдвэрийг үндэслэн Засгийн газраас прокурорын байгууллагыг бүтцийн хувьд Шүүх явдлын яаманд харьяалуулан байгуулах шийдвэр гаргаж, 8 дугаар сарын 14-нд Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 25 дугаар тогтоолоор прокурорын дагаж мөрдөх эрх, үүргийн дүрмийг **"Улсын прокуроруудаас гүйцэтгэх эрх, үүргүүдийн дүрэм"** нэртэйгээр баталж, төрийн нэрийн өмнөөс хуулийн биелэлтэд хяналт тавих өндөр хариуцлагатай, нэр хүндтэй үүргийг хүлээлгэсэн юм.

Үүнийг Монгол Улсад прокурорын байгууллага бий болсон шийдвэр, анх үүссэн цаг хугацаа хэмээн тооцдог билээ. "Улсын прокуроруудаас гүйцэтгэх эрх, үүргүүдийн дүрэм"-ээр Улсын прокурорыг Шүүх явдлын яамны дэд сайд хавсарч, бусад прокуроруудыг ажилд томилох, өөрчлөх асуудлыг Улсын прокурорын саналаар шүүх явдлын яамны сайд шийдвэрлэхээр тусгаснаас гадна прокурор нь

- Бүх яамд, аж ахуй, худалдаа, үйлдвэрийн байгууллагууд, ард иргэдээс хувьсгалт хууль цаазыг хэрхэн дагаж буйг



1930-1934 онд прокурорын байгууллага Багшийн дээд сургуулийн ард байсан энэхүү нэг давхар байшинд Шүүх явдлын яам, Улсын Дээд шүүхийн хамтаар байрлаж байв.

улсын нэрийн өмнөөс хянахын хамт хэрэв хууль цаазыг зөрчсөн байвал эрүүгийн хэргийг үүсгэн явуулах;
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагуудын ажлыг хянаж удирдах;
- Улсын дотоодыг хамгаалах газар, түүний харьяа байгууллагуудын ажлыг хянах, мөрдөн байцаах ажлыг нь удирдах;
- Бүх шүүхүүдийн ажлыг хянах;
- Иргэний хэргүүдийг шүүхээс шийдвэрлэхэд оролцож улс олон нийтийн ба ард иргэдийн эрх ашгийг хамгаалах;
- Хүнийг хорих, албадан хөдөлмөр хийлгэх болон шүүхийн тогтоолын биелэлтийг хянах;
- Гэмт хэрэгтэй тэмцэх явдлыг хянаж удирдах, түүнийг нэг мөр журмаар явуулах;
- Аливаа хуулиудыг зохиох явдалд оролцох бүрэн эрхтэй болохыг тодорхойлсон байна.


## УЛААН ЦЭРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫГ БАЙГУУЛАВ

БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 1930 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 25 дугаар тогтоолоор Цэргийн шүүн таслах газар, Цэргийн прокурорын тухай дүрмийг баталснаар Улаан цэргийн прокурорын газрыг Цэргийн шүүхэд харьяалуулан байгуулсан. Цэргийн прокурорын дүрэмд Улсын батлан хамгаалах явдлыг бэхжүүлэхэд цэргийн прокурорын хувьсгалт хууль ёсны биелэлтэд хяналт тавих хяналтыг ерөнхий хяналт, мөрдөн байцаалтанд тавих хяналт, шүүхийн хяналт, засан сайжруулах хяналт гэсэн үндсэн чиглэлтэй байхаар заажээ.

Цэргийн прокурорын газрын анхны прокуророор В.Содном-Иш, байцаагчаар Балдан, нарийн бичгийн даргаар Эрдэнэ нарыг томилон ажиллуулж байсан байна.

# 1930

## БНМАУ-ЫН ПРОКУРОР ЛХАМСҮРЭНГИЙН ДЭНДЭВ



БНМАУ-ын анхны прокуророор 1930 онд ажиллаж байсан Л.Дэндэв нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт 1885 онд төржээ.

Тэрбээр автономитын үед хошуу мээрэн, сул гүн зэрэг жинсээр шагнагдаж, 1922-1925 онд Дотоод яамны дансны тал бичээч, орон нутаг удирдах хэлтсийн туслах, дарга, эрхэлсэн түшмэл, 1925-1930 онд Шүүх явдлын яамны сайд, орлогч сайдаар ажиллаж байхдаа БНМАУ-ын анхны прокуророор томилогдон ажилласан байна.


Түүнийг 1941 онд Шинжлэх ухааны хүрээлэнгийн даргаар ажиллаж байхад нь Дотоод явдлын яамнаас хилс хэргээр баривчилж, 1943 онд 10 жилийн хорих ялаар шийтгэсэн байна.

Л.Дэндэвийг 1957 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Цагаатгалын ажил эрхэлсэн комиссын 1 дүгээр хурлаар хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгажээ.

# 1930

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

## МАШ НУУЦ



Цэргийн прокуроруудын зорилго ба эрх үүрэг хийгээд ажиллах арга маягийн тухай заавар:

“Нэг. Хөтөлбөр өгүүлэл


Цэргийн прокурор ба Ардын прокуроруудын зорилго нь нэгэн төрлийн нэг төрөл болмой.

Иймийн тул өнгөрсөн хорин оны 7 дугаар сарын 25-нд Шүүх яамнаас тайлбар зааврын хамт гаргасан Прокурорын дүрмийн аймгийн прокуроруудад дагаж шийтгүүлсэн нь мөн үндсэндээ Цэргийн прокуроруудад удирдлага болон хэрэглэгдмой.

Гагцхүү Цэргийн прокуроруудаас гүйцэтгэх ажлын байдлаас аймгийн прокуроруудын мөрдөж буй зааврын дотор зарим зүйлийг засаж өөрчлөх хэрэгтэй бөгөөд улмаар Цэргийн прокуроруудад дагаж шийтгүүлбээс зохимой.

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

“Улсын прокуроруудаас гүйцэтгэх эрх, үүргүүдийн дүрэм”-ийг баталсан БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1930 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 25 дугаар тогтоолын хэсэг



# 1931

## ФЕОДАЛЫН ХӨРӨНГӨ ХУРААХ АЖЛЫГ ТҮРГЭТГЭЭ

1931 онд БНМАУ-ын Ерөнхий сайдаар Цэнгэлтийн Жигжиджав ажиллаж байсан ба Коминтерний шийдвэрийг үг дуугүй биелүүлэх МАХН-ын Төв хорооны адил эрхтэй, гурван нарийн бичгийн дарга нар нам, төрийн ажлыг удирдаж байв. МАХН-ын VII Их хурлын шийдвэрийн дагуу 1930 оноос улс



*mongoltoli.mn, Д.Эрдэнэбатын хувийн архив*

орон даяар өрнүүлсэн “феодалын хөрөнгө хураах” ажил хангалтгүй байна хэмээн үзэж Коминтерний зааврааp 1931 оны 1 дүгээр сарын 13-нд Дотоодыг хамгаалах газар хувийн аж ахуйтан, феодалын хөрөнгө хураах ажлыг тухайн ондоо багтаан тус газар болон Шүүн таслах газруудаас зохион байгуулахыг санал болгосон байна.

“Барууны үзэлтэн, архинд орсон” гэх зэргээр шүүмжлэгдэж нэг хэсэг ажилгүй байсан Х.Чойбалсан 1931 оны эцсээр Мал тариалангийн яамны сайдаар томилогдлоо.

## ДОТООДЫГ ХАМГААЛАХ ГАЗРЫГ ХЯНАНА

Засгийн газрын Эрхлэх товчооны хуралдаанаас Дотоодыг хамгаалах газрын Улаанбаатар дахь төвийг хянах явдлыг шууд Улсын прокуророос эрхлэн явуулах тухай тогтоол гаргажээ. 1931 онд орон нутгийн 73 хошууны шүүхийг татан буулгаж, зургаан аймагт прокурорын газруудыг байгуулсан ба шүүн

**1 сарын 31.** БНМАУ-ын Шүүх явдлын яамны сайдын 8 дугаар тушаалаар Улаанбаатар хотын прокурорын газрыг Хотын шүүхийг түшиглэн байгуулжээ.

**2 сарын 6.** Шүүх явдлын яамны сайдын тушаалаар Ховдод Ж.Сэржхүү, Завханд Г.Даншийцоодол, Төв аймагт Линзэн, Дорнодод Дугарсүрэн, Хөвсгөлд Б.Цэдэнбалжир, Өвөрхангайд Сэрээтэр, Архангайд Жамбал, Өмнөговьд Гэндэн, Дорноговьд Д.Дамдинжав нарыг прокуророор тус тус томилжээ.

**4 сарын 4.** Засгийн газрын Эрхлэх товчооны хуралдаанаас Дотоодыг хамгаалах газрын Улаанбаатар дахь төвийг хянах явдлыг шууд Улсын прокуророос эрхлэн явуулах тухай тогтоол гаргажээ.

**4 сарын 24.** Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор БНМАУ-ын Шүүх, Прокурорын газрууд ба түүний байцаагч, прокурорын дүрмийг баталжээ.

**7 сарын 5.** Улсын 10 жилийн баярыг тохиолдуулан өршөөн хэлтрүүлэх комиссыг Улсын прокуророор даргалуулан 7 хүнтэй байгуулжээ.

# 1931

**4 сарын 24.** “БНМАУ-ын Шүүх таслах газар, прокурор, байцаагч нарын газруудын дүрэм”-ийг Улсын Бага хурал батлав.

**6 сарын 18.** Улсын Бага хурлын Тэргүүлэгчдээс “Прокурор, мөрдөн байцаагч нарын ажлын дүрэм, заавар”-ыг батлав.

**8 сарын 22.** Засгийн газрын Эрхлэх товчооны 41 дүгээр тогтоолд зааснаар феодалуудаас хураасан хөрөнгийн 80 хувийг хамтрал, артельд, 15 хувийг САА-д, 5 хувийг ядуучуудыг тэтгэх хөрөнгөд олгох болов.


- Аймаг, хотын прокуроруудыг томилох, шилжүүлэх, огцруулахыг Улсын прокурор эрхлэх боловч Шүүх явдлын яам заавал баталдаг болов.

- Засаг захиргааны шинэчлэл хийж хошуу устган, 13 аймаг, 311 сумыг байгуулсантай холбогдуулан Дорнод, Завхан, Өвөрхангай, Төв, Увс, Хөвсгөл аймагт тус тус прокурорын газруудыг байгуулав.

таслах газруудын дэргэдэх байцаагч нарын дагаж хэрэглэх заавар, Дотоодыг хамгаалах газрын аймаг дахь хэлтсүүдийн ажилд аймгийн прокурорын тавих хяналтад баримтлах журам зэрэг прокурорын байгууллагын үйл ажиллагааны удирдамж болохуйц гол гол баримт бичгүүдийг батлан мөрдүүлжээ.

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

*УЛСЫН ДОТООДЫГ ХАМГААЛАХ ГАЗРЫН ТӨВИЙГ ПРОКУРОРООС ХЯНАХАД БАРИМТЛАХ ДҮРЭМ*



...Улсын Дотоодыг хамгаалах газрыг хянах явдлыг Улсын прокуророос шууд эрхлэн гүйцэтгэмой.

Аливаа байцаах хэргүүдийг хэрхэн гүйцэтгэж буйг хянахын хамтаар Улсын прокуророос хяналцах зүйлүүд нь:

-Мөрдөн байцаах хэргүүдийг хэрхэн тогтоосон цаг хэмжээний дотор гүйцэтгэн буйг хянах

-Аливаа хэргийг байцаахад хэрэг байцаах шийтгэх тухай хуульд заасныг хэрхэн баримтлан буйг хянах

-Аливаа хэргийн учир хоригдож буй хүн байх аваас тэдгээрийг хориход баривчилваас зохих учир буй эсэхийг хянан тогтоох

-Аливаа хэрэгт холбогдолтой бөгөөд түүнд баригдаж хоригдох сул буй этгээдийг барьж хорих нь чухал болох эсэхийг тогтоох...

# 1931


## ҮЛДСЭНЭЭ САЙН ИДЭЖ АВЬЯ...

“Феодалын хөрөнгө хураах ажил” гэгчийн тухай ахмад прокурор С.Батсүх ийн дурсжээ. “Дотоодыг хамгаалах газраас мөрдөж шилжүүлсэн хэргийг 7 хоногийн дотор заавал багтаан шүүн таслах, зөрчвөл хатуу хариуцлага хүлээлгэнэ гэх зэргээр нэн хатуу заалт өгсөн учраас шүүх, прокурор, Дотоодыг хамгаалахын байгууллагууд феодалуудын хэргийн гэм буруугийн үндсийг нарийвчлан тогтоохгүйгээр мөрдөн байцаах, шүүхээс таслах, хөрөнгийг хураах ажиллагаанд багагүй алдаа нугалаа завхрал гаргаж байсан юм.

Гэмт хэргийг баримт нотолгоог тогтоохгүйгээр шүүхэд шилжүүлж байсны дотор Хөвсгөл аймагт 125 хэрэгт нэг ч гэрч байцаагаагүй, 38 анги хэргийг нэг өдөр нэг тогтоолоор тасалж байсан.

Зарим нь феодалын хөрөнгө хураахдаа ам бүл, хөдөлмөрийн чадвар байдлыг харгалзахгүй 10 хувь үлдээх зааврыг зөрчиж байсан жишээ бий. Феодалуудын хэргийг мөрдөн байцаахдаа заримыг зодож жанчих, эрүү шүүлт хэрэглэх явдал ч гарч байлаа. Шүүхээс зарим хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж хэрэгсэхгүй болгосны дараа дахин баривчилж, тусгай комисст шилжүүлэн шийтгүүлж байжээ. Хувьсгалын эсэргүү хэрэгт шийтгэгдээд ялаа эдлээгүй үхсэн нэг феодалын хүүд эцгийн нь үлдсэн ялыг эдлүүлэхээр тасалж байсан, хөрөнгөө хураагдах үед “Үлдсэнээ сайн идэж авья” гэж хэлсэн хүнийг арван жил хорьсон, хоёр лам хоорондоо Маркс, Лениний суртал, шашны суртлын талаар харилцан тэмцэлдсэн хэргийг хувьсгалд тэрслэв гэж алах ял оногдуулж байсан зэрэг завхарлыг хуулийн дээд байгууллагууд заримыг нь цаг тухайд нь илрүүлж засаж байсан” хэмээн тэмдэглэжээ.

## БНМАУ-ЫН ПРОКУРОР ЛХАМЖАВЫН ЧУЛУУНБАТ



БНМАУ-ын прокуророор 1930-1931 онд ажиллаж байсан Лхамжавын Чулуунбат нь Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан суманд 1907 онд төржээ. Тэрбээр хошуу тамгын бичээч, эвлэлийн хорооны тал бичээч, бичиг хэргийн эрхлэгчээр ажиллаж байгаад 1931-1932 онд Шүүх Яамны эрхэлсэн сайд бөгөөд Улсын прокурор, 1932 оноос Өвөрхангай аймгийн Шүүх таслах газрын дарга, аймгийн прокурорын алба хашиж байв.

Л.Чулуунбат нь Өвөрхангай аймгийн Ардын Шүүх таслах газрын 1934 оны 6 дугаар сарын 19-ний тогтоолоор эрүүгийн хэргийн 357 дугаар зүйлээр 2 жилийн хорих ялаар хилсээр шийтгэгджээ.

# 1931

## АЛДАА, ЗАВХРАЛЫГ ЗАСЪЯ

МАХН-ын доторх зүүнтнүүдийн алдаатай бодлогын улмаас хуулийн байгууллагуудын ажилд гарсан завхралыг засч, хувьсгалт хуулийг биелүүлэх талаар Шүүх, прокурорын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн 1931 оны 12 дугаар сарын 2-5-нд болжээ.

Зөвлөгөөнд Улсын прокурор Л.Чулуунбат илтгэл тавьж, Бүх цэргийн прокурор Ө.Пунцаг, Дорнодын прокурор Х.Балдан, Завханы прокурор Д.Наваанцэдэн нар үг хэлжээ. Энэ зөвлөгөөн зүүнтний бодлогыг хэрэгжүүлэгчид нам төрийн удирдлагад байсан цаг үед зохион байгуулагдсан атал энэ үеийн алдаа завхралыг засах талаар хөндөж байснаараа онцлогтой юм.

## УЛААНБААТАР ХОТ ПРОКУРОРТОЙ БОЛОВ

Улаанбаатар хотын прокурор анх мөрдөн байцаагч гурав, нарийн бичгийн дарга нэг орон тоотой байгуулагдаж прокуророор С.Пунцагдорж томилогджээ. Ардын байцаагчаар А.Норолхоожав, Г.Жамсран нарыг томилсон байна. Тус прокурорын газар ардын хувьсгалын анхны зорилтыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, улс олон нийтийн хөрөнгийг ашиглан шамшигдуулагчид, иргэдийн өмчийг хулгайлах, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хохироогчидтой тэмцэл явуулж, нийслэл хотод шинээр үүсэн хөгжиж байсан аж үйлдвэр, тээвэр холбоо, соёл гэгээрэл, эрүүлийг хамгаалах байгууллагуудыг бэхжүүлэх, шинэ эргэлтийн бодлогыг зөв явуулах, хувьсгалт хуулийн учрыг ард олонд ойлгуулах ажилд голлон анхаарч байжээ.

## АНХНЫ ЭМЭГТЭЙ ПРОКУРОР



1931 онд Улаанбаатар хотод прокурорын түр сургуулийг байгуулж, төгсөгчдийг Шүүх яамны сайдын туршаалаар хэд хэдэн аймагт прокуророор томилсон байна.

Тэдний дотор 20 настай Далайн Дашжид хэмээх эмэгтэй төгсөгчийг (Дээд Шүүхийн дарга, Шүүх яамны сайд байсан Даншийцоодолын гэргий) 1931-1932 онд Архангай аймгийн прокуророор томилон ажиллуулжээ.

## ЗАВХАНЫ ПРОКУРОР ХОЁУЛХНАА

БНМАУ-ын Засгийн газрын 1931 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн тогтоолоор хуучин Хантайшир аймгийг татан буулгаж, Завхан аймгийг байгуулж, түр хорооны даргаар Дашням, прокуророор Гэмпилийн Даншийцоодол нарыг томилжээ. Ингэснээр Хантайшир аймгийн яам ба Шүүх таслах газруудыг татан буулгаж, Завхан аймгийн прокурорын газрыг байгуулсан ба жинхэнэ прокурор, мөрдөн байцаагч гэсэн орон тоотойгоор 36 сум, 280 гаруй багийг харьяалан хяналтын ажиллагаагаа эхэлж, 1931 оны 10 дугаар сарын 13-ны өдөр анх удаагаа эрүүгийн хэрэг шийдвэрлэх ажиллагаанд оролцжээ.

# 1931

## ДОРНОДЫН ПРОКУРОРЫН ТӨСӨВ

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн хурлын тогтоолоор Хан Хэнтий уулын аймгийн Засаг захиргааны зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, Дорнод аймгийг байгуулахад аймгийн прокурорын газар нарийн бичгийн дарга, байцаагч, прокурор тус бүр нэгтэй, 80-120 төгрөгийн цалинтай, 3480 төгрөгийн төсөвтэйгөөр 1931 оны 4 дүгээр сарын 1-нд байгуулагджээ. Аймгийн анхны прокуророор Д.Балган ажиллаж байжээ.

## ӨВРИЙН ХАНГАЙД ИНГЭЖ ЭХЛЭВ

Өвөрхангай аймгийн прокурорын газар нь мөн оны 2 дугаар сард Аймгийн шүүхийн харьяанд үүсэн байгуулагдаж, прокуророос хуулийн биелэлтэд хяналт тавих албыг аймгийн шүүхийн орлогч дарга хариуцан гүйцэтгэж байжээ. Өвөрхангай аймгийн прокурорын газар нь анх аймгийн прокурор, мөрдөн байцаагч, нарийн бичгийн дарга гэсэн 3 орон тоотойгоор байгуулагдсан байна. Анхны аймгийн прокуророор Чулууны Цэвэгсүрэн томилогджээ.

## УЛААНБААТАРТ КОНТОРТОЙ АЙМГИЙН ПРОКУРОР

Төв аймгийн прокурорын газар 1931 онд Улаанбаатар хотноо өдгөөгийн Улсын Багшийн дээд сургуулийн баруун хойно байрлах хөх өнгийн тоосгон байшинд прокурор нэг, мөрдөн байцаагч хоёртой байгуулагджээ. Анхны аймгийн прокурор Лэнзэн 1930 оны намраас 1931 оны тавдугаар сар хүртэл ажиллаад өвчний учир чөлөөлөгджээ. Оронд нь Гүнсэнгийн Мягмар 1931 оны тавдугаар сарын 18-ны өдрийн 38 тоот тушаалаар Төв аймгийн хоёр дахь прокуророор томилогдож мөн оны эцэс хүртэл ажиллажээ.

## УВСЫН ПРОКУРОР ҮҮДЭЭ НЭЭВ

1931 оны нэгдүгээр улирлаас Чандмань Уулын аймгийн шүүхийн даргад хавсруулан, шүүхийн байцаагч нэрээр ажилласнаар Увс аймгийн прокурорын үндэс тавигджээ. Тус аймгийн анхны прокуророор Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын харьяат Б.Лхайсүрэнг томилон, гурван хүний орон тоотой, монгол гэр 2, ширээ сандал төдийхөн аж ахуйтайгаар ажил үүргээ эхлэн явуулж байжээ.

## ХӨВСГӨЛИЙН ПРОКУРОР ХАРИН Ч ОЛУУЛ

Мөн оны 10 дугаар сарын 19-нд аймгийн прокурор байцаагч, нарийн бичгийн дарга зэрэг 5 орон тоотойгоор тэр үеийн аймгийн төв Хатгал хотод аймгийн захиргааны байранд прокурорын газар үйл ажиллагаагаа эхэлж, анхны прокуророор Б.Жүгдэрнамжил ажиллаж байжээ.

# 1932

6 сарын 16. Шүүх явдлын яамны харьяанд Хэнтий аймагт прокурорын газар байгуулав.

8 сарын 1. Шүүх явдлын яамны харьяанд Дорноговь аймагт прокурорын газар байгуулав.

10 сарын 1. Шүүх явдлын яамны харьяанд Өмнөговь аймагт прокурорын газар байгуулав.

10 сарын 11. Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн хурлаар “БНМАУ-ын Шүүх явдлын яамны дүрэм”-ийг баталж, Улсын прокурор (хууль сахих газар)-ын талаар тусгасан байна.

11 сарын 5. Улсын Бага хурлын тэргүүлэгчдийн 43 дугаар тогтоолоор Улсын 11 жилийн ойг тохиолдуулан ялтан, хэрэгтэнд өршөөл үзүүлжээ.

-1932 онд гарсан бослого хөдөлгөөнтэй холбогдуулан прокурорын байгууллага цаашдын зорилго, үйл ажиллагаагаа тодорхой болгов.

## ЭСГИЙ ГЭРТЭЙ ХЭНТИЙН ПРОКУРОР



Тухайн үеийн прокуроруудын ажлын байр

Монгол Улс Шүүх яамныхаа харьяанд албан ёсоор прокурорын байгууллагатай болсноос хойш богино хугацаанд орон тоо, бүтцийн хувьд өргөжин тэлж, 1932 онд Дорноговь, Өмнөговь, Хэнтий аймагт хууль хэрхэн хэрэгжиж буйд хяналт тавих прокурорын хяналтыг хүргэх боломж бүрджээ. Хэнтий аймгийн прокурор нэг эсгий гэрт прокурор, мөрдөн байцаагч хоёулхнаа 2500 төгрөгийн төсөвтэйгээр байгуулагджээ. Аймгийн анхны прокуророор тэр үеийн Хэнтий аймгийн Өлзийт сумын харьяат Гүнчингомбын Гонгор /1932-1934/, анхны мөрдөн байцаагчаар шүүхийн байцаагч байсан Дончинсүрэн нар томилогджээ.

## ДОРНОГОВИЙН АНХНЫ ПРОКУРОР Г.ДОРЖГОТОВ

Дорноговь аймгийн Прокурорын газар аймгийн шүүхийн дэргэд үүсэн байгуулагдаж, прокурорын хяналтын ажлыг аймгийн шүүхийн орлогч хариуцан гүйцэтгэж байгаад аймгийн анхны прокуророор Г.Доржготов 1932 онд томилогдож 1937 он хүртэл ажиллажээ.

# 1932

## ШҮҮХ ЯВДЛЫН ЯАМНЫ САЙДЫН ТУШААЛААР...

Өмнөговь аймгийн Прокурорын газар Шүүх явдлын яамны сайдын тушаалаар прокурор, мөрдөн байцаагч гэсэн хоёр орон тоотойгоор байгуулагдаж, нэг эсгий гэрт Даланзадгад сумын төвд байрлаж, тулгын чулуугаа тавьжээ. Өмнөговь аймгийн прокуророор Ү.Мажигсүрэн 1931-1934 онд ажиллаж байжээ. Ийнхүү 1932 оны байдлаар орон нутагт 72 хошууны шүүхэд прокурор, мөрдөн байцаагч нар үйл ажиллагаагаа явуулж байсан байна.

## 3203 ЯЛТАНД ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЖЭЭ

Улсын Бага хурлын тэргүүлэгчдийн 43 дугаар тогтоолоор хүнд, хөнгөн хэргээр урт, богино хугацаагаар ял эдэлж байсан 3203 хүнээс 2601 хүнийг суллаж, 478 хүний эдлэх ялыг хөнгөрүүлжээ.

Энэ үед Анхан шатны шүүхийн тогтоол шийдвэрийг Улсын Бага хуралд давж заалддаг байжээ. 1932 онд ийнхүү өршөөл үзүүлэхэд прокурорын байгууллага голлох нөлөө үзүүлсэн гэж үздэг.

## ПРОКУРОРЫН ЭРХ, ҮҮРЭГ ТОДОРХОЙЛОГДОВ

Прокурорын байгууллага 1940 он хүртэл Шүүх Яамны бүтцэд багтаж, яамны ерөнхий удирдлагын дор ажиллаж байсан боловч 1932 онд гарсан дараахь дүрэм прокуроруудын эрх, үүрэгт томоохон нөлөө үзүүлжээ.

## БНМАУ-ЫН ПРОКУРОР ӨЛЗИЙБҮРЭНГИЙН ПУНЦАГ



БНМАУ-ын прокуророор 1931-1932 онд ажиллаж байсан Өлзийбүрэнгийн Пунцаг нь Ховд аймгийн Буянт суманд төржээ. Тэрбээр Дотоодын цэргийн сургууль, Зөвлөлтийн морин цэргийн дунд сургууль, Хоршооны дээд курст суралцаж төгссөн монгол-орос хэл бичигтэн байжээ.

Ө.Пунцаг 1921 онд Ардын журамт цэрэгт элсэж салаа, суман, хорооны дарга, Дотоодыг хамгаалах газрын тусгай хэлтсийн дарга, Цэргийн прокурор, Аж үйлдвэрийн комбинатын даргаар ажиллаж Цусан гавьяаны одон, Алтангадас одонгоор шагнагджээ.

Ө.Пунцагийг П.Гэндэн, Г.Дэмид нарын эсэргүү байгууллагын гишүүн хэмээн буруутгаж, 1937 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Онцгой Бүрэн эрхт комиссын 5 дугаар хурлын тогтоолоор дээд хэмжээгээр шийтгэжээ. Улмаар 1962 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Цагаатгах ажлыг эрхлэх комиссын хурлын 80 дугаар тогтоолоор цагаатгажээ.

# 1932

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 13, Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 37 дугаар хурлаар шинэчлэгдэн баталсан “Шүүх яамны дүрэм”-ийн 15 дугаар зүйлд тусгайлан зааснаар прокурорууд нь Улсын яамд, төвийн



албаны газрууд, үйлдвэр аж ахуй, худалдаа болон нийт иргэдээс хууль цаазыг хэрхэн нэг мөр дагаж байгааг хянах, гэмт хэрэгтэй тэмцэх, энэ ажилд олон нийтийг татан оролцуулах ажлыг удирдах, Дотоодыг хамгаалах газар болон цагдан сэргийлэхэд аливаа хэргийг үүсгэн явуулах, байцаан шийдвэрлэх ажлыг хянах, шүүх хуралд оролцох, олны өмнө хэрэг яллах зэргээр эрх, үүрэг нь тодорхойлогджээ.

## ЭСЭРГҮҮ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЭЛЭЛЦЭВ

Улс орныг удирдаж байсан зүүнтний алдаатай бодлогын улмаас 1932 онд Архангай, Хөвсгөл, Өвөрхангай, Завхан аймгуудад зэвсэгт бослого гарсантай холбогдуулан мөн оны 10 дугаар сард аймаг, хотын, шүүх прокурорын удирдлагуудын III зөвлөгөөн болжээ. Зөвлөгөөнөөр прокуроруудын илтгэл, сонсголыг хэлэлцсэн байна. Энэ үед прокурорын газрууд Архангайгаас бусад аймгуудад байгуулагдаад байсан цаг.

**Шүүх яамны сайд Дэндэв, Улсын**



# 1932

*Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...*

**прокурор Чойдогсүрэн нараас аймгуудын шүүх, прокурорын дарга нарт илгээсэн албан захидал**


Зааварлан сануулах захидал

Нөхөд өө. Намын төв Хорооны 3-р онц Бүгд хурал ба Улсын 17-р онц бага хурлаас зүйл зүйлийн чухал шинэ зорилтуудыг урт хугацаанд буюу олон жилд баримтлан гүйцэтгэхээр шийдвэрлэсний дүнд тогтоолуудыг гаргасан болно.

Ард олны итгэмжлэлийг бататган хангаж улсын үлэмжхэн их эрмэлзлийг өндөрсгөн чадах болохын тулд шүүхийн тэргүүлэгч ба Прокурор нараас энэхүү тогтоолуудыг нэгхэн ч минутад үл умартан гүйцэтгэвээс зохимой.

Шүүх таслах газруудын ба прокурор нарын явуулан бүхий ажлууд нь зайлшгүй болмой. Эдгээр тогтоолуудыг түр зуурдын хэмээн үзвээс даруй хөнгөн мөчид бодлого болмой. Манай улсын бат бэх хүчин чадлыг үл итгэдэг гагцхүү чалчигч нар ба ургасан модны чинээтэй зузаан үеийг үл хардаг сохор хүмүүсээс хувьсгалаар олсон ашиг тус бүхий зүйлийг феодал ба хувьсгалын эсэргүү үзэлтэй дээд ангийн лам нарт гэдрэг эгүүлэн өгч ядуус ба дунд ард олныг үйл заяандаа орхигдсон чанартай тогтоол хэмээн өгүүлдэг болой.

...Үүний улмаас орон нутгуудын албан газрууд ба аймгуудын яамны дарга нар лугаа харилцаа сулрах байдал чангарч бие биедээ гоморхож дайсан бололцон бие биенээс илүү болох явдлын төлөөнөө тэмцэх утгуудыг гаргаваас алс чанаддаа анги бүлэг болж хагарал эвдрэлд хүрэх болой. Бид болвол ийм байдал төлвүүд лүгээ эрс тэмцэх болохыг прокуроруудад урьдаар дуртган санууллъя.



# 1933

## БНМАУ-ЫН ПРОКУРОР ЖАМЪЯНГИЙН ДЭНДЭВ



1932 онд БНМАУ-ын прокуророор ажиллаж байсан Ж.Дэндэв нь Архангай аймгийн Хангай сумын нутагт 1900 онд төржээ. Тэрбээр Улсын прокурор, Шүүх яамны сайд, 1934-1936 онд Монгол Улсаас ЗХУ-д суух Элчин сайдаар томилогдон ажиллаж байжээ.

Ж.Дэндэвийг 1937 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр улс төрийн хэрэгт хилсээр баривчилж 1937 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Онцгой Бүрэн эрхт комиссын 9 дүгээр хурлын тогтоолоор дээд хэмжээгээр шийтгэж, түүнийг П.Гэндэнгийн даалгавраар орон нутгийн ангийн шүүхийг татан буулгаж сумын захиргаанд хийх ажлыг нь шилжүүлснээр хуулийн тэмцлийг сулруулсан, хөнгөн ялтай лам нарыг суллах тухай Өвөрхангай аймгийн прокурор Гомбосүрэнд албан ёсоор даалгаж гүйцэтгүүлж байснаар нь шалтаглан ялласан бөгөөд 1962 онд цагаатгасан байна.

## “ЛХҮМБИЙН ХЭРГЭЭР” ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ ЭХЭЛЖЭЭ

Улсын Бага хурлын Тэргүүлэгчид, Засгийн газрын Эрхлэх товчооны гишүүдийн



*Ж.Лхүмбэ*

хамтарсан Онц хурлаас гаргасан шийдвэрийн дагуу МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга байсан Ж.Лхүмбэ, Ерөнхий сайд Жигжжав нараар толгойлуулсан “Хувьсгалын эсэргүү, Японы тагнуулчдын бүлэг” хэрэг гэх үндэслэлээр Лхүмбийн хамсаатан хэмээж 1500 орчим хүнийг хилс хэрэгт татсан нь манай улсын түүхэнд хамгийн олон хүнийг хамруулсан хилс хэрэг болж үлджээ.

## СУМЫН ДАРГА НАРТ МӨРДӨН БАЙЦААХ ЭРХ ОЛГОВ

Хошуудыг халж сумд байгуулагдсантай холбогдуулан сумын захиргааны дарга нарт шүүн таслах, мөрдөн байцаах ажлыг хавсруулжээ. Аймгийн прокурор нь сумдын нарийн бичгийн дарга нарт дайчлах, баривчлах, мөрдөн байцаах, нэгжих, шалгах эрх бүхий үнэмлэх олгож, шууд өөрийн удирдлагын дор мөрдөн байцаалтын ажилд 1943 оныг хүртэл татан оролцуулсан байдаг. Тэр үед аймгийн прокурор нь

шүүхийн байцаагчидтай хамтран хөдөө сумдаар нүүдэллэн прокурорын хяналтын дүрмийн заалтын дагуу эрүү, иргэний хэрэгт оролцох, хууль дүрмийн биелэлтэд хяналт тавьж, хөдөлмөрчдийн өргөдөл, гомдлыг барагдуулах, хохирлыг төлүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэж байжээ.

## Г.МЯГМАР: АЙМАГ, ХОТЫН ПРОКУРОРЫГ ХАВСРАН АЖИЛЛАСАН

Улаанбаатар хотын прокуророор ажиллаж байсан С.Пунцагдорж 1933 оны 3 дугаар сарын 10-нд Г.Мягмарт ажлаа хүлээлгэн өгсөн акт бичигт “Аймгийн байцаагч Жүгдэрнамжилд мөрдөгдөж байгаа 24, хотын байцаагч Нацагдорж, Хоролсүрэн нарт 25, бүгд 59 хэрэг байснаас гадна шүүхүүдийн гардаж байсан 27 хэргийн хамт хүлээлгэн өгөв” гэж дурдсан нь тухайн үеийн ажлын ачааллыг харуулах түүхэн баримт ажээ.



С.Пунцагдоржийн ажлыг авсан Г.Мягмар нь түүний адил Улаанбаатар хотын прокурорын албыг Төв аймгийн прокурортой хавсарч байжээ. Г.Мягмар дурдатгалдаа “1933 онд Шүүх яамны сайдын 9 тоот тушаалаар Улсын прокурорт байцаагч болсон Сэрээтэрийн Пунцагдоржийн оронд дахин томилогдож Улаанбаатар ба Төв аймгийн прокуророор 1935 он хүртэл хавсран ажилласан. Дараа нь цэргийн газар шилжсэн” гэжээ. С.Пунцагдорж хожим БНМАУ-ын прокурор болсон бол Г.Мягмар нь Төв аймгийн дөрөв дэх прокуророор томилогдон 1935 он хүртэл ажилласан байна.

# 1933

**3 сарын 30.** СнЗ-ийн 13 дугаар хурлаар баруун аймгуудад гарсан зэвсэгт бослогын толгойлогчдын хэргийг таслах хурлын Улсын яллагчаар Улсын прокурор М.Ядамсүрэн, Гомбожав нарыг томилжээ.

**4 сарын 10.** Прокурорын газруудаас гүйцэтгэх үүрэг хариуцлагын тухай Шүүх явдлын яамны сайд Л.Дэндэвийн илтгэлийг СнЗ-өөр хэлэлцэв.

**5 сард.** Улсын прокурор М.Ядамсүрэн Улаанбаатар хотын лам нарын хуралд илтгэл тавьжээ

-Ердөө хоёр орон тоотой ажиллаж байсан Завхан аймгийн прокурорын газарт нарийн бичгийн даргын орон тоо нэмжээ.

# 1933

## УЛСЫН БА АРДЫН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛНА

“Хувьсгалт хуулийг ёсчлон биелүүлэхийн төлөө тэмцэх явдалд шүүх таслах ба прокурорын газруудаас гүйцэтгэх үүрэг хариуцлагын тухай” илтгэлийн мөрөөр СнЗ-өөс прокурорууд Дотоодыг хамгаалах газрын мөрдөн байцаалтыг удирдах, хэрэг яллах, улсын ба ардын эрх ашгийг хамгаалах, шүүх, прокурорыг ард олны дунд алдар хүнд, хэлхээ холбоотой болгох, ажлын чанар, хариуцлагыг сайжруулах зэрэг чухал заалт бүхий тогтоол гаргасан юм.

## “ХУУЛИЙГ ДАГАВАЛ ХАМГААЛАЛТТАЙ, ЗӨРЧВӨЛ ЯЛТАЙ”

Төр, шашин тусгаарласан хуулийг зөрчих явдалтай тэмцэх талаар прокурорын байгууллага дээд, дунд, ядуу лам нарын хурлыг ялгаж хийлгэн, хууль дүрмийг биелүүлэхийг хатуу шаардаж байжээ.

Тухайлбал, 1933 онд Улсын прокурор М.Ядамсүрэн Улаанбаатар хотын Гандан хийдийн лам нарын хурлыг хийлгэж, хууль дүрэм зөрчиж байгаа ноцтой баримтуудыг илрүүлэн зааж, улсын хуульд шууд захирагдан, ядуу лам нар, энгийн ардын хурлаас гаргасан тогтоолыг ягштал биелүүлж, хуулийг чандлан сахихыг шаардаж, “Хуулийг дагавал хамгаалалттай, зөрчвөл ялтай” гэдгийг сануулж байжээ.

Үүний нэг жишээ нь Дорнод аймгийн сүм хийдүүдийг харьяалан суулгасан Засгийн газрын төлөөлөгч Н.Цэвээнтэй хамтран прокурор “Баянтүмэний хийд, Егүзэрийн хийд, Дарьгангын Байшинт, Овоон сүм зэрэг томоохон хийдийн лам, шавилагч нарын хурлыг удаа дараа хийлгэж, хууль дүрэм зөрчих явдлыг зогсоох, ядуу болон лам хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах талаар нам, засгийн бодлогыг сурталчлан таниулжээ.



# 1934

## П.ГЭНДЭН И.В.СТАЛИНТАЙ УУЛЗАВ



П.Гэндэн

Улсын Бага хурлын 18 дугаар хуралдаанаар СнЗ-ийн дэргэдэх Бүх цэргийн зөвлөлийг татан буулгаснаар Х.Чойбалсан ЗХУ-д эмчилгээнд явж, 11 дүгээр сарын 15-нд БНМАУ-ын Ерөнхий сайд П.Гэндэн Москвад И.В.Сталинтай түүхэн уулзалт хийжээ.

## СЭЛЭНГИЙН ПРОКУРОР ТӨВХНӨВ



Сэлэнгэ аймгийн прокурорын газрын анхны байр

1930 онд байгуулагдсан Тариалангийн аймаг нь одоогийн Сэлэнгэ аймаг аж. 1934 онд Сэлэнгэ нэртэй болсон тус аймагт прокурорын газар байгуулах шийд гарч анхны прокуророор Д.Балган, мөрдөн байцаагчаар С.Сосор, нарийн бичгийн даргад Цэнд, аж ахуйн нярав Довдон, зарлага Жамц нарын орон тоотой Алтанбулаг сумын төвд, жижиг дүнзэн байшинд ажлын гараагаа эхэлжээ.

## БНМАУ-ЫН ПРОКУРОР МӨРДЭНДЭВИЙН ЯДАМСҮРЭН



БНМАУ-ын прокуророор 1932-1934 онд ажиллаж байсан М.Ядамсүрэн нь Улаанбаатар хотноо 1904 онд төржээ. Тэрбээр Намын төв сургуулийн хичээлийн эрхлэгч, ерөнхий түүхийн багш, Шүүх явдлын яамны дэд сайд, Аж ахуйн яамны хэлтсийн дарга, Улсын Төв театрын даргаар ажиллаж байжээ. Түүнийг улс төрийн хилс хэрэгт 1937 оны 9 дүгээр сарын 27-нд “Анхны 14-ийн хэрэг”-т баривчлан Улсын Дээд Шүүх таслах газраас Засгийн эсрэг ажлууд хийж байсан гэж буруутган хуулийн дээд хэмжээгээр шийтгэжээ.

М.Ядамсүрэнг Ардын Их хурлын тэргүүлэгчдийн дэргэдэх Цагаатгах ажлыг эрхлэх комиссын 1962 оны 80 дугаар тогтоолоор цагаатгажээ.

# 1934

## “ШҮҮХ ТАСЛАХ БА ПРОКУРОРЫН ГАЗРУУДЫН ДАГАЖ ЯВАХ ДҮРЭМ”

5 сарын 4. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар “Шүүх цаазын бичиг”-ийн ерөнхий ангийг шинэчлэн баталжээ.

6 сарын 11. Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 19 дүгээр хурлаар “Шүүх таслах ба прокурорын газруудын дагаж мөрдөх дүрэм”-ийг шинэчлэн баталжээ.

- Шүүх явдлын яамны Хууль цааз боловсруулах, хянах комисс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг орос хэл дээр бичиж боловсруулжээ.

-Цэргийн шүүх, Прокурорын ба Цэргийн нөхрийн шүүхийн дүрэм баталжээ.

-Шүүх явдлын яамны дэд сайд бөгөөд Улсын прокурорыг СнЗ-өөс томилж, Улсын Бага хурлын Тэргүүлэгчдээс баталж байхаар болов.

-Улс төрийн бэлтгэлтэй, бичиг үсэгтэй хүмүүсээс мөрдөн байцаагчдыг томилох болжээ.

-Дотоодыг хамгаалах газрын мөрдөн байцаах ажилд прокурор хяналт тавих эрхтэй болжээ.



Улсын прокурорын газар 1934-1942 онд одоогийн Монгол Улсын Боловсролын Их сургуулийн байшинд байрлаж байв.

1934 онд “Шүүх таслах ба прокурорын газруудын дагаж явах дүрэм” батлагджээ. Энэ дүрмээр прокурорын байгууллагыг нэгдсэн системд оруулж, прокурорын үндсэн зорилтыг тодорхойлон, тэр тусмаа прокурорын байгууллагын зохион байгуулалтыг бэхжүүлэх, хяналтыг хүчтэй болгоход ач холбогдолтой болсон гэж судлаачид үздэг. Тухайн үеийн дүрэм нь 7 бүлэг, 45 зүйлтэй, гол онцлог нь шүүх, прокурорын үйл ажиллагааг нэг дүрмээр зохицуулсанд оршино.

# 1934


## ЗӨВЛӨЛТИЙН МЭРГЭЖИЛТЭН КЛОПОВЫГ ҮДЭВ

Шүүх явдлын яам, Улсын прокурорын газарт зөвлөхөөр 1924-1934 онд ажиллаж байсан Зөвлөлтийн мэргэжилтэн П.Т.Клоповыг нийслэлийн ойролцоох Шар хөвийн дөрөлж дээрээс хуулийн байгууллагуудын удирдах хүмүүс нутаг руу нь үдэн гаргажээ. Түүнийг Улсын Бага хурлын тэргүүлэгчдийн шийдвэрээр Аж ахуйн гавъяаны одонгоор шагнаж, Шүүх явдлын яам, Дээд шүүх, Улсын прокурорын газраас үндэсний хувцас, мөнгөн аяга дурсгаж байсан байна.

## ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫГ ӨРГӨТГӨВ

Прокурорын хяналт зөвхөн мөрдөн байцаах ба шүүх таслах ажлаар хязгаарлаж байсныг Улсын VII Их хурлаас буруушаажээ. Улмаар аймаг, хот, сумдын захиргаадаас ард түмэнд хууль ёс сурталчлах явдлыг өргөтгөх хийгээд хууль цааз зөрчихтэй эрс хатуу тэмцэхийг үүрэг болгосон байна. Энэхүү шийдвэр нь прокурорыг Шүүх явдлын яамны харьяаллаас гаргах, бие даасан байдлыг хангах, орон тоо, аппаратыг өргөтгөн чадваржуулах урьдач нөхцөлийг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж судлаачид үздэг.

***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***



Мөрдөн байцаалтын ажиллагаа дуусч прокурорт шилжүүлэх тогтоолыг тухайн үед “Мөрдөн байцаалтыг тасалбар болгон зогсоох тогтоол” гэдэг байв.

# 1935

## БНМАУ-ЫН ПРОКУРОР ЧОЙЖООГИЙН ЧОЙДОГСҮРЭН



БНМАУ-ын прокуророор 1935-1937 онд ажилласан Ч.Чойдогсүрэн Өвөрхангай аймгийн Дэлгэрбулаг суманд 1902 онд төржээ.

Тэрбээр 1921 оноос хошуу тамгын бичээч, товчлох хорооны дарга, нягтлан бодох, аймгийн эвлэлийн хорооны дарга, намын хорооны зохиолын хэлтсийн эрхлэгч, Шүүхийн даргаар ажиллаж байсан байна.

Ч.Чойдогсүрэнг 1937 оны 9 дүгээр сарын 11-нд улс төрийн хэрэгт хилсээр баривчилж, Засгийн газрын Онцгой бүрэн эрхт комиссын 10 дугаар сарын 25-ны тогтоолоор Дотоод явдлын яамны гүйцэтгэх ажилд ноцтой хохирол учруулсан хэмээн буруутгаж хуулийн дээд хэмжээгээр шийтгэжээ.

Түүнийг АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэдэх Цагаатгах ажлыг эрхлэх комиссын 1962 оны 80 дугаар тогтоолоор цагаатгасан байна.

## УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ХҮНДРЭВ

БНМАУ-ын гадаад байдал түгшүүртэй болсон 1935 оны эцсээр Ерөнхий сайд П.Гэндэн, Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжин Г.Дэмид, Дотоодыг хамгаалах газрын дарга Д.Намсрай нар ЗХУ-д айлчилж Зөвлөлтийн удирдагчидтай уулзав. Энэ үед И.В.Сталин монголчууд лам нартайгаа эрс тэмцэхгүй байна хэмээн дургүйцэж байгаагаа тэмдэглэж "...Танай Д.Намсрай тэргүүтэй Дотоодыг хамгаалах газар нь улсаа хамгаалах явдалд дотоодын хувьсгалын эсэргүү лам нар лугаа тэмцэх ямар ч ажил хийгээгүй байна" хэмээн зэмлэжээ. Энэ үеэс Ерөнхий сайд П.Гэндэн, Бүх цэргийн жанжин Г.Дэмид нарыг албан тушаалаас нь зайлуулахад ЗХУ-ын удирдлагууд анхаарч эхлэв.


## ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ ХОЁР ДАХИН НЭМЭГДЖЭЭ

БНМАУ-ын олон аймаг, хот, цэргийн шүүх таслах газрын дарга ба прокуроруудын 4 дүгээр зөвлөгөөнд Шүүх явдлын яамны сайд, Улсын прокурор Ч.Чойдогсүрэн тавьсан илтгэлдээ "Прокурорууд нь өөрийн үүргийг зохих ёсоор гүйцэтгэж шүүхийн шүүн таслах ажиллагаа, түүний таслан шийдвэрлэсэн тогтоолыг хянах, албан аж ахуйн газартай харьцан хяналт тавьж ажилласнаар ерөнхий хяналтын аргаар 1935 онд илрүүлсэн зөрчил өмнөх оноос бараг хоёр дахин нэмэгдсэний гадна мөрдөн байцаалтын ажлыг шуурхай болгож, 1269 хэрэг буюу 93 хувь нь хуулийн хугацаанд барагдуулж дуусгасан, мөн Дотоодыг хамгаалах газар,

хэлтэс, ангитай харьцах, төв, орон нутгийн засан сайжруулах газрын ажиллагааны талаар хяналт тавьж ажилласны үр дүнд төв засан хүмүүжүүлэх газраас ялтныг хүмүүжүүлэхэд тус хүргэснийг тэмдэглэнэ" хэмээн онцолжээ.

## СҮМ, ХИЙДИЙН МАЛААС ТАТВАР ХУРААХАД ХЯНАЛТ ТАВЬЖ БАЙВ

Аймгуудын прокурорын газар байгуулагдсан эхэн үедээ зөвхөн шүүн таслах, мөрдөн байцаах ажилд хяналт тавьж байсан бол 1935 оноос аймаг, сумын захиргааны ба аж ахуй, албан газар, байгууллагын ажилд хяналт тавих, улс төрийн буюу төрийн эсрэг биш эрүүгийн бүх хэргийг мөрдөн байцаах ажлыг цөөн орон тооны дайчин шуурхай ажиллагаагаар барагдуулахын хамтаар сумын нарийн бичгийн дарга нарын мөрдөн байцаах ажлыг шалгаж зааварлах үүргийг давхар гүйцэтгэж байжээ.



Энэ үед мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, ажлын дадлага туршлага хомс, дотоод ажил явуулахад хүндрэлтэй байсны дээр контор байр хүрэлцээгүй, алба, амины 2-3 гэрт, морин өртөөгөөр шүүхийн байцаагчидтай хамтран нүүдэллэж, чиг үүргээ гүйцэтгэж иржээ.

Жишээ татахад энэ онд батлагдсан "Сүм хийдийн малаас хураах албан татварын тухай хууль" зэрэг хууль, тогтоомжийг сахин биелүүлэхэд үндсэн хяналтыг тавьж ажилласан байна.

# 1935

9 сард. Улсын Бага хурлаас Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг "Аливаа хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай хууль" нэртэйгээр гурав дахь удаагаа боловсруулан гаргажээ.

11 сарын 21. Аймгуудын шүүх, прокурорын ажилтнуудын 4 дүгээр зөвлөгөөн болов.

-Хөвсгөл аймгийн прокуророор М.Наваанцэдэн 1935-1937 онд ажиллав.

-Хэнтий аймгийн прокуророор Б.Лхасүрэн 1935-1936 онд ажиллажээ.

-МАХН-ын Төв хорооноос Шүүх явдлын яам, Улсын прокурор, Цагдан сэргийлэх газар, Дээд шүүхэд Японы өдөөн хатгалгын тухай анхааруулах нууц бичиг илгээв.

# 1936

4 сард. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид “Шүүх цаазын бичиг”-т Цэргийн гэмт хэргийн тухай бүлгийг шинээр нэмж баталжээ.

7 сарын 5. Хуулийн байгууллагуудын 10 жилийн ойг Улсын 15 жилийн ойтой хамтатган тэмдэглэв.

-Улсын прокурор Ч.Чойдогсүрэн ажлын тайлангаа маршал Х.Чойбалсанд илтгэх хуудсаар хүргүүлэв.

-Шүүх явдлын яам, Улсын прокуророос Хөвсгөл, Дорноговь, Дорнод аймгийн 2 дугаар корпусын Цэргийн прокурорын ажлыг шалгаж, хэлэлцүүлэв.

-СнЗ-ийн дэргэдэх Хууль, тогтоол, тушаалын биелэлтийг шалгах комиссын гишүүн, Улсын прокурорын туслах прокурор С.Пунцагдорж Төв аймагт шалгалт хийж, зөрчил дутагдал олныг илрүүлснээ СнЗ-д танилцуулжээ.

-Нэрэнхүүгийн Борхүүг (1937 онд Улсын прокурор болсон) ЗХУ-д цэргийн сургуульд суралцуулав.

-Архангай аймгийн прокуророор Доржготов, Хэнтий аймгийн прокуророор Ням-Осор нар томилогджээ.

## ЗАСАГ ТӨРИЙН ЖОЛОО НЭГ ГАРТ ШИЛЖИВ



1936 оны хавар МАХН-ын Төв хорооны Бүгд хурлаас Ерөнхий сайд П.Гэндэнг огцруулж, ЗХУ-д нутаг заан суулгав. Дотоодыг хамгаалах газрыг Дотоод явдлын яам болгон өргөтгөж Х.Чойбалсанг сайдаар нь томилж, “Хувьсгалын эсэргүү” нартай тэмцэх гол үүргийг тус яаманд хариуцуулжээ. 1936 оны 3 дугаар сард Д.Догсомыг Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн даргаар, А.Амарыг Ерөнхий сайдаар томилсон боловч төр, засгийн бүх эрх мэдэл Х.Чойбалсанд шилжсэн учир хууль тогтоох дээд байгууллага, гүйцэтгэх засаглал ор нэр төдий болж, улс оронд өрнөж буй үйл явцыг ажиглахаас хэтрэхгүй болжээ гэж Монгол Улсын түүхийн 5 дугаар ботид судлаачид дүгнэжээ.

## ПРОКУРОРЫН ХҮҮХДЭД ХӨНГӨЛӨЛТ ЭДЛҮҮЛЭВ

Энэ үед ажиллаж байсан хуулийн байгууллагын ажилтнуудад төрийн зүгээс чамгүй хөнгөлөлт, урамшуулал олгож байжээ. Тухайлбал, Улсын төв архивын баримтад “Төв аймгийн прокурор Балган, Дорноговь аймгийн прокурор

# 1936

Л.Хоролсүрэн нарын 7 нөхдөд биктрул хэмээх эгшигт хайрцаг ба үүрд хадгалагдах үнэмлэхээр тус тус шагнахаас гадна эдгээр бүхий л нэр дурдсан нөхдүүдэд үүрд хадгалах гавъяаны хэд хэдэн зүйлийн хөнгөлөлт бүхий дурсгалын үнэмлэхэд улсаас эдлүүлэх хөнгөлөлтүүд нь: Түүний биеийг албан ажилд бусдаас урьтал болгон авах, Улсын албан яам, засаг захиргаа, аж ахуй, олон нийтийн байгууллагуудаас энэ нөхдөд ямар нэгэн онц гачигдал тохиолдвол зохих тусламжийг урьтал болгон үзүүлэх, Үр хүүхдийг нь гадаад дотоодын зэрэг аливаа хүссэн сургуулиудад нь саадгүй оруулах, ямар нэгэн ший жүжиг, кино зэрэг олон нийтийн цугларах цэнгэлдэх газруудад үнэ төлбөргүй шууд оруулж үзүүлэх, эдгээр эрх хөнгөлөлтүүдийг эдлүүлсүгэй" гэжээ.

## ЦЭРЭГ ДАЙЧИЛГААГ ХЯНАВ

Прокурорын газрууд цөөн орон тоотой боловч үйл ажиллагаагаа байнга өргөжүүлж байсны баримт нотолгоо цөөнгүй үлджээ.

Тухайлбал, 1936 онд Улаанбаатар хотын прокурорын газар ард иргэдээс 80 гаруй өргөдөл хүлээн авч барагдуулан, 800 шахам хэргийг мөрдөж, 541-ийг нь шүүхэд шилжүүлэн, 127-г хэрэгсэхгүй болгож, 31 хэргийн үлдэгдэлтэй, 24 удаа 3448 хүнд хуулийн яриа таниулга хийж, сүм жасын албан татвар төлөлт, лам нараас хураах цэргийн тусгай татвар, цэрэг дайчилгааны ажлын явц байдлыг ерөнхий хяналтаар шалгаж байжээ.



# 1937

2 сарын 8. Прокурорын байгууллагыг Засгийн газрын мэдэлд харьяалуулав.

9 сарын 11. Улсын прокуророор ажиллаж байсан Ч.Чойдогсүрэнг улс төрийн хилс хэрэгт татан баривчлав.

9 сарын 20. Шүүх явдлын яамны сайд, Улсын прокуророор ажиллаж байсан М.Ядамсүрэнг улс төрийн хилс хэрэгт баривчлав.

10 сард.Намын төв Хорооны өргөтгөсөн 3 дугаар бүгд хурлаас ДЯЯ-ны үйл ажиллагаанд прокуророос тавих хяналтыг зогсоов.

10 сарын 7. Н.Борхүүг Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 56 дугаар тогтоолоор Улсын прокуророор томилов.

10 сарын 17. Улсын прокурор Н.Борхүүг улс төрийн хилс хэрэгт татан баривчлав.

10 сарын 21. Шүүх явдлын яамны сайд, Улсын прокуророор ажиллаж байсан М.Ядамсүрэнг хуулийн дээд хэмжээгээр шийтгэв.

10 сарын 25. Улсын прокуророор ажиллаж байсан Ч.Чойдогсүрэнг Онцгой бүрэн эрхт комиссын 1 дүгээр хурлын тогтоолоор хуулийн дээд хэмжээгээр шийтгэжээ.

## УЛСЫН ПРОКУРОР ЗАСГИЙН ГАЗАРТ ЗАХИРАГДАНА

Намын Төв хорооны Тэргүүлэгчдийн 53 дугаар хурлаас гаргасан тогтоолд “...хууль хамгаалагч нарын тэмцлийг одоо үеийн хөгжлийн шатанд тохируулан зохион байгуулалтын өөрчлөлтийг гаргаж явуулах нь чухал болох тул Улсын прокурорыг Шүүх яамны харьяанаас салгаж шууд Засгийн газар харьяалуулахын хамтаар мөн Улсын прокурорыг Шүүх яамны дэд сайдын үүргээс нэгэн адил тусгаарлан салгаж Улсын прокуророор ажиллуулбаас зохимой” гэжээ.

## УЛС ТӨРИЙН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТ УЛАМ ГААРАВ

“Монгол Улсын түүх”-ийн 5 дугаар ботид “И.Сталины зааврыг хэрэгжүүлэхэд бүх хүч чадлаа зориулах болсонд Монголын эрх баригчид бараг цөмөөрөө Х.Чойбалсанг дэмжихээ больж, харин ч түүнийг эсэргүүцэж байлаа. Тухайлбал, 1937 оны эхээр Улсын прокурор Ч.Чойдогсүрэн, Шүүх яамны сайд Г.Цэрэндорж нар хамтарсан тушаал гаргаж, ДЯЯ-ны ажилд хуулийн хараа хяналт тогтоох,



хууль ёс завхруулах явдлаас урьдчилан сэргийлэх чиглэл бүхий заалт оруулсан байна” хэмээжээ. Гэвч Х.Чойбалсан тушаалыг хэрэгжүүлэх талаар огтхон ч санаа тавиагүйгээр үл барам ДЯЯ-ны мөрдөн байцаалт хууль бусаар явагдаж

# 1937

байгааг илчилсэн шүүмжлэлийг шууд няцааж, “хууль хяналтын байгууллагаас Дотоод явдлын яамны ажилд саад учруулж байна” хэмээн зэмлээд Намын Төв Хороонд мэдээлэл гарган өгчээ. МАХН-ын Төв Хороо 1937 оны 5 дугаар сарын 31-нд Тэргүүлэгч гишүүдийнхээ хурлаар хэлэлцэж, Х.Чойбалсангийн байр суурийг дэмжсэн байна. 8 дугаар сарын 23-нд маршал Г.Дэмид ЗХУ-д албан хэргээр одох замдаа хорлогдон нас барсан ба 9 дүгээр сарын 2-нд Х.Чойбалсанг Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжнаар томилж, удалгүй мөн л түүнээр даргалуулсан “Онцгой бүрэн эрхт комисс”-ыг байгуулснаар улс төрийн хэлмэгдүүлэлт гал дээр тос асгасан мэт газар авчээ.

## ХЯНАЛТ ТАВИАД ЯЛ ТУЛГАГДАВ

Олон мянган ард иргэд, лам нар, төрийн ажилтнуудыг хилсдүүлсэн 1937 оны аймшигт хэлмэгдүүлэлтийг нэр бүхий прокурорууд эсэргүүцэж, хууль ёсыг сахиулахын төлөө тэмцсэн ч өөрсдөө золиос болжээ.

10 дугаар сард Намын төв Хорооны өргөтгөсөн 3 дугаар бүгд хурлаар “Хувьсгалын эсэргүү нартай тэмцэх Дотоод яамны үйл ажиллагаанд шүүх, прокурор саад учруулж байна” гэсэн Дотоод яамны сайд Х.Чойбалсангийн мэдээлэл, түүний прокурорын хяналтаас татгалзсан шаардлагыг авч үзэж, дэмжсэнээр прокурорын хяналтыг хэрэг дээр нь устгасан байна.

Үндэсний Төв архивт хадгалагддаг Улсын прокурор Ч.Чойдогсүрэнд тулгасан хэргийн материалаас энэ байдал тодорхой харагддаг. Түүнийг “Улсын прокурорын үүрэг гүйцэтгэж байхдаа эсэргүү гэмт хэрэгтнүүдийг дайчлах баривчлах, хорих ялыг шийтгэх явдлуудыг саатуулан хориглож Дотоод явдлын яамны гүйцэтгэх ажилд ноцтой хохирол учруулж байсан” хэмээн ял тулгажээ.

## ХЭЛМЭГДҮҮЛЭЛТЭД ПРОКУРОРУУД ӨРТӨВ

Оны сүүл рүү хууль, хяналтын байгууллагын удирдлагуудыг хоморголон хэлмэгдүүлэх явдал газар авчээ. 1937 оны есдүгээр сар хүртэл Улсын прокуророор ажилласан Ч.Чойдогсүрэн, 10 дугаар сарын 7-нд Улсын прокуророор томилогдоод 10-хан хоног үүрэгт ажлаа гүйцэтгэсэн Н.Борхүү, өмнө нь Шүүх

10 сард. С.Пунцагдоржийг Улсын прокуророор томилов.

11 сарын 30. Улсын прокурор, Шүүх яамны сайд, 1934-1936 онд Монгол Улсаас ЗХУ-д суух Элчин сайдаар ажиллаж байсан Ж.Дэндэвийг улс төрийн хэрэгт хилсээр баривчлав.

12 сарын 10. Онцгой Бүрэн эрхт комиссын 6 дугаар хурлаар Улсын прокуророор ажиллаж байсан Н.Борхүүг хуулийн дээд хэмжээгээр шийтгэв.

12 сарын 30. Улсын прокуророор ажиллаж байсан Ө.Пунцагийг Онцгой Бүрэн эрхт комиссын 5 дугаар хурлын тогтоолоор дээд хэмжээгээр шийтгэв.

12 сарын 31. Улсын прокурор, Шүүх яамны сайд Ж.Дэндэвийг Онцгой Бүрэн эрхт комиссын 9 дүгээр хурлын тогтоолоор хуулийн дээд хэмжээгээр шийтгэв.

-Л.Хоролсүрэн Төв, Банзрагч Архангай, Б.Лхаасүрэн Завхан, Чойдог Өвөрхангай, О.Чулуун Ховд, Б.Лувсандорж Хөвсгөл аймгийн прокуророор тус тус томилогдон ажиллаж эхлэв.

# 1937

## БНМАУ-ЫН ПРОКУРОР НЭРЭНХҮҮГИЙН БОРХҮҮ



БНМАУ-ын прокуророор 1937 онд ажиллаж байсан Н.Борхүү Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутагт 1905 онд төрж, 1926 оноос Дотоод явдлын яаманд сургагч, бага дарга, хязгаарын комендант, бичээч, төлөөлөгч, тасгийн дарга, Намын товчооны дарга зэрэг ажил хийж байв. Тэрбээр 1936 онд ЗХУ-д цэргийн сургуульд суралцаж ирээд Улсын прокурорын албан тушаалд Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1937 оны 10 дугаар сарын 7-ны тогтоолоор томилогдсон ч 10 хоногийн дараа П.Гэндэн, Г.Дэмид нарын хэрэгт хилсээр холбогдуулан Онцгой бүрэн эрхт комиссын 1937 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 6 дугаар хурлаар Шүүх цаазын бичгийн 43, 44, 45 дугаар зүйлээр хуулийн дээд хэмжээгээр шийтгэжээ. Түүнийг БНМАУ-ын Ардын Их хурлын Тэргүүлэгчдийн дэргэдэх Цагаатгах комиссын тогтоолоор цагаатгажээ.

яамны сайд, Улсын прокуророор ажиллаж байсан Ө.Пунцаг, Ж.Дэндэв, М.Ядамсүрэн нарыг гуравхан сарын дотор шинэ он гарахаас өмнө багтаан Онцгой бүрэн эрхт комиссын шийдвэрээр цаазалсан байна.

Тэрчлэн Улсын прокурорын орлогч Г.Цэвэгсүрэн, Өвөрхангай аймгийн прокурор Г.Гомбодорж Улсын прокурорын туслах Ж.Гүнчин, Ховд аймгийн прокурор Ж.Сэржхүү, Бүх цэргийн прокурор С.Лувсанцэдэв нарын олон прокурорыг хэлмэгдүүлжээ. Хожим тэд бүгд төрийн шийдвэрээр цагаатгагдсан.

1960-1969 онд БНМАУ-ын прокуророор ажиллаж байсан Д.Ёндондүйчир “1937 оны үед прокурор хяналт тавих ямар ч бололцоо, эрх байсангүй” хэмээн тэмдэглэсэн нь бий.

## ОН СОЛИГДОХ ТОРГОН МӨЧИД

12 дугаар сарын 31-нд Улаанбаатар хот, олон аймаг, Цэргийн шүүх таслах газруудын дарга, прокуроруудын 5 дугаар зөвлөгөөн болж Шүүх яамны сайд Г.Цэрэндорж илтгэл тавьжээ.

Зөвлөгөөнд Улсын прокуророор томилогдоод удаагүй С.Пунцагдорж, Улсын Дээд шүүх таслах газрын дарга Г.Даншийцоодол нар үйл ажиллагааныхаа талаар тайлан тавихдаа сайдын илтгэлийг дэмжиж, Намын Төв хорооны 3 дугаар Бүгд хурлаас гаргасан тогтоолыг биелүүлэх, тэмцлийг цаашид хэрхэн явуулах талаар өөрсдийн саналаа илэрхийлжээ.


# 1937

## ДУТАГДАЛ, ШАМШИГДЛЫГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭВ

Улаанбаатар хотын прокурорын газар Хоршоодын ерөнхий хорооны 631 мянган төгрөг, Мах комбинат, Нарийн боовны үйлдвэрүүдийн 3 сая шахам төгрөгийн дутагдал, шамшигдал болон Хотын шүүхийн эрүүгийн тогтоолоор төлөгдөх 220 мянга 766 төг, иргэний тогтоолоор 67 мянга 933 төгрөгийг тус тус төлүүлжээ.

***ТЕГ-ын Тусгай архивын сан хөмрөгөөс...***

БНМАУ-ын прокуророор 1937 онд ажиллаж байгаад хилс хэрэгт хэлмэгдэж, амь насаа алдсан Н.Борхүүгийн хувь заяа хэрхсэнийг архивын баримтаас харж болно. Хилс хэрэгт хэлмэгдээд, цагаатгагдсан бусад Ерөнхий прокуроруудын холбогдолтой архивын баримт материалд ч ийм л дүр зураг, нөхцөл байдал илэрхий байдаг юм.



ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТУСГАЙ АРХИВ
ХУУЛБАР УНЭН

МАГАДЛАЛ

1939 оны 8 -р сарын 1 -ээр

Дутагдал 93 Улаанбаатар хот

БНМАУ-ын Дээд Шүүхийн Цэргийн хэрэг арбитрлах коллегийн хяналтын шатны

эрүүгэ хэрэг бүрдлээ гүйцэтгэгч:

Дарга Ц.Долмон

Гишүүд Б.Цогтсайхан


Дэд хуранда Д.Цэрэнбалтав

Орлогсон прокурор Ц.Жалшаа

Дүнгээ айлчлэн Говь-Угтаал сумын харьяат, 32 настай, ам бүл 4, улсын хууль хамгаалах прокуророор томилогдоод ундлагүй барицуулагдсан, Нарийхүүгийн Борхүү нь:

Б.Гэнцэн, Г.Дэмидийн хувьсгалын эсэргүү байгууллагад 1933 онд Б.Гэнцэнд элсэгдсэн, засаг терийг устгах япон колони болгохоор шууд бэлтгэж байсан зэрлэг ажиллагаанд оролцсон, Ж.Лхүмбэ нарын хэргийг хилс тавьж хэмээн хүчингүй болгохыг тэмцсэн, сүүлийн үед Б.Гэнцэн, Г.Дэмид нарын хэргийг хилс тавьж хэмээн гүтгэлэг явуулж байсан гэсэн хэрэгт шүүх хаазны бичгийн 43, 44, 45-р зүйлээр ял тавьлагдаж, мөн зүйлээр буудан алж, бүх хөрөнгийг хураах ялаар шийтгүүлжээ.

Прокурорын эсэргүүцэл: Н.Борхүү терийн эсэргүү гэмт хэрэг үйлдээгүй болох нь тогтоогдсон тул тогтоолын түүнд холбогдох хэсгийг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгуулж цагаатгуулъя гэжээ.



2.

Оролцсон прокуророос: Прокурорын эсэргүүцлийг дэмжиж байна гэв.

Хянавал:

Н.Борхүү улсын прокуророор томилогдсоор 10 хоногийн дараа барив чилж, түүнээс хойш 52 хоногийн дараа зөвхөн ганцхан удаагийн Д.Намсрайтай нүүрэлдүүлж байцаасан мэдүүлгийг үнэлэлэн, Н.Борхүүг огт хэрэг хүлээгээгүй байхад, хилс хэрэгт тулгаж протоколд түүний гарын үсгийг өөр хүн зурж, ял шийтгэжээ.

Н.Борхүүгийн элсэгдсэн гэх Б.Гэнцэнгийн мэдүүлэгт түүний нэр гараагүй, япон колони болгохоор бэлтгэж байсан, япон гаднуулыг бэ жүүлж, дайсны хорт явуулгыг чилээлэй болгох зорилго тавьж байсан гэдгийг тэр үед нь нотлож шалгаагүй, одоо тогтоох боломжгүй байна.

Харин Н.Борхүү Ж.Лхүмбэйн хэргийг шалгахад оролцож байсны хувьд хилс тавьж хэмээн хүчингүй болгохын төлөө тэмцэж байсан гэдгийг өөрөө мэдүүлсэн байх бегээд ялын талаалгээнд сүүлийн үед Б.Гэнцэн, Г.Дэмид нарын хэргийг хилс тавьж хэмээн гүтгэлэг явуулж байсан гэсэн нь Н.Борхүүгийн үзэл бодол зөв зүйтэй байсныг гэрчилж байна.

Иймд түүнийг цагаатгуулахаар бичсэн прокурорын эсэргүүцлийг хүлээж авах нь зүйтэй байна.

БНМАУ-ын ЭБШ хуулийн 369-р зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

ДЭЙ-ны дэргэдэх Онц бүрэн эрхт комиссын 1937 оны 12-р сарын 10-ны өдрийн 6-р хурлын тогтоолын Нэрэлхүүгийн Борхүүд холбогдох хэсгийг хүчингүй болгож, түүнийг цагаатгаж, гэмт хэрэгтэн бүрэлдэхүүнгүй тул хэргийг ЭБШ хуулийн 6-р зүйлийн 2 дахь хэсгийг барим тлан хэрэгсэхгүй болгосугай.

ДАРГА Ц.ДОЛМОН
ГИШҮҮД Б.ЦОГТСАЙХАН
ДЭД ХУРАНДАА Д.ЦЭРЭНБАЛТАВ

# 1938

2 сарын 14. Булган аймагт прокурорын газар байгуулав.

2 сарын 18. Шүүх явдлын яамны сайдын 2 дугаар сарын 18-ны тушаалаар тус яамны харьяанд нууцын эрхлэгч, хууль цаазын хэлтсийн туслахын орон тоо бий болгож, Дамдинсүрэнг томилжээ. Түүнд Шүүх яам, Дээд шүүх, Улсын прокурорын маш нууц бичиг баримтуудыг туйлын нарийвчлан хадгалж, маш журамтай хөтлөн явуулахыг үүрэг болгожээ.

9 сарын 1. Шүүх явдлын яамны сайдын тушаалаар яамны дэргэд олон аймгуудын шүүх таслах байцаагч, хууль хамгаалагч прокуроруудын сургах түр сургууль байгуулав.

- Аймаг, хотын шүүх, прокурорын ажилтнуудын V зөвлөгөөн болж Шүүх явдлын яамны сайд Г.Цэрэндорж, Улсын прокурор С.Пунцагдорж нар илтгэл хэлэлцүүлжээ.

- Улаанбаатар хотын прокуророор Б.Лувсандорж, Архангай аймагт Г.Дамдинсүрэн, Өвөрхангайд М.Гомбосүрэн, Өмнөговьд Д.Бямбаа, Хөвсгөлд Р.Туваандорж, Ж.Чадраабал, Төв аймагт Л.Хоролсүрэн нар тус тус прокуророор ажиллаж эхэлжээ.

## УЛСЫН ИХ, БАГА ХУРАЛ ХУРАЛДСАНГҮЙ

1938 онд Ерөнхий сайдаар А.Амар ажиллаж байв. Аппаратын удирдлага, ажилтнууд олноороо хилс хэрэгт



татагдсанаас болж гурван жил тутамд хуралдах төрийн дээд эрх барих Улсын Их хурал хуралдсангүй, мөн жил тутам хуралдаж, Засгийн газрын үйл ажиллагааны тайлан, улсын төсвийн төлөвлөлт хэлэлцэх үүрэгтэй Улсын Бага хурал тус онд хуралдаж чадсангүй.

## ЛАМЫН ОРХИМЖ ХУЛГАЙЛАГЧИД ОНООСОН ЯЛЫГ ХҮНДЭДСЭН ГЭЖ ҮЗЭВ

Энэ онд зарим аймгийн прокурорын газарт төвөөс шалгалт хийжээ. Тухайлбал, Шүүх яамны зөвлөх, Зөвлөлтийн мэргэжилтэн Э.К.Сетинсон, Дээд шүүхийн гишүүн Навааңцэдэн нар 5 дугаар сард Хөвсгөл, Хэнтий, Дорнод аймгуудын шүүхийн байцаагч, прокуроруудын ажил хэргийг шалгаж, үйлдсэн акт материалыг хянан хэлэлцээд ажлын ололтуудыг тэмдэглэж, илрүүлсэн дутагдал завхралуудыг даруй засахыг үүрэг болгожээ. Шалгалтаар дээрх аймгийн шүүгч, прокурорууд эрүүгийн бодлогыг завхруулж, хувьсгалт

# 1938

эсэргүү гэмт хэрэг үйлдсэн болон Төр шашныг тусгаарласан хуулийг зөрчсөн том толгой лам нарт туйлын хөнгөн ял оногдуулж, ерөнхийлөн өршөөл үзүүлсэн гэж дүгнэсэн байна. Тэрчлэн, Шүүх яамны зөвлөх П.Т.Клопов, Дээд шүүхийн гишүүн Навааңцэдэн нар Зүүн хязгаарын корпусын Цэргийн шүүх, прокурорын газрын ажлыг шалгасан, актыг авч хэлэлцжээ. Шалгалтаар зарим хэрэгт ял оногдуулахдаа хууль зөрчиж хөнгөрүүлж, хүндрүүлсэн зөрчлүүдийг илрүүлжээ. Тухайлбал бусдаас 10 төгрөг 20 мөнгө ашиглахыг завдсан цагдаа Дамдинг 2 жил хорих ялаар шийтгэж, ламын нэг ширхэг орхимж хулгайлсан цагдаа Гонгорыг 1 жил 6 сараар хорьж хуулийн заалтыг хүндрүүлж хэрэглэсэн байна гэж үзжээ. Мөн оны сүүл 10 дугаар сард Г.Даншийцоодол, Э.К.Сетинсон нар Увс, Ховд, Завхан аймгийн шүүх, прокурорын ажлыг шалгаж, дүгнэлтээ Шүүх яамны коллегийн хурлаар хэлэлцүүлсэн байна.

## ХЭЛМЭГДЭГСДИЙН ГАРЫН ҮСЭГТЭЙ ҮНЭМЛЭХИЙГ ХУРААН АВАВ

СнЗ-ийн Ерөнхий сайдын даалгаснаар Шүүх явдлын яамны сайд 8 тоот тушаал гаргав. Тушаалд П.Гэндэн, Г.Дэмид ба Шүүх явдлын яамны сайд агсан Л.Дэндэв, Чойдогсүрэн, М.Ядамсүрэн нарын гарын үсэг бүхий дурсгалын үнэмлэх, тэмдэг, бусад зүйлүүдийг ажилтан, ажилчдаас хураан авахыг үүрэг болгожээ.

## ГУРВАН БАЙШИНГ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙГЭЭР ХОТЫН ШҮҮХ, ПРОКУРОРТ ШИЛЖҮҮЛЭВ

Шүүх явдлын яамны сайдын 5 дугаар сарын 1-ний өдрийн 50 дугаар тушаалаар Улаанбаатар хотын шүүх, прокурорын байгууллага нь олигтой конторгүйгээс өдөр тутмын албан хэргээ хууль ёсоор явуулахад хүндрэлтэй байна гэж тус яамны хуучин хашаа байшингийн дотроос тус бүр 3000, 3900 төгрөгийн үнэтэй хоёр агуулах бүхий гурван байшинг үнэ төлбөргүйгээр хотын шүүх, прокурорын мэдэлд шилжүүлж тэдгээрийг сэлбэн засахад зориулж төсөвт суулгасан 12000 төгрөгийг журмын дагуу зарцуулахыг үүрэг болгов.

## АРВАН МЯНГАН ТӨГРӨГИЙН ТӨСӨВТЭЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

Булган аймгийн прокурорын газар Шүүх явдлын яамны сайдын 2 дугаар сарын 14-ний өдрийн 20 дугаар тушаалаар аймгийн прокурор, мөрдөн байцаагч, галч-цэвэрлэгчийн орон тоотой, эсгий гэр нэг, 10000 төгрөгийн төсөв хөрөнгөтэй байгуулагдав.

Аймгийн анхны прокуророор Цонхлон сумын дарга байсан Жадамбаа, мөрдөн байцаагчаар Хантай сумын нарийн бичгийн дарга байсан Санжаажамц нар томилогджээ.

# 1938

## БНМАУ-ЫН ПРОКУРОР СЭРЭЭТЭРИЙН ПУНЦАГДОРЖ



1936-1940 онд БНМАУ-ын прокуроороор ажиллаж байсан Сэрээтэрийн Пунцагдорж 1901 онд төржээ. Тэрбээр аймгийн эвлэлийн хорооны дарга, аймаг хотын шүүхийн дарга, прокурор, Улсын ба туслах прокуророор ажиллаж байгаад эл албанд томилогджээ.

С.Пунцагдоржийг хилс хэргээр баривчилж, Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Тусгай байгуулсан шүүхээс Рэнчин, Лосол, Сэнгэдорж, Дуламсүрэн нарын хамт эх орноосоо урвасан, Шүхэрт нартай хамт засаг төрийн эсрэг ажиллагаа явуулсан гэж үзэн хуулийн дээд хэмжээгээр шийтгэж УБХ-ын Тэргүүлэгчдийн 1941 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 5 дугаар тогтоолоор баталжээ.

Ардын Их хурлын Тэргүүлэгчдийн дэргэдэх Цагаатгах ажлыг эрхлэх комиссын 1962 оны 80 дугаар тогтоолоор түүнийг цагаатгасан байна.

## БОГДЫН ШАР ОРДНЫ ХАШААНД ГЭРЭЭ ДУГУЙЛАВ

Төв аймгийн прокурорын газар хотын прокурорын газраас салж нүүн, Богдын шар ордны хашаанд албан конторын гурван эсгий гэрийнхээ ханыг дугуйлжээ. Энэ тухай тус аймгийн прокуророор ажиллаж байсан Уламбаярын Магсар “Зүүн хүрээний хойд хэсэгт хуучин Богдын шар орд гэх хүрэн будагтай том банзан хашаанд Төв аймгийн бүх байгууллага нэгдэж, цөм гэр контортой



төвлөрч байхад хашааны баруун захад жижиг модон дуганы дэргэд шүүх, прокурорынхон 5-6 гэртэй байсан. Төв аймаг 31 сумтай том аймаг байсан учир хэрэг их гарна. Тиймээс прокурор нь хоёр мөрдөн байцаагчтай жилд олон хэрэг бүртгэж шийдвэрлүүлдэг байлаа” гэж дурсжээ.

## ПРОКУРОР, ШҮҮХИЙН ДАРГА НАРЫГ НАЙДВАРГҮЙ ЭТГЭЭД ХЭМЭЭН ЦОЛЛОВ

Улсын хэмжээнд өрнөсөн хилс хэлмэгдүүлэлт янз бүрийн хэлбэрээр үргэлжилж байлаа. Энэ тухай прокурор


# 1938


С.Батсүх “Ерөнхий сайд А.Амар, Шүүх яамны сайд Г.Цэрэндорж нарын хамтарсан тушаалаар зарим аймгийн прокурорыг томилолгүй үлдээж, ажлаас гэнэт халсан юм. Шүүх яамны сайд Г.Цэрэндорж Дорнод аймагт 1938 оны эцсээр очиход миний бие ажлаа танилцуулахдаа тус аймагт лам нар, буриад иргэд, албан хаагчдыг олноор нь баривчилж байгааг шүүмжилж, эргэлзэж байгаагаа ярьсанаас намайг халсан болов уу гэж санадаг байсан.

Үнэхээр ч Г.Цэрэндорж гуай 1939 оны эхээр баригдаж мөрдөгдөхдөө, миний дээрх үгийг үндэслэн прокурор С.Батсүх бол эсэргүү байгууллагын гишүүнээр элсүүлсэн гэж мэдүүлж байжээ. Тэр үед Дотоод яамны төв, орон нутгийн зарим ажилтан өөрсдийн санаа бодлоо албархан хүлээлгэх хандлага хүчтэй байсан, зарим нөхөд хүнийг заавал шийтгүүлэх гэх буюу хэргээс мултлахыг олонтаа шаарддаг байсан” хэмээн дурсжээ.

***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***

Эрүүгийн хэрэг үүсгэн явуулах тогтоолыг Аймгийн прокурор гарын үсэг зурж, тогтоолын толгой хэсэгт тэмдэг дарж баталгаажуулдаг байв. Энэ уламжлал одоо ч хадгалагдаж, “Эрүүгийн хэрэг үүсгэх тогтоол”-ыг прокурор баталдаг юм.





Тухайн үед хэргийн газрын үзлэгийг хийхдээ бодит байдлыг дүрслэн үзүүлэх хэлбэрээр хийдэг байсан нь одоо ч уламжлагдан хийгдэж байна. Зурагт хэргийн газар дахь хохирогчийн цогцсыг сумын төвөөс хэдэн км зайд ямар байдалтай байсныг бодит байдлаар зурж үзүүлсэн нь өнөөг хүртэл хэрэгт хадгалагдан үлджээ. Хэргийн газрын үзлэгийн зургийг нэхэмжлэгч, хохирогчоор өөрөөр нь зуруулж авдаг байсан байна.

# 1939

2 сарын 8. МАХН-ын Төв хорооны Тэргүүлэгчдийн 53 дугаар тогтоолд Улсын прокурорын байгууллагын орон тоо, аппаратыг өргөтгөн, хүчин чадлыг нэмэгдүүлэх тухай заалт батлагдав.

2 сарын 28. СнЗ-ийн хурлаар прокурорын газрыг Шүүх явдлын яамны харьяаллаас, аймаг, хотын ба Улаан цэргийн прокурорын газруудыг харьяалах шүүхээс нь тусгаарлан байгуулах тогтоол гаргав.

3 сарын 7. Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн тогтоолд хүнийг баривчлахад хуулийг хатуу баримтлан прокурорын зөвшөөрөл, шүүхийн тогтоолоор гүйцэтгэж байх, үүнийг зөрчсөн этгээдийг эрх хэмжээ хэтрүүлсэн гэж үзэж шүүхэд шилжүүлж байх, хүнийг баривчлахад бүрэн дүүрэн үндэс бүхий баримтад тулгуурлахыг заав.

6 сарын 9. СнЗ-ийн 17 дугаар тогтоолоор Хязгаарын цэргийн прокурорыг байгуулж, Улсын прокурорын орлогч хавсран ажиллах болов.

## ПРОКУРОР БИЕ ДААЖ, ЭД ХОГШИЛТОЙ БОЛЛОО

МАХН-ын Төв хорооны Тэрүүлэгчдийн 53 дугаар тогтоолд “Прокурорын газрууд нь тус улсын хэмжээнд хувьсгалт хуулийг сахин хамгаалах, ёсчлон биелүүлэх ба гэмт явдлыг урьдчилан сэргийлж, тэмцэх онц хариуцлагыг нам, засгийн өмнө хүлээсэн чухал байгууллага” хэмээн тэмдэглээд “Улсын прокурорын газрыг Шүүх явдлын яамны харьяанаас гаргаж, Улсын прокурорын эзэлбэл зохих байр суурийг эзэмшүүлэн Засгийн хуулийг төв орон нутгийн байгууллагаас хэрхэн нэг мөр журмаар биелүүлж байгаа эсэхийг хянах үүргийг хангах, орон нутгийн прокурорын удирдах нөлөөг чангатгах, Улсын прокурорын орон тоо, аппаратыг өргөтгөн хүчин чадлыг нэмэгдүүлэн явуулах нь чухал” гэсэн улс төрийн ач холбогдолтой заалт батлагдав.



Улмаар СнЗ-ийн 2 дугаар сарын 18-ны өдрийн XIV хурлаар БНМАУ-ын прокурорын газрыг Шүүх явдлын яамны харьяаллаас, аймаг, хотын ба Улаан цэргийн прокурорын газруудыг харьяалах шүүхээс нь тусгаарлан байгуулжээ. Ийнхүү Монгол Улсын прокурорын байгууллага орон нутгаасаа төвөө хүртэл нэгдмэл төвлөрсөн удирдлагатай, хууль ёсны биелэлтэд хяналт тавих чиг үүрэгтэй, төрийн шүүх эрх мэдлийн хүрээнд хамаарах бие даасан байгууллага боллоо.

Үүнтэй холбогдуулан Шүүх явдлын яамны сайд Г.Цэрэндорж 2 дугаар сарын 23-ны өдрийн 9 дүгээр тушаал гарган доорхи эд хогшлыг прокурорын газарт хуваарилжээ.

Архивын баримтад дурдсанаар “Улаанбаатар хотын 5 дугаар хорооны 17 тоотын 6000 төгрөгийн үнэтэй хашаа, байшин, Хотын шүүхийн баруун хойд талд байгаа 3890 төгрөгийн үнэтэй гурван тасалгаа бүхий хашаа байшин, 1445 төгрөгийн үнэтэй хоёр машин багтах шавар гарааш,

# 1939

13000 төгрөгийн үнэтэй Америк хуучин хар өнгийн Форд машин нэг, долоон ханатай бүрэн хэрэглэлтэй 2117 төгрөгийн үнэтэй гэр нэг, 3335 төгрөгийн ширээ, сандал, 20591 төгрөгийн үнэтэй бас бус хэрэглэл, эд хогшлыг Улсын прокурорын газарт олгон шийдвэрлэжээ.

Түүнчлэн орон нутгийн прокурорын байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан 60-ыг 20591 төгрөгийн эд хөрөнгөтэйгөөр бие даасан шинэ бүтцэд шилжүүллээ. Ийнхүү прокурорын байгууллагыг Шүүх яамнаас тусгаарлан онцлон байгуулсан үед "Прокурорын байгууллагын боловсон хүчнийг сургах, мэргэжилтэн бэлтгэхэд ЗХУ-ын прокурорын хууль цаазын мэргэжилтэн, Шүүх явдлын яамны зөвлөх



Пришкин, П.Т.Колопов, М.Г.Килимиков, Э.К.Сетинсон, Г.М.Крицин нар БНМАУ-д тус тус ажиллаж, Шүүх явдлын яамны дэргэд түр сургууль, курс байгуулан боловсон хүчин бэлтгэх, боловсронгуй болгоход ихээхэн хувь нэмэр оруулсан байна.

Шүүх яамны дэргэд Улсын прокурорын газартай хамтарч ажлын зөвлөгөөнийг сар тутам хоёроос доошгүй тогтмолоор хийж байхаар тогтож, Улсын прокурор, Цэргийн прокурор, Дээд шүүхийн дарга, гишүүд, хотын шүүх, прокурорын дарга нарыг томилогдсон аймгуудын шүүхийн дарга, прокуроруудын хамтаар оролцуулах болжээ.

Энэ үед БНМАУ-ын Прокуророор Сэрээтэрийн Пунцагдорж ажиллаж байлаа.

-Прокурорын байгууллага 1939 оноос Цагдан сэргийлэхийн мөрдсөн хэргүүдийг хянаж батлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцдаг болов.

-Шүүх, прокурорын ажилтнуудыг зохих дээд байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөр газар шилжүүлэхийг зогсоов.

- Прокурорын байгууллагын зохион байгуулалт, төсөв, контор, унаа хүчний талаар танилцуулж байх зорилгоор намын хороодын тэргүүлэгчдийн хуралд прокуроруудыг оролцуулж байхаар болов.

-Улаанбаатар хотын прокуророор С.Батсүх, Булган аймгийн прокуророор Н.Дагвадорж, Дорноговьд Г.Дамдинсүрэн, Завханд Л.Цогт, Өвөрхангайд Ж.Банзрагч, Төв аймагт У.Магсар, Увсад Б.Дагва, О.Батчулуун, Хөвсгөлд Д.Жадамба, Б.Дагважамц нар аймгийн прокуророор тус тус ажиллаж эхлэв.

# 1939

## УЛААН ЦЭРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫГ ШҮҮХЭЭС ТУСГААРЛАВ

1931-1932 онд Шүүх яамны орлогч сайдын хавсран гүйцэтгэж байсан Цэргийн прокурорын чиг үүрэг өөрчлөгдлөө.

Улс орны зүүн хязгаар, Халхын голд харийн дайснууд өнгөлзөж, зэвсэгт мөргөлдөөнүүд сүүлийн жилүүдэд тасрахаа байсан, улмаар Дэлхийн 2 дугаар дайны эхлэл гэж тооцогдох болсон Халхын голын дайн энэхүү 1939 онд болох нь нэгэнт тодорхой болоод байлаа.

Тиймээс БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын зөвлөлийн 1939 оны 4 дүгээр хурлаар Улаан цэргийн прокурорын газрыг харьяа шүүхээс нь тусгаарлан байгуулжээ. Улмаар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 6 дугаар сарын 9-ний өдрийн тогтоолоор Хязгаарын цэргийн прокурорын газрыг Дотоод яамны мөрдөн байцаалт хариуцсан Улсын прокурорын орлогч хавсран ажиллахаар шинээр байгуулав. Ингэснээр дайны цагийн он жилүүдэд цэргийн прокурорын байгууллага нь харьяандаа Баянтүмэнд байрлалтай Зүүн хязгаарын цэргийн прокурорын газар, Ховдод байрлалтай Баруун хязгаарын цэргийн прокурор хэмээн хоёр салбар газартай үйл ажиллагаа явуулж байв. Цэргийн прокурорыг дөрвөн жилийн хугацаатай томилох, мөн шилжүүлэх ажлаас халах явдлыг гагцхүү Улсын Ерөнхий прокуророос гүйцэтгэх болов.

## АРЫН ХАНГАЙД ПРОКУРОРЫН ГАЗАР ҮҮДЭЭ НЭЭВ

Улсын Бага хурлын Тэргүүлэгчид, Сайд нарын Зөвлөлийн шийдвэрээр Архангай аймагт прокурорын газар байгуулж, аймгийн прокурор, мөрдөн байцаагч, нарийн бичгийн



# 1939

дарга бөгөөд данс хөтлөгч, бичээч, галчийн орон тоотой, 14,8 мянган төгрөгийн төсөвтэй ажиллуулж эхлэв.

Аймгийн анхны прокуророор Г.Дамдинсүрэн, мөрдөн байцаагч туслах прокуророор Р.Өлзийбуян нар ажиллав.

## ПРОКУРОРУУДЫГ ДОТООД, ГАДААДАД БЭЛТГЭЖ ЭХЛЭВ


МАХН-ын Төв хорооны 2-р сарын 8-ны өдрийн 53 дугаар тогтоолд заасанчлан ЗХУын Хууль цаазын дээд сургуульд энэ оноос эхлэн мэргэжлийн прокурорууд бэлдэх зорилгоор прокурорын ажилтнуудаас сонгон суралцуулж эхлэв.

Түүнчлэн Улсын Төв сургуулийн дэргэд 25 орон тоо бүхий хууль цаазын анги байгуулах шийдвэр гаргаснаар дотоод, гадаадад нэгэн зэрэг прокуроруудыг бэлтгэж эхлэв.

## ЦАГААН, УЛААН ЦЭРЭГТ ЯВСАН ЭСЭХ...

Аймаг, хотын прокуроруудын нэгдсэн зөвлөгөөний үеэр Улсын прокурорын зөвлөх Н.Ф.Махов “Хэргийн оролцогч нараас байцаалт тэмдэглэл авахдаа биеийн байцаалтад одоогийн байцаалтад тусгагддаг асуултуудаас гадна нийгмийн гарал угсаа, хөрөнгө хогшил, гишүүнчлэл, цагааны ба эсэргүү хөдөлгөөн, улаан цэрэгт явсан, хугацаа дуусгасан эсэх, сонгуулийн эрхтэй эсэх, хийд шашны газраа хэд хичнээн жил ямар үүрэг тушаал хүлээж явсан, хэрэв лам бол хэд хичнээн шавьтай болох, гүрэмч төлөгч, зурхайч эсэх” зэргийг нарийвчлан тусгах талаар шаардлага тавьж байжээ.

***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***



Дээр дурдсан Б.Жамбалдорж, Н.Ф.Махов нарын зөвлөж байсан хэргийн оролцогч нараас байцаалт тэмдэглэл авахад бөглөх бичиг

# 1939

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

**Цэргийн байгууллага дотор анхан шатны байцаалтыг явуулах этгээдийг прокуророос хянах заавар**

Агуулга нь,

-Цэргийн байгууллага дотор анхан шатны байцаалтыг явуулах этгээдийг цэргийн прокурор ба цэргийн байцаагч нараас хэрхэн удирдах ба хянан загварлах тухай


-Цэргийн прокуророос өөрийн байцаагч-даа анхан шатны байцаалтыг явуулах этгээдийг удирдах ба хянан зааварлах явдалд дүүрэн эрхийг олгох буюу эсвэл хагас эрхийг олгомой.


-Цэргийн байцаагчаас анхан шатны байцаалтыг явуулах этгээдийг удирдах ба хянан шийдвэрлэхдээ харьяа прокурорт дүүрэн захирагдаж сануулга дагалтыг гүйцэтгэдэг болгомой.

-Цэргийн прокурорын байцаагч нараас даалгаж сануулсан зүйлийг анхан шатны байцаалтыг явуулах этгээдээс эрх биш гүйцэтгэх үүргийг хүлээмой.

-Гагцхүү анхан шатны байцаалтыг явуулах этгээдээс эрхбиш цэргийн байцаагчаас даалгаж сануулсан үүргийг зөвшөөрөхгүйгээр хэрхэх саналыг цэргийн прокуророос лавлаж болох бөгөөд цэргийн прокурорын таслаж өгсөн саналыг шууд гүйцэтгэх үүргийг хүлээмой.

-Хэдий тийм боловч уг зөвшөөрөхгүй саналыг цэргийн прокуророос асуусан зүйлийн хариуг хүлээж байцаагчийн даалгасан зүйлийг орхигдуулахгүй.








# ХОЁРДУГААР БҮЛЭГ: 1940-1949 ОН




# 1940

6 сарын 30. Улсын VIII Их хурлаар прокурорын байгууллагын статусыг Үндсэн хуулиар баталгаажуулав.

7 сарын 10. Улсын Бага хурлын тэргүүлэгчдийн 35 дугаар тогтоолоор БНМАУ-ын прокурор Ж.Банзрагчийг Алтан гадас одонгоор шагнажээ.

8 сарын 15. Шүүх явдлын яамны сайдын 58 дугаар тушаалаар гадаадад хууль цаазын сургуульд суралцагсдын зардлыг шийдвэрлэжээ.

10 сарын 1. БНМАУ-ын прокурорын 50 тоот тушаалаар Баян-Өлгий аймгийн прокурорын газрыг байгуулжээ.

11 сарын 25. Шүүх явдлын яамны сайдын 74 дүгээр тушаалаар Шүүх, Прокурорын бүх ажилтнуудыг шинэ үсэгт сургахыг үүрэг болгов.

12 сарын 5. Говь-Алтай аймгийн прокурорын газрыг байгуулжээ.

## ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ҮНДСЭН ХУУЛИАР БАТАЛГААЖУУЛАВ



Үндсэн хууль боловсруулах комиссын хуралдаан...

Улсын VIII Их хурлаар шинэ Үндсэн хуулийг батлан гаргахдаа Прокурорын байгууллагын эрхзүйн байдлыг анх удаа хуульчилж “Шүүх ба прокурорын газар” гэсэн 7 дугаар бүлэг нэмж оруулжээ. Уг хуулийн 57 дугаар зүйлд “Бүх яамд ба төв, орон нутгийн албан байгууллагууд хийгээд тэдгээрийн харьяат газрууд мөн албан тушаалын хүмүүс ба ард нийтээс хууль цаазыг нарийнаар биелүүлж байгаа явдлыг байцаан хянах үүргийг Улсын прокурор /хууль сахиулагч/ гүйцэтгэнэ” гэж хуульчлан тодорхойлжээ.

## ШИНЭ ҮСЭГ СУРГАХЫГ ҮҮРЭГДЭВ

Шүүх явдлын яамны 74 дүгээр тушаалаар Шүүх, прокурорын бүх ажилтнуудыг шинэ үсэгт сурахыг үүрэг болгож долоо хоногийн лхагва, пүрэв гаригт 08.00-16.40 цаг хүртэл нэгдсэн хичээлд суулгах болжээ.

Гавьяат хуульч С.Батсүх тэр үеийн прокурорууд сайндаа хэдэн сарын курст суралцсан бичиг үсэгтэй хүмүүс боловч нам, ард түмнийхээ үйл хэргийн төлөө чин үнэнчээр зүтгэж, шинжлэх ухаан, техникийн хэрэгсэл нэвтрээгүй ч бүхий л арга ухааныг сүвэгчлэн өдөр шөнийг үл хайхран явган, морьтой цуцалтгүй хөөцөлдөж, ээдрээтэй хэргийн үнэн зөвийг тунгааж явсан тухай дурсчээ.

# 1940

## АЛС АЛТАЙД ПРОКУРОРЫН ХЯНАЛТ ХҮРЭВ

Говь-Алтай аймаг Завхан аймгаас тасран байгуулагдсанаар аймгийн прокурорын газар нь анх жинхэнэ прокурор, туслах прокурор, байцаагч, бичээч, нарийн бичгийн дарга, галч зарлага гэсэн долоон орон тоотой, гурван эсгий гэр, 30800 төгрөгийн төсөв хөрөнгөтэй байгуулагджээ. Аймгийн анхны прокуророор Д.Буянт 1940-1941 онд ажиллаж байв.

## БАЯН-ӨЛГИЙД ПРОКУРОРЫН ГАЗАР ТӨВХНӨВ

Баян-Өлгий аймаг байгуулагдсантай холбогдуулан БНМАУ-ын прокурорын 50 тоот тушаалаар аймгийн прокурорын газрыг аймгийн прокурор, хэсгийн байцаагч, нарийн бичгийн дарга, зарлага зэрэг зургаан орон тоотой анх байгуулжээ. Тус аймгийн анхны прокуророор С.Дашжав 1940-1941 онд ажилласан байна.

## ГАДААДАД СУРАЛЦАГЧДАД ЗАРДАЛ ОЛГОВ

ШЯЯ-ны сайдын 58 дугаар тушаалаар тус яамнаас гадаадад хууль цаазын сургуульд суралцах болсон Уртнасангийн зардалд 633 төгрөг 33 мөнгийг Улаан-Үд хотод гуйвуулах, Гэсэржав, Чунгууд нарын Улаан-Үд хүрэх зардалд 598 төгрөг 67 мөнгийг өөрт нь олгож Улаан-Үдээс Москва хүртэл зардал 768 төгрөг тус тус олгохоор заажээ.

-Прокурорын байгууллага Шүүх яамны харьяанаас бүрэн гарч, төвлөрсөн, нэгдмэл системтэй, бие даасан төрийн байгууллага болов.

-БНМАУ-ын прокуророор Жигжжавын Банзрагч 1940-1946 онд ажиллажээ.

-БНМАУ-ын Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиуд батлагдсан нь прокурорын хяналтыг өндөржүүлэв.

-БНМАУ-ын прокурорыг Улсын Бага хурлаас 5 жилийн хугацаагаар, хот, аймаг, сум, багийн хэмжээн дээр прокурорын байцаан хянах явдлыг БНМАУ-ын прокуророос 4 жилийн хугацаагаар томилогдсон хот, аймгийн прокурорууд биелүүлнэ гэж тэдгээрийн бүрэн эрхийн хугацааг хуульчлав.

# 1940

## БНМАУ-ЫН ПРОКУРОР ЖИГЖЖАВЫН БАНЗРАГЧ



1940-1946 онд БНМАУ-ын Ерөнхий прокуророор ажиллаж байсан Жигжжавын Банзрагч нь 1905 онд Архангай аймгийн Булган суманд төржээ.

Тэрбээр Улсын прокурорын нэр хүндтэй хариуцлагатай албыг хашиж байхдаа Улсын Бага хурлын гишүүнээр сонгогдож, Алтан гадас одонгоор шагнуулж байжээ.

Хачирхалтай нь Улсын прокуророор долоон жил ажилласан хүний намтар түүхийн ямар нэгэн учир тохиолоор архивт хадгалагдаж үлдсэнгүй.

## УЛСЫН БАГА ХУРАЛД СОНГОГДСОН ПРОКУРОРУУД

1940 онд Улсын прокурор Ж.Банзрагч, Улсын прокурорын орлогч Б.Дагважамц, Увс аймгийн прокурор Х.Цэрэндорж, Ховд аймгийн прокурор О.Чулуун нар Улсын Бага хурлын гишүүнээр сонгогдсон нь байгуулагдаад удаагүй прокурорын



байгууллагын нэр хүнд мэдэгдэхүйц өссөний баримт юм гэж Монгол Улсын Гавьяат хуульч О.Лхамсүрэн тэмдэглэсэн байдаг.

## УЛСЫН ГАВЬЯАНЫ ОДОНТ ПРОКУРОР

1940 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн Улсын Бага хурлын тэргүүлэгчдийн 35 дугаар тогтоолоор Үндэсний хувьсгалын 19 жилийн ой ба шинэ Үндсэн хууль батлагдсан хийгээд цэрэг ба ардын хувьсгалын их баярыг тохиолдуулан тус улсын тусгаар тогтносон бүрэн эрхтэй байдлаа бататган бэхжүүлэх ба соёл боловсрол, аж ахуй үйлдвэр, худалдаа зэргийг хөгжүүлэх ажил хэрэгт чин үнэн сэтгэлээр чармайн зүтгэсэн Улсын прокурор Ж.Банзрагч, Цэргийн явдлын яамны 5 дугаар дивизийн их бууны дарга Гончиг нарын ажлын амжилтыг тэмдэглэж Улсын гавьяаны 1 дүгээр зэргийн Алтан гадас одонгоор сайшаан шагнажээ.

# 1940

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

Хожим 1940 онд баталсан Үндсэн хуулийн 7 дугаар бүлэгт Шүүх ба прокурорын газрын тухай ийн зүйлчилсэн заалт оруулсан байна.

*...49 дүгээр зүйл.*

Дээд шүүх таслах газраас нь улсын прокуророос хянан таслуулахаар шилжүүлсэн ихээхэн чухал хэргүүдийг хянан шийтгэх бөгөөд мөн шүүхийн доод байгууллагуудаар таслагдсан хэргийг гомдол ба эсэргүүцлийг баримталж өөрчлөх ба байцаан хянах журмаар тасалмуй.

*50 дугаар зүйл.*

Бүх яамд ба төв орон нутгийн албан байгууллагууд хийгээд тэдгээрийн харьяат газрууд, мөн албан тушаалын хүмүүс ба ард нийтээс хууль цаазыг нарийнаар биелүүлж буй явдлыг байцаан хянах туйлын үүргийг Улсын прокурор (хууль сахигч) хүлээмүй.

*51 дүгээр зүйл.*

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын прокурорыг Улсын Бага хурлаас 5 жилийн хугацаагаар томилмуй.

*52 дугаар зүйл.*


Хот. аймаг, сум, багийн хэмжээн дээр прокурорын байцаан хянах явдлыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын прокуророос 4 жилийн хугацаагаар томилсон хот, аймгийн прокуророос биелүүлмүй.

*53 дугаар зүйл.*

Орон нутаг дахь прокурорууд өөрийн ажлыг орон нутгийн ямар ч байгууллагад захирагдахгүй явуулах бөгөөд гагцхүү Улсын прокурорт захирагдмуй.

*54 дүгээр зүйл.*

Хэргийг таслахдаа монгол хэл дээр буюу эсхүл үндэсний хэл дээр энэхүү хэлийг үл мэдэх хүмүүст уг хэргийн материалыг



хэлмэрчээр дамжуулан бүрнээ таниулж таслах явдлыг хангах бөгөөд мөн шүүх таслах хурал дээр Үндсэн хэл дээр хэлэх эрхтэй баймуй.

# 1941

**1 сарын 8.** Улсын Дээд Шүүх, Улсын прокуророос Баян-Өлгий, Архангай, Өвөрхангай, Сэлэнгэ, Дорноговь, Говь- Алтай, Увс, Ховд, Өмнөговь аймгийн Шүүх прокурорын ажлыг шалгаж дүгнэлт гаргалаа.

**2 сарын 22.** Өмнөх онд нь улс төрийн хэрэгт татан баривчилсан Улсын прокурор С.Пунцагдоржийг Тусгай шүүхээс хуулийн дээд хэмжээгээр шийтгэж, өөрөө амь хэлтрүүлэхийг гуйсныг нь хэрэгсэхгүй болгон шүүхийн тогтоолыг хэвээр баталжээ.

**5 сарын 5.** Улсын прокурорын 28 тоот тушаалаар Хязгаарын цэргийн прокурорын газрыг байгуулж, хууль сахиулагчаар нь Дугарыг анх томилжээ.

**6 сард.** Улсын Дээд Шүүх, прокурорын тушаалаар аймгийн Шүүх, Прокурорын ажлыг шалгах зааварчилгааг батлав.

**7 сарын 30.** Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 46 дугаар тогтоолоор “БНМАУ-ын прокурорын байгууллагын дүрэм” (гурав дахь)-ийг шинэчлэн батлав.

## БҮХНИЙГ ЯЛАЛТЫН ТӨЛӨӨ

Дэлхийн 2 дугаар дайн эхэлсэнтэй холбоотойгоор Зөвлөлтийн армид зориулан “Бүхнийг фронтод, бүхнийг ялалтын төлөө” уриан дор хөрөнгө хуримтлуулах ардын хөдөлгөөн өрнөж эхлэв.



Нам, төр, олон нийтийн байгууллагуудын бүх ажил энэ хөдөлгөөнд чиглэгдэж, Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 15 дугаар тогтоолоор ардын аж ахуйтнууд улсад мах, өөх тос албан журмаар нийлүүлэх, улсын ачаа тээврийг ардын аж ахуйтны ердийн хөсгөөр заавал тээвэрлүүлэх, ард иргэдээс цэргийн алба хаах зэрэг олон шинэ хуулиуд батлагдаж, энэ хэрээр прокурорын байгууллагын хяналтын цар хүрээ нэмэгдсэн байна.

Зөвлөлтийн армид бэлэг тусламж хуримтлуулах, агт морьд бэлтгэхэд орон нутгийн шүүх, прокурорууд биечлэн оролцож байжээ.

# 1941

## АДУУ МАЛААС АГУУЛАХАД БУЙ БАРААНЫ ХАДГАЛАЛТ ХҮРТЭЛ...

Шинэчлэн баталсан “БНМАУ-ын прокурорын байгууллагын дүрэм”-ээр прокурорын эрх, үүргийг өргөжүүлж, прокурорын байгууллагын тогтолцоо, прокурорыг томилох, чөлөөлөх журам, БНМАУ-ын прокурор, түүний орлогч, туслах прокурорын эрх, үүрэг, аймаг, хот, цэргийн прокурорын эрх, үүрэг, прокурорын мөрдөн байцаагчийн эрх, үүргийг тус тусад нь тодорхойлж, ажлаа тайлагнах зарчим, журмыг тогтоосон бөгөөд БНМАУ-ын Прокурорыг Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор 5 жил, Улсын Прокурорын орлогч, туслах прокурорыг Улсын прокуророос 5 жилийн хугацаагаар томилж, Улсын Бага хурлын Тэргүүлэгчдээс баталдаг болжээ. Аймаг, хот, цэргийн прокуророууд, тэдгээрийн туслах прокурорыг 4 жилийн хугацаатай томилох, шилжүүлэх явдлыг гагцхүү Улсын прокуророос гүйцэтгэж байхаар тогтоосон.

Уг дүрэмд улсын бүх байгууллага, албан тушаалтан, ард иргэд хуулийг хэрхэн чанд биелүүлж байгаад тавих хяналтыг ерөнхий хяналт, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд тавих хяналтыг тусгай хяналтын чиглэлээр тогтоожээ.

## 25300 ТӨГРӨГИЙН ТӨСӨВТЭЙГӨӨР АЖИЛЛАЖ ЭХЛЭВ

Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1941 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор Баянхонгор аймаг анх байгуулагдахад нэг гэр контортой, аймгийн прокурор 1, туслах прокурор 1, мөрдөн байцаагч 2, нарийн бичгийн дарга 1 орон тоотойгоор байгуулав.

Шинэ газар 25.3 мянган төгрөгийн төсөвтэйгөөр үйл ажиллагаагаа эхэлжээ. Аймгийн анхны прокурор Б.Ламжав, туслах прокурор Дүгэрнямаа, Б.Даваасамбуу, мөрдөн байцаагч Ц.Бадарч, Б.Дашзэвэг, З.Сандаг, жолооч Д.Шарав, Ж.Содной, галч Баасанхүү нар нь тус газрын анхдагчид болжээ.

**8 сарын 28.** Шүүх явдлын яамны сайдаар ажиллаж байхдаа БНМАУ-ын анхны прокурорын албыг давхар хашсан Л.Дэндэвийг Шинжлэх ухааны хүрээлэнгийн даргаар ажиллаж байхад нь Дотоод явдлын яамнаас улс төрийн хилс хэргээр баривчлав.

**12 сарын 11.** Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Архангай, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн 16 сумыг нийлүүлэн Баянхонгор аймаг байгуулахад прокурорын газрыг хамтатган нээв.

-Улаан цэргийн прокурорын газрыг Монгол ардын хувьсгалт цэргийн прокурорын газар хэмээн нэрийдэв. Хязгаарын ба Дотоодын цэргийн прокурорын газрууд байгуулагдав.

-Б.Сүхээ Баян-Өлгийд, Л.Гүрсэд Булганд, Н.Гончиг Говь-Алтайд, Самбуу Өвөрхангайд, Д.Балсанпунцаг Өмнөговьд, Д.Буянт Хөвсгөлд, Лхамсүрэн Хэнтий аймагт тус тус аймгийн прокуророор ажиллаж эхлэв.

-Гавьяат хуульч Д.Очирхуяг прокурорын байгууллагад мөрдөн байцаагчаар ажиллаж эхлэв.

# 1942

**2 сарын 24.** Гэмт хэрэгтэнд хүч хэрэглэхийг Дотоод явдлын яамны удирдлагад зөвшөөрсөн Улс төрийн Товчооны нууц тогтоол хэрэгжиж эхлэв.

**3 сарын 1.** Дундговь, Сүхбаатар аймагт прокурорын газар байгуулав.

**7 сард.** Улсын прокурорын газраас Төв засан сайжруулах газрын харьяа бүх хорих газруудын ажлыг шалган Шүүх явдлын яамны сайдад танилцуулжээ.

-Улсын Дээд шүүхийн эрүү, иргэний коллегид Улсын прокурор 195 эсэргүүцэл бичжээ.

-Гавьяат хуульч О.Лхамсүрэн Увс аймгийн прокурорт мөрдөн байцаагчаар ажлын гараагаа эхлэв.

-Шүүх цаазын бичгийг шинэчлэн баталснаар БНМАУ-ын Улсын VIII Их хурлаас Эрүүгийн анхны хууль батлагдав. Энэ хууль нь 8 бүлэг 54 зүйлтэй ерөнхий, 11 бүлэг 255 зүйлтэй тусгай гэсэн хоёр ангитай батлагдаж байв.

## ЦЭРГИЙН БЭЛТГЭЛИЙН ЯВЦ, ДАЙЧИЛГААГ ХЯНАХ БОЛЛОО

2 дугаар сард МАХН-ын Төв хороо, Сайд нарын Зөвлөлөөс нийт хүн амыг цэргийн анхан шатны бэлтгэлтэй болгох тухай тогтоол гаргажээ.



Тогтоол ёсоор хот, аймаг, сумын төв, албан үйлдвэрийн газар, сангийн аж ахуй, сургуулиудад Улсыг батлан хамгаалах зөвлөлийн шугамаар сургалтын төвүүд байгуулагдав.

Ардын Сайд нарын Зөвлөлийн шийдвэрийн дагуу 1942 оны 12 дугаар сараас эхлэн хот, хөдөөд эрхэлсэн тодорхой ажилгүй 18-45 насны хүмүүсийг үйлдвэр, барилга, тээвэр, Сангийн аж ахуйд тодорхой хугацаагаар дайчлан ажиллуулах болов.

## АШИГЛАЛ, МАЛЫН ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ БАЙЛАА

Намсрайн Гончигцэрэн “Би Төв аймгийн ес дэх прокуророор 1942 оны 2 дугаар сараас 1943 оны 12 дугаар сар хүртэл ажиллаж байсан. Энэ үед аймгийн прокурор нь зарим өдөр 100 шахам хэрэгтэй, нэг байцаагч 40 хэрэг мөрдөх өдөр олон байв. Манай прокурорын хамт олны ажиллаж байсан арга бол ард зонтой өдөр

# 1942

-Шүүх таслах газар харьяалагдаж байсан мөрдөн байцаах аппаратыг прокурорт шилжүүлэв.

-Н.Гончигцэрэн Төв, Чулуун Баян-Өлгийд, Б.Ламжав Баянхонгорт, Г.Дамдинсүрэн Дундговьд, Д.Бямбаа Сүхбаатарт, Н.Гончигсүрэн Төв, О.Жамбал Увс аймагт тус тус томилогдон ажиллаж эхлэв.

-Европ он тооллыг хэрэглэж эхлэв.

тутмын холбоотой байж, тэднээс ажиж сэдсэн зүйлд зохих хэмжээгээр түшиглэдэг байсан. Тухайлбал, Угтаалцайдам сумын хоршооны ня-бо Базар данс баримтыг мэдэгдэх аргагүйгээр засаж 30 гаруй мянган төгрөг ашигласан, аймгийн захиргааны ажилтан Нордов чек хулгайлж 15000 төгрөгийг шамшигдуулсан, Баянбараат сумын адуучин Пүрэв бусдыг уруу татаж 100 гаруй бод мал хулгайлсан, цэрэгт яваад 17 жил оргосон “ногоон” хэмээх Пүрэв 175 бод мал хулгайлсан зэрэг ноцтой хэргүүд илэрч шийтгэгдэж байлаа” гэжээ.

## ДУНДГОВЬ, СҮХБААТАРТ ПРОКУРОРЫН ГАЗАР БАЙГУУЛАВ

Дундговь аймгийн прокурорын газрыг 3 дугаар сарын 1-ний өдөр үүсгэн байгуулж, прокуророор нь Г.Дамдинсүрэнг томилон удирдлагад нь туслах прокурор, ахлах мөрдөн байцаагч, мөрдөн байцаагч, нарийн бичгийн дарга, галч цэвэрлэгчийн орон тоо батлажээ.

Мөрдөн байцаагч Дэмбэрэл, Батбуян, Үржин, нарийн бичгийн дарга Тогоо, зарлага-галч Долгор нарын ажилтнууд хоёр эсгий гэрт конторлон “Аливаа хянан байцаах эрх



Аймаг, хотын шүүхийн дарга, прокуроруудын зөвлөгөөн

# 1942


хэмжээг хэрэгжүүлэх” ажилдаа шамдан оржээ. Жавхлант шарга аймаг нэртэйгээр анх байгуулагдсан Сүхбаатар аймагт прокурорын газар мөн оны 3-р сарын 1-ний өдөр 12 ажилтны орон тоотой албан хэргээ эхэлж, Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1943 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Аймгийн прокурор гэж нэрлэгдэх болж бичгийн нүүр, тамга нь аймгийнхаа нэрээр нэрлэгджээ.

## ТЭМЭЭН ХӨСӨГ АЧААЛАН НҮҮДЭЛЛЭЖЭЭ

Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 12 дугаар тогтоолоор Төв аймаг Улаанбаатар хотоос нүүж Богд Дүнжингарав уулын өвөр өдгөөгийн Зуунмодны аманд төвлөрөхөд аймгийн прокурорын газар тэмээн хөсөг ачаалан нүүдэллэж шинэ нутагтаа төвхнөжээ.



***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***



Эрхэлсэн ажилдаа хайнга хандсан хэрэгт шүүх цаазны бичгийн 96 дугаар зүйлд зааснаар ял төлөвлөсөн “Ялын төлөвлөгөө” буюу одоогийн “Яллах дүгнэлт”

# 1943

## ДОТООД ЯВДЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЯНАНА

МАХН-ын Төв хорооны Тэргүүлэгчдийн 22 дугаар хурлаас БНМАУ-ын Үндсэн хууль, прокурорын хяналтын дүрмийн шаардлагаас үндэслэн прокурорын байгууллагын ажлыг үндсээр нь сайжруулах зорилгоор прокурорын эрх, үүргийг өргөтгөсөн тогтоол гаргав. Үүний дагуу Дотоод явдлын яамны мөрдөн байцаалтын ба хорих, мөрдөх ажилд тавих хяналтыг сайжруулах, прокурорын орон тоог өргөтгөх ба боловсон хүчнээр хангах, намын байгууллагаас прокурорын ажилд туслах явдлыг сайжруулахаар энэ тогтоолд заажээ. Түүнчлэн аймаг, хотын намын хорооны хуралд прокурорыг суулгаж байх, иргэдийн өргөдөл гомдлыг түргэн шуурхай барагдуулж, хүнд суртал гаргагчдад хатуу арга хэмжээ авч байхыг даалгасан байна.

## ӨР, АВЛАГА, ЦУУРХАЛ ГЭХ МЭТ ХЭРГЭЭР ХУУЛИЙГ БУРУУ ХЭРЭГЛЭХИЙГ ТАСЛАН ЗОГСООВ

Сум, хороодын өргөтгөсөн эрхийг зогсоож, эрүү, иргэний бүх хэргийг аймаг, хотын шүүх, прокурорын байгууллага харьяалан эрхэлж эхэлсэн 1943 он прокурорын байгууллагын түүхэнд чухал цаг үед тооцогдоно.

Нэхэн санаваас 1933 онд СнЗ-ийн тогтоолоор шүүн таслах, мөрдөн байцаах ажлыг ард түмэнд ойртуулах зорилгоор ангийн шүүх, ангийн мөрдөн байцаагч нарыг татан буулгаж, сумдын захиргааны эрхийг өргөтгөж, мөрдөн байцаах, шүүн таслах эрх олгосноор сумын захиргааны дарга дангаараа нэг сар хүртэл албадан ажил хийлгэх, 150 хүртэл төгрөгөөр торгох ял бүхий эрүүгийн хэрэг, 250 хүртэл төгрөгийн нэхэмжлэл бүхий иргэний хэрэг, сумын дарга, ардын хоёр төлөөлөгчтэйгөөр нэг жил хүртэл хорих буюу албадан ажил хийлгэх, эсвэл 1000 хүртэл төгрөгөөр торгох ял бүхий эрүүгийн хэрэг, 250-1000 хүртэл төгрөгийн нэхэмжлэл бүхий иргэний хэргийг, мөн СнЗ-ийн 1934 оны тогтоолоор Улаанбаатар хотын ангийн шүүхийг татан буулгаж, хороодын захиргаадад адил эрх олгосноор 6 сараас дээшгүй хорих ял

**3 сарын 11.** Прокуроруудыг давтан сургах хуулийн түр курс байгуулав.

**4 сарын 5.** Улсын анхны прокуророор ажиллаж байсан Л.Дэндэвийг Дотоод явдлын яамны дэргэдэх Онцгой бүрэн эрхт тусгай комиссоос 10 жилийн ялаар шийтгэв.

**8 сарын 2.** Ардын шүүх таслах газрууд ба прокурорын байгууллагын дүрмийн 5 дугаар бүлгийг өөрчлөн баталжээ.

-Сум хоорондын өргөтгөсөн эрхийг зогсоож, эрүү, иргэний бүх хэргийг аймаг, хотын шүүх, прокурорын байгууллагад харьяалав.

-Н.Намжил, Б.Самдан нар Улаанбаатар хотын прокуророор, З.Дорж Архангайд, Б.Хави Баян-Өлгийд, Д.Буянт Баянхонгорт, М.Дорж Завханд, Д.Галсанпунцаг Өвөрхангайд, Л.Цогт Өмнөговьд, Д.Лхамсүрэн Сүхбаатарт, Ж.Цагаанхүү Төв аймагт, С.Равжаа Увсад, Б.Лхамжав Хөвсгөлд, Д.Шагдарсүрэн, С.Батсүх нар Хэнтийд томилогдон аймгийн прокуророор ажиллаж эхлэв.

# 1943

бүхий эрүүгийн хэрэг, 250 хүртэл төгрөгийн нэхэмжлэл бүхий иргэний хэргийг тус тус таслан шийдвэрлэдэг болсон байв.

Жишээ нь 1936 онд эрүүгийн хэрэг 3773, үүнээс сумын дарга дангаар шийтгэсэн хэрэг 1271, ардын төлөөлөгчтэй тасалсан хэрэг 1902, сумын дарга дангаар ба ардын төлөөлөгчтэй тасалсан иргэний хэрэг 3093-ыг шийдвэрлэж байжээ. Гэвч хууль цаазын мэргэжил, шүүх, мөрдөн байцаах ажлын дадлага туршлагагүйгээс орон нутгийн захиргаад хуулийг зөв биелүүлэх явдалд




ноцтой алдаа дутагдал гаргаж байлаа. Тухайлбал, “60 төгрөгийн өрийг өгсөнгүй удаашруулав” гэж авлагадаа цахиур бууг нь барьж авсан хүнийг зургаа хоног хоолгүй хорьж, 1 жил хорих ялаар шийтгэсэн, цэргийн албанд татагдсан тодорхой хүний тухай “Тэр гуай сураггүй болж, нас барсан шиг байна” гэж эхнэртээ хуучилсан хүнийг цуурхлын хэргээр шийтгэсэн байжээ. Өршөөлийн

тогтоолгүйгээр “Майн 1”-ний баяраар өршөөл үзүүлж байсан, хэрэг шийтгэх тогтоолгүйгээр амаар ял оногдуулах, давж заалдах эрх үл олгох, албадан ажил хийлгэх ялтай хүнийг сүм хийдэд дуган бариулах, хэрэгтэнд хүллэг хэрэглэх, малын эзэнд чи хөрөнгөтэй гээд хулгайчаас төлбөр үл гаргуулах зэрэг алдаа зөрчил ихээхэн гарсны дээр хоёр жилийн хугацаанд нэг ч хэрэг шийдээгүй сумын захиргаад ч байжээ. Хөдөлмөрчдийн өргөдөл гомдол, хэрэг материалыг удаашруулах, бүрдэл дутуу буюу харьяаллын бус хэргийг шийдвэрлэх, ялын бодлогыг алдагдуулж, морь хулгайлсан хэрэгтэнд 10 жил хорих ял оногдуулсан тохиолдол ч гарч байжээ.


Ийм учир шалтгаануудаас 1943 онд сум, хороодын захиргаадад шилжүүлсэн прокурорын чиг үүргүүдийг цуцалж, эрүү, иргэний бүх хэргийг аймаг, хотын шүүх, прокурорын байгууллага харьяалан эрхлэх болжээ.

# 1943

***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***



1943 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Хүн эмнэлгийн акт”. Иргэн Н.Тэгшжавын биед хөнгөн зэргийн гэмтэл учирсныг доктор тогтоожээ.



Монгол Улсын 33 дугаар он буюу 1943 онд ард Дашзэвэгийн гаргасан “Танхайн хэргийн хохирогч болсон” утга бүхий өөрийн гараар бичиж өгсөн гомдол.

# 1944

**10 сарын 21.** БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 78 дугаар хурлын тогтоолоор бүх цэргийн прокурорыг улсын прокурорын нэгэн орлогчийн эрх үүрэгтэй болгож, Улсын прокурорын орлогч бөгөөд бүх цэргийн прокуророор ажиллуулж эхэлжээ.

-Х.Бандьхүү Улаанбаатар хотын прокуророор, О.Магсар Баянхонгорт, Д.Буянт Завханд, Б.Ганжууржав Өвөрхангайд, С.Равжаа Төвд, Ж.Цагаанхүү Увсад, Д.Галсанпунцаг Хөвсгөлд тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллаж байв.

-Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Баруунхараа, Цагаантолгойд хэсгийн байцаагчийн орон тоо бий болгов.

## ХӨДӨӨГИЙН ПРОКУРОРУУД НҮҮДЭЛЛЭН АЖИЛЛАВ

Сум, хороодын захиргаадад шилжүүлсэн эрх мэдлийг 1943 онд цуцалснаар аймгийн прокурорын газар прокурор, байцаагч нэжгээд, аймгийн шүүх дарга, орлогч тус бүр нэгээс илүүгүй цомхон орон тоотой байсан боловч бүх сумдаараа морь, тэмээ, нүүдлийн хөсөг ашиглан зуу зуун хэргийн материал, өргөдөл, гомдлыг ганзагалан 60-70 хоног нүүдэллэн явж, тэдгээрийг газар дээр нь шалган бүртгэн шийдвэрлэж байжээ.

Хэргийн холбогдол бүхий хүмүүсийг очсон сумын багууд, зах залгаа сумдаас морин өртөөчдөөр зарлан дуудуулахад зарим нь нүүдлийн шүүх ирсэн сургаар зайлж олдохгүй болох нь цөөнгүйгээс хэрэг материалын зарим хагасыг шийдвэрлэн дуусгаж чадахгүй аймгийн төв рүүгээ буцааж, дараагийн нүүдэллэх ээлж хүртэл хэдэн сараар удаашруулах явдал ч гардаг үе байв. Холбоо харилцаагүйн учир холын сумдад гарсан ноцтой хэргийн тухай мэдээ бичиг өртөөгөөр хэдэн хоногт ирнэ. Түүнийг хүлээн авмагц мөн тийм хугацаагаар явж очих хүртэл уг хэрэг явдлын халуун мөр арилж, зарим гэмт хэрэг, гэмт этгээдийг цаг тухайд нь олж илрүүлж чадахгүйд хүрэх нь олонтаа тохиолдож байсан тухай ахмад прокурор С.Батсүх дурсамж номдоо тэмдэглэн үлдээжээ.



# 1944


## ЭСГИЙ ГЭРЭЭ ХАЛЖ, “ГАЗ” МАШИН УНАВ

1944 онд Дундговь аймгийн прокурорын газарт 32554 төгрөгийн төсөв батлагдаж эсгий гэр бүхий конторoо халж, тоосгоор барьсан 8 тасалгаа бүхий конторын барилгатай болж мөрдөн байцаалтын зориулалттайгаар “ГАЗ-67” маркийн суудлын машин авч албаны унаатай болон жолоочоор Б.Жанчив гэгч хүн ажиллаж байжээ.

## ӨДӨР ШӨНӨ ЯЛГАЛГҮЙ...

1944 оны үед ажлын хариуцлага, шаардлага өндөрт тавигдсан хатуу цаг. Прокурорууд ажлаа өдрийн 8 цагаар хязгаарлахгүй, шөнийн цагт буюу амралтын үед ч ажлаа хийж албан дээрээ тогтмол конторлох нь нийт байгууллага, нэн ялангуяа прокурорын байгууллага дээр бүр ч илүүтэй байсныг ахмад прокурорууд хуучилсан байдаг.

***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***



Хэнтий аймгийн прокурор Батсүхийн баталж, байцаагч Ширнэнгийн үйлдсэн 1944 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн “Ял сонсгох тогтоол”. “Хэнтийн хүнсний комбинатын складнаас 626 төгрөгийн чихэр, боовыг бүлэглэн хулгайлсан хэрэгт эрүүгийн хуулийн тусгай ангийн 173 дугаар зүйлийн 5-д зааснаар яллагдах болно” хэмээжээ.



# 1945

12 сарын 17. БНМАУ-ын Бага Хурлын тэргүүлэгчдийн 113 дугаар хурлын тогтоолоор “БНМАУ-ын Прокурорын байгууллагын дүрэм”-ийг баталж, бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт оруулан, Улсын прокурорт орлогч, туслах прокуроруудын орон тоог шинээр нэмэв.

-Улсын прокуророор Жигжжавын Банзрагч улиран томилогдов.

-Дорнод аймгийн прокурорын газарт мөрдөн байцаалтын туслах прокурорын орон тоо шинээр батлагдав.


-Налайх дүүргийн прокуророор Н.Гомбо ажиллав.

-ЗХУ-ын хуулийн мэргэжилтэн А.П.Аргасцев Улсын прокурорын газрын зөвлөхөөр ирж ажиллав.

-Сумд харьяалсан хэсгийн байцаагчдын орон тоог бий болгож эхэллээ.

## ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД ЦЭРГИЙН ПРОКУРОР ОРОЛЦОВ

Дэлхийн 2 дугаар дайнд ЗХУ болон Холбоотнууд фашист Германыг буулган авах нь тодорхой болж, дайны цагийн байдал эргэсэн ба 1945 оны 2 дугаар сард Ялтад хуралдсан ЗХУ, АНУ, Их Британийн удирдагчид ЗХУ-ын саналын дагуу БНМАУ-ын статусквог хэвээр байлгахаар тогтсон нь манай улсын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх шийдэл болов.



Улмаар Холбоотон гүрнүүдийнхээ өмнө хүлээсэн үүргийн дагуу Зөвлөлтийн Улаан арми Японы милитаристуудад дайн зарлаж, Алс Дорнод, Солонгосын хойг, Манжуур, Хятадын нутагт нэгэн зэрэг давшин оров. Үүнтэй зэрэгцэн МАХЦ-ийн анги нэгтгэлүүд Зөвлөлтийн армитай хамт Японы эсрэг дайнд нэгдэн орсноор хуулийн байгууллагууд, ялангуяа Цэргийн Ерөнхий прокурорын газар болон Хязгаарын ба Дотоодын цэргийн прокурорын газар онцгой нөхцөлд ажиллан чөлөөлөх дайны баатруудтай мөр зэрэгцэн хилийн чинадад үйл ажиллагаагаа явуулжээ.


## ДҮРЭМ ШИНЭЧЛЭГДЭЖ ЭРХ ӨРГӨЖИВ

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 113 дугаар тогтоолоор “БНМАУ-ын прокурорын дүрэм”-ийг 4 бүлэг, 28 зүйлтэйгээр шинэчлэн батлав. Дүрмийн 3 дугаар зүйлд “Монгол Ард

# 1945

Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн ёсоор бүх яамд ба төвийн олон албан байгууллагууд хийгээд тэдгээрийн харьяа байгууллагууд ба түүнчлэн албан тушаалтан хүмүүс, БНМАУ-ын дотор оршин сууж байгаа ард иргэдээс хууль цаазыг хэрхэн биелүүлж байгаа явдлыг хянах туйлын үүргийг улсын прокуророос гүйцэтгэх болно" гэж заажээ. Прокурорын үүрэг ихээхэн өргөжиж, Улсын бүх шүүн таслах газруудын ажлын явуулгыг хянах, шүүн таслах газрын хурал дээр улсын өмнөөс хэрэг яллах, шүүн таслах байгууллагуудын тасалсан хэргийг хянах, гэмт хэрэг үйлдэгчид болон хууль зөрчсөн албан тушаалтныг мөрдөн илрүүлж эрүүгийн хариуцлагад татах буюу захиргааны хариуцлага хүлээлгэх, мөрдөн байцаах, хорьж мөрдөх хугацааг ЭБШХ-д заасныг баримтлан сунгах, ялын төлөвлөгөөг батлах, гэмт хэрэг биш гэж үзвэл ял хэлэлцэх явдлыг хэрэгсэхгүй болгох эрхтэй болжээ.

***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***



Шүүх цаазын бичгийн 173 дугаар зүйл буюу хулгайн хэргээр 10 сар хөдөлмөрийн лагерт хорих ялаар шийтгүүлсэн хэргийн шийтгэх тогтоол. Тогтоолыг 5 хувь гаргаж үлдэх, хавтаст хэрэгт үдэгдэх, прокурорт хүргүүлэх, хорих ангид, шүүх яаманд тус тус хүргүүлдэг болохыг тодорхойлон бичдэг байсан байна. Өнөө үед хэргийн оролцогч нарт тогтоолын хувийг гардуулан өгдөг уламжлал хэвээр байна.

# 1945

## УЛСЫН ПРОКУРОРЫН ЭРХИЙГ ӨРГӨТГӨВ

“БНМАУ-ын прокурорын дүрэм”-д Улсын прокурор нь Улсын Бага Хурлаас 5 жилийн хугацаатай томилогдож, Улсын Бага Хурал, түүний Тэргүүлэгчдэд ажлаа хариуцан тайлагнах, прокурорын байгууллагад Улсын прокурорын орлогч, туслах прокурор, аймаг, хотын прокурор ба тэдгээрийн туслах прокурор, мөрдөн байцаагчид ажиллахаар заажээ.

Улсын прокурор нь аймаг, хотын прокуророуд, тэдгээрийн туслах прокуроруудыг 4 жилийн хугацаагаар томилох бөгөөд аймаг, хотын, туслах прокуророуд, тэдний мөрдөн байцаагч нарыг ажлаас халах, шилжүүлэх явдлыг гагцхүү Улсын прокуророос шийдвэрлэв. Улсын прокурорын эрхийг өргөтгөж, дараах гурван орлогчтой байхыг зөвшөөрөв. Үүнд:

- Улсын прокурорын ерөнхий хяналтын ажлыг эрхэлсэн орлогч прокурор;
- Улсын прокурорын орлогч бөгөөд тусгай хэргийг эрхэлсэн прокурор;
- Улсын прокурорын орлогч бөгөөд цэргийн хэргийг эрхэлсэн прокурор;

Улсын прокурорын ерөнхий хяналтын ажлыг эрхэлсэн орлогч прокурор болон тусгай хэргийг эрхэлсэн прокурор нарыг Улсын прокуророос 5 жилийн хугацаагаар томилж Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлахаар журамласан байна.

Эдгээрээс гадна Улсын прокурор нь 3 туслах прокурортой байхыг зөвшөөрөв. Тухайлбал:

- Мөрдөн байцаалтын ажлыг эрхэлсэн туслах прокурор;
- Шүүхийн хэргийг хянах ажлыг эрхэлсэн туслах прокурор;
- Захиргаа, аж ахуй, шинэ хүчний хэргийг эрхэлсэн туслах прокурор, мөн мөрдөн байцаагчидтай байхаар зохион байгуулалтын бүтцийг нь тогтоов.

## “ТОЛГОЙЛОГЧДОД БУУДАН АЛАХ ЯЛ ОНООВ”

...Долдугаар сарын 18-ны өдөр хурлаар орж Хөвсгөл аймгийн прокуророор батлагдаад очиход аймгийн прокурорын ажил айхтар доройтсон, өмнөх прокурор нь ажил албаа алдаж архи дарсанд орсноос аймагтаа нэр хүндгүй болж халагдсан байлаа.

Аймгийн прокурорын мөрдөн байцаалтад 2 жил шахам мөрдөгдсөн Арбулаг сумын харьяат зартай хулгайч Лувсангомбоор толгойлуулсан 30 шахам холбогдогчтой хэрэг, Хатгалын дамжлага баазын 250 гаруй мянган төгрөгийн мал хөрөнгийг хулгайлан дээрэмдсэн хэрэг, Должин хэмээх бөө, удганд хамаарах хулгайн хэрэг, түүнийг Очирбат гэгч байцаагч байцаасан боловч бичиг нь гаргагдахгүй учир өөрөөр нь уншуулж дахин бичүүлэх шаардлагатай зэрэг хэргүүд шийдэл хүлээж байв.

Эдгээрээс Лувсангомбо нарын хэргийг аймгийн шүүхийн дарга Лувсандорж олон нийтийн өмнө тасалж, аймгийн клубт гурван өдөр, шөнө шүүж, Лувсангомбо, Рэнцэн, Дугар нарын толгойлогч 7 хүнийг буудан алах, бусдыг нь удаан хугацаагаар хорихоор тасалсан билээ.

*Гавьяат хуульч О.Лхамсүрэнгийн дурдатгалаас*

# 1945

***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***



1945 онд Хэнтий аймгийн шүүхээс иргэн Шаравыг эрүүгийн хуулийн 177 дугаар зүйлийн 177.1 дэх хэсэгт зааснаар 6 сар хорих ял шийтгэснийг иргэн Шаравын зүгээс “Хилс шийтгэгдсэн ялаас хэлтрүүлмүй” хэмээн давж заалдсан өргөдлийг хүлээн авч шүүх таслах газраас шийтгэх тогтоолыг хүчингүй болгон, хэргийг иргэний журмаар шийдэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн тогтоол хадгалагдан үлджээ.

# 1945

## “ОЛНЫ ӨМНӨ ОНЦГОЙ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭВ”

Д.Хорхой миний бие 1942 оны 11 дүгээр сард ДЯЯ-ны сайдын тушаалаар Дотоодын ба Хязгаарын цэргийн прокурорт мөрдөн байцаагчаар томилогдон, дараа нь мөн газрын прокурорын орлогчоор дэвшиж ажилласан. 1945 оны 7 дугаар сарын эцсээр Бүх цэргийн Ерөнхий прокурор хурандаа Ц.Буурал намайг дуудаж “Та Цэргийн Ерөнхий прокурорт түр шилжлээ. Тусгай үүрэг гүйцэтгээд хилийн цэрэгтээ буцаж очих болно” гэлээ. Ийнхүү Бүх цэргийн прокурор, хурандаа Ц.Буурал, түүний орлогч н.Лувсаншарав нарын хамт мөрдөн байцаагч байгууллага галын шугамд цэрэг эрстэйгээ мөр зэрэгцэн үүрэг гүйцэтгэсэн юм. Дайн дуусч Монголын арми нутагтаа буцаж ирмэгц 1945 оны 9 дүгээр сард намайг Хязгаарын цэрэгт буцааж Дотоодын ба хязгаарын цэргийн прокурорын орлогчоор дэвшүүлсэн юм. Хилийн цэргийн албанаас бэрхшээн дайны жилүүдэд эх орноосоо урваж Япон, Гоминданы Чан Кай Шигийн талд ажиллаж байсан нэр бүхий урвагчдын хэргийг хянаж, тэднийг урьд алба хааж байсан хилийн цэргийн Овоот, Сангийн далай, Сулинхээр, Замын-Үүд, Дарьгангын



миний бие Японы милитаристуудын эсрэг Чөлөөлөх дайнд мордсон билээ. Хоёр хоногийн дараа 8 дугаар сарын 10-ны өглөө И.С.Плиев, Ю.Цэдэнбал нарын командалсан Зөвлөлт-Монголын армиуд БНМАУ-ын хилийг Байшинтын чиглэлээр давж япончуудын эсрэг давшин байлдаж эхэлсэн хүнд нөхцөлд цэргийн шүүх, прокурорын отрядууд дээр аваачиж олны өмнө таслахад би улсын яллагчаар оролцож, шүүх хурлаас оногдуулсан дээд хэмжээний ялыг ангийн жагсаалын өмнө командлан гүйцэтгүүлэх хэцүү хүнд бөгөөд хариуцлагатай үүргийг удаа дараа гүйцэтгэж байв.

*Д.Хорхой прокурорын дурдатгалаас*

# 1945

## БНМАУ-ЫН БАГА ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 1945 ОНЫ 12-Р САРЫН 17-НЫ 113-Р ХУРЛЫН ТОГТООЛ

**Улсын прокурорын байгууллагын дүрмийг батлах тухай**

1. Улсын прокурорын хуучин дүрэм нь одоогийн хөгжил байдлаас хоцрогдсон болох тул төлөвлөж ирүүлсэн шинэ дүрмийг баталсугай.

2. 1941 оны 7-р сарын 30-ны өдрийн тус тэргүүлэгчдийн 46-р тогтоолоор батлагдсан улсын прокурорын дүрэм нь хүчингүй болно.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Прокурорын дүрэм 4 бүлэг, 28 зүйл

**Нэг. Ерөнхий анги**

**Нэгдүгээр зүйл.** Бүгд Найрамдах Монгол Ард Улсын прокурорын байгууллагыг Үндсэн хуулийн 58-р зүйлийн ёсоор Улсын Бага Хурлаас таван жилийн хугацаагаар томилогдсон Улсын прокурор толгойлон удирдана.

**Хоёрдугаар зүйл.** Улсын прокурор нь Улсын Бага Хурал буюу Тэргүүлэгчдийн хуралд тайлан илтгэлийг гаргаж байх болно.

**Гуравдугаар зүйл.** Монгол Ард Улсын Үндсэн хуулийн 57-р зүйлийн ёсоор бүх яамд ба төвийн олон албан байгууллагууд хийгээд тэдгээрийн харьяа байгууллагууд ба түүнчлэн албан тушаалтан хүмүүс Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дотор оршин сууж байгаа ард иргэдээс хууль цаазыг хэрхэн биелүүлж байгаа явдлыг хянах туйлын үүргийг Улсын прокуророос гүйцэтгэх болно.

**Дөрөвдүгээр зүйл.** Улсын прокурор нь өөрийн үүргийг гүйцэтгэхийн тулд орлогч туслах нар, аймаг, хотын прокурор ба тэдний туслах хийгээд мөрдөн байцаагч нартай байхаас гадна Улсын прокурор нь албан байгууллагууд ба аж үйлдвэрийн газруудад прокурорын байгууллагад туслах группүүдийг Сайд нарын Зөвлөлөөс баталсан тусгай дүрмийн ёсоор байгуулах эрх бүхий болно.

**Тавдугаар зүйл.** Улсын прокурор нь зарим нэгэн чухал шаардагдсан газар хэсгийн прокурорыг байгуулах эрхтэй бөгөөд хэсгийн прокурор нь аймаг, хотын прокурорын туслахын үүргийг гүйцэтгэнэ.

**Зургадугаар зүйл.** Улсын прокурор нь аймаг, хотын прокурорууд ба мөн түүний туслах нарыг дөрвөн жилийн хугацаагаар томилох бөгөөд аймаг, хотын жинхэнэ, туслах прокурорууд ба мөн тэдний мөрдөн байцаагч нарыг ажлаас халах, шилжүүлэх явдлыг гагцхүү Улсын прокуророос шууд эрхлэн шийдвэрлэнэ.

**Долдугаар зүйл.** Улсын прокурор буюу түүний орлогч нар нь прокурорын даалгавраар Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн ба Сайд нарын Зөвлөлийн хурал хийгээд яамдын коллеги буюу бусад газруудын хуралд зөвлөх эрхтэй сууна.

**Наймдугаар зүйл.** Прокуророос гаргасан тогтоол, санал, шаардлагууд нь эрх хэмжээний дотор багтсан байвал албан газар, байгууллага буюу албан тушаалтан, энгийн ард иргэд хэн ч бол заавал дагаж гүйцэтгэх болно.

**Есдүгээр зүйл.** Улсын прокурор нь Сайд нарын Зөвлөлөөс баталсан орон тооны ёсоор прокурорын байгууллагын ажилчдыг нөхөн авч хангах үүрэгтэй болно.

**Аравдугаар зүйл**. Прокурорын байгууллагууд нь Улсын төсвийн хөрөнгөөр хангагдаж гүйцэтгэгдэх бөгөөд аж ахуйн зардлуудыг батлагдсан төсвийн дотор багтаан гүйцэтгэж байвал зохино.

*Дүрмийн хэсгээс*

# 1946

7 сарын 25. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 23 дугаар тогтоолыг үндэслэж, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 85-р тогтоолоор Улсын прокурорын газрын зохион байгуулалтад өөрчлөлт оруулж Улсын прокурорын хэлтсүүдийг Улсын прокурорын орлогч, туслахууд удирдах болжээ.

11 сарын 15. Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Улсын прокурорын газрын зохион байгуулалтыг өргөтгөж, Ерөнхий хяналт, Шүүх хяналт, Захиргаа аж ахуйн хэлтсүүдийг тус тус байгуулав.

12 сарын 11. Шүүх яамны сайдаар ажиллаж байсан Б.Жамбалдоржийг Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1946 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 94 дүгээр тогтоолоор Улсын прокуророор томилов.

-Прокурорын хяналтын дүрэм шинэчлэн батлагдав.

-Улаанбаатар хотын прокуророор З.Дорж, Архангай аймгийн прокуророор Ж.Цагаанхүү, Увс аймгийн прокуророор Б.Балжинням нар томилогдон ажиллав.

-Сүхбаатар хотын байцаагчийг хэсгийн прокурор болгов.

## ДАЙНЫ ЦАГИЙН ПРОКУРОРЫН АЖЛЫГ САЙШААВ

-Улс төрийн товчоо “Дайны үед прокурорын байгууллага, цэргийн хуулийг биелүүлэхэд хянан шалгах анхаарлаа зөв дайчилсан” хэмээн дүгнэжээ. Дайны жилүүдэд Улсын прокурорын харьяанд Улаанбаатар хот, 16 аймаг, Ардын цэрэг, Дотоод яамны хязгаарын цэргийн прокурорууд тэдгээрийн мөрдөн байцаагч нар ажилладаг байжээ.

БНМАУ-ын Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Бүх цэргийн прокурорыг БНМАУ-ын прокурорын орлогчийн эрх, үүрэгтэй болгож дээшлүүлсэнтэй холбоотойгоор цэргийн прокурорын байгууллагуудын эрх хэмжээ ч өндөрт гарсан хэмээн энэ жилүүдийн прокурорын байгууллагын түүхийг судалсан хүмүүс бичиж үлдээжээ.

## САХИЛГА БАТ АЛДСАН НЭГ Ч ЯВДЛЫГ ЗҮГЭЭР ӨНГӨРҮҮЛЭХГҮЙ...

МАХН-ын Төв Хорооны 1946 оны Бүгд хурлаар улсын ба хөдөлмөрийн сахилга батыг албан аж ахуйн газруудад цэгцлэн сайжруулах, сахилга бат алдсан нэг ч явдлыг зүгээр өнгөрүүлэхгүй байх, улс, олон нийтийн өмч хөрөнгийг арвилан хэмнэхийн төлөө аж ахуйч бус явдалтай хатуу тэмцэх, нам, засгийн тогтоол шийдвэр, улсын төлөвлөгөөг хэрхэн биелүүлж байгаад тавих прокурорын хяналт шалгалтыг хүчтэй болгохыг үүрэг болгов. Тухайлбал, Улс Төрийн товчооны 23 дугаар тогтоолд “...улсын ба олон нийтийн хөрөнгийг сүйтгэгчидтэй тэмцэх явдалд онц



анхаарлыг тавьж, хэргийг хуульд заасан хугацаанд дуусгах, улсад учруулсан хохирлыг нөхөн гаргуулж байх..., иргэдийг хуулийн хариуцлагад үндэсгүйгээр татсан баримтуудыг байцаан шалгаж, гэмт этгээдэд хариуцлага хүлээлгэж байх..."-ыг прокурорт даалгажээ.

## ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ӨӨРЧЛӨГДӨВ

Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 85-р тогтоолоор Улсын прокурорын газрын зохион байгуулалтад өөрчлөлт оруулав. Ерөнхий хяналтын хэлтэс, Шүүх хяналтын хэлтэс, Захиргаа аж ахуй ба шинэ хүчний хэлтсүүд, хянах байцаах анги болгож 17 орон тоог шинээр нэмж, 47 орон тоотой ажиллаж байжээ. Үүнтэй холбогдуулан 6 аймагт ерөнхий хяналтын 2 байцаагчийг нэмжээ. Түүнчлэн Улсын Прокурорын хэлтсүүдийг Улсын прокурорын орлогч, туслахууд удирдах болжээ.



# 1946

## БНМАУ-ЫН ПРОКУРОР БАТ-ОЧИРЫН ЖАМБАЛДОРЖ



БНМАУ-ын прокуророор 1946-1957 онд ажиллаж байсан Б.Жамбалдорж Дундговь аймгийн Өлзийт суманд 1908 онд төржээ. Тэрбээр 1928 оноос Богд Хан-Уулын аймгийн Хоёр Өлзийт хошууны Баясгалант сумын нарийн бичгийн дарга, ХЗЭ-ийн үүрийн дарга, Мандах сумын дарга, Аймгийн Намын хороонд зааварлагчаар ажиллаж байгаад 1930 онд Нягтлан бодохын сургууль, 1939 онд ЗХУ-д КУТВ-ийг (Сталины нэрэмжит Дорно дахины хөдөлмөрчдийн эв хамтын сургууль) төгсчээ. Тэрбээр 1939-1941 онд Дотоод явдлын яамны Улсын аюулаас хамгаалах газрын дарга, 1941-1946 онд Шүүх яамны сайд, 1946-1957 онд БНМАУ-ын прокурор, 1957-1958 онд Хянан шалгах яамны сайд, 1958-1960 онд ЗСБНХУ дахь Монголын Элчин сайдын яамны улс төрийн зөвлөх, 1960-1971 онд Улсын арбитрчаар ажиллаж байжээ.

# 1946

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

СнЗ-өөс Улсын прокурорт хандан “...Улаанбаатар хотын дотор малаа эзэнгүй сул бэлчээн, хотыг боловсон, тохилог болгох явдалд саад болж байгаа буюу малыг арчлан хамгаалах тал дээр сул муугаар ажиллаж байгаа малтай хүмүүст авсан арга хэмжээнүүд зүйтэй, гагцхүү гудамжаар эзгүй явах малыг шууд хураан авна гэснийг үл зөвшөөрөх ба тэрхүү эзэнгүй малыг алдуул малын тухай заасан журмыг баримтлана уу” хэмээх утга бүхий албан тоот.

Б. Н. М. А. У.

Сайд нарын Зөвлөл

Улаанбаатар хот.

1946 оны 6 сарын 8 өдөр № 323

Улсын Прокурорт,

Танаа[illegible] тоотыг үзэв. Үүнд Улаанбаатар хотын захиргааны төрүүлэгчдийн [illegible] дугаар хурлын тогтоол, хотын Прокурорын 11 тоот протест, мөн захиргаанаас хотын Прокурорт бичсэн 259 тоот харуу зөрчлийн Сайд нарын Зөвлөлийн 69 дүгээр хурлын тогтоолтой нийлүүлж хянавал, энэ талаар Сайд нарын Зөвлөлийн тогтоолыг үндэс болгож Улаанбаатар хотын дотор малаа эзэнгүй тавьж хотыг боловсон тохилог болгох явдалд саад болж байгаа буюу малыг арьчлан хамгаалах явдал дээр сул муугаар ажиллаж байгаа малтай хүмүүс дээр хотын захиргааны төрүүлэгчдийн хурлаас тогтоож гаргасан арга хэмжээнүүд нь зүйтэй гэж үзэнэ Гагцхүү гудамжаар эзэнгүй явах малуудыг шууд хураан гөсэнийг үл зөвшөөрөх бөгөөд харин тэрхүү эзэнгүй тэнэж яваа малуудыг иргэний хуульд алдуул малын тухай заасан журмыг баримтлан гүйцэтгэвэл зохихыг Улсын Прокурорт мэдэгдэгүй.

Хуулбарыг Улаанбаатар хотын захиргаанд явуулсугай.

Хөрөг эрхлэх газрын
дарга Жамсран ( Бат-Очир

Орон нутгийн засаг захиргааны
хэргийг эрхлэх хэлтсийн
дарга Данзандэв

# 1946

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

СнЗ-өөс Улсын прокурорт хандан “Прокурорын газрын гарааш ба орон сууцны барилгатай холбогдуулан илгээсэн албан бичиг. Энэхүү бичгийн нэг хувийг Сангийн яаманд илгээсэн байна.

Б. Н. М. А. У.

Сайд нарын Зөвлөл

Улаанбаатар хот.

1946 оны 6 дугаарын 7 өдөр. № 454

Улсын прокурорт.

Танай гараажа ба орон сууцны барилгат улсаас 75 мянган төгрөгийг олгуулах хөмөөсийг хянавал засгийн газрын шийдвэрээр хуучин гараажийг албадгасон цэргийн хэргийг эрхлэх газраа шилжүүлэн туүний зохих үнийн 115 мянган төгрөгийг нэгэнт авсан болох тул улсаас тусгайлан хөрөнгийг олгохгүй, харин танай газар нь их барилга ба засварын ажлыг засгийн газрын зөвшөөрөл ба тесевгүйд төлөвлөгөөгүй дур зоргоор үйлдэн нь үндсэн хөрөнгийг санхүүжүүлэх тухайн журмыг гажуудуулсан хэрэг болох тул бүрүүшаан цайшид энэ мэтийн дутагдлыг гаргаж ул болхыг мэдэгдсүгэй.

Хуулгыг сангийн яаманд.

Ерөнхий сайдын нэгдүгээр

орлогч сайд (( ЛУВСАН ))

# 1947

1 сард. Улсын прокурорын газар улсын өмч хөрөнгийн тооцоо тооллого, бүртгэлийн өргөн хүрээ бүхий шалгалт явуулж, ноцтой зөрчил дутагдал илрүүлжээ.

2 сарын 4. МАХН-ын Төв Хороо Улсын прокурорын мэдээллийн үндсэн дээр “Улсын ба олон нийт, хоршооллын өмчийг хамгаалах тухай” тогтоол гаргав.

2 сард. МАХН-ын Төв Хорооны тогтоолыг үндэслэн “Улсын ба олон нийт, хоршооллын байгууллагуудын өмчийг хамгаалах тухай” Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн тогтоол гарлаа.

10 сарын 12. Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор Улсын прокурорын газрын зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, орон тоог 17 хүнээр нэмэгдүүлж бүгд 47 ажилтны орон тоотой болгожээ.

## “ХӨРӨНГИЙГ ХУРААНА, ТЭР Ч БҮҮ ХЭЛ...”

1945 онд дууссан дайны улмаас улсын сан хөмрөгт учирсан хохирлыг гэтлэх зорилгоор газар сайгүй үргүй зардлыг багасгах, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих хяналт шалгалтыг чангатгахад чиглэсэн “Улсын ба



олон нийт, хоршооллын байгууллагуудын өмчийг хамгаалах тухай” БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 5 дугаар хуульчилсан тогтоол батлагдлаа. Түүнд “...Улс, олон нийтийн байгууллагын өмчийг онц хортой аргаар буюу зохион байгуулалттайгаар, түүнчлэн үлэмж хэмжээгээр хулгайлан шамшигдуулсан гэмт этгээдийг хуулийн дээд хэмжээ хэрэглэж, буудан алж, бүх хөрөнгийг хураах, хэрэв хөнгөтгөх учир байвал буудан алах ялыг 10 жилийн хориогоор сольж, бүх хөрөнгийг хураах гэх мэт хатуу чанд заалтууд тусгагдав. Тэр ч байтугай энэ тогтоолын дагуу шийтгэгдэгсдэд төрөөс өршөөл үзүүлэхийг хориглосон байна. Дайны хажуугаар дажин гэгчээр өмч хөрөнгийг хулгайлах, ашиглан шамшигдуулах явдал түгээмэл байсан учир түүнийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд ийнхүү хуулийн хатуу санкцуудтай баримт бичгийг прокурорууд мөрдөж байв.

Тэр үед ял шийтгэл оногдуулсан зарим хэргээс дурдвал, Тамсагийн хоршооны салбарын худалдагч, банкны кассын нярав гурван иргэн хуйвалдаж, 265 мянган төгрөгийг санаатай ашигласан хэрэг, аймгийн авто тээврийн баазын дарга механикч хятад иргэнтэй хуйвалдан ашиглан шамшигдуулсан 300 гаруй мянган төгрөгийн хэрэг зөвхөн Дорнод аймагт илэрч шийтгэгдэж байв.

# 1947

## ПОРТ-АРТУРЫН ХЭРЭГ ГЭГЧИЙГ ПРОКУРОРУУД ДЭВЭРГЭСЭНГҮЙ

1937 онд оргилдоо хүрсэн хэлмэгдүүлэлт хумигдсан ч намын даалгавар нэрээр хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагаанд нөлөөлөх явдал үргэлжилж байлаа. Үүнээс үүдэн нугалаа, завхрал ч гарч эхлэв. Тухайлбал нам, эвлэлийн гишүүд, сэхээтэн, олон нийтийг сэм тагнах, тэдний үзэл бодол, улс төрийн байр суурийн тухай дүгнэлт гаргуулах гэх мэт ажлыг хуулийн байгууллагуудад даалгаж, үүний улмаас хардлага сэрдлэг газар авав. Үүний тод жишээ нь 1947 онд гадаадын тагнуулын "Порт Артурын хэрэг" гэгчийг Дотоод явдлын яам зохиомжлон 80 гаруй хүнийг баривчлан шийтгэж байжээ. Түүнчлэн нам, Улсын бага хурлын төлөөлөгчдийг мөрдөн мөшгиж, хэлсэн ярьсныг нь тагнаж чагнасан явдал ч гарч байлаа. Хэдийгээр хууль бус дарамт шахалт ийнхүү хүчтэй байсан ч прокуроруудын олонхи нь хууль ёсыг хэлбэрэлтгүй сахиж байсны хүчинд 1937 оны хэлмэгдүүлэлтийн шуурга улс орныг 10 жилийн дараа дахин нөмрөхөөс аварсан гэж үздэг судлаачид, түүхчид цөөнгүй байдаг.

11 сард. 1948-1952 онд улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэн баталсан МАХН-ын 11 дүгээр Их хуралд прокурорын байгууллагын төлөөлөл цөөнгүй оролцжээ.

-Улаанбаатар хотын прокурорын газрын орон тоонд ерөнхий хяналтын асуудлыг эрхэлсэн байцаагч хоёрыг нэмэв.



-С.Равжаа Архангайд, М.Хайсандай Баянхонгорт, Х.Цэрэндорж Завханд, Г.Наваан Төв, О.Бадарч Увс аймагт тус тус аймгийн прокуророор томилогдов.

## БАРУУН ХИЛИЙН ТУЛГАРАЛТ

1947-1948 онд БНМАУ-ын газар нутгийн баруун хэсгээр зэвсэгт халдлага идэвхжиж, баруун хилийн тулгаралтууд олон нийтийн санаа бодлыг түгшээж, хил дээр гарч буй хэрэг явдлыг хэлэлцэн зохицуулах гэсэн манай талын санаачилгыг сөргөлдөгч талууд хүлээн авахгүй байв. Иймд БНМАУ-ын баруун ба баруун өмнөд хил хязгаарын тайван байдлыг

# 1947

алдуулагчдад цэргийн хүчээр цохилт өгсөн ба энэ үйл хэрэгт цэргийн прокурорууд хүч тавьж тодорхой үүрэгтэй оролцжээ. Жишээ дурдвал Монгол Улсын Гавьяат хуульч ахмад прокурор О.Лхамсүрэн салаан даргаар, мөн гавьяат хуульч Ж.Гомбодорж байлдагчаар хилийн цэрэгт алба хааж байхдаа баруун хилийн тулгаралтад оролцон эх орноо хамгаалж байлаа.

## АРВАН АТАН ТЭМЭЭГЭЭР БАРИЛГЫНХАА МАТЕРИАЛЫГ ТАТАВ

Харьяалах сумдаараа морь, тэмээн хөсгөөр нүүдэллэж, монгол гэр дугуйлан албан үүргээ гүйцэтгэж ирсэн прокурорууудын ажлын нөхцөл, ахуй хангамж жилээс жилд дээшилж байлаа. Эсгий гэрээс албан конторт шилжиж, машин унаатай ч болж эхэлжээ.

Тэр үеийн бодит нөхцөл байдлыг илэрхийлэх нэгэн жишээ дурдвал, Өмнөговь аймгийн прокурор Л.Цогт нутгийн ардуудаас 10 атан тэмээ худалдан авч, прокурорын нарийн бичгийн дарга, бичээч, зарлага нарын хамтаар хуучин сүм, хийдийн нураасан модыг ердийн хөсгөөр тээвэрлүүлж, Мандал-Овоо сумын иргэн Сумхүү, Ханхонгорын Лувсандооров, Манлай сумын Чүлтэм, Гаваа нарын уран дархчуулын дэмжлэгээр конторын барилга бариулж, тус аймгийн прокурор анх удаа 7 өрөө шинэ барилгад нүүн орж байжээ.

Телефон утастай конторлох болсноор улсын хэмжээнд аль шаардлагатай газар, хүмүүстэй шууд харилцдаг болж, материаллаг баазын хувьд бэхэжсэн байна. Улмаар аймгийн шүүх яамнаас актлагдсан Пикап машиныг сэлбэн засч, прокурорууд ажил үүргээ гүйцэтгэх болжээ.



# 1947

## ОЛЗЛОГДСОН ЦЭРГИЙН ХЭРЭГ ЭРХЛЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР НЭГЭНТ ӨӨРЧЛӨГДСӨН УЧИР...

БНМАУ-ын прокурор Б.Жамбалдоржийн гаргасан тушаал нэгэн түүхийг өгүүлнэ. 1939 оны Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайны дараагаар БНМАУ-д Олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх Ерөнхий газар хэмээх байгууллага ажиллаж байсан бөгөөд энэ нь дэргэдээ прокурорын салбартай байжээ.

БНМАУ нь Чөлөөлөх дайны ялагч улсын хувиар ЗХУ-ын удирдагчидтай харилцан тохиролцсоны үндсэн дээр Зөвлөлтийн талаас 1945 оны төгсгөл үед 12318 япон цэргийг нэрсийн жагсаалтгүйгээр зургаан удаагийн цуваагаар хүлээн авсан байдаг.

Тухайн үед Улаанбаатарт хотжих үйл явц эхэлж байсан учир нийслэлийн өнгө төрхийг илтгэсэн зарим барилгуудын суурийг тавих, барих зэрэг бүтээн байгуулалтын ажилд япон цэргүүд дайчлагдсан.

Олзны цэргүүд 1946-1947 оны төгсгөл үеийг хүртэлх хоёр жил орчмын хугацаанд бүтээн байгуулалтад ажиллаад нутагтаа буцсан бөгөөд үүнтэй холбоотойгоор БНМАУ-ын прокурор тушаал гаргаж байжээ.



Улсын прокуророос 1947 оны 11 дүгээр сарын 21 ний өдөр гаргасан 102 тоот тушаал.

Утга нь олзлогдсон цэргийн хэрэг эрхлэх ерөнхий газрын дэрэгдэх прокурорыг татан буулгах тухай.

§1.Олзлогдсон цэргийн хэргийг эрхлэх ерөнхий газар нэгэнт өөрчилөгдсөн учир дэрэгдэх прокурорын байгууллагыг энэ 11 дүгээр сарын 15 ны өдрөөс эхлэн татан буулгасугай

§2.Мен газрын прокурор Лувсанцэрэв орлогч прокурор Гэндэн-Дорж нарыг хууль цаазны Актимын курст суралцуулхаар Цэргийн ламны мэдэлд шилжүүлсүгэй.

§3.Мен газрын байцаагч Дугарсүрэн нарийн бичгийн дарга Дамба нарыг хэзгаарын цэргийн прокурорын мэдэлд шилжүүлсүгэй.

§4.Татан буулгасан прокурорын бичиг хэргийг эмхлэн цэгцлэх нарийн акттайгаар тус газрын нууцад архивлан шилжүүлэх ба өөрийн дуудагаагүй хэргүүдийг нэн түргэн дуусгах гүйцэтгэхийг байцаагч Дашзэвэгт даалгасугай.

Улсын Прокурор ((Жамбалдорж))

# 1948

-Улаанбаатар хотын прокурорын газрын харьяа Аж үйлдвэрийн комбинатын хэсгийн прокурорын орон тоог бий болгов.

-“Монголын иргэдийг Зөвлөлтийн дээд сургуулиудад суралцуулах тухай” гэрээ батлагдсанаар шүүх, прокурорын мэргэжлээр олон оюутан залуус, хуулийн байгууллагын ажилтнууд хойд хөршид суралцаж эхлэв.

-Аж үйлдвэрийн комбинат хэсгийн прокурортой болж, Цахилгаан комбинат, Нарийн төмөр замын байгууллагуудад хууль ёс хэрхэн сахигдаж байгаад хяналт тавьж байв.

-Д.Шагдарсүрэн Сүхбаатар аймгийн прокуророор томилогдов.

## ХАТУУ ХУУЛЬ ДЭВШИЛ, ЗАВХРАЛ НЭГЭН ЗЭРЭГ ДАГУУЛАВ

Өмнөх жилд нь батлагдсан хуульчилсан тогтоолын дагуу өмчийн хэрэгт шийтгүүлэгсдийн тоо энэ онд өмнөх оныхоос 60 хувиар нэмэгджээ. Энэ цаг үед хууль сахиулах байгууллагуудын гүйцэтгэж байсан үүргийг гавьяа гэж үздэг хүмүүс байхад завхрал гажуудал ч дагуулж байсныг хатуугаар дүгнэх хуульчид ч байжээ.

Тухайн үед Улсын прокуророор ажиллаж байсан Б.Жамбалдорж “Дардан бус замаар далаад жил” дурсамж номондоо “Улс, олон нийтийн өмчийг хамгаалах тухай хууль маш ач холбогдолтой хууль, үүргээ ч гүйцэтгэсэн. Улс, олон нийтийн өмчийг элдэв хэлбэрээр шамшигдуулах, ашиглах явдал газар авах шинжтэй болсон тэр үед Төв Хороонд өгсөн танилцуулах, илтгэх хуудасны мөрөөр Төв хороо, Засгийн газар хэлэлцэн хамтарсан тогтоол гаргаж, түүнийг үндэслэн хуулийн хүчин чадалтай тогтоол гаргасан. Өмч хамгаалах тухай дээрх хууль бол их хатуу хууль.



Харин тэр хуулиар шийтгэгдсэн хүмүүсийн хэрэг үндэслэлгүй, зохиомол хэрэг байгаагүй гэдгийг баттай хэлж чадна. Дээрх хууль эрх бүхий байгууллагаар батлагдан, улс орны хөгжлийн тодорхой цаг үед үүргээ гүйцэтгэж, эдийн засгийн өсөлт бэхжилт, хүн ардын ухамсарт ихээхэн ахиц дэвшил авчирсныг үгүйсгэх хэрэггүй. 90-ээд оны эхээр энэ хуулиар хүнийг хэлмэгдүүлсэн гэх мэт яриа хөөрөө гарсан юм. Баримтаар баталгаажуулахаар холбогдох байгууллагуудад хандах, архивын баримт материал шүүх

# 1948

зэргээр нэлээд хөөцөлдсөн ч тодорхой ул мөр, баримт олдоогүй" хэмээн тэмдэглэжээ. Тэгвэл ахмад прокурор С.Батсүх "...хуулийн байгууллагууд энэ хуулийг хэрэгжүүлэх явцад ажлын хариуцлага алдаж, өмч хөрөнгийг үрэгдүүлсэн, яасан нь мэдэгдэхгүй их хэмжээний мөнгө оргүй дутагдуулсан хэргийг нарийвчлан шалгаж, үнэн мөнийг тогтоохгүйгээр шууд хуулийн зүйлчлэлд хамааруулан хавтгайруулж олон хүнийг хүнд хэрэг, ялд оруулан хэлмэгдүүлсэн ноцтой алдаа багагүй гарсан.

Энэ нь шүүх, прокурор, Дотоод яам, цагдан сэргийлэхийн төв, орон нутгийн байгууллагын тэр үеийн ажилтан бидний үйл ажиллагаанд гарсан сүрхий алдаа байлаа" хэмээн дүгнэсэн байдаг.

## АНХДУГААР ТАВАН ЖИЛИЙН ГАРААНЫ ЖИЛ

Өмнөх жилд нь МАХН-ын 11 дүгээр Их хурал баталсны дагуу Анхдугаар таван жилийн төлөвлөгөөг баталсан билээ. Малын тоо толгойг 31 саяд хүргэх, аж үйлдвэрийн газрыг өргөтгөж, түүний нийт бүтээгдэхүүнийг 96,8 хувиар өсгөх, бүх хүүхдийг анхан шатны сургуулиар заавал сургах, насанд хүрэгсдийн бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах зэрэг томоохон зорилт дэвшүүлсэн анхдугаар таван жилийн төлөвлөгөөний гарааны оны зорилтуудыг хувийн аж ахуйтан, үйлдвэрлэгчид, улс хоршоодын байгууллагууд хэрхэн биелүүлж байгаад төв орон нутгийн прокурорууд улс орон даяар ерөнхий хяналт тавьж байлаа.

## ҮЙЛДВЭР КОМБИНАТ ПРОКУРОРТОЙ БОЛЛОО

1934 онд байгуулагдсан аж үйлдвэрийн комбинат өргөжин тэлж, үйлдвэрлэл нэмэгдэхийн хэрээр фабрик, заводуудад хууль ёс хэрхэн сахигдаж байгаад хяналт тавих шаардлага гарах болжээ. Анх Шүүх яамны харьяанд ажил үүргээ гүйцэтгэж байгаад улмаар төрийн тусгай байгууллага болон өргөжсөн Улсын прокурорын газар нь 1948 оныг хүртэл хот, аймгаас өөр газарт бие даасан салбар нэгж байгаагүй аж. Харин энэ онд нэгэн онцлог түүх бичигдэж эхэлсэн нь прокурор улс ардын аж ахуйн салбарт хяналтын прокурорын албатай болсон хэрэг юм. Аж үйлдвэрийн комбинатын хэсгийн прокурор нь АҮК-ын Арьс ширний завод, ноос угаах завод, цэмбэний фабрик, нэхий эдлэлийн үйлдвэрээр зогсохгүй цахилгаан комбинат, нарийн төмөр замын байгууллагуудад хууль ёс хэрхэн сахигдаж байгаад хяналт тавьж эхэлжээ.



# 1949

**2 сард.** Улсын 9 дүгээр Их хурал Үндсэн хуульд нэмэлт оруулж, Улсын Бага хурлыг татан буулгаж, Улсын Их хурлыг төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага гэж хуульчлав.

**5 сард.** Шүүх, прокурорын удирдах ажилтнуудын зөвлөгөөн болов.

**7 сарын 27.** Хууль цаазын сургууль байгуулах, ЗХУ-ын хууль, цаазын сургуулиудад жил бүр 6-гаас доошгүй хүн суралцуулах, намын шинэ хүчний сургуулийн төгсөгчдөөс шүүх, прокурорын ажилтнаар авч ажиллуулах хүсэлтийг Шүүх явдлын яам, Улсын прокуророос нам, төрийн удирдлагуудад гаргав.

-П.Шарав Налайхыг хариуцсан (Улаанбаатар хотын) прокуророор, Б.Баяндэлгэр Өмнөговь, О.Магсар Хөвсгөл аймгийн прокуророор тус тус томилогдон ажиллаж эхлэв.

-Улсын Бага хурлаас гэмт хэрэг үйлдсэн 14-16 насны хүүхдийг баривчлах, насанд хүрэгсдийн адил ял ногдуулах, эд хогшил мал сүргийг тооллогоос дарагдуулагсад, ажил тасалж, гологдол бүтээгдэхүүн гаргагсдыг эрүүгийн хуулиар шийтгэх заалт бүхий өөрчлөлтийг Эрүүгийн хуульд оруулав.

## МОРИН ӨРТӨӨ ХЯНАЛТААС ГАРАВ

Улсын 9 дүгээр Их хурлын шийдвэрийн үндсэн дээр Бага хурлын Тэргүүлэгчдийн зарлиг гарч, өртөөний албыг улс өөртөө авч улсын морин ба авто өртөөг байгуулан ардын аж ахуйтныг морин өртөөний албанаас чөлөөлсөн нь чухал шийдвэр болов. Ингэснээр прокурорын байгууллагын ерөнхий хяналтын салбар салбарын олон чиг үүргээс ардын аж ахуйтныг хянах, шалгах ажил бага боловч хасагджээ. Ардын аж ахуйтныг морин өртөөний дарамтнаас чөлөөлсөн хэдий ч улсын төлөвлөгөөт даалгавар, бэлтгэлийн бодлогоос малын тоо толгой олигтой өсч чадаагүй байна.

## “ТОДОРХОЙ ХЭРГИЙГ ӨДӨРТ НЬ ДУУСГА...”

Улаанбаатар хотын прокурор З.Доржийн 1949 оны ажлын тайланд “Мөрдөн байцаалтыг сар, долоо хоног, өдөр тутмын төлөвлөгөөтэй явуулж байсан, урьд онуудад зарим байцаагч нар тодорхой баримттай багавтар хэргийг өдөрт нь дуусгах үүрэг өгөхөд хэдий бага ч хэрэг бүртгэхэд ажиллагаа их ордог тул амжихгүй гээд дуусгахгүй явдал байсан. 1949 онд хэргийг нэгэн өдөрт байтугай 3-4 цагийн дотор дуусгаж болох туршлагыг байцаагч Дашням, Гомбожав, Шарав нараас гаргасан” гэж дурджээ. Улаанбаатар хотын прокурор, ажилтнуудаас мөрдөн байцаалтад хүлээн авч шалгаж барагдуулсан хэрэг материалыг тэр үед ажиллаж байсан байцаагч нарынх нь тоонд хувааж үзэхэд нэг мөрдөн байцаагчид дунджаар 100 хавтаст хэрэг материал ногдож байжээ.



Аймаг, хотын прокуроруудын нэгдсэн зөвлөгөөний үеэр БНМАУ-ын прокурор Б.Жамбалдорж, Улсын прокурорын зөвлөх Н.Ф.Маховын хамтаар









# ГУРАВДУГААР БҮЛЭГ: 1950-1959 ОН



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын

Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

*1955 оны 9 дугаар сарын 6-ны өдөр.* *Дугаар 482* *Улаанбаатар хот*

Шүүх, прокурорын байгууллагыг байгуулах тухай

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Улаанбаатарын төмөр замын газрын дэргэд шүүх ба

Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчийн дарга Ж. Самбуу (Ж. САМБУУ)

Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчийн орлогч дарга (Л. ШАРАВ)

Б. Н. М. А. Улсын Их Хурлын Тэргүүлэгчийн нарийн бичгийн дарга (Л. ДАМБА)

(С. ЯНЖМАА)

# 1950

1 сард. МАХН-ын Төв Хорооны хурал нэгдэлжүүлэх хөдөлгөөн өрнүүлэхийг СнЗ-д даалгав.

7 сарын 1. Улсын хэмжээнд бүх албан хэргийг шинэ бичгээр хөтлөн явуулж эхлэв.

-Хууль цаазын дунд сургууль байгуулав.

-СнЗ-өөс илүү цагаар ажиллахыг зогсоож, ажлын цагийг журамтай болгох тогтоол гарсныг прокурорын байгууллагын хэмжээнд даган мөрдөв.

-Г.Пүрэвдоо нийслэлд, Сүрэн Архангайд, З.Дорж Говь-Алтайд, Д.Цэдэндаржаа Дорноговьд, С.Авирмэд Дундговьд, О.Лхамсүрэн Завханд, Гончиг Увсад аймгийн прокуророор томилогджээ.

-Налайхад хэсгийн прокурорын газар байгуулагдав.

## ХОТЫН ПРОКУРОРЫН ХҮРЭЭ ӨРГӨЖИВ

Нийслэл Улаанбаатар хотын хүн ам эрчимтэй нэмэгдсэн тул Хотын прокурорын байгууллага бүтэц зохион байгуулалт, боловсон хүчний хувьд өргөжив. Орон тоог 6-гаар нэмэгдүүлж, Налайхад хэсгийн прокурорын газар шинээр байгуулав. Улсын хэмжээнд 1950 онд прокурорын байгууллагын ажилтан, ажилчид нийт 336 хүн ажилласан ба прокуроруудын батлагдсан орон тоо 210, үүнээс жинхэнэ прокурор 22, орлогч, туслах болон хэсгийн ба хэлтсийн прокурор бүгд 54, бүх прокурор 76, байцаагч 134 байжээ.



## ЯЛТАЙ МАЛ...

1950-иад оны дундуур МАХН хувийн өмчит ардын аж ахуй байгаа нөхцөлд “социализмыг дэлгэрэнгүй байгуулах” боломжгүй бөгөөд түүнээс гарах зам бол ардын аж ахуйтныг социалист ёсоор хоршоолох явдал буюу нэгдэлжүүлэх гэж үзсэн байна. Ингээд хөдөө аж ахуйг нэгдэлжүүлэх бэлтгэл ажил эхлэв. Хөдөө аж ахуйн хоршоо хувийн аж ахуйгаас давуутайг сурталчилсан өгүүлэл, баримт сэлтийг сонин хэвлэлд өргөн нийтлэх болов. Улсын 9 дүгээр Их хурлаас баталсан малын тоо толгой, өсөлт бойжилтын хуулиар ямар нэгэн учир шалтгаанаар малаа хорогдуулж албан журмын ногдлыг тасалдуулсан малчид шийтгэгдэж байснаас болж,

# 1950

малчид малаасаа төвөгшөөж “ялтай мал” гэж үзэх болжээ. Энэ байдал нь яваандаа малчин ардын зарим хэсэг, ялангуяа чинээлэг ардын аж ахуйтныг малаа нэгдэлд “нийгэмчилж” яс амрах, ядуу хэсэг нь нэгдлийн “буянг” шүтэхэд хүргэсэн байна. Мал аж ахуйн хөдөлмөрийн нийгмийн үнэлгээ буурч, малчид төв суурин газар улс, хоршооны байгууллагууд бараадан,



үр хүүхдээ сургууль соёлын мөр хөөлгөх нь ирээдүйтэй гэж үзэх болов.

## МЯТАВЫН ЖАВХЛАН



М.Жавхлан Увс аймгийн Тэс суманд 1917 онд төржээ.


Тэрбээр 1939 оны Халх голын, 1945 оны чөлөөлөх дайнд оролцож “Бид ялав, “Цэргийн гавьяаны одон”-гоор шагнагджээ.

М.Жавхлан 1945-1950 онд Увс аймгийн шүүхийн орлогч дарга, дарга, 1950-1991 онд Увс аймгийн прокурорын газар хэсгийн болон хяналтын прокуророор тасралтгүй 41 жил ажиллажээ.

Түүний хүү Бямбаа 1988-1990 онд БНМАУ-ын прокурорын нэгдүгээр орлогчоор ажиллаж байв.


***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***

Кирилл бичигт шилжсэний дараах “Хавтаст хэргийн материалыг хэрэгтэнд танилцуулсан тогтоол”



# 1950

***ТЕГ-ын Тусгай архивын сан хөмрөгөөс...***



1950 оны 3 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Шүүх-Прокурорын ажилтныг бэлтгэх хуулцаазын сургуулийг байгуулах тухай.

Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Шүүх-Прокурорын мэргэжилтэй шинэ хүчнийг бэлтгэхийн тулд, нэгэн жилийн хугацаатай, байнга ажиллах хуулцаазын сургууль байгуулахыг Улсын прокурор,шүүх яамнд зөвшөөрсүгэй.

2.Хуулцаазын сургуульд шүүх- прокурорын практикт ажилтнаа дөрөөс элсүүлэн суралцуулах сурагчдыг тоог 30 хүнээр тогтоож, тэдний цалинг тус сургуульд суралцах бүх хугацаанд урьд ажиллаж байсан газраар нь хөвөөр олгож байсугай.

3.1950 онд хуулцаазын сургуулийн зардалд хэрэглэгдэх 101,100 төгрөгийг Улсын төсвөөр энэ зүйлд зориулагдсан хэмжээнээс гаргаж санхүүжүүлэхийг сангийн яамны сайд нарт МОЛОТОВ-д үүрэг болгосугай.

4. Хуулцаазын сургуулийг худалдааны техникумын байранд байгуулж, түүний сурагчдын ахуй байдлын хэрэгцээг мөнхүү техникумын зардлаас хангаж байсугай.

Хуулцаазын сургуулийн ажилтагаар удирдах ба харицуулах ядлыг Шүүх яамны сайд нарт ГАМЕЛАРАА-д үүрэг болгож, түүнд уг сургуулийг санхүүжүүлэхээр олгосон зардлыг бараа бүтээгдэхүүнээр олгосон

Зөв: Ерөнхий Сайд Улсын Бага Хурлын Тэргүүлэгчийн Нарийн Бичгийн Дарга

Улаанбаатар Маршал

Хэрэг Эрхлэх Газрын дарга

Тогтоол Ангийн эрхлэгч

Бүртгэлийн архивт олгосугай.

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ТУСГАЙ АРХИВ

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

2020 оны 01 сарын 01-ний өдөр

9131701 ГСТ6056

# 1951

## ГАРНИЗОНЫ ПРОКУРОРУУДЫГ ТАТАН БУУЛГАВ

Халхын голын байлдаан, дэлхийн 2 дугаар дайн, Чөлөөлөх дайн, баруун хилийн тулгаралтуудаас хойш байдал намжиж, улс орны хэмжээнд энх цагийн бүтээн байгуулалтууд эрчимжсэн энэ үед хувийн болон нийгмийн өмчийн холбоотой тодорхой төрлийн гэмт хэргийн гаралт жилээс жилд нэмэгдсэнтэй холбогдуулан, Улсын Батлан хамгаалах яамны орон тоо зохион байгуулалтын өөрчлөлтөд зохицуулан Улсын прокурор Б.Жамбалдоржийн 9 дүгээр сарын 24-ний өдрийн 95 дугаар тушаалаар Өндөрхаан,



Чойбалсан, Улаанбаатар хотын Цэргийн гарнизоны прокуроруудыг татан буулгаж, эрхэлсэн чиг үүрэг нь Цэргийн Ерөнхий прокурорт хавсруулжээ.

## ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГА ЭНХ ТАЙВНЫ ТӨЛӨӨ

БНМАУ-ын гадаад харилцаа жилээс жилд өргөжиж байв. Монголын төлөөлөгчид дэлхийн энх тайвны төлөө байгууллагын олон удаагийн хурал, түүний дотор Ази, Номхон далайн орнуудын энх тайвны төлөөх Их хуралд удаа дараа оролцдог болов. МҮЭ, МХЗЭ, МОХ, МЭХ зэрэг олон нийтийн байгууллага тус тусын шугамаар Дэлхийн Энх тайвны Зөвлөл, Дэлхийн Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо,

3 сарын 31. СнЗ-ийн тогтоолоор Дээд шүүх, Улсын прокурорын зөвлөхийн орон тоог хязгаарласан тул Зөвлөлтийн мэргэжилтэн зөвлөх Колгановыг чөлөөлөв.

7 сарын 10. Улсын прокурорын тушаалаар нууцын эрхлэгч Ц.Амгалан, зарлага С.Лувсан, бичээч Ц.Цэгмэд, нягтлан С.Дарьсүрэн нарыг Алтан үсгийн үнэмлэх, толиор, хэлтсийн прокурор Т.Самбууг дээлийн чисчүүгээр тус тус шагнажээ.

9 сарын 24. Улсын прокурорын тушаалаар цэргийн гарнизоны прокуроруудыг татан буулгажээ.

# 1951

-Цэргийн Ерөнхий прокурорын газрын ахмад Шагдаржавыг Цэргийн Ерөнхий прокуророор түр томилжээ.

-Н.Жадамба Төвд, Б.Магауия Баян-Өлгийд, Б.Дамба Булганд, С.Дугарсүрэн Б.Гүржав Говь-Алтайд, Д.Лхамсүрэн Дорноговьд, Г.Жамбал Увсад, Э.Авирмэд Ховдод, Г.Наваан Хөвсгөл аймагт тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллаж эхлэв.

-Прокурорын байгууллагад нийт 339 хүн ажиллахаас 333 хүн ажилласан тухай тайланг Улсын прокурорын газраас гаргажээ.

Дэлхийн Ардчилсан залуучуудын холбоо зэрэг олон улсын нэр хүндтэй байгууллагын гишүүн болж, энх тайвны дэлхий дахины хөдөлгөөнд идэвхтэй оролцох болов. Тиймээс 1950 оны 4 дүгээр сард Улсын Бага хурлын Тэргүүлэгчид энх тайвны төлөө тунхаг бичиг гаргаж, түүнийг дагалдуулан 1951 оны 2 дугаар сард дайны тухай суртал нэвтрүүлэх буюу түүнд дэмжлэг үзүүлсэн этгээдийг гэмт хэрэгтэн гэж үзэж, 10-25 жилээр хорих ял оноох шийтгэл оногдуулах тухай заасан “Энх тайвныг хамгаалах тухай” хууль батлав. Ингэснээр Монголын прокурорын байгууллага БНМАУ-ын олон улсын гэрээ, хэлэлцээрүүд, энх тайвныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж эхлэв.



Нийслэлийн прокурорын газар 1950-иад онд байрлаж байсан барилга



Улсын прокурорын газар 1951 оноос эхлэн 1974 оныг хүртэл одоогийн Д.Нацагдоржийн нэрэмжит номын сангийн хойд талд буй энэхүү байшинд байрлаж байжээ.

# 1951

## Д.ЖАМБАЛДОРЖ: АЖЛЫНХАА МЭДЦИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР ЭРХБИШ АХИЦ ОЛЖЭЭ

БНМАУ-ын прокурор Д.Жамбалдоржийн 1952 оны 3 сарын 31-ний өдөр тавьсан илтгэлд “Улсын прокурорын байгууллага нь тус улсын дагаж шийтгэгдэн байдаг хуулиуд, нам засгийн тогтоол шийдвэрүүдийг зөв бөгөөд ухралтгүй биелүүлж байх ба хуулийн ямар нэг зөрчил завхралд хяналт хийх ажиллагааг өнгөрсөн 1951 онд нийт прокуроруудын гол анхаарах асуудлын нэгэн болгож зохиосон бөгөөд түүний дүн нь 1951 онд Улсын прокурорын хэмжээгээр хувьсгалт хуулийн гажуудлуудыг засуулахаар төв ба орон нутгийн албан байгууллагуудын эрх баригчдад прокурорын эсэргүүцэл 277, мэдэгдэл 567-г бичжээ. Үүнийг 1950 оныхтой зэрэгцүүлэн үзэхэд 1951 онд эсэргүүцэл 145,1 хувиар, мэдэгдэл 55,3 хувиар тус тус өссөн байх бөгөөд энэ нь манай ажилтан албан хаагчдаас өөрсдийн ухамсар ба үндсэн ажлынхаа мэдцийг дээшлүүлэх талаар эрх биш ахицыг олсон явдлыг харуулж байна” хэмээн дүгнэжээ.

## ШИНЭ ХҮЧНИЙ ТАЛААР...

Улсын прокурор ба түүний харьяа байгууллагын хэмжээгээр 1951 онд байгуулагдсан орон тоогоор Улсын ба аймаг хот, цэргийн жинхэнэ прокурор 88, орлогч прокурор 4, туслах ба хэсгийн прокурор 39, хэлтсийн прокурор 8, байцаагч 126 бусад ажилтан ажилтан ажилчид 141 эдгээр бүгд 340 хүнтэйгээр ажиллаж иржээ. Улсын прокурор Б.Жамбалдорж, орлогч прокурор Д.Хорхой, Санжмятав, туслах прокурор Цэрэндорж, хэлтсийн прокурор Лувсандорж, Дугарсүрэн, Галт нар нь Увс, Баян-Өлгий, Ховд, Говь Алтай, Завхан, Хөвсгөл, Булган, Архангай, Баянхонгор, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Өвөрхангай, Дорноговь аймгуудаар биечлэн явж, аймгийн прокуроруудын ажил төрлийг шалган танилцаж, удирдлага зааврыг өгчээ.

## ДАМИРАНГИЙН ХОРХОЙ



Д.Хорхой Увс аймгийн Улаангом сумын нутагт 1921 онд төржээ. Тэрбээр 1939 оноос ДЯЯ-ны төлөөлөгч, 1940 оноос Дотоод яамны Хязгаарын цэргийн гүйцэтгэх хэлтэст, 1942-1945 онд Хязгаарын цэргийн прокурорт мөрдөн байцаагч, 1945-1948 онд Хязгаарын цэргийн орлогч прокурор, 1951-1954 онд БНМАУ-ын прокурорын орлогч, 1958-1960 онд Улаанбаатар хотын прокурор, 1960-1964 онд БНМАУ-ын СнЗ-ийн хуулийн хороонд ахлах зөвлөгч, 1964 онд хуулийн хорооны дарга, 1972 онд БНМАУ-ын Шүүх яамны 1-р орлогч сайд, 1975 онд ЭЗХТЗ-ийн нарийн бичгийн дарга нарын газарт эрхзүйн эксперт, 1979 онд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн референт, 1980-1988 онд БНМАУ-ын прокурорын орлогчоор хоёр дахь удаагаа томилогдон ажиллажээ.

# 1952

5 сарын 25. БНМАУ-ын прокурорын 36 дугаар тушаалаар зарим прокуроруудыг шагнажээ.

-Н.Гончиг Баянхонгор, Г.Гэнэн Дундговь, П.Галт Өвөрхангай, Д.Амгалан

## НАМ, ТӨРИЙН УДИРДАГЧИД СОЛИГДОВ

1935 оноос хойш нам, төрийн удирдагчаар он удаан жил ажилласан улсын маршал Х.Чойбалсан таалал төгслөө. Ерөнхий сайдын орлогч Ю.Цэдэнбалыг Ерөнхий сайдаар томилжээ. Ийнхүү Ю.Цэдэнбал засаг төрийн дээд удирдлагад гарч ирлээ.



Нам, төрийн удирдагч Х.Чойбалсанг эцсийн замд нь үдэх ёслол

Сүхбаатар аймагт тус тус аймгийн прокурорын албан тушаалд, Ц.Бямбаа Налайхыг хариуцсан хэсгийн прокуророор тус тус томилогдов.

-Улсын прокурор Б.Жамбалдорж БНМАУ-ын төлөөлөгчдийг тэргүүлж Албани улсын Хөдөлмөрийн намын 2 дугаар Их хуралд оролцов.

## ХОЁР НҮДНИЙ ДУРАН, КАЛИБР БУУ...

Улсын прокурорын 5 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тушаалаар ажилдаа идэвх санаачилгатай ажилласан прокуроруудыг урамшуулан эд зүйлсээр шагнасан нь өдгөө архивын шарласан хуудсанд үлджээ.

Уг тушаалд “1952 оны ажилдаа хэд хэдэн эдийн засгийн томоохон бөгөөд хялбаргүй хэргүүдийг өөрийн ажиллагаагаар илрүүлж барагдуулан цаашдаа улам сайн ажиллах талаар санаачлан ажиллаж буй Хөвсгөл аймгийн прокурор Навааныг 2 нүдний дуран нэгээр”, “Өөрийн ажилдаа идэвх зүтгэлтэй, хөнгөн гавшгай бөгөөд санаачлагатай байгаа Дорноговь аймгийн прокурор Очирхуягийг калибр буу нэгээр”, “Хэнтий аймгийн прокурорын ажлыг богино хугацаанд өөрчлөн сайжруулж үр дүнг үзүүлсэн аймгийн прокурор Доржийг нэг нүдний дурангаар шагнаж урамшуулсугай” хэмээжээ.

# 1952

## МОРЬ ТЭРЭГТЭЙ НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОР

Ахмад хуульч Д.Хишиг-Очир “Амьдралын туршлага сураагүй 16-хан насандаа Улаанбаатар хотын прокурорын харьяа Аж үйлдвэрийн комбинат дахь хэсгийн прокурорын газарт зарлага, нарийн бичгийн даргын ажилд орсноор хөдөлмөрийн гараагаа эхэлж, сард 225 төгрөгийн цалин авч байлаа. Тэртээх 1952 оны үед Улаанбаатар хотын прокурорын газар нь хуучны муудсан шавар байшинд “толгой хоргодож”, Пикап маркийн эвдэрхий хар машинтай, нуруу, туурай нь муудсан хээр зүсмийн тэрэгний морьтой байв. Хэдэн прокурор, мөрдөн байцаагч нарын дунд хууль цаазны дээд боловсролтой хүн нэгээхэн ч үгүй, бүх ажлаа явганаар явж гүйцээнэ. Намайг ажиллаж байх үед нэг прокурор жилдээ 270-400 хэрэг хянаж байсны зэрэгцээ Шүүх, сэргийлэх, бусад албан байгууллагуудад хуулийн биелэлтийн талаар олон удаа хяналт шалгалт хийдэг байлаа.

Мөн миний үед прокурор, мөрдөн байцаагч нар их дээд, дунд сургууль болон богино хугацааны курс, дугуйланд орой ба эчнээгээр суралцаж лекц семинарт өргөн оролцож, шинээр гаргасан хууль дүрэм, зарлиг тогтоолуудыг нарийн судлаж мэргэжил мэдлэгээ байнга дээшлүүлэх хүсэл тэмүүлэлтэй ажилладаг байлаа” гэж хуучилсан байдаг.

## ГЭМТ ХЭРГИЙГ ГАЗАР ДЭЭР НЬ ШИЙДДЭГ БАЙСАН

Ахмад хуульч С.Дашзэгвэ “Тэр үед би 27-хон настай, Улсын прокурор Жамбалдоржийн тушаалаар 1952 онд Төв аймгийн прокурорт томилогдон, Жаргалант сумын хэсгийн прокуророор ажилласан юм. Жаргалант сумын хэсгийн прокурор нь Борнуурын алтны үйлдвэр, Угтаалцайдам сум, Заамар сум, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумыг хамарч нэлээд өргөн хүрээнд ажиллана. Сумдын хооронд мориор, үхэр тэргээр 10-15 хоног, зарим үед сараар нүүдэллэн ажиллах ч удаатай. Тэр үеийн нэг гол онцлог бол гэмт хэрэг зөрчлүүдийг газар дээр нь шүүхтэйгээ хамт шийдвэрлэдэг байсан” хэмээжээ.



# 1953

**3 сард.** МАХН-ын Төв Хорооны Бүгд хурлаар Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцжээ. Энэ Бүгд хурлаас хуулийн байгууллагуудын ажлын амжилтыг сайшаасан байна.

**3 сард.** Монгол Улсын гавьяат хуульч Хайргын Жамбал прокурорын босгыг алхаж хуульчийн гараагаа эхлэв.

**8 сарын 3.** АИХ-ын Тэргүүлэгчдийн 88 дугаар зарлигаар Хязгаарын цэргийн прокурорыг татан буулгаж, үүрэгт ажлыг нь Цэргийн прокурорт хавсарган гүйцэтгүүлэв.

**9 сард.** Монгол Улсын гавьяат хуульч Мабушкийн Бадрах Хөвсгөл аймгийн прокурорын газарт Мөрдөн байцаалт эрхэлсэн туслах прокуророор ажлын гараагаа эхлэжээ.
-Г.Наваан Улаанбаатар хотын прокуророор, Н.Лхамсүрэн Баянхонгор, С.Түдэвпунцаг Говь-Алтай, Д.Очирхуяг Дорноговь, Н.Жадамба,

## УДИРДАГЧИД ТААЛАЛ ТӨГСӨЖ, УЛС ТӨР ЗӨӨЛРӨВ

1953 онд БНМАУ-ын удирдлагуудад улс төрийн нөлөө үзүүлж байсан ЗХУ-ын удирдагч И.В.Сталин нас нөгчсөн, түүний өмнөх жилд Х.Чойбалсан таалал төгссөн зэргээс шалтгаалж улс төрийн уур амьсгал манай улсын дотоод, гадаадад нэгэн зэрэг өөрчлөгдөж эхлэв. Ингэснээр утга учиргүй хилс хэлмэгдүүлэлт гаарах нь арилж, хуулийн байгууллагууд жинхэнэ хууль ёсныхоо дагуу, аливаа улс төрийн нөлөөгүйгээр зарчмаа барьж ажиллах боломж жинхэнэ утгаараа бүрдэж эхэлжээ.

## ХУУЛЬ ЁСЫГ САХИН ХАМГААЛЖ САЙШААГДАВ

Дайны дараа энх цагийн бүтээн байгуулалтад шилжсэнээр манай улсын эдийн засаг, нийгэм хурдацтай хөгжиж,



үйлдвэрлэх хүчин нэмэгдсэн нь 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлсний гол үр дүн байв. Энэ хугацаанд нийт мал 8.7 хувиар өсч, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 2 дахин нэмэгджээ. Хүн амын эрүүлийг хамгаалахад ахиц гарч, өвчнөөс урьдчилан сэргийлэх ажил сайжирчээ. Ажилчин албан

# 1953

Ж.Авирмэд нар Өмнөговь, Ц.Дугарсүрэн Сүхбаатар, Л.Гүрсэд Хөвсгөл аймагт тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллав.

-Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Алтанцөгц, Ногоонуур сумдад хэсгийн байцаагч ажиллуулж эхлэв.

хаагчдын цалин, бодит орлого нэмэгдэв.

Хамгийн гол үзүүлэлт болох эдийн засаг хурдацтай хөгжихөд хуулийн байгууллагууд, тэр дундаа прокурорын байгууллагын зүгээс улс, олон нийтийн өмчийг шамшигдуулан, үрэгдүүлэхийн эсрэг тууштай тэмцэл явуулж, хууль ёсыг сахин хамгаалсантай холбоотой болохыг МАХН-ын Төв Хорооны Бүгд хурлаар сайшаасан байна.

## ТЭРЭГТЭЙ ХУЛГАЙЧИЙГ ТЭМЭЭГЭЭР ХӨӨЖ БАРИВ

1950-иад оны үед орон нутгийн прокурорын газрууд унаа машинтай болсон ч дийлэнхдээ хуучин актлагдсан машиныг засаж, сэлбэж ашиглаж байсан тул ажил хэргээ гүйцэлдүүлэхдээ энгийн хөсөг, морь, тэмээ хэрэглэх нь түгээмэл хэвээр байсныг гэрчлэх нэгэн дурсамжийг ахмад прокурор З.Батсүх ингэж ярьжээ.

“...1953 оны 12 дугаар сард машинтай хулгайчийг тэмээгээр гүйцэх шаардлага надад тулгарсан юм. Сумын сүү тосны мастер албаны 37 мянган төгрөг гэртээ хадгалаад алджээ. Тэр мөнгийг нэгэн зальт этгээд хулгайлан аваад замын машинаар Улаанбаатар хот явсан нь тодорсны хойноос нөхдийн хамт тэмээгээр хөөж 30 гаруй км газар яваад Дааган дэл уулын өвөрт айлын гадаа машинаа тавиад түр амарч байхад нь баривчилж, ял төлөвлөн шүүхэд шилжүүлж байв.

Үүнийг аймгийн прокурор Навааны Жадамба үнэлэн үзэж 5 метр ногоон дурдангаар шагнасанд би их баярлаж билээ” хэмээн дурсчээ.

***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***



Улсын дээд шүүх таслах газраас ял нь хөнгөдсөн гэж үзэж дахин таслуулахаар хэргийг мөрдөн байцаалтад буцаасан тогтоол

# 1954

4 сарын 18. СнЗ-ийн дэргэдэх Улсын орон тооны комиссын тогтоолоор прокурорын байгууллагын орон тоо, цалингийн фондыг шинэчлэн тогтоожээ.

11 сард. МАХН-ын 12 дугаар Их хурал “Социализмыг дэлгэрэнгүй байгуулах” үзэл санаа дэвшүүлж, нам, улс төр, нийгэм эдийн засгийн бүхий л үйл ажиллагаа эл зорилтод захирагдах болжээ.

12 сард. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны тогтоолоор “Порт-Артурын хэрэг” гэгчийг шийдвэрлэсэн асуудлыг судлан шалгах комиссыг байгуулав.

-Ардын Их Хурлын Тэргүүлэгчид улсын бэлтгэлийн ба албан татварын ногдлыг төлөвлөгөө ёсоор байвал зохих малд биш, бэлэн байгаа малын тоогоор бодож ногдуулах шинэ журам тогтоожээ.

-Улсын прокурор Б.Жамбалдорж БНМАУ-ын төлөөлөгчдийг тэргүүлж БНАрдчилсан Герман Улсын 5 жилийн ойн баярт оролцов.

## “СОЦИАЛИЗМЫГ ДЭЛГЭРЭНГҮЙ БАЙГУУЛАХ”-ЫН ХАЖУУГААР...

Оны төгсгөлд хуралдсан МАХН-ын 12 дугаар их хурал социалист байгуулалтыг шууд практик зорилт болгон дэвшүүлжээ. Уг их хурлаас “Манай улс 1940 оны үеэс эхлэн социалист хөгжлийнхөө шатанд орж, феодалыг эсэргүүцсэн хувьсгал социалист хувьсгал болон шилжиж эхэлсэн. Социализмыг дэлгэрэнгүй байгуулах эд материалын ба соёлын урьдчилсан нөхцөлийг хангахын тулд ихээхэн цаг



шаардагдах юм. Манай нам эдгээр эд материалын ба соёлын урьдчилсан нөхцөлийг бий болгохын тул ажиллаж ирсэн, ажилласаар ч байна” хэмээн заажээ.

Ингэснээр “социализмыг дэлгэрэнгүй байгуулах” хэмээх ойлголтыг хувийн өмчийг устгаж, нийгмийн өмчийн үнэмлэхүйн ноёрхлыг тогтоох явдал гэж үзсэнээс ардын хувийн аж ахуйтныг хоршоолох нь хойшлуулшгүй зорилт хэмээн тавьжээ.

Судлаачдын үзсэнээр энэхүү хурлаас хойш бүх үйл явдал “социализмыг дэлгэрэнгүй байгуулах” уриан дор өрнөж, ЗХУ болон бусад социалист орны нийгэм-эдийн засаг, улс төрийн харилцааны хөгжлийн эерэг, сөрөг туршлагыг Монгол орны өвөрмөц нөхцөл байдлыг төдийлөн харгалзахгүйгээр догматикаар хуулбарлан, яарч даарч, хагас дутуу хэрэгжүүлж эхэлсэн байна. Гэхдээ нийгмийн шударга ёсыг тогтоох чиглэлээр бас ч чамлахааргүй зарим ахиц

# 1954

гарч байсныг Монгол Улсын түүхийн 5 дугаар ботид онцлон тэмдэглэжээ. Тухайлбал 1954 онд “Порт-Артурын хэрэг” гэгчийг нарийвч-лан шалгах комиссыг МАХН-ын Улс төрийн Товчооны тогтоолоор байгуулж байжээ.

## ОРОН ТОО НЭМЖ, ЦАЛИНГИЙН ФОНД ШИНЭЧЛЭВ

БНМАУ-ын СнЗ-ийн 128 дугаар тогтоолд зохицуулж, Улсын орон тооны комиссоос Улсын Прокурорын газрын албан тушаалын орон тоог 41 нэгжээр, жилийн цалингийн фондыг 192 мянга 285 төгрөгөөр, Улаанбаатар хотын Прокурорын газрын албан тушаалын орон тоог 23 нэгжээр, тэдгээрийн цалингийн фондыг 84 мянга 925 төгрөгөөр, аймгуудын прокурорын албан тушаалын орон тоог 276 нэгжээр, тэдгээрийн цалингийн фондыг 81 мянга 900 төгрөгөөр тус тус тогтоожээ. Эндээс Улаанбаатар хотын Прокурорын газрын жилийн цалингийн фондын хэмжээг 23 албан тушаалын орон тоонд хуваарь үзвэл дунджаар нэг прокурорт сарын цалин 307 орчим төгрөг оногдож байжээ.

-БНМАУ-ын прокурор, цагдаагийн хошууч генерал С.Бүдрагчаа Завхан аймгийн прокурорын газарт хэсгийн прокурор, мөрдөн байцаагчаар ажиллаж эхлэв.

-Ц.Дугарсүрэн Төв, Ч.Шар Сүхбаатар, Г.Дамдинсүрэн Төв, Г.Иш Увс, З.Дорж, Г.Шагдаржав нар Хэнтий аймагт тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллаж эхэлжээ.

***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***

1950-иад оны үед мөрдөн байцаагч нарын хэрэглэдэг байсан нэгжлэг хийх эрхийн бичиг.
Энэ бичгийг БНМАУ-ын Цэрэг ба Нийгмийг Аюулаас Хамгаалах хэргийг эрхлэх яамнаас олгодог нэгжлэг хийх тухай ордер хэмэээн нэрлэж байв.



Б. Н. М. А. У.

Цэрэг ба Нийгмийг Аюулаас Хамгаалах Хэргийг Эрхлэх

Я А М

НЭГЖЛЭГ ХИЙХ ТЭХАЙ ОРДЕР.

ДУГААР—1

1953 он—6 сар—19 өдөр

# 1955

**5 сарын 18.** МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны хурлаар “Порт-Артурын хэрэг” гэгчийг хэрхэн шийдсэн шалгалтын дүнг хэлэлцжээ.

**9 сарын 6.** БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 422 дугаар тогтоолоор Улаанбаатар Төмөр замын дэргэд Шүүх ба Прокурорын газрыг байгуулах шийдвэр гаргав.

**10 сарын 1.** Тээврийн прокурорын газрын үйл ажиллагаа Улаанбаатар төмөр замын прокурорын газар нэртэйгээр эхлэв.

-“БНМАУ-ын шүүх прокурорын байгууллагын ажлын байдлын тухай” МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 187 дугаар тогтоол гарчээ.

-Ю.Гэндэнлхүндэв Налайхын хэсгийн прокурор, О.Хавдал, Т.Увш нар Баян-Өлгий, Т.Ууш Баянхонгор, Д.Пунцаг Говь-Алтай, С.Чүлтэм Дундговь, П.Хүүхнээ Завхан, Ш.Гэнэн Увс аймагт тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллажээ.

## УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН ПРОКУРОРЫН ГАЗАР



Төмөр зам орчим

БНМАУ-ын СнЗ-ийн хуралдаанаас Улаанбаатар төмөр замын прокурорын газрыг прокурорын мөрдөн байцаагч, галч, зарлага гэсэн орон тоотойгоор байгуулжээ. Ингэснээр тус прокурорын газар нь тухайн үед Улаанбаатар Төмөр замын прокурорын газар нэртэйгээр төмөр замын төв буудлын хойд талд байрлах орон сууцны 4 дүгээр байранд 10 дугаар сарын 1-ний өдрөөс ажлаа эхэлсэн байна. Анхны прокуророор нь Б. Жадамба ажиллаж байжээ. Төмөр замын прокурорын газар байгуулагдснаар Улаанбаатар төмөр замын хувь нийлүүлсэн нийгэмлэгийн хэмжээнд хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж иржээ.

## ТУСГАЙ КОМИССЫГ ТАТАН БУУЛГАВ

ЗХУ-д Н.С.Хрущевийн “дулаарал”-ын үйл явц эхэлсэнтэй холбоотойгоор Монголд ч бас нийгмийн шударга ёсыг тогтоох чиглэлээр чамлахааргүй ахиц гарч байв. Тухайлбал МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны хурлаар “Порт-Артурын хэрэг” гэгчийг хэрхэн шийдсэн талаарх комиссын шалгалтын дүнг хэлэлцээд уг хэрэгт хилсээр шийтгэгдэн ял эдэлж байсан хүмүүсийг суллах, хууль ёсыг бүдүүлгээр

# 1955

зөрчсөн хууль хяналтын болон Дотоод яамны холбогдох ажилтнуудад хуулийн хариуцлага хүлээлгэх, гэмт хэрэгтэнд хүч хэрэглэхийг Дотоод яамны удирдлагад зөвшөөрсөн МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1942 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн нууц тогтоолыг хүчингүй болгох, шүүх, прокурорын байгууллагын ажлыг үндсээр нь сайжруулж, нарийвчлан шалгагдаж гэм буруу нь тогтоогдоогүй нөхцөлд хүнийг дайчлан баривчлах явдлыг таслан зогсоох зэрэг чухал заалт бүхий тогтоол гаргажээ. Мөн Дотоод явдлын яамны дэргэд байгуулсан тусгай комиссыг татан буулгахаар шийдвэрлэсэн байна.

## ХОТЫН ПРОКУРОР ХОТЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИВ

1955 онд хотын прокурор нь 23 орон тоотой, дээд боловсролтон 2, хууль цаазны курс төгссөн 10, бүрэн бус дунд боловсролтой 1 хүн ажиллаж байжээ. Хотын прокурорын төсөв нь Улсын прокурорын төсөвтэй хамт байж байгаад энэ оны 1 дүгээр сараас эхлэн Улаанбаатар хотоос санхүүждэг болсноор ажиллах нөхцөлд нь ахиц гарч, засвар хийх, эд зүйл авах зэрэг төсөв нь өмнөх оныхоос 20 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

## ХОРТОЙ АРГААР АШИГЛАСНЫГ ИЛРҮҮЛЖЭЭ

Энэ үед прокурорууд нь хяналтынхаа ажлын гол хэсгийг улс, иргэдийн өмчийг ашиглах, хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд голлон чиглүүлж, олон тооны ашиглал, хулгайн хэргийг илрүүлж шалган шийдвэрлэдэг байжээ. Хотын прокурор Наваан 1955 оны ажлын тайландаа “... мөрдөн байцаагч Бадамжав Үйлдвэрчний эвлэлийн хотын зөвлөлийн кассын няравын “М72” мотоцикл 2, “Иж-49” мотоцикл 1 болон хашаа, байшин зэрэг нуугдмал хөрөнгийг илрүүлж, улсын 107 мянган төгрөгийг хортой аргаар ашигласныг, мөн 104 адуу хулгайлсан Дондовын хэргийг шалгаж илрүүлсэн” хэмээн дурджээ.




# 1955

## ШУУДАЙТАЙ ХЭРГҮҮДЭЭ ХОРМОЙЛЖ ОРОВ

*Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...*

Төв аймгийн прокурорын орлогч, ахмад прокурор Загдын Батсүхийн дурдатгалд “1955 оны 5 дугаар сард БНМАУ-ын прокурор Б.Жамбалдорж бүх хэрэг материалаа авчирч ажлаа танилцуул гэсний дагуу 60 гаруй тооны хавтаст хэрэг, материалыг гурилын шуудайд хийж үүрч очсон. Шуудайтай нь оруулж танилцуулахаас санаа зовж монгол дээлэндээ хормойлж ороод зөвөлгөөний ширээн дээр давхарлан овоолж байгаад тус бүрээр нь танилцуулсан.

Төв байгууллага хэргийн заримыг шийдэж шилжүүлж цөөлсөн боловч 300 гаруй үхэр ашиглаж үрэгдүүлсэн хэрэгт улсын прокурорт мөрдөгдөж байсан “үхрийн” Дамба гэгчийн 13 хавтаст хэрэг материалд тодруулж нотлуулах нэг зүйлийг надаар дахин шалгуулсан ба энэ нь гурван жилийн өмнө үхсэн үхрийн толгой хэд байгааг тоолж магадлаад ирэхийг надад даалгасан. Би газар дээр нь тоолоход 81 толгой байсан гэхэд Улсын прокурор “83 л баймаар юмсан, зөв тоолсон биз дээ” гэж эргэлзэж байсан гэжээ.



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын

Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1955 оны 5 сарын 6-ны өдөр. 9 дугаар Дугаар 482 Улаанбаатар хот

Шүүх, прокурорын байгууллагыг байгуулах тухай

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Улаанбаатарын төмөр замын газрын дэргэд шүүх ба прокурорын байгууллагыг 1955 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн байгуулсугай.

2. Улаанбаатарын төмөр замын газрын дэргэдэх шүүх ба прокурорын байгууллагын 1955 оны орон тоо, сарын цалингийн хэмжээ, аж ахуйн зардлын тесвийг бүгд 29 100 төгрөгөөр 1,2-р хавсралтын ёсоор батлуулсугай.

3. Улаанбаатарын төмөр замын газрын дэргэдэх шүүх ба прокурорын байгууллагын 1955 оны зардалд зориулж, Сайд нарын Зөвлөлийн бэлтгэл хөрөнгөөс бүгд 29 100 төгрөг, үүнээс Шүүх Яаманд 19 600 төгрөг, Улсын прокурорын газарт 9 500 төгрөг олгосугай.

ЕРӨНХИЙ САЙДЫН
I - ОРЛОГЧ
ХӨРӨТ АРХИВЫН
ГАЗРЫН ДАРГА

/ ШИРЭНДЭВ /

/ БАДАРЧ /

цохив. лхам.


# 1955



Хөвсгөл аймгийн прокуророууд БНМАУ-ын прокурор Б.Жамбалдоржтой, 1955 он

***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***

Таслан сэргийлэх арга хэмжээний нэг төрөл болох цагдан хорих тогтоол.
Хэдийнэ кирилл үсэгт шилжээд байсан ч зарим газарт үндэсний бичгээ ашигласаар байв. Цагдан хорих тогтоолыг мөрдөгч нь гараар бичиж Дотоод явдлын яамны тусгай хэлтсийн дарга, аймгийн прокурор нар баталдаг байжээ.



# 1956

**4 сард.** МАХН-ын Төв хорооны 4 дүгээр Бүгд хурлаас Х.Чойбалсанг тахин шүтсэн, хууль ёсыг ноцтой зөрчиж, үй олон хүнийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлснийг анх удаа албан ёсоор шүүмжлэв.

**7 сард.** АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар Сэлэнгэ аймгийг татан буулгасантай холбогдуулан аймгийн прокурорын газрын бүтцэд өөрчлөлт оруулав.

**9 сард.** АИХ-ын Тэргүүлэгчдээс Улс ба олон нийт, хоршооллын өмчийг ашиглан үрэгдүүлэх явдлаас хамгаалах тухай, Ард иргэдийн өмчийг хулгайгаас хамгаалах явдлыг чангатгах тухай зарлигууд гаргаж хулгайн хэрэгтэй явуулах тэмцлийг хүчтэй болгохыг хуулийн байгууллагуудад үүрэг чиглэл болгов.

**11 сард.** Шүүх, прокурорын байгууллагын төлөөлөгчид анх удаа ЗХУ-д хуулийн байгууллагын практик судлахаар морджээ.

## “ХИЛСЭЭР ХОХИРОГЧДЫН НЭРИЙГ АРИУТГАН ЦЭВЭРЛЭ...”

МАХН-ын Төв хорооны 4 дүгээр Бүгд хурал намын 1 дүгээр нарийн бичгийн дарга Д.Дамбын тавьсан илтгэлийг



Д.Дамба тэргүүтэй нам, төрийн удирдлагууд

хэлэлцэж, Х.Чойбалсанг тахин шүтэж байсныг болон хууль ёсыг ноцтой зөрчиж, үй олон хүнийг улс төрийн талаар хэлмэгдүүлснийг анх удаа албан ёсоор шүүмжилж, хувьсгалын эсэргүү хэрэгт худал зэмлэгдэн хилс шийтгэгдсэн зарим хүний нэрийг хянан үзэх нь чухал гэж МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоо үзжээ. Зөвхөн шийтгэгдээд амьд үлдсэн хүмүүсээр зогсохгүй, амь үрэгдсэн үнэнч шударга хүмүүсийн нэрийг ариутган цэвэрлэх нь тэдний үр хүүхэд, төрөл садны ирээдүйд их ач холбогдолтой гэдгийг тэмдэглэжээ.

Д.Дамба Бүгд хурлын гишүүдэд “Сүм хийдийг устгасныг Х.Чойбалсангаас болсон гэх баримт алга. Гэндэн, Дэмид нарын эсэргүү хэргийг илрүүлэн, тэдний хамсаатан нарыг бутцохих явцад гэмгүй олон шударга хүмүүсийг устгасан явдлыг Х.Чойбалсангаас болсон гэх баримтыг олоогүй. Харин Х.Чойбалсан хэтэрхий олон хүнийг завхрал гаргалаа гэж МАХН-ын Төв Хороонд илтгэл оруулаад тодорхой арга хэмжээ авсан албан ёсны баримт байна” хэмээн илтгэжээ.

# 1956

-Д.Чойдон Говь-Алтай, Л.Гомбосүрэн Увс, Б.Самбуу Ховд аймагт тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллаж эхлэв.

## ХОРИН ХУУЛЬЧ ХОЛБООТ УЛСЫГ ЗОРИВ

11 дүгээр сард Улсын прокурорын орлогч Л.Цэнд, Дээд шүүхийн орлогч дарга Д.Содномцэрэн нарын 20 хүний бүрэлдэхүүнтэй шүүх, прокурорын байгууллагын төлөөлөгчид анх удаа ЗХУ-ын хуулийн байгууллагын практик судлахаар явсан үеэс манай прокурорууд гадаадад сургалт, дадлага хийх суурь тавигдсан байна.



Зураг: ЗХУ-ын хуулийн байгууллагын практик судлахаар Москва хотноо ажилласан прокурорууд

Улсын Прокурорын мөрдөн байцаалт эрхэлсэн туслах прокурор С.Дугарсүрэн, Шүүх хяналт эрхэлсэн туслах прокурор С.Хорлоо, Ерөнхий хяналтын хэлтсийн прокурор Н.Авирмэд, Улаанбаатар хотын прокурор Г.Наваан, Булган аймгийн прокурор С.Батсүх, Төв аймгийн прокурор Ц.Дугарсүрэн, Хөвсгөл аймгийн прокурор Л.Гүрсэд нарын 8 прокурор, Шүүх Яамны орлогч сайд Д.Батаа, бусад шүүгч өмгөөлөгч нийт 20 хүн явсан байна. Тэднийг ЗХУ-ын Ерөнхий прокурор Р.А.Руденко хүлээн авч өөрийн орны Прокурорын байгууллагыг танилцуулжээ.

## СЭЛЭНГИЙН ПРОКУРОР ХЭСГИЙН ЭРХТЭЙ БОЛОВ

АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар Сэлэнгэ аймгийг татан буулгаж Төв, Булган аймагтай нийлүүлсэнтэй зэрэгцэн аймгийн прокурорын газар ч татан буугдав. Үүнтэй холбогдуулан Сүхбаатар хотын хэсгийн прокурор өргөжиж прокурор 1, мөрдөн байцаагч 2, зарлага 1 гэсэн орон тоотой Төв аймгийн прокурорын харьяанд одоогийн Сүхбаатар хотын төвд үйл ажиллагаагаа явуулах болжээ.

# 1957

**3 сард.** МАХН-ын Төв Хорооны Бүгд хурал “Сэхээтний төөрөгдөл” гээч нийгэмд бий болсныг тэмдэглэж, энэ явдалтай тэмцэхийг уриалав.

**7 сард.** МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны хурлаар 1937-1947 онд улс төрийн хэргээр шийтгэгдсэн Б.Баасанжав, Ж.Сэнгэдорж, С.Мягмар нарын 36 хүнийг цагаатгав.

**7 сарын 10.** БНМАУ-ын анхны Улсын прокурор, Шүүх яамны сайд агсан Л.Дэндэвийг Цагаатгалын ажил эрхэлсэн комиссын 1 дүгээр хурлаар цагаатгажээ.

**10 сарын 15.** БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 151 дүгээр зарлигаар “БНМАУ-ын Прокурорын хяналтын дүрэм“-ийг баталжээ.

-Улсын прокурор Б.Жамбалдоржийг ажлаас нь чөлөөлж, Хянан шалгах яамны сайдаар томилов.

## “СЭХЭЭТНИЙ ТӨӨРӨГДӨЛ”-ИЙН ХАЖУУГААР

Нам, төрийн ажилд Ю.Цэдэнбал, Д.Дамба нарын зөрчил мэдэгдэхүйц нөлөөлж, “Сэхээтний төөрөгдөл” гээчийг сэдсэнээр нийгэмд түгшүүртэй цаг үе дахин ирэх вий хэмээх болгоомжлол бий болж эхлэв. МАХН-ын Төв Хорооны Улс



Д.Дамба, Ю.Цэдэнбал

төрийн товчооноос “Манай намын бодлогод харш үзэл санаа, үг, өгүүлэл гарч байгаа тухай“ нэртэй тогтоол гаргаж, сэхээтний шүүмжлэлт уур амьсгал, олон ургальч үзлийг бүхэлд нь “Сэхээтний төөрөгдөл” хэмээн томьёолсон ч нэг хүнийг тахин шүтэж байсны хор уршгийг арилгах талаар нэгэнт эхэлсэн арга хэмжээгээ тасалдуулсангүй нь завшаантай хэмээн түүхчид дүгнэдэг.

МАХН-ын Төв Хороо ЗХУ-д аваачин хэлмэгдүүлсэн Монголын удирдах хүмүүсийн тухай асуудлыг ЗХУКН-ын Төв Хороонд албан ёсоор хүсэлт тавьж, Зөвлөлтийн тал ч Монголын удирдагчдад оногдуулсан ялыг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон ЗСБНХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллегийн шийдвэр, материалыг манайд шилжүүлэн өгчээ. Түүнчлэн Дотоод яамнаас шийтгэсэн улс төрийн хэргүүдийг нягтлан шалгах комиссыг МАХН-ын Төв хорооны дэргэд байгуулан ажиллуулж эхлэв.

# 1957

10 сарын 29. Сэвжидийн Батсүхийг БНМАУ-ын прокурорын орлогчоор томилов.

-Д.Очирхуяг Төмөр замын прокуророор, Т.Бодаубай Баян-Өлгий, Л.Гүрсэд Булган, Ж.Сангитүгж Өвөрхангай, Б.Бадарч Сүхбаатар, С.Лувсандаш Хөвсгөл аймагт тус тус аймгийн прокуророор томилогдов.

-Аж үйлдвэрийн комбинатын хэсгийн прокурорын газрыг татан буулгаж Улаанбаатар хотын прокурорын газарт төвлөрүүлэв.

## НЭГДМЭЛ, ТӨВЛӨРСӨН УДИРДЛАГЫН ЗАРЧМААР АЖИЛЛАНА

Ардын Их хурлын Тэргүүлэгчдийн 151 дүгээр зарлигаар “БНМАУ-ын прокурорын хяналтын дүрэм”-ийг баталсан нь тухайн цаг үеийн Монголын нийгэм, эдийн засаг, хууль цаазын хөгжлийн хэрэгцээг тусгасан, хууль ёсыг бэхжүүлэх ажлыг улам сайжруулах шаардлагаас ургаж гарсан ба хэрэглэсэн нэр томьёо, утга найрлагын хувьд өмнөх дүрмүүдээс илт боловсронгуй болсон хэмээн судлаачид дүгнэжээ. Дүрмээр прокурор нь орон нутгийн ямар ч байгууллага, албан тушаалтанд хамаарагдахгүй гагцхүү Улсын прокурорт захирагдах, нэгдмэл, төвлөрсөн удирдлагын зарчмын дагуу үйл ажиллагаа явуулж, АИХ-д ажлаа хариуцан тайлагнах бие даасан байгууллага болохыг зааж өгчээ.

Мөн улсын бүх яам, албан газар, түүний харьяа байгууллага, орон нутгийн байгууллага, хоршоолол нийгэмлэгүүд, олон нийтийн байгууллагын гаргаж буй акт тушаал, тогтоол, заавар, шийдвэр нь БНМАУ-ын хууль, СнЗ-ийн тогтоолд тохирч байгаа эсэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах газар, шүүхүүд, хорих газруудын үйл ажиллагаа хууль ёсоор явагдаж байгаа эсэхэд төрийн нэрийн өмнөөс хяналт тавих үндсэн үүрэгтэйг заагаад , хяналтын чиглэл тус бүрээр ямар үйл ажиллагаа явуулахыг нарийвчлан тусгажээ.

Шинэ дүрмийн зорилт, шаардлагатай уялдуулан прокурорууд ажлынхаа арга хэлбэрийг өөрчлөн ажилласан нь зохих үр дүнгээ өгсөн байна. Тухайлбал хууль тогтоомжийн биелэлтийг шалгасан газрын тоо 24,8 хувиар, шалгаж барагдуулсан хэрэг материал 1,1 дахин өссөн зэрэг хяналтын ажлын гол үзүүлэлтүүд ахисан ажээ.

Дүрэмд зааснаар Улсын прокурор нь АИХ-ын Тэргүүлэгчдээс томилогдсон орлогчидтой, төмөр зам ба цэргийн прокуророос гадна ажил төрлийн хэлтсүүдтэй, хэлтсийн дарга нар нь Улсын туслах прокурорууд байна. Улсын прокурорын газрын мөрдөн байцаах хэлтэст чухал хэргийн мөрдөн байцаагч нар, аймаг хотын прокуроруудад ахлах мөрдөн байцаагч, мөрдөн байцаагч нар ажиллахаар тусгажээ.

# 1957

## БНМАУ-ЫН ПРОКУРОР САНДАГИЙН ЧОЙЖАМЦ



БНМАУ-ын прокуророор 1957-1959 онд ажиллаж байсан С.Чойжамц нь 1912 онд Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр суманд төржээ. Тэрбээр БНМАУ-ын Шүүх яамны сайд, Үйлдвэр хоршооллын Төв зөвлөлийн дарга, Аймгийн намын хорооны 1 дүгээр нарийн бичгийн дарга, МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга, МАХН-ын Төв хорооны Хянан шалгах хорооны орлогч даргаар тус тус ажиллаж байв.

С.Чойжамц нь Улсын прокуророор томилогдохдоо хуулийн мэргэжилгүй ч өндөр боловсрол, мэдлэгтэй, нам төрийн байгууллагад олон жил удирдах ажил хийж явсан нэр нөлөө бүхий хүн байжээ. Хожим 1964 онд 52 настайдаа МУИС-ийн Хууль цаазын ангийг төгсчээ.

## ПРОКУРОРУУДЫН БОЛОВСРОЛД АНХААРАВ

Цаг үе өөрчлөгдөж, хууль дүрэм боловсронгуй болохын хэрээр прокурорууд дотоод, гадаадын хууль, цаазын сургуульд мэргэжил, мэдлэг, боловсролоо дээшлүүлэхэд анхаарах болов. Жишээ татвал, Улаанбаатар хотын прокурорын газраас боловсон хүчнийхээ мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд ихээхэн анхаарч зөвхөн энэ онд прокурор, мөрдөн байцаагч 14 хүний дөрөв нь Хууль цаазын дунд сургуульд оройгоор, дөрөв нь Марксизм-Ленинизмийн оройн дээд сургуульд, гурав нь Орос хэлний оройн курст суралцаж байв. Энэ хэрээр прокурорын байгууллагын төсөв орон тоо нэмэгдэж байлаа.



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн
ТОГТООЛ

1957 оны 10 дугаар сарын 11-ний өдөр. Дугаар 413 Улаанбаатар хот.

Улсын прокурорын газрын орон тоо, цалинг бэхлэх тухай.

БНМА Улсын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

Улсын прокурорын газрын орон тоог 44 нэгж, сарын цалингийн фондыг 25 515 төгрөгөөр хэвээрлэтэл өсөөр батлагдсугай.

БНМА Улсын Сайд нарын Зөвлөлийн дарга
I-р орлогч дарга ШӨНД


БНМА Улсын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн эрхлэгч /ДАГВАДОРЖ/

Бүртгэлийн дугаар 41
ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТҮСГАЙ АРХИВ
ХУУЛБАР ҮНЭН

# 1957

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

# Зарлиг

1957 он 10 дугаар сарын 15-өөр, дугаар 151
Улаанбаатар хот

Б Н М А УЛСЫН ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН
ДУРМИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Б.Н.М.А.Улсын Их Хурлын Тэргүүлэгчдээс Т О Г Т О О Х нь :

1.Б.Н.М.А.Улсын Прокурорын хяналтын дүрмийг батлансугай.

2.Б.Н.М.А.Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 113 дугаар тогтоолоор батлагдсан Улсын Прокурорын дүрмийг хүчингүй болгосугай.

Б. Н. М. А. Улсын Их Хурлын
Тэргүүлэгчдийн дарга ..... (Ж. САМБУУ)

Б. Н. М. А. Улсын Их Хурлын
Тэргүүлэгчдийн орлогч дарга ..... (Д. ШАРАВ)

Б. Н. М. А. Улсын Их Хурлын
Тэргүүлэгчдийн нарийн
бичгийн дарга ..... (Д. ДАМБА)

Тэргүүлэгчид: (С. ЯНЖМАА)
(М. ХАШГАМБЙ)
(Д. ТӨМӨР-ОЧИР)
(Д. БАЛЖИН-НЯМ)

# 1958

-Хуулийн байгууллагын төв орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөн болов.

-Нам улс төрийн амьдралд нөлөө бүхий хэвээр байсан Хянан шалгах яамны сайд Б.Жамбалдоржийг ЗСБНХУ дахь Монголын Элчин сайдын яамны Улс төрийн зөвлөхөөр томилон хойд хөршид илгээв.

-Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотын хэсгийн прокурорыг байгуулав.

-С.Бүдрагчаа Улсын прокурорын туслах прокуророор, Д.Хорхой Улаанбаатар хотын прокуророор, Г.Дамдинсүрэн Төв, Л.Мишигдорж Архангай, Ц.Жалцав Баян-Өлгий, Б.Бэгз Баянхонгор, Г.Юндэнбазар Өмнөговь аймагт тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллаж эхлэв.

## НАМ, ТӨРИЙН БҮХ ЭРХ МЭДЭЛ НЭГ ХҮНИЙ ГАРТ ДАХИН ОРОВ

1950-иад оны төгсгөлд ЗХУ болон социалист системийн бусад орнуудад Намын Төв хорооны I нарийн бичгийн даргын байр суурь эрс өндөржиж, улс орны удирдлагын бүрэлдэхүүнд тэргүүн зэрэгт дэвшин гарч ирсэн байна. Үүний жишгээр 11 дүгээр сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны 2 дугаар Бүгд хурал Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалыг Намын Төв Хорооны 1 дүгээр нарийн бичгийн даргаар томилж, Д.Дамбыг Намын Төв Хорооны 2 дугаар нарийн бичгийн даргад тушаал бууруулав.



Нам, төрийн удирдлагад өөрчлөлт, шилжилт болсны нөлөөгөөр хуулийн байгууллагуудын удирдах бүтцэд ч гэсэн энэ оноос эхлэн цөөнгүй өөрчлөлтүүд орсныг судлаачид тэмдэглэжээ.

## ХУУЛЬЧДЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ ЦЭНДИЙН БҮДХАНД

Ц.Бүдханд Дундговь аймгийн Сайнцагаан суманд 1933 онд төржээ. Тэрбээр Хууль цаазны дунд, ЗХУ-д Дотоод яамны дээд сургууль төгсчээ.

# 1958



Ц.Бүдханд 1955 оноос Дундговь аймгийн ХЗЭ-ийн хорооны II нарийн бичгийн дарга, Хууль цаазны дунд сургуульд багш, захирал, цэргийн дээд сургуульд ахлах багш, Улсын болон Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокуророор ажиллажээ.


Тэрбээр “Хууль цаазны дунд сургуулийг 1950 онд Улсын Бага Хурлын тогтоолоор шүүх, прокурорын удирдах ажилтны хууль зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой байгуулсан. Тэр үед аймгуудын шүүгч, прокуроруудын 80 гаруй хувь нь мэргэжлийн бус хүмүүс байлаа. СнЗ-өөс тус сургуулийн суралцах хугацааг 1954 онд 2 жил, 1957 онд 3 жил болгон, дунд мэргэжлийн хуульчийн диплом олгохоор тогтоосон. Миний бие 1970-1988 онд тус сургуулийн захирлаар ажиллахдаа хуулийн өдөр, оройн ангийг 1144, захиргааны ангийг 270, архив, бичиг хэргийн ангийг 252, бүгд 1688 хүнд хууль зүйн дунд мэргэжил эзэмшүүлсэн” хэмээн дурсчээ.

-Баян-Өлгий аймгийн прокурорын газарт анхны хуульч мэргэжилтэй Ц.Жалцав, Б.Бураан, Б.Серикбай нар ажиллаж эхлэв.

-Улсын прокурорын газрын харьяанд аймаг, хот, цэрэг, төмөр замын зэрэг 21 прокурорын газар ажиллаж байв.

***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***

1958 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн “Хууль ёсоор гаргасан баталгаа”



# 1959

1 сарын 8. Улсын прокуророос “Асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж байх тухай” тушаал гаргаж, Эрүүгийн хэргээр бүртгэгдэх буюу ерөнхий тушаалаар шалгалт хийхээс бусад асуудалд гурав хоногийн дотор хариуг өгөх ба боловсруулах зүйлийг долоо хоногийн дотор дуусгаж байхыг үүрэг болгов.

6 сарын 29. “Социалист өмчийг ашиглах, үрэгдүүлэх явдалтай хийх тэмцлийг сайжруулах тухай” Улсын прокурорын тушаал гарав.

7 сарын 7. “Прокурорын байгууллагын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх” тушаалыг Улсын прокурор гаргажээ.

9 сарын 1. Улсын прокурорын газрын дэргэд долоон хүний бүрэлдэхүүнтэй зөвлөх эрх бүхий коллегийг байгуулав.

12 сарын 31. АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар Сэлэнгэ аймгийг дахин байгуулж, аймгийн прокурорын газрыг сэргээн байгуулжээ.

## Д.ДАМБА ТЭРГҮҮТЭН ШАХАГДАЖ, АВТОРИТАР ДЭГЛЭМ ТОГТОВ

МАХН-ын Төв Хорооны 3 дугаар Бүгд хурлаар Д.Дамбыг Намын Төв хорооны Улс төрийн Товчооны бүрэлдэхүүнээс гаргаж, Намын Төв хорооны 2 дугаар нарийн бичгийн даргаас халжээ. Д.Дамбын “хань хамсаатан” гэж үзэж, Б.Дамдин, Д.Ламчин, Ч.Сүрэнжав, С.Балган, Д.Самдан нарыг мөн намын удирдлагаас гаргасан байна. Ийнхүү улс оронд авторитар дэглэм тогтох улс төр, үзэл суртлын урьдач нөхцөл аажим аажмаар бэлтгэгдсээр байв. Түүнчлэн 50-иад оны эцэст ардын хувийн аж ахуйтныг хоршоолсноор БНМАУ-д авторитар дэглэм тогтох эдийн засгийн гол нөхцөл бүрэлдэв.

## АТАР ГАЗАР ЭЗЭМШИХЭД ЧҮ ПРОКУРОРЫН ХЯНАЛТ ОРХИГДООГҮЙ

МАХН-ын Төв хороо, Сайд нарын Зөвлөл 2 дугаар сард “Тус улсын газар тариалангийн ажлыг 1959-1960 онд эрс нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” тогтоол гаргажээ. Дараа сард нь МАХН-ын Төв Хорооны 3 дугаар Бүгд хурлаас “Атар газар эзэмших, гурилын хэрэгцээг дотооддоо хангах” асар том зорилт дэвшүүлэн тавив. Эдгээр тогтоол, шийдвэрүүдийн биелэлтэд прокурорын байгууллагыг хяналт тавьж ажиллахыг анхааруулжээ.



# 1959

## УЛСЫН ПРОКУРОРЫН АНХНЫ КОЛЛЕГИ

АИХ-ын тэргүүлэгчдийн 146 дугаар зарлигаар долоон хүний бүрэлдэхүүнтэй зөвлөх эрх бүхий Улсын прокурорын коллегийг анх байгуулсан нь хамтын удирдлага, ардчилсан зарчмыг хэрэгжүүлэхэд чухал алхам болжээ. Улсын прокурорын коллегийн анхны долоон гишүүнд БНМАУ-ын прокурор С.Жалан-Аажав, Улсын прокурорын нэгдүгээр орлогч С.Баатар, Улсын прокурорын орлогч Д.Цэдэнжав, Улсын прокурорын туслах, шүүхийн хяналтын хэлтсийн дарга Д.Лувсаншарав, Улсын прокурорын туслах, тусгай хяналтын хэлтсийн дарга Л.Чимид, Улсын прокурорын туслах, мөрдөн байцаах хэлтсийн дарга С.Батсүх, Улаанбаатар хотын прокурор Д.Хорхой нар тус тус багтаж байжээ.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

ЗАРЛИГ

1959.он 9.дүгээр сарын 1.өдөр, дугаар 146
Улаанбаатар хот

Б Н М А УЛСЫН ПРОКУРОРЫН ГАЗАРТ
КОЛЛЕГИ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Б Н М А Улсын Их Хурлын Тэргүүлэгчдээс Т О Г Т О О Х нь:

1.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Прокурорын газарт зөвлөх эрхтэй коллегийг байгуулсугай.

2.Улсын прокурорын газарт коллегийг бий болгосонтой холбогдуулан БНМАУ-ын прокурорын хяналтын дүрмийн 89 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

„ 89-р зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Прокурор нь прокурорын байгууллагуудын үйл ажиллагаанд удирдахын хамт харьяа прокуророуудын ажилд хяналт тавина.

БНМАУ-ын прокурорын газарт БНМАУ-ын прокурор /коллегийн хуралдаг даргална/ ба прокурорын газрын удирдах ажилтныг оролцуулсан 7 хүний бүрэлдүүнтэй коллегийг бай-гуулна.

Коллегиас гишүүдийг БНМАУ-ын прокурорын санаалыг үндэслэж БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдээс батална.

Улсын прокурорын газрын коллеги нь хуралдаанаараа хуулийн асуудлаар прокуророос хянамт тавих,практик ажилла-гаа,прокурор-чи[illegible]ын байцаах ялын оловсон хүчнийг бэлтгэх, сонгон [illegible]чуулж туршлага,заавар тогтлийг боловсруулах асуул-

-С.Дугарсүрэн Төв, Хорлоо Архангай, Д.Дашжамц Булган, Л.Хүрлээ Говь-Алтай, Д.Цэдэндаржаа Дорноговь, Ж.Цагаанхүү Сүхбаатар, Н.Авирмэд Увс, М.Хайсандаа Ховд, Г.Дамба Хөвсгөл аймагт тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллаж эхлэв.

-Өвөрхангай аймагт Улсын прокурор, Дээд шүүх, цагдаагийн байгууллагын хамтран зохион байгуулсан Хуульчдын бүсийн зөвлөгөөн болов.

-БНМАУ-ын СнЗ-ийн Хуулийн хорооны орлогч даргаар Д.Ёндондүйчирийг томилов.

-Дорноговь аймгийн прокурорын газарт шүүхийн хяналт эрхэлсэн туслах прокурор нэмэгдэж, хэсгийн байцаагчид хэсгийн прокурор болж өөрчлөгдөв.

# 1959


## БНМАУ-ЫН ПРОКУРОР САМПИЛЫН ЖАЛАН-ААЖАВ




С.Жалан-Аажав Завхан аймгийн Алдархаан сумын нутагт 1923 онд төржээ. Тэрбээр 1959-1960 онд БНМАУ-ын прокурор, 1960-1964 онд БНМАУ-ын СнЗ-ийн хуулийн хорооны дарга, 1964-1971 онд Мэдээлэл, радио телевизийн улсын хорооны дарга, 1971-1983 онд МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны гишүүн, нарийн бичгийн дарга, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн орлогч дарга, 1988-2006 онд ШУА-ийн харьяа Төр, эрхзүйн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 1988 оноос МУИС-ийн Хуульзүйн сургуульд зөвлөх профессороор ажиллажээ.

Монгол Улсын Гавьяат хуульч С.Жалан-Аажав 1980-аад оны эхээр албан тушаалын хувьд Ю.Цэдэнбалын дараа орж байсан ч түүнийг бүх албан тушаалаас нь огцруулж Завхан аймгийн Алдархаан суманд бригадын тоо бүртгэгчээр томилон хэлмэгдүүлж байв.

***Эрүүгийн хэргийн төв архивын сан хөмрөгөөс...***



Дээд шүүхийн даргаас Улсын Дээд шүүхийн Бүгд хуралд 1959 оны 2 дугаар сарын 6-ны өдөр бичсэн эсэргүүцэл




Хэнтий аймгийн прокуророос 1959 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр бичсэн энгийн эсэргүүцэл














# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: 1960-1969 ОН

# 1960

6 сарын 1. БНМАУ-ын прокурорын тушаалаар аймаг, хотын хэсгийн прокуроруудаас гүйцэтгэх ажлын зааврыг шинэчлэн батлав.

6 сард. Улсын прокурор Д.Ёндондүйчир Зөвлөлтөд ял шийтгүүлсэн хүмүүсийн хэргийг хэрхэн шийдвэрлэсэн талаар ЗСБНХУ-ын Ерөнхий прокурор Р.А.Руденкод албан захидал явуулав.

7 сарын 4. БНМАУ-ын Үндсэн хуулийг баталж, төр улсын түүхэн хөгжлийн ололт амжилтыг бататгаж, тодорхой үе шатны шинэ зорилт, чиглэл, эрх зүйн зохицуулалтын үндсийг тодорхойлов.

10 сарын 25. ЭБШХ-ийн 132 дугаар зүйлд хэргийн мөрдөн байцаалт нэг сарын дотор багтахгүй бол уг хугацааг аймаг, хотын прокурор 30 хоног хүртэл, түүнээс дээш хугацааг улсын прокурор сунгана гэсэн өөрчлөлт оруулсан байна.

-Улсын прокурор С.Жалан-Аажавыг албан тушаалаас нь чөлөөлж, БНМАУ-ын СнЗ-ийн Хуулийн хорооны даргаар томилов.

## ҮНДСЭН ХУУЛИАР ПРОКУРОРЫН ЭРХ, ҮҮРГИЙГ БАТАЛГААЖУУЛАВ

БНМАУ-ын Үндсэн хуулийг 3 дахь удаагаа шинэчлэн баталж, 72 дугаар зүйлд “БНМАУ-ын бүх яам, төв байгууллагууд, тэдгээрийн харьяа албан газар, байгууллага, орон нутгийн засаг захиргаа болон олон нийт, хоршооллын бүх байгууллага, мөн албан тушаалтан ба ард иргэдээс хуулийг хэрхэн нарийн чанд биелүүлж байгааг нэгэн адил хянах дээд хяналтыг улсын прокурор гүйцэтгэнэ” хэмээн заажээ.

Энэ үеэс Улсын прокурорын газар нь Улсын прокурор, түүний орлогчид, хэлтсийн дарга бөгөөд туслах прокурорууд, ахлах ба жинхэнэ мөрдөн байцаагчид, аж ахуйн хэлтэс, боловсон хүчний тасаг, нууцын эрхлэгч, прокурорын нарийн бичгийн дарга зэрэг албан тушаалын 42 орон тоотой ажиллах болов.

## МАШ НУУЦ 3543СС ТООТ ХАРИУ

Өмнө нь Б.Ширэндэв даргатай Намын Төв хорооны дэргэдэх комисс, С.Чойжамц даргатай АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэдэх Цагаатгах комисс нэлээд хүмүүсийг цагаатгасан байлаа.

1960 оноос Намын Хянан шалгах хорооны Т.Гэндэн даргатай хоёр дахь комисс томилогдож, түүний бүрэлдэхүүнд Б.Лхамсүрэн, С.Жалан-Аажав, Х.Дамдин, генерал Д.Батаа, хурандаа Цэрэнбалжир болон Улсын прокурор Д.Ёндондүйчир нарыг оруулав. Эсэргүү хэрэгт шийтгэгдсэн хэсэг удирдах хүмүүсийн хэрэг хэрхсэн тухай ЗСБНХУ-ын Ерөнхий прокурор Р.А.Руденкод Улсын прокурор Д.Ёндондүйчир захидал бичив.

А.Руденкогоос 1960 оны 6 дугаар сарын 15-нд Улсын прокурор Д.Ёндондүйчирийн нэр дээр “Маш нууц 3543СС” тоот бүхий хариу илгээж 35 хүний хэргийг Зөвлөлтийн прокурор, шүүхийн байгууллага хянан үзээд холбогдолгүй болгож цагаатгасныг дурдсан материал хавсаргаж ирүүлжээ.

Эдгээр хүмүүсийн дотор Ерөнхий сайд П.Гэндэн, Ерөнхий сайд А.Амар, Намын Төв хорооны нарийн бичгийн дарга Ө.Бадрах, Дээд шүүхийн дарга Г.Даншийцоодол,

# 1960

орлогч жанжин Ц.Лувсандоной, Худалдаа, аж үйлдвэрийн яамны сайд Э.Мэнд, Цэвээн-Жамсранжав зэрэг хүмүүсийн нэрийг дурджээ. Энэ тоот бол ЗХУ-д шийтгэгдсэн хүмүүсийн хэргийг тэндэх хуулийн байгууллагууд хянаж үзээд хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан тухай манайд ирүүлсэн анхны албан ёсны хариу байлаа.

Д.Ёндондүйчир “Миний бодлоор энэ олон хүнийг хэлмэгдүүлэх ажил хоёр шаттай явагдсан болов уу. Эхлээд олон хүнийг хилсдүүлж ихэнхийг нь устгасан, дараа нь тэр хэргийг сайн мэдэх, өөрсдөө гардан завхрал гаргаж байсан хүмүүсээ барьж устган ул мөрөө баллахыг оролдсон байдал ойлгогддог. Энэ үед прокурорууд өөрсдөө хэлмэгдсэн юм” хэмээсэн байдаг.

## Х.ДАМДИН: ГАНЦ НЭГЭЭРЭЭ ЗҮТГЭЭД АМЖИЛТ ОЛОХГҮЙ

Д.Ёндондүйчир Улсын прокурор болж, би Дээд шүүхийн даргын ажлыг авахад хуулийн байгууллагууд бүхэлдээ сулхан болчихсон, ажилтнуудын санаачлага, хариуцлага мөн тиймэрхүү, мөр мөрөө хөөсөн, хэдэн хавтаст хэргээ бие биедээ дамжуулсан төдий байлаа. Бид ярьж байгаад ерөөсөө хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааг буй болгоё.

Ганц нэгээрээ зүтгээд амжилт олохгүй юм байна гэж ярилцаад юуны өмнө гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэсэн нэгэн цэг дээр тэдний анхаарал, үйл ажиллагааг төвлөрүүлж нэгтгэе гэж тохирсон билээ. Удсан ч үгүй бидний энэ санаачилгыг нам, засаг маш их дэмжиж намын Төв хорооны тогтоол гаргасан.

Тогтоолын дагуу МХЗЭ, МҮЭ, Эмэгтэйчүүд, Хэвлэл мэдээллийн байгууллага, мэдээж хууль хяналтын байгууллага, бүр пионерийн байгууллага хүртэл гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг өөр өөрсдийн үндсэн үүрэгтэйгээ хослуулж, өөр өөрийн ажлын арга хэлбэрээр өрнүүлж эхэлснээр бүх нийтийн хөдөлгөөн болсон түүхтэй. Товчоор хэлбэл хууль, хяналтын байгууллагуудыг олон түмэн ойлгож, тэдгээрийн хэлхээ холбоо шинэ шатанд гарсан гэж болно.

*Улсын Дээд шүүхийн дарга асан Х.Дамдингийн дурдатгалаас*

-Хөвсгөл аймгийн прокурорын газар лабораторитой, байцаагчийн цүнх, дуу хураагч, гэрэл зургийн иж бүрэн хэрэгсэлтэй болов.

-Хөдөө орон нутаг дахь хэсгийн мөрдөн байцаагчдыг хэсгийн прокурор болгож эрх, үүргийг өргөтгөв.

-Улсын прокурорын тушаалаар прокурор, цагдан сэргийлэхийн байгууллагуудад 24 цагийн жижүүр гаргаж, хэргийн газрын үзлэгт прокурор оролцох журмыг тогтоож, харьяа прокурорын газрын дарга нарт давхар үүрэг болгов.

-Гавьяат хуульч Б.Дагвадорж Ховд аймгийн прокуророосын газраас хуульчийн ажлын гараагаа эхлэв.

-С.Дугарсүрэн Улаанбаатар хотын, С.Билэгт Налайхын, Г.Дамдинсүрэн Дундговь, Г.Лувсандорж Завхан, Т.Даваажав Өвөрхангай, П.Авирмэд Сэлэнгэ, О.Лхамсүрэн Төв, А.Балжинням Увс, Ю.Санжаажамц Хөвсгөл аймагт тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллаж эхлэв.

# 1960

## БНМАУ-ЫН ПРОКУРОР ДОНДОВЫН ЁНДОНДҮЙЧИР




БНМАУ-ын прокуророор 1960-1969 онд томилогдон ажилласан Д.Ёндондүйчир Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан суманд 1921 онд төржээ. Тэрбээр 1938 онд цэргийн албанд татагдаж, 1941-1944 онд Байшинтын 7 дугаар морьт дивизийн 19 дүгээр морьт хороонд сумангийн улс төрийн орлогч, 1947-1950 онд МАХН-ын Төв Хорооны дэргэдэх намын шинэ хүчний дээд сургуулийн багш, 1950-1954 онд БНМАУ-ын хэвлэл, утга зохиолыг хянах газарт төлөөлөгч, ахлах төлөөлөгч, 1959-1960 онд БНМАУ-ын СнЗ-ийн Хуулийн хорооны орлогч дарга, 1960-1969 онд БНМАУ-ын прокурор, 1969-1982 онд Монголын Ардын Армийн Улс төрийн газрын даргаар тус тус ажиллажээ. Д.Ёндондүйчир БНМАУ-ын прокуророор ажиллах хугацаандаа хууль тогтоомжийг шинэчлэх үйлсэд их хувь нэмэр оруулахын зэрэгцээ (БНМАУ-ын Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, иргэний хууль, Иргэний байцаан шийтгэх хууль, Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль) прокурорын байгууллагын гадаад харилцаа, прокурор ажилтнуудын мэдлэг, боловсрол, мэргэшилд чиглэсэн даацтай арга хэмжээнүүдийг авч түүний Улсын прокуророор ажилласан жилүүдэд өндөр боловсролтой, мэргэжлийн прокуроруудын эзлэх хувь мэдэгдэхүйц өсчээ.

Тэрээр ЗХУ-ын Ерөнхий прокурорын урилгаар Зөвлөлтөд айлчилж, хоёр улсын прокурорын байгууллагын хамтын ажиллагаанд шинэ үе шатыг нээжээ. Түүний урилгаар ЗХУ-ын Ерөнхий прокурор Р.А.Руденко 1965 онд, Болгарын Ерөнхий прокурор Иван Вачков 1967 онд айлчилж, тэднээс ажилдаа зөвлөлгөө, туслалцаа авснаас гадна Чехословак, Болгар, Ардчилсан Германы прокуроруудтай уулзаж ажил төрлийн холбоо тогтоосон байна.

Д.Ёндондүйчир ажлаа авсан анхны жилд Улсын прокурорын газраас 25 мөрдөн байцаагч ЗХУ-д 6 сарын хугацаагаар сургалтад хамрагджээ. Улмаар прокурор, мөрдөн байцаагч нарыг гадаадад мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулахын зэрэгцээгээр орон нутгийн прокурор, мөрдөн байцаагч нарыг төв аппаратад авчирч 10 хоногоос 3 сар хүртэл хугацаагаар дадлагажуулах сургалтын хүрээ тэлж, МУИС, Намын дээд сургууль, СнЗ-ийн дэргэдэх курст мэргэжил дээшлүүлэх ажлыг удаа дараа явуулж сургах болжээ.

# 1960

***ТЕГ-ын Тусгай архивын сан хөмрөгөөс...***



110

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн

Т О Г Т О О Л

1960 оны 8 дугаар сарын 17 -ны өдөр | дугаар 104 | Улаанбаатар хот

Дээмэйн хэсгийн шүүх, прокурорын эсхион байгуулалтын тухай.

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1.Улсын ба орон нутгийн томоохон үйлдвэр, аж ахуйн газар төвлөрсөн буюу зарим онцгой шаардлагатай тойрог, хэсэгт 1-р эрргийн хэсгийн шүүх, хэсгийн прокурор, тэдгээрээс бусад тойрог, хэсэгт 2-р эрргийн хэсгийн шүүх,прокурорын байцаагчтай байхаар тогтоосугай.

2.Энэ тогтоолын 1-р зүйлийн үндсэн дээр одоогийн байгаа хэсгийн шүүх, прокурорын эсхион байгуулалтад энэ оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн, 1,2-р хавсралтын ёсоор дор дурдсан өөрчлөлт оруулахыг Улсын Дээд Шүүх, Улсын Прокурорын газарт зөвшөөрөх үүнд:

а/хэсгийн шүүх 98-аас 34-ийг 1-р эрргийн хэсгийн шүүх, 64-ийг 2-р эрргийн хэсгийн шүүх болгох;

б/хэсгийн прокурор, байцаагч 68-аас 28-ыг хэсгийн прокурор, 40-ийг прокурорын байцаагч болгохыг тус тус зөвшөөрсүгэй.

3.Хэсгийн шүүх, прокурорын ажилтан нарын сарын цалингийн хэмжээг 1960 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн, дор дурдсанаар шинэчлэн тогтоосугай:

а/1-р эрргийн хэсгийн шүүгч, хэсгийн прокурор 400 төгрөг;

б/1-р эрргийн хэсгийн шүүхийн нарийн бичгийн дарга 273 төгрөг;

Бүртгэлийн дугаар 40

ТАГНУУДЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТУСГАЙ АРХИВ

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ажилтны гарын үсэг

20.. оны .. сарын .. -ний өдөр

9131701 ГСТ6056

# 1961

1 сард. Аймаг, хотын шүүх, прокурор, НАХЯ, Улсын цагдан сэргийлэх газрын анги хэлтсийн удирдах ажилтнуудын хамтарсан зөвлөгөөнийг зохион байгуулав.

3 сарын 24. АИХ-ын Тэргүүлэгчдийн 90 дүгээр зарлигаар БНМАУ-ын Эрүүгийн хуулийн зарим зүйлүүдэд заасан гэмт хэргийн урьдчилсан мөрдөн байцаалтыг прокурорын мөрдөн байцаагч явуулахаар өөрчлөлт оруулж, Улсын прокурорын тушаалаар Улсын прокурорын мөрдөн байцаалтын хэлтсийн мөрдөх хэргийн харьяаллыг анх тогтоосон байна.

7 сарын 3. МАХН-ын 14 дүгээр Их хурлаас социалист нийгмийг байгуулж дуусгах шинэ үед шилжин орсныг тодорхойлон зааж, хуулийн байгууллагуудад уриалга илгээв.

10 сарын 27. БНМАУ Нэгдсэн Үндэстний байгууллагын гишүүн болж, олон улсын тавцанд хууль ёсны эрх, үүрэг бүхий орон боллоо.

## ХОТЖИЛТ, ХӨГЖИЛ ЦЭЦЭГЛЭЛТ ХУУЛЬ ЁС ШААРДАНА

Энэ онд Улаанбаатар хотын хүн ам 200 мянгад хүрэв. Улс орны хөгжил цэцэглэлт, хотжилтоос шалтгаалан хотын прокуророос тавих хяналтын ажлын хэмжээ далайц нь өмнөхөөс улам их болов. Нэгдүгээр сард аймаг, хотын шүүх, прокурор, НАХЯ, Улсын цагдан сэргийлэх газрын анги хэлтсийн удирдах ажилтнуудын хамтарсан зөвлөгөөн



# 1961

болоход энэ байдлыг онцлон тэмдэглэж, шинээр гарсан олон тооны хууль тогтоомжуудыг нэг мөр сахиж биелүүлэхэд тавих прокурорын хяналтыг бүх талаар эрс сайжруулах зорилт тавьжээ.

Зөвлөгөөнд СнЗ-ийн дарга, МАХН-ын Төв хорооны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал оролцож, социалист нийгмийг байгуулж дуусгах шинэ үед хуулийн байгууллагуудын оролцоо чухал болохыг онцлон тэмдэглэжээ. Мөн энэ үеэр СнЗ-ийн Хуулийн хорооны дарга С.Жалан-Аажав, БНМАУ-ын прокурор Д.Ёндондүйчир нар илтгэл тавьж хэлэлцүүлсэн ба үүний мөрөөр хот хөдөөгүй прокурорын газруудад олон арга хэмжээ авч ажиллажээ.



## ХУУЛЬТАЙ ХАЙРЦАГ

Дундговь аймагт ойролцоо аймгуудын прокурор, шүүх, цагдан сэргийлэх ангийн дарга нарын бүсчилсэн зөвлөгөөн болов. Энэ үеэр шинээр батлагдсан БНМАУ-ын Эрүүгийн хуулиар семинар хийж, Төв аймгийн прокурор О.Лхамсүрэн “Хуулийн сурталнэвтрүүлгиин ажил хэрхэн зохиож байгаа тухай” сонсгол тавьж хэлэлцүүлсэн байна. Тэрээр 40 шахам хууль тогтоомжийг багтаасан, хуудас хуудсаараа салдаг өргөдөл, гомдол хүлээж авах хайрцаг бүхий “Хууль сурталчлах хавтас”-ыг улсын хэмжээнд анх санаачилснаа танилцуулсан байна.

-Ардын Их Хурлаас БНМАУ-ын Эрүүгийн хуулийг батлав.

-Г.Шагдаржав, Г.Тогоонтөмөр, Р.Батмөнх нарын 30 хуульчийг ЗХУ-ын Харьков хотын прокурор, мөрдөн байцаах ажилтны мэргэжил дээшлүүлэх институтэд 6 сарын курст суралцуулав.

-Ж.Авхиа Нийгмийг аюулаас хамгаалах яамны Нэгдүгээр орлогч сайд бөгөөд Улсын цагдан сэргийлэх Ерөнхий газрын даргаар томилогдов.

-Дашжамц Архангай, Ж.Цагаанхүү Булган, Н.Авирмэд Сүхбаатар, Н.Өлзийбадрах Ховд аймагт тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллаж эхлэв.

-Зүүнхараа хотын прокурорын газрыг байгуулав.

-Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Алтанцөгц, Ногоон нуур сумын хэсгийн байцаагчийг хэсгийн прокурор болгон эрх, хэмжээг нь өргөтгөн ажиллуулав.

# 1961

*Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...*

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД**
**УЛСЫН ПРОКУРОРЫН**

# ТУШААЛ

1961 оны 7 -р сарын 24 № 128. Улаанбаатар хот

мотоцикл хуваарилах тухай.

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 6-р сарын 14-ний өдрийн 318-р тогтоолын 4-р зүйлд Улаанбаатар хотын дотор ба төмөхөн үйлдвэрийн газар, сангийн ая ахуйн нудын дэргэдэх хэсгийн прокуроруудад хэлэлцүүлэхээр олгосон 12 мотоциклийг дор дурьдсан аймаг хотын хэсгийн прокуроруудад хуваарилсугай.

1. Улаанбаатар хотын Налайхын хэсгийн прокурорт.
2. Улаанбаатар хотын Толгойтын хэсгийн прокурорт.
3. Улаанбаатар хотын комбинатын хэсгийн прокурорт.
4. Сэлэнгэ аймгийн дархан хэсгийн прокурорт.
5. Сэлэнгэ аймгийн зүүнбүрэнгийн хэсгийн прокурорт.
6. Сэлэнгэ аймгийн Зүүнхараагийн хэсгийн прокурорт.
7. Өвөрхангай аймгийн Хар хорины хэсгийн прокурорт.
8. Завхан аймгийн Тосонцэнгэлийн хэсгийн прокурорт.
9. Төмөр замын прокурорт.
10. Төв аймгийн Баян-чандмангийн хэсгийн прокурорт.
11. Архангай аймгийн Төвшрүүлэхийн хэсгийн прокурорт.
12. Улсын прокурорын тусгай хяналтын хэлтэст.

2. Мотоцикл хэрэглэх болсон хэсгийн прокуроруудад мотоцикл ашиглаж болох хугацаанд өдөрт нэг литр бензин хэрэглүүлэхээр боцож зохих зардлыг олгож байхыг аймаг хотын прокуроруудад даалгасугай!

# 1961

## 1960-ААД ОНЫ ШИЛДЭГ ПРОКУРОРУУД

БНМАУ-ын прокурор 1960-1969 онд ажиллаж ирсэн Д.Ёндондүйчир “Улсын прокурорын газарт ажиллаж байсан он жилүүдэд миний нэгдүгээр орлогчоор С.Баатар, Б.Жадамбаа, С.Бүдрагчаа, орлогч прокуророор Д.Цэдэнжав, Ц.Загд, прокуророор Д.Цэдэндаржаа, Б.Хорлоо, Ц.Дугарсүрэн, О.Лхамсүрэн, Г.Наваан, Д.Очирхуяг, Г.Гэндэнлхүндэв, Т.Даваажав, С.Дугарсүрэн, Р.Батмөнх, Г.Шагдаржав, М.Гомбосүрэн, Ж.Сангитүгж, Д.Лувсандагва, М.Жалцав, М.Бадрах, Г.Юндэнбазар, Л.Хөхийсүрэн, Л.Хүрлээ, Г.Бэгз, Д.Дашжамц, Самбуу, Д.Хишигдэлгэр, Х.Жамбал, Д.Зундуй, Ж.Гомбодорж, Х.Үржиндорж, А.Буран, М.Дүнчинсүрэн, А.Ядмаа, Д.Сүрэнжав, Л.Сүрэнхорлоо, О.Жамбалдорж, Н.Сүрэнхорлоо, Г.Тогоонтөмөр, З.Цэдэн-Иш, Н.Сосорбарам, Л.Ядмаа, Д.Сэдээхүү, С.Дашдондов, Д.Даваасүрэн зэрэг олон жил ажилласан санаачлага, баялаг туршлага идэвх зүтгэлтэй прокурорууд ажиллаж байлаа” хэмээн дурсчээ.



60-аад оны үеийн Увс аймгийн прокурорын газрын прокурор, ажилтнууд

# 1961

***ТЕГ-ын Тусгай архивын сан хөмрөгөөс...***

4b

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн

**ТОГТООЛ**

1961 оны 6 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 312 | Улаанбаатар хот

Улсын прокурорын хүсэлтийн тухай.


БНМА Улсын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Өлөн сум, байгууллага харьяалж байгаа зарим прокурорын байцаагч нарыг хавсралтын ёсоор энэ оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн, хэсгийн прокурор болгохыг Улсын прокурор /н.ЁНДОНДҮЙЧИР/-т зөвшөөрсүгэй.

2. Орон нутагт ажилладаг байгаа хэсгийн прокурор, байцаагч нарт харэглэгдэж байгаа морь, тэмээнээс үүрэг гүйцэтгэж чадахгүй болсны нь актлан, хөдөө аж ахуйн зэргэлдэ шилжүүлж, оронд нь хэсгийн харьяалсан сум бүрд 2 морь буюу /говьд/ тэмээгээр бодож, эдэлгээнд тохирох залуу морь, тэмээг зөвшөөр авахуулах буюу орон нутгийн харьяа улсын байгууллагаас шилжүүлж байхыг аймгуудын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаадын дарга нарт даалгасугай.

3. Сангийн аж ахуйнуудын дэргэд ажиллаж байгаа хэсгийн прокуроруудын уналгад зориулан, 4-6 морийг балансаас балансад шилжүүлэн өгөхийг Сангийн аж ахуйнуудыг удирдах газар /н.ЛООХУУЗ/-д даалгасугай.

4. Улаанбаатар хотын дотор ба томоохон үйлдвэрийн газрууд, сангийн аж ахуйнуудын дэргэдэх хэсгийн прокуроруудад хэрэглэгдэх 12 мотоцикл худалдан авахад шаардагдах хөрөнгийг Сайд нарын Зөвлөлийн бэлтгэл хөрөнгөөс Улсын прокурорт олгохыг Сангийн яам /н.ДУГЭРСҮРЭН/-д даалгасугай.






# 1961

***ТЕГ-ын Тусгай архивын сан хөмрөгөөс...***

2.

5. Прокурорын байгууллагад олгосон мотоциклийн бензиний эдер дутам төвд 1 литрээр, хөдөө 3 сумдаар явахад явсан км-ээр бодож олгохоор тогтоосугай.

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн 1-р орлогч дарга МОДОМЖАМЦ

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн Хэрэг эрхлэх
газрын 1-р орлогч дарга ЦЭРЭНЖАВ

Хуулбар үнэн: Тогтоол эрхлэгч ДАГВАДОРЖ






# 1962

**2 сарын 13.** Хилс хэрэгт амиа алдсан Улсын прокурор Ө.Пунцаг, Ж.Дэндэв, М.Ядамсүрэн, Н.Борхүү, С.Пунцагдорж нарыг АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэдэх Цагаатгах ажлыг эрхлэх комиссын 80 дугаар тогтоолоор цагаатгаж, хэргийг хэрэгсэхгүй болгов.

**4 сарын 7.** СнЗ-ийн 424 дүгээр тогтоолоор Дархан хотын прокурорын газар байгуулагдв.

**4 сарын 18.** Улсын прокурор гэмт хэргийн газрын үзлэгт прокуророос заавал оролцож байх тушаал гаргав.

**6 сарын 12.** Улсын прокурорын тушаалаар Урьдчилсан мөрдөн байцаалтыг төвлөрүүлэх ажлыг эрхлэх комиссыг байгуулжээ.

-БНМАУ Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлд ажиглагч гишүүнээр 6 жил болсны эцэст гишүүнээр элсэв.

-МАХН-ын Төв Хорооны III Бүгд хурал Д.Төмөр-Очироос намын эсрэг үйлдсэн ажил явуулгын тухай хэлэлцэж тогтоол гаргажээ.

## НЯМБАЙ ХУУЛИЙГ ЧАМБАЙ ХУУЛЬЧИД БОЛОВСРУУЛДАГ

БНМАУ-ын Эрүүгийн хууль, Иргэний хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний байцаан шийтгэх хууль, Засан хүмүүжүүлэх хууль зэргийг 1960 онд батлагдсан Үндсэн хуультай уялдуулан шинэчлэх нөр их ажил хоёр жил үргэлжилж дууссан ба АИХ-аар эцэслэн батлуулж, даган мөрджээ. Энэ ажилд СнЗ-ийн дэргэдэх (1958 онд Шүүх яам татан буугдаж оронд нь байгуулагдсан) Хуулийн хорооны дарга С.Жалан-Аажав, мөн хорооны орлогч дарга Д.Хорхой, Дээд шүүхийн дарга Х.Дамдин, Улсын прокурор Д.Ёндондүйчир нар оройлон оролцсоноос Д.Ёндондүйчир Эрүүгийн хуулийн төсөл дээр дагнан ажиллажээ.

Энэхүү хуулиуд нь 1992 он хүртэл засваргүйгээр мөрдөгдсөн маш чамбай хууль байсныг хууль, эрхзүйн судлаачид, нэртэй хуульчид хүлээн зөвшөөрдөг.

## ЦАГААТГАХ АЖЛЫГ УЛСЫН ПРОКУРОРООС УДИРДАНА


МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооноос 1962 оны 2 дугаар сарын 8-ны өдөр “Хувьсгалын эсэргүү хэрэгт хилс шийтгэгдэгчийн хэргийг шалган цагаатгах ажлыг эрхлүүлэх тухай” 4 тоот тогтоол гаргаж, Цагаатгах ажлыг эрхлэх комиссыг татан буулгаж, хэргийг Шалгах хэлтсийг Нийгмийг аюулаас хамгаалах яамны дэргэд хэвээр ажиллуулж, ажил хэргийн хувьд Улсын прокуророос удирдаж, Намын Хянан Шалгах хороо хяналт тавьж цагаатгах ажлыг эрхлэн явуулахыг даалгасан байна.

Энэ тогтоолтой нийцүүлэн БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1962 оны 3 дугаар сарын 9-нд “Хувьсгалын эсэргүү хэрэгт хилс шийтгэгдэгчдийг цагаатгах журмын тухай” 57 тоот зарлиг гаргаж, Цагаатгах ажлыг эрхлэх комиссыг татан буулгаж, Нийгмийг аюулаас хамгаалах яамны шалгалтаар хилс шийтгэгдсэн нь батлагдаж байгаа хүмүүсийн талаар Дээд Шүүхийн бүгд хуралд эсэргүүцэл бичиж байхыг Улсын прокурорт, прокурорын эсэргүүцлийг үндэслэн Дээд Шүүхийн бүгд хурлаар хэргийг хянан хэлэлцэж, цагаатгах эсэхийг шийдвэрлэж

# 1962

байхыг тус тус даалгасан байна. Улс төрийн хэрэгт хилсээр ял шийтгүүлсэн хүмүүсийн хэргийг шалгах, цагаатгах ажиллагаа ийнхүү тус улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу явагдах болсон байна.

***ТЕГ-ын Тусгай архивын сан хөмрөгөөс...***



Бүртгэлийн дугаар 43

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУСГАЙ АРХИВ

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ҮНЭН

Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1962 оны 6 дугаар сарын 18-ны өдөр — Дугаар 8/8 — Улаанбаатар хот

Мөрдөн байцаах ажлыг төвлөрүүлэх тухай.

Мөрдөн байцаах ажлыг прокурорын байгууллагад төвлөрүүлэх тухай БНМА Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчийн 1962 оны 114 дүгээр зарлигийг үндэс болгон, БНМА Улсын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Улсын цагдан сэргийлэх газрын системд ажиллаж байгаа мөрдөн байцаах аппаратыг татан буулгаж, бүх мөрдөн байцаах ажлыг 1962 оны 7 дугаар сарын 1-нээр тасалбар болгон, прокурорын байгууллагад төвлөрүүлж, Улаанбаатар хотын прокурорын дэргэд мөрдөн байцаах газар, аймгийн прокурорын дэргэд мөрдөн байцаах групп байгуулан ажиллуулахаар тогтоосугай.

2.Нийгмийг Хамгаалах Яам /н.БАНЗРАГЧ/-д үүрэг болгох нь:

а/Улсын цагдан сэргийлэх газрын харьяа хот,хөдөөгийн мөрдөн байцаах аппаратад ажиллаж байгаа 40 хүнийг бүх төсөв зардал, эд хогшил, орон сууц, "ГАЗ-69" машин нэгийн хамт Улсын Прокурорын Газрын мэдэлд шилжүүлсүгэй;

б/Улаанбаатар хотын мөрдөн байцаах аппаратын конторт зориулан, одоо цэргийн шүүх, прокурорын байрлаж байгаа конторыг шилжүүлэхийн хамт, Улсын цагдан сэргийлэх газрын контороос 6 тасалгаа гаргаж өгсүгэй;

в/төв хориход хоригдож байгаа хүмүүсийг байцаахад зориулан,байцаагч нарын ажлаах 4 тасалгааг энэ оны 7 дугаар сард багтаан засварлаж өгсүгэй.

3.Мөрдөн байцаах ажлыг төвлөрүүлж байгаатай холбогдуулан, Улсын Прокурорын Газарт хэлтсийн прокурор 2,мөн Улаанбаатар хотын прокурорын орон тоог 20 нэгж, аймгийн прокурорынхыг 27 нэгжээр тус тус нэмэгдүүлж, эдгээр 49 хүний цалин ба бусад зардлыг Улсын цагдан сэргийлэх газраас шилжиж очсон хөрөнгөнд багтаахыг Улсын Прокурорын Газар /н.ӨНДӨНДУЙЧИР/,Сангийн Яам /н.

9131701 ГСТ6056

-Дархан, Налайх хотын прокурорын газруудыг байгуулав.

-АИХ-ын Тэргүүлэгчдээс Улсын прокурорын газрыг хөдөлмөрчдөд хууль таниулах ажлыг сайжруулах, улс, хоршооллын өмч хамгаалахад бусад байгууллагатай хамтарч ажиллах тухай тогтоол гаргав.

-Т.Даваажав Улаанбаатар хотын прокуророор, Н.Авирмэд, Б.Данзан нар дараалан Тээврийн прокуророор, С.Дугарсүрэн Архангай, А.Бураан Баян-Өлгий, Д.Авирмэд Дархан, Ш.Хөхийсүрэн, С.Цэдэн-Иш дараалан Дорноговь, Д.Цэдэндаржаа Өвөрхангай, Б.Чойлдон Сүхбаатар, Д.Очирхуяг Хөвсгөл аймагт тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллаж эхлэв.

# 1962

## МӨРДӨН БАЙЦААЛТЫГ ПРОКУРОРТ ТӨВЛӨРҮҮЛЭВ

Нам, төрийн удирдлагууд мөрдөн байцаах ажлыг прокурорын байгууллагад нэгтгэн төвлөрүүлэх томоохон шийдвэрийг энэ онд гаргав. Улсын прокурорын 6 дугаар сарын 12-ны өдрийн тушаалаар Урьдчилсан мөрдөн байцаалтыг төвлөрүүлэх ажлыг эрхлэх комиссыг байгуулж комиссын даргад Улсын прокурорын орлогч Н.Цэдэнжав, гишүүдэд Улсын прокурорын туслах прокурор Ц.Дугарсүрэн, боловсон хүчний эрхлэгч Ц.Шархүү, нягтлан бодогч Дарьсүрэн нарыг томилжээ.

Мөн тушаалаар прокурорт шилжиж ирсэн байр, орон сууц, эд хогшил, машин зэргийг бүртгэн авч, УЦСЕГ-ын мөрдөн байцаах хэлтэст мөрдөж байгаа бүх хэргийг нэг бүрчлэн шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Дараа сард нь Улаанбаатар хотын прокурорын газарт Цагдан сэргийлэхийн мөрдөн байцаалтын ажлыг орон тооны хамт шилжүүлэн төвлөрүүлснээр хотын прокурорын газар нь хоёр хэлтэс, 28 мөрдөн байцаагч бүхий Мөрдөн байцаах газартай болж, үйл ажиллагаа нь өргөжжээ.



Ж.Гомбодорж тэргүүтэй БНМАУ-ын прокурорын байгууллагын төлөөлөгчид ЗХУ-ын Иркутск хотноо мэргэжил дээшлүүлэх сургалтад суухаар очоод байгаа нь, 1962 он

# 1962



## НАЛАЙХ ХОТ БОЛЖ, ХЭСГИЙН ПРОКУРОР ТОМРОВ

“Уурхайчдын хороо” нэртэй байсан Налайхыг АИХ-ын Тэргүүлэгчдийн 88 дугаар зарлигаар өөрчилж хот болгов. Үүнтэй холбогдуулан Улаанбаатар хотын прокурорын газрын харьяа хэсгийн прокурорын газрыг Налайх хотын прокурорын газар болгон өргөжүүлэв.

Ингэснээр Налайх хотын прокурорын газар нь прокурор нэг, туслах прокурор 3, мөрдөн байцаагч, нарийн бичгийн дарга, зарлага, жолооч нэжгээд зэрэг найман орон тоотой ажиллах болсон байна. Өмнө нь Налайхын прокурорын ажлыг Н.Гомбо, П.Шарав, Ц.Бямбаа, Ю.Гэндэнлхүндэв нар ажиллаж байсан бол 1960-1963 онд прокуророор ажиллаж байсан С.Билэгтийн үед ийнхүү хотын прокурорын газар болжээ.

## ДАРХАН ЗАНГИЛААНЫ 8 ТООТ ЧУЛУУН БАЙШИНД

Дархан хотын прокурорын газар нь СнЗ-ийн 424 дүгээр тогтоолоор хотын прокурор, мөрдөн байцаагч, зарлага, үйлчлэгч тус бүр нэгийн орон тоотойгоор байгуулагдаж, Дархан зангилааны 8 тоот чулуун байшинд үйл ажиллагаагаа явуулж эхлэв. Үүнээс өмнө Сэлэнгэ аймгийн прокурорын газарт харьяалагдан хэсгийн прокурорын нэгж орон тоогоор ажиллаж байв. Хот байгуулагдах үед хэсгийн прокуророор ажиллаж байсан Д.Авирмэд нь хотын прокуророор дэвшин томилогдсон учир Дархан хотын анхны прокурор болжээ.

## ТҮВШИНГИЙН ДАВААЖАВ



Т.Даваажав Баян-Өлгий аймгийн Алтанцөгц суманд 1925 онд төрж, МУИС-ийн хуулийн ангийг төгсчээ.

Тэрбээр 1942-1945 онд Баян-Өлгий аймгийн шүүхэд гар бичээч, нарийн бичгийн дарга, орлогч дарга, 1945-1949 онд Өмнөд фронтын цэргийн шүүхийн нарийн бичгийн дарга, 1949 оноос Улаанбаатар хотын цэргийн шүүхийн орлогч, 1950 оноос Өндөрхааны гарнизоны цэргийн шүүхийн дарга, 1951 оноос Бүх цэргийн прокурорын туслах бөгөөд Нийслэл хотын цэргийн прокурор, 1954 оноос Улсын Дээд шүүхийн гишүүн, 1958 оноос Дээд Шүүхийн орлогч дарга, 1960-1986 онд Өвөрхангай аймаг, Улаанбаатар хот, Ховд аймгийн прокуророор томилогдон ажиллажээ. Т.Даваажав 1962 онд Улаанбаатар хотын прокуророор томилогдоход хотын прокурорт УЦСГ-ын Мөрдөн байцаах албыг бүхэлд нь шилжүүлж өгснөөр хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, хяналт тавих бүхий л үйл ажиллагаа тэнд хийгдэх болсон байна.

# 1963

**1 сарын 20.** Улсын прокурорын тушаалаар мөрдөн байцаагч нарыг протфель (цүнх), зургийн аппаратаар хангах шийдвэр гаргав.

**2 сарын 22.** СнЗ-ийн 73 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын прокурорын газрыг өргөжүүлэн зохион байгуулав.

**9 сарын 30.** БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 181 дүгээр зарлигаар БНМАУ-ын прокурорын хяналтын дүрмийн 39 дүгээр зүйлд өөрчлөлт оруулж, Улсын прокурорын коллегийн бүрэлдэхүүнийг 9 нэгжээр тогтоосон байна.

**2 сарын 28.** Улсын прокурорын тушаалаар Соёлын довтолгооны комисс байгуулж даргаар нь туслах прокурор Н.Дугарсүрэнг томилжээ.

**7 сарын 19.** Ж.Авхиа НАХЯ-ны Нэгдүгээр орлогч сайд бөгөөд Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын дарга, Р.Гүнсэн НАХЯ-ны Нэгдүгээр орлогч сайд бөгөөд УАХЕГ-ын даргаар тус тус томилогдов.

## ХОТЫН ПРОКУРОР ТОМОРЧ ХҮРЭЭГЭЭ ТЭЛЭВ

СнЗ-ийн тогтоол ёсоор Улаанбаатар хотын прокурорын газрын ажлын шаардлагыг харгалзан орон тоог 14-өөр нэмж, жижүүрийн машин нэг, мотоцикл гурвыг тус тус өгч, мөрдөн байцаах ажлын чухлыг харгалзан, мөрдөн байцаагч нарын үндсэн цалинг 650-700 төгрөг болгон нэмсэн байна.

Ингэснээр Улаанбаатар хотын прокурорын газар нь жинхэнэ прокурор 1, газар хэлтсийн дарга, туслах прокурор 18, мөрдөн байцаагч 34, бичиг хэрэг, аж ахуйн үйлчилгээний ажилчин 19, бүгд 71 орон тоотой, ачааны машин 1, суудлын машин гуравтай томоохон байгууллага болж өөрчлөгдөв.

Энэ оны байдлаар Улаанбаатар хотод олон нийтийн шүүх 217, цагдан сэргийлэхэд туслах олон нийтийн бригад, товчоо штаб 220, ахмадын зөвлөл, өрх аж ахуйн нөхөрлөл, ардын пост, охид хөвгүүдийн зөвлөл, сэхээтний ба социалист хөдөлмөрийн бригад зэрэг 10 шахам төрлийн 1345 зөвлөл, бригад нөхөрлөлд 17000 гаруй хүн хамрагдаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд сайн дураараа



# 1963

хуулийн байгууллагынхантай хамтран ажиллаж, баяр ёслол, амралтын өдөр, орой үдшийн цагаар эргүүлд 3000 гаруй хүн тогтмол гардаг байжээ.

## БУУРЛЫН ЖАДАМБА



БНМАУ-ын прокурорын нэгдүгээр орлогч Буурлын Жадамба нь 1929 онд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын нутагт төржээ.

Тэрбээр 1952-1953 онд Хуулийн ажилтны нэг жилийн курс, 1957-1962 онд ЗХУ-ын Ленинград хотын их сургуулийн Хуулийн анги, 1968-1971 онд Москва хотод Дипломатын Дээд сургуульд тус тус суралцаж төгсчээ.

Б.Жадамба 1945-1946 онд Жаргалтхаан суманд бичээч, 1947-1948 онд мөн суманд ангийн шүүхэд нарийн бичгийн дарга, 1948-1950 онд Бригадын буудлагын батальонд бичээч, эх зохиогч, 1950-1951 онд Өндөрхааны цэргийн прокурорт нарийн бичгийн дарга, 1951-1953 онд Бүх цэргийн прокурорт нарийн бичгийн дарга, 1953-1955 онд Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотын прокурорт туслах прокурор, 1955-1957 онд Улаанбаатар төмөр замын прокурор, 1962-1963 онд БНМАУ-ын прокурорын газарт хэлтсийн дарга, 1963-1968 онд Прокурорын нэгдүгээр орлогч, 1971-1980 онд БНМАУ-ын СнЗ-ийн Зохион зааварлах хэлтсийн дарга, 1980-1989 онд Элчин сайд, Шүүх яамны нэгдүгээр орлогч сайдаар ажиллаж байв.

12 сард. МАХН-ын Төв хорооны 4 дүгээр Бүгд хурал Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарыг авч хэлэлцэн, “Намын эсрэг бүлэг” хэмээн үзэв.

-Ардын Их Хурлаас БНМАУ-ын Иргэний хуулийг батлав.

-Буурлын Жадамбыг БНМАУ-ын прокурорын нэгдүгээр орлогчоор томилов.

-МАХН-ын Төв Хорооны 169-р тогтоолыг биелүүлэх арга хэмжээний тухай Улсын прокурорын 110 тоот тушаал гарган мөрджээ.

-Прокурорын байгууллагын боловсон хүчинтэй ажиллах заавар, гүйцэтгэлийн шалгалт явуулах тухай удирдамжийг батлан гаргажээ.

-Г.Готов Тээврийн, Д.Бэгзжав Архангай, Д.Дулмаа Баянхонгор, Бадарч Булган, Н.Лундаажанцан Дархан, Ж.Гомбодорж, Х.Жамбал дараалан Дорноговь, М.Доржпалам Өмнөговь, Г.Чогсом Хэнтий аймагт тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллаж эхлэв.

# 1964

**8 сард.** Улаанбаатар хотын прокурорын мөрдөн байцаалтын ажлын ихэнх хэсгийг Улсын цагдан сэргийлэх Ерөнхий газарт буцаан шилжүүлэв.

-Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг батлав.

-Прокурорын байгууллагын 12 ажилтныг ЗХУ-ын Эрхүү хотын Прокурорын газрын ажилтай танилцуулж, 14 хоногийн хугацаагаар туршлага судлуулав.

-Худалдааны системийн бүх байгууллагууд дээр социалист өмчийн хадгалалт хамгаалалт зарцуулалтын байдалд прокурорын ерөнхий хяналтын шалгалт хийжээ.

-Прокурорын ерөнхий хяналтын шугамаар Хөдөө аж ахуйн нэгдлүүдийн дүрэм журам нь хууль тогтоомжтой хэрхэн нийцэж буйг шалгажээ.

-Шинээр батлагдсан ЭБШ Хуулийг төв ба орон нутгийн хуулийн бүх ажилнуудад бүсчилсэн байдлаар танилцуулж 40 цагийн семинар зохион байгуулжээ.

-Шаалуу Тээврийн прокуророор, М.Хайсандай Дундговь, Ц.Жалбасүрэн Сүхбаатар, М.Хашгамбай Ховд аймгийн прокуророор тус тус томилогдон ажиллаж эхлэв.

## МӨРДӨН БАЙЦААЛТ “БУЦАВ”

АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар Улаанбаатар хотын прокурорын мөрдөн байцаалтын ажлын ихэнх хэсгийг НАХЯ-ны харьяа Улсын цагдан сэргийлэх Ерөнхий газарт



шилжүүлсэн ба мөрдөн байцаагч 39, ГАЗ-69 машин хоёр, 89600 төгрөгийн эд хогшил, конторын барилга (төсвийн хамт) тус тус шилжсэн байна. Энэ өөрчлөлтийн дараа Улаанбаатар хотын прокурорын газар нь 32 орон тоотой үйл ажиллагаа явуулах болжээ.

## “НАМЫН ЭСРЭГ БҮЛГИЙНХЭН”

Оны эцсээр хуралдсан МАХН-ын Төв хорооны 6 дугаар Бүгд хурлаас Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарыг “Намын эсрэг бүлгийнхэн” хэмээн нэрлэж “Үндсэрхэх үзлийг шууд хамгаалан, нэгэнт илчлэгдсэн улс төрийн хутган үймүүлэгч Төмөр-Очир, Цэнд нарыг далдуур дэмжигчид болохоо харуулсан” гэж буруутгажээ. Улмаар тэднийг намаас хөөж, хань хамсаатан нь гэж үзсэн олон арван хүнийг албан тушаалаас нь халж, хөдөөд нутаг заан суулгах зэргээр хилсдүүлэн хохироожээ.

# 1964

## Д.ЁНДОНДҮЙЧИР: ЭРҮҮГЭЭР ШИЙТГЭХ ҮНДЭС БАЙХГҮЙ...

Намын Төв хорооны Бүгд хурлын дараа Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарт ямар хариуцлага хүлээлгэвэл зохих тухайд Улс төрийн товчооны хуралд Улсын прокурор Д.Ёндондүйчир, Дээд шүүхийн дарга Х.Дамдин нарыг дуудан тэдний саналыг асуужээ. Энэ тухайд Д.Ёндондүйчир “Бид эрүүгээр шийтгэх үндэс байхгүй, намын шугамаар шийдвэрлэх нь зохимжтой” гэсэн саналаа хэлсэн. Дагаж мөрдөж байгаа хуулийн маань үндэслэл ийм юм. Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарыг Эрүүгийн хуулиар шийтгэх тухай Бүгд хурал дээр зарим гишүүд санал гаргаж байсан. Намын Хянан шалгах хорооны хурлаар Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав, тэдний хамсаатан гэх зарим хүмүүсийн тухай нэг бүрчлэн хэлэлцэхдээ Х.Дамдин бид хоёрыг хааяа дуудаж суулгадаг байсан. Бид тэднийг хуулиар шийтгэх үндэслэлгүй гэдгээ хэлсэн. Бид үнэн байдлыг л хэлдэг байсан” хэмээн “Миний амьдралын хуудас” номондоо өгүүлсэн байдаг.

## ДЭЭД ШҮҮХЭЭС ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН БҮХ ХЭРГИЙГ ТАТАЖ ХЯНАВ

...Жил ба улирлын төлөвлөгөөнүүдийн үндсэн дээр худалдааны бүх байгууллагуудад социалист өмчийн хамгаалалт, зарцуулалт, хадгалалтын талаар, хөдөө аж ахуйн нэгдлүүдийн дүрэм ба дотоод журам нь нам, засгийн шийдвэр тогтоол хуулийн заалтуудтай хэрхэн нийцэж байгаа талаар төв, хөдөөд шалгасан юм. Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 40 цагийн семинар сургалтыг төв ба орон нутгийн бүх хуулийн ажилтнуудад бүсчилсэн байдлаар зохион байгуулж, хуультай холбогдож мөрдөн байцаалтын ажиллагаанд шаардагдах нэлээд асуудлыг боловсруулж гаргасан байна.

Увс, Ховд, Баян-Өлгий, Архангай, Баянхонгор, Дорнод, Хэнтий, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Төв, Дархан, Налайх зэрэг 17 аймаг, хотуудын прокурорын 1963, 1964 оны ажлыг группээр шалгаж, прокурорын ажилтан нарын ажлын хариуцлагатай холбогдуулж, зарим аймагт тусгай шалгалт хийсэн юм. Түүнчлэн улсын прокурорын коллегийн хурлыг орон нутагт хийх, хулгайн хэргийн талаар судалгаа хийх, Дээд шүүхийн эрүүгийн коллегиос ял холбогдолгүй болгосон бүх хэрэг, хоёрдугаар шатны шүүхээр шалгагдаж буцаагдсан бүх хэргийг татаж хянах, зарим онцлог хэргүүдэд хотын шүүхээс ногдуулж байгаа ялын бодлогыг судлаж үзэх, тусгай хяналтын талаар дагаж мөрдөж байгаа хүчинтэй хууль, тогтоол, заавар, эрхийн актуудын товъёгийг гаргах, шорон гяндан, төв хөдөөгийн хорих лагериудыг эргэж шалгах ажлуудыг хийсэн байна.

1964 онд Улсын Их сургуулийн хуулийн факультет ба хуулийн дунд сургууль төгссөн 40 гаруй хүнийг зохих ажилд хуваарилан томилох, сэргийлэхийн төв хөдөөгийн хэлтэс ангиудын хэрэг бүртгэлтийн ажилд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг яаж биелүүлж байгааг шалгах, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг хэрэглэхэд гарсан практикийн зарим асуудал, хугацаа сунгах журамтай холбогдсон Улсын прокурорын тушаал заавар гаргах зэрэг гол гол асуудлууд хийгдсэн байна.

*БНМАУ-ын прокурорын жилийн ажлын тайлан илтгэлээс...*

# 1965

**8 сарын 11.** Улаанбаатар хотын Сүхбаатар, Найрамдал, Ажилчин, Октябрийн районд прокурорын газрыг тус тус байгуулав.

**11 сард.** ЗХУ-ын “Социалистическая законность” сэтгүүлд үлгэр жишээ прокурор О.Лхамсүрэнгийн зураг нийтлэгдэв.

**12 сард.** Улсын прокурор Д.Ёндондүйчирээс бичсэн хоёр дахь захидлын хариу ЗХУ-аас ирэв.

-ЗХУ-ын Ерөнхий прокурор Р.А.Руденко тэргүүтэй төлөөлөгчид Улсын прокурорын урилгаар БНМАУ-д айлчлав.

-Энэ оноос район, орон нутгийн прокурорын газарт шүүхийн хяналтын туслахын орон тоо бий болгов.

-С.Бүдрагчаа Улаанбаатар хотын прокуророор, Д.Цэрэнбалтав Тээврийн прокуророор, Д.Хайсандай Найрамдлын районы, Д.Өлзий Октябрийн, Ж.Сангитүгж Ажилчны, Г.Тогоонтөмөр Налайхын районы прокуророор, Г.Чогсом Дундговь, П.Хүүхнээ Завхан, А.Ядмаа Увс, С.Лувсандагва Хэнтий аймгийн прокуророор тус тус томилогдон ажиллаж эхлэв.

## 1055 ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ СЭРГЭЭВ

Улсын прокуророос бичсэн дараачийн захидалд ЗХУ-ын прокурор Р.А.Руденкогоос хариу ирэв. Маш нууц 1/910 СС тоот албан бичигт Сангийн яамны сайд С.Довчин, орлогч жанжин Г.Дамба, ДЯЯ-ны Ц.Готов, Цэргийн ар талын газрын С.Алтангэрэл, Мал тариалангийн яамны сайд З.Пүрэвдорж, Худалдааны яамны сайд Д.Шагдаржав, Улсын худалдааны баазын Нанзад нарын олон хүмүүсийг цагаатгасан тухай өгүүлжээ. Ийнхүү ЗХУ-ын Ерөнхий прокурор Р.А.Руденкогийн нэр дээр 1960, 1965 онд хоёр удаа албан захидал бичиж албан ёсоор ирүүлсэн хариу баримтуудыг үндэслэн Улсын прокурорын эсэргүүцлээр Улсын Дээд шүүхээр 1960-1965 онд 1055 хүнийг цагаатгажээ.

## ОКТЯБРИЙН РАЙОНЫ ПРОКУРОРЫН ГАЗАР

АИХ-ын Тэргүүлэгчдийн 8 дугаар сарын 11-ний зарлигаар Улаанбаатар хотын Засаг захиргааны зохион байгуулалтыг өөрчилж, Октябрийн районы прокурорын газрыг байгуулав. Районы прокурор нэг, шүүн таслах ажиллагаанд хяналт тавих туслах прокурор нэг, цагдан сэргийлэх албадын үйл ажиллагаанд хяналт тавих туслах прокурор нэг, нарийн бичгийн дарга гэсэн дөрвөн орон тоотой үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ.

Октябрийн районы прокурорын газраас одоогийн Баянгол дүүргийн прокурорын газрын түүх эх авдаг. Анхны прокурор Д.Өлзий, шүүхийн хяналт эрхэлсэн туслах прокурор Д.Долгорсүрэн, тусгай хяналт эрхэлсэн туслах прокурор Юлсүрэн, нарийн бичгийн даргаар Д.Юүзээ нар тус тус ажиллаж, Барилгачдын 6 дугаар байранд орон сууцны зориулалттай хоёр өрөөнд ажлаа эхэлжээ.

Октябрийн район нь газар нутгийн байршил, хүн амын нягтрал төвлөрөл зэргээс шалтгаалан 1992 онд хоёр хуваагдаж Баянгол, Сонгинохайрхан дүүрэг болж зохион байгуулагдсанаар Баянгол дүүргийн прокурорын газар болж нэр нь өөрчлөгджээ.

# 1965

## НАЙРАМДЛЫН РАЙОНЫ ПРОКУРОРЫН ГАЗАР



Найрамдлын районы Прокурорын газар районы прокурор, тусгай хяналтын туслах, шүүхийн хяналтын туслах, нарийн бичгийн дарга зэрэг дөрвөн орон тоотой анх зохион байгуулагдаж, районы прокуророор Д.Хайсандай, шүүхийн хяналтын туслах прокуророор Н.Цагаанхүү, тусгай хяналтын туслахаар Н.Готов нар томилогдон ажиллажээ. Ерөнхий хяналтын ажлыг районы прокурор өөрөө хариуцан ажиллаж байв. Анх байгуулагдах үедээ 46,7 мянган га нутаг дэвсгэр, орон сууц гудамжны 23 хороо, 11000 өрх, 50000 хүн амтай, 183 албан газрыг хамруулан үйл ажиллагаа явуулж байв. Хожмоо Найрамдлын район нь Баянзүрх дүүрэг болон өөрчлөгдсөн билээ.

## СҮХБААТАРЫН РАЙОНЫ ПРОКУРОРЫН ГАЗАР

Сүхбаатарын районы прокурорын газар өдгөө Сүхбаатар дүүргийн прокурорын газар болон нэршил нь хэвээр үлджээ. Орон тоо гуравтай үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйлдвэр хоршооллын 48 айлын орон сууцны 1 давхрын 4 өрөө байранд ажлаа явуулж байжээ. Сүхбаатарын районы анхны прокуророор Н.Батмөнх томилогдон 1981 оныг хүртэл 16 жил ажиллажээ. Анх байгуулагдахад нь шүүх хяналтын прокуророор Н.Цэвэгээ, Ерөнхий хяналтын прокуророор Ж.Баасанлхүндэв, нарийн бичгийн даргаар Н.Буниа нар ажилласан байна.

## АЖИЛЧНЫ РАЙОНЫ ПРОКУРОРЫН ГАЗАР

Аж үйлдвэрийн комбинат хариуцсан хэсгийн прокурорын газрыг 1957 онд татан буулгаж байсан бол энэ онд анхны дөрвөн районы прокурорын газрыг байгуулсны нэг нь “Ажилчин” нэрээр овоглосон прокурорын газар байв. Энэ нь өдгөөгийн Хан-Уул дүүргийн прокурорын газрын үүсэл байв.

Районы прокурорын газар нь прокурор, туслах прокурор, нарийн бичгийн дарга гэсэн 3 орон тоотой, Сүхбаатар районы прокурортой дундаа зарлага, үйлчлэгч тус тус нэгтэйгээр үйл ажиллагаа



явуулж ерөнхий хяналт, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих, шүүхийн хяналт, тусгай хяналт гэсэн дөрвөн үндсэн хяналтын ажлыг хэрэгжүүлж эхэлжээ. Анхны прокурор нь Ж.Сангитүгж.

# 1965

ЗХУ-ын Ерөнхий прокурор Р.А.Руденко тэргүүтэй төлөөлөгчид
Улсын прокурорын урилгаар БНМАУ-д айлчлав.





# 1965

## НАЛАЙХЫН ПРОКУРОРЫН ЭРЭМБЭ ӨӨРЧЛӨГДӨВ

Хотын статустай болсон Налайхын прокурорын газар дахин бүтцийн өөрчлөлтөд оров. Энэ онд Налайх нь Улаанбаатар хотын харьяа Налайхын район болж өөрчлөгдсөний дагуу хотын прокурорын газар нь Налайхын районы прокурорын газар болжээ. Налайхын районы прокуророор анхлан Г.Тогоонтөмөр ажиллаж байв.


## ЭНГИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЛД ХОРИГДОЛ ХҮНИЙГ ХАРУУЛ ХАМГААЛАЛТГҮЙ ШИЛЖҮҮЛЭН ӨГЧ...

НАХЯ-ны сайд Жамбалсүрэнд хандан хорих дүрмийн заалт, шаардлагыг зөрчин завхруулж байгаа тухай Улсын прокурорын мэдэгдлээс...

...Дундговь аймгийн цагдан сэргийлэх хэлтсийн хорих тасаг ба мөрдөнгийн ажиллагааны байдлыг хянан танилцахад дор дурдсан ноцтой зөрчлүүд илэрч байна.

Үүнд, Нэгэнт гэмт хэрэг үйлдэж шүүхийн тогтоолоор хорих ял заагдсан хоригдол хүмүүсийн эдлэх ялыг шүүхээс гадуур дур мэдэн өөрчлөх, өөр газрын мэдэлд хөдөлмөр хийлгэхээр гэрээгээр шилжүүлэх явдал байж болохгүй юм. Гэтэл Цагаан-Овоонд байсан хорих лагерь 1963 онд Улаанбаатар хотын шүүхээс эрүүгийн хуулийн 63-ын В-гээр 10 жил хоригдох ял шийтгүүлсэн Ш-ыг аймгийн гүйцэтгэх захиргааны хүсэлтийг үндэслэсэн гэж хорих дүрмийн заалт, хорьж хүмүүжүүлэх хатуу зарчмыг дур мэдэн зөрчиж тус аймгийн авто тээврийн 17-р баазад 6 сарын хугацаатай хорих лагерийн ажилтан ахмад Баянжаргал, Дундговь аймгийн 17-р авто баазын дарга нар хэлэлцэн тохирч энгийн албан байгууллагын мэдэлд хоригдол хүнийг харуул хамгаалалтгүй шилжүүлэн өгч хууль бус хөдөлмөр хийлгэж байсан төдийгүй мөрдөн хоригдож байгаа хэрэгтэн хүмүүс эргэлт оруулах журмыг замбараагүй болгох, мөрдөн байцаагчийн зохих зөвшөөрөлгүйгээр сэргийлэхийн нарийн бичгийн дарга н.Норов нь хэрэгтэн Равдандорж гэгчид хоол, цай, идэшний бусад зүйл оруулах зөвшөөрөл өгч эрхээ хэтрүүлж байсан байна...

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ПРОКУРОРЫН

МЭДЭГДЭЛ

№ 5.

Н.А.Х.ЯАМЫН САЙД Н.ЖАМБАЛСҮРЭНД.

ХОРИХ ДҮРМИЙН ЗААЛТ ШААРДЛАГЫГ ЗӨРЧИН ЗАВХРУУЛЖ БАЙГАА ТУХАЙ.

Дундговь аймгийн цагдан сэргийлэх хэлтсийн хорих тасаг ба мөрдөнгийн ажиллагааны байдлыг хянан танилцахад дор дурьдсан ноцтой зөрчлүүд илэрч байна.ҮҮНД:

Нэгэнт гэмт хэрэг үйлдэж шүүхийн тогтоолоор З.Х.Х.лагерт хорих ял заагдсан хоригдол хүнүүсийн эдлэх ялыг шүүхээс гадуур дур мэдэн өөрчлөх,өөр газрын мэдэлд хөдөлмөр хийлгэхээр гэрээгээр шилжүүлэх явдал байж болохгүй юм.

Гэтэл Цагаан-Овоонд байсан хорих лагерь 1963 онд ЭБ хотын шүүхээс эрүүгийн хуулийн 63-ын В-гээр 10 жил хоригдох ял шийтгүүлсэн Цунцаг овогтой хоригдол Шаравыг аймгийн гүйцэтгэх захиргааны хүсэлтийг үндэслэсэн гэх хорих дүрмийн заалт, хорьж хүмүүжүүлэх хатуу зарчмыг дур мэдэн зөрчиж тус аймгийн авто тээврийн 17-р баазад 6 сарын хугацаатай хөдөлмөрийн /гэрээ/-г хорих лагерийн ахмад Баянжаргал, Дундговь аймгийн 17-р авто баазын дарга нар хэлэлцэн тохирч энгийн албан байгууллагын мэдэлд хоригдол хүнийг харуул хамгаалалтгүй шилжүүлэн өгч хууль бус хөдөлмөр хийлгэж байсан төдийгүй мөрдөн хоригдож байгаа хэрэгтэн хүмүүс эргэлт оруулах журмыг замбараагүй болгох, мөрдөн байцаагчийн зохих зөвшөөрөлгүйгээр сэргийлэхийн нарийн бичгийн дарга н.Норов нь хэрэгтэн Равдандорж гэгчид хоол,цай,идэшний бусад зүйл оруулах зөвшөөрөл өгч эрхээ хэтрүүлж байсан байна.

# 1965


## ГЭМТ ЭТГЭЭДҮҮДИЙГ ЧӨЛӨӨТЭЙ ЯЛ ЗАВШУУЛЖ БАЙГААГ ЗАСУУЛАХ...

Улсын дээд шүүхийн дарга Дамдинд Улсын прокуророос БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль зөрчигдөж байгааг илрүүлсэн тухай мэдэгдэл бичжээ...

Саяхан Булган аймагт хийгдсэн шалгалтын дүнгээс хянавал, Булган аймгийн шүүхийн ажиллагаанд ЭБШ хуулийн заалт шаардлага зөрчигдөж байгаа, прокуророос ял төлөвлөж шүүхэд шилжүүлсэн хэргийг хугацаанд нь хянаж шийдвэрлэхгүй дарах, мөн 2-р шатны шүүхээр өөрчлөгдөж анхны тогтоолыг хүчингүй болгосон хэргүүдийг дахин авч хэлэлцэхгүй удаан хугацаагаар дарагдуулж, хууль зөрчсөн байдлууд илэрч байна.

Баримт нь, Сайхан сумын хоршоонд барааны нярав байхдаа 10 гаруй мянган төгрөг ашигласан Доржийн Мягмарсүрэнгийн хэргийг аймгийн прокурор бүртгэж ял төлөвлөж шилжүүлсэн ба энэ хэргийг хянаж шийдвэрлэхгүй 1 сар гаруй хугацаагаар хадгалж байгаагаар барахгүй Улсын дээд шүүхийн эрүүгийн коллегиос аймгийн шүүхийн анхны тогтоолыг хүчингүй болгож дахин авч хэлэлцэхийг даалгасан.

...хэргийг онцлох шалтгаангүй дарж гэмт этгээдүүдийг чөлөөтэй ял завшуулж байгаа зэрэг нь БНМАУ-ын ЭБШ хуулийн 236, 333, 334-р зүйлүүдийг зөрчсөн гажуудал байх тул зөвтгөн засч уг хэргүүдийг даруй шийдвэрлэх арга хэмжээ авахуулахаар танд энэ мэдэгдлийг бичлээ...



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ПРОКУРОРЫН

МЭДЭГДЭЛ

1965 - оны 11 -р сарын 2 № 8 Улаанбаатар хот

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ДАРГА
н. ДАМДИНД.

Б.Н.М.А.УЛСЫН ЭБШ ХУУЛИЙН
ЗААЛТ ЗӨРЧИГДӨЖ БАЙГАА
ТУХАЙ.

Саяхан Булган аймагт хийгдсэн шалгалтын дүнгээс хянавал: Булган аймгийн шүүхийн ажиллагаанд ЭБШ хуулийн заалт шаардлага зөрчигдөж байгаа прокуророос ял төлөвлөж шүүхэд шилжүүлсэн хэргүүдийг хянаж шийдвэрлэхгүй дарах, мөн 2-р шатны шүүхээр өөрчлөгдөж анхны тогтоолыг хүчингүй болгосон хэргүүдийг дахин авч хэлэлцэхгүй удаан хугацаагаар дарагдуулж, хууль зөрчсөн байдлууд илэрч байна. Баримт нь:

Сайхан сумын хоршоонд барааны нярав байхдаа 10 гаруй мянган төгрөг ашигласан Доржийн Мягмарсүрэнгийн хэргийг аймгийн прокурор бүртгэж 1965-9-4-нд ял төлөвлөж шилжүүлсэн энэ хэргийг хянаж шийдвэрлэхгүй 1 сар гаруй хугацаагаар хадгалж байгаагаар барахгүй улсын дээд шүүхийн эрүүгийн коллегиос аймгийн шүүхийн анхны тогтоолыг хүчингүй болгож дахин авч хэлэлцэхийг даалгасан.

Баян-Агт сумын харьяат нэгдлийн 10 шахам адуу ашигласан Ламжав, Гомбосүрэн нарын хэргийг нэг жил, Гурванбулаг сумын харьяат буудын 10 гаруй бод мал хуйвалдаж хулгайлсан Индон, Цэрэндор Нямдорж нарын хэргийг 1 жил 4 сар, буудын 2 морь хулгайлсан Баян Агт сумын харьяат Самбуу, Цүрэвсүрэн нарын хэргийг 2 жил шахам хугацаагаар тус тус онцлох шалтгаангүй дарж гэмт этгээдүүдийг чөлөөтэй ял завшуулж байгаа зэрэг нь БНМА Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 236,333,334-р зүйлүүдийг зөрчсөн гажуудал байх тул зөвтгөн засч уг хэргүүдийг даруй шийдвэрлэх арга хэмжээ авахуулахаар танд энэ мэдэгдлийг бичлээ.

# 1966

## ХУУЛЬ ДҮРМИЙН КОДИФИКАЦИТАЙ БОЛОВ

Энэ он БНМАУ-ын төдийгүй прокурорын байгууллагын гадаад харилцаа, гадаадад мэргэжил дээшлүүлэх ажилд онцгой анхаарал хандуулсан жил байв. Зөвлөлтийн удирдагч Л.И.Брежнев БНМАУ-д албан ёсны айлчлал хийсэн бол ЗХУ-ын Бүх Холбоотын Эрдэм шинжилгээний институтын захирал, доктор профессор Н.С.Карпец, ЗХУ-ын прокурорын тоо бүртгэл эрхэлсэн ахлах туслах Н.С.Хрупин нар Монголд айлчилж, мөрдөн байцаах ажилд криминалистикийн арга техникийг нэвтрүүлэх, прокурорын тоо бүртгэлийг цэгцлэх талаар сургалт явуулж, хууль дүрмийн кодификацитай болох эхлэлийг тавьж өгчээ.

Үүний зэрэгцээ ЗХУ-д мэргэжил дээшлүүлэх курст Өмнөговь аймгийн прокурор М.Доржпалам, Дорноговь аймгийн туслах прокурор Д.Лхамсүрэн, Сүхбаатар аймгийн туслах прокурор Т.Цэдэнжав, Дорнод аймгийн туслах прокурор Ю.Гэндэнлхүндэв, Увс аймгийн туслах прокурор Б.Цэвээн, Хөвсгөл аймгийн туслах прокурор М.Бадрах, Улсын прокурорын газрын хэлтсийн прокурор Н.Сүрэнхорлоо, мөн газрын хэлтсийн прокурор Д.Сүрэнжав, Ардын Цэргийн орлогч прокурор Т.Довдон, Улаанбаатар хотын туслах прокурор С.Цэрэнлхам нарыг суралцуулсан байна.

## Г.ТОГООНТӨМӨР: КРИМИНАЛИСТИКИЙН ӨРӨӨ, ФОТО ЛАБОРАТОРИ БАЙГУУЛАВ

Намайг мөрдөн байцаагчаар ажиллаж байсан тэр үед одоогийнх шиг техник хэрэгсэл байсангүй. Үндсэндээ орос, хятад сампин, шугам, харандаа, фото зургийн Зенит аппарат ажлын минь гол багаж хэрэгсэл байв. Тэр үеийн удирдлагууд хөөцөлдөж байж мөрдөн байцаагчийн 20-иод цүнх ЗХУ-аас авчирч өгсөн нь биднийг ажлаа амжилттай сайн гүйцэтгэх нэг бодит нөхцөл болсон. Онцгой хэргийн мөрдөн байцаах тасагт мөрдөн байцаагчаар ажиллаж байхдаа прокурор Л.Болд, С.Бадарч нарын хамт Криминалистикийн өрөө, Улсын прокурорын газрын одоогийн байрны доод хонгилд хэсэг нөхдийн хамт фото лаборатори байгуулж байв.

**1 сарын 14.** Улсын Прокурорын 03 тоот тушаалаар ЗХУ-д 5 сарын хугацаагаар суралцах ажилтнуудын ахлагчаар Өмнөговь аймгийн прокурор М.Доржпаламыг томилжээ.

**2 сарын 24.** Улсын прокурорын тушаалаар мөрдөн байцаалтын группийн ахлахын албан тушаалыг Чухал хэргийн мөрдөн байцаагч гэж өөрчилсөн байна.

**5 сарын 6.** Улсын прокурорын 85 дугаар тушаалаар “Ерөнхий хяналтын заавар”-ыг батлаж, ерөнхий хяналтын шалгалт хийх үндсэн журмуудыг тодорхой болгов.

**8 сарын 26.** АИХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн Улсын прокурорын газрын шалган зааварлах хэлтсийг байгуулж, дотоод хяналт, Коллегийн хуралд холбогдох асуудал зэрэг дотоод асуудлыг хариуцуулахаар шийдвэрлэжээ.

-Тусгай хяналтыг Мөрдөн байцаалтад хяналт тавих хэлтсээс тусгаарлаж бие даасан Тусгай хяналтын

# 1966

хэлтэс байгуулан даргаар нь Улсын прокурорын туслах Д.Хишигдэлгэрийг томилов.

-“Шүүхийн ажиллагаанд тавих прокурорын хяналтыг сайжруулах тухай” Улсын прокурорын 245 тоот тушаал гарч, семинар, зөвлөгөөн хийлгэв.

-ЗХУ-ын прокурорын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах Бүх холбоотын институтийн зохирал доктор, профессор И.И.Карпец тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.

Үзүүлэн таниулах материал өөрсдийн боломжоороо хийж, сургалт явуулж байснаа одоо орчин үеийн техник хэрэгсэлтэй харьцуулахад инээдэмтэй мэт санагдавч тэр үед хийж бүтээсэн зүйл маань энэ байгууллагын ажлын нэгээхэн хэсэг байжээ гэж боддог юм.

*Г.Тогоонтөмөрийн дурдатгалаас*

## Б.ДАГВАДОРЖ: ПРОКУРОР ХҮНД Ч ӨРӨВДӨХ СЭТГЭЛ БИЙ

Би 1963 онд Улаанбаатар хотод шилжиж, хотын прокурорт ажилласан. Тэгж ажиллаж байхдаа оройн сургуульд сурч аравдугаар ангийг онц төгсөөд, улмаар Марксизм, Ленинизмийн оройн дээд сургуулийг төгссөн. Нэг удаа 52 настай өвгөний хэргийг шийдвэрлэх шүүх хуралд Улсын яллагчаар орж арван жилийн ял ногдуулахад их өрөвдөж билээ. Энэ хэрэг 1966 оны их үерийн жил болсон юм. Үерийн усанд урсаж явсан зүйлээс зарим шунахай

-Г.Тогоонтөмөр Налайхын прокуророор, Х.Үржиндорж Булган, Ч.Ядмаа Говь-Алтай, Д.Очирхуяг Сэлэнгэ аймагт тус тус аймгийн прокуророор томилогдон ажиллаж эхэлжээ.



Сэлэнгэ аймагт прокуророор томилогдон очиж буй ирээдүйн гавьяат хуульч, Д.Очирхуяг прокурор автомашинаа хүлээн авч буй нь.

# 1966

хүмүүс хулгай хийнэ. Байгалийн гамшигт өртсөн хүмүүс зовж байхад дээрээс нь эд зүйлийг нь хулгайлна гэдэг байж болшгүй зүйл шүү дээ. Тэгээд тэр “С” гэдэг өвгөнийг хатуу ялласан юм. Хэргийг нь Яармагийн талбай дээр гадаа шүүн тасалсан. МАХН-ын Төв хорооноос дарга нар ирчихээд, хүмүүс маш ихээр цуглачихаад сүртэй шүүх хурал болж билээ. Нөгөөх “С” гэдэг хэрэгтэн маань арван жилийн ял авчихаад уйлж байхыг нь харахаас өрөвдмөөр байсан.

*Гавьяат хуульч Б.Дагвадоржийн дурдатгалаас*


## ГОМБЫН ТОГООНТӨМӨР



Г.Тогоонтөмөр 1962-1963 онд Сүхбаатар аймгийн прокурорын газарт мөрдөн байцаагч, 1963 онд Улаанбаатар хотын харьяа Налайх хотын прокурорын газарт мөрдөн байцаагч, 1966 оноос Налайхын районы прокуророор томилогджээ.

1967 онд Найрамдлын районы прокурорын газарт мөрдөн байцаагч, Нийслэлийн прокурорын газарт мөрдөн байцаагч, Улсын прокурорын газрын Онцгой хэргийн мөрдөн байцаах тасагт Чухал хэргийн мөрдөн байцаагч, тасгийн дарга, Улсын прокурорын газрын Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажилд хяналт тавих хэлтэст хэлтсийн прокурор, Ажилчны районы прокурорын газарт мөрдөн байцаагчаар тус тус ажиллаж, 40 гаруй жилийн ажил, амьдралаа прокурорын байгууллагатай холбожээ.

***ҮТАГ-ын сан хөмрөгөөс...***



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ПРОКУРОРЫН
Т У Ш А А Л

1966 оны 10. сарын ...245... Улаанбаатар хот
..10..ны өдөр

ШҮҮХИЙН АЖИЛЛАГААНД ТАВИХ
ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ
Т У Х Ай.

МАХН-ын 15-р Их Хурлын түүхт шийдвэр,намын шинэ программын эвлэлтыг биелүүлж,улс,олон нийт,хоршоололын байгууллагаг,хөдөлмөрчдийн хуулъ ёсны эрх ашгийг хамгаалж,социалист хуулъ ёсыг нэгдмэл, зөв хэрэгжүүлэх зорилт нь прокурорын үндсэн хяналтуудын чанар, эрге хэлбэрийг улам сайжруулахыг шаардаж байна.

Туе улсын шүүхийн шүүн таслах ажил тагаанд социалист хуулъ ёс хэрхэн биелэгдэж байгаа болон, улс, нийгэм,иргэдийн эрх ашгийг хамгаалж, гаргцхүү бодит үнэлд тулгуурлаж үнэн зөв тогтоол шийдвэр гаргах цаг хугацаанд нь биелүүлж байгаа эсэхэд прокурорын хяналт чиглэгдэж ёстой.

Сүүлийн жилүүдэд прокурор шүүх хурлаад оролцож дүгнэлт өгөх шүүхийн тогтоол,шийдвэр эрүү,иргэний хэргийг хянаж, эсрүүлийг шүүж зөвүүлэх талаар шүүхийн хяналтын ажилд ахиц гарч орон нутгийн шүүхүүдийн ажиллагаанд байгуулагын хяналт тавьж байх боломжтой болж байна.

Гэвч шүүх хурлын ажиллагаанд эрүү,иргэний байцаан шийтгэх хуулийг зөв хэрэглэх,гэмт хэрэг үйлдэгч нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгах,хэргийн нотлох баримт,шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоох,шүүх хурлын явцад оролцогчын тавьсан хүсэлтийг зөв хянаж байгаад прокурорын хяналт зохих өсөөр тавигдахгүй байна.

# 1966

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД**
**УЛСЫН ПРОКУРОРЫН**

**Т У Ш А А Л**

17г

6 оны 11 р сарын 3. № 259 Улаанбаатар хот

КОМИСС ТОМИЛОХ ТУХАЙ ТУШААХ НЬ.

I.Улсын прокурорын хэмжээгээр эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ба прокурорын ажлын нэгдсэн тоо бүртгэлийн маягт зааврыг боловсруулах комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнээр байгуулсугай.

Комиссын даргад

Ц. Загд — Улсын прокурорын орлогч.

Гишүүдэд

Р. Сүхбаатар — Мөрдөн байцаах хэлтсийн дарга.
Н. Цэрэн-надмид — Хэлтсийн прокурор.
С. Хорлоо — Хэлтсийн прокурор.
Арслан — Хэлтсийн прокурор.

2. Нэгдсэн тоо бүртгэлийн маягт,зааврыг нарийвчлан боловсруулж II-р сарын 30-ны дотор коллегид оруулахыг комисс-д даалгасугай.

БНМАУ газар

Б.Н.М.А.УЛСЫН ПРОКУРОР /Ц.ЛОНДУЙЧИР/.

Боловсруулсан. Ц.Цэрэннадмид

# 1966

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД**
**УЛСЫН ПРОКУРОРЫН**

**ТУШААЛ**

1966 оны 7-р сарын 23 № 154 Улаанбаатар хот

Л.Х/РЛЭЭГИЙН ХАНГАМЖИЙН ТУХАЙ.

МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын 1966 оны 7-р сарын 4-ны өдрийн зөвлөлгөөнөөр Говь-Алтай аймгийн прокурор н.Лувааншавын Х/рлээг ЗХ Улсын коммунист намын дээд сургуульд 2 жил суралцахаар батлагдсан.

Н.Х/рлээ прокурорын байгууллагад он удаан,жил идэвхтэй ажилласан,өөрийн бүтээлтэй хөдөлмөрлөж байсны дээр олон ам бүлтэй бөгөөд //ний дотроос 2-15 насны 6 хүүхэдтэй аж амьдралын талаар гачигдалтай байдлыг харгалзан ТУШААХ НЬ:

1 §

Н.Лувааншавын Х/рлээг суралцаж байх хугацаанд нь т//ний гэр бүлд /нээр нь орон сууц,т/лш олгож байхыг Говь-Алтай аймгийн прокурорт даалгасугай.

Б.Н.М.А.УЛСЫН ПРОКУРОР /Гарын/ /ЕНДОНД/ЙИНР/

# 1967

7 сарын 19. Улсын хэмжээнд хоёр жилд нэг удаа нийт прокурор, мөрдөн байцаагч нарын ажилд аттестатын журмаар дүгнэлт өгөх болов.

10 сарын 2. МАХН-ын Төв Хорооны Нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний 368 дугаар тогтоолоор Европын социалист орнуудын эрүүгийн эрхийн зарим асуудлаар хийсэн олон улсын хуульчдын симпозиумд Улсын прокурорын орлогч Ц.Загд оролцжээ.

12 сарын 16. Улсын прокурор, Шүүх, НАХЯ-ны сайдын хамтарсан тушаалаар Эрүүгийн хэргийн нэгдсэн тоо бүртгэл ба гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах ажлыг зохион байгуулж явуулах болов.

-БНМАУ-ын прокурор Д.Ёндондүйчир, Улаанбаатар хотын прокурор С.Бүдрагчаа нар Болгар Улсад айлчлав.

-М.Дүнчинсүрэн Дархан хотын прокурор, Б.Арслан Налайхын районы, Б.Бэгз Архангай, Ц.Жалцав Баянхонгор, Л.Ядмаа

## СОГТУУРАГЧИД, ТАНХАЙЧУУДТАЙ ТЭМЦЭВ

Энэ онд хуулийн байгууллагууд, ялангуяа прокурорын байгууллагын зүгээс гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхэд анхаарч ажиллажээ.

Тухайлбал “Ууж согтуурах, нийгмийн хэв журам зөрчиж, танхайрахтай тэмцэх тухай” Намын Төв хорооны тогтоол, АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигууд батлагдаж, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа идэвхжүүлж, захиргааны хяналтын хүрээг өргөтгөх тодорхой арга хэмжээ авчээ. Улс орны хэмжээнд эрүүгийн нөхцөл байдлыг тогтворжуулах, зарим төрлийн гэмт хэргийг бууруулах, гэмт хэргийн бүтцэд эерэг өөрчлөлт оруулах чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон гэж судлаачид дүгнэжээ. Мөн эрүүгийн хэргийн нэгдсэн тоо бүртгэл ба гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, эрүүгийн хэрэгт холбогдогчийн карт, бүртгэл гаргаж, тэдний хөдөлгөөнийг судлах зэрэг олон ажилд прокурорын байгууллагын зүгээс анхаарч ажиллажээ.

## АТТЕСТАТ БА АЖИЛ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Улсын прокурорын 109 дүгээр тушаалаар МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны тогтоолыг хэрэгжүүлэхийн тулд нэгэн онцгой арга хэмжээ авч ажилласан байна. Энэ нь улсын хэмжээнд нийт прокурор, мөрдөн байцаагч нарын ажлын үр бүтээл, мэдлэг боловсролын дээшлүүлэлтэд анхаарах үүднээс хоёр жилд нэг удаа аттестатын журмаар дүгнэлт өгөх, аттестатчилалгүй жилд ажил байдлын тодорхойлолтыг гаргаж Улсын прокурорын боловсон хүчний хэлтэст ирүүлж байхыг харьяа прокурорын байгууллагуудад үүрэг болгожээ.

# 1967

## М.АДЬЯА: ХҮН АМИНЫ ХЭРЭГ ДЭЭР ГОЛЧЛОН АЖИЛЛАДАГ БАЙЛАА

Аймгийн прокурорын орлогч нь ерөнхий хяналтын ажлыг хариуцаж, хууль тогтоомж сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон үйлдвэр, албан газар байгууллагуудад хууль дүрэм хэрхэн биелэгдэж буйг шалгах, албан тушаалтнаас гаргадаг эрхийн актуудыг хянаж, зөрчлийг засуулах арга хэмжээг авдаг ба энэ ажилд хэсгийн прокуроруудыг удирдан зохион байгуулдаг байлаа.

Орлогч прокурорын хувьд голдуу хүн амины хэргийн газрын үзлэгт оролцох, эрүүгийн шүүх хуралд улсын яллагчаар оролцдог байсан ба жишээ татвал Дорноговь аймгийн харьяат Д гэгч удаа дараа хулгай хийж, урьд нь шийтгэгдэж байсан этгээд хоёр хүний амь нас хохироогоод буу зэвсэгтэй оргож явсныг Дорноговь, Дундговь аймгийн Цагдаагийн хэлтсийн хамтын ажиллагаагаар баривчилж, мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн шүүх хуралд нь улсын яллагчаар оролцож байлаа. Миний бие 1967 оноос Дундговь аймгийн прокурорын газарт мөрдөн байцаалт хариуцсан туслах прокурор, аймгийн прокурорын орлогчоор тус тус ажиллаж, нийт хорь гаруй жил прокурорын байгууллагад хүчин зүтгэсэн юм.

*М.Адьяагийн дурдатгалаас*

## ЦЭВЭГИЙН ЗАГД



Ц.Загд Хэнтий аймгийн Баянмөнх суманд 1924 онд төржээ.Тэрбээр 1957-1963 онд ЗХУ-д Цэргийн улс төрийн академи төгсчээ.

Ц.Загд 1950-1957 онд Бүх Цэргийн прокурорт байцаагч, орлогч дарга, 1963-1965 онд Цэргийн прокурор, 1965-1971 онд БНМАУ-ын прокурорын орлогч, 1971-1974 онд ЭЗХТЗ-ийн нарийн бичгийн дарга, 1974 оноос Цэргийн тусгай шүүхийн даргаар ажиллажээ.

Ховд, Д.Дамбасүрэн Хөвсгөл аймгийн прокуророор тус тус томилогдон ажиллаж эхлэв.

-АИХ-аас Иргэний байцаан шийтгэх хуулийг баталжээ.

-Шүүх, прокурор, Улсыг аюулаас хамгаалах газар, Улсын Цагдан сэргийлэх ерөнхий газар, Засан хүмүүжүүлэх газрууд хамтран баталсан журмаар эрүүгийн хэрэгт холбогдогчийн карт, бүртгэл гаргаж, тэдний хөдөлгөөнийг байнга судлахыг даалгажээ.

-Аймаг, хот, тусгай прокуроруудын бүсийн зөвлөгөөнийг хийж, ЭБШ хуулийг зөв хэрэглэх талаар хичээл зааж, харилцан туршлага солилцсон байна.

-Орон нутгийн прокурорын байгууллагын прокурор, мөрдөн байцаагчийн мэргэжил, боловсрол, ажлын бүтээл, ажил хариуцах чадварт дүгнэлт хийж, чадваржуулах талаар арга хэмжээ авчээ

# 1968

**1 сарын 1.** Эрүүгийн хэрэгт холбогдогчийн бүртгэл, хөдөлгөөнийг Улсын Цагдан сэргийлэх ерөнхий газрын дэргэдэх нэгдсэн тоо бүртгэлийн шалгах, судлах тасагт төвлөрүүлэн хариуцуулахаар болжээ.

-С.Бүдрагчаа Улсын прокурорын Нэгдүгээр орлогчоор, Т.Даваажав Улаанбаатар хотын прокуророор тус тус томилогдов.

-Болгар Улсын Ерөнхий прокурор Иван Вачков Монголд айлчлав.

-Хуулийн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн болж Улсын прокурор Д.Ёндондүйчир "Урьдчилсан мөрдөн байцаалтыг сайжруулах тухай" Дээд шүүхийн дарга Х.Дамдин "Шүүн таслах ажлыг үндсээр нь сайжруулах тухай" илтгэл тус тус тавьж хэлэлцүүлжээ.

-Ерөнхий хяналтын туслах прокуроруудын долоо хоногийн семинар, зөвлөгөөн болов.

## И.ВАЧКОВ ХАРИУ АЙЛЧЛАВ

Өмнөх онд нь БНМАУ-ын прокурор Д.Ёндондүйчир, Улаанбаатар хотын прокурор С.Бүдрагчаа нар Болгар Улсад айлчлахдаа тус улсын прокурорын байгууллагын төлөөлөгчдийг хариу айлчлал хийж, туршлага солилцохыг урьсан байна. Энэ ёсоор БНБАУ-ын Ерөнхий прокурор Иван Вачков тэргүүтэй төлөөлөгчид Монгол оронд айлчилжээ. Улмаар социалист системийн орнуудтай эрүү, иргэн, гэр бүлийн эрхзүйн туслалцаа үзүүлэх Засгийн газар хоорондын гэрээний хүрээнд хоёр орны прокурорын байгууллага идэвхтэй хамтын ажиллагаагаа эрчимжүүлсэн байна.

## АСУУДЛЫН 94,9 ХУВИЙГ БИЕЛҮҮЛСЭН...

МАХН-ын Төв Хороо, АИХ-ын Тэргүүлэгчдийн газрын өдөр тутмын удирдлагын дор, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил болон үндсэн хяналт, дотоод ажлыг улам сайжруулж ажилтны хариуцлага, сахилга батыг бэхжүүлэх зорилтыг ханган биелүүлэх, хүмүүсийн бүтээл, түүний чанарыг өндөржүүлэхэд гол анхаарлаа чиглүүлж ажиллав. Жилээр 35, улирлаар 63, бүгд 98 асуудалтай төлөвлөгөө боловсруулж, 93 асуудал буюу 94,9 хувийг биелүүлсэн байна.

Ажлын төлөвлөгөөнд прокурорын байгууллагын өмнө нам, төрөөс тавьсэн үүрэг зорилтыг биелүүлэх, ажлын арга барил, чанар үр дүнг дээшлүүлэх зэрэг цаг үеийн ээлжит зорилттой холбогдсон асуудлыг оруулж байв.

Залуу үеийг хүмүүжүүлэх талаар зохиож байгаа ажлын тухай Хөвсгөл аймгийн, ууж согтуурах, танхайн хэрэгтэй тэмцэх талаар зохиож байгаа ажлын тухай Сэлэнгэ аймгийн хуулийн байгууллагын илтгэлийг хэлэлцэн нийт хуулийн байгууллагуудад даалгавар гаргасан.

Коллегийн хурлыг 18 удаа хийж, Сэлэнгэ аймгийн прокурор Д.Очирхуяг, мөрдөн байцаалтын ажилд техник-шинжлэх ухааны арга хэрэгслийг хэрхэн хэрэглэж байгаа тухай, Улаанбаатар хотын прокурор С.Бүдрагчаа, өргөдөл гомдлын барагдуулалтын байдлын тухай, Өвөрхангай аймгийн прокурор н.Цэдэндаржаагийн илтгэл зэрэг 25 асуудлыг хэлэлцсэн байна.

*БНМАУ-ын прокурорын жилийн тайлангаас*

# 1969

## Ю.ЦЭДЭНБАЛ: “Ж.АВХИА ЧИ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР БОЛ”

Нэг өдөр “Таныг Ю.Цэдэнбал дарга дуудаж байна” гэв. Би яах гэж байгааг нь огт мэдэхгүй очиход, хэсэг зуур ярьж байгаад, “Ж.Авхиа чи Улсын Ерөнхий прокурор бол” гэв. Тэгэхэд нь би “Дарга аа, энэ өндөр хариуцлагатай ажлыг би хийж чадахгүй. Би сурсан дассанаараа цагдаагийн байгууллагадаа ажиллая” гэв. Гэтэл Ю.Цэдэнбал дарга “Бид яриад тохирчихсон, маргааш товчоогоор орно. Битгий татгалзаарай” гээд яриагаа өндөрлөв. Гараад Жамбалсүрэн сайдтай уулзаж болсон явдлыг хэлэхэд “Дарга надтай ярьсан, би зөвшөөрсөн. Чи очоод ажилла. Уг нь би чамайг Аюулаас хамгаалах асуудал хариуцсан (УАХГ) Нэгдүгээр орлогчоороо авч ажиллуулах гэсэн юм, одоо яая гэх вэ” гэж билээ. Маргааш нь намайг прокуророор батлсны дараахан дуудаж, чекистийн хүндэт тэмдэг, макаров гар буу, хоёр магазин сумтай шагнал болгож өгсөн юм. Миний оронд НАХЯ-ны Нэгдүгээр орлогч сайд, Улсын Цагдан сэргийлэх ерөнхий газрын даргаар Улаанбаатар хотын прокуророор ажиллаж байсан С.Бүдрагчаа томилогдов.

*БНМАУ-ын прокурор Ж.Авхиагийн дурдатгалаас*

## МӨРДӨН БАЙЦААГЧИД ЗӨВЛӨЛДӨВ

Мөрдөн байцаах ажилтнуудын улсын зөвлөгөөний үеэр тэргүүний мөрдөн байцаагчдыг шалгаруулж, онцгой амжилт гаргасан хүмүүсийг шагнаж урамшуулав. Мөрдөн байцаагч нарыг ажиллах нөхцөл, телефон утас, унаагаар хангах арга хэмжээ авч, мөрдөн байцаах ажлыг сайжруулах тухай Намын Төв хороо, СнЗ-ийн 1969 оны 186, 404 дүгээр тогтоолууд батлагджээ. Прокурорын байгууллага мөрдөн байцаах ажилд зөвхөн хяналт тавьж байснаар зогсоогүй бүр мэргэжлийн удирдлагаар хангаж байв. Онц ноцтой гэмт хэргүүдийг прокурорын байгууллагын чухал хэргийн мөрдөн байцаагчид мөрдөж байжээ.

2 сарын 15. АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар БНМАУ-ын прокурорын Нэгдүгээр орлогчоор Гончигийн Иш томилогджээ.

3 сард. БНМАУ-ын прокурор Д.Ёндондүйчирийг Армийн улс төрийн газрын даргаар томилж, түүний оронд БНМАУ-ын прокуророор Жарантайн Авхиаг томилов.

-Ардын цэргийн прокурорын орлогчоор Ж.Балжинням томилогдов.

-Энэ оны байдлаар прокурор, мөрдөн байцаагч нарын 28 хувь дээд, 66,3 хувь дунд, 6,5 хувь нь бага боловсролтой байсан тухай статистик мэдээ гарч байв.

-Улсын прокурорын Нэгдүгээр орлогчоор ажиллаж байсан С.Бүдрагчааг НАХЯ-ны Нэгдүгээр орлогч сайд, УЦСЕГ-ын даргаар томилов.

-Н.Агваансүрэн Найрамдлын районы, Н.Рэнцэндорж Ажилчны районы прокуророор, Л.Доржсүрэн Булган, Б.Жанлав Өмнөговь, Х.Үржиндорж Хэнтий аймгийн прокуророор тус тус томилогдов.

# 1969

## Ж.БАЛЖИННЯМ: ТА МАНАЙ ЯАМНЫ БҮХ ГАЗАРТ ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГТЭЙ ШҮҮ...

“ЗХУ-д Цэрэг, улс төрийн академийн хуулийн ангид таван жил суралцаж, улсын шалгалтаа “онц” дүнтэй өгчихөөд харьж явахдаа хожим прокурорын төв штабт ажиллана гэж зүүдлээ ч үгүйсэн. Тэр цагийн залуус угаасаа даруулгатай өсч хүмүүжсэн болохоор өнөөгийн цээжээ дэлдсэн залуус шиг “Би л чадна, би ч чадна” гэж ханхалздагтүй байж. Өнөө л оюутан ахуйн мөрдөгч болох хүсэл хэвээр. Хүйтэн дайн ид эрчээ авч 1950-иад оноос татан буулгасан Хилийн цэргээ шинээр эмхлэн байгуулах ажил үйлс өрнөж байлаа. Удалгүй коллегийн хурлаар ороход “Ахмад Ж.Балжиннямыг Ардын цэргийн прокурорын орлогч бөгөөд шинээр байгуулагдаж буй Хилийн ба Дотоодын цэргийн газрын прокуророор томилох саналтай байна” гэх сонсдов. Цэрэг хүний ёсоор зөвшөөрөл аваад мөрдөн байцаагчаар ажиллах хүсэлтэйгээ хэллээ. Гэтэл Хилийн цэргийн прокурорын газар одоогоор орон тоо цөөтэй, тэгээд ч прокурор хүн өөрөө хэрэг мөрдөх эрхтэй гэж аргалаад шууд ажилдаа ор гэлээ. Эндээс гурав дахь газарт хамааралтай боллоо. Тэр үеийн НАХЯ-ны сайд, дэслэгч генерал Жамбалсүрэн, Хилийн ба Дотоодын цэргийн удирдах газрын дарга, генерал Б.Цэдэн-Иш нар хүлээн авч “Та бол зөвхөн Дотоодын ба хилийн цэргийн прокурор төдийгүй манай яамны бүх газарт хяналт тавих үүрэгтэй шүү. Ер нь манай яаманд прокурорын хяналт нэн шаардлагатай байгаа юм” гээд баримт дэлгэн ярив.

*БНМАУ-ын прокурор Ж.Балжиннямын дурдатгалаас*

## ТӨВ ХОРОО ДУУДАЖ ТОМИЛОЛТ ӨГӨВ


“Прокуроын газрын нэгэн үеийн хамт олон бүрэлдэж урам зориг дүүрэн ажилллаж байсан тэр цагт Намын Төв хорооноос дуудаж, Монголын Ардын Армийн Улс төрийн газрын даргаар томилох болсныг мэдэгдэв. Үгүй гэхэд хэцүү, за гэхэд ч хэцүү юм болсон. Хэдийгээр би Цэргийн Ерөнхий сургууль төгсч, армид улс төрийн ажил хийж байсан ч шинэчлэгдэж өөрчлөгдсөн албанд ажиллана гэдэг мэдээж хэцүү байсан. Ийнхүү намайг 1969 оны 3 дугаар сард Армийн улс төрийн газрын даргаар томилсон билээ.

1945 оны дайны дараа Монгол ардын хувьсгалт цэрэг хэрэг дээрээ татан буугдсан. Цаг үеийн шаардлагаас үндэслэн 1950-иад оны дунд үеэс Монголын Ардын Армийг сэргээж өргөтгөн зохион байгуулах ажлыг би 1970-аад онд үргэлжлүүлэх болсон юм. Урьд манайд уламжлалт морин цэрэг байсан бол шинэ өргөтгөсөн зохион байгуулалтаар орчин үеийн хүчит зэвсэг техникээр зэвсэглэсэн мотобуудлагын болон төрөл мэргэжлийн, тусгай мэргэжлийн анги, нэгтгэлүүдийн бүтэцтэй болж Монголын Ардын арми өргөжиж эхэлсэн. Яг энэ үед өргөтгөн зохион байгуулалт ид явагдаж байхад намайг Ардын армид томилон ажиллуулсан билээ.

*БНМАУ-ын прокурор Д.Ёндондүйчирийн дурдатгалаас*

# 1969

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***



БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

ЗАРЛИГ

1969 оны 2 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хот

ГОВЬГИЙН ИЛЧИР БНМАУ-ЫН ПРОКУРОРЫН
I ДҮГЭЭР ОРЛОГЧООР ТОМИЛОХ ТУХАЙ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс
Т О Г Т О О Х Н Ь:

Говьгийн Илчир БНМАУ-ын Прокурорыг I-р орлогчоор томилсугай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчийн дарга Ж. Самбуу

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчийн орлогч дарга

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчийн нарийн бичгийн дарга

Тэргүүлэгч гишүүн:

# 1969

## БНМАУ-ЫН ПРОКУРОР ЖАРАНТАЙН АВХИА



1969-1978 онд БНМАУ-ын прокуророор ажиллаж байсан Ж.Авхиа Говь-Алтай аймгийн Шарга сумын нутагт 1923 онд төржээ. Тэрбээр 1939-1940 онд Багш нарыг бэлтгэх курс, 1947-1950 онд ЗХУ-ын Алма-Ата хотод Морин цэргийн дунд сургууль, 1953-1956 онд Улаанбаатар хотын намын хорооны дэргэдэх Марксизм, Ленинизмийн оройн дээд сургууль, 1956-1960 онд Москва хот дахь Цэрэг-Улс төрийн академийн Хууль цаазын факультет, 1978 онд ЗХУ-ын Зэвсэгт хүчний жанжин штабын Академийн дээд курст тус тус суралцаж, хууль цаазын болон цэргийн хос мэргэжил эзэмшсэн, Хуульзүйн шинжлэх ухааны доктор, профессор, Төрийн хууль цаазын жинхэнэ зөвлөх, хурандаа генерал, Монгол улсын харцага цолтон юм.

Ж.Авхиа 1943-1947 онд хилийн цэрэгт тусгай хорооны цэрэг, суман, штабын бичээч, удирдах газарт офицер, газрын даргын даалгавар гүйцэтгэгч, нарийн бичгийн дарга, 1950-1956 онд НАХЯ-ны Хилийн ба дотоодын цэргийн удирдах газарт тасгийн дарга, 1961-1963 онд УЦСЕГ-ын орлогч дарга, 1963-1969 онд НАХЯ-ны нэгдүгээр орлогч сайд, УЦСЕГ-ын дарга, 1969-1978 онд БНМАУ-ын прокуророор, 1978 оны 4 дүгээр сараас Батлан хамгаалах яамны Нэгдүгээр орлогч сайд, 1978-1982 онд мөн яамны сайдаар тус тус ажиллаж байв.

Ж.Авхиа 1983 оноос Улсын прокурорын газрын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэн, ШУА-ийн төр, эрх зүйн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, зөвлөх, Улсын Ерөнхий прокурорын газрын ахмадын хорооны дарга, өмгөөлөгч, Их Засаг Их сургуулийн ректорын зөвлөх, эрдмийн зөвлөлийн гишүүн, тэнхмийн эрхлэгч зэрэг ажил эрхэлж сургалт судалгаа шинжилгээний ажлаа хорь гаруй жил үргэлжлүүлж байв.

Ж.Авхиа 1990 оны сонгуулиар АИХ-ын депутатаар сонгогдож, шинэ Үндсэн хуулийг хэлэлцэн батлах үйлсэд гар бие оролцон 1998 онд Монгол Улсын гавьяат хуульч цолоор шагнагджээ.

Ж.Авхиа прокурорын байгууллагын хяналтын үйл ажиллагааны дүрмийг хууль болгон, хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд хуульд заасан арга хэмжээ авах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалах, хохирсон эрхийг сэргээх, прокурор, мөрдөн байцаагч, прокурорын байгууллагын ажилтнууд албан тушаалын зэрэгт тохирсон цол, формын хувцас хэрэглэх, нэмэгдэл цалин авах зэрэг шинэ шинэ заалтыг тусган боловсруулж төрийн эрх барих дээд байгууллага болох АИХ-ын чуулганаар батлуулсан нь прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үндсэн хяналтуудын үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүний шинжлэх ухааны үндэслэлийг дээшлүүлэх шинэчлэл болсон гэдгийг үе үеийн прокурорууд хүлээн зөвшөөрдөг.









БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

ЗАРЛИГ

*19 70 оны 4 дугаар сарын 20 өдөр. Дугаар 70*

*Улаанбаатар хот*


ОКУРОРЫН ТОМИЛОЛТЫН
ӨӨРЧЛӨН ТОГТООХ ТУХАЙ


БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс
ТОГТООХ НЬ:

1.БНМАУ-ын прокурорыг Ардын Их Хурлаас 4 жилийн хугацаагаар томилж байхаар тогтоосугай.

2.Энэ зарлиг гарсантай холбогдуулан, БНМАУ-ын Үндсэн хуулийн 78 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруул-

# ТАВДУГААР БҮЛЭГ: 1970-1979 ОН





# 1970

**4 сарын 20.** АИХ-ын Тэргүүлэгчдийн 70 дугаар зарлигаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулж БНМАУ-ын прокурорыг дөрвөн жилийн хугацаагаар томилох болов.

**4 сарын 20.** АИХ-ын Тэргүүлэгчдийн 69 дүгээр зарлигаар Гавьяат хуульч цол буй болгож, прокурорын байгууллагад ажиллаж буй тэргүүний хүмүүсийг шагнав.

**5 сарын 8.** БХЯ-ны сайд, Улсын Ерөнхий прокурорын тушаалаар Барилгын цэргийн прокурорын газар, Зүүнбаян цэргийн нэгтгэлийн прокурорын газрыг байгуулав.

**8 сарын 12.** АИХ-ын Тэргүүлэгчдийн 144 дүгээр зарлигаар БНМАУ-ын прокурорын байгууллагын 40 жилийн ойг тохиолдуулан Улсын прокурорын газрын Хэлтсийн прокурор Гэндэнгийн Дамдинсүрэн, Сэвжидийн Батсүх нарыг анх түрүүн БНМАУ-ын Гавьяат хуульч цолоор шагнажээ.

**8 сарын 14.** Прокурорын байгууллагын 40 жилийн ойн орон даяар өргөн тэмдэглэв.

## Ц.ЛООХУУЗ: “ЧАМД БОЛ БАЙЦААГДАНА, Ю.ЦЭДЭНБАЛД БАЙЦААГДАХГҮЙ”



Ц.Лоохууз

Улсын прокуророос “Намын эсрэг бүлэгт хамрагдан нутаг заагдан амьдарч байсан” Ц.Лоохуузад эрүүгийн хэрэг үүсгэн шалгах даалгавар өгсөн учир би энэ хэрэгт мөрдөн байцаалт явуулж байлаа.

Түүнийг цагдан хорьж хэргийг нь шалгасан бөгөөд нэг удаа Ганц худгаас авчраад байцаах гэж өрөөндөө оруулсан үедээ бие нь ямар байгааг асууж тамхи өгсөн юм.

Үүнд Ц.Лоохууз гуай маш их баярласнаа сүүлд манай хүү Т.Сүхбаатарт “Танай эцэг Г.Тогоонтөмөр сайн мөрдөн байцаагч төдийгүй, бас ч эр хүний тасархай байлаа” гэж.

Тэр үед мөрдөн байцаагч хүн хэргийн холбогдогчид харьцаа тогтоож болохгүй зарчимтай байсан. Түүнийг зүрх гаргаж эвдсэн хэрэг. Ер нь прокурор, мөрдөн байцаагч хэн боловч аливаа хэргийг шалгахдаа юу юугүй хууль дүрэм ярихаасаа өмнө хүнд хүн сэтгэлээр хандаж, эрхийг нь хамгаалах асуудлыг илүүд үзэж байх нь чухал.

Миний энэ байдлыг Ц.Лоохууз гуай тухайн үедээ сайн ойлгосон байх. Нэг удаа Ц.Лоохууз гуай “Чи бол ажлаа хийж байгаа жирийн мөрдөн байцаагч, чамд бол байцаагдана. Харин Ю.Цэдэнбалд бол байцаагдахгүй” гэж хатуу чанга харьцаж байсан удаа ч бий.

*Г.Тогоонтөмөрийн дурдатгалаас*

# 1970

## МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН МАНЛАЙ ГАВЬЯАТУУД

1970 онд прокурорын байгууллага 40 жилийн ойгоо тэмдэглэх гээд хөл ихтэй жил байлаа. БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ж.Самбуу эзгүй тул орлогч дарга Н.Лувсанравдан анхны Монгол Улсын гавьяат хуульч цолыг прокурор Г.Дамдинсүрэн бид хоёрт гардуулсан. Ингэж бид хоёр нэг зарлигаар гавьяат хуульч болсон юм. Г.Дамдинсүрэнд 001, надад 002 тоот үнэмлэх олгосон. Энэ нь прокурор төдийгүй Монголын хуульчдын дотроос анхны хүндтэй цол байв.

*Гавьяат хуульч С.Батсүхийн дурдатгалаас*

1970-аад оны үеийн прокурорын албан тасалгааг зурсан байдал. Сүхбаатар аймгийн прокурорын газрын архиваас...



-НАХЯ-ны Нэгдүгээр орлогч сайд, УАХЕГ-ын дарга Р.Гүнсэнг Улсын Дээд шүүхийн даргаар томилов.

-Улсын прокурорын тушаалаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хууль сурталчлах ажлын далайцыг дээшлүүлэх зорилгоор Улсын прокурорын газарт бичмэл сэтгүүлийн зөвлөлийг байгуулж, даргаар нь Г.Иш, гишүүдэд нь Ц.Загд, Д.Зундуй, Н.Сосорбарам нарыг томилжээ.

-Г.Чогсом Октябрийн районы, Д.Сосорбарам Ажилчны районы прокуророор, Н.Авирмэд Дундговь, Н.Өлзийбадрах Увс аймгийн прокуророор тус тус томилогдов.

# 1970

## БНМАУ-ЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ ГЭНДЭНГИЙН ДАМДИНСҮРЭН



Г.Дамдинсүрэн Дорноговь аймагт 1910 онд төржээ. Тэрбээр 1933-1934 онд Дорноговь аймгийн шүүхэд байцаагч, 1936-1938 онд аймгийн прокурорын орлогч, 1942-1950 онд Дундговь, Дорноговь аймгийн прокурор, 1950-1952 онд Архангай аймгийн прокурор, 1952-1959 онд Төв аймгийн прокурор, 1960-1962 онд Дорноговь аймгийн прокурор, 1962-1974 он хүртэл Улсын прокурорын газарт хэлтсийн прокуророор ажиллаж байжээ.

Түүнд БНМАУ-ын Гавьяат хуульч цолыг 1970 онд анх түрүүн хүртээжээ.

## Ж.ЧОЙЖАНЦАН: МӨРДӨН БАЙЦААГЧИЙН ӨРӨӨ

Намайг Төв аймгийн прокурорын чухал хэргийн мөрдөн байцаагчаар 1970 онд томилогдоход хэдийгээр техник хэрэгсэл дутмаг байсан ч аймгийн прокурор О.Лхамсүрэн мөрдөн байцаагчийн ширээг тоноглох шинэ загварыг гарган дотор нь дуу хураагч магнитофон, бичгийн машин, утас, зургийн аппарат, мөрдөн байцаагчийн цүнх, цүнхэнд хэргийн газар очиход хэрэг болох

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

ЗАРЛИГ

1970 оны 8 дугаар сарын 12 өдөр. Дугаар 144
Улаанбаатар хот

БНМАУ-ЫН „ГАВЬЯАТ ХУУЛЬЧ"
ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс
ТОГТООХ НЬ:

БНМАУ-ын прокурорын байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, социалист хууль ёсыг хатуужүүлэн бэхжүүлэхэд амжилт гаргасан учир БНМАУ-ын Прокурорын дэлгэн зааварлах хэлтсийн прокурор Гэндэнгийн ДАМДИНСҮРЭН; мөн ерөнхий хяналтын хэлтсийн прокурор Сэвжидийн БАТСУХ нарт БНМАУ-ын „ГАВЬЯАТ ХУУЛЬЧ" цол олгосугай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга /Ж.САМБУУ/

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Ц.ГОТОВ/

бүх зүйлийг багтааж өгсний зэрэгцээ өрөөнд нь сэжигтэн, яллагдагчийг байцаахдаа суулгадаг сандлыг шалтай нь, ширээг ханатай бэхэлсэн нь мөрдөн байцаагчийн аюулгүй байдлыг хангаж, суухад тохитой, ажил явуулахад тохиромжтой сэтгэл хангалуун ажлаа хийдэг байж билээ.

*Төрийн хууль цаазын шадар зөвлөх*
*Ж.Чойжанцангийн дурдатгалаас*

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН
АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН

ЗАРЛИГ

197 0 оны 8 дугаар сарын 12 өдөр. Дугаар 145
Улаанбаатар хот

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ АЖИЛТАН
НАРЫГ ОЛОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс
ТОГТООХ НЬ:

Прокурорын байгууллагад олон жил идэвх зүтгэл, ур бүтээлтэй ажилласан дор дурдсан ажилтан нарыг прокурорын байгууллагын 40 жилийн ойг тохиолдуулан одон, медалиар шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР:

1. Довдонгийн ЦЭВЭЛДАРААА — -Өвөрхангай аймгийн прокурор
2. Сандангийн ХОРЛОО — -Улсын прокурорын газрын шүүхийн хяналтын хэлтсийн прокурор

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН
ТУГИЙН ОДОНГООР:

1. Түвшингийн ДАВААДАВ — -Улаанбаатар хотын прокурор
2. Жономоогийн ЦАГААНХҮҮ — -Улсын прокурорын газрын шалган зааварлах хэлтсийн прокурор
3. Бэгзийн ЗОНРОЙ — -Архангай аймгийн прокурорын шүүхийн хяналтын түслах прокурор
4. Равсадын БАТМӨНХ — -Сүхбаатарын районы прокурор
5. Дондовын ЕНДОНДУЛИР — -БНМАУ-ын Ардын армийн улс төрийн газрын дарга

# 1970

## БНМАУ-ЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ СЭВЖИДИЙН БАТСҮХ



С.Батсүх Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт 1912 онд төржээ. Тэрбээр 1930 онд Хууль цаазын түр сургуулийг “Аймаг хошууны шүүхийн байцаагч, хошууны шүүхийн түшмэлд тэнцэнэ” гэсэн Шүүх явдлын яамны 1930 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 552 тоот үнэмлэхтэй төгсчээ.

С.Батсүх 1932 оноос Хан Хэнтий уулын аймгийн Дарьгангын хошууны шүүхийн түшмэл, аймгийн шүүгч, дарга, орлогч, прокурор, 1934 оноос Дорнод, Хэнтий, Булган аймгийн болон Улаанбаатар хотын прокурор, Улсын прокурорын орлогчоор 50 шахам жил ажиллажээ.

Түүнд БНМАУ-ын Гавьяат хуульч цолыг 1970 онд хүртээжээ.

# 1970

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН**
**АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН**

## ЗАРЛИГ

*19 70 оны 4 дугаар сарын 20 өдөр. Дугаар 70*
*Улаанбаатар хот*

БНМАУ-ЫН ПРОКУРОРЫН ТОМИЛОЛТЫН
ХУГАЦААГ ӨӨРЧЛӨН ТОГТООХ ТУХАЙ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс
Т О Г Т О О Х НЬ:

1.БНМАУ-ын прокурорыг Ардын Их Хурлаас 4 жилийн хугацаагаар томилж байхаар тогтоосугай.

2.Энэ зарлиг гарсантай холбогдуулан, БНМАУ-ын Үндсэн хуулийн 73 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

„Далан гуравдугаар зүйл. БНМАУ-ын прокурорыг Ардын Их Хурлаас дөрвөн жилийн хугацаагаар томилно. Улсын прокурор бол Ардын Их Хурал, түүний тэргүүлэгчдэд ажлаа хариуцан тайлагнана".

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга — (Ж. САМБУУ)
БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн орлогч дарга — (Н. ЛУВСАНПРАВДАН)
БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга — (Ц. ГОТОВ)
Тэргүүлэгч гишүүн: (Б. АЛТАНГЭРЭЛ)
(Д. БАТАА)
(Д. ЁНДОНДУЙЧИР)
(С. УДВАЛ)
(Ч. ПҮРЭВЖАВ)
(Д. ЯДАМСҮРЭН)

# 1971

## САЙЖАА, ЯНЖМАА НАРЫГ ЦАГААТГАВ


Улаанбаатар хотын Ажилчны районы худалдааны касснаас 20 гаруй мянган төгрөг хулгайд алдагдсан ноцтой хэргийн талаар тухайн үед Улсын прокуророор ажиллаж байсан Ж.Авхиа “...Улаанбаатар хотын прокурорын газар энэ хэргийг мөрдөн шалгаж, цагдан сэргийлэхийн ажилтан офицер Р.Сайжаа, түүний эхнэр Янжмаа нарыг эрүүгийн хариуцлагад татаж, хотын шүүхэд шилжүүлсэн. Шүүх тэдэнд 3-5 жилийн хорих ял оноосныг Улсын Дээд шүүх давж заалдах шатаар хянаад ялыг хэвээр баталсан.

Би энэ хэрэг үнэн зөв шийдсэн гэдэгт эргэлзэж, Улсын прокурорын газрын Шүүхийн хяналтын хэлтэс, Мөрдөн байцаах хэлтэс тус бүрээс нэг, нэг туршлагатай прокурорт үүрэг өгч, уг хэргийг уншуулаад, саналыг удирдлагын зөвлөгөөнөөр сонсон улмаар бүрдэл дутуу гэж үзээд, Дээд шүүхийн Бүгд хуралд Улсын прокурорын эсэргүүцэл бичсэн юм.

Бүгд хурал эсэргүүцлийг авч хэлэлцээд, Хотын шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг мөрдөн байцаалтад буцаалаа. Уг хэргийг Улсын прокурорын газарт мөрдсөн ба мөрдөн байцаалт гүйцэтгэх, эрэн сурвалжлах ажлыг зөв явуулахын тулд Улсын цагдан сэргийлэх газрын дарга С.Бүдрагчаад хүсэлт тавихад,

-МАХН-ын 16 дугаар Их хурлаас социалист хууль ёсыг хэлбэрэлтгүй сахиж, хууль тогтоомжийг боловсронгуй болгохыг зааж, энэ үйл хэрэгт өнгөрсөн жилүүдэд хуулийн байгууллагууд, тэр дундаа Улсын прокурорын газар үлгэр жишээч ажиллаж ирснийг онцлон сайшаажээ.

-Улсын прокурорын орлогчоор Ж.Балжинням, Төмөр замын прокуророор М.Дүнчинсүрэн, Дархан хотын прокуророор Г.Хоохор, Сэлэнгэ аймгийн прокуророор Ч.Бэгзжав тус тус томилогдов.



1970-аад оны үеийн нийслэлийн Ажилчны район

# 1971

## БНМАУ-ЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ ОЙДОВЫН ЛХАМСҮРЭН



Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн О.Лхамсүрэн Ховд аймгийн Мянгад суманд 1918 онд төрж, 1955-1960 онд Намын дээд сургуулийг дүүргэжээ.

Тэрбээр 1937-1941 онд цэргийн алба хааж, 1941-1943 онд Увс аймгийн прокурорын газарт мөрдөн байцаагч, ахлах мөрдөн байцаагч, туслах прокурор, 1943-1945 онд Говь-Алтай аймгийн туслах прокурор, 1949-1950 онд Улсын прокурорт хэлтсийн прокурор, 1950-1955 онд Завхан аймгийн прокурор, 1960-1982 онд Төв аймгийн прокуророор тасралтгүй ажиллаж иржээ.

Түүнд 1971 онд БНМАУ-ын Гавьяат хуульч цол олгожээ.

А.Думбарай, Дамдинсүрэн нарын хоёр гүйцэтгэх ажилтныг миний мэдэлд өгч, бид тусгай төлөвлөгөөтэйгөөр хамтарч ажилласан юм.

Ингээд 22 хоногийн дараа уг хэргийн жинхэнэ эзэн илэрч, мөнгийг тус байгууллагын ажилтан эмэгтэй Цэнд гэгч хулгайлан авсан нь баримтаар нотлогдон, өөрөө ч хэргээ хүлээж, шүүхээр долоон жилийн хорих ялаар шийтгэгдсэн. Ингэж гэм буруугүй Сайжаа, Янжмаа нар цагаатгагдаж байлаа. Энэ хэргийг өмнө нь шалгасан буруутай хүмүүст ч арга хэмжээ авсан. Аливаа хэргийн гэм бурууг үнэн зөв мөрдөж тогтоох нь мөрдөн байцаах чанартай салшгүй холбоотой" хэмээн өгүүлсэн байдаг.

*БНМАУ-ын прокурор Ж.Авхиагийн дурдатгалаас*

## КРИМИНАЛИСТИКИЙН КАБИНЕТ, ЗОХИОМОЛ ХЭРГИЙН ГАЗАР

Улаанбаатар хотын прокурорын газар мөрдөн байцаалтын ажилд криминалистикийн техник хэрэгслийг ашиглах, прокурор, мөрдөн байцаах ажилтнуудыг сургаж дадлагажуулахад анхаарч ЗХУ-ын прокурорын эрдэм шинжилгээний ажилтан В.С.Сорокиныг урьж ирүүлэн криминалист прокурор Л.Болдыг дагалдуулан сургаж, улмаар криминалистикийн кабинет байгуулжээ.

Уг кабинетэд шүүхийн гэрэл зураг, хэргийн газар үзлэг хийх, ул мөр илрүүлэх, бэхжүүлэх зэрэг мөрдөн байцаалтын арга техникийг харуулсан 40 гаруй төрлийн самбар, кино, фото зургийн аппарат, магнитофон, мөрдөн байцаагчийн цүнх, чемодан зэрэг техник хэрэгсэл тавигджээ. Мөн фото зургийн лаборатори, зохиомол хэргийн газрын үзлэгийн байр, техник

# 1971



хэрэгслэлээр бүрэн тоноглосон мөрдөн байцаагчийн өрөө зэргийг байгуулан ажиллаж жил бүр прокурор, мөрдөн байцаагчдад 50-70 цагийн хичээл зааж дадлагын ажил хийлгэдэг болсон байна.

## Ж.БАЛЖИННЯМ: ТЭДНИЙ ДЭМЭЭР БИ ӨДИЙ ЗЭРЭГТ ХҮРСЭН ХҮН

Цэргийн прокурорын орлогчоос Ерөнхий прокурор болтлоо 15 жил энэ системд ажилласан Ж.Балжинням “1971 оны хавар хөдөөгийн нэгэн хорих ангид гарсан хүн амины хэргийг шалгаж байтал Улсын прокурорын орлогч Г.Иш яаралтай дуудуулжээ. Замын тоосоо ч гөвөлгүй ирснээ мэдэгдвэл Иш прокурор Жалан-Аажав даргатай уулзахыг даалгав.

С.Жалан-Аажав дарга ажил төрөлтэй маань товчхон танилцаад “Улсын прокурорын газраас таныг тус газрын мөрдөн байцаалт эрхэлсэн орлогч прокуророор томилуулах санал оруулж ирсэн. Улс төрийн товчооны хурлаар орох учраас зохих бэлтгэлийг хангах хэрэгтэй” гэв. Тэр үед Улсын прокурорын газарт манай хуульчдын “алтан үеийнхэн” гавьяат хуульч Г.Дамдинсүрэн, С.Батсүх, прокурор Б.Цагаанхүү, Р.Сүхбаатар, Д.Цэдэндаржаа, Ж.Гомбодорж, З.Ширчин, А.Ядмаа, орон нутагт гавьяат хуульч О.Лхамсүрэн, Х.Жамбал, М.Бадрах, прокурор Г.Бэгз, П.Хүүхнээ, Д.Очирхуяг, Ц.Жалбасүрэн, Х.Буран, Х.Үржиндорж, Б.Чулуун нарын ланжгарууд ажиллаж байлаа. Тэдний дэмээр би өдий зэрэгт хүрсэн хүн” хэмээжээ.

## О.ЛХАМСҮРЭН: БИ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР НЭГ, ОРЛОГЧ НЭГИЙГ БЭЛТГЭСЭН

Монгол Улсын гавьяат хуульч цол шинээр бий болсны дараа жил нь О.Лхамсүрэн прокурор гавьяат хуульч цолоор шагнуулж 4 дугаартай үнэмлэхийг гардан авчээ. Тэрбээр “Би Монгол Улсын Ерөнхий прокурор 1, орлогч прокурор 1, аймаг нийслэлийн прокурор 16-г бэлтгэж гаргасан” хэмээн бахархан ярих дуртай.

Монгол Улсын Ерөнхий прокурор байсан С.Бүдрагчаа прокурорыг Завхан аймгийн прокурор байхдаа аймгийн

# 1971

боловсролын хэлтсийн байцаагчаас прокурорын газарт байцаагчаар авч прокурор болох замыг нь нээсэн, Улсын Ерөнхий прокурорын орлогч Н.Чойжанцанг 20 настай байхад нь хүлээн авч хэсгийн прокурор, чухал хэргийн мөрдөн байцаагчаар 7 жил ажиллуулж Монгол Улсын их сургуульд 5 жил суралцуулж төгсгөөд аймгийн прокурорын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих прокуророор томилуулж 1 жил ажиллуулаад өөрийнхөө тасралтгүй 22 жил хашсан аймгийн ерөнхий прокурор гэсэн нэр хүндтэй, өндөр хариуцлагатай албан тушаалаа хүлээлгэн өгсөн аж.

## МОНГОЛЫН ХУУЛЬЧИД БОЛГАРТ АЙЛЧЛАВ

МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвөлгөөний 1971 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 229 дүгээр тогтоолоор зөвшөөрөгдсөн ёсоор Бүгд найрамдах Болгар Ард Улсын Шүүх яам, Ерөнхий прокурорын газар, Дээд Шүүхийн урилгаар манай улсын хуулийн төв байгууллагуудын төлөөлөгчид 1971 оны 9 дүгээр сарын 2-12-ны өдрүүдэд БНБАУ-д зочилж хуулийн байгууллагуудын ажилтай танилцжээ.

Зочдыг Бүгд найрамдах Болгар Ард Улсын Ерөнхий прокурор Иван Вачков, Дээд Шүүхийн дарга Ангел Велев, Шүүх яамны I-р орлогч сайд Атнас Войнов нар хүлээн авч харилцан мэдээлэл солилцсоны дараа Ерөнхий прокурорын газар БНМАУ-ын прокурор Ж.Авхиаг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн байна.

## ГЭМТ ХЭРГЭЭС СЭРГИЙЛЭХ ГОЛ ЗОХИЦУУЛАГЧ Н.СОСОРБАРАМ



Нанзадын Сосорбарам Хөвсгөл аймгийн Бүрэнхаан суманд 1941 онд төржээ.

Тэрбээр МУИС-ийг 1964 онд төгсөж, Улсын прокурорын газарт хэлтсийн прокуророос ажлаа эхэлсний дотор 1971-1977 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн даргаар ажиллахдаа насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэрэгт тавих хяналтыг улсын хэмжээнд удирдаж, Цагдан хорих төвд хүүхдийг тусгайлан хорих өрөөтэй болгон, Техник мэргэжлийн сургууль, Үйлдвэр, аж ахуйн газруудад сурч, ажиллаж буй хүүхдийг хэрэг зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх ажилд ахиц дэвшил гаргажээ.

Түүнчлэн тэрбээр 1967-1988 онд телевизийн “Хууль зүй” нэвтрүүлгийг хөтөлж, “Радиогийн иргэн ба хууль”, “Залуучууд, хууль ёс” нэвтрүүлгийг бэлтгэн, 2001-2012 онд УЕПГ-ын Ахмадын хороог толгойлж ажилласныг нь үнэлэн төрөөс 2009 онд Сүхбаатарын одонгоор шагнагджээ.

# 1972

## АВХИАГИЙН АЛСЫГ ХАРСАН АЖЛУУД

БНМАУ-ын прокурор, Хууль цаазын жинхэнэ зөвлөх Ж.Авхиа, Улсын прокурорын нэгдүгээр орлогч прокурор, хууль цаазын шадар зөвлөх Г.Иш нарын удирдлагууд прокурорын байгууллагын хяналтын ажлын үр нөлөөг дээшлүүлэх, аж ахуй зохион байгуулалтын хувьд бэхжүүлэхэд асар их үүрэг гүйцэтгэжээ. Тэдний санаачлагаар 1972 онд прокурорын байгууллага, прокуроруудын ажил хэргийг үндсээр нь өөрчлөхүйц томоохон өөрчлөлтийг Намын Төв хороо, СнЗ-ийн тогтоолоор шийдвэрлэжээ. Тухайлбал, Улсын Ерөнхий Прокурорын газрын өнөөгийн байрыг бариулсан, прокурорын ажилтныг цол хэргэм, дүрэмт хувцастай болгох шийдвэр анх гаргуулсан, прокурорын байгууллагын дэргэд Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах хүрээлэн байгуулах шийдвэрийг гаргуулж, бий болгосон, “Социалист хууль ёс” сэтгүүлийг бий болгож, улирал тутам хэвлүүлсэн, олон аймгийн прокурорын газрыг шинэ байр, унаатай болгосон. Улсын прокурорын газрын ажилтнуудад зориулж зуслангийн 40 гаруй байр бариулж зунд нь зусланд гаргадаг болжээ.

## АВХИА ПРОКУРОР АЖИЛТНАА ӨӨРӨӨ СУДАЛДАГ БАЙЛАА

МУИС-ийн хуулийн ангийг 1972 онд төгсөх үед Улсын прокуророор ажиллаж байсан Ж.Авхиа гуай шинэ ажилтнуудаа их сургууль дээр очиж биечлэн судалсан юм билээ. Тэгэхдээ хүүхдүүдтэй уулзаагүй, багш нартай нь уулзаж, оюутнуудын бичсэн дипломын ажлыг уншчээ. Түүнийг бид хожмоо мэдсэн. Үнэндээ боловсон хүчнээс, хүнээс ажил шалтгаалдаг тул хүн сонгоход ингэж анхааралтай хандаж байсан нь хэнд ч сургамжтай зүйл. Манай төгсөлтийнхнөөс дөрөв нь Улаанбаатарт, найм нь орон нутагт хуваарилагдсан юм. Миний бие Улсын прокурорын газарт насанд хүрээгүй хүмүүсийн асуудал эрхэлсэн хэлтсийн прокуророор томилогдсон. Тэр үед нь би гайхаж байсан ч Ерөнхий прокурор ажилд авах хүнээ сургууль төгсөхөөс нь өмнө өөрөө биечлэн судлаж байсныг хожим ойлгосон.

*Монгол Улсын Гавьяат хуульч Н.Жанцангийн дурдатгалаас*

**4 сарын 8.** МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоо шүүх, прокурорын байгууллагын ажлыг сайжруулах тухай 96 дугаар тогтоол гаргав.

**4 сарын 8.** Ардын цэргийн прокурорын газрыг Цэргийн Ерөнхий прокурорын газар болгон нэрийг нь өөрчлөв.

-МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны болон СнЗ-ийн 228 дугаар тогтоолоор Улсын прокурорын газрын дэргэд Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэнг байгуулав.

-АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар засаг захиргаа, үйлдвэр аж ахуйн нэгж газруудтай, 6000-аас доошгүй байгын оршин суугчидтай, хүн амын олонх нь хөдөө аж ахуйгаас бусад салбарт ажилладаг төвлөрсөн сууринг хот гэж тодорхойлсны дагуу прокурорын орон нутгийн бүтцэд өөрчлөлт оржээ.

# 1972

-МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 96 дугаар тогтоолоор Хязгаарын ба дотоодын цэргийн прокурорын газрыг дахин байгуулав.

-Улсын прокурорын орлогч Ж.Балжинням Ардын армийн Ерөнхий прокурорын үүргийг хавсран гүйцэтгэх болов.

-Улаанбаатар хотын прокурорын газарт тусгай хяналтын хэлтсийг байгуулав.

-“Социалист хууль ёс” сэтгүүлийг бий болгох шийдвэр гаргав.

-Мөрдөн байцаах ажилтны улсын II зөвлөгөөн 1972 онд болжээ.

-Г.Шагдаржав Найрамдлын, Ч.Ядмаа Ажилчны районы прокуророор, Б.Жанлав Булган, Ц.Цоодол Говь-Алтай, Г.Шаравнямбуу Өмнөговь, М.Бадрах Хөвсгөл аймгийн прокуророор томилогдов.

## ОРГИЙН ЖАМБАЛДОРЖ



О.Жамбалдорж Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан суманд 1940 онд төрж, 1959-1964 онд Ленинградын УИС, 1978 онд ЗХУ-д Нийгмийн ухааны академи төгсчээ.

О.Жамбалдорж 1964-1965 онд БНМАУ-ын Прокурорын газрын чухал хэргийн мөрдөн байцаагч, 1965-1972 онд СнЗ-ийн Хуулийн хороонд ахлах зөвлөх, 1972-1973 онд Шүүх яамны гадаад харилцааны хэлтсийн дарга, 1972-1983 онд Шүүх яамны орлогч сайд, нэгдүгээр орлогч сайд, 1982-1988 онд Шүүх яамны сайд, 1988-1990 онд Хууль зүй, арбитрын яамны сайд, 1990 оноос МУИС-ийн Хууль зүйн сургуульд багшилж иржээ. Тэрбээр 1981 онд Хууль зүйн ухааны дэд эрдэмтний зэргийг хамгаалжээ.

## ЛУВСАНДОРЖИЙН РЭНЧИН



Л.Рэнчин Завхан аймгийн Цагаан хайрхан суманд 1943 онд төржээ. Тэрбээр 1966 онд Эрхүүгийн Улсын их сургуулийн хуулийн анги, 1981 онд Москва хотын нийгмийн ухааны академийг төгсөж, Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалжээ.

Л.Рэнчин 1966-1971 онд Сэлэнгэ аймгийн прокурорын газарт хэсгийн болон туслах прокурор, 1971-1977 онд БНМАУ-ын прокурорын газарт тасгийн дарга, Улсын прокурорын газрын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэнгийн орлогч захирал, 1980-1982 онд МАХН-ын Төв хороонд зааварлагч, 1982-1984 онд БНМАУ-ын Шүүх яамны нэгдүгээр орлогч сайд,1984-1986 онд МАХН-ын Төв хорооны Захиргааны байгууллагын хэлтсийн орлогч эрхлэгч, 1986-1990 онд Монгол Улсын Дээд шүүхийн даргаар ажиллажээ. Түүний зүтгэлийг үнэлж төрөөс Монгол Улсын гавьяат хуульч цолоор шагнажээ.

# 1973

## ПРОКУРОР ДЭРГЭДЭЭ ХҮРЭЭЛЭНТЭЙ БОЛОВ

Гэмт хэргийн гаралтыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхийн тулд шинжлэх ухааны үндэстэй судалгаа, шинжилгээний ажлыг чухалчилж Гэмт хэргийн нөхцөл, шалтгааныг судлах хүрээлэн байгуулагдав. Энэ хүрээлэн арав орчим жил оршин тогтнохдоо “БНМАУ-д үйлдэгдэн гарч байгаа гэмт хэргийн нөхцөл шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдвийн хүрээнд судалгаа хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэдвээр 10 гаруй эрдэм шинжилгээний бүтээл, аргачлал, зөвлөмж, нэг сэдэвт зохиолууд гаргаж, эгнээнээсээ Ж.Авхиа, Н.Жанцан, К.Тажебакед, Ц.Бүжинлхам, Ч.Энхбаатар нарын эрдэмтэдийг төрүүлжээ.

Хүрээлэн эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг дотооддоо зохион явуулахын зэрэгцээ олон улсын симпозиум, криминалогичдийн их хуралд удаа дараа оролцож байжээ.

Дэргэдээ эрдэм шинжилгээний хүрээлэнтэй болсноор прокурорын байгууллагын эрх, үүрэг, үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан хуультай болох, энэ чиглэлээр олон улсын прокурорын байгууллагуудын туршлагаас судалгаа хийх боломж нэмэгдсэн байна.



Зөвлөлт Украины Харьков хотноо мэргэжил дээшлүүлэх сургалтад суусан прокурорууд

2 сарын 26. Улсын прокурорын газрын дэргэд Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэнг албан ёсоор нээж, дагаж мөрдөх түр дүрмийг батлан, анхны орлогч захирлаар нь Лувсандоржийн Рэнчинг томилов.

9 сарын 5. ЗХУ-д мэргэжил дээшлүүлэх 3 сарын курст суралцах удирдах ажилтны курсийн ахлагчаар Улсын прокурорын орлогч Ж.Балжиннямыг томилжээ.

-Прокурорын байгууллагын дэргэд “Социалист хууль ёс” сэтгүүл анхны дугаараа хэвлүүлж, захиалагчдын тоо 20 мянгад хүрэв. Энэ сэтгүүл 1990 оныг хүртэл 18 жил хэвлэгдэж, Хариуцлагатай нарийн бичгийн даргаар нь Ж.Сарантуяа ажиллаж байв.

-Улаанбаатар хотын прокурорын газрын мөрдөн байцаах хэлтсээс, Октябрийн районоос бусад гурван районы прокурорын газарт тус бүр нэг мөрдөн байцаагчийг шилжүүлэн ажиллуулав.

# 1973

-Аймаг, хотын цагдан сэргийлэх анги, хэлтсийн дарга нарын төлөөлөл Төв аймгийн прокурорын газарт туршлага судлав.

-Аймаг хотын прокурорын байгууллагын дэргэд хэвлэл радиогийн идэвхтэн бичигчдийн сурвалжлах хэсэг байгуулан ажиллуулж, Радио, телевиз, “Хөдөлмөр”, “Залуучуудын үнэн”, “Пионерийн үнэн” сонинд жил, улирлын төлөвлөгөөтэй хууль зүйн сэдвээр бичих болов.

-Хууль эрхийн холбогдолтой лекц ярианы сэдэв 349-ийг боловсруулж сурталчилгааны ажилд хэрэглэв.

-Нийслэл хотод гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх ажлыг улам эрчимжүүлэх зорилгоор 4 районы хуулийн төв байгууллагууд хариуцан ажиллав.

-Ж.Юлсүрэн Октябрийн районы прокуророор томилогдов.

## Ц.БҮЖИНЛХАМ: ГЭМТ ХЭРЭГТЭЙ ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТЭМЦСЭН



Прокуророос төрсөн Хууль зүйн ухааны доктор Ц.Бүжинлхам “Манай хүрээлэн байгуулагдаад 3 секторт 10 ажилтан ажиллаж, захирлыг нь Улсын прокурорын орлогч хавсарч, өдөр тутмын ажлыг орлогч захирал Л.Рэнцэн хариуцаж, секторын эрхлэгчээр Н.Жанцан, Н.Туяа бид ажилладаг байлаа. Би прокурорын хяналтын секторын эрхлэгч байсан юм. Энэ хүрээлэн нь төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах зорилготой байгуулагдсан. Манай хүрээлэнгээс 5 хүн эрдмийн зэрэг хамгаалж, “Гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” гэсэн 10 гаруй бие даасан товхимол, Криминалогийн сурах бичиг бүтээж, хуульчдын онолын мэдлэгт түс болж байсан.


Манай хүрээлэн Монгол Улсын нутаг дэвсгэрт гарч байгаа гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлаж, дүн шинжилгээ хийн, урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулж зөвлөмж санал өгөх ажлуудыг голлон хийдэг байв. Бид Зөвлөлтийн эрдэмтэн зөвлөхүүдийг эх орондоо урьж тэдний туслалцаатай шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа явуулж байв. Орон нутагт үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгааныг судлахдаа тухайн газарт нь очиж судалгаа авах, ярилцлага хийх зэрэг олон аргыг хэрэглэдэг байсан. Харамсалтай нь уг хүрээлэнг 1990-ээд онд татан буулгасан юм даа” хэмээн дурсаж байна.

# 1973

## ХҮНДЭЭ ХҮРСЭН ХУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА

Улс аймаг хотын прокурорын байгууллагууд дэргэдээ хэвлэл радиогийн идэвхтэн бичигчдийн сурвалжлах хэсэг байгуулан Радио, телевиз, “Хөдөлмөр”, “Залуучуудын үнэн”, “Пионерийн үнэн” сонинтой жил, улирлын төлөвлөгөөтэй хамтран ажиллаж хууль зүйн сэдвээр бичиж нэвтрүүлдэг болов. Үүний үр дүнд хууль эрхийн холбогдолтой лекц ярианы сэдэв 349-ийг бичиж сурталчлах ажилд хэрэглэснээс гадна 1973 онд 490525 хүнд хууль сурталчилж, уулзалт, үдэшлэг, 254 удаа зохиожээ. Прокурор, мөрдөн байцаагч нар хүмүүжил сахилгаар сул, тогтворгүй 4381 хүнд зөвлөгөө өгч, 2046 хүнийг ажил сургуульд оруулжээ.

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***



Н.ХАРАНТАЙН АВХИАГ СУХБААТАРЫН
ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс
ТОГТООХ НЬ:

Улсын байгууллагын удирдах ажилд олон жил идэвх зүтгэл, ур бүтээлтэй ажиллаж байгааг тэмдэглэж, БНМАУ-ын прокурор нөхөр Харантайн АВХИАГ 50 насны нь ойг тохиолдуулан СУХБААТАРЫН одонгоор шагнасугай.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1-р орлогч дарга
БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн орлогч дарга
БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Тэргүүлэгч гишүүн:

(С. ЛУВСАН)
(Ц. ДҮГЭРСҮРЭН)
(Ц. ГОТОВ)
(Б. АЛТАНГЭРЭЛ)
(С. БАТАА)
(Д. ЕНДОНДҮРЭВИР)
(Н. ЛУВСАНРАВДАН)
(С. УДВАЛ)
(Ч. ПҮРЭВЖАВ)
(Д. ЯДАМСҮРЭН)



Урд эгнээнд зүүн талаас Ажилчны районы прокурор Ч.Ядмаа, Улаанбаатар хотын прокурор Т.Даваажав, Найрамдлын районы прокурор Р.Батмөнх, арын эгнээний зүүн гар талаас Октярийн районы прокурор Ж.Юлсүрэн, Улаанбаатар гарнизоны прокурор Готов нар.

# 1974

11 сард. ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн тэргүүлэгчдийн дарга Л.И.Брежнев тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав. Айлчлалын үеэр хоёр орны удирдлагууд хууль, эрхзүйн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурав.

12 сард. АИХ-ын Тэргүүлэгчид прокурор, мөрдөн байцаагч нарт цол буй болгох тухай 358 дугаар зарлиг гаргав.

12 сард. СнЗ-өөс прокурор, мөрдөн байцаах ажилтны цолны нэмэгдлийн хэмжээг тогтоосон тогтоол гаргав.

-“Прокурорын байгууллагын тухай” хуулийг батлан гаргав.

-МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны хурлаас “Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” тогтоол гаргажээ.

## ХУУЛЬ ХЭРЭГЖИХЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ ЗӨВХӨН ПРОКУРОРТ ОЛГОВ

Прокурорын байгууллагын тухай хууль батлагдан түүнд “Прокурор дээд хяналт тавина” гэж хуульчилж өгснөөр “Төр, аж ахуй, худалдаа үйлчилгээ болон нийгмийн бүх салбарт хууль ёс нэг мөр хэрэгжихэд тавих хяналтыг зөвхөн прокурорт олгов. Хуулийн дагуу прокурорын байгууллага нь үндсэн дөрвөн чиглэлээр хяналт тавих болжээ.

1. Ерөнхий хяналт: БНМАУ-ын 40 гаруй хууль, Ардын Их хурал, Сайд нарын зөвлөлийн 200 гаруй хэм хэмжээ тогтоосон эрхийн актыг нэг мөр хэрэгжиж байгаад Ерөнхий хяналт тавьж мөрдүүлэх;

2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналт: Цагдан сэргийлэх, нийгмийн аюулаас хамгаалах, цэргийн болон хилийн цэргийн прокурорын мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж удирдан чиглүүлэх;

3. Шүүхийн хяналт: Эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд оролцож дүгнэлт өгөх, шүүн таслах үйл ажиллагааны явцад гарсан зөрчлийг прокурорын эсэргүүцэл, мэдэгдэл бичүүлэн засуулах арга хэмжээ авах;

4. Тусгай хяналт: Цагдан сэргийлэх, нийгмийн аюулаас хамгаалах байгууллагаас явуулдаг гүйцэтгэх ажиллагаа, хорих засан хүмүүжүүлэх байгууллагуудын үйл ажиллагаанд хууль хэрхэн мөрдөгдөж байгаад хяналт тавих.

## АЛБАН ТУШААЛЫН ЦОЛ, НЭМЭГДЭЛТЭЙ БОЛОВ

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид прокурор, мөрдөн байцаагч нарт цол буй болгох тухай 358 дугаар зарлиг гаргаж, үүний дагуу СнЗ-өөс прокурор, мөрдөн байцаах ажилтны цолны нэмэгдлийн хэмжээг тогтоосноор “Хуульч”, “Ахлах хуульч”, “Хууль цаазын дэд зөвлөх”, “Хууль цаазын зөвлөх”, “Хууль цаазын ахлах зөвлөх”, “Хууль цаазын жинхэнэ зөвлөх” зэрэг албан тушаалын долоон зэрэг бүхий цол ба цолны нэмэгдэл цалинтай болжээ. Цолны нэмэгдэл цалинтай болсноор аймаг, хотын прокуроруудын цалин 25 хувиар, мөрдөн байцаагч нарынх 40 гаруй хувиар нэмэгдэв.

# 1974

## БИД... ШИЙТГЭХЭЭСЭЭ СЭРГИЙЛНЭ

Хуулийн байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төвлөрөн ажиллах болсныг 1974 он 6 дугаар сард “Төв, орон нутгийн хуулийн байгууллагуудын удирдах ажилтнуудын зөвлөгөөн”-д БНМАУ-ын прокурор Ж.Авхиагийн тавьсан илтгэл батална. Тэрбээр “Хууль ёсыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах хуулийн байгууллагын зорилт” илтгэлдээ “Гэмт хэрэгтэй тэмцэх гол арга бол урьдчилан сэргийлэх явдал юм. Одоо бид гэмт хэрэг гарсны төлөө арга буюу шийтгэж байхын оронд урьдчилан сэргийлнэ. Гэмт хэрэг гарсны дараа нэлээд сүржин дуу шуугиантай боловч үр дүн багатай хөөцөлдөж байгаа арга практикийг өөрчилж, хуулийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтыг оновчтой, үр дүнг дээшлүүлэх замаар юуны өмнө гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг гаргахгүй байхад гол анхаарлыг төвлөрүүлэх нь чухал” гэсэн байдаг.

## ТЕЛЕВИЗИЙН НЭВТРҮҮЛГИЙГ ПРОКУРОРУУД ХӨТЛӨВ

АИХ-ын чуулганаар “Хөдөлмөрчдийн эрхзүйн хүмүүжлийг дээшлүүлэх тухай” илтгэлийг авч хэлэлцсэний дүнд Үндэсний телевиз хууль, эрхзүйн сэдэвт нэвтрүүлгийн цаг гаргав. Долоо хоногт хоёр удаа цацагдах нэвтрүүлгийн анхны дугаарыг Улсын прокурорын нэгдүгээр орлогч Г.Иш, хэлтсийн прокуророр Н.Сосорбарам нар хөтлөн явуулжээ. Нэвтрүүлгийг Монгол телевизийн сэтгүүлч Амбасэлмаа, Лхагвасүрэн, Төрмандах, нар цаашид хөтөлжээ. Эрдэмтэн зохиолч Л.Түдэв, сэтгүүлч Үржинбадам, сурган хүмүүжүүлэх ухааны эрдэмтэн Даваасүрэн нарын олон эрдэмтэд ажилтнууд нэвтрүүлэгт оролцон үнэтэй зөвлөлгөө өгчээ.

Ийнхүү Монгол телевизээр хуулийн сурталчилгаа хүчтэй хийгдэж эхэлснээс хойш тухайн үеийн бүх сонин хэвлэлүүд хуульзүйн тогтмол булантай болж, энэ ажилд прокурорын байгууллагын зүгээс хэлтсийн прокурор Н.Сосорбарам мэргэжлийн туслалцаа идэвхийлэн үзүүлж байв.

-АИХ-ын Тэргүүлэгчид “Танхайрагчид, нийгмийн хэв журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай”, “Согтуурах явдалтай тэмцэх тухай” зарлигуудыг батлан гаргав.

-Прокурорын мөрдөн байцаагчдыг ЗХУ-ын Ленинград хотноо дамжаанд сургажээ.

-Ж.Гомбодорж Улаанбаатар хотын, Д.Зулхаажия Тээврийн прокуророор, Б.Чулуун Баянхонгор, Л.Ядмаа Завхан, Д.Цэндцэсэм Өвөрхангай, Т.Даваажав Ховд аймагт тус тус аймгийн прокуророор томилогдов.

# 1974

## САНГИЙН ЯАМНААС ЖАВТИЙ ХҮРТЭВ

Тухайн үеийн прокурорын удирдлагын ажил хэрэгч, идэвхтэй, ухаалаг ажиллагааны үр дүнд 1974 онд Улсын прокурорын газар тохилог шинэ 4 давхар байртай болж, цаашид улсын төлөвлөгөөгөөр жил тутам 2-3 аймгийн шүүх, прокурорын нэгдсэн контор барих эхлэл бий болжээ. Улсын прокурорын орлогчоор ажиллаж байсан Ж.Балжинням “Тэр үед прокурорын газар аж ахуй, орон байрны хувьд ядмаг байлаа. Хоёр давхар өмийсөн модон байртай. Аймаг, хотын прокурорын газрууд бүр ч хэцүү байсан. АИХ-ын Тэргүүлэгчдийн 1 дүгээр орлогч дарга С.Лувсан шүүх, прокурорын газрын нэгдсэн байр барихыг зөвшөөрч улсын төлөвлөгөөнд оруулснаар бидний олон жилийн хүсэл биелж өнөөгийн энэ байранд орсон. Гэхдээ энэ ажил тийм ч амар бүтээгүй юм шүү. Барилгыг чанартай бариулах, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр хангахад Улсын прокурорын 1 дүгээр орлогч прокурор Г.Иш нэн их анхаарч хөөцөлдсөний эцэст л бүтсэн. Прокурорын газрын байрыг барьсан алдарт барилгачин Намсрайн бригадыг шагнаж урамшуулсны улмаас Сангийн яамнаас жавтий хүртэж, төлбөрт ч унах шахаж явлаа” хэмээн дурсжээ.



1974 онд УЕПГ-ын одоогийн байр ашиглалтад оров

## АВХИА ПРОКУРОРЫН АМАРГҮЙ ДААЛГАВАР

1973 оны намар аймаг, хотын прокуроруудыг ахалж Украины Харьков хотод мэргэжил дээшлүүлэхээр явах үед Ж.Авхиа прокурор надад “Москвагаар дайрахдаа ЗХУ-ын Ерөнхий прокурор Руденкотой уулзаж миний мэндийг дамжуулж, манай прокурорын газар шинэ байранд орсныг илтгэж, мебель тавилгаар туслахыг гуй” гэсэн бэрх даалгавар өгөв. Би Москвад ЗХУ-ын Ерөнхий прокурор, фашист Германы цэргийн гэмт хэрэгтнүүдийг шүүсэн Нюрнбергийн олон улсын шүүхийн яллагч Роман Андреевич Руденкод бараалхав.


Өрөөнд нь орж Авхиа прокурорын мэндийг дамжуулбал Руденко прокурор Монголд айлчилж байснаа дурсаж, нүүр хагарсны дараа мебелээ гуйвал “Манай прокурорын газар ч ялгаагүй төсвийнх. Мебель тавилга туслах боломж байхгүй. Ингэхэд чи мөнгөтэй ирсэн үү?” гэв. Би “Харьковын мэргэжил дээшлүүлэх курст суралцах хүмүүсийн байрны хөлсний 20-иод мянган рублээс өөр мөнгөгүй” гэвэл “Чи мөнгөтэй хүн байна. Тэр мөнгөөрөө мебель худалдаж аваад яв. Манайх та нараас байрны хөлс авахаа болъё. Ингээд тохирох уу?” гэдэг юм байна. Би ч ажлаа бүтээсэндээ баярлаж, Руденко прокурорт талархаад гарч билээ. Ингэж Улсын прокурорын газар маань шинэ байранд орж, шинэ мебель тавилгаар бүрэн тоноглож байлаа.

*Ж.Балжинням прокурорын дуртатгалаас*

# 1975

## ЦАХИЛГААН СТАНЦЫН ДЭЛБЭРЭЛТИЙН ШАЛТГААНЫГ ТОГТООВ

Жавар тачигнасан өвлийн хүйтэнд нийслэлийг дулаанаар хангадаг 3 дугаар цахилгаан станцад дэлбэрэлт болов. Улсын нийслэлд хөлдөх аюул нүүрлэлээ. Станцыг сэргээн босгох



Улсын комиссыг СнЗ-ийн орлогч дарга М.Пэлжээ толгойлж, дэлбэрэлтийн шалтгааныг тогтоох комиссыг БНМАУ-ын прокурорын орлогч Ж.Балжиннямаар удирдуулав. Станцынхан дэлбэрэлт болсон нь гадны шалтгаантай, өөрөөр хэлбэл гаднаас хэн нэгэн “хорлон сүйтгэгч” нэвтрэн орж дэлбэлсэн хэмээцгээжээ. Харин орлогч прокуророор удирдуулсан мөрдөн байцаагчид мэргэжлийн хүмүүсийн туслалцаа авч, шинжээчийн дүгнэлт зэрэг бүх баримт, нотолгоонд түшиглэн мэргэжлийн өндөр түвшинд дүгнэлт гаргажээ.

Дэлбэрэлтийн шалтгаан нь станцын түлш дамжуулах цехийн тоос зөвшөөрөгдсөн хэвийн хэмжээнээс олон дахин хэтэрч дэлбэрэх аюултай болсон үед хориглосон газарт гагнуур хийснээс болсныг дүгнэлтээр тогтоов. Энэ дагуу станцад хөдөлмөр хамгааллын дүрэм зөрчигдөж, хэд хэдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирсныг тогтоож, буруутай хүмүүст хариуцлага хүлээлгэв.

**2 сарын 3.** Булган аймгийн Эрдэнэт хороонд хэсгийн прокурорын газар нээв.

**2 сарын 28.** АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар анхны Хууль цаазын жинхэнэ зөвлөх цолыг БНМАУ-ын прокурор Ж.Авхиад олгов.

**3 сарын 15.** УЕП-ын 42 дугаар тушаалаар Эрдэнэт хороонд цэргийн прокурорын газар нээв.

**7 сарын 5.** Улсын прокурорын газар, Улсын дээд шүүхийн удирдах ба гүйцэтгэх ажилтнуудын мэргэжил мэдлэг дээшлүүлэх хоёр жилийн хугацаатай курсыг тус газруудын дэргэдэх намын үүрүүдийг түшиглэн байгуулж, сард 2 удаа хичээллүүлэхийг Боловсон хүчний тасгийн эрхлэгч З.Ширчин, Батхүү нарт хариуцуулжээ.

**12 сарын 11.** Эрдэнэт хороог хот болгон өргөтгөх зарлиг гаргав.

-Улсын прокурорын тушаалаар прокурор, мөрдөн байцаагч нар аттестат бичихэд мөрдөх заавар, журмыг гаргав.

-Октябрийн районы прокуророор Н.Буниа, Сэлэнгэ аймгийн прокуророор С.Чулуунбаатар нар томилогдов.

# 1975

## ЭРДЭНЭТ ХОРОО ХОТ БОЛОВ

Эрдэнэтийн уурхай, уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийг ашиглалтад оруулах бүтээн байгуулалт 1973-1981 оны хооронд үргэлжилсэн. Улс орны өнцөг булан бүрээс залуучууд Эрдэнэтийг зорьж, бүтээн байгуулалтад олноороо гар бие оролцсон тул 1975 оны 2 дугаар сард хороо болгон өөрчлөн байгуулжээ.

Удалгүй 10 сарын дараа орон нутгийн захиргааны нэгжийг хот болгон өргөтгөх зарлигийг АИХ-ын Тэргүүлэгчид гаргасан байна. Эрдэнэт хорооны прокурорын газар анх прокурор, мөрдөн байцаагч, нарийн бичгийн дарга гэсэн орон тоотой батлагдаж хэсгийн прокуророор М.Найдан, мөрдөн байцаагчаар Д.Батсайхан нар томилогдон ажиллажээ. Эрдэнэт хорооны хэсгийн прокурорын газрыг хотын прокурорын газар болгох бэлтгэл ажил он солигдохтой зэрэгцэн эхлэв.




## НУМАНДОРЖИЙН БУНИА



Н.Буниа Ховд аймгийн Манхан суманд 1937 онд төржээ. Тэрбээр 1960-1965 онд Хууль цаазын дунд сургууль, 1967-1972 онд МУИС-ийн Хуулийн ангийг төгсөж, 1965 оноос Сүхбаатар дүүргийн прокурорын газарт үйлчлэгч, Нарийн бичгийн дарга, 1972 оноос тус дүүргийн прокурорын газарт хяналтын прокурор, 1975-1991 онд Октябрийн районы прокурор, 1991-1996 оны хооронд Баянгол дүүргийн Ерөнхий прокурор, 1996 оноос Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокуророор ажиллажээ.

Н.Буниа өндөр насны тэтгэвэрт гарсан хойно ч 2006-2016 онд Нийслэл, дүүргийн прокуроруудын ахмадын хороог тэргүүлэн ажиллаж байв.

# 1976

4 сарын 8. Эрдэнэт хорооны хэсгийн прокурорын газрыг Эрдэнэт хотын прокурорын газар болгон өргөжүүлж, үйл ажиллагааг нь эхлүүлэв.

11 сарын 29. БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 253 дугаар зарлигаар Прокурорын хяналтын хуулийг 6 бүлэг, 65 зүйлтэйгээр анх баталжээ.

-С.Пүрэв Эрдэнэт хотын прокуророор, Д.Чулуун Завхан, Т.Ядмаа Өмнөговь аймгийн прокуророор тус тус томилогдов.

-БНАрдчилсан Герман Улсын Ерөнхий прокурорын орлогч, генерал Альфред Лайбнер тэргүүтэй төлөөлөгчид БНМАУ-д айлчлав.

## Ю.ЦЭДЭНБАЛ: “ПРОКУРОР АЧ ТУСТАЙ АЖИЛ ХИЙЖЭЭ”

МАХН-ын Төв хорооны 1 дүгээр нарийн бичгийн дарга, АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга Ю.Цэдэнбал 1976 онд хуралдсан намын 17 дугаар Их хуралд тавьсан тайлан илтгэлдээ “Хууль ёс зөрчигчидтэй тэмцэх талаар прокурор, цагдан сэргийлэх, шүүхийн байгууллага нийгэм, ард иргэдийн эрх ашгийг хамгаалсан их ач тустай ажил хийжээ” хэмээн хуулийн болон прокурорын байгууллагын ажлыг үнэлжээ.

1976 онд прокурорын байгууллагын хяналтын үйл ажиллагааны дүрмийг хууль болгон шинэчлэн боловсруулж, төрийн эрх барих дээд байгууллага АИХ-ын чуулганаар батлуулав. Прокурорын хяналтын шинэ хууль нь ЗХУ-ын яг ийм хуулиас өмнө батлагдсан тул манай хуулийн зарим шинэлэг санаанууд Зөвлөлтийн хуулинд тусгагдсан тухай БНМАУ-ын прокуророор ажиллаж байсан Ж.Авхиа хожим өгүүлсэн байдаг. Прокурорын хяналтын хуулинд тусгасан шинэ зүйлүүдийн дотор хуулийг улс орон даяар хүн бүр нэг бүрчлэн биелүүлэх, хууль зөрчсөн гэм буруутай этгээдэд хуульд заасан арга хэмжээ авах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалах, хохирсон эрхийг сэргээх, прокурор, мөрдөн байцаагч нар, прокурорын байгууллагын ажилтнууд албан тушаалын зэрэгт тохирсон цол, формын хувцас хэрэглэх, нэмэгдэл цалин авах зэрэг шинэ заалтууд орсон юм.

## ХАМРАХГҮЙ ШАЛГАЛТ ХОВОР

Тэр үед орон нутагт ажил үүрэг гүйцэтгэж байсан хэсгийн прокуроруудын өдөр тутмын ажил хэргийн талаар 32 жил тасралтгүй прокуророор ажилласан Норовжийн Тэрбиш “Миний бие 1976 онд МУИС-ийн хуулийн ангийг төгсч, Хөвсгөл аймгийн прокурорын газарт хэсгийн прокуророор томилогдсон. Намайг томилогдоход тус аймгийн прокурорын газарт их дээд сургууль төгссөн эмэгтэй прокурор байгаагүй. Би Галт, Жаргал, Шинэ-Идэр, Төмөрбулаг, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр сумдыг хариуцан хэсгийн прокуророор ажиллаж, голлон прокурорын

# 1976

ерөнхий хяналтын ажил хийдэг байв. Тухайлбал өвөлжөө, хаваржааны хашаа, худаг ашиглалт, хамгаалалт, малын зүй бусын хорогдол, эмчилгээ тэжээлийн цэгийн ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, сахилга хариуцлага, ер нь хийхгүй шалгалт гэж байгаагүй. Хэсгийн шүүгч, хэсгийн төлөөлөгчийн ажлыг шалгах, суманд гарсан эрүүгийн болон иргэний хэргүүдэд төрийг төлөөлөн оролцох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор харуул манааны хариуцлага шалгах, хууль сурталчлах үдэшлэг, өдөрлөг зохион байгуулах, гэмт хэрэгт орж болзошгүй хүмүүстэй ганцаарчилж уулзах гээд нэг суманд явахдаа хийсэн байх ёстой бүх ажлаа амжуулж аваад дараагийн сум руугаа ГАЗ-53 машины тэвшинд суугаад явдаг байлаа” хэмээн дурсчээ.

## ХЭСГИЙН ПРОКУРОР ХОТЫНХ БОЛОВ

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар Эрдэнэтийг улсын зэрэгтэй хот болгосонтой холбогдуулан хэсгийн прокурорыг Булган аймгийн прокурорын газрын харьяанаас гаргаж, хотын прокурор болгон өргөтгөх бэлтгэл ажил дөрвөн сарын турш үргэлжилж 4 дүгээр сарын 8-наас Эрдэнэт хотын прокурорын газар үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Тус прокурорын газрыг прокурор 1, орлогч прокурор 1, туслах прокурор 2, хэсгийн прокурор 1, чухал хэргийн мөрдөн байцаагч 1, нарийн бичгийн дарга, бичээч, цэвэрлэгч гэсэн орон тоотой баталжээ.



Зөвлөлт Украины нийслэл Киев хот дахь Богдан Хмельницкийн хөшөөний дэргэд манай прокурорын байгууллагын төлөөлөгчид

# 1976

## СУРАГЧДАД ХУУЛЬ СУРТАЛЧЛАВ

Улаанбаатар хотын прокурорын газар хүүхэд залуучуудад хууль сурталчлах булан самбар, үзүүлэн диаграмм, хууль эрхийн холбогдолтой ном, лавлах материалын кабинет зэргийг байгуулж, нийслэлийн ерөнхий боловсролын болон ТМС-ийн сурагчдыг хамруулан хууль сурталчилж байв. Үр дүнд нь нийслэл хотод гэмт хэрэггүй байгууллага, хамт олон болох хөдөлгөөн өрнөсөн юм.



## ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСТЭЙ СУДАЛГАА ЧУХАЛ

МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны “Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 24 дүгээр тогтоолд “Социалист хууль ёсыг хэлбэрэлтгүй биелүүлж, хөдөлмөрчдийн эрх ашгийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг улам хүчтэй болгох талаар тавьсан зорилтыг хуулийн нийт байгууллагаас хэрэгжүүлэн биелүүлэхэд шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулагдсан тоо бүртгэл, мэдээ, судалгаа чухал ач холбогдолтой юм” гэж заажээ.

## ЛЭГЦЭГИЙН ЯДМАА



Л.Ядмаа Ховд аймгийн Мөст сумын нутагт 1925 онд төржээ.

Тэрбээр 1961 онд Хууль цаазын дунд сургууль, 1970 онд МУИС-ийн хуулийн ангийг төгсөж, ЗХУ, Герман улсад мэргэжил дээшлүүлжээ.

Л.Ядмаа 1945-1949 онд Баруун хязгаарын Байтаг богдын 6 дугаар морьт хороонд тасгийн дарга, радист, штабын бичээч, 1949-1954 онд Ховд аймгийн шүүхэд тогтоол гүйцэтгэгч, нарийн бичгийн дарга, хэсгийн шүүхийн дарга, 1954-1962 онд прокурорын мөрдөн байцаагч, хэсгийн прокурор, туслах прокурор, 1962-1964 онд Улаанбаатар хотын прокурорын газрын мөрдөн байцаах хэлтсийн дарга, 1964-1966 онд НАХЯ-нд ахлах мөрдөн байцаагч, 1966-1974 онд Ховд аймгийн прокурор, 1974-1976 онд Завхан аймгийн прокурор, 1976-1989 онд Улсын прокурорын газрын боловсон хүчний хэлтсийн даргаар ажиллажээ. Л.Ядмаа нь тухайн цаг үедээ Улсын прокурорын газрын боловсон хүчний бодлогын хүрээнд эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэлтэй, хүнийг зөв тавьж, үнэлж дүгнэдэг байснаар нь “Боловсон хүчний Ядмаа” гэж хамт олондоо нэрлэгджээ.

# 1977

**11 сарын 24.** Мөрдөн байцаах ажилтны улсын III зөвлөгөөн хийв.

-МАХН-ын Төв хорооноос прокурорын байгууллагыг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, мөрдөн байцаах ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах тухай 345 дугаар тогтоол гаргав.

-Эрүүгийн хэргийн 83.1 хувьд улсын яллагчаар, иргэний хэргийн 49.3 хувьд прокурор оролцож 592 удаа иргэний нэхэмжлэл гаргасан нь өмнөх 10 жилээс 11.4 дахин өссөн байна.

-Мабушкийн Бадрах, Дуламжавын Очирхуяг нарыг Гавьяат хуульч цолоор шагнав.

-Болгарын Ерөнхий прокурор Иван Вачков, Унгарын Дээд прокурор Сиярто Карой тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.

-С.Мишигдорж Дундговь аймгийн прокуророор томилогдов.

## Ю.ЦЭДЭНБАЛ ДАРГААС ЗӨВЛӨЛТӨД СУРГАХ ЗӨВШӨӨРӨЛ АВАВ

МАХН-ын Төв хорооны 345 дугаар тогтоол прокурор төдийгүй хуулийн байгууллагын ирээдүйд өндөр ач холбогдолтой байжээ.



Зөвлөлт Украины Харьков хотноо суралцагч прокурорууд

Намын Төв хорооны энэхүү тогтоолд 1977 оноос эхлэн Улсын прокурорын байгууллагын нэр дээр ЗХУ-д жил бүр 10 хүн явуулж сургах болжээ. Мөн тогтоолоор МУИС-ийн дэргэд 25 хүний бүрэлдэхүүнтэй мөрдөн байцаах ажилтан бэлтгэх анги нээж, прокурорын байгууллагад техник хэрэгсэл худалдаж авахад зориулж 300 мянган төгрөг улсаас олгожээ.

Энэ тухай Ж.Авхиа “Урьд нь жил бүр прокурорын байгууллагын нэр дээр хоёр хүүхэд Зөвлөлтөд явуулж сургадаг байв. Гэтэл Улсын төлөвлөгөөний комиссын дарга Рэнчинпэлжээ “Мөнгө төгрөгийн хүрэлцээ муу” гээд бүр хасчихав. Би Ю.Цэдэнбал даргад энэ байдлыг танилцуулаад, Улсын прокурор, Дээд шүүх, Шүүх яам тус бүр жилд 10 хүн, нийт 30 хүнийг Зөвлөлтөд сургах зөвшөөрлийг анх гаргуулсан. Энэ тогтоол хэрэгжин ЗХУ-д хуулийн дээд мэргэжил эзэмшсэн Н.Цэрэндорж, Н.Ганбаяр, С.Лувсанжав, Д.Батсайхан, Намсрайжав, Ц.Нямдорж, Л.Цог, Д.Одсүрэн, Ц.Оюунбаатар нарын тэргүүний хуульчид прокурорт ажилласан” хэмээжээ.

# 1977

## БНМАУ-ЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ ДУЛАМЖАВЫН ОЧИРХУЯГ



Д.Очирхуяг Дорнод аймгийн Матад суманд 1918 онд төржээ. Тэрбээр 1954 онд хуулийн 1 жилийн курс, 1961 онд Марксизм-Ленинизмийн оройн дээд сургууль төгсчээ.

Д.Очирхуяг 1937-1940 онд цэргийн алба хааж, 1940-1941 онд Матад сумын нарийн бичгийн дарга, 1941 оноос прокурорын байгууллагад мөрдөн байцаагч, туслах прокурор, Дорнод, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн прокуророор 30 шахам жил тасралтгүй ажиллаж олон арван шинэ залуу боловсон хүчнийг прокурорын ажилд дадлагажуулан сургасан нэр хүндтэй, чадварлаг зохион байгуулагч, удирдах ажилтан байв.

Түүний зүтгэлийг төрөөс үнэлж БНМАУ-ын Гавьяат хуульч цолоор шагнажээ.

## “Д.ОЧИРХУЯГ ПРОКУРОР ӨВӨРМӨЦ АРГАТАЙ ХҮН”

Монгол Улсын гавьяат хуульч Д.Очирхуяг хүнийг ажилд сургах өвөрмөц аргатай хүн байлаа. Нэг удаа Зүүнхараа хотод ажиллаад ирэхдээ надад 20 хэрэг авчирч өгөөд “Чи үүнийг уншаад танилцуул” гэв. Би бүгдийг уншаад 13 хэрэгт эсэргүүцэл бичиж, 7 хэргийг хэвээр үлдээх санал тавьтал Д.Очирхуяг гуай аль эрт уншаад дүгнэлтээ биччихээд намайг хэр зэрэг хэрэг хянадаг, хууль мэддэг, үүргээ гүйцэтгэж чадах хүн бэ? гэдгийг сорьж даалгавар өгсөн байж билээ. Санал зөрсөн 7 хэрэг дээр эсэргүүцэл бичих шалтгааныг надад тайлбарлахад “Мөн ч өдий байна даа” гэж өөрийгөө голж байв. Энэ хүний дэргэд таван жил ажиллаад их зүйл сурсан. Өөрийнхөө биеийг хэзээ ч түрүүнд тавьдаггүй тийм тэсвэр тэвчээртэй, ажилсаг хүн байсан нь одоо ч тодхон санагдаж байна.

*Прокурор М.Гомбосүрэнгийн дурдатгалаас*

## М.БАДРАХ: “ЭЗЭН НЬ ИЛРЭЭГҮЙ ХЭРЭГ БАЙХГҮЙ БОЛСОН”

1950-иад онд мөрдөн байцаагчид эрүүгийн хэрэг үүсгэсэн хэрэг нэг бүрийг 1 сарын хугацаанд шийддэг байсан. Сарын хугацаанд эцэслэх боломжгүй хэргүүдэд аймгийн прокурор 15 хоногийн хугацаа нэмж өгөх эрхтэй байсан юм. Ажлын төлөө бие сэтгэлээ бүрэн зориулж их л эрчимтэй ажиллаж байснаа одоо эргэж санахад залуу насны эрч хүч байжээ гэж бодогддог. Хагас, бүтэн жилээр мөрдсөн хэрэг, шалгаж барагдуулсан материалаар нь байр эзлүүлэн ажлаа дүгнүүлж, мөрдөн байцаагчдын улсын

# 1977

## БНМАУ-ЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ МАБУШКИЙН БАДРАХ



М.Бадрах Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр суманд 1928 онд төржээ. Тэрбээр Хууль цаазын дунд, дээд сургууль, ЗХУ-д мөрдөн байцаах ажилтны дээд курс, прокурорын удирдах ажилтны курс төгссөн байна.

М.Бадрах 1948-1949 онд Хөвсгөл аймгийн Хатгал дахь 4 дүгээр хэсгийн шүүхэд нарийн бичгийн дарга, 1949-1952 онд Цэргийн шүүхэд нарийн бичгийн дарга, 1952-1953 онд Шүүх яаманд нарийн бичгийн дарга, 1953-1972 онд Хөвсгөл аймгийн прокурорын газарт мөрдөн байцаалт эрхэлсэн туслах прокурор, 1972-1979 онд аймгийн прокурор, 1979-1989 онд Улаанбаатар хотын прокурорын газарт хяналтын прокурор, хэлтсийн даргын алба тус тус хашжээ.

Түүнд 1977 онд БНМАУ-ын Гавьяат хуульч цол олгожээ.

3 удаагийн зөвлөгөөнд шалгаран оролцож байв. 1970-аад онд Хөвсгөл аймгийн хэмжээнд гарсан хулгайн хэргийн газрын үзлэгт прокуроруудыг оролцуулж хяналт тавихын зэрэгцээ мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажлыг цагдаагийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж байсны үр дүнд тус аймагт орон байрны хулгайн хэргийн илрүүлэлт эрс сайжирч эзэн нь илрээгүй хэрэг 1972-1979 онд бараг байхгүй болсон билээ.

*Гавьяат хуульч М.Бадрахын дурдатгалаас*

## УЛСЫН ХЭМЖЭЭНД САЙШААГДАВ

Мөрдөн байцаах ажилтны улсын III зөвлөгөөн дээр МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга С.Жалан-Аажав мөрдөн байцаалтын ажилд улс төрийн талаар дүгнэлт, мэргэжлийн нарийн шинжилгээ хийж дутагдлын шалтгааныг илрүүлэн түүнийг засаж арилгах арга замыг заахдаа “Дорнод аймгийн прокурорын мөрдөн байцаагч Эрдэнэбаатар, Төв аймгийн прокурорын мөрдөн байцаагч Гандаръяа... нарын зэрэг ажил мэргэжил дээрээ өсч амжилт бүтээл гаргаж байгаа мөрдөн байцаагчид, Төв аймгийн прокурор БНМАУ-ын гавьяат хуульч О.Лхамсүрэн, туслах прокурор О.Дорж, Дорнод аймгийн прокурор Даваасүрэн, Сүхбаатар аймгийн прокурор Жалбасүрэн... нарын зэрэг манай арвин их туршлагатай, ажлын арга барил сайнтай ахмад, удирдах ажилтнуудынхаа ажлын бүтээл алдар нэрийг энд гарган тэмдэглэхэд таатай байна.

# 1977

Төв аймгийн прокурорын туслах прокурор О.Дорж эрхэлсэн ажилдаа нарийн бүртгэл тооцоотой ажиллаж прокурор, сэргийлэхийн мөрдөн байцаалтын ажилд тавих хяналтыг хүрэлцээтэй явуулахын тулд ажлаа тодорхой мэдэж, төлөвлөн, өдөр тутам мэргэжлийн удирдлага, туслалцаатайгаар сайн хангаж мөрдөн байцаагчдын хүрээлэлийг татаж ажилладаг учраас хяналтын ажил нь үр дүнд хүрдэг байна" хэмээн онцлон тэмдэглэжээ.






Болгарын Ерөнхий прокурор Иван Вачков тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.



Унгарын Дээд прокурор Сиярто Карой тэргүүтэй төлөөлөгчид Монголд айлчлав.

# 1978

4 сарын 18. БНМАУ-ын прокурор А.Авхиаг Батлан хамгаалах яамны Нэгдүгээр орлогч сайдаар томилов.

12 сарын 26. БНМАУ-ын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж БНМАУ-ын прокурор хууль санаачлах эрхтэй болов.

-Дээд шүүхийн дарга Р.Гүнсэнг БНМАУ-ын прокуророор томилов.

-Улсын Ерөнхий прокурорын Нэгдүгээр орлогч Г.Иш Дээд шүүхийн даргаар томилогдов.

-Ж.Балжиннямыг БНМАУ-ын прокурорын орлогч бөгөөд Цэргийн Ерөнхий прокуророор томилов.

-Л.Адъяа Ажилчны районы прокуророор томилогдов.

-Улсын прокурорын газрын дэргэд Халамжлан хүмүүжүүлэх зөвлөл байгуулж даргаар нь М.Дүнчинсүрэнг томилов.

-Нийт прокурор, мөрдөн байцаагчдын 98,4 хувь нь хуулийн дээд, дунд боловсролтой болсон тухай дүн мэдээ гарчээ.

-ЗХУ-д хуулийн байгууллагын нэр дээр 38 хуульч сургав.

## Ю.ЦЭДЭНБАЛ: “АВХИА ЧИ БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ САЙДААР ОЧ”

БНМАУ-ын ерөнхий прокуророор 1960-1969 онд ажиллаж байсан Д.Ёндондүйчир Армийн улс төрийн газрын даргаар томилогдож байсан бол 1969-1978 онд БНМАУ-ын Ерөнхий прокуророор ажилласан Ж.Авхиа мөн л улсыг



батлан хамгаалах үйлсэд хүчин зүтгэх болов. Энэ тухай Ж.Авхиа “...Ю.Цэдэнбал дарга “Авхиа чи Батлан хамгаалах яамны сайдаар оч. Тэнд өргөтгөсөн зохион байгуулалт хийнэ. Цэрэг, армийн сахилга, зохион байгуулалт сайн биш байна” гэв.

Энэ үгийг сонсоод би нэлээд сандарч, “Дарга таны энэ хүндэтгэлтэй даалгаврыг биелүүлэх бололцоо надад бага байна. Учир нь, миний нас 50 гарсан, цэрэг армийн ажил амьдралаас хөндийрөөд удлаа. Би хилийн цэрэгт армийн генерал Б.Доржийн гараар хүмүүжиж өдий зэрэгт хүрсэн. Надад түүний ажлыг авахад хүнд байна, би сурсан дассан ажлаа л хийе” гэв. Дарга миний тайлбарыг сонсоод “Доржийг АИХ-ын Тэргүүлэгчдийн дэргэдэх ахмадын хорооны дарга болгоно. Цалин хангамжийг нь хэвээр байлгана. Улс төр, ажлын чадварын хувьд чи тохирох хүн. Тийм учраас чамд нэг үгээр хэлэхэд ажил сайжруул гэж даалгаж байна. Маргааш Улс төрийн товчооны хуралтай,

битгий татгалзаарай” хэмээгээд яриагаа өндөрлөв. Маргааш нь буюу 1978 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны хурлаар “Авхиаг Улсын Ерөнхий прокурорын үүрэгт ажлаас чөлөөлж, Батлан хамгаалах яамны Нэгдүгээр орлогч сайдаар баталъя” (намар нь БХЯ-ны сайдаар томилсон) гэсэн санал гарахад, би мөн л даргад хэлсэн шалтгаанаа тоочсон боловч хүлээж авсангүй”.

*БНМАУ-ын прокурор Ж.Авхиагийн дурдатгалаас*

## УЛСЫН ПРОКУРОРТ ЧИ ОРЛОГЧООР САЙН АЖИЛЛАСАН...

Улсын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хамгаалах асуудлыг гол зохицуулагч нь прокурорын байгууллага болоод байв. Тус байгууллагын нүүр царай, нэр хүнд ийнхүү хуулийн байгууллагууд дундаа төдийгүй ерөнхий хяналтын ажлаараа улсын бүхий л байгууллагуудад толгой цохиж, хүлээн зөвшөөрөгдсөн үед удирдах аппаратад нь томоохон өөрчлөлт орсон юм. Улсын прокурор батлан хамгаалах руу томилогдсон бол орлогч нь ч бас улсын онц хариуцлагатай салбарыг тэргүүлэх боллоо. Тэр үеийн нөхцөл байдлын тухай Ш.Сүхбаатарын “Төрийн тэргүүн шүүгч Гончигийн Иш” номонд “...Улс төрийн товчооны гишүүн, Төв хорооны нарийн бичгийн дарга С.Жалан-Аажав гаднаас орж ирснээ “Иш прокурор таныг Ю.Цэдэнбал дарга дуудуулсан, одоо

# 1978

## БНМАУ-ЫН ПРОКУРОР РАВДАНГИЙН ГҮНСЭН



БНМАУ-ын прокуророор 1978-1982 онд ажилласан Р.Гүнсэн Увс аймгийн Түргэн суманд 1923 онд төржээ. Тэрбээр 1947-1949 онд Намын боловсон хүчний дээд сургууль, 1949-1952 онд Улсын багшийн институт, 1956-1960 онд ЗХУ-ын АХХ-ны дээд сургууль, 1963-1965 онд ЗХУ-ын ДЯЯ-ны дээд сургуулийн аспирантурт тус тус суралцан төгсөж Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж, профессор цол хүртжээ.

Р.Гүнсэн 1947-1952 онд УЦСГ-ын орлогч дарга, дарга, 1952-1954 онд ДЯЯ-ны Дорноговь дахь хэлтсийн дарга, 1960-1961 онд УЦСГ-ын орлогч дарга, 1961-1963 онд НАХЯ-ны Нэгдүгээр орлогч сайд бөгөөд УЦСЕГ-ын дарга, 1963-1970 онд НАХЯ-ны Нэгдүгээр орлогч сайд бөгөөд УАХЕГ-ын дарга, 1970-1978 онд Улсын дээд Шүүхийн дарга, 1978-1982 онд Улсын прокурор, 1982-1985 онд БНМАУ-аас БНСВУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, 1985-1986 онд НАХЯ-ны Цагдаагийн дээд сургуулийн захирлаар ажиллаж байв. Түүнд төрөөс хууль цаазын жинхэнэ зөвлөх, хошууч генерал цолыг тус тус олгожээ.

# 1978

орно” гэжээ. Даргын өрөөнд хамт орж урт ширээний өнцөг хавьд суувал, “ийшээ суу” гээд даргын албархуу яриа эхэлж. Тэр хоёрын хооронд ийм яриа болсон аж.

Ю.Цэдэнбал: Иш ээ, чи Улсын Дээд шүүхийн дарга бол, маргааш Улс төрийн товчооны хуралд оруулна.

-Г.Иш: Дарга аа, би дасч дадсан прокурорын ажлаа л хийе.

Ю.Цэдэнбал: Улсын прокурорт чи орлогчоор олон жил сайн ажилласан. Одоо нэг байгууллага бие даан аваад явахад бүрэн бэлтгэгдсэн. Шүүх, прокурор, сэргийлэх гээд хуулийн байгууллагуудыг СнЗ-д байхаасаа сайн зангидаж ажилласан. Чи Ленинград хотын Улсын их сургууль төгссөн хүн. Одоо шүүхэд оч. Ер нь бид нэлээд нуруутай, эрдэм номтой, тулхтай шүүхийн даргатай болох гэж бодсон юм. Чи чадна. Энүүхэндээ гэхэд Авхиагийн оронд Гүнсэн ирнэ. Гүнсэнгийн оронд чамайг тавина” хэмээн яриа өндөрлөжээ.

Энэ тухай сонссон Ж.Авхиа прокурор “Бид прокурортоо олон жил ажиллалаа, одоо хөдлөх цаг нь болсон байх, чи шүүхийг аваад явчихна” хэмээжээ.

## “СЭТГЭЛ ЗҮЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ТАЛААР ЗӨВЛӨМЖ ӨГӨӨЧ...”

Прокурор хүн олон төрлийн мэргэжлийн мэдэгдэхүүнтэй байх шаардлагатай байдаг. 1978 онд Ажилчны районы прокуророор томилогдсоны дараахан районы хүүхдийн эмнэлгээс эмч сувилагчдын хариуцлагын талаар яриа хийж өгнө үү гэж урив. Яриагаа эмч ажилчдын эмчилгээний үндсэн үүргийн талаар сэдэв үүсгэн эмч, сувилагчид хүнийг эмчлэхдээ эм зүй, мэс зүй, сэтгэлзүйн гурван хэлбэрээр эмчлэх ёстой юм билээ гэж яриагаа эхлээд түүнийгээ өөрийн ойлгоцын хэрээр задалж тайлбарлав. Хүмүүс анхааралтай сонсож асуулт ч нэлээн гаргав. Маргааш нь нэг эмч ирж талархал илэрхийлээд “Та сэтгэлзүйн эмчилгээнийхээ талаар зөвлөмж өгөөч” хэмээн хүсэхэд би их урам авч байж билээ.

*Прокурор Л.Адьяагийн дурдатгалаас*

## ИРЭЭДҮЙН УЛСЫН ПРОКУРОРУУД ХААНА ЯВАВ

БНМАУ-ын прокурор Ж.Авхиа Батлан хамгаалах яамны сайдаар томилогдож, Р.Гүнсэн БНМАУ-ын прокуророор томилогдож байх энэхүү түүхэн онд манай улсын ирээдүйн прокурорууд хуулийн байгууллагад ажил, хөдөлмөрийн гараагаа эхлүүлж байсан сонирхолтой давхцал байдаг аж. 1990-2010 онд Улсын прокуророор ажиллаж байсан гурван прокурор буюу Г.Бахдал Улсын Ерөнхий прокурорын газарт чухал хэргийн мөрдөн байцаагчаар 24 настай, Н.Ганбаяр Улсын Дээд шүүхийн гишүүнээр 25 настай, М.Алтанхуяг Дорноговь аймгийн шүүхийн шүүгчийн ажлаа 23 настайдаа тус тус эхлүүлж байжээ.

## ЗӨВЛӨЛТИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДЭЭС НОМЫН ДУУ СОНСОВ

ЗХУ-ын Ерөнхий прокурорын газар, түүний эрдэм шинжилгээний хүрээлэнтэй тогтоосон ажил хэрэгч харилцаа холбоогоо БНМАУ-ын прокурорын байгууллага улам өргөтгөж ЗХУ-ын хуулийн салбарын нэрт эрдэмтэн Н.И.Загародников, А.Н.Игнатов, В.К.Звирбуль, К.Ф.Скворцов, ЗХУ-ын прокурорын орлогч А.С.Панкратов нарыг

# 1978

урьж ирүүлэн, “Прокурорын хяналтын арга барилыг боловсронгуй болгох нь” асуудлаар онол, практикийн бага хурал зохион байгуулж, сурах бичиг хамтран гаргах талаар ярилцаж, туршлага солилцжээ. ЗХУ-ын Ерөнхий прокурорын дэргэдэх эрдэм шинжилгээний хүрээлэнгээс В.Б.Ястребов, Г.В.Дашков, В.П.Рябцев, Махов нарыг БНМАУ-ын прокурорын байгууллагын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах хүрээлэнд зөвлөх мэргэжилтнээр урьж ирүүлэн ажиллуулах болсон байна.

## ГОНЧИГИЙН ИШ



Г.Иш Увс аймгийн Малчин суманд 1923 онд төржээ.

Тэрбээр монгол бичиг гэрээр заалгаж тайлагдан, улмаар 1957-1962 онд Ленинград хотын Улсын их сургууль төгсчээ.

Г.Иш 1939-1940 онд Малчин суманд бичээч, бичиг үсгийн багш, 1940-1943 онд цэргийн албанд татагдаж нисэх дивизийн штабын бичээч, 1947-1951 онд Увс аймгийн прокурорт нарийн бичгийн дарга, мөрдөн байцаагч, 1954-1955 онд Увс аймгийн прокурор, 1955-1956 онд Улсын прокурорын газарт хэлтсийн прокурор, 1956-1957 онд СнЗ-ийн Хэрэг эрхлэх газарт зөвлөх, 1962-1969 онд МАХН-ын Төв хороонд зааварлагч, 1969 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс 1978 онд БНМАУ-ын прокурорын нэгдүгээр орлогч, 1978-1982 онд Дээд шүүхийн даргаар ажиллажээ.

## БЭГЗИЙН ДАВААСАМБУУ



Б.Даваасамбуу Завхан аймгийн Баянтэс сумын нутагт 1928 онд төржээ.

Тэрбээр 1962-1966 онд ЗХУ-ын Нийгмийн хэв журам хамгаалах яамны дээд сургууль төгсчээ.

Б.Даваасамбуу 1945-1947 онд Хүн эмнэлгийн техникумын багш, ЭХЯ-ны боловсон хүчний байцаагч, 1950-1954 онд Дорнод аймгийн Баянтүмэн дэх 5 дугаар морьт дивизийн дэргэдэх тусгай тасагт төлөөлөгчөөр ажиллаж байгаад цагдаагийн байгууллагад шилжин 1954-1962 онд Дорнод аймгийн цагдан сэргийлэх ангид өмчийн төлөөлөгч, УЦСЕГ-ын мөрдөн байцаах хэлтэст мөрдөн байцаагч, ахлах мөрдөн байцаагч, хэлтсийн дарга, 1966-1976 онд УЦСЕГ-ын мөрдөн байцаах газарт хэлтсийн дарга, газрын дарга, 1976- 1978 онд УЦСЕГ-ын нэгдүгээр орлогч дарга, 1978 онд Улсын прокурорын газарт шилжиж 1989 оныг хүртэл Улсын прокурорын мөрдөн байцаалт эрхэлсэн орлогч, мөн орлогч бөгөөд цэргийн Ерөнхий прокурор, зөвлөх прокуророор ажиллаж байв.

Б.Даваасамбууд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1976 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн 158 дугаар тогтоолоор хошууч генерал цол хүртээсэн бөгөөд 1978 онд “Төрийн хууль цаазны зөвлөх” цол олгожээ.

# 1979

2 сарын 2. АИХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд Улсын прокурор Р.Гүнсэн прокурорын байгууллагын ажлын талаар илтгэл тавив.

2 сарын 9. Аймаг, хотуудын шүүх хяналт эрхэлсэн туслах прокуроруудын зөвлөгөөн болжээ.

3 сарын 12. МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөний 137 дугаар тогтоолоор БНМАУ-ын прокурорын байгууллагын 50 жилийн ойг 1980 оны хоёрдугаар хагаст тэмдэглэхийг зөвшөөрч, төсөв хөрөнгийг баталжээ.

4 сарын 25. Төв, орон нутгийн прокурорын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн болов.

## ПРОКУРОРЫН АЖЛЫГ ДЭМЖИХИЙГ ХҮСЭВ

БНМАУ-ын прокурорын ажлыг хүлээж авсныхаа дараа жил Р.Гүнсэн удирдлагын хувьд олон чухал ажил хийж гүйцэтгэсний дотор хариуцлага, сахилга батыг дээшлүүлэхтэй холбоотой асуудалд ихээхэн анхаарч байжээ. Жишээ дурдвал, Баянхонгор, Төв, Архангай аймгуудын Намын хороо, аймгийн Ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны дарга нарт прокурорын байгууллагын ажлыг дэмжих, тухайн аймгуудад шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар тодорхой ажил зохиолгох тухай албан захидлуудыг хүргүүлсэн нь архивын баримтад үлджээ.

## ПРОКУРОРЫН 1098 ЭСЭРГҮҮЦЛЭЭР АРГА ХЭМЖЭЭ АВАХУУЛАВ

1960 оны Үндсэн хуулиар прокурорын байгууллагын эрх үүрэг, түүний дотор ерөнхий хяналтын тухай зааж өгснөөр 1960-1979 он хүртэл Ерөнхий хяналт нь прокурорын байгууллагын хамгийн том хяналтын хэлтэс байж, улс даяар хууль тогтоомжийн биелэлтийг шалгадаг байв. Зөвхөн 1979 онд Ерөнхий хяналтаар хууль тогтоомжийн биелэлт ямар байгаа тухай 2551 байгууллагад шалгаж, 237,2 мянган эрхийн акт хянан, 11025 зөрчил илрүүлжээ. Эдгээр зөрчлийг засуулахаар прокурорын 1098 эсэргүүцлээр нам, олон нийтийн захиргаанд сахилгын арга хэмжээ авахуулж, 44 хүнийг эрүүгийн хариуцлагад татан, 22.3 сая төгрөгийн хохирлыг улсад нөхөн төлүүлсэн тухай дүн мэдээ гарч байсан байна.

## ШААРДАГДАХ ТЕХНИК ХЭРЭГСЛЭЭР ХАНГАЖ, ЭЗЭМШҮҮЛЖ СУРГАХЫН ТУЛД...

Прокурорын байгууллагыг мөрдөн байцаалтын ажилд шаардагдах техник хэрэгслэлээр хангаж, эзэмшүүлж сургахын тулд хичээл зааж, дадлага хийлгэх, хяналтын ажилд холбогдолтой сэдвээр аргачлал зөвлөмж гаргаж өгөх,

# 1979



БНМАУ-ын прокурор Р.Гүнсэн Болгар улсын прокурор Иван Вачкогийн урилгаар тус улсад ажлын айлчлал хийв



БНМАУ-ын прокурор Р.Гүнсэн Улаанбаатар хотын прокурор Ж.Гомбодорж, Улсын прокурорын газрын Ерөнхий хяналтын хэлтсийн прокурор Н.Лувсанжав нар Болгар улсын прокуроруудтай, Софи хот 1979 он.

7 сард. С.Бүдрагчааг Улсын прокурорын Нэгдүгээр орлогч бөгөөд Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах хүрээлэнгийн захирал, “Социалист хууль ёс” сэтгүүлийн эрхлэгчээр хавсран томилов.

11 сарын 25. Зүүн аймгуудын мөрдөн байцаах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулав.

-Б.Чимэдийг Шүүх яамны сайдаар томилов.

-ЗХУ-д 40, МУИС-ийн мэргэжил дээшлүүлэх институдэд 25 ажилтныг 45-60 хоногийн хугацаатай сургалтад хамруулав.

-Д.Сэдээхүү Булган, Ц.Дамдинсүрэн Дундговь, Д.Цэндцэсэм Завхан, Д.Чулуун Өвөрхангай, Х.Равзан Увс, С.Мишигдорж Хөвсгөл аймагт тус тус аймгийн прокуророор томилогдов.

# 1979



БНМАУ-ын прокурор Р.Гүнсэн Болгар улсын Софи хотноо зохиогдсон социалист орнуудын Ерөнхий прокуроруудын уулзалтад

ажил нь хоцрогдож байгаа зарим газарт бие хүн явуулж туслалцуулах ажил зохиожээ. Хэдийгээр эхлэлтийн чанартай, бүрэн журамлагдаж чадаагүй ч хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагуудад эрүү үүсгэн шалгаж байгаа бүх хэргүүд, түүний хөдөлгөөнд картаар хяналт тавих, илрүүлсэн зөрчил дээр зөрчлийн бүртгэл карт хөтлөх, зэргээр хяналтын ажилд судалгаа тооцоотой хандах зорилт тавин ажиллаж байсан нь баримт болон үлджээ.

## МАНАЙД ГЭМТ ХЭРЭГ СОЦИАЛИСТ ОРНУУДААС ДООГУУР БАЙНА

Манай улсад 10,000 хүн ам тутмаас гарч байгаа гэмт хэрэг зарим социалист орнуудынхаас доогуур байгаа бөгөөд энэ нь манайд гэмт хэрэг харьцангуй бага гарч байна. Жишээ нь, 10000 хүн амаас БНПАУ-д 94,3, БНАГУ-д 78,3 хэрэг гарсан байхад манай улсад сүүлийн 10 жилийн дунджаар 30 хэрэг гарч байна.

1979 онд гарсан гэмт хэргийг 1978 оныхтой харьцуулахад нийт хэрэг 1,9 хувь, социалист өмчийг ашиглан шамшигдуулсан хэрэг 14,4 хувь, хүн амины хэрэг 6,2 хувь, хүчин 0,7 хувь, иргэдийн эрх чөлөөнд халдсан ба танхайрсан хэрэг 2,6 хувиар буурсан байна.

## ХЯНАЛТЫН АЖЛЫГ ЕРӨНХИЙГӨӨС ТОДОРХОЙД...

Мөрдөн хяналтын ажлыг ерөнхийгөөс тодорхойд шилжүүлж, өөрөөр хэлбэл прокурор, цагдан сэргийлэх байгууллагад мөрдөгдөж байгаа хэрэг нэг бүрт хүрэлцэж аль болохоор салалтгүй хяналт тавьж байх зорилгоор эрүү үүсгэсэн хэрэг нэг бүрт картаар хяналт тавьдаг шинэ журам тогтоон хэрэгжүүлжээ. Энэ онд Дорноговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Төв, Өвөрхангай, Дорнод аймаг, Улаанбаатар, Эрдэнэт хотын прокурорын газрын мөрдөн байцаалтын болон хяналтын

# 1979

ажлыг МАХН-ын Төв Хорооны 1969 оны 186 дугаар тогтоолын заалт, мөрдөн байцаах ажилтны улсын 3 дугаар зөвлөгөөний шийдвэрийг биелүүлэх, сахилга, хариуцлага, мэдлэг мэргэжлийн өсөлттэй холбон шалгаж, оршиж байгаа зөрчил дутагдлыг арилгуулахаар зааварлаж, шалгалтын дүнг тус тусын нь зөвлөгөөнөөр хэлэлцүүлжээ.

## БИЕТЭЙ БОДИТОЙ АЖЛУУД ХИЙЖЭЭ

Энэ онд прокурорын мөрдөн байцаалтын ажилд шаардлагатай техник хэрэгслэлээр хангах, хяналтын ажилд судалгаа тооцоотой хандахад онцлон анхаарчээ. Шинээр авсан техник хэрэгслэлээ прокуроруудад эзэмшүүлж сургах, хяналтын ажилд холбогдох сэдвээр аргачлал зөвлөмж гарган өгөх, ажлын хоцрогдолтой газарт бие хүнээр туслалцуулах зэргээр биетэй бодитой ажлууд хийжээ.

## “УЛСЫН ПРОКУРОРЫН АЖИЛ УДИРДЛАГААС ШАЛТГААЛНА”

Улсын прокурорын 1979 оны ажил дүгнэсэн зөвлөгөөн дээр БНМАУ-ын Прокурорын 1 дүгээр орлогч С.Бүдрагчаа хэлсэн үгэндээ “Та бидний ажилд дутагдал их байна. Дутагдлыг арилгаж ажил хэргийг өөдрөг, өнгө жавхаатай, үр дүнтэй болгон аппаратыг эрүүл саруул, эмх цэгц, зохион байгуулалттай байлгах, манай амьдрал үйл ажиллагаанаас сайныг дэлгэрүүлж, саарыг шахан зайлуулахад тус улсын прокурорын газрын удирдлага, улсын прокурорын орлогч Бүдрагчаа, Даваасамбуу ялангуяа хэлтэс, тасгийн дарга нар тухайлбал А.Ядмаа, Р.Сүхбаатар, Б.Янжмаа, Д.Гэндэндаржаа, Ц.Жалцав, Л.Ядмаа, С.Цэрэндорж, хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч С.Жамьян, Р.Цэвэг, Б.Эрдэнэбилэг нар шийдэх гол хүмүүс гэдгийг зориуд тэмдэглэж байна” гэжээ.

## ПРОКУРОРЫН МЭДЭГДЭЛ ХУУЛЬ МЭТ ҮЙЛЧИЛЖ БАЙЛАА


“БНМАУ-ын прокурор түүний харьяа прокурор хуулийн зөрчил түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар улс, хоршоолол, олон нийтийн байгууллагад мэдэгдэл бичнэ. Прокурорын мэдэгдлийг хүлээн авч хэлэлцээд заасан зөрчлийг нэн даруй арилгах тодорхой арга хэмжээ авч мэдэгдэл бичсэн прокурорт 30 хоногийн дотор хариу өгнө” гэж БНМАУ-ын Прокурорын хяналтын хуулийн 23 дугаар зүйлд заасан нь хууль мэт үйлчилж байлаа.

## НАМСРАЙЖАВЫН ЛУВСАНЖАВ



Н.Лувсанжав Улаанбаатар хотноо 1954 онд төржээ.

Тэрбээр 1977 онд Эрхүүгийн Улсын их сургуулийг төгсөж, 1977-1980 онд Улсын прокурорын газарт хэлтсийн прокурор, тасгийн дарга, 1992-1996 онд Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд, 2002-2008 онд УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, 2009-2012 онд Сонгуулийн ерөнхий хорооны даргаар ажиллаж, 2017 онд Монгол Улсын Гавьяат хуульч цолоор шагнагджээ.




АНХНЫ
БАЯЖМАЛ
ПЕРВЫЙ
КОНЦЕНТРАТ







# ЗУРГАДУГААР БҮЛЭГ: 1980-1989 ОН









# 1980

**2 сарын 14.** Багануурын районы прокурорын газрыг байгуулав.

**10 сарын 31.** Ахмад прокурор, ажилтнуудын нэрсийг бичих дурсгалын самбарыг бий болгов.

**11 сарын 26.** Прокурорын байгууллагын 50 жилийн ойгоор Х.Жамбалд БНМАУ-ын гавьяат хуульч цол хүртээв.

-Улсын иргэний агаарын тээврийг удирдах газрын дэргэд цэргийн прокурорын газар байгуулав.

-БНМАУ-ын прокурорын байгууллагын 50 жилийн ойд баяр хүргэж МАХН-ын Төв хороо, АИХ, СнЗ, ЗСБНХУ-ын прокурорын газар, Улаанбаатар хотын намын хороо, Мэдээлэл, радио телевизийн Улсын хороо зэрэг 28 яам, тусгай газрууд баярын бичиг, цахилгаан ирүүлжээ.

-БНМАУ-ын прокурорын орлогч бөгөөд Цэргийн Ерөнхий прокурор Ж.Балжиннямыг МАХН-ын Төв хорооны дэргэдэх Намын хянан шалгах хорооны орлогч даргаар томилов.

## ДУРСГАЛЫН САМБАР, ҮҮРД ХАДГАЛАГДАХ ГЭРЧИЛГЭЭ

АИХ-ын Тэргүүлэгчдийн 10 дугаар сарын 31-ний өдрийн тогтоолоор БНМАУ-ын прокурорын байгууллагыг үүсгэн бэхжүүлэх үйл хэрэгт идэвх зүтгэл гарган, нэр хүндтэйгээр олон жил ажиллаж байсан ахмад прокурор,



прокурорын байгууллагын удирдах албан тушаалтан хүмүүсийн дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор нэрийг нь бичиж байх дурсгалын самбарыг бий болгожээ.

Самбарыг байгууллагын 50 жилийн ойг тохиолдуулан Улсын прокурорын газрын байранд бий болгохоор тогтоосон тухай архивын баримтад үлджээ. Тэртээх дөчөөд онд Улсын прокуророор ажиллаж байсан Ж.Банзрагч, Улсын прокурорын орлогч, Бүх Цэргийн прокуророор олон жил



Прокуроруудын нэгдсэн сургалт зөвлөгөөнд оролцогчид

# 1980

ажилласан Ц.Буурал, Дорноговь, Дундговь, Төв, Архангай зэрэг аймгийн прокуророор ажиллаж байсан, анхны гавьяат хуульч Г.Дамдинсурэн, Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн прокурор байсан О.Чулуун нарын нэрийг гантиг чулуун самбарт бичиж, дурсгалын самбарыг БНМАУ-ын прокурор Р.Гүнсэн нээж үг хэлсэн байна.

Самбар нээх ёслолд хүрэлцэн ирсэн Ж.Банзрагч прокурорын төрсөн дүү ахмад дайчин, хурандаа Ж.Самбуу, Ц.Бууралын гэргий Ц.Цэндцэсэм, Г.Дамдинсүрэнгийн гэргий Ө.Гүмэд, О.Чулууны гэргий С.Цагаанхүү нарт үүрд хадгалагдах гэрчилгээг гардуулжээ.

## БАГАНУУРЫН РАЙОНЫ ПРОКУРОРЫН ГАЗАР

Эзгүй зэлүүд байсан Нүүрэнтэйн хөндийд нүүрсний орд газрыг түшиглэн Баганууурын уурхайн их бүтээн байгуулалтын ажил 1978 оноос эхэлсэн. Уурхайг түшиглэн бий болсон Багануур хороог 1980 онд АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигаар өргөтгөн район болгосон ба ингэснээр районы прокурорын газрын үүдийг нээжээ.

Районы прокурор, ерөнхий хяналт эрхэлсэн туслах прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажил эрхэлсэн туслах прокурор, мөрдөн байцаагч, нарийн бичгийн даргын орон тоотой байгуулагдав. Баганууурын районы прокурорын газрын анхны прокуророор С.Чулуунбаатар, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажил эрхэлсэн туслах прокуророор Х.Равзан, мөрдөн байцаагчаар Н.Шүрэнцэцэг, нарийн бичгийн даргаар Г.Дагвадорж нар ажиллаж байжээ.

## ЦЭРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫГ ӨРГӨТГӨВ

1980 оны 8 дугаар сарын 27-нд Цэргийн прокурорын газрын орон тоонд багтаан Эрдэнэт хот, Зүүнбаян, Улиастайн гарнизоны цэргийн прокурорын газар, Барилгын Цэргийн Ерөнхий газар болон Улсын Иргэний агаарын тээврийг удирдах газрын дэргэд Цэргийн прокурорын газрыг тус

-Намын хянан шалгах хорооны дарга Т.Гэндэнгээр ахлуулсан Цагаатгах ажлыг зохион байгуулах хоёр дахь удаагийн комисс байгуулагдаж, бүрэлдэхүүнд нь С.Жалан-Аажав, Х.Дамдин, Б.Лхамсүрэн, С.Батаа, Д.Цэрэнбалжир нар багтав.

-Улсын прокурорын газрын дэргэд Редакцийн зөвлөл байгуулж, даргаар нь С.Бүдрагчааг томилов.

-ГХШНСХүрээлэнгийн эрдмийн зөвлөлийг байгуулж, С.Бүдрагчаа, Ц.Жалцав, Ц.Авирмэд, Б.Содовсүрэн, Д.Дашдэмбэрэл, Д.Зундуй, О.Жамбалдорж, Д.Содномгомбо, Д.Сэвжиддорж, Л.Хүрлээ, Ц.Бүжинлхам, зөвлөх В.Н.Махов нарыг бүрэлдэхүүнд нь багтаав.

-Б.Даваасамбуу Улсын прокурорын орлогч бөгөөд Цэргийн ерөнхий прокуророор, Д.Ханджав Найрамдлын районы, С.Чулуунбаатар Баганууурын, Ц.Цоодол Архангай, Б.Хатанбаатар Говь-Алтай, С.Сүрэн Сэлэнгэ, Л.Сэлээд Увс аймагт тус тус аймгийн прокуророор томилогдов.

# 1980

## БНМАУ-ЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ ХАЙРГЫН ЖАМБАЛ



Х.Жамбал Дорноговь аймгийн Улаанбадрах суманд 1929 онд төржээ. Тэрбээр бага дунд сургууль, МУИС-ийн хуулийн ангийг тус тус төгсчээ.

Х.Жамбал 1952-1958 онд Дорноговь аймгийн прокурорын газарт мөрдөн байцаагч, хэсгийн байцаагч, 1958-1963 онд Улсын прокурорын газарт хэлтсийн прокурор, 1963-1990 онд Дорноговь, Дундговь аймгуудад аймгийн прокуророор тасралтгүй ажиллаж байсан прокурорын байгууллагаас төрсөн зургаа дахь БНМАУ-ын Гавьяат хуульч цолтон юм.

тус байгуулсан байна. Улмаар Цэргийн прокурорын газрын мөрдөн байцаах аппаратын орон тоо, цалингийн хэмжээнд өөрчлөлт оруулахгүйгээр Мөрдөн байцаах хэлтэс байгуулж ажиллуулжээ.

## Х.ЖАМБАЛ: ХУУЛИНД ЗАХИРАГДАЖ АЖИЛЛАВАЛ ХҮНД ИТГЭГДЭНЭ

Гавьяат хуульч Х.Жамбал “Намайг анх прокурорын ажилд сургасан ачтан бол манай нутгийн ахмад прокурор Д.Цэдэндаржаа, гавьяат хуульч Д.Очирхуяг нар юм. Нэгэн үед хууль, хүчний байгууллагуудын дотор прокурор зонхилох үүрэгтэй тэдний ажилд хяналт тавьж дээд хяналтын үүрэг гүйцэтгэж байлаа. Ер нь прокурорын байгууллага хатуу чанд сахилга хариуцлагатай аливаа асуудал, хэрэг зөрчил болсон үйл явдалд их сонор соргог ханддаг, гэмт хэрэг үйлдсэн л бол хэнийг ч бай хатуу зарчмаар, хуулийнхаа заалт үг үсэг бүрд захирагдан шийдвэрлэдэг. Үүгээрээ прокурорын байгууллага ард түмэнд хайрлагдаж хүндлэгдсэн итгэл үнэмшлийн газар гэж би боддог.

Би Дорноговь, Дундговьд аймгийн прокуророор 20 гаруй жил олон сайн хуульчидтай мөр зэрэгцэн ажиллаж, тэднийхээ гүн туслалцаа, хайр хүндэтгэлийг хүлээж, тэднээс сурч, эрхбиш асуудлын зах зух, ээдрээ, эгзэг дүр төрхийг гадарладаг болсон. Хамт олныг удирдаж, бодсон санаснаа нийцүүлж, хийж бүтээж болгохын төлөө явлаа. Хуулийн ажил хуулиндаа захирагдаж хуулиа биөлүүлж байсан цагт ард түмэн аяндаа итгэл хайраа өгнө” гэж ажил мэргэжлийнхээ онцлогийг тайлбарлажээ.

# 1981

## ОНЫ АЖЛАА НЭГТГЭН ДҮГНЭВЭЛ...

БНМАУ-ын прокурорын байгууллагаас 1981 онд хийсэн ажлыг нэгтгэн дүгнэж үзвэл, хууль тогтоомжийн биелэлтийг улс, хоршоолол, олон нийтийн байгууллагад 5962 удаа шалгаж 363930 эрхийн акт хянаж, 17602 зөрчил, дутагдал илрүүлэн 2049 эсэргүүцэл, 3049 мэдэгдэл, 2083 зааварлага бичиж, 5456 хүнд нам захиргаа, олон нийт, сахилгын болон материалын хариуцлага хүлээлгүүлэх арга хэмжээ авч, 497 хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуулийн байгууллагад шилжүүлжээ. Мөн эрүүгийн 2072 хэрэгт мөрдөн байцаалт явуулж, иргэдийн 4436 өргөдөл, гомдлыг шалгаж шийдвэрлэсэн байна.

## ҮЙЛДВЭР, УУРХАЙН ХЯНАЛТЫГ ЧАНГАТГАВ

МАХН-ын 18 дугаар Их хурал “Социалист үйлдвэржүүлэлт нь социализмын материал-техникийн бааз байгуулах бодит зүй тогтлын нэг мөн” хэмээн чухалчилж үзэв. Ийнхүү хүнд, хөнгөн аж үйлдвэрийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн нөөц бүхий орд газрыг өргөн ашиглахын хамт шинэ орд газрыг аж ахуйн эргэлтэд нэмж оруулахыг чухалчлан заасан МАХН-ын Их хуралд прокурорын байгууллагын удирдлагууд оролцож, хуулийн салбарыг төлөөлөн үг хэлж, илтгэл тавьжээ.

## ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХҮРСЭН ҮР ДҮН

Хууль тогтоомжийн биелэлтийг прокурорын ерөнхий хяналтын шугамаар 2476 байгууллагад шалгаж, 257,9 мянган эрхийн акт хянаж, 13790 зөрчил илрүүлж, тэдгээрийг засуулахаар 1185 эсэргүүцэл бичсэний 88,8 хувь, 1734 мэдэгдэл бичсэний 81,9 хувь нь биелэгдэв.

Гэм буруутай 392 хүнд нам, олон нийтийн, 1679 хүнд сахилгын, 2782 хүнд захиргааны арга хэмжээ авахуулж, 464 хүнийг эрүүгийн хариуцлагад татаж, улс, хоршоолол, олон нийтийн байгууллагад учирсан 53 сая 904 мянган төгрөгийн төлбөр хохирлыг төлүүлэв.

-МАХН-ын XVIII Их хурал хуралдав.

-БНМАУ-ын прокурор Р.Гүнсэн АИХ-ын депутатаар тав дахь удаагаа сонгогдов.

-Үлгэр жишээч прокурор О.Лхамсүрэнгийн ажлын арга барилын тухай Зөвлөлтийн “Социалистическая законность” сэтгүүлд хоёр дахь удаагаа нийтлэгдэв.

-ЗХУ-ын Харьков хотын мэргэжил дээшлүүлэх курст аймаг хотын 21 прокурор суралцав.

-Улсын прокурорын газрын хэлтсийн дарга Н.Янжмаа тэргүүтэй 3-н прокурор Зөвлөлтийн прокурорын байгууллагын туршлага судалснаас гадна эрдэм шинжилгээний хурээлэнгийн хоёр ажилтан ЗХУ-ын прокурорын газрын дэргэдэх ЭШХ-нд туршлага судлажээ.

-Г.Далайжамц Сүхбаатарын районы прокуророор томилогдов.

-Уг онд Эрдэнэт үйлдвэр бүрэн ашиглалтад орж дууссан бол Япон улсын дайны төлбөрт төлсөн хөрөнгөөр ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах “Говь” комбинатыг байгуулж ашиглалтад оруулав.

# 1981

Прокурорын байгууллагаас хийсэн бүх хяналт шалгалтын 35,3 хувийг социалист өмч хамгаалах, 16,9 хувийг хөдөлмөр, 10,2 хувийг байгаль хамгаалах, 2,6 хувийг сахилга, 6,6 хувийг тайлан мэдээ гаргалт зэрэг асуудалтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтэд хийсэн шалгалт эзэлж байна.

Түүнчлэн прокурорын байгууллагаас НАХЯ-ны харьяа байгууллагуудад 261 удаа хууль тогтоомжийн биелэлт шалган, эрхийн акт 15649-ийг хянаж, 1294 зөрчил илрүүлэн, зөрчлийг засуулахаар эсэргүүцэл 17, мэдэгдэл 179, шаардлага 64-ийг бичжээ.

## ЗХУ-ЫН ТУРШЛАГЫГ СУДЛАЖ БАЙНА...

Прокурорын байгууллага ЗХУ-ын хууль хамгаалах байгууллагын туршлагыг ном хэвлэлээс орчуулж судлахаас гадна Улсын прокурорын газрын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнд ирж ажилласан Хууль зүйн ухааны дэд эрдэмтэн В.Н.Маховаар 1981 оны эхний хагас жилд тусгай хөтөлбөрийн дагуу онол практикийн хичээл 7 хоногт 2 удаа заалгаж буйг тухайн жилийн ажлын тайлан илтгэлд тэмдэглэжээ.




Зөвлөлт Украины Харьков хотноо суралцагчид,1981 он

# 1982

4 сард. Төв, орон нутгийн шүүх, прокурорын байгууллагын бүсчилсэн зөвлөгөөнүүд болов.

12 сард. Улсын прокурорын тушаалаар “Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэнгийн дэргэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зохицуулах зөвлөл байгуулагджээ.

-Мал сүргийг өсгөн ашиг шимийг нэмэгдүүлэхэд хохирол учруулж байгаа байдлыг аймаг, хотын прокурорын байгууллагууд бүх аймаг сумдын хэмжээнд шалгаж нэгдсэн дүнг СнЗ-д танилцуулжээ.

-БНМАУ-ын прокурор Р.Гүнсэнг үүрэгт ажлаас нь чөлөөлж, гадаад улсад суух Элчин сайдаар томилов.

-БНМАУ-ын прокуророор прокурорын нэгдүгээр орлогчоор ажиллаж байсан С.Бүдрагчааг томилов.

-Ж.Эрдэнэбаатар Баянхонгор, Б.Чулуун Сүхбаатар, Ж.Чойжанцан Төв аймагт тус тус аймгийн прокуророор томилогдов.

## “ХАМТЫН ТЭМЦЛИЙГ ХҮЧТЭЙ БОЛГОЁ”

Төв, орон нутгийн шүүх, прокурорын байгууллагын зүүн бүсийн зөвлөгөөнийг 4 дүгээр сард Дорноговь аймагт хийж Дорнод, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар, Хэнтий аймгуудын прокурорын ажилтнууд оролцов.

Зөвлөгөөнд “МАХН-аас хууль ёсыг бэхжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд мөрдөн байцаах, шүүн таслах ажлыг чиглүүлж хамтын тэмцлийг хүчтэй болгоё” нэртэй илтгэлийг БНМАУ-ын прокурорын Нэгдүгээр орлогч С.Бүдрагчаа тавьжээ.

## ПРОКУРОРУУД ТЭРГҮҮН ТУРШЛАГАА СОЛИЛЦОВ

Ховд аймгийн төвд баруун бүсийн зөвлөгөөн 6 дугаар сарын 1-4-ний өдрүүдэд болж Говь-Алтай, Завхан, Увс, Баян-Өлгий аймгуудын прокурорууд оролцсон байна. Зөвлөгөөнийг дээрх аймгуудын шүүх, прокурорын байгууллагын туршлага солилцох хэлбэрээр зохион байгуулсан ба аймаг бүрээс тэргүүн туршлагын эвхмэл самбар, шилжин явах дарцаг, ажлын үзүүлэлтүүдийн самбар, хүндэт самбар зэргээр үзүүлэн гаргаж тэргүүний хүмүүс, арга туршлагаасаа солилцжээ.

Энэ үед Архангай аймгийн төвд, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Хөвсгөл аймгуудын шүүх, прокурорын байгууллагын ажилтнуудын бүсийн зөвлөгөөн болж БНМАУ-ын прокурор Р.Гүнсэн илтгэл тавьжээ.

## ХИЛСДҮҮЛЭЛТ, ХИЙРХЭЛ ДАХИН НҮҮРЛЭВ

1980-аад он гарснаар нам төвт улс төрийн системийг шүтэн амьдрах тогтолцоо олон жил нийгэмд ноёлсны уршиг илэрч, захиргаадалт, хүнд сурталд суурилсан нүсэр бүтэц бүхий намын толгойд хөдөлгөөн орж эхлэв. Төрийн удирдагчид зулгуйдах замаар бүх эрх мэдлийг гартаа атгах гэсэн намын дээд удирдлагуудын дундах далд сөргөлдөөн нэмэгдэх тусам хуулийн болон цэрэг, армийн байгууллагын удирдлагуудыг үндэслэлгүйгээр ажлаас нь халах, солих байдал ихэсч, нийгэмд далд айдас бий

# 1982

## БНМАУ-ЫН ПРОКУРОР СОДНОМБАЛЖИРЫН БҮДРАГЧАА



БНМАУ-ын прокуророор 1982-1988 онд ажилласан. С.Бүдрагчаа Завхан аймгийн Тэлмэн суманд 1933 онд төржээ. Тэрбээр 1956-1958 онд Улаанбаатар хотын Хууль цаазны дунд сургууль, 1958-1961 онд Марксизм, Ленинизмийн оройн их сургууль, 1961-1965 онд ЗХУ-ын Эрхүү хотын их сургууль төгсчээ.

С.Бүдрагчаа 1953-1954 онд Завхан аймгийн АДХГЗ-ны гэгээрлийн хэлтэст кабинетын эрхлэгч байцаагч, 1954-1956 онд Завхан аймгийн прокурорт хэсгийн прокурор, мөрдөн байцаагч, 1958-1961 онд Улсын прокурорын туслах, 1965-1968 онд Улаанбаатар хотын прокурор, 1968-1969 онд Улсын прокурорын нэгдүгээр орлогч, 1969-1979 онд НАХЯ-ны нэгдүгээр орлогч сайд, УЦСЕГ-ын дарга, 1979-1982 онд Улсын прокурорын нэгдүгээр орлогч, 1982-1988 онд БНМАУ-ын прокурор, 1988-1990 онд НАХЯ-ны Нэгдүгээр орлогч сайд, УЦСЕГ-ын дарга, 1992-1993 онд Мөрдөн байцаах газрын зөвлөх, 1993-1997 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхөөр тус тус ажиллаж байв.

болжээ. Ш.Сүхбаатарын “Төрийн тэргүүн шүүгч Гончигийн Иш” номонд “Хуулийн зарим байгууллагын цөөн тооны хүмүүст байсан багахан алдааг ч бүхэлд нь нялзаан буруутгаж, шүүн таслах, мөрдөн байцаах ажлаараа цаг үедээ толгой цохиж байсан шилдэг хүмүүсийг гэнэт ажлаас нь зайлуулж,



арга хэмжээ авах, хорьж шийтгэх болсон нь олныг гайхашруулж байлаа” гэжээ. 1982 оны 6 дугаар сард хуульчдын бүсийн зөвлөгөөнд илтгэл тавьж байсан БНМАУ-ын прокурор Р.Гүнсэнг учир битүүлгээр гэнэт ажлаас нь чөлөөлж Вьетнам улсад суух Элчин сайдаар томилон Улаанбаатараас явуулав.

Улсын Дээд шүүхийн дарга Г.Ишийг 6 дугаар сарын 25-нд ажлаас нь халав. Хилсдүүлэлт, хийрхэл шүүх, прокуророор зогссонгүй. НАХЯ-ны Нэгдүгээр орлогч сайд, УЦСЕГ-ын дарга генерал А.Думбурайг ажлын арга барил сүрхий хоцорч, социалист хууль ёсыг сахин биелүүлэхэд тавих хяналт, шаардлагыг сулруулсан хэмээн нэр цохон буруутгаж, ажлаас нь чөлөөлөв.

# 1982

Батлан хамгаалах яамны сайд Ж.Авхиаг МАХН-ын Улс төрийн товчооны 291 дүгээр тогтоолоор үүрэгт ажлаас нь чөлөөлж, дэслэгч ба хурандаа генерал цолыг хурааж, Боловсролын сайдын 1984 оны 93 дугаар тогтоолоор зарим бүтээлийг нь сургалтад хэрэглэхийг хориглов.



## Ж.ЧОЙЖАНЦАН: БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОМИЛГООНД НЯХУУР ХАНДДАГ БАЙЛАА

Төрийн хууль цаазын шадар зөвлөх Ж.Чойжанцан Төв аймгийн прокуророор томилогдсон талаараа “Аймгийн прокурорт Улсын прокурорын газраас нэр дэвшүүлсэн хүнийг Намын Төв хорооны боловсон хүчний хэлтэс, захиргааны хэлтэс нарийн шалгаж, шалгалтыг амаар, бичгээр авах, уулзаж ярилцах зэргээр судалдаг байсан. Улмаар Төв хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөнөөр оруулж, шийдвэр гарах хүртэл арваад удаа шалгалт, шүүлэг, ярилцлага, хурлаар оруулж байж ажилд томилно. Хариуцлагатай ажилд боловсон хүчнийг томилохдоо няхуур, нарийн ханддаг байсны жишээ энэ юм. Төв хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөгөөнийг Намын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбал даргалж Улс төрийн товчооны гишүүд оролцдог байсан. Намайг Төв аймгийн прокуророор томилох хуралдааныг Улс төрийн товчооны гишүүн, Төв хорооны нарийн бичгийн дарга Д.Моломжамц гуай даргалсан. Улсын прокурор Р.Гүнсэн намайг хуралдаанд оруулж танилцуулахад Д.Моломжамц дарга бусад гишүүдээс асуух зүйл байна уу гэхэд асуудал тавих хүн гараагүй тул “Төв аймаг бол том аймаг шүү хүү минь, том аймагт залуу хүн томилогдож байгаа юм байна, сайн ажиллаарай” гэж хэлээд баталж байсан. Ингээд зогссонгүй Р.Гүнсэн прокурор Улсын прокурор дээр дагуулж ирээд Коллегийн хурлаар оруулж танилцуулсны дараа Төв аймгийн прокуророор би томилогдсон юм” дурсчээ.

# 1983

3 сарын 18. АИХ-ын 6 дугаар тогтоолоор прокурорын байгууллагын зохион байгуулалтыг өөрчлөн батлав.

-ЗХУ-ын Ерөнхий прокурорын урилгаар БНМАУ-ын прокурор С.Бүдрагчаа тэргүүтэй прокурорын байгууллагын төлөөлөгчид хойд хөршид айлчлав.

-Улаанбаатар хотын прокурорын газрын байрыг тохижуулан засч, албан контор болгон өөрчлөв.

-Улаанбаатар хотын прокурорын газарт 3 хэлтэс, 3 туслах, 19 прокурор ажилладаг болгож, дүүрэгт зарим орон тоог шилжүүлж, төвийн 6 дүүрэгт дунджаар 12-13 прокурор, бүгд 112 нэгжтэй ажиллах болов.

-Б.Дашням Найрамдлын районы, Ж.Балсанлхүндэв Төмөр замын прокурор, Д.Зулхажия Баян-Өлгий, Г.Бахдал Өмнөговь аймгийн прокуророор тус тус томилогдов.

## МАХН-ЫН ТӨВ ХОРОО, АИХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭВ

Прокурорын байгууллага 1983 онд хяналтын чиглэлээр 4472 шалгалт хийж 334.4 мянган эрхийн актыг хянан 24.9 мянган зөрчил дутагдал илрүүлж давхардсан тоогоор 26468 хэрэг материал татан хянаж, 2519 хэрэг мөрдөж, эсэргүүцэл 2664, мэдэгдэл 4409, тоот шаардлага 1976, зааварчлага 2937-г бичиж гэм буруутай 7055 хүнд эрүүгийн бус, 604 хүнд эрүүгийн арга хэмжээг авахуулж, 228.9 сая төгрөгийн хохирол төлбөрийг барагдуулжээ.

Оны эцсээр Улсын прокурор С.Бүдрагчаагийн прокурорын байгууллагаас хийж гүйцэтгэсэн ажлын тухай илтгэлийг МАХН-ын Төв хороо, АИХ-ын Тэргүүлэгчдийн хамтарсан хурлаар хэлэлцээд “МАХН-ын Төв хорооны Бүгд хурлуудын шийдвэрийг хэрэгжүүлэхэд ажлаа чиглүүлэн ажилласан байна” гэсэн дүгнэлтийг өгчээ.

## “ХАР ТОГТООЛ”

Өнгөрсөн онд нь нам төрийн удирдлагын хагарал, хийрхлээс шалтгаалан хуулийн байгууллагын удирдлагуудыг нөмөрсөн хилс хэлмэгдүүлэлт 1983 онд ч үргэлжлэв. Мөрдөн байцаах ажлыг өөрөөсөө илүү мэддэг хэмээгдэн олон түмэндээ алдаршсан Улсын прокурорын мөрдөн байцаах хэлтсийн дарга Р.Сүхбаатар, УЦСЕГ-ын мөрдөн байцаах газрын орлогч дарга П.Доржпалам нарыг хилсээр баривчилсан ба Дээд шүүхийн коллегийн дарга, гавьяат хуульчдыг бөөнөөр нь хоморголон албан тушаалаас чөлөөлөв.

Тухайн үеийн хуулийн байгууллагынхны дунд нэрлэгдэж байснаар “Хар тогтоол” гэгдэх болсон МАХН-ын Төв Хорооны 316 тоот тогтоол 12 дугаар сарын 17-нд гарч өмнөх онд нь учир битүүлгээр ажлаас нь чөлөөлсөн хууль, шүүхийн байгууллагын удирдлагуудыг нэр цохон буруушааж, ажлын арга барилаар хоцрогдож, социалист хууль ёсыг сахин биелүүлэхэд тавих хяналт, шаардлагыг сулруулсан хэмээн тайлбарлажээ.

# 1983

-Прокурорын байгууллага 1983 онд үйл ажиллагаагаа МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн хамтарсан шалгалтаар илэрсэн дутагдал доголдлыг арилгах, Улсын прокурор С.Бүдрагчаагийн илтгэлийг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд өгсөн заалт чиглэл, МАХН-ын Төв Хорооны 1983 оны VI, VII бүгд хурлын шийдвэрийг хэрэгжүүлэн биелүүлэхэд чиглүүлэн ажиллажээ.

## ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ӨӨРЧЛӨВ

-БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1983 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 6 дугаар тогтоолоор БНМАУ-ын Прокурорын хяналтын хуулийн 50 дугаар зүйлд заасныг үндэслэн, БНМАУ-ын Прокурорын газрын зохион байгуулалтыг дор дурдсанаар баталсан байна.

а/ Ерөнхий хяналтын хэлтэс;
б/ Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажилд хяналт тавих хэлтэс (онцгой хэргийг мөрдөн байцаах тасагтай);
в/ Шүүн таслах ажилд хяналт тавих хэлтэс (иргэний хэргийг шүүн таслах ажилд хяналт тавих тасагтай);
г/ Тусгай хяналтын хэлтэс;
д/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хэлтэс;
е/ Шалган зааварлах хэлтэс;
ж/ Аж ахуйн хэлтэс;
з/ Боловсон хүчний тасаг.




Зөвлөлтийн прокурор, Батлан хамгаалахын төлөөлөгчдийг хүлээн авав, 1983 он

# 1983



БНМАУ-ын прокурор С.Бүдрагчаа ЗСБНХУ-д айлчилж хоёр орны прокурорын байгууллагуудын хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурав



Прокурорууд Москва хотноо

Урд эгнээнд зүүн гараас Д.Дашдооров, Л.Цог, С.Дашдондог, арын эгнээнд зүүн гараас О.Баяраа, Б.Цэрэнбалтав, Н.Батсүх, Т.Сүхбаатар, Б.Дашням, Л.Октябрь нар

# 1983

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД
УЛСЫН ПРОКУРОРЫН
ЭСЭРГҮҮЦЭЛ

1983 оны 4-р сарын 11 № 5/50 Улаанбаатар хот

БНМАУ-ЫН ДЭЭД ШҮҮХИЙН ИРГЭНИЙ ХЭРЭГ
ЭРХЭЛСЭН КОЛЛЕГИД

Булган аймгийн шүүхийн 1982 оны
114-р шийдвэрийн талаар

Булган аймгийн хууль зүйн зөвлөлгөө өгөх газар нэхэмжлэлдээ: Тус аймгийн Ингэт толгойн САА-н үтрэмийн нярваар ажиллаж байсан Г.Бямбажав 1981 онд 4160 төгрөгийн эд зүйл дутагдуулж одоо хүртэл төлөөгүй байгаа тул түүнийг гаргуулж, САА-г хохиролгүй болгуулж өгнө үү гэжээ.

Булган аймгийн шүүх БНМАУ-ын Хөдөлмөрийн хуулийн 128-р зүйлийн "в"-д зааснаар Г.Бямбажаваас 246 төгрөг 33 мөнгийг гаргуулан мөн аймгийн Ингэт-толгойн САА-д олгож, хууль зүйн зөвлөлгөө өгөх газрын нэхэмжлэлээс 3914 төгрөг 57 мөнгийг хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэжээ.

Хянавал: Хэргийн материалд шүүх хурлын протокол байхгүй байгаа нь БНМАУ-ын ИБШ хуулийн 226-р зүйлийн "д"-д заасныг зөрчсөн байна.

Иймд Булган аймгийн шүүхийн 1982 оны 6-р сарын 23-ны өдрийн 114-р шийдвэрийг хүчингүй болгуулж уг хэргийг дахин шийдвэрлүүлэхээр ИБШ хуулийн 240-р зүйлийн 2-т заасныг баримтлан эсэргүүцэл бичив.

БНМАУ-ЫН ПРОКУРОРЫН ОРЛОГЧ
ТӨРИЙН ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨХ Д.ХОРХОЙ

# 1984

1 сард. МАХН-ын Төв хорооноос “С.Жалан-Аажавын намын эсрэг явуулгын тухай” тогтоол гаргав.

2 сарын 26. Москвад ЗХУКН-ын Төв хорооны Улс төрийн товчооны олон улсын асуудал хариуцсан комисс хуралдаж, Ю.Цэдэнбалын тухай асуудлыг хэлэлцжээ.

6 сарын 18. Улсын прокуророос “Хэргийн хугацаа сунгах журам гаргаж түүнд тавих прокурорын хяналтыг сайжруулах тухай” тушаал гаргав.

6 сарын 21. Улсын прокуророос “Хэргийн хөдөлгөөний карт хөтлөх” шинэ журмыг тогтоов.

7 сарын 2. Улсын прокурорын тушаалаар Цэргийн хэсгийн прокурорын тухай дүрмийг баталжээ.

8 сарын 4. Улсын прокурорын газрын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг татан буулгав.

8 сарын 14. Улсын прокурор тушаал гарган БНМАУ-ын прокурорын газрын дэргэдэх Эрдэм шинжилгээ арга зүйн зөвлөлийн дүрмийг батлав.

## ХОМОРГОЛОН ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙН ДАЛД ШАЛТГААН ИЛ ГАРАВ



1984 оны 1 дүгээр сард МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны гишүүнээр ажиллаж, нам, төрийн удирдлагад “хоёр дахь” хүн байсан С.Жалан-Аажавыг хорин жилийн өмнөх Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нарын “намын эсрэг” бүлэг гэгчид идэвхтэй оролцож байсан хэмээн Намын хянан шалгах хорооны хурлаар хэлэлцжээ. Үүнээс үндэслэн “С.Жалан-Аажавын намын эсрэг явуулгын тухай” тогтоол гаргаж, БНМАУ-ын прокуророор 1959-1960 онд ажиллаж байсан С.Жалан-Аажавыг нутаг заан суулгажээ.

1982-1983 онд хууль, цэргийн байгууллагын удирдлагуудыг наанаа социалист ёс, ажлын үүрэг хариуцлага ярьж хоморголон халж, хэлмэгдүүлж байсны цаад шалтгаан нь ийнхүү 1984 онд С.Жалан-Аажавыг улс төрийн шалтгаанаар хилсдүүлснээр тод илрэн гарсан болохыг түүх судлаачид хожим тэмдэглэжээ. Тухайлбал “С.Жалан-Аажав нь намын эсрэг бүлэг гэгчид оролцсондоо ч биш, харин намын дээд удирдлагын дураар авирлах, ёс зүйг умартах, төрийн хууль, дүрмийг ноцтой зөрчих явдлыг таслан зогсоох хандлага бүхий санаа гаргаж байсантай холбоотойгоор ийн хэлмэгдсэн” хэмээх өнөөгийн түүхчдийн дүгнэлт тэр үед хилсдэж ажил, амьдралаараа хохирч явсан олон хуульчдад ч бас нэгэн адил хамаатай.

## Ю.ЦЭДЭНБАЛЫГ ЧӨЛӨӨЛӨВ

Крымд амарч байсан СнЗ-ийн дарга Ж.Батмөнх, Улс төрийн товчооны гишүүн Д.Моломжамц нарыг Москвад 8 дугаар сард дуудав. Тэдэнд Ю.Цэдэнбалын эрүүл мэндийн талаархи эмнэлгийн оношийг танилцуулж, албан ажлаас нь чөлөөлөхийг зөвлөжээ. 8 дугаар сарын 22-нд яаралтай зарлан хуралдуулсан МАХН-ын Төв хорооны ээлжит

# 1984

бус 8 дугаар Бүгд хурлын үеэр Д.Моломжамц эрүүл мэндийн шалтгаанаар Ю.Цэдэнбал ажлаа үргэлжлүүлэн хийх боломжгүй болсныг мэдэгдэж, маргааш нь АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга, МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Улс төрийн Товчооны гишүүнээс чөлөөлжээ. Түүнд асар их эрх мэдэл төвлөрч, олон түмний дотор "дарангуйлах" нэр хүнд олсон учраас нам, төрийн дээд албанаас чөлөөлөхдөө тун болгоомж, сэрэмжтэй үйл ажиллагаа явуулж, Зөвлөлтийн талын дэмжлэг авч байж хэрэгжүүлсэн байна.

Намын амьдралын хэм хэмжээ алдагдаж, төр олон нийтийн байгууллагын дотоод хэрэгт шууд оролцох, эрх хэмжээг нь орлон эдлэх, хууль хяналтын гадна үлдэх болсноор улс төрийн шинжээ алдаж, дотооддоо хүнд сурталд суурилсан нүсэр бүтцийг бий болгох замд орсон гэж тухайн үеийн хэвлэлүүд бичиж байжээ. Нам төрийн удирдлагад 44 жилийн турш завсаргүй нэг номерын хүн байсан Ю.Цэдэнбалыг өөрчилснөөр хууль хяналтын байгууллагууд ялангуяа прокурорын байгууллага нам, засгаас хараат бус шийдвэр гаргаж ажиллах таатай нөхцөл бүрджээ.

## ХҮРЭЭЛЭН ТАТАН БУУГДАЖ ТАСАГ БОЛОВ

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнг Улсын прокурорын тушаалаар 8 дугаар сарын 4-нд татан буулгасан ч дараа сард нь АИХ-ын Тэргүүлэгчдийн зарлигийн дагуу Улсын прокурорын тушаалаар Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэнгийн суурин дээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий "Тоо бүртгэл, мэдээлэл судалгааны тасаг"-ийг дарга 1, прокурор мэргэжилтэн 5 орон тоотойгоор байгуулжээ. Тасгийн даргаар Нүрзэдийн Туяа, прокурор мэргэжилтнээр Д.Цэрэнбалжир, Е.Өнөрбаяр, Б.Дэлгэрмаа, Ж.Авхиа, С.Оюундэлгэр нарыг томилжээ.

Мөн Улсын прокурорын тушаалаар БНМАУ-ын прокурорын газрын дэргэдэх Эрдэм шинжилгээ арга зүйн зөвлөлийн дүрмийг батласан байна. Арга зүйн зөвлөлийн даргаар Улсын прокурорын Нэгдүгээр орлогч Н.Жадамба, нарийн бичгийн даргаар Н.Жанцан, гишүүдээр Л.Цог, Л.Ядмаа, Н.Туяа, С.Батсүх, Жанлав, Л.Цэнд, В.Хурцгэрэл, Аюуш, Д.Тогтохжаргал, Т.Сэнгэдорж, С.Нарангэрэл, Л.Баасан нарыг тус тус баталжээ.

8 сарын 23. МАХН-ын Төв Хорооны 8 дугаар Бүгд хурал Ю.Цэдэнбалыг МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Улс төрийн Товчооны гишүүнээс чөлөөлөв.

10 сарын 25. Ж.Батмөнх МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдов.

-БНМАУ-ын прокуророор ажиллаж байсан, Батлан хамгаалах яамны сайд Ж.Авхиагийн дэслэгч ба хурандаа генерал цолыг хурааж, Боловсролын сайдын тогтоолоор зарим бүтээлийг нь сургалтад хэрэглэхийг хориглосон хилс шийдвэрүүд гаргав.

-Үлгэр жишээч прокурор О.Лхамсүрэнгийн тухай мэдээлэл 3 дахь удаагаа Зөвлөлтийн хуулийн байгууллагын сэтгүүлд нийтлэгджээ.

-Тэргүүний мөрдөн байцаагч нарын Улсын IV зөвлөгөөн болов.

-Б.Доржготов Тээврийн, О.Баяраа Завхан аймгийн прокуророор томилогдов.

# 1985

**4 сард.** ЗХУКН-ын Төв хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М.С.Горбачёв өөрчлөлт шинэчлэлийн “Перестройка” хэмээх бодлого хэрэгжүүлэх гэж буйгаа зарлав.

**6 сарын 1.** Прокурор, мөрдөн байцаах ажилтнуудыг аттестатчилах журмыг Улсын прокуророос шинэчлэн тогтоов.

-БНМАУ-ын прокуророор ажиллаж байгаад учир битүүлэг шалтгаанаар ажлаасаа чөлөөлөгдөж, Вьетнам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилогдон ажилласан Р.Гүнсэнг эгүүлэн дуудаж, НАХЯ-ны Цагдаагийн дээд сургуулийн захирлаар томилов.

-С.Пүрэв Дархан, Г.Хоохор Эрдэнэт хотын прокуророор, Л.Сэлээд Архангай, Ц.Дамдинсүрэн Дорноговь, Х.Жамбал Дундговь, Д.Батсайхан Өвөрхангай, Т.Сүхбаатар Увс, Ц.Цоодол Хөвсгөл, Д.Рагчаабазар Говь-Алтай аймгийн прокуророор томилогдов.

## ГОРБАЧЁВЫН ПЕРЕСТРОЙКА

ЗХУ-ын Коммунист намын Ерөнхий нарийн бичгийн дарга К.У.Черненко өвчний улмаас 3 дугаар сарын 10-нд таалал төгсөв. Тэрбээр 73-тайдаа нэг жил хойд гүрний удирдагчаар ажилласан бөгөөд түүнийг таалал төгссөний маргааш нь Коммунист намын Ерөнхий нарийн бичгийн даргаар М.С.Горбачёв томилогдсон. ЗХУ-ын төрийн удирдлагад гарсан энэхүү өөрчлөлт хойд хөршийн төдийгүй Монгол орны улс төр, нийгмийн амьдралд, цаашлаад социалист системийн орнуудад гүн гүнзгий нөлөө үзүүлсэн. М.С.Горбачёв дараа сард нь Намын Төв хорооныхоо Бүгд хуралд “Перестройка” бодлогоо танилцуулж, улс орон даяар хэрэгжүүлж эхэлсэн нь Монголд ч мөн шууд нөлөө үзүүлж эхэллээ.

## Ц.НЯМДОРЖ САЙШААЛЫН ҮНЭМЛЭХ, 50 ТӨГРӨГӨӨР ШАГНУУЛАВ

Улсын прокурорын газрын прокуроруудын дунд 1985 онд социалист уралдаан зарлаж жилийн эцэст дүгнэхэд Тусгай хяналтын хэлтсийн прокурор С.Баттөмөр 1 дүгээр байр эзэлж, гэрчилгээ 200 төгрөг, Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор З.Ринчиндорж удаах байранд орж 150 төгрөгөөр, Ц.Ёндонжамц, Ж.Авхиа, С.Дашдондов нар гутгаар байр эзэлж тус бүр 100 төгрөг, Шүүх хяналтын хэлтсийн хяналтын прокурор Ц.Нямдорж сайшаалын үнэмлэх 50 төгрөгөөр тус тус шагнагдаж байжээ.

## ЯЛ ТӨЛӨВЛӨСӨН ХЭРГИЙНХЭЭ 97,1 ХУВИЙГ ШҮҮХЭЭР ГОЛОГДОЛГҮЙ ШИЙДВЭРЛҮҮЛЖЭЭ

Улаанбаатар хотын прокурорын газраас урьдчилсан мөрдөн байцаалтад тавьсан прокурорын хяналтын ажлын үзүүлэлт жил дараалан өссөний дээр 1985 онд мөрдөж шийдвэрлэсэн хэргийн 90,7 хувийг хуулийн хугацаанд

# 1985

дуусган, гэмт хэргийн улмаас улс, иргэдэд учирсан хохирлын 83,3 хувийг урьдчилан төлүүлж ял төлөвлөсөн хэргийн 97,1 хувийг шүүхээр гологдолгүй шийдвэрлүүлсэн тоо баримт энэ онд гарчээ.

## ХУУЛИАРАА Л ХЭРЭГ ШИЙДЭГДДЭГ БАЙЛАА

“Би аймаг, сумдад 20 гаруй жил прокуророор ажилласан. Тэр үед томилолтоор 10-45 хоног хөдөө явах тохиолдол байнга гарна. Хөдөө хээр унаа тэрэг эвдэрч хээр хонох, ачааны машин, трактор суух, айлын хөрөнгө битүүмжлэх, прокурорын шийдвэр сонсоод хүмүүс ухаан алдаж унах, гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн шаналал зовлонг биеэр мэдэрч сонсох гээд хуулийн байгууллагын ажилтны амсах ёстой жаргал, зовлон, хүнд хүчир бүхнийг би туулж явсан.

1980-аад онд сахилга хариуцлага жинхэнэ утгаараа хэрэгждэг, ажилтан нь ажлаа хийдэг, удирдлага нь удирдлагаар хангадаг системтэй байв.

Чухал хэргийн мөрдөн байцаагч байхдаа албан тушаалын болон өмч ашиглалын хэргүүд шалгаж байхад аймгийн прокурорын зүгээс ингэж тэгж шийд гэдэг систем байгаагүй. Хуулиараа л хэрэг шийдэгддэг байлаа” хэмээжээ.

*Прокурор С.Цэцэгээгийн дурдатгалаас*



БНМАУ-ын прокурор С.Бүдрагчаа БНАГУ-ын прокурорын байгууллагын урилгаар тус улсад айлчлав

# 1985

Гэрэл зургийн цомгоос: БНМАУ-ын прокурор С.Бүдрагчаа тэргүүтэй Монголын хуулийн байгууллагын төлөөлөгчид БНАГУ-д





# 1986

## УЛСЫН ПРОКУРОРЫН ОРЛОГЧ НАРЫН АЖЛЫГ ХУВААРИЛАВ

БНМАУ-ын прокурорын орлогч нарын ажлын хуваарийг шинэчлэн баталсан. Энэ үед Д.Хорхой, Б.Хатанбаатар нар прокурорын орлогчоор ажиллаж байв. Шинэчлэн батлагдсан хуваарь ёсоор Д.Хорхой Ерөнхий хяналт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, Захиргаа аж ахуйн хэлтэс, Тоо бүртгэл мэдээлэл, судалгааны тасгийг хариуцаж ажилласан бол Б.Хатанбаатар Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, Засан хүмүүжүүлэх байгууллагын үйл ажиллагаа, шүүн таслах ажиллагаанд хяналт тавих хэлтэс, “Социалист хууль ёс” сэтгүүлийг хариуцах болжээ.

## ХУУЛЬЧ ЦОЛ ХҮРТЭЭВ

Прокурорын байгууллагын боловсон хүчний сахилга, гүйцэтгэх чанарыг нь дээшлүүлэх зорилгоор Төв, орон нутгийн прокурорын байгууллагын прокурор мөрдөн байцаагч нарын ажлын тайлан хамгаалалт, зөвлөгөөн зохион байгуулж ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөв. Төв, орон нутгийн 319 прокурор, мөрдөн байцаагч тайлан хамгаалснаас 9 хүн буюу 2.8 хувь нь онц, 195 хүн буюу 61.1 хувь нь сайн, 89 хүн буюу 27.8 хувь нь дунд, 3 хүн буюу 0.9 хувь нь хангалтгүй дүн авчээ.

Эрхэлсэн ажлаа сайн хийж цаашид өсөх бололцоотойгоо харуулсан Увс аймгийн хэсгийн прокурор Чимэдцэрэн, Пүрэвцэрэн, Архангай аймгийн хэсгийн прокурор Чулуунаа, Говь-Алтай аймгийн туслах прокурор Л.Болд нарыг ЗХУ-д сургуульд явуулах асуудлыг шийдвэрлэсэн ба З.Ренчиндорж, С.Баттөмөр, Чимидцэрэн, Ц.Бямбажав, Р.Мөнхтариа, Дашжамц, Цэдэн-Иш, Түвшинжаргал нар онц сайн дүн үзүүлсэн тул “Хуульч” цол хүртсэн байна.

2 сарын 5. ЗХУ-ын Ерөнхий прокурорын газраас ирүүлсэн мөрдөн байцаагчийн чемоданууды прокурорын байгууллагын 14 газарт хуваарилжээ.

4 сарын 10. БНМАУ-ын Прокурор, Шүүх яамны Сайдын хамтарсан тушаалаар “Эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн хамт олны тэргүүний зөвлөл шалгаруулах” уралдаан зарлажээ.

6 сарын 29. Прокурорын байгууллагаас “Иргэн ба хууль”сэдэвт өдөрлөгийг хүүхэд, залуучуудын паркт зохион байгуулав.

7 сарын 19. Өвс хадаж, тушаах ажлыг зохион байгуулах комисс байгуулж Улсын прокурорын орлогч Д.Хорхойг даргаар нь, гишүүдэд С.Баттөмөр, Д.Лүндээжанцан, С.Дугуйцагаан нарыг баталжээ.

7 сарын 23. Улсын прокурорын тушаалаар ЗХУ-ын прокурорын газрын гадаад харилцааны хэлтсийн дарга Н.С.Заед, А.М.Рекушков нарт үнэ бүхий зүйл дурсгажээ.

# 1986

12 сарын 9. Ерөнхий боловсролын сургуулиудын дундаас гэмт хэрэг, хэв журмын эсрэг чилгүй хамт олон шалгаруулж, шалгарсан Баян-Өлгий, Дорнод, Увс, Говь-Алтай, Сэлэнгэ зэрэг аймгуудын сургуулиудыг 6000 төгрөгөөр тэнцүү хуваах урамшуулжээ.

-Төв, орон нутгийн прокурорын байгууллагын прокурор, мөрдөн байцаагч нарын ажлын тайлан хамгаалалт хийх зөвлөгөөн зохион байгуулав.

-БНМАУ-ын прокурорын орлогч нарын ажлын хуваарийг шинэчлэн батлав.

-Б.Галдаа Ховд, Н.Батсүх Хэнтий аймгийн прокуророор томилогдов.

-Москва хотын прокурорын удирдах ажилтнуудын 45 хоногийн курст Ж.Чойжанцан нарын 10 прокурорыг суралцуулав.

## ЗӨВЛӨЛТИЙН ПРОКУРОРТОЙ ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРАВ

БНМАУ-ын прокурор С.Бүдрагчаа ЗХУ-д айлчлахдаа БНМАУ-ын прокурорын газар, ЗСБНХУ-ын прокурорын газрын хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурж, БНМАУ-ын прокурорын байгууллагын прокурор, мөрдөн байцаагчдыг Москва хот дахь ЗСБНХУ-ын прокурорын газрын удирдах ажилтны сургалтын төв, Ленинградын сургалтын төв, Киев хот дахь сургалтын төвд тус тус суралцуулах болов.

Энэ гэрээний дагуу ЗХУ-ын Ерөнхий прокурорын газраас Улсын прокурорын газарт мөрдөн байцаагчийн чемоданууд олноор ирүүлжээ. Үүнтэй холбогдуулан прокурор мөрдөн байцаагчдад криминалистикийн техник хэрэгслийг чадамгай эзэмшиж, гэмт хэргийн газарт үзлэг хийхэд мөрдөн байцаагчийн чемоданаа байнга ашиглах явдлыг чухал гэдгийг онцлон тэмдэглэсэн утга бүхий тушаалыг БНМАУ-ын прокуророос гаргаж байв.

## Д.ДАВААДОРЖ: ПРОКУРОРЫН “БҮТЭЭГДЭХҮҮН” САЙН БОЛ ШҮҮХ ЭНДДЭГГҮЙ

“Би 1986 онд сургууль төгсөөд цэргийн прокурорт хувиарлагдсан. Энд прокурорын бүх төрлийн хяналт, мөрдөн байцаагчийн ажлыг 10 гаруй жил хийсэн. Цэргийн прокурорын газаргүй орон дэлхийд байхгүй. Харин манайх үгүй болгосон. Прокурор сайн бол мөрдөн байцаагч алддаггүй, прокурор, мөрдөн байцаагчийн “бүтээгдэхүүн” сайн бол шүүх бас эндээгүй юм. Үүнийг дандаа санаж явах ухааныг Цэргийн прокурорын газар надад суулгасан. Тэртээх 1937 оны үеийн шүүх, прокурорын байгууллагын ажил байдал, арга барил нь ямар түвшинд байсан зэргийг харьцуулж, хуульч мэргэжлийн хүний бодол санааг би “1937 оны мөрдөн байцаалт” нэртэй ном бичиж олон түмэндээ хүргэж байлаа” хэмээн хожим 1999 онд нийслэлийн прокурор болсон Д.Даваадорж өгүүлжээ.

# 1987

-АИХ-ын чуулганд БНМАУ-ын прокурор тавьсан илтгэлдээ хөдөлмөрийн сахилгыг бэхжүүлэх, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж буй прокурорын хяналт, цаашдын зорилтын тухай дурджээ.

-БНМАУ-ын прокурорын орлогчоор Буриадын Хатанбаатар томилогдов.

-Д.Зулхажия Налайхын прокуророор, С.Баттөмөр Архангай, З.Казбек Баян-Өлгий, Ц.Оюунбаатар Завхан аймгийн прокуророор томилогдов.

-1990 он хүртэл ирээдүйд өсөх чадвартай боловсон хүчнийг төр, засгийн түвшинд шилэн сонгож авч ажиллуулдаг байв. Энэ шалгуурт тэнцэж прокурорын байгууллагад ажиллагсдаас БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн газарт Равдангийн Михиал, Балдангийн Янжмаа, Цэрэндагвын Цэцэгмаа, Намсрайжавын Лувсанжав, Далайжамц, Н.Сосорбарам, МАХН-ын Төв хороонд Даржаагийн Зундуй, Оргийн Жамбалдорж, Лувсандоржийн Рэнчин, Цэндийн Цолмон, Логийн Цог, Навааннэрэнлэйн Жанцан, Сүрэнгийн Цэрэндорж нар шалгаран ажиллаж, хожмоо хууль хүчний байгууллагуудын жолоон дээр сууцгаасан билээ.

## БУРИАДЫН ХАТАНБААТАР



Б.Хатанбаатар 1975 онд Эрхүүгийн Улсын Их сургууль, 1984-1986 онд ЗХУКН-ын Төв хорооны дэргэдэх Нийгмийн ухааны академид тус тус суралцан төгсчээ.

Б.Хатанбаатар 1975-1980 онд Хэнтий аймгийн прокурорын газарт мөрдөн байцаагч, 1980-1984 онд Говь-Алтай аймгийн прокурор, 1986-1990 онд Улсын прокурорын шалган зааварлах хэлтсийн дарга, Улсын прокурорын орлогч прокурор, 1990-1993 онд Цэргийн ерөнхий прокурор, 1993 оноос Цэргийн Ерөнхий прокурорын газар татан буугдаж Хэрэг бүртгэх алба болоход даргаар нь томилогдон хурандаа цолтой ажиллаж байв.

## САНХҮҮЧДИЙГ “УРВУУЛЖ” ХУУЛЬЧ БОЛГОВ

Наяад онд прокурорын байгууллага социалист өмч ашиглалт, үрэгдүүлэлтийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулдаг байсан ба уг хэргийг мөрдөхөд санхүүгийн мэргэжлийн хүмүүс шаардлагатай байв. Тиймээс санхүүгийн мэргэжилтнүүдээс “урвуулан” сургаж, хуульчийн мэргэжил олгон төв, орон нутгийн прокурорын байгууллагад ажиллуулах тохиолдол цөөнгүй байв. Тэдний нэг Ч.Баасанжав анх санхүүгийн мэргэжилтэй байгаад МУИС-ийн эрхзүйн ангид суралцан төгсөөд Архангай аймгийн прокурорын байгууллагад ажиллажээ.

Тэрбээр “Олон хоногоор сум дамжин явж прокурорын байгууллагын хяналтын бүх ажлыг хийж гүйцэтгэх нь эмэгтэй хүнд ахадсан мэт боловч прокурорын нэр хүндтэй ажлыг хийхэд улсаас өргөн мэдлэг олгож, дадлага туршлагатай болгож байсан, хамт олон маань ч дэмжлэг

# 1987

туслалцаа их үзүүлнэ. Би аймгийн прокурорын газарт ажиллаж байгаад 1987 оноос Улаанбаатар хотод шилжин ирж Октябрийн районы прокурорын газарт хэрэг бүртгэлтийн ажиллагаанд хяналт тавих хяналтын прокурорын албыг хашихад аймагт гардаг хэрэг зөрчлөөс дүүрэгт гардаг хэрэг зөрчил 2-3 дахин их байлаа. Гэсэн ч хийх ёстой ажлаа цаг хугацаанд нь хийж, олон сайхан залуучуудтай хамтран ажилладаг байсан" хэмээн өгүүлжээ.

*Прокурор Ч.Баасан-жавын дурдатгалаас*

## ЛЕНИНГРАД, ХАРЬКОВ, ЭРХҮҮД МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН ПРОКУРОР

ЗХУ-ын нийслэл Москва болон Ленинград, Киев, Харьков зэрэг томоохон хотуудад БНМАУ-ын прокурорын байгууллагаас прокурор, мөрдөн байцаагчдыг жил бүр олноор нь илгээж мэргэжил дээшлүүлэн суралцуулж байжээ.

Хуулийн байгууллага бүрийн нэр дээр жил бүр 10 хуульчийг хойд хөршид сургадаг байсан үе түүх болон улирч, 50 гаруй прокурор, мөрдөгчид ЗХУ-ын томоохон хотуудыг энэ онд зорьжээ.

Прокурорын байгууллагад 39 жил ажилласан А.Ширэндэв прокурор 1987 онд Ленинград хотод хэрэг бүртгэлт, мөрдөн хяналтын чиглэлээр 45 хоног суралцаж, мэргэжил дээшлүүлсэн нэгэн. Тэрбээр өмнө нь 1972 онд ЗХУ-ын Харьков хотод шүүхийн хяналтын чиглэлээр 3 сар, хойно нь 1995 онд Эрхүү мужийн прокурорын дэргэдэх мэргэжил дээшлүүлэх курст бүх хяналтын чиглэлээр 14 хоног тус тус суралцаж мэргэжил дээшлүүлж байснаа бахархан дурсчээ.



ЗСБНХУ-ын Ерөнхий прокурорын урилгаар БНМАУ-ын прокурорын орлогч Б.Хатанбаатар, Улсын прокурорын газрын шалган зааварлах хэлтсийн прокурор Б.Дүгэржав, тусгай хяналтын хэлтсийн прокурор Б.Гүнсэнхорлоо нар ажлын айлчлал хийв.
1987 оны 7 дугаар сар

# 1987

## “ПРОКУРОРЫН ХҮНДЭТ АЖИЛТАН” ТЭМДЭГ БИЙ БОЛОВ




Улс, ардын аж ахуй, соёлын олонхи салбарт “Тэргүүний ажилтан” тэмдэг бий болж шилдэг хүмүүсээ шагнаж иржээ. Уг асуудлыг Сайд нарын зөвлөл шийдвэрлэж, тэмдгийн мөнгөн шагналд 100 төгрөг дагалддаг байсан ч прокурорт 1987 он хүртэл ийм шагнал байсангүй.

БНМАУ-ын Прокурор ажлаа Ардын Их Хурал, түүний тэргүүлэгчдэд шууд хариуцан тайлагнадаг онцлогийг харгалзан “Прокурорын хүндэт ажилтан” тэмдэг бий болгох асуудлыг БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдээр шийдвэрлүүлэхээр Улсын прокурорын газраас 1987 онд санал оруулжээ.

Уг саналыг АИХ-ын Тэргүүлэгчдийн Төрийн байгуулалтын хэлтсийн дарга Бяраагийн Чимид Ардын Их Хурлын

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***



ТАНИЛЦУУЛГА

"Прокурорын хүндэт ажилтан" тэмдэг бий болгох тухай

БНМАУ-ын Прокурорын байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан прокурор, мөрдөн байцаагчид, ажилтан, түүнчлэн гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэхэд өндөр амжилт гаргасан бусад байгууллагын ажилтныг шагнан урамшуулж байх зорилгоор "Прокурорын хүндэт ажилтан" тэмдэг бий болгох тухай саналыг БНМАУ-ын Прокурорын газар оруулсныг зүйтэй гэж үзэж зохих тогтоолын төслийг тэмдгийн тодорхойлолт, загварын хамт Ардын Их Хурлын Тэргүүлэгчдэд батлуулахаар оруулж байна.

Улс, ардын аж ахуй, соёлын олонхи салбарт "Тэргүүний ажилтан" тэмдэг бий болгож зохих хэмжээгийг шагнан урамшуулж ирсэн ю. Улс, ардын аж ахуй, соёлын салбарын "Тэргүүний ажилтан" тэмдгийг бий болгож асуудлыг Сайд нарын Зөвлөл шийдвэрлэдэг бөгөөд тэмдгийн мөнгөн шагналыг 100 төгрөгөөр тогтоосон байна. Энэхүү практикийг харгалзан БНМАУ-ын Прокурор ажлаа Ардын Их Хурал, түүний Тэргүүлэгчдэд шууд хариуцан тайлагнадаг онцлогийг ийм үндэс болгон "Прокурорын хүндэт ажилтан" тэмдэг бий болгох асуудлыг Ардын Их Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэв.

БНМАУ-ын "Прокурорын хүндэт ажилтан" тэмдэг бий болгох тухай тогтоол, уг тэмдгийн тодорхойлолт, загварыг хянан үзэж баталж өгнө үү.

Хэлтсийн дарга Б.ЧИМИД

Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулахад “БНМАУ-ын Прокурорын байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан прокурор, мөрдөн байцаагч, ажилтан, түүнчлэн гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэхэд өндөр амжилт гаргасан бусад байгууллагын ажилтныг шагнан урамшуулж байх нь зүйтэй” гэж үзэж, БНМАУ-ын “Прокурорын хүндэт ажилтан” тэмдэг бий болгон, тэмдгийн тодорхойлолт, загварын хамт баталжээ.

# 1988

1 сарын 16. Хилийн ба дотоодын цэргийн прокурор, Барилгын цэргийн болон Улиастай гарнизоны цэргийн прокурорын газруудыг Цэргийн ерөнхий прокурорын газарт нэгтгэв.

2 сарын 5. АИХ-ын Тэргүүлэгчдийн 20 дугаар зарлигаар “БНМАУ-ын Прокурорын хяналтын хууль”-д нэмэлт оруулав.

3 сарын 5. АИХ-ын Тэргүүлэгчдийн 54 дүгээр зарлигаар БНМАУ-ын Прокурорын байгууллагын прокурор, мөрдөн байцаагч нарыг сайшаан урамшуулах, тэдэнд сахилгын арга хэмжээ авах журмын тухай дүрмийг батлав.

3 сарын 12. АИХ-ын Тэргүүлэгчдийн 11 дүгээр зарлигаар “Прокурорын хүндэт ажилтан” тэмдэг бий болгож, түүний тодорхойлолтыг хавсралт ёсоор баталж, уг тэмдгээр зарлигт дурдсан хүмүүсийг шагнаж байх эрхийг БНМАУ-ын Прокурорт олгожээ.

6 сарын 15. БНМАУ-ын прокурор С.Бүдрагчаа нийт прокуроруудад хандан ил захидал бичив.

## 1970-1980-ААД ОНЫ ШИЛДЭГ ПРОКУРОРУУД

БНМАУ-ын прокуророор ажиллаж байсан Жарантайн Авхиа 1988 онд хэвлэлд өгсөн ярилцлагадаа “Хуульчид, ялангуяа прокурорын байгууллагад ажиллаж гавъяа байгуулсан хүмүүсийг шагнах “Гавьяат хуульч” цол бий болгох асуудлыг санаачлан боловсруулсныг Намын Төв Хороо, АИХ дэмжиж 1970 онд прокурорын байгууллагын 40 жилийн ойгоор анх удаа прокурорын байгууллагаас Г.Дамдинсүрэн, С.Батсүх нар шагнагдсан. Дараа нь О.Лхамсүрэн, Г.Очирхуяг, М.Бадрах нарын 5 прокурор Гавьяат хуульч болсон.

Дээрх гавьяатуудаас дутахгүй ажил, мэргэжлийн өндөр чадвартай 1970-1980-аад оны прокурорын байгууллагын гол ачааг үүрч явсан прокурор Г.Иш, Ц.Загд, Р.Сүхбаатар, Ж.Балжинням, Ц.Жалцав, Д.Зундуй, Ц.Гэндэндаржаа, Б.Хатанбаатар, Д.Хишиг-Очир, А.Ядмаа, Л.Ядмаа, М.Дүнчинсүрэн, З.Ширчин, С.Жамъян, Н.Жанцан, Л.Ринчин, Ж.Чойжанцан, Н.Сосорбарам, Б.Янжмаа, Б.Дагвадорж, Т.Даваажав Д.Цэдэндаржаа, Д.Өлзий, И.Батмөнх, Д.Лувсандаш, Ц.Дамдинсүрэн, Г.Шагдаржав, Н.Буниа, Г.Цэрэнлхам, М.Алтанхуяг, Л.Цог, Л.Сүрэнхорлоо, Н.Цэрэннадмид, Д.Цэрэнбалжир, Ц.Бүжинлхам, Б.Доржготов, С.Дашдондов, Ч.Шаравдорж, Е.Сүрэн, З.Рэнцэндорж, Н.Бэгзжав, Л.Баадай, Ж.Гомбодорж, С.Лувсандагва, Ц.Жалбасүрэн, Х.Үржиндорж, Д.Даваасүрэн, А.Бураан, Г.Бэгз, Н.Өлзийбадрах, П.Хүүхнээ, Д.Цэндцэсэм, Б.Жанлав, Д.Рагчаабазар, Ц.Цоодол, Б.Чулуун, С.Пүрэв, Б.Сандуйжав, П.Дайрийжав, Ш.Энхцэцэг, Д.Ханджав, Д.Эрдэнэчимэг, З.Батсүх, С.Балжинням, Д.Жамбалдорж, О.Дорж, Х.Мерейхан, П.Хоролгарав, С.Баттөмөр, Б.Цэрэнбалтав, И.Дамдин, Л.Сэлээд, Д.Сэдээхүү, Б.Дашням, Е.Сагсай, Д.Одсүрэн, О.Баяраа, Х.Алтанзүрх, Д.Зулхаажия, Ч.Содномдоо, И.Рэнцэндорж, санхүүч С.Дугуйцагаан, нараараа би үргэлж бахархаж явдаг” хэмээжээ.

## ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫГ ӨРГӨТГӨВ

АИХ-ын Тэргүүлэгчдийн 20 дугаар зарлигаар Прокурорын хяналтын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

# 1988

Нэмэлт, өөрчлөлтөөр байгууллага, албан тушаалтан хуулийг зөрчсөнийг нэн даруй арилгуулах, гэм хор учрахаас сэргийлэхэд чиглэсэн шуурхай арга хэмжээ (прокурорын даалгавар, сануулгаар шаардлага тавих) авах үүргийн шинжтэй эрхтэй болсон. Энэ нь тус улсад социализм байгуулах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд 1966-1990 онд гаргаж байсан “цэвэр социалист агуулга”-тай хуулиудын нэг хэмээн судлаачид үздэг.

## АЙСУЙ ӨӨРЧЛӨЛТ БА ПРОКУРОР

Монгол оронд төдийгүй социалист лагерийн бүх оронд, түүнчлэн ЗХУ-д хүртэл өрнөж байгаа өөрчлөлт шинэчлэлтийн нөлөөгөөр МАХН-ын Төв Хорооны 5 дугаар Бүгд хурал хуралдаж, улс төрийн тогтолцоог шинэчлэх зарим санаа дэвшүүлсэн боловч, түүнийг шуурхай хэрэгжүүлэх тал дээр бараг юу ч хийсэнгүй. Гэтэл улс төрийн идэвх өсч ЗХУ болон социалист орнуудад өрнөж байсан



үйл явцыг анхааралтай ажиглаж байсан монголчууд оюун санааны хүрээнд өөрчлөн байгуулалтыг хүсэмжилж байлаа.

Нам, төрийн удирдагчдын байдал нийгмийн бухимдлыг дэвэргэж, залуучуудын дунд хөдөлгөөнүүд бий болж эхлэв. Прокурорын байгууллага нийгэмд өрнөж буй өөрчлөлт, хөдөлгөөнийг анхааралтай ажиглахын зэрэгцээ хууль ёс сахиулах ажилд тухайн үеийн хуулийн дагуу огтхон ч хазайлгүй ажиллаж байлаа.

-С.Бүдрагчааг НАХЯ-ны Нэгдүгээр орлогч сайд, УЦСЕГ-ын даргаар томилов.

-Ж.Балжинням БНМАУ-ын прокуророор томилогдов.

-Ж.Бямбаа Улсын прокурорын Нэгдүгээр орлогчоор, О.Дагвадорж Улсын прокурорын орлогч, Цэргийн ерөнхий прокуророор, Г.Бахдал Улсын прокурорын газрын Шалган зааварлах хэлтсийн даргаар, Б.Цэрэнбалтав тусгай хяналтын прокуророор томилогдов.

-Н.Мягмардорж Улаанбаатар хотын прокуророор, Ж.Амаржаргал Найрамдлын, Д.Ганболд, Б.Дамдинсүрэн нар дараалан Сүхбаатарын, О.Нямаа Ажилчны районы прокуророор, Б.Дашням Эрдэнэт хотын прокуророор томилогдов.

-С.Жалан-Аажав МУИС-ийн Хуульзүйн сургуульд зөвлөх профессороор ажиллаж эхлэв.

# 1988

## БНМАУ-ЫН ПРОКУРОР ЖҮГДЭРИЙН БАЛЖИННЯМ



БНМАУ-ын прокуророор 1988-1990 онд ажилласан Ж.Балжинням Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын нутагт 1930 онд төрж, 1964-1969 онд Москва хотын Цэргийн улс төрийн академид хуульч мэргэжил эзэмшжээ.

Тэрбээр 1951-1954 онд Улсын дээд шүүхийн коллегид бичээч, нарийн бичгийн дарга, 1954-1964 онд УТЗ-д мэргэжилтэн, хэлтэс, албаны дарга, 1969-1972 онд Ардын цэргийн прокурорын орлогч, 1972-1978 онд БНМАУ-ын прокурорын орлогч, 1978-1980 онд БНМАУ-ын прокурорын орлогч бөгөөд Цэргийн Ерөнхий прокурор, 1980-1982 онд Намын хянан шалгах хорооны орлогч дарга, 1982-1988 онд Монголын Ардын армийн улс төрийн газрын дарга, 1988-1990 онд Улсын прокуророор ажиллаж байв.

Ж.Балжинням нь 1978 онд хошууч генерал, 1982 онд дэслэгч генерал, 1988 онд Төрийн хууль цаазын жинхэнэ зөвлөх цол хүртжээ.

## АЖЛАА ӨГӨХДӨӨ ИЛ ЗАХИДАЛ БИЧИВ

БНМАУ-ын прокурор С.Бүдрагчаа албан тушаалаа өгөхдөө прокурорын байгууллагын нийт прокурор, мөрдөн байцаагчдад ил захидал бичив. Захидалд “...Би НАХЯ, түүний цагдан сэргийлэх байгууллагад ажиллах болсныг та нөхөд мэдэж байгаа биз ээ. Та бүхэнтэй хамтран зүтгэж, та бүхний хяналтын дор ямагт байдаг, хэцүү хатуу ажилтай цагдан сэргийлэх байгууллага, тэдгээрийн удирдлага болон офицер, сэргийлэгч, засан хүмүүжүүлэх байгууллагын ажилд байнгын халуун туслалцаа үзүүлж, ажил явдлыг нь өөд татахад шийдвэрлэх нөлөө үзүүлж өгөхийг хүсч байгааг минь хүлээн авна уу” хэмээн захидлынхаа төгсгөлд дурдсан нь бий.

## М.ОДОНХҮҮ: АЖЛЫН АРГА БАРИЛЫГ ӨӨРЧЛӨВ

Би Улаанбаатар хотын прокурорын ерөнхий хяналт эрхэлсэн орлогчоор 1988 оны 5 дугаар сард томилогдсон. Энэ үед ЗХУ-д Михаил Горбачёвын сэдэж санаачилсан өөрчлөн байгуулалт өрнөж, эрхзүйт төр, ил тод байдал, олон ургальч үзэл гэх мэт ардчиллын суурь ойлголт ид яригдаж, энэ нь манайд мөн тусгалаа олж байсан юм. Би орос хэл дээр хэвлэгддэг мэргэжлийн болоод улс төрийн сонин, сэтгүүл, ном захиалж, их уншина. Эндээс санаа авч, ерөнхий хяналтын ажлын арга барилыг өөрчлөх, ер нь нийгмийн харилцаанд прокурорын хяналтын эзлэх байр суурийг өөрийнхөө хувьд тодорхойлохыг оролдож, зарим зүйлийг хийж билээ.

Юуны өмнө, прокурор бүх зүйлийг өөрөө

# 1988

гардаж хийдэг, бүх салбарын ажил руу “хошуу дүрж”, бүхнийг мэдэгч болон хувирсан тэр арга барилыг өөрчлөхийг зорьж, хичээсэн юм. Хуулийн биелэлтийн талаар хяналт шалгалт хийхдээ аливаа хэрэг, зөрчлийг хэн нэгнээр мугуйдлан хүлээлгэх, хийсвэр тоо хөөх бус харин үндэслэл бүхий баримт сэлтээр нотолж, шалтгаан нөхцөлийг нь тогтоож, тэдгээрийг болон хууль бус үр дагаврыг нь арилгах арга барилыг хэрэглэхийг зорьсон болно. Ингэж ажилласнаар тодорхой үр дүнд хүрснийг хэлэх хэрэгтэй.

*Улсын прокурорын 1 дүгээр орлогч М.Одонхүүгийн дурдатгалаас*

## ҮНСЭН ШУУРГЫГ ҮГҮЙ ХИЙВ

Нийслэлд жил бүрийн хавар үнсэн шуурга босч, хотын үзэмж, гудамжны ариун цэвэр, иргэдийн эрүүл мэндэд халтай байдал бий болдог байлаа. Энэ бол Ажилчны район дахь хуучны 1 дүгээр цахилгаан станцын хаягдал үнсэн сангийн асуудал бөгөөд олон нийтийн зүгээс шүүмжлэлтэй ханддаг байв. Прокурорын байгууллага байгаль орчныг хамгаалахтай холбогдох хууль, тогтоомжийн биелэлтэд хяналт тавих үүрэгтэй тул энэ асуудалд анхаарч шалгалт явуулжээ. Хэдэн арван жилээр хуримтлагдсан үнсний хаягдлыг байгаль орчны байцаагч нараар шалгуулж дүгнэлт гаргуулан, холбогдох мэргэжилтэн, албан тушаалтнуудаас асуумж, тодорхойлолт авах, бодит байдлын фото зургийг авч дүрс бичлэг хийх замаар баримтжуулж Түлш, Эрчим хүчний яамны сайдад илэрсэн зөрчлийг арилгуулахаар прокурорын мэдэгдэл бичжээ. Түлш эрчим хүчний яамны коллегийн хуралд Улаанбаатар хотын прокурорын ерөнхий хяналт эрхэлсэн орлогч прокурор М.Одонхүү шалгалтын дүнг танилцуулснаар үнсээр бүрхэгдсэн олон арван га талбайг хөрсжүүлж, зүлэг тарих ажлыг зохион байгуулсан удаатай.

## ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН ҮҮРГИЙГ НАРИЙВЧЛАН ТОГТООВ

Улсын Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогчоор Ж.Бямбаа нь 1988-1990 онд



БНМАУ-ын прокурорын орлогчоор ажиллаж байсан Ж.Бямба хамт олонтойгоо

# 1988

ажиллахдаа ерөнхий хяналтын ажлын үндсэн үүргийг нарийвчлан тогтоож, юуны урьд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлийг тодорхой болгон, А.Ядмаа, Д.Лүндээжанцан нарын удирдсан хамт олны хүч хөдөлмөрт тулгуурлан олон чухал ажил санаачлан хэрэгжүүлжээ. Тэр үеийн “эцсийн сануулга” хэмээн нэрлэгдсэн прокурорын мэдэгдлээр төрийн захиргаа, төрийн удирдлагын салбаруудад үр дүнтэй олон арга хэмжээ зохион байгуулагдсан түүх бий.

## ЖАВХЛАНГИЙН БЯМБАА



Жавхлангийн Бямбаа Увс аймгийн Тэс суманд төрсөн. Тэрбээр 1969 онд Хууль цаазын дунд сургууль, 1976 онд Эрхүүгийн Улсын их сургууль дүүргэжээ. Тэрбээр 1969 оноос Ховд аймгийн Хууль зүйн зөвлөгөө өгөх газарт эрхлэгч, өмгөөлөгч, 1976-1986 онд МАХН-ын Төв Хороонд зааварлагч, ахлах зааварлагч, 1988-1990 онд Улсын Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогч, 1993-2011 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд тэнхмийн эрхлэгч, 2012 оноос МУИС-ийн Хууль зүйн сургуулийн зөвлөх профессор, Шихихутуг их сургуулийн магистр, докторын сургалтын албыг эрхлэн ажиллаж байна.

Ж.Бямбаа нь Монголын ардчилсан төрийн шинэ тогтолцооны тулгуур Монгол улсын Үндсэн хуулийн Цэцийн анхны гишүүдийн нэг юм. Профессор Ж.Бямбаа нь 1988 онд Москва хотын Нийгмийн шинжлэх ухааны Академийн аспирантурт суралцаж Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалж, Үндсэн хуулийн болон эрүүгийн эрх зүй, өмгөөллийн чиглэлээр цөөнгүй бүтээл туурвижээ.

## ОЙДОВЫН ДАГВАДОРЖ



О.Дагвадорж Дундговь аймгийн Цагаандэлгэр суманд 1946 онд төржээ.Тэрбээр 1965-1968 онд Цэргийн Ерөнхий сургууль, 1972-1977 онд ЗХУ-ын Дотоод явдлын яамны Академи төгсөж, 2004 онд доктор /Ph.D/-ын зэрэг хамгаалжээ.

О.Дагвадорж 1968-1970 он УЦСЕГ-т төлөөлөгч, 1971-1972 онд Дундговь аймгийн ЦСА-д Мөрдөн байцаагч, Ахлах мөрдөн байцаагч, 1977-1980 онд Хөвсгөл аймгийн ЦСА-д ангийн дарга, 1980-1981 онд Иргэний агаарын тээврийн ЦСА-д ангийн дарга, 1981-1988 онд МАХН-ын Төв хорооны Зохион байгуулах хэлтэст Зааварлагч, 1988-1990 онд Улсын Прокурорын орлогч бөгөөд Цэргийн Ерөнхий прокурор, 1996-2000 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт Тамгын газрын дарга, 2000-2001 онд Сутай дээд сургуульд Тэнхимийн эрхлэгч, 2002-2007 онд Улаанбаатар дээд сургуулийн Захиргааны газрын дарга, 2007-2009 онд Чингис хаан дээд сургуульд тэнхмийн эрхлэгч, 2009-2013 онд Орхон их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирлаар ажиллажээ.

# 1989

-Төв, орон нутгийн прокуроруудын удирдах ажилтны зөвлөгөөнийг Төв аймагт зохион байгуулж, БНМАУ-ын прокурор Ж.Балжинням, орлогч прокурор Ж.Бямбаа, Б.Хатанбаатар нар оролцжээ.

-ЗСБНХУ-ын прокурорын газрын урилгаар БНМАУ-ын прокурорын байгууллагын төлөөлөгчид Москвад айлчилж, хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурав.

-Герман, Польшийн прокурорын байгууллагын төлөөлөгчид Монголд айлчлав.

-Ц.Сарантуяа Тээврийн прокурор, Ц.Түмэн, Б.Цэрэнбалтав нар дараалан Сүхбаатар, Г.Хадхаан Баянхонгор, М.Алтанхуяг Өмнөговь аймгийн прокуророор томилогдов.

## АРДЧИЛСАН ХУВЬСГАЛ ЭХЛЭВ



Захиргаадалтын нийгмийг өөрчлөх олон нийтийн хүсэмжлэл туйлдаа хүрлээ. ЗХУ-д нэгэнт хүчээ авсан өөрчлөн байгуулалтын нөлөөгөөр Болгар, Чехословак, Польш, Унгарт коммунист нам байр сууриа алдаж, Румынд олон нийт эрх баригчдын хооронд зэвсэгт мөргөлдөөн болж байв.

1989 оны төгсгөлөөр нийслэлийн гудамж, талбайд засаг төрийн бодлогыг шүүмжилсэн, улс төр, оюун санааны хүлээсээс ангижирч, эрх чөлөө, шударга ёсны төлөө тэмцэлд орох цаг болсныг уриалсан ухуулах хуудас наах, оюутан залуучууд, салбар салбарын мэргэжилтнүүдийн дунд улс төрийн идэвх бүхий клуб, хөдөлгөөнүүд байгуулах, дэргэдээ дээрхийн адил утгатай мэдээлэл бүхий сонин, сэтгүүл бий болгож олон нийтэд хэвлэн тараах зэргээр цагийн байдал эрс өөрчлөгдөж эхлэв.

Хэдийгээр намын зүгээс хяналт, шахалт туйлын хүчтэй байсан ч тогтмол сонин хэвлэлүүд өөрчлөн байгуулалтыг дэмжсэн нийтлэл, ярилцлага олноор гаргах болов. 12 дугаар сарын 6, 7-нд Эрдэнэт хот, Ховд аймагт жагсаал, цуглаан болж, Монголын ардчилсан холбоо байгуулагдсанаар Монголд ардчилсан хувьсгал эхэлсэн гэж үздэг. Улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөж, байвал зохих хэм хэмжээ алдагдан, нийгмийн сэтгэл зүй маш тогтворгүй болсон энэ цаг үед прокурорын байгууллага аль нэг тийш хэлбийлгүй үйл ажиллагаагаа хуулийн дагуу явуулж, олон нийтийн санаа бодлыг анхааралтай ажиглаж байв.

# 1989

## Б.БАЗАРХАНД: ОНОВЧТОЙ САНАЛ ГАРГААД УРАМШУУЛАЛ ХҮРТЭВ

Миний бие Сүхбаатар дүүргийн прокурорын газрын мөрдөн байцаалтад хяналт тавих ажил хариуцсан туслах прокуророор, Нийслэлийн прокурорын газарт Ерөнхий хяналт болон Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэст хяналтын прокуророор тус тус ажиллаж байв. Өөрчлөн байгуулалт, шинэчлэлийн давалгаа ид хүчээ авч байх үед прокурорууд бид хууль, журамд ямраар заасан, түүний л дагуу үйл ажиллагаа явуулж байсны зэрэгцээ хувийн идэвх санаачлагаа ч сулруулалгүй ажиллаж байв. 1989 онд автобусны тасалбарын үнийг 1 төгрөг болгох шийдвэр гарч 50 мөнгөний билет 2 ширхгийг таслан өгч байхыг хараад би нэгэнт 1 төгрөг болгосон шийдвэр гарсан байхад 1 билет тасалж өгөх нь гадаадад өндөр үнээр хэвлүүлдэг билетийг хэмнэх талаар тэр үеийн “Ардын эрх” сонинд бичиж нийтлүүлснээр энэ байдалд өөрчлөлт орж, 1 билет өгдөг болж Улаанбаатар хотын АДХГЗ-наас оновчтой санал гаргасан тул 500 төгрөгөөр урамшуулан шагнуулж байж билээ.

*Прокурор Б.Базархандын дурдатгалаас*

## ХУУЛИЙНХНЫГ ЦОЧРООСОН ДУУЛИАНТ НИЙТЛЭЛ

Нэрт зохиолч, сэтгүүлч Ж.Барамсайн “Шорон дотроос өшөө авагчид байдаг юм биш биз?” нэртэй шуугиант нийтлэл Үнэн сонины 258 дугаарт нийтлэгдэв. Уг нийтлэлд 1982 онд Эрдэнэт хотын ойролцоо Булган аймгийн Ингэттолгойн САА-н явуулын агент Дугархорлоо үл мэдэгдэх шалтгаанаар амиа алдсан хэргийг эргэн сөхөж, энэ хэрэгт шоронд ял эдэлж буй ялтантай тохиролцон, хүн амины хэргийг хүлээлгэж, шинээр ялтан ба гэрчүүдийг зохиомлоор бий болгодог тухай өгүүлсэн.

Энэ нь Монголын хуулийн байгууллага, ялангуяа прокурорын байгууллагын ажилтнуудын нэр хүнд ганц нэг хүний үйл ажиллагаанаас болж олон нийтийн дунд ямар ч байдлаар доргиж болохыг сануулсан ноцтой анхааруулга болсон юм.



Прокурорын удирдах ажилтны зөвлөгөөн 1989 он

# 1989



Завхан аймгийн прокурорын газрын олон нийтийн туслахын анхдугаар зөвлөгөөн, хуульчид БНМАУ-ын прокурор Ж.Балжиннямын хамт, 1989 он



БНМАУ-ын прокурорууд Тувад, 1989 он

# 1989



БНМАУ-ын прокурорын байгууллагын удирдах ажилтнууд Удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх институтэд суралцах үеэр, 1989 он



Төв аймагт болсон прокурорын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд оролцогчид, 1989 он










# ДОЛДУГААР БҮЛЭГ: 1990-1999 ОН









# 1990

**3 сарын 23.** Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн тогтоолоор “БНМАУ-ын шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх байгууллагын хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах журмын тухай хууль”-ийг батлав.

**5 сард.** 1960 онд батлагдсан БНМАУ-ын Үндсэн хуульд нэмэлт оруулж, Ардын Их хурлын 11 дэх удаагийн сонгуулийг анх удаа ардчилсан зарчмаар зохион байгуулав.

**5 сарын 10.** БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.5-д БНМАУ-ын прокурорыг БНМАУ-ын Ерөнхийлөгчийн санал болгосноор Ардын Их хурал томилох, чөлөөлөхөөр заав.

**5 сард.** Ардчилсан сонгуулийн үр дүнд бий болсон хоёр танхимтай байнгын ажиллагаатай парламент байгуулагдав.

**6 сард.** Прокурорын байгууллагын 60 жилийн ойгоор Б.Дагвадоржид БНМАУ-ын гавьяат хуульч цол хүртээв.

## Ж.БАЛЖИННЯМ: УЛС ТӨРИЙН ТЭМЦЭГЧДИЙГ БАРИВЧЛАХ, ХҮЧ ХЭРЭГЛЭХ ЭРХ БАЙХГҮЙ



Жагсаал цуглаанууд оны эхээр эрчээ авч 2 дугаар сарын 11-нд Ялалтын талбай, 3 дугаар сарын 4-нд Сүхбаатарын талбайд олон арван мянган хүн оролцсон жагсаал цуглаанууд болж, 3 дугаар сарын 7-нд улс төрийн өлсгөлөн зарлагдаж, улмаар МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсон үйл явдлууд шил дараалан өрнөв.

Энэ үед БНМАУ-ын прокуророор ажиллаж байсан Ж.Балжинням “1990 оны тэр мартагдашгүй өдрүүдэд Улсын прокурорын болон аймаг, хотын прокурорын газрууд үүрэг хариуцлагаа гүнзгий ухамсарлаж, элдэв өдөөн хатгалгад авталгүйгээр байр суурин дээрээ баттай зогсож, улс төрийн тэмцлийг тайван замаар явуулахад хяналтаа чиглүүлж байсан. Энэ үед НАХЯ-ны сайд, дэслэгч генерал А.Жамсранжав бид хоёр “Хуулийн хүрээнд улс төрийн тэмцэл явуулж буй хүмүүсийг зөвшөөрөлгүйгээр баривчлах, саатуулах, хүч хэрэглэх эрх хэнд ч байхгүй” гэдэг дээр бүрэн санал нэгтэй байсан юм. Ж.Батмөнх дарга Жамсранжав генерал бид хоёртой тэр өдрүүдэд тусгайлан уулзаж, болж байгаа асуудлын талаар санал сонсож, элдэв самуун гарахаас сэрэмжлэх, гагцхүү хэлэлцээ хийж тайван замаар Засгийн

# 1990

эрхийг шилжүүлэхээс өөр замгүй гэдэг дээр санал нийлж байлаа. Энэ үе бол Монгол Улсын прокурорын байгууллага, цагдаагийн байгууллагад нийгмийн захиалгаар оногдсон хүнд сорилт байсан юм. Хэрэв бид олон түмний улс төрийн идэвх дээд цэгтээ хүрсэн хүнд үед тэмцэлд боссон залуусаа хүчээр нухчин дарахыг оролдсон бол ямар аюултай хор уршиг тарьж, хэчнээн хүний амь насыг золиослоход хүрч болох байсныг одоо төсөөлөхөд ч бэрх.

Нийгмийн донсолгооны тэр хүнд өдрүүдэд Монгол Улсын прокурорын нэн хариуцлагатай албыг хашиж, “эмээл хазаар” бүтэн гарч, хойч үеийнхнийхээ өмнө нүүр улайх нүгэл хилэнц хийлгүйгээр гавъяаныхаа амралтад гарсандаа сэтгэл хангалуун явдаг” хэмээн тухайн цаг үеэ дурсчээ.

## ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙГ ЭХЛҮҮЛЭВ

Монгол Улс цагаан морин жил буюу 1990 оны ардчилсан хувьсгалаар улс төрийн тоталитари тогтолцоог халж, хүний эрхийг дээдэлсэн ардчилсан дэглэмтэй, өмчийн олон хэлбэрт зах зээлийн эдийн засагтай, олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрсөн эрхзүйт төр улс болон хөгжих замыг сонгов. Энэ нь эрхзүйн шинэтгэл хийх гол шалтгаан төдийгүй улс төр, эдийн засаг, нийгэм-оюун санааны урьдач нөхцөл болсон тухай гавьяат хуульч Б.Чимид дүгнэжээ.

5 дугаар сард Ардын Их хурлын 11 дэх удаагийн сонгуулийн 9 дүгээр чуулганаас “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль” баталж энэ хуулиар БНМАУ-ыг Ерөнхийлөгчтэй болгож, Улсын Бага хурлыг байгуулж ажиллуулах, СнЗ-ийг шинэчлэн зохион байгуулах, шүүх, прокурорын байгууллагын хууль тогтоомж, бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх эрхзүйн үндсийг хуульчилж өгсөн.

Үүний дагуу анхны байнгын ажиллагаатай парламент болох Улсын Бага хурал байгуулагдаж, Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын салбарт нэн шаардлагатай шинэтгэлийн чанартай 35 хууль шинээр гаргаж, БНМАУ-ын Иргэний хууль, Иргэний байцаан шийтгэх хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль зэрэг цөөнгүй хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Эдгээр нь ардчилсан тогтолцооны үе дэх прокурорын байгууллагын үндсэн чиг үүргийг шинэчлэн томьёолж, эрхзүйн шинэтгэл явуулахад шийдвэрлэх нөлөө үзүүлснийг судлаачид дүгнэжээ.

**9 сарын 2.** БНМАУ-ын АИХ-ын хуралдаанаар анхны Ерөнхийлөгчөөр П.Очирбат, Улсын Бага хурлын даргаар Р.Гончигдорж, Ерөнхий сайдаар Д.Бямбасүрэн, Дээд шүүхийн даргаар Д.Дэмбэрэлцэрэн нар сонгогдож, томилогдов.

**9 сарын 11.** БНМАУ-ын прокуророор Г.Бахдалыг томилов.

**9 сарын 27.** Улсын Бага хурлын 6 дугаар тогтоолоор БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасныг үндэслэн, БНМАУ-ын Ерөнхий прокурор нь нэгдүгээр орлогч 1, орлогч 1-тэй байхаар тогтоов.

**10 сарын 2.** БНМАУ-ын прокурорын нэгдүгээр орлогчоор М.Одонхүү, орлогчоор М.Алтанхуягийг томилов.

**11 сарын 10.** МАХН-ын Улс төрийн товчооны 316 дугаар тогтоолын мөрөөр хуулийн байгууллагын ажилтнуудыг хэрхэн хилсдүүлж байсан тухай хуульч сэтгүүлч Ш.Сүхбаатарын “Хар тогтоол” нийтлэл төрийн төв хэвлэл “Ардын эрх” сонины 52 дугаарт нийтлэгдэв.

# 1990

-Нийт прокурор, мөрдөн байцаагч нарын 99.1 хувь нь хуулийн дээд боловсролтой тухай дүн мэдээ гарав.

-Ж.Авхиаг хилсээр буруутгасан тогтоолуудыг БНМАУ-ын прокурорын эсэргүүцлээр хүчингүй болгосны мөрөөр “Ж.Авхиа улс төрийн шалтгаанаар хэлмэгдсэн бөгөөд түүнийг цагаатгасугай” хэмээсэн шүүхийн шийдвэр (2000 онд) гарчээ.

-Прокурор Д.Хишиг-Очир, С.Мишигдорж нарыг “Сүхбаатарын одон”-гоор шагнажээ.

-Б.Доржготов УБ хотын, Х.Алтанзүрх Багануур дүүргийн, Х.Мерейхан Баян-Өлгий, Ц.Цоодол Булган, Ж.Мэндсайхан Дорноговь, Ш.Цэдэн Дундговь, Д.Цэрэнбалжир Завхан, З.Ширчин Өвөрхангай, Н.Сүхээ Өмнөговь, З.Казбек Увс, Ж.Отгонбаяр Ховд, Ч.Хүрэлбаатар Хөвсгөл, Д.Одсүрэн Хэнтий аймгийн прокуророор тус тус томилогдов.

## ШИНЭ ТӨРИЙН БАГАНЫГ ТУЛАВ

1960 онд батлагдсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, анхны ардчилсан сонгууль явуулах, байнгын ажиллагаатай парламент зохион байгуулах, цаашлаад хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг тунхаглах шинэ Үндсэн хууль батлах зэрэг шинэ төрийнхөө баганыг тулах ажилд прокурорууд ханцуй шамлан оров. Прокурорын байгууллагад олон жил ажилласан Н.Жанцан анхны ардчилсан сонгуулиар АИХ-ын депутат, Улсын Бага Хурлын гишүүнээр сонгогдон Үндсэн хуулийг боловсруулах, батлах ажиллагаанд биечлэн оролцсон бол БНМАУ-ын



прокурорын нэгдүгээр орлогч М.Одонхүү 1990 оны сүүлээр байгуулагдсан Монгол Улсын Үндсэн хууль боловсруулах ажлыг зохион байгуулах комисст прокурорын байгууллагаа төлөөлөн орж ажиллажээ. Мөн олон жил прокурорын байгууллагыг удирдаж явсан төрийн зүтгэлтэн Ж.Авхиа АИХ-ын депутатаар сонгогдож, Үндсэн хуулийг хэлэлцэн батлах үйлсэд гар бие оролцжээ.

## ХЭЛТСИЙН ПРОКУРОР ХЯНАЛТЫНХ БОЛОВ

1990 онд засаг захиргааны бүтцийн өөрчлөлтөөр Нийслэл хот есөн дүүрэгтэй болсноор Нийслэлийн прокурорын газар, түүний харьяа Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Хан-Уул, Багануур-

# 1990

Багахангай, Налайх дүүргийн прокурорын газрууд бүгд 10 нэгжтэй, 67 прокурор, 33 бага тушаалын орон тоотой ажиллаж эхлэв.

Улаанбаатар хотын прокурорын 12 дугаар сарын 17-ны өдрийн тушаалд "...Хотын прокурорын төв аппаратыг хэлтэсгүй зохион байгуулалтад шилжих болсонтой холбогдуулан Ерөнхий, Тусгай, Шүүх, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Хэрэг бүртгэх, Мөрдөн байцаах ажилд хяналт тавих хэлтсүүдийг татан буулгаж, Мөрдөн байцаах хэлтсийг Мөрдөн байцаах алба болгон өөрчилж даргыг нь прокурорын эрхгүйгээр туршилтын журмаар ажиллуулжээ. Боловсон хүчин, хяналт шалгалт хариуцсан туслахыг Зохион байгуулалт, боловсон хүчин эрхэлсэн туслах болгон өөрчилж, бүх хэлтсийн прокуроруудыг хяналтын прокурор болгон нэрлэсэн" байна.

## ДУУЛИАНТ НИЙТЛЭЛИЙН МӨРӨӨР

Өмнөх жилд Үнэн сонинд гарсан "Шорон дотроос өшөө авагчид байдаг юм биш биз?" нийтлэлийн араас "Хуульчид өөрсдөө багаа хууллаа" нийтлэлийг сэтгүүлч Ж.Барамсай бичив. Нийтлэлийн мөрөөр БНМАУ-ын прокурор Ж.Балжиннямын тушаалаар Улсын прокурорын газрын чухал хэргийг мөрдөх тасгийн дарга Т.Сүхбаатар, шилдэг мөрдөн байцаагч Догсом, Дэрэм нар цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагчидтай хамтран Архангай, Булган, Орхон аймагт багагүй хугацаанд ажиллаж, 25 мянган хуудас, 120 гаруй хавтаст хэргийг нарийвчлан шалгасны үр дүнд хэрэгт авагдсан мөчид баримтаар гэм зэмгүй хүмүүсийг шийтгэснийг олж тогтоон Улсын Дээд шүүхэд дүгнэлт бичиж явуулжээ.

## БНМАУ-ЫН ПРОКУРОР ГОМБОДОРЖИЙН БАХДАЛ



БНМАУ-ын прокуророор 1990-1993 онд ажилласан Г.Бахдал Дорнод аймагт 1954 онд төржээ. Тэрбээр 1978 онд Эрхүүгийн Улсын Их сургуулийг хуульч мэргэжлээр төгсчээ.

Г.Бахдал 1978 оноос Улсын прокурорын газарт чухал хэргийн мөрдөн байцаагч, Сэлэнгэ аймгийн прокурорын газрын орлогч прокурор, Өмнөговь аймгийн прокурор, 1988-1990 онд Улсын прокурорын Шалган зааварлах хэлтсийн дарга, 1990-1993 онд БНМАУ-ын прокуророор ажиллажээ.

Г.Бахдал шилжилтийн амар-гүй цаг үед Улсын прокурорын хариуцлагатай албыг нэр төртэй хашиж, тус байгууллагын эрх зүйн орчин, үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үнэлэгддэг. Тодруулбал төрийн шинэ тогтолцоонд прокурорын байгууллагын эзлэх байр суурийг зөв томъёолох ажлыг удирдаж Үндсэн хуульд тусгуулж чадсан юм.

# 1990

## БНМАУ-ЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ БАЛЧИНГИЙН ДАГВАДОРЖ



Б.Дагвадорж 1933 онд төржээ. Тэрбээр 1970 онд МУИС-ийн хуулийн анги төгсчээ.

Б.Дагвадорж 1960-1963 онд аймгийн прокурорт мөрдөн байцаагч, 1963-1990 онд Улаанбаатар хотын прокурорт мөрдөн байцаагч, хяналтын болон туслах прокурор, нэгдүгээр орлогч прокуророор ажиллахдаа прокурор цагдан сэргийлэхийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажилд хяналт тавих, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, хяналтын ажлыг удирдах зэргээр дан мөрдөн байцаалтын ажил хариуцан ажиллаж БНМАУ-ын АИХ-ын депутатаар сонгогдож байсан байна. Түүнд БНМАУ-ын Гавьяат хуульч цолыг 1990 онд олгожээ.

## МҮҮЗЭЭГИЙН ОДОНХҮҮ



М.Одонхүү Улаанбаатар хотод 1957 онд төржээ. Тэрбээр 1981 онд ЗХУ-ын Ленинград хотын Улсын их сургуулийг хуульч мэргэжлээр төгсөж, 1981 оноос Сүхбаатар аймгийн прокурорын орлогч, 1982 оноос Улаанбаатар хотын прокурорын газарт мөрдөн байцаагч, хэлтсийн болон туслах, орлогч прокурор, 1990 оны 10-р сараас БНМАУ-ын Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогч, 1992 оны 2-р сараас Монгол улсын Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогчоор ажиллажээ.

## МОНГОЛ УЛСЫН БАГА ХУРЛЫН ГИШҮҮН ЖАНЛАВЫН БЯМБАЖАВ



Ж.Бямбажав нь 1953 онд Архангай аймгийн Жаргалант суманд төрж, 1971-1977 онд Эрхүүгийн Их сургууль төгсчээ.

Тэрбээр 1977-1978 онд Найрамдлын районы прокурорын газар Шүүхийн хяналт эрхэлсэн прокурор, 1978-1986 онд Улсын ерөнхий прокурорын газар Хэлтсийн прокурор, тасгийн дарга, 1986-1990 онд Монголын Өмгөөлөгчдийн холбооны анхны эмэгтэй дарга, 1990-1992 онд Монгол Улсын Бага Хурлын гишүүн, 1992-1996 онд Улсын Их Хурлын гишүүн, 1996-2002 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн анхны эмэгтэй гишүүн, 2002-2012 онд Үндсэн хуулийн Тамгын газрын референт, ахлах зөвлөх, 2012 оноос Үндсэн хуулийн цэцийн орон тооны бус зөвлөхөөр ажиллаж байна.

# 1991

8 сарын 19. Прокурорын дэргэдэх намын хороо, үүрүүд татан буугдав.

8 сарын 24. Чойр хотын прокурорын газрыг байгуулав.

-БНМАУ-ын Батлан хамгаалах яам, Улсын Ерөнхий прокурорын А40/23 дугаар тушаалаар Улаанбаатар гарнизоны болон Арвайхээр дэх цэргийн прокурорын газруудыг татан буулгав.

-Л.Цэнддоо нийслэлийн Найрамдлын, Б.Галдаа Ажилчны районы прокуророор, Д.Цэндцэсэм Баганаар хотын, С.Дамчаасүрэн Дундговь, Н.Сосорбарам Хөвсгөл аймгийн, Ж.Бат-Эрдэнэ Тээврийн прокуророор томилогдов.

## ШҮҮХ, ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАНА

БНМАУ-ын Бага хурлын 1991 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 10 дугаар тогтоолоор “БНМАУ-ын шүүх, прокурорын байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол гаргав. Тогтоолд шүүх, прокурорын байгууллагын хараат бус байдлыг хангах зорилт тавьж дараахь арга хэмжээ авчээ.

1. Ардын төлөөлөгч нарын шүүхэд үүргээ гүйцэтгэсэн хугацааны дундаж цалинг шүүхийн төсөвт тусган гүйцэтгэлээр олгож байх;

2. Шүүх хурлын дэг сахиулах, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэх баталгааг сайжруулах зорилгоор аймаг, хотын болон тусгай шүүх, орон нутгийн хот, дүүргийн шүүхүүдэд шүүх хурлын харгалзагчийн орон тоо бий болгох;

3. Шүүх хурлын харгалзагч, тогтоол гүйцэтгэгч нарыг албаны дүрэмт хувцастай болгож, тэдгээрт цол олгох журам тогтоох;

4. Улсын дээд шүүх, Улсын прокурорын газарт жилийн цалингийн сангийн 10 хувиар тооцож болзошгүй арга хэмжээний зардлын санг бий болгох;

5. Монголын өмгөөлөгчдийн холбоог бие даасан статусаа хадгалж аж ахуйн тооцоотой ажиллах чадвартай болтол нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

6. Хуулийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах системийг боловсронгуй болгож, шүүх, прокурорын байгууллагын албан контор, ажиллагчдын орон сууцны хүрэлцээ, нөхцөлийг сайжруулахыг үүрэг болгосон байна.

## Б.ГАЛДАА: ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫГ ҮГҮЙСГЭХИЙГ ОРОЛДОВ

Ажилчны районы прокуророор миний ажилласан цаг хугацаа Монгол Улс ардчилсан зах зээлийн шинэ харилцаанд дөнгөж шилжсэн, эрхзүйн шинэ харилцааны үндэс суурь нь эхлэл төдий, шинэ хуучин хоёрын завсрын

# 1991

үетэй давхацсанаас шалтгаалан прокурорын чиг үүргээ биелүүлэх, хуулийг хэрэглэх ажиллагаанд багагүй бэрхшээл, ил далд дарамт, тэр ч бүү хэл прокурорын хяналтыг илтэд үгүйсгэх оролдлого ч цухалзаж байсан.

1990-ээд оны эхэн үед дэг журам илтэд суларч үүнийг даван туулахад Улсын прокурорын тухайн үеийн шийдмэг бодлого,



прокурорын бүх шатны байгууллагын нэгдмэл ажиллагаа, прокуроруудын хуулиа дээдлэх, мэргэжил, ёс зүйгээ эрхэмлэх тууштай зан чанар, орон нутгийн төр, захиргааны байгууллагын дэмжлэг, хуулийн хүрээнд хууль, хяналтын бусад байгууллагатай хамтран ажиллах чадвар, арга ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

*Прокурор Б.Галдаагийн дурдатгалаас*

## ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ НАМЫН БАЙГУУЛЛАГУУД ТАТАН БУУГДАВ

Хойд хөршид төрийн эргэлт хийх оролдлого 8 дугаар 19-нд гарч, үүнийг тус улсын ардчиллын үйл явцад бодит аюул учруулсан явдал хэмээн судлаачид тодорхойлдог. Энэхүү төрийн эргэлт хийх оролдлогын дараа ОХУ-д коммунист намын үйл ажиллагааг зогсоож, хөрөнгийг нь хураасан. Үүнээс улбаалан манай Улсын Бага хурал ЗХУ-д төрийн эргэлт хийх гэсэн оролдлогыг эрс эсэргүүцэн тогтоол гаргахын хамт Улс төрийн намын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж аливаа улс төрийн намыг нутаг дэвсгэрийн зарчмаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу хууль хяналтын байгууллагууд, түүний дотор прокурорын дэргэдэх намын хороо, үүрүүд татан буугдав.

## ЧОЙРТ ПРОКУРОРЫН ГАЗАР БАЙГУУЛАГДАВ


Улсын Бага хурлын 8 дугаар сарын 24-ний тогтоолоор Дорноговь аймгийн прокурорын газраас тусгаарлуулан Чойр хотын прокурорын газрыг (ирээдүйн Говьсүмбэр аймгийн прокурорын газар) хотын прокурор 1, орлогч прокурор 1, туслах прокурор 3, мөрдөн байцаагч 1, хэсгийн прокурор 2 орон тоотой байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлжээ.

Чойр хотын анхны прокуророор Т.Түвшинбаярыг 9 дүгээр сарын 1-ний өдрөөс томилон ажиллуулжээ.

# 1991

## ТАНИЛЦУУЛАХГҮЙ БАЙХ АРГАГҮЙ БОЛЖЭЭ

Бараа, үйлчилгээний үнэ өсч, төгрөгийн худалдан авах чадвар муудаж, хөдөлмөрчдийн амьжиргааны түвшин доошилж байгаа шилжилтийн хүндрэлтэй нөхцөлд прокурорын байгууллагын боловсон хүчнийг тогтворшуулах, нөхөн хангахад бодитой бэрхшээл учирч байгааг БНМАУ-ын дэд Ерөнхийлөгч, Улсын Бага хурлын дарга Р.Гончигдорж, БНМАУ-ын



БНМАУ
УЛСЫН ПРОКУРОРЫН
ТАНИЛЦУУЛГА

БНМАУ-ын дэд Ерөнхийлөгч, Улсын Бага хурлын
дарга Р.Гончигдорж, БНМАУ-ын Засгийн газрын
Ерөнхий сайд Д.Бямбасүрэн нар танаа

Прокурорын ажилтны цалин
хангамжийн тухай

Бараа, үйлчилгээний үнэ өсч, төгрөгийн худалдан авах чадвар
муудажхөдөлмөрчдийн амьжиргааны түвшин доошилж байгаа шилжилтийн
нөхцөлд прокурорын байгууллагын боловсон хүчнийг
тогтворшуулах, нөхөн хангахад бодитой бэрхшээл учирч байгааг тэр.
дээд байгууллагаа танилцуулжкгүй гэлээ аргагүй болоо.

Улсын Бага Хурлын 1991 оны 10 дугаар тогтоолоор шүүх,
прокурорын байгууллагын ажилтны цалингийн схемийг шинэчлэн
батласнаар прокурор, мөрдөн байцаагч нарын цалингийн хэмжээ 10-20
хувь нэмэгдсэн юм.

Шүүх, прокурорын байгууллагын одоо хүртэл явж ирсэн зохион
байгуулалт, үйл ажиллагааны тогтолцоонд эдгээр байгууллагын ижил
эрхзүйлийн албан тушаалд ажиллагчдын мэргэшил, чадварын түвшинг
адилтган үнэлж, сонгон томилдог, цалин хангамж нь ч адил байсан
учраас хүмүүсийн сэтгэлгээ, ойлголт ч тэр байдалд хоногшин
дасчээ.

Шүүхийн засаглалыг төлөвшүүлэхэд чиглэсэн зохион
байгуулалтын өөрчлөлтийг бодитой хийж эхэлсэн, хийсэн нөхцөлд
дүгчийн цалин хангамж хуулийн бусад ажилтнаасаа илүү өндөр байх
нь зүйн хэрэг.

Гэтэл хуулийн байгууллага
ажилтнууд
сье.

ЕРӨНХИЙ ПРОКУРОР Г.БАХДАЛ

Ерөнхий сайд Б.Бямбасүрэн нарт 1991 оны 10 дугаар сарын 24-нд Ерөнхий прокурор Г.Бахдал “Прокурорын ажилтны цалин хангамжийн тухай” танилцуулахгүй байх аргагүй болсноо илтгэжээ.

“Улсын Бага хурлын 1991 оны 10 дугаар тогтоолоор шүүх, прокурорын байгууллагын ажилтны цалингийн схемийг шинэчлэн баталснаар прокурор, мөрдөн байцаагч нарын цалингийн хэмжээ 10-20 хувь нэмэгдсэн юм.

Шүүх, прокурорын байгууллагын одоо хүртэл явж ирсэн зохион байгуулалт, үйл ажиллагааны тогтолцоонд эдгээр байгууллагын ижил эрхзүйлийн албан тушаалд ажиллагчдын мэргэшил, чадварын түвшинг адилтган үнэлж, сонгон томилдог, цалин хангамж нь ч адил байсан учраас хүмүүсийн сэтгэлгээ, ойлголт ч тэр байдалд хоногшин дасчээ. Гэтэл хуулийн байгууллагын хуучин тогтолцоо, тэдгээрийн ажилтнуудын гүйцэтгэж буй ажил үүрэг хэвээр байгаа бодит нөхцөл байдлыг үл харгалзан шүүгч, прокурорын цалингийн хэмжээг хэтэрхий их зөрүүтэй тогтоожээ.

Прокурорын байгууллагын ажлын голыг нугалдаг, нийт ажилтны олонх нь болдог хэсгийн прокурорын үндсэн цалин хэсгийн шүүгчийнхээс 300 төгрөгөөр, цол, шүүн таслах ажлын нэмэгдлийг оролцуулсан дүнгээр бол 435 төгрөгөөр бага болов.

...Сүүлийн 1 жил 10 сарын хугацаанд манай 40 шахам ажилтан хүсэлтээрээ ажлаас чөлөөлөгдөж... боловсон хүчний алдагдал нэмэгдэж байна.

Оны эхэн үед манай ажилтнууд прокурорын байгууллагын ирээдүйн хувь заяанд эргэлзэж, санаа хоёрдох, ажиллах идэвх нь сулрах хандлагатай байснаа сүүлийн үед цалин хангамжаа хангалтгүй байна гэж идэвхгүй байдалд орох төлөвтэй болоод байна. Энэ байдал цааш үргэлжилбэл шилдэг боловсон хүчнээ алдаж, эцэст нь цалин нэмээд ч төрийн энэ байгууллагыг бэлтгэгдсэн ажилтнаар хангаж чадахгүйд хүрч болзошгүй тул урьдчилан арга хэмжээ авах нь чухал байна” хэмээн танилцуулсан байна.

# 1992

1 сарын 13. Монгол Улсын дөрөв дэх Үндсэн хууль батлагдав.

7 сарын 1. УИХ-ын тогтоолоор Прокурорын байгууллагын мөрдөн байцаах албыг орон тоо, төсөв, эд хөрөнгийн хамт Цагдаагийн Ерөнхий газарт шилжүүлжээ.

8 сарын 18. УИХ-ын 18 тоот тогтоолоор Улаанбаатар хотын 6 район, 4 хороог татан буулгаж, шинээр найман дүүрэг байгуулснаар, прокурорын байгууллагын бүтцэд өөрчлөлт оров.

-БНМАУ-ын прокурорыг Улсын Ерөнхий прокурор болгон өөрчлөв.

-Улсын Ерөнхий прокурорыг УИХ-тай зөвшилцөн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс зургаан жилийн хугацаагаар томилох болов.

-УИХ-ын тогтоолоор БНМАУ-ын прокурорын газрыг Монгол Улсын Ерөнхий прокурорын газар болгон өөрчлөв.

-Прокурорын байгууллагын чиг үүрэг, бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан Улсын Ерөнхий прокурорын газарт Хэрэг эрхлэх газар байгуулав.

## ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХЗҮЙН ҮНДЭС ТАВИГЧИД

1990-1992 оны хооронд, Үндсэн хууль батлагдах хүртэл ахархан хугацаанд прокурорын байгууллага ямар статус, чиг үүрэгтэй байх талаар янз бүрийн түвшинд өөр өөр хувилбар яригдаж, прокурорын хяналтыг бүхэлд нь үгүйсгэх байр суурь ч илэрч байв. Энэ бүхэнд шинэ Үндсэн хууль цэг тавив.



Улсын Ерөнхий прокурор Г.Бахдал, Үндсэн хууль боловсруулах комисст прокурорын байгууллагыг төлөөлөн ажилласан Улсын Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогч М.Одонхүү, анхны ардчилсан сонгуулиар АИХ-ын депутат, УБХ-ын гишүүнээр сонгогдсон Н.Жанцан, Улсын Бага хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны даргаар ажиллаж байсан Н.Ганбаяр, 1985-1989 онд Улсын прокурорын хэлтсийн даргаар ажилласан Д.Лүндээжанцан (1990-1992 онд Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн) нарын олон хуульчид прокурорын байгууллагаа шинэ цаг үеийн төрийн багана болгох, эрхзүйн үндсийг нь тавихад онцгойлон зүтгэсэн байна. М.Одонхүү “Бид, энэ ажилд их ч цаг, хүч зарцуулсан. Олон хүний хүч хөдөлмөрийн үр дүнд бүтсэн зүйл. Тэр бүхнийг түүхчлэн бичнэ гэвэл нэгэн дурдатгалд багтахгүй. Бидэнд чиг гаргаж өгөх, шинэ санаа, сэдэл хэлэх талаар тухайн үед БНМАУ-ын Бага Хурлын гишүүн, нарийн бичгийн дарга Б.Чимид гуай их тусалсныг зориуд тэмдэглэх хэрэгтэй” хэмээжээ.

# 1992

## ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ ДҮЙЦҮҮЛЭВ

Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар прокурорын байгууллагыг “Монгол Улсын төрийн байгуулал” хэмээх гуравдугаар бүлгийн “Шүүх эрх мэдэл” хэсэгт хамааруулан тодорхой заав. Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд прокурорын үндсэн чиг үүргийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд тус тус хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцохоор тодорхойлжээ.

Түүнчлэн прокурорын байгууллагын чиг үүргээс хуулийн биелэлтэд дээд хяналт тавих хяналт, (ерөнхий хяналт) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тодорхой төрлийн гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулах, шүүхийн шүүн таслах ажиллагаанд хяналт тавих (шүүхийн хяналт), иргэний хэрэг үүсгэх зэрэг эрх хасагдав. Ерөнхий хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхгүй болсноор үйл ажиллагаа нь зарим талаар хумигдсан ч хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх тодорхой төрлийн гэмт хэрэгт хяналт тавих байдлаар улам гүнзгий орж ажиллах боломжтой болсон, шүүх эрх мэдлийг хянаж, түүнийг “гартаа авах” байдлаар социализмын үеийнх шигээ бус, харин түүнийг түшиглэн, хүрээнд нь багтаж ажиллах болсноор олон улсын хуулийн байгууллагын жишигт дүйцэхүйц болсон тухай судлаачид дүгнэжээ.

## БНМАУ-ЫН ПРОКУРОРУУДТАЙ ЗӨВШИЛЦӨВ

Үндсэн хуульд “Прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрхзүйн үндсийг хуулиар тогтооно” гэсэн нь прокурорын байгууллагын тухай хууль гаргах үндсийг тавьж өгчээ.

Прокурорууд байгууллагынхаа тухай хууль боловсруулах ажилдаа ханцуй шамлан орлоо. Хуулийн төсөл боловсруулах ажлыг Улсын Ерөнхий прокурор Г.Бахдал өөрөө удирдан зохион байгуулж, төслийн олон хувилбар боловсруулав.

Хуулийн төсөлд санал авахаар Улсын Ерөнхий прокурор Г.Бахдал Улсын прокуророор ажиллаж байсан

-УИХ-ын тогтоолоор Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Багануур, Налайх дүүргийн прокурорын газруудыг байгуулав.

-БНХАУ-ын Ерөнхий прокурорын урилгаар Улсын Ерөнхий прокурор Г.Бахдал тэргүүтэй төлөөлөгчид өмнөд хөршид айлчлав.

-Прокурор Б.Цэрэнбалтав “Ёнзон хамбаар толгойлуулсан лам нарын эсэргүү бүлгэм”, “П.Гэндэн, Дэмид, Лхүмбийн Японы тагнуулын эсэргүү байгууллага” гэдэг нь зохиомол хилс хэрэг болох талаар Улсын Бага Хуралд танилцуулга бичив.

-Д.Рагчаабазар Архангай, Я.Сайнжаргал Баянхонгор, Ж.Баатар Говь-Алтай, С.Баттөмөр Төв, Н.Батначин Увс, Т.Хадхаан Ховд аймгийн прокуророор, Д.Цэндцэсэм Багануур дүүргийн прокуророор томилогдов.

# 1992

## МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ ГАЛДАНГИЙН СОВД



Г.Совд Увс аймгийн Завхан суманд 1930 онд төржээ. Тэрбээр Хууль цаазын дунд сургууль, Свердловск хотын их сургууль сурал-цан төгсч, Хууль зүйн ухааны дэд эрдэмтэн, Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалжээ.

Г.Совд 1954-1956 онд Увс аймгийн прокурорт мөрдөн байцаагч, 1958-1959 онд Хууль цаазын дунд сургуульд багш, 1962-1964 онд Улсын Дээд Шүүхийн гишүүн, 1964-1974 онд МУИС-д тэнхимийн эрхлэгч, 1974-1978 онд Улсын Дээд Шүүхийн нэгдүгээр орлогч дарга, 1978-1979 онд Улсын прокурорын нэгдүгээр орлогч, 1979-1984 онд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн газарт хэлтсийн дарга, 1984-1985 онд Улаанбаатар хотын прокурорт хяналтын прокурор, 1985-1989 онд МУИС-д багш, тэнхмийн эрхлэгч, 1989-1991 онд ШУА-ийн Төр, эрх зүйн хүрээлэнгийн захирал, 1991-1992 онд МУИС, ШУА-ийн хууль зүйн сургалт эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, 1992-1998 онд Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн гишүүн, Цэцийн анхны дарга, 1998-2005 онд Удирдлагын академийн эрх зүйн тэнхмийн эрхлэгч, багшаар ажиллаж байв.

С.Жалан-Аажав, Д.Ёндондүйчир, Ж.Авхиа, С.Бүдрагчаа, Ж.Балжинням нарыг урьж уулзан боловсруулсан хуулийн төслийг танилцуулан санал солилцож байв. Ингээд багагүй хугацааны туршид боловсруулсны эцэст Прокурорын байгууллагын тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн Ц.Нямдорж, Г.Ганболд нарын зүгээс Улсын Их хурлаар хэлэлцүүлэхээр өргөн барьжээ.

## ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Монгол Улсын прокурорын байгууллагын бүтцийг шинээр зохион байгуулахад Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрыг байгуулав. Хэрэг эрхлэх газарт захиргааны удирдлага, боловсон хүчин, дотоод хяналт, төсөв санхүү, гадаад харилцаа зэрэг хэлтэс, тасгийн хариуцаж байсан ажлыг нэгтгэсэн байна. Хэрэг эрхлэх газрын анхны даргаар 5 дугаар сарын 1-нд Ж.Чойжанцанг томилов. Аймгуудын прокурорын газрын төсөв орон нутагт байсныг төвлөрүүлэн Хэрэг эрхлэх газарт авахад зарим аймгийн прокурорын төсөв өртэй байжээ.

## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ ДЭХ ПРОКУРОРУУД

Монгол Улсын Үндсэн хуулийг сахиулах шүүх байгууллагыг бий болгосон цагаас эхлүүлэн, төдийгөөс өдий хүртэл Үндсэн хуулийн Цэцийн танхимд мэргэжлээрээ хүлээн зөвшөөрөгдсөн прокурорууд хуульчийн ур ухаанаа уралдуулсаар ирэв.

Улсын Бага хурлын хуралдаанаар Үндсэн хуулийн Цэцийн анхны бүрэлдэхүүн гишүүдийг батлахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Жавхлангийн Бямбаа, Навааннэрэнлэйн Жанцан, Галдангийн Совд нарыг, Улсын

# 1992

Дээд шүүхийн санал болгосноор Жамцын Чойжанцанг Үндсэн хуулийн Цэцийн гишүүнээр тус тус томилжээ. Улмаар 1954-1956 онд Увс аймгийн прокурорын газарт мөрдөн байцаагчаар ажлын гараагаа эхлүүлж, 1978-1979 онд Улсын прокурорын нэгдүгээр орлогч, 1984-1985 онд Улаанбаатар хотын прокурорын газрын хяналтын прокуророор ажиллаж байсан Г.Совдыг Үндсэн хуулийн Цэцийн анхны даргаар сонгожээ. Үндсэн хуулийн Цэцийн анхны гишүүдийн нэг Н.Жанцан 1972 онд Улсын прокурор Ж.Авхиагийн санголтоор прокурорын байгууллагад ажлын гараагаа эхлүүлж, прокурорын дэргэдэх Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнаас захирал хүртэл, Улсын прокурорын туслах бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн даргын албыг хаших зэргээр прокурорын байгууллагад 15 жил ажиллаад байв. Тэрээр АИХ-ын депутат, Улсын Бага хурлын гишүүнээр шинэ Үндсэн хуулийг батлалцаж, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүнээр томилогдсоноос хойш Цэцийн дарга, орлогч дарга, гишүүнээр тасралтгүй 26 жил ажилласан.

Мөн ялгаагүй Ж.Чойжанцан 1969 онд Төв аймгийн прокурорын газраас хуульчийн ажлын гараагаа эхлүүлж, Төв аймгийн прокурор, Улсын Ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын анхны даргаар ажиллаж байсан. 1992 онд Үндсэн хуулийн Цэцийн анхны гишүүдийн нэгээр томилогдсон ч удалгүй прокурорын байгууллагадаа Улсын Ерөнхий прокурорын орлогчоор эргэн ирсэн байдаг.

## МӨРДӨН БАЙЦААХ АЛБЫГ ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ ШИЛЖҮҮЛЭВ

Монгол Улсын Бага хурлын 1991 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн “Прокурорын байгууллагын үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн зохицуулах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолоор прокурорын байгууллагын мөрдөн байцаах албыг орон тоо, төсөв, эд хөрөнгийн хамт 1992 оны 7 дугаар сарын 1-ний дотор Цагдаагийн Ерөнхий газарт шилжүүлэхийг Улсын прокурорын газар, Засгийн газарт зөвшөөрч, Мөрдөн байцаах албаны бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авахыг үүрэг болгосон байна.



БНМАУ-ын прокурор Г.Бахдал тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д айлчлав

# 1992

## Г.БАХДАЛ: МИНИЙ ҮЕ УЛС ОРНЫ ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ОГЦОМ ЭРГЭЛТИЙН ЖИЛҮҮД БАЙЛАА

Манай улсад 1990 онд явагдсан анхны ардчилсан сонгуулиар байгуулагдсан БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганы 1990 оны 9 сарын 11-ний өдрийн хуралдаанаас БНМАУ-ын Ерөнхий прокуророор томилогдсон Г.Бахдалтай ярилцлаа.

**-1990-ээд оны эхэн үед прокурорын байгууллага хүнд сорилттой тулгарсан. Таныг Ерөнхий прокурорын ажил хүлээн авахад байдал ямар байсан вэ?**

-Миний БНМАУ-ын Ерөнхий прокуророор томилогдсон цаг үе нь манай улс орны түүхэн хөгжлийн огцом эргэлтийн нэн ээдрээтэй цаг үе байлаа. Халагдаж буй нийгмийн үед бүрэлдэн тогтсон бараг бүх зүйлийг бүхэлд нь хавтгайруулан үгүйсгэх үзэл нийгмийн сэтгэхүйд давамгайлж байсны дотор өмнөх нийгмийн төрийн тогтолцооны чухал механизм болж байсан прокурорын байгууллага болон түүний хяналтыг шинэчлэн сайжруулья гэхээс илүү түүнийг хэрэг дээрээ халж үгүй болгох, үгүйдээ гэхэд прокурорын эрх хэмжээг ёс төдий болтол нь хязгаарлах гэсэн туйлшрал хүмүүсийн дунд, ялангуяа хуулийн бусад байгууллага, хуульчдын зүгээс маш хүчтэй түрхрэн давалгаалж байв. Энэ хандлага Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль болон Прокурорын байгууллагын тухай хууль батлагдан гарах хүртэл эрчтэй хэвээр үргэлжилсэн юм. Зарим нь “Англи мэт өндөр хөгжилтэй барууны орнуудад прокурор гэж байдаггүй юм, тиймээс энэ байгууллагыг бүр татан буулгая” гэсэн санал ч гаргаж байв.

Өмнөх нийгмийн нам, засгийн дээд удирдлагуудын эсрэг үүсгэсэн “Тойрон хүрээлэгчдийн” гэж нэрлэгдсэн хэрэг тэр үеийн нийгмийн бухимдал тайлах нэг золиос, халагдаж буй нийгэмтэй тооцоо бодох өсөрхөлийн нэг бай болж байлаа. Энэ хэргийг бүр 1990 оны эхээр БНМАУ-ын Прокурор Ж.Балжиннямын санаачилгаар тус газрын Мөрдөн байцаах алба эрүү үүсгэн шалгаж эхэлсэн бөгөөд албан үүргийн хувьд мөрдөн байцаах ажиллагаанд нь биечлэн оролцож байгаагүй учир би тэр хэргийн талаар нарийн ширийнийг мэдэхгүй байв. Харин Ерөнхий прокурор болсны дараа хэргийг нарийвчлан танилцаад, явцыг нь хянаад үзэхэд тэдэнд холбогдуулан буруутгаж байсан үйлдлийг тухайн үеийнх нь хуулиар гэмт хэрэг гэж тооцох эрх зүйн ямар ч боломжгүй гэдэг нь тодорхой болсон. Эцэст нь тэр хэргийг Дээд шүүх хэрэгсэхгүй болгосныг зүй ёсны зөв шийдвэр гэж бид үзээд эсэргүүцээгүй орхисон юм.

**-Улс орныг бүхэлд нь хянаж байсан прокурорын ерөнхий хяналт татан буугдсан. Энэ хэр зөв байсан бэ?**

-БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуульд заасан прокурорын байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, эрх хэмжээ нь тухайн үеийн нийгмийн тогтолцоондоо тохирч байсан. Үйлдвэрлэлийн бүх хэрэгсэл төрийн өмчлөлд байсан тэр үед прокурор өмчлөгчийн нүд, чих болж бүхнийг хамарсан ерөнхий хяналт тавих эрх, үүрэгтэй байв. Ер нь аливаа нийгэмд өмчийн харилцаа бусад бүх харилцааны эх суурь нь болдог. Тиймээс хуулийн биелэлтийг хянах прокурорын олон талт үүргийн зорилго нь эцсийн дүндээ өмчийн эзний эрх ашгийг хамгаалахад л төвлөрч байсан юм. Гэтэл 1992 оны Үндсэн хуулиар төрийн өмчийн дагнасан ноёрхолыг халж, улс орны эдийн засагт хувийн сектор давамгайлах чиг хандлагатай болсон учир прокурорын ерөнхий хяналт хуучин хэвээр үргэлжлэх эрх зүйн суурь үндэсгүй болсон. Жишээ нь, 100 хувь хувьчлагдсан үйлдвэрт төрийн нэрийн өмнөөс хяналт тавьдаг прокурор очоод юуг нь хянах билээ? Тэнд төрийн өмчөөс

# 1992

үүдэлтэй төрийн ашиг сонирхол үндсэндээ байхгүй шүү дээ. Хувийн компанийн өмчийн асуудалд төр хөндлөнгөөс оролцох ганц шижим нь албан татвар байдаг. Тэр нь татварын албаны хийх ажил. Төрөөс стандарт тогтоож түүний биелэлтийг хянаж байх ёстой. Энэ утгаар бол төрөл бүрийн мэргэжлийн хяналт төрд байх нь зүйн хэрэг. Гэхдээ энэ нь хуулийн биелэлтийг хянах ажил биш, техник технологийн хяналт юм. Энэ бол прокурорын үүрэг биш. Прокурор гэж хэн билээ? Зөвхөн хуульч. Түүнээс инженер, санхүүч, эмч, технологич биш. Хэн ч байлаа гэсэн мэргэжлийнхээ ажлыг л хийх ёстой. Гэтэл прокурор одоогийн Улсын Мэргэжлийн хяналтын газрын хийж байгаа ажлыг л хийх гэж оролддог байж л дээ. Зөвхөн энэ үүднээс харсан ч ерөнхий хяналт гэдэг нь прокурорын шууд үүрэг биш нь хэнд ч илэрхий.

Өмч хувьчлалыг зөв зохистой явуулах ажлыг Засгийн газар болон түүний харьяа Төрийн өмчийн хороо хариуцаж байсан. Энэ ажил 1996-2000 оны хооронд л эрчимтэй явагдсан шүү дээ. Харин өмч хувьчлалын явцад хууль бус арга хэрэглэсэн, төрийн өмчийг хууль бусаар авсан, завшсан асуудал гарвал эрүүгийн журмаар шалгах ёстой бөгөөд тэр шатанд бол прокурор чиг үүргээ гүйцэтгэх учиртай. Ийм гэмт хэрэг гарч байгаа эсэхийг прокурор хянах эрх, үүрэгтэй байсан. Харин энэ үүргээ биелүүлж чадаж байсан эсэх нь бол өөр асуудал.

**-1992 оны Үндсэн хуулийн төсөлд прокурорын байгууллагын талаар ямар санал өгч байв?**

-Бид төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчихийн эсрэг прокурорын хяналт (наад зах нь шилжилтийн үед) чиглэх ёстой гэж үзэж байсан. Одоогийн өндөрлөгөөс харахад энэ нь захиргааны хэргийн шүүхийн харьяалах асуудал боловч 1990-ээд оны турш ийм эрх, үүргийг прокурорт хариуцуулсан бол нэг их гай болохгүй л байсан болов уу. Захиргааны актыг прокурор шууд хүчингүй болгохгүй ч гэсэн шүүхийн өмнөх шатанд зөрчлийг засуулахаар шаарддаг эрхтэй байж болох л байж. Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль биелүүлэх үйл ажиллагаанд прокурор хяналт тавих ёстой гэсэн манай байр суурийг хууль тогтоогч хүлээж аваагүй.

**-Үндсэн хуулийн болоод Прокурорын байгууллагын тухай хуулийн төсөл боловсруулан хэлэлцүүлэх шатанд та ямар байр суурьтай байв?**

-Би ч юу байхав бид прокурорын байгууллагын үндсэн гол чиг үүрэг нь эрүүгийн мөрдөн мөшгих ажиллагаа (уголовное преследование) байх ёстой гэсэн концепцийг баримталж байсан. Үүнээс үүдээд прокурор эрүүгийн гэмт хэргийг шалгаж тогтоох ажлын хүрээнд мөрдөн шалгах ямар ч ажиллагааг шаардлагатай үед өөрөө биечлэн хийж магадлан шалгах эрхтэй байх ёстой гэж бид үзэж байлаа. Тэгэхдээ мөрдөн байцаалтыг прокурор үндсэн ажлын хувиар биш, хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгон хэрэглэх учиртай. Прокурорын байгууллагын тухай хуулийн төслийг боловсруулах явцад “Прокурор мөрдөн байцаах ажиллагааг биечлэн хийх эрхтэй байна биз дээ” гэж би Б.Чимид гуайгаас асуухад “Байлгүй яах юм, гар мухар хүн шиг хараад сууж байх юм уу?” гэж билээ. Гэтэл энэ заалтыг эсэргүүцэгч нар 1992 оны Үндсэн хуульд “Прокурор мөрдөн байцаалт явуулах эрхтэй” гэж заагаагүй гэж махчилан сөргүүлж байв. Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавина” гэсэн заалт дотор дээрх ухагдахуун багтаж байгаа. Гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээж аваад прокурор өөрөө анхан шатны магадлан шалгалт хийх эрхгүй байх нь асуудалд хайнга хандахыг өөгшүүлж байгаа мэт утгагүй зүйл л дээ. Харин 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.3-д өмнөх хуулийн дутууг засах зарим оролдого хийсэн байна билээ.

# 1993

**2 сарын 5.** УИХ-ын тогтоолоор прокурорын байгууллагыг хууль зүйн дээд боловсролтой боловсон хүчнээр хангах, одоо ажиллаж байгаа хууль зүйн дунд боловсролтой боловсон хүчнийг давтан сургах асуудлыг 1995 онд багтаан шийдвэрлэхийг Засгийн газарт даалгав.

**4 сарын 23.** УИХ-ын гишүүн Ц.Нямдорж, Г.Ганболд нар санаачилсан "Прокурорын байгууллагын тухай хууль"-ийг УИХ батлан гаргав.

**6 сарын 6.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд П.Очирбат ялалт байгуулав.

**6 сарын 7.** Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх зорилгоор УИХ-аас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулав.

**6 сард.** Улсын Ерөнхий прокурор Г.Бахдал эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж, Н.Ганбаяр Улсын Ерөнхий прокуророор томилогдов.

**7 сарын 9.** УИХ-ын 59 дугаар тогтоолоор прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулав.

**7 сарын 25.** Районы болон Улаанбаатар Төмөр замын прокурорын газар,

## ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ТҮҮНИЙ ОРЛОГЧ НАРЫГ ШИНЭЭР ТОМИЛОХ ХҮРТЭЛ

Монгол Улсын Их хурлын 1993 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн "Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 16 дугаар тогтоолоор, Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Ерөнхий прокурор, түүний орлогч нарыг шинээр томилох хүртэл БНМАУ-ын Ардын Их Хурлаас томилсон Улсын ерөнхий прокурор, түүний харьяа прокурорууд Үндсэн хууль болон Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуульд нийцүүлэн бүрэн эрхээ хэрэгжүүлж байхаар тогтоож, Прокурорын байгууллагыг хууль зүйн дээд боловсролтой боловсон хүчнээр хангах, одоо ажиллаж байгаа хууль зүйн дунд боловсролтой боловсон хүчнийг давтан сургах асуудлыг 1995 онд багтаан шийдвэрлэхийг Засгийн газарт, Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хуульд нийцүүлэн шинэчлэх саналаа 1993 оны 6 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, түүнд заасан журам, дүрмийг боловсруулан гаргах, батлуулах ажлыг 1993 онд багтаан гүйцэтгэхийг Улсын ерөнхий прокурор (Г.Бахдал)-т тус тус даалгасан байна.

## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ

Шинээр батлагдсан Үндсэн хуулийн дагуу Монгол Улсын анхны Ерөнхийлөгчийг сонгох ардчилсан сонгуулийг зохион байгуулав. Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас П.Очирбат, МАХН-аас Л.Түдэв нар нэр дэвшин өрсөлдөв. Нийт 1 сая 25 мянга 970 сонгогчид санал өгснөөс 592 мянга 836 саналаар П.Очирбат ялалт байгуулж, Монгол Улсын анхны Ерөнхийлөгчөөр сонгогдов.

# 1993

Цэргийн прокурорын газрыг тус тус татан буулгав.

12 сарын 1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар прокурорын байгууллагын бэлгэдэл, прокурорын энгэрийн тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг батлав.

-Системийн хэмжээнд 71 орон тоотой ажиллаж байсан Цэргийн ерөнхий прокурорын газрыг татан буулгав

-Улаанбаатар хотын прокурорын газрыг Нийслэлийн прокурорын газар хэмээн нэршил, бүтцийг нь өөрчлөв.

-Улсын Ерөнхий прокурорын орлогчоор Ж.Чойжанцанг томилов.

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар прокурорын “Зэрэг, дэв олгох” дүрмийг батлав.

-Д.Бямбаа Дундговь, Д.Бат-Өлзий Өмнөговь, Н.Цэрэннадмид Сэлэнгэ, С.Дамчаасүрэн Хэнтий аймгийн, А.Ширэндэв Баянзүрх, Л.Болд Чингэлтэй, Ж.Ганхуяг Сонгинохайрхан дүүргийн, Н.Сүрэнхорлоо Тээврийн прокуророор томилогдов.

## ПРОКУРОРЫН ХУУЛЬ ХЭРЭГЖИЖ ЭХЛЭВ

“Прокурорын байгууллагын тухай хууль” нь 6 бүлэг, 43 зүйлтэй бөгөөд прокурорын байгууллагын чиг үүрэг, үндсэн зарчим, тогтолцоо, ерөнхий прокурор, түүний орлогч нарын бүрэн эрхийн хугацаа, прокурорын эрх хэмжээ, хяналтууд, прокурор шүүх хуралдаанд оролцох эрх, Улсын Ерөнхий прокуророос Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн Цэц, Улсын Дээд шүүхтэй харилцах дэг журам, онцлог, боловсон хүчин зэрэг харилцааг зохицуулсан байна.

Прокурорын байгууллагыг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай зөвшилцөн 6 жилийн хугацаагаар томилсон Улсын Ерөнхий прокурор удирдана. Ерөнхийлөгч Улсын Ерөнхий прокурорын саналыг үндэслэн түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд Улсын Ерөнхий прокурорын газарт Улсын Ерөнхий прокурор, түүний орлогч, туслах прокурор болон хяналтын прокурор, аймаг, нийслэлийн прокурорын газарт аймаг, нийслэлийн прокурор, түүний орлогч, туслах прокурор болон хяналтын прокурор, сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газарт ахлах болон хяналтын прокурор ажиллах зохицуулалтыг нарийвчлан зааж өгчээ.

1976 оны Прокурорын байгууллагын тухай хуулиас ялгарах нэг онцлог нь прокуророор томилохдоо боловсрол, мэргэжил, ажилласан хугацааны шалгуур зэргийг тодорхой болгов.

## ЗЭРЭГ ДЭВ ШИНЭЧЛЭГДЭВ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар прокурорын “Зэрэг дэв олгох” дүрмийг баталснаар прокурорууд “Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх”, “Төрийн хууль цаазын шадар зөвлөх”, “Хууль цаазын итгэмжит зөвлөх”, “Хууль цаазын ахлах зөвлөх”, “Хууль цаазын зөвлөх”-ийн зэрэг дэвтэй болж, зэрэг дэв олгох албан тушаалын ангиллыг тодорхойлжээ.

# 1993

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР ГАВЬЯАТ ХУУЛЬЧ
## НАНЗАДЫН ГАНБАЯР



Монгол Улсын Ерөнхий прокуророор 1993-1999 онд томилогдон ажилласан Нанзадын Ганбаяр Улаанбаатар хотод 1953 онд төржээ. Тэрбээр 1971-1976 онд ЗХУ-ын Эрхүү хотын Улсын Их сургуулийн хуулийн анги, Эрхүү хотын Улс төрийн оройн их сургуульд тус тус суралцаж хуульч, улстөр судлаач мэргэжил эзэмшжээ.

Н.Ганбаяр 1976-1978 онд Улсын Дээд шүүхэд зааварлагч, тусгай тасгийн дарга, шүүхийн практик судлах хэлтсийн дарга, 1978-1984 онд Улсын Дээд шүүхийн гишүүн, 1984-1987 онд Улаанбаатар хотын Шүүхийн дарга бөгөөд хотын Ерөнхий арбитрч, 1987-1990 онд МАХН-ын Төв хороонд ахлах зааварлагч, 1990-1992 онд Улсын Бага хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга, 1992-1993 онд Соёлын тэргүүн дэд сайд, 1993-1999 онд Улсын Ерөнхий прокурор, 1999 онд Хууль зүйн сайдын зөвлөх, 2000-2013 онд Шүүхийн Ерөнхий зөвлөлд Гүйцэтгэх нарийн бичгийн дарга, 2013 оны 2 дугаар сарын 7-ноос өнөөг хүртэл Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр ажиллаж байна.

Н.Ганбаяр 1993 онд Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх, 2012 онд Монгол Улсын Гавьяат хуульч цолоор шагнагджээ.

Н.Ганбаяр Улсын Ерөнхий прокуророор ажиллах хугацаандаа шилжилтийн үеийн прокурорын байгууллагыг удирдаж, тус байгууллага дахь шинэчлэлт, өөрчлөлтийг өрнүүлэн төлөвшүүлэх, уламжлал шинэчлэлийг хослуулахад чиглэсэн дорвитой арга хэмжээ авч ажиллаж байв.

# 1993

## ПРОКУРОРЫН ГАЗАР ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР БОЛОВ

Монгол Улсын Их хурлын 1993 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн “Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай” 59 дугаар тогтоолоор Монгол Улсын Прокурорын газрыг Монгол Улсын ерөнхий прокурорын газар болгон өөрчилж, аймаг, нийслэлийн прокурорын газруудыг 1 дүгээр хавсралт, сум болон сум дундын, дүүргийн прокурорын газруудыг 2 дугаар хавсралт, дагнасан прокурорын газрыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус шинэчлэн байгуулж, прокурорын газруудын 1993 оны цалингийн санг 4 дүгээр хавсралтын ёсоор батлаж, Прокурорын газруудыг шинэчлэн байгуулсантай холбогдуулан одоо ажиллаж байгаа аймаг, хот, район, орон нутгийн хотын болон Улаанбаатар Төмөр замын прокурорын газруудыг энэ тогтоолыг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс, цэргийн прокурорын газрыг 1993 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс тус тус татан буулгасанд тооцож, Цэргийн прокурорын газруудын орон тоо, цалингийн санг тээврийн хэрэгсэл, эд хөрөнгийн хамт Улсын ерөнхий прокурорын газарт 1993 оны 8 дугаар сарын 1-ний дотор шилжүүлжээ.

## НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН БҮТЭЦ

Нийслэлийн прокурорын газар хэмээн нэр нь өөрчлөгдсөнөөр Улаанбаатар хотын прокурорын газрын бүтэц ч өөрчлөгдөв. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар Хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих алба, Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих алба, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих алба, Шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох алба, Тамгын хэлтэстэй байхаар тогтоожээ.

1980-1993 он хүртэл Улаанбаатар хотын прокурорын газарт боловсон хүчин, хяналт шалгалт эрхэлсэн туслах прокурор (Хотын прокурорын туслах) ажиллаж байгаад Прокурорын байгууллагын тухай хуулийн дагуу Улсын Ерөнхий прокурорын тушаалаар Нийслэлийн прокурорын газрын бүтцэд анх удаа Тамгын хэлтэс бий болгов.

## ДҮҮРГҮҮДЭД ПРОКУРОРЫН ГАЗАР БАЙГУУЛАГДАВ

Монгол Улсын Ерөнхий прокуророор 6 дугаар сард томилогдож ирүүтээ Н.Ганбаяр бүтцийн өөрчлөлтийн тушаал гаргав. УЕП-ын газрын Хэрэг эрхлэх газар хуваагдаж, Тамгын газар, Санхүү, аж ахуйн газар болов.

УИХ-ын тогтоолын дагуу УЕП тушаал гарган Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрыг байгуулж, дүүргийн анхны ахлах прокуророор Ж.Ганхуяг, хяналтын прокуророор Ц.Бурмаа, Л.Долгор, С.Нансалмаа, Ц.Гийзэв нар томилогдов. Баянзүрх дүүргийн прокурорын газрыг ахлах прокурор А.Ширэндэвийн удирдлага дор байгуулсан бол Чингэлтэй дүүргийн прокурорын газар ахлах прокурор Л.Болдын удирдлага дор 13 орон тоотой үйл ажиллагаа явуулж эхлэв. Хяналтын прокуророор Б.Чимгээ, Ш.Алтанцэцэг, Д.Дамдинсүрэн, нарийн бичгийн даргаар Л.Чимэдлхам нар тус тус томилогджээ.

# 1993

## ДАГНАН ХЯНАЛТ ТАВИХ БОЛОВ

7 дугаар сарын 9-ний өдрийн УИХ-ын тогтоолын хавсралтад зааснаар Улаанбаатар төмөр замын прокурорын газрыг хяналт тавих обьектыг өргөжүүлэв. Улаанбаатар төмөр зам дахь Цагдаагийн хэлтэс, Замын цагдаагийн газар, Иргэний агаарын тээврийн Цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд дагнан хяналт тавих Тээврийн прокурорын газар болгон шинэчлэн байгуулав.

Түс прокурорын газар нь Улаанбаатар Төмөр зам дахь цагдаагийн хэлтэс, Замын цагдаагийн газар, Иргэний агаарын тээврийн Цагдаагийн хэлтэс, Буянт-Ухаа дахь гаалийн газар, Буянт-Ухаа дахь хилийн мэргэжлийн хяналтын алба, Буянт-Ухаа дахь хилийн шалган нэвтрүүлэх боомт, Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх алба, Улаанбаатар Төмөр замын тээврийн хяналтын албадын байцаагчийг хамруулан хяналтын үйл ажиллагааг явуулж, нийслэлийн шүүх, дүүргүүдийн шүүхийн эрүүгийн шүүн таслах ажиллагаанд төрийг төлөөлөн оролцож эхлэв.

## БЭЛГЭДЭЛ, ТЭМДЭГТЭЙ БОЛОВ

Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлд “прокурорын байгууллага бэлгэдэлтэй байна, прокурор энгэрийн тэмдэг хэрэглэнэ, прокурорын ...бэлгэдэл, энгэрийн тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг Ерөнхийлөгч батална” хэмээн заасны дагуу 12 дугаар сарын 1-нд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат “Прокурорын байгууллагын бэлгэдэл, прокурорын энгэрийн тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг батлах тухай” зарлиг гаргалаа. Прокурорын байгууллагын бэлгэдэл нь найман товруу бүхий дугуй бамбай хэлбэртэй байх бөгөөд энэ нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн хамгаалах прокурорын үйл ажиллагааны үндсэн агуулгыг илэрхийлнэ. Харин энгэрийн тэмдэг нь прокурорын байгууллагын бэлгэдлийн үндсэн хэлбэрийг хадгалсан байх бөгөөд “бамбайн доод хэсэгт цагаан паалан дээр шар өнгийн дармал үсгээр прокурор гэж бичсэн байна” хэмээн журамд заажээ. Прокурорын бэлгэдлийг бүх шатны прокурорын албан тасалгаа, хэвлэл, шагнал, уналгын хэрэгсэл, албан бичгийн хэвлэмэл хуудас болон баяр ёслол, түүнд зориулсан чимэглэлд дүрслэн хэрэглэх зориулалтай.

## ЖАМСРАНГИЙН ЭНХНАСАН



Ж.Энхнасан Улаанбаатар хотод 1954 онд төрж, 1973-1979 онд ЗХУ-ын Эрхүү хотын Улсын Их сургуулийг төгсчээ. Тэрбээр 1979-1991 онд Цэргийн прокурорт мөрдөн байцаагч, гарнизоны прокурор, барилгын цэргийн прокурор, Цэргийн Ерөнхий прокурорын орлогч, 1991-1993 онд Улсын Бага Хурлын Хууль зүйн байнгын хороо, УИХ-ын тамгын газарт зөвлөх, 1993-1996 онд Улсын Ерөнхий прокурорын орлогч прокурор, 1996-2001 онд Тагнуулын ерөнхий газрын дарга, 2002-2012 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргааны хэлтсийн дарга, секторын эрхлэгч, 2009-2013 онд Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Дэд ерөнхийлөгч, өмгөөлөгчөөр ажиллаж байна.

# 1993

*ҮТАГ-ын сан хөмрөгөөс...*

2 20

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН

**ЗАРЛИГ**

1993 оны 12 дугаар сарын 1-ний өдөр

Дугаар 112

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Прокурорын байгууллагын бэлгэдэл, прокурорын энгэрийн тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг хавсралтын ёсоор батлалсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.ОЧИРБАТ

# 1994

3 сарын 28. УИХ Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулав.

12 сарын 29. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар газрын зохион байгуулалт, бүтэц орон тоог шинэчлэн тогтоов.

-Уг оныг прокурорын хяналтын үйл ажиллагааны шинэчлэлийг гүнзгийрүүлэх жил болгон зарлав.

-Монгол Улсын Ерөнхий прокурор Н.Ганбаяр, Нийслэлийн прокурор Б.Доржготов, Гадаад харилцааны ажилтан Ш.Цэдэнсодном нар Унгар, Австри улсад айлчлав.

-Прокуророуд Монголын прокуроруудын Үндэсний холбоог үүсгэн байгуулав.

-Монгол Улсын Ерөнхий прокурорын туслах, УЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын даргаар Ш.Сүхбаатарыг томилов.

-П.Ананд Говь-Алтай, П.Түвшинбаяр Өвөрхангай, Ц.Ариунболд Өмнөговь аймагт, Я.Дамдинрагчаа Чингэлтэй, Ж.Мэндсайхан, Ц.Дамдин нар дараалан Сонгинохайрхан дүүрэгт ахлах прокуророор томилогдов.

## ЕРӨНХИЙ ГАЗРЫН БҮТЭЦ ДАРААХ БАЙДЛААР ӨӨРЧЛӨГДӨВ

Улсын Ерөнхий прокурорын 12 дугаар сарын 29-ний өдрийн А/110 дугаар тушаалаар Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын зохион байгуулалт, бүтэц орон тоог доорх байдлаар шинэчлэн тогтоожээ. Үүнд:

- Эрүүгийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих алба
- Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих алба
- Шүүх хуралд төрийн нэрийн өмнөөс оролцох алба
- Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих алба
- Захиргааны эөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих алба
- Хэрэг эрхлэх газар (Мэдээлэл, судалгаа, сургалтын төв, Санхүү үйлчилгээ аж ахуйг эрхлэх хэлтэстэй)

## НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОР БҮТЦЭЭ ШИНЭЧЛЭВ

Өмнөх онд гаргасан Улсын Ерөнхий прокурорын тушаалыг үндэслэн 4 дүгээр сард Нийслэлийн прокурор Б.Доржготовын 41 тоот тушаал гаргав. Тушаалаар Нийслэлийн прокурорын газрын бүтцийг шинэчлэн зохион байгуулж Тамгын хэлтсийг туслах прокурор Л.Нарангуад хариуцуулан, хяналтын прокурор 1 байхаар тогтоожээ.

## ҮНДЭСНИЙ ХОЛБООТОЙ БОЛОВ

Монголын прокуроруудын Үндэсний холбоо нь прокурорын байгууллагын бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох, бодлого чиглэлийг тодорхойлоход туслах, прокурорын байгууллагаас явуулж байгаа аливаа үйл ажиллагааг дэмжин туслах, прокуроруудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, Олон улсын болон бусад орны ижил төрлийн байгууллагуудтай хамтран ажиллаж мэдээлэл солилцох, харилцан суралцах, гишүүдийнхээ эрх ашиг сонирхлыг илэрхийлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж

# 1994

ажиллах зорилготойгоор байгуулагджээ. Түс холбоо нь Прокурор болон урьд прокуророор ажиллаж байсан ажилтан, прокурорын байгууллагын үйл ажиллагааг дэмжих хүсэлтэй прокуроруудыг эгнээндээ нэгтгэсэн төрийн бус байгууллага юм. Анхны тэргүүнээр нь Улсын Ерөнхий прокурорын туслах Г.Баясгалан томилогджээ.

## МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН БАГ ТАЙВАНЬД СУРАЛЦАВ

Социалист систем задран унасны дараа 1994 онд анх удаа Монголын хуульчдын баг Тайваньд мэргэжил дээшлүүлэв. Улсын ерөнхий прокурорын Тамгын газрын дарга Ш.Сүхбаатараар ахлуулсан тус багт Ерөнхий прокурорын туслах бөгөөд хэлтсийн дарга Х.Алтанзүрх, Г.Баясгалан, Т.Сүхбаатар, аймгийн прокурор Т.Ананд, Түвшинбаяр болон ирээдүйн Улсын дээд шүүхийн дарга С.Батдэлгэр нарын 20 хуульч хамрагдан хоёр сар суралцжээ.

## ЖАМЦЫН ЧОЙЖАНЦАН



Ж.Чойжанцан нь 1948 онд Архангай аймгийн Хотонт сумын нутагт төржээ. Тэрбээр 1966-1969 онд Хууль цаазын дунд сургууль, 1976-1981 онд МУИС төгсчээ.

Ж.Чойжанцан 1969-1976 онд Төв аймгийн прокурорын газарт хэсгийн прокурор, чухал хэргийн мөрдөн байцаагч, 1981-1982 онд мөн аймгийн прокурорын газрын мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих туслах прокурор, 1982-1992 онд Төв аймгийн прокурор, 1992-1993 онд Монгол Улсын Ерөнхий прокурорын газарт Хэрэг Эрхлэх газрын дарга, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн гишүүн, 1993-1999 онд Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч, 2000 оноос Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргаар ажиллаж байв.



Прокурорууд Тайваньд, 1994 он

# 1995

1 сарын 27. Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийг Ерөнхий прокурор Н.Ганбаяр даргалж, Зөвлөлийн гишүүдэд Ж.Чойжанцан, Ж.Энхнасан, Ш.Тогтох, Ш.Сүхбаатар, Х.Алтанзүрх, Г.Баясгалан, Б.Дамдинсүрэн, Б.Доржготов нар орж байсан бөгөөд туслах прокурор О.Баяраа, Ж.Эрдэнэбаатар ажлын шугамаар хуралд оролцдог байжээ.

8 сарын 1. Чойр хотын прокурорын газрыг Говьсүмбэр аймгийн прокурорын газар хэмээн нэрлэх шийдвэр гаргав.

9 сарын 19. Улсын Ерөнхий прокурорын орлогч Ж.Чойжанцанг АНУ-ын Хууль зүйн яамны урилгаар тус улсын цэрэг хуулийн тогтолцоо судлах ажлаар 14 хоног томилон ажиллуулжээ.

9 сарын 26. Хээл хахуультай тэмцэх асуудлаар Бээжин хотноо болох олон улсын прокуроруудын бага хуралд Улсын Ерөнхий прокурорын орлогч Ж.Энхнасан, туслах прокурор Ж.Эрдэнэбаатар нарыг оролцуулжээ.

9 сарын 28. Улсын ерөнхий прокурор, Татварын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар “Аймаг, нийслэл, тээврийн прокурор татварын байгууллагын харилцан ажиллагааны журмыг баталжээ.

## БИЕ ДААЖ АЖИЛЛАХ ЧАДВАРЫГ ПРОКУРОР БҮР САЙН ЭЗЭМШ

Хуулийн байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөнд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат оролцож үг хэлжээ. Тэрбээр “Прокурор хөндлөнгийн ажиглагчийн байр сууринаас ханддаг хуучин сэтгэлгээ арга барилаараа ажиллаж эрүүгийн хэрэг үүсэхээс эхлээд хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх хүртэлх ажиллагаанд үйл явдлын гүнд орж чадахгүйн дээр, гэм буруутай этгээдийг яллах болон цагаатгах бүх талын нотолгоог хуульд заасан үндэслэл журмын дагуу цуглуулж, бэхжүүлж, үнэлж буй эсэхэд гол анхаарлаа хандуулахгүй байгаагаас хууль зөрчигдөх, хуулийг буруу хэрэглэх, иргэдийн эрх ашиг хохирох явдал үргэлжлэн гарсаар байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд прокурор оролцож зөвшөөрөл олгох, заалт чиглэл өгөх шийдвэр гаргах эрх мэдэл бол түүнд хуулиар хүлээлгэсэн үнэхээр өндөр хариуцлага бөгөөд гаргасан шийдвэрээ дангаар хариуцахын хувьд бусдын нөлөөнд үл автан хууль ёсны дагуу бие дааж ажиллах чадварыг прокурор бүр сайн эзэмших шаардлагатай” хэмээн хэлсэн үгэндээ онцолсон байна.

## ЧОЙРЫН ПРОКУРОР АЙМГИЙНХ БОЛОВ

Монгол Улсын Их Хурлын тогтоолын дагуу 8 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсын Ерөнхий Прокурор А/47 дугаар тушаал гаргаж Чойр хотын прокурорын газрыг “Говьсүмбэр аймгийн прокурорын газар” гэж нэрлэх шийдвэр гаргав. Статусыг нь өөрчлөн аймгийн прокурор 1, орлогч прокурор 1, туслах прокурор 3, хяналтын прокурор 2-оор орон тоог тогтоожээ.

## Ж.ЧОЙЖАНЦАН: ЕРӨНХИЙ ПРОКУРОР НАДАД БАЯР ХҮРГЭЖ БИЛЭЭ

1995 онд Прокурорын байгууллагын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад 36 дугаар зүйлийн 6 дугаар хэсэгт

# 1995

“Прокурор дүрэмт хувцастай байна, Прокурорын дүрэмт хувцаст прокурорын зэрэг дэвийг тусгасан ялгах тэмдэг байна, тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг Ерөнхийлөгч батална” хэмээн тодорхой зааж өгчээ. Ерөнхий прокурорын орлогч Ж.Чойжанцан “Ерөнхий прокурор Н.Ганбаяр прокурорын дүрэмт хувцасны загварыг Ерөнхийлөгчөөр батлуулахдаа бэлтгэл ажлыг өөрөө биечлэн зохион байгуулсан.

Дүрэмт хувцасны загварыг батлуулах үед “Хувцас хийх хөрөнгийн асуудлыг Засгийн газраас зөвшөөрүүлж чадахгүй байна” гэхээр нь “Та ямар ч байсан хувцасныхаа загварыг батлуулчих” гэж би хэлж билээ. Загвар албан ёсоор батлуулсны дараа аймаг, хотын прокуроруудад дуулгаж, бүх прокуроруудын хоёр сарын цолны мөнгийг төвлөрүүлж, цэргийн оёдлын үйлдвэрээр хийлгэж бүх прокуроруудаа дүрэмт хувцсаар хангасан. Их ч гоё хувцас болж прокурорууд их баяртай байв. Ийм амархан хийлгэх байсан юм уу? гээд Ерөнхий прокурор маань надад баяр хүргэж билээ. Прокуроруудын анхны дүрэмт хувцсыг хийлгэж өгсөндөө баяртай байдаг” хэмээжээ.

Ерөнхий прокурор дүрэмт хувцасны загварыг анх Монгол генералын хувцаснаас санаа авч судалгаа хийсний эцэст Ерөнхий прокурорын хувцасны энгэрт байрлах хээ угалзыг эмээлийн тэвшний угалзнаас санаа авч хийсэн гэдэг.

## ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ЯЛЛАХ ДҮГНЭЛТ БИЧНЭ

Прокурорууд нийт аймаг, нийслэлийн шүүхийн хэмжээнд бүх эрүүгийн хэрэгт яллах дүгнэлт бичдэг боллоо. Хуулийн өөрчлөлтөөр цагдаагийн мөрдөн байцаагч нар ялын төлөвлөгөөг бичиж прокурор баталдаг байсныг өөрчилж яллах дүгнэлтийг прокурор дагнан боловсруулж бичих шинэ чиг үүргийг нэмжээ. Шинэ чиг үүрэгтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр прокурорын байгууллагын хэмжээнд шуурхай сургалт, семинар зохион байгуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх боломжийг олгох зохион байгуулалтын шинжтэй ажлуудыг шийдвэрлэсэн байна.

**10 сарын 25.** Увс аймаг, Тува улсын прокурорын байгууллагуудын шууд харилцаа тогтоолгохоор Увс аймгийн прокурор Т.Жадамбааг Тува улсад 7 хоногийн хугацаатайгаар томилжээ.

**11 сарын 8.** Улсын Ерөнхий прокурорын газрын албан хэрэг хөтлөх журмыг баталжээ.

12 сарын 26. Монгол Улсын Их хурлын тогтоолоор Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

-Ерөнхий прокурорын газраас “Удирдах ажилтны сахилга, хариуцлагыг өндөржүүлэх жил” болгон зарлав.

-Ерөнхий прокурорын орлогч Ж.Чойжанцан тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д айлчлав.

-С.Мишигдорж Говьсүмбэр, М.Жанчив Дорноговь, Д.Алгаа Дундговь, Т.Жадамбаа Увс, Я.Дамдинрагчаа Хөвсгөл аймгийн, Ц.Бямбацогт Баянгол, Н.Сосорбарам Чингэлтэй дүүргийн прокуророор томилогдов.

# 1995

## НАЙМАН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТҮҮХЭН УУЛЗАЛТ

Прокурорын байгууллагын 65 жилийн ой тохиосон 1995 онд Монгол Улсын ерөнхий прокурор Н.Ганбаяр өмнө ажиллаж байсан ерөнхий прокуроруудаа хүндэтгэл үзүүлэх уулзалт зохион байгуулахыг даалгав.

Тэр түүхэн уулзалтад БНМАУ-ын прокуророор 1946 оноос хойш ажиллаж байсан Б.Жамбалдорж, С.Жалан-Аажав, Д.Ёндондүйчир, Ж.Авхиа, С.Бүдрагчаа, Ж.Балжинням, Г.Бахдал нарын долоон эрхэм хүрэлцэн ирж Н.Ганбаяр прокурор хүлээн авч халуун дотно яриа өрнөсөн. Миний бие Хэрэг эрхлэх газрын даргын хувьд Савхин эдлэлийн үйлдвэрт “БНМАУ-ын ерөнхий прокурор” гэсэн бичээс бүхий цүнх захиалан хийлгэж, тус бүрт нь нэг хонь бэлэглэх ажлыг хариуцан гүйцэтгэж байлаа.



Баруун гар талаас өвөр эгнээнд БНМАУ-ын прокуророор ажиллаж байсан С.Бүдрагчаа (1982-1988), Ж.Авхиа (1969-1978), Б.Жамбалдорж (1946-1957), С.Жалан-Аажав (1959-1960), Д.Ёндондүйчир (1960-1969), Ж.Балжинням (1988-1990), Ж.Энхнасан (Орлогч прокурор), Г.Бахдал (1990-1993), Н.Ганбаяр (1993-1999), Ж.Чойжанцан (Орлогч прокурор) нар



УЕПГ-ын прокурорууд анх удаа дүрэмт хувцаараа ижилсэв. 1995 он

# 1996

## ОЛОН УЛСЫН ГИШҮҮНЧЛЭЛТЭЙ БОЛЛОО

Прокурорын байгууллагын гадаад харилцаанд гарсан нэг тэмдэглэлт үйл явдал бол 1996 оны 9 дүгээр сард Монголын прокуроруудын үндэсний холбоо нь Олон улсын прокурорын холбоонд гишүүнээр элсэн явдал юм. Тус холбооны их хуралд Б.Цэрэнбалтав тэргүүтэй төлөөлөгчид оролцож энэхүү хүндтэй үүргийг нэр төртэй гүйцэтгэжээ.

Өдгөө Монголын Прокуроруудын холбоо нь Олон улсын прокурорын холбооны шугамаар Унгар, Канад, БНХАУ, Австрали, ӨАБНУ, Англи, АНУ, БНСУ, Дани, Франц, Тайланд, Хонконг, Сингапур зэрэг улсад зохион байгуулсан хурал зөвлөгөөнд идэвхтэй оролцож, ажил төрлийн харилцаа тогтоожээ.

## ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГУУД ЭРХ МЭДЛЭЭ ХЭТРҮҮЛЖ БАЙВ

Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлд заасан чиг үүргээ прокурорын байгууллага хэрэгжүүлж, хяналтын обектуудын хууль зөрчих явдлыг багасгах ялангуяа цагдаа, мөрдөн байцаах, хорих, хил гаалийн байгууллагын албан тушаалтнуудын үйл ажиллагаа хуульд хэрхэн нийцэж байгаад анхаарал хандуулав. 1996 онд энэ чиглэлээр нийт 1080 удаа шалгалт хийж, 10976 хуулийн зөрчил илрүүлж тэдгээрийг засуулах тодорхой арга хэмжээ авсны дотор 133 албан тушаалтанд эрүүгийн хариуцлага, 871 албан тушаалтанд захиргааны болон сахилгын шийтгэл хүлээлгэж, 1685 хүний зөрчигдсөн эрхийг сэргээж, учирсан хохирлыг арилгуулсан байна.

Захиргааны зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагаагаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын дотоодын хяналт шалгалтаар ч илрээгүй олон зөрчлийг ил болгов. Тухайлбал Гаалийн Ерөнхий газар, Тагнуулын төв газар, Хилийн цэргийн удирдах газрын даргын хамтарсан тушаалаар хилийн цэрэг, тагнуулын байгууллагын ажилтнууд гаалийн хууль тогтоомжийн зөрчил илрүүлснийхээ үнийн дүнгийн 25 хүртэлх хувийн урамшууллыг авч байх журам тогтоож байсныг хүчингүй болгуулжээ.

**2 сарын 26.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн 26 дугаар зарлигаар прокурорын дүрэмт хувцас, зэрэг дэвийг ялгах тэмдгийн загвар, прокурорын дүрэмт хувцсыг хэрэглэх журмыг батлав.

**6 сарын 30.** Монгол Улсын Их хурлын хоёр дахь удаагийн сонгууль нэг мандат бүхий 76 тойргоор явагдаж, МҮАН, МСДН, НН-ын “Ардчилсан холбоо” эвсэл 50 суудал авч ялав.

**9 сард.** Монголын прокуроруудын Үндэсний холбоо Олон улсын прокурорын холбоонд гишүүнээр элсэн орж, Монголын прокуроруудын Үндэсний холбооны дэд тэргүүн, Сүхбаатар аймгийн прокурор Б.Цэрэнбалтав тэргүүтэй төлөөлөгчид Унгарын Будапешт хотноо болсон тус холбооны их хуралд оролцжээ.

**10 сарын 31.** УИХ “Прокурорт нэмэгдэл олгох журмыг батлах тухай” тогтоол гаргав.

**11 сард.** Хүний эрх, эрх чөлөөнд далдуур халдах үйл ажиллагааг хуульчлан хязгаарлах зорилгоор Улсын Ерөнхий Прокурор, Хуульзүйн сайдын хамтарсан тушаалаар баталсан комисс “Гүйцэтгэх ажлын хууль”-ийн төсөл дээр ажиллав.

# 1996

-НҮБ-ын Хүний эрхийн төв, АНУ-ын Тэнгисийн цэргийн хуулийн академи, МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулиас зохион байгуулсан семинар, сургалтад 50 прокурорыг хамруулав.

-Улс төрийн хилс хэрэгт шийтгүүлсэн хүмүүсийг цагаатгах ажлыг үргэлжлүүлэн хийж 257 хүний нэр төрийг шүүхээр сэргээн цагаатгуулжээ.

-УЕПГ-ын болон Нийслэлийн прокурорын газарт тус бүр 2 орлогч ажиллаж байсныг нэг болгов.

- Ж.Энхнасан Нийслэлийн, Ц.Мөнхбат Булган, Д.Итгэл Дундговь, Л.Мөнхсайхан Завхан, Б.Жаргалсайхан Өвөрхангай, Г.Батбаатар Увс аймгийн, Г.Чагнаадорж Сүхбаатар, Б.Цэрэнбалжир Хан-Уул дүүргийн прокуророор тус тус томилогдов.

## Н.ГАНБАЯР: “ШИНЭ ЗОРИЛТЫГ ХУУЧНЫ АРГААР ШИЙДЭХГҮЙ”

Ерөнхий прокурор Н.Ганбаяр төв, орон нутгийн прокурорын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд тавьсан илтгэлдээ “Төр, засгийн эрх мэдэл улс төрийн нэг хүчнээс нөгөөд шилжиж, Монгол Улсын прокурорын байгууллага өнөөгийн шинэ нийгмийн үед ажиллах чиглэл хөлөө олж, байгууллагын нэр хүнд өсч, байр суурь нь бэхжлээ. Нөгөө талаар хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндлэх ажил Монгол оронд өргөн хүрээтэй зохион байгуулагдаж байгаа өнөө үед та бид ажиллаж амьдарч байна.

Ерөнхий прокурорын газар Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг боловсруулан Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлснээр прокурор нь анхан болон давж заалдах шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр хуульд нийцээгүй гэж үзвэл эсэргүүцэл бичих, гүйцэтгэх ажил болон эрүүлжүүлэх, цагдан хорих, баривчлах шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хяналт тавих, дүрэмт хувцас хэрэглэх, сахилгын шийтгэл оногдуулах зэрэг шинэ эрх хэмжээтэй болов.

Прокурорын бүрэлдэхүүнд мэргэжил, нас, хүйсийн нааштай өөрчлөлт гарч байгаа боловч судлаж шийдвэрлэвэл зохих асуудал цөөнгүй байгаа нь нууц биш юм. Тухайлбал, бидний дунд шинэ зорилтыг хуучны мэдлэг, уламжлалт арга барилаараа шийдвэрлэхээр оролддог хүн цөөнгүй, тэднийг харилцагч байгууллагын залуу мэргэжилтнүүд голж, шүүмжилж эхэллээ. Прокурорын байгууллага ганц эрдэмтэнтэй, эрдэм шинжилгээний ажил эрхэлж байгаа ажилтангүй, дэлхийн олон улсын харилцааны хэл (оросоос бусад хэл)-ийг төгс эзэмшсэн хүнгүй байна.

Бид нийгэм, улс төр, эрх зүй, эдийн засаг, шинжлэх ухаан технологийн орчин үеийн мэдээллээр хомс байдалд ажиллаж байгаа учраас “хөгжихгүй” байна. Өөрийн ажил мэргэжлийн түвшинд бодитой үнэлгээ өгч, “өөрийгөө хөгжүүлэх” арга барилд хүмүүсийг сургах шаардлагатай боллоо. Үүнтэй уялдан аймаг, нийслэл, тээврийн прокурор, дүүрэг, сум, сум дундын ахлах прокурорууд

# 1996

бүрэлдэхүүнийхээ сургалтад ихээхэн хүч анхаарал тавьж ажиллах нь зүйтэй байна" хэмээн дурджээ.

## ТӨРИЙН ЭРХ ШИНЭ ХҮЧИНД ШИЛЖИВ

Монгол Улсын Их хурлын хоёр дахь удаагийн сонгууль нэг мандат бүхий 76 тойргоор 6 дугаар сарын 30-ны өдөр явагдаж, МҮАН, МСДН, НН-ын "Ардчилсан холбоо" эвсэл 50 суудал, МАХН 25 суудал, МҮНН 1 суудал авснаар төрийн эрх мэдэл анх удаа улс төрийн шинэ хүчинд шилжсэн онцлогтой парламент байгуулагдав.

Энэ удаагийн УИХ бүрэн эрхийнхээ хугацаанд шинээр 173 хууль баталж, давхардсан тоогоор 255 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан 32 хуулийг хүчингүй болсонд тооцжээ. Мөн олон улсын гэрээ, конвенци 71-ийг соёрхон баталсан байна.

1996-2000 оны хооронд төрийн эрх баригчид, улс төрийн намуудын зөрчил гүнзгийрч Засгийн газар 4 удаа солигдсон ээдрээтэй цаг үед прокурорын байгууллага үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, чадварлаг удирдлага, хуульчдынхаа дор хууль ёсыг хэлбэрэлтгүй сахиулахын төлөө ажилласаар байв.

## ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН ҮЕ

Төрийн эрх шинэ хүчинд шилжсэний дараагаар өмч хувьчлал явуулах ажлыг Засгийн газар болон түүний харьяа Төрийн өмчийн хороо хариуцаж улс орон даяар явуулав.

Өмч хувьчлалын явцад төрийн өмчийг хууль бусаар авсан, завшсан асуудлыг эрүүгийн хуулиар шалгаж байв. Ийм гэмт хэрэг гарч байгаа эсэхийг хянах эрх, үүрэгтэй хуулийн байгууллагууд үүргээ биелүүлж чадсан эсэхийг өнөө хүртэл янз бүрээр дүгнэн ярьцгаадаг. Улсын хэмжээнд гүйцэтгэх засаглалын хүрээнд хараа хяналт багатай явуулсан энэ ажлыг хуулийн байгууллагууд боломжийнхоо хэрээр хумиж, шалгахыг хичээж байлаа.

Ялангуяа прокурорын байгууллагын хүчтэй хяналт, эсэргүүцэлтэй тулгарсан хэдий ч төрийн зүгээс кампанит ажил болгон явуулсан өмч хувьчлал шат дараатай зохион байгуулалттай арга хэмжээ болж чадаагүйг өнөөдөр ярьж, бичицгээдэг.

## ЖУРАМ ШИНЭЧЛЭН ГАРГАВ

Төрийн яам, агентлагийн сайд, дарга нар бүрэн эрхийнхээ хүрээнд байгууллагынхаа дотоодод болон үйл ажиллагаа явуулах салбартаа чиглэсэн дүрэм журмуудыг гаргадаг.

Прокурорын байгууллагаас эдгээр дүрэм журмуудын хууль зүйн үндэслэлийг хянах асуудалд нэлээд нухацтай хандаж Улсын Ерөнхий прокурорын тушаалаар "Гэмт хэрэг үйлдсэн сэтгэцийн өвчтөн, согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх нөхцөл, журам", "Хорих засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялыг тэнсэж, хянан харгалзсан болон хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан ялтны засрал хүмүүжилд хяналт тавих журам" зэрэг таван журмыг гаргаж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллажээ.

# 1997

5 сард. ОХУ-ын Ерөнхий прокурорын орлогч А.Розанов тэргүүтэй төлөөлөгчид манай оронд албан ёсны айлчлал хийв.

7 сард. Прокурорын дүрэмт хувцсыг Улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулав.

8 сарын 8. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 8-н заалт бүхий үүрэг, даалгаврыг прокурорын байгууллагад өгөв.

10 сарын 23. УИХ "Прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай" тогтоол гаргав.

-Гүйцэтгэх ажлын тухай хууль батлагдав.

-Боловсон хүчнийг сургаж, хөгжүүлэх асуудлыг судалгаа, тооцоон дээр тулгуурлаж, үндэслэлтэй зохион байгуулахын тулд прокурорын байгууллагын хэмжээнд аттестатчилал, шалгалт явуулав.

- Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар Нийслэлийн прокурорын газрын бүтцийг Тамгын хэлтэс, Захиргааны зөрчил болон эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй 1 дүгээр хэлтэс, Ял эдлүүлэх ажиллагаанд

## УДАМ ДАМЖСАН ПРОКУРОР НИЙСЛЭЛЭЭ УДИРДАВ

Прокурорын байгууллагад удам дамжсан прокурорууд цөөнгүй. Тэдний нэг болох, 1960-аад оноос прокурорын байгууллагад зүтгэж ирсэн ахмад үеийн прокурор Тогоонтөмөрийн хүү Сүхбаатар Улсын прокурорын газрын Онцгой хэргийг мөрдөн байцаах тасгийн даргаар ажиллаж байхдаа "Ю.Цэдэнбалын хэрэг", "Тойрон хүрээлэгчийн хэрэг", "Отгонбаярын", "Армийн шатахууны" зэрэг ноцтой хэргүүдийг мөрдөн шалгаж шийдвэрлүүлж байв.

Т.Сүхбаатар тухайн онд Нийслэлийн прокуророор томилогдсон юм. Тэрбээр ажлаа хүлээн аваад юуны өмнө тэртээх 1960-аад оны эхээр ашиглалтад орсноосоо хойш дорвитой засвар хийгдээгүй байсан конторын барилгыг засч сайжруулахаар хотын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд санал тавьж, 40 сая төгрөгийн төсөв батлуулжээ. Тэр үед Нийслэлийн прокурорын газрын ажлын ачаалал их, 1997 онд улсын хэмжээнд 22000 гаруй гэмт хэрэг гарч байсны 50 хувь нь нийслэлд гарч байжээ. Нийслэлийн прокурор, шүүх, цагдаагийн байгууллагуудтай сар бүр харилцан мэдээлэл солилцож, цаашид ямар ажил зохиох талаараа зөвлөлдөх ажлыг Т.Сүхбаатар прокурорын үеэс уламжлал болгон хэвшүүлжээ.

Т.Сүхбаатар "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зөвхөн хуулийн байгууллагынхны үүрэг биш" гэж Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулж, энэ ажилд бусад байгууллагууд оролцож байхаар шийдвэрлүүлж, хэд хэдэн чухал тогтоол гаргуулжээ. Үүний үр дүнд Нийслэлийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил эрс сайжирч, гэмт хэргийн гаралт ч буурсан аж.

## "ДҮРЭН ХАНГАЛТТАЙ" ҮНЭЛГЭЭТЭЙ ПРОКУРОРУУД УДИРДЛАГЫН НӨӨЦӨД...

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 1997 оны 8 дугаар сард өгсөн үүрэг, даалгаврын дагуу прокурорын байгууллагын хэмжээнд нэгдсэн удирдамжийн дагуу аттестатчилал, шалгалт явуулав.

# 1997

Боловсон хүчний ажил, мэргэжлийн түвшинг тогтоох шалгалт явуулж, прокуроруудын ажлыг сүүлийн 3 жилийн байдлаар дүгнэсэн төдийгүй улс төр судлал, удирдлага, хууль эрхийн онолын мэдлэгийн ярилцлага хийх, сонжуур бөглүүлэх зэрэг арга хэлбэрээр шалгаж дүгнэжээ. Үүний үр дүнд прокуроруудын мэдлэг, чадвар ямар түвшинд байгааг нэгтгэн дүгнэж, цаашид баримтлах чиглэл, бодлогыг тодорхойлох боломжтой болсон байна.

Шалгалтаар Улсын Ерөнхий прокурорын газар, түүний харьяа 42 нэгжид ажиллаж байгаа 357 прокурорын 353 буюу 98,8 хувь нь хамрагдаж, Прокурорын мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар 11 прокурорын ажлыг “дүүрэн хангалттай” гэж үнэлэн удирдах ажилтны нөөцөд авч, 265 прокурорын ажлыг “хангалттай” гэж үнэлж албан тушаалд хэвээр үлдээж, ажил мэдлэгээ сайжруулах хугацаатай үүргийг 19 прокурорт өгчээ.

## 6 ТЭРБУМЫН ӨР БАРАГДУУЛАХАД ОРОЛЦОВ

Банкны өр, зээл барагдуулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас хийж байгаа ажилд төв, орон нутгийн прокурорын бүх шатны байгууллага оролцож, нэгдсэн аяны хүрээнд холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай хамтран ажиллаж зургаан тэрбум гаруй төгрөгийн өрийг барагдуулсан байна.

## ДҮРЭМТ ХУВЦАС УЛСЫН БҮРТГЭЛД

УИХ-аас Прокурорын байгууллагын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу прокуроруудд дүрэмт хувцастай болсон билээ. “Прокурорын иж бүрэн дүрэмт хувцас, Форменные одежды для прокуроров, Uniform for public prosecutor”-ын бүтээгдэхүүний загварыг туслах прокурор Б.Дагвасүндэлийн нэрээр, УЕПГазар патент эзэмшигчээр 1997 онд Улсын Бүртгэлийн газар албан ёсоор бүртгүүлжээ.

хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэгтэй 2 дугаар хэлтэс болгон өөрчлөв.

-Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч, Ерөнхий прокурорын хамтарсан захирамж, тушаал гаргаж, иргэний 13 төрлийн хэрэгт прокурор заавал оролцохоор журамласан байна.

-Хүний халдашгүй эрхийг хүндэтгэн хамгаалах чиглэлээр үзүүлэх нөлөөллийг бодитой болгох, практикт төлөвшүүлэх зорилтыг прокурорын байгууллагын хэмжээнд дэвшүүлэв.

-Эрүүгийн хэрэгт бусдыг үндэслэлгүйгээр удаан хугацаагаар хорих явдлыг таслан зогсоох зорилгоор Ерөнхий прокурорын тушаал гарав.

-Ж.Эрдэнэбаатар, Т.Сүхбаатар нар дараалан Нийслэлийн, Ш.Сүхбат Говь-Алтай, Д.Бат-Эрдэнэ Дархан-Уул, Н.Дашжамц Дорноговь, Б.Чойжилсүрэн Сүхбаатар, Д.Жамбалдорж Төв аймгийн, Х.Алтанзүрх Баянгол, Б.Цэрэнбалтав Баянзүрх, С.Баттөмөр Сүхбаатар, М.Жанчив Хан-Уул дүүргийн прокуророор тус тус томилогдов.

# 1998

2 сарын 13. Улсын Ерөнхий прокурор Н.Ганбаяр “Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхэд прокуроруудын сахилга, хариуцлагыг өндөржүүлье” сэдвээр төв, орон нутгийн прокурорын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд илтгэл тавив.

6 сарын 29. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар төвийн бүх дүүргийн прокурорын газарт мэргэжилтэн операторчныг томилон ажиллуулав.

8 сарын 20. Монгол Улсын Их хурлын тогтоолоор “Прокурорын байгууллагын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

11 сарын 25. Улсын Ерөнхий прокурорын газрын Ахмадын хорооны дарга Ж.Авхиад Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээв.

-Ж.Чойжанцан Нийслэлийн, Ц.Дамдинсүрэн Говьсүмбэр, Б.Үнэнбат Ховд, Г.Ганхүү Хэнтий аймгийн, Т.Сүхбаатар Хан-Уул дүүргийн прокуророор тус тус томилогдов.

-Олон улсын Прокуроруудын холбооны 2 дугаар Их хурал, Азийн прокуроруудын ээлжит Бага хуралд Монгол Улсын Ерөнхий прокурор Н.Ганбаяр тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

## Ж.АВХИАГИЙН ГАВЬЯАГ ТӨР ҮНЭЛЭВ

УЦСЕГ-ын дарга, БНМАУ-ын прокурор, Батлан хамгаалахын сайдаар ажиллаж, хууль хамгаалах байгууллагуудыг бэхжүүлэх, боловсон хүчнээр хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход оруулсан хувь нэмэр, гавъяа зүтгэлийг нь үнэлэн Ж.Авхиад Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар гавьяат хуульч цол хүртээжээ.

Манай орны хууль, батлан хамгаалах байгууллагуудад олон жил ажиллаж, гавьяа байгуулсан Ж.Авхиа бүтээн босгож, хамгаалж асан нийгмийнхээ алдаа завхралыг амсаж, улс төрийн хилс хэлмэгдүүлэлтэд өртөж явсан ч ардчилсан төрийг босгох үйлсэд хүчин зүтгэж байсан билээ. Түүнд Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээсэнд олон жил хуулийн байгууллагын ажил хөдөлмөрийн талбарт хамт ажилласан прокурорын байгууллагын хамт олон нь талархалтай хандаж байв.

## ЭРҮҮДЭХИЙГ ЭРМЭЛЗЭГЧДИЙГ ИЛРҮҮЛЭВ

Гүйцэтгэх ажил явуулдаг байгууллагын зарим ажилтан элдэв мэдээлэл болон иргэд хоорондын аж ахуйн маргааныг эрүүгийн хэрэг болгож “шийдвэрлэх”-ээр чармайх, дураараа авирлаж хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах, хэрэг дарагдуулах, шалгалтыг удаашруулж, иргэдийг чирэгдүүлэх явдал гарч байгааг прокурорын хяналтаар илрүүлжээ. Үүн дээр үндэслэж, мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байгаа болон түдгэлзүүлсэн, хэрэгсэхгүй болгосон эрүүгийн хэргийн тооллогыг улсын хэмжээнд явуулж, иргэний эрх зөрчигдсөн нэлээдгүй зөрчлийг арилгуусан байна.

## ХОРИГДЛЫГ ХОРИГДЛООР НЬ ЭРҮҮЛЖЭЭ

УЕПГ-аас зарим нэгжүүдэд хийсэн шалгалтаар хууль зөрчсөн үйлдлүүд олон гарчээ. Тухайлбал зарим аймагт түдгэлзүүлсэн хэргийн 40 хувийг тогтоосон хугацаанд нь хянаагүй, бусдын гэрт 2 удаа буудаж ноцтой танхайрагчийн хэрэгт хорих ялын доод хэмжээгээр яллаж,

# 1998

тэнсэх санал тавьсан, хорих ангийн албан тушаалтнууд оргосон хоригдлыг “эрэн сурвалжлуулахаар” хоёр хоригдлыг явуулснаар тэд архидан согтуурч хянагчийг хутгалж гэмтэл учруулсан зэрэг хуулийн байгууллагын ажилтнуудтай холбоотой хэрэг цөөнгүй гарсныг прокурорын байгууллагаас илрүүлж, зохих арга хэмжээ авснаар хууль зөрчсөн буруутнуудад хариуцлага тооцуулсан байна.

## Н.ГАНБАЯР: АСУУДЛЫГ АЛДАА, МАДАГГҮЙ ШИЙДВЭРЛЭ...

Улсын Ерөнхий прокурор Н.Ганбаяр прокурорын байгууллагын дотоодын хяналт шалгалтыг хүчтэй явуулдаг, прокурорын ажлын арга барилд хатуу шаардлага тавьдаг байсан нь удирдах ажилтны зөвлөгөөнд тавьсан илтгэлүүдээс нь тод харагддаг.

Тухайлбал, 1998 онд “Прокуроруудын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх нь” сэдэвт илтгэлдээ “Хэрэг, зөрчлийг шалгаж, шийдвэрлэх явцад хүний эрх, эрх чөлөөнд халдах асуудлыг хянахдаа ширээний ард сууж бичиг цаастай хэт зууралдах, эсвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн санал, өмгөөлөгч, бусад хүмүүсийн гуйлт, хүсэлтэд автаж “зөвшилцдөг” арга барилаасаа эрс салж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид, тухайлбал сэжигтэн, яллагдагч, гэрч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгч зэрэг хүмүүстэй бүх шатны прокуроруд аль болохоор нүүр тулан уулзсаны үндсэн дээр асуудлыг алдаа,



Зүүн гараас туслах прокурор Ж.Одсүрэн, О.Баяраа, Ш.Тогтох, УЕП-ын орлогч Ж.Чойжанцан, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, Улсын Ерөнхий прокурор Н.Ганбаяр, ЕТГ-ын дарга С.Баяр, туслах прокурор Б.Доржготов, Т.Сүхбаатар нар Төрийн ордон, 1998 он

# 1998

мадаггүй шийдвэрлэх арга барилд шилжиж, шүүхээс шударга, зөв шийдвэр гаргахад прокурорын нөлөөллийг эрс дээшлүүлэх шаардлага амьдралаас урган гарч байна.

Сүүлийн үед хуулийн байгууллагын хүнд суртал, чирэгдэл, алдаа дутагдлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хурц ярьж, олон түмний санал, шүүмжлэл гарсаар байгаа нь манай ажлыг шинэчлэн өөрчлөхөд тус дөхөм үзүүлэх нь дамжиггүй. Үүнтэй уялдан прокурорын төв, орон нутгийн байгууллага бүр сонин, хэвлэлд гарсан санал, шүүмжлэлд зарчмын дүгнэлт хийж, ажлынхаа арга барилд шүүмжлэлтэй хандаж, хүлээх байр сууринаас биш, давшингуй, идэвхтэй, санаачлагатай хандах шаардлага чухлаар тавигдаж байна.

Түүнчлэн прокурорын хяналтын ажлын хурц үзүүрийг онц хүнд, хүнд гэмт хэрэг, олон нийтийг түгшээсэн хэрцгий, харгис шинжтэй гэмт явдал, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглүүлбэл зохино” хэмээн илтгэж байв.

## ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН НУУЦ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ПРОКУРОР ХЯНАЛТ ТАВИНА

Эрх бүхий байгууллагаас явуулж, хүний эрх, эрх чөлөөнд далдуур халддаг гүйцэтгэх ажилд прокурор хяналт тавьдаг болох талаар Улсын Ерөнхий прокурорын газраас гаргасан саналыг Монгол Улсын Их Хурал хүлээн авч Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Ингэснээр Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хуулиар Улсын аюулгүй байдлыг хангах газрын сөрөх тагнуул, Цагдаагийн ерөнхий газрын эрүүгийн алба, тагнуул, Шүүхийн шийдвэр биелүүлэх Ерөнхий газрын гүйцэтгэх албанаас явуулах гүйцэтгэх ажлын нууц үйл ажиллагаанд прокурор хяналт тавих хэм хэмжээг нарийвчлан тогтоосон байна.

Тухайлбал, тус хуульд заасны дагуу прокурор гүйцэтгэх ажлын зориулалт бүхий техник хэрэгслэлийн бүртгэл болон эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд, сэжигтэн, яллагдагчийг нууцаар дагаж ажиглах, захидал телефон




утсыг нь хянах, орон байр, эд зүйлд нууцаар үзлэг хийх ажиллагаанд зөвшөөрөл олгож, хэрэгжилтийн байдалд хяналт тавих, гүйцэтгэх байгууллагад даалгавар өгөх эрхтэй болсон аж.

Энэхүү хяналтын шинэ чиг үүрэг нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөнд тусгай арга, хэрэгслэлээр халдаж, түүнийг мөрдөн мөшгих нууц далд үйл ажиллагааг прокурор зөвшөөрч хийлгэх, эсхүл хориглож болиулах шийдвэр гаргаж, түүнийхээ хэрэгжилтэд хяналт тавьж эцсийн үр дагаврыг хариуцах нарийн зохицуулалт байлаа.

# 1999

## ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮТЭЦ ӨӨРЧЛӨГДӨВ

Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуягийн 1999 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн тушаалаар Улсын Ерөнхий прокурорын газрын зохион байгуулалт, бүтцийг захиргаа аж ахуй, санхүү, боловсон хүчний асуудал хариуцсан Хэрэг эрхлэх газар, прокурорын байгууллагын дотоодын хяналт шалгалт, доод шатны прокурорын газрын хоорондын ажлын зохицуулалт хийх чиг үүрэгтэй Шалган зааварлах хэлтэстэйгээр, Хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс, Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэс, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтэс, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэс болгож шинэчлэн өөрчилсөн нь прокурорын байгууллагын ажлын зохион байгуулалтыг оновчтой болгон, боловсон хүчний байршлыг тогтоох, хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг эрчимжүүлэх чухал шинэчлэл болсон байна.

## БИЕ ХАМГААЛАГЧТАЙ ПРОКУРОР

1999 онд Нийслэлийн прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн даргын албан тушаалд томилогдсон. Энэ хугацаанд нэлээд ноцтой, олны анхаарал татсан “Центрпойнт”, “Сэргээн босголтын банк”-ны, “Казино”-гийн хэргүүд гарч манай хэлтэс хяналт тавьж байлаа. Манай хэлтэс улсын хэмжээний хүнд, онц хүнд, ээдрээ төвөгтэй хэргүүдэд хяналт тавьж ажилладаг байсан.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ГАВЬЯАТ ХУУЛЬЧ МОНГОЛЫН АЛТАНХУЯГ



Монгол Улсын Ерөнхий прокуророор 1999-2010 онд ажилласан М.Алтанхуяг Дундговь аймгийн Цагаандэлгэр суманд 1955 онд төржээ. Тэрбээр 1978 онд МУИС-ийн Нийгмийн Ухааны факультетийн хууль зүйн салбарыг хуульч мэргэжлээр төгсчээ. М.Алтанхуяг 1978-1979 онд Дорноговь аймгийн шүүхэд шүүгч, 1979-1981 онд Хилийн цэргийн удирдах газарт нууцын офицер, 1981-1989 онд Хязгаарын цэргийн прокурорт мөрдөн байцаагч, туслах, орлогч прокурор, 1989-1990 онд Өмнөговь аймгийн прокурор, 1990-1993 онд Улсын Ерөнхий прокурорын орлогч, 1993-1999 онд өмгөөлөгч, 1999-2010 онд Монгол Улсын Ерөнхий прокуророор ажиллажээ. Түүний зүтгэлийг төрөөс үнэлж Монгол Улсын гавьяат хуульч цолоор 2009 онд шагнажээ. Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх цолтой.

# 1999

**6 сарын 3.** Монгол Улсын Их хурлын тогтоолоор Монгол Улсад прокурорын байгууллага байгуулагдсаны 70 жилийн ойг 2000 оны 8 дугаар сарын эхний долоо хоногт тэмдэглэхээр тогтоов.

**6 сарын 23.** Монгол Улсын Ерөнхий прокуророор М.Алтанхуягийг томилов.

**11 сарын 4**. Улсын Ерөнхий прокурорын орлогчоор Б.Цэрэнбалтав, Ц.Жамъяансэнгээ нарыг томилов.

**12 сарын 6.** Прокурорын байгууллагын нууц хамгаалах журмыг шинэчлэн батлав.

-Ерөнхий прокурор Н.Ганбаяр Хууль зүйн сайдын зөвлөх, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллав.

-УЕП М.Алтанхуяг “Архидан согтуурахтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай” 240 дүгээр тушаал гаргав.

-Д.Даваадорж Нийслэлийн, Д.Юра Дорноговь, А.Айтахмет Увс, Н.Тэрбиш Хөвсгөл аймгийн, Е.Сагсай Баянзүрх, Д.Цэрэнбалжир Сүхбаатар, М.Жанчив Хан-Уул, Г.Бадамханд Чингэлтэй дүүргийн прокуророор тус тус томилогдов.

Тэр үед олны анхаарал татсан, нийгмийг зарим талаараа түгшээсэн, “эрүүгийн элементүүд” гэж нэрлэгдэж байсан нэлээд олон хүн энэ хэргүүдэд хамрагдаж, шалгагдсан.

Тухайн үед УЕП-ын орлогч Ц.Жамъяансэнгээ “...хэргийн нөхцөл байдлаас шалтгаалаад прокурорт бие хамгаалагч хэрэгтэй, Цагдаагийн Ерөнхий газрын тусгай тасгаас энэ хэрэг дуустал бие хамгаалагч ажиллуулж, таны аюулгүй байдлыг хамгаална...” гэж хэлж байсан.



Прокурор Ж.Оюунчимэг, М.Дэлгэрнасан, Б.Галдаа нар шүүх хуралдааны үеэр

Эдгээр хэргүүдийг шийдвэрлэж дуусах гурван жил гаруй хугацаанд би бие хамгаалагчтай байсан.

Эргээд бодоход нэг талаас намайг хамгаалах, нөгөө талаас гадны нөлөөнд автуулахгүй гэсэн утгаар хамгаалалт өгсөн гэж боддог.

*Прокурор М.Дэлгэрнасангийн дурдатгалаас*

# 1999

## ЦЭНД-АЮУШИЙН ЖАМЬЯНСЭНГЭЭ



Ц.Жамьянсэнгээ Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод 1950 онд төрсөн. Тэрбээр 1972 онд Цэргийн Ерөнхий Дээд сургууль, 1988 онд ЗХУ-ын (хуучнаар) Дотоод явдлын яамны академи төгсчээ. Ц.Жамьянсэнгээ 1972 оноос Улсын Цагдан Сэргийлэх Ерөнхий газрын хэлтэст төлөөлөгч, 1973 оноос ахлах төлөөлөгч, 1979 оноос тасгийн дарга, хэлтсийн орлогч, 1985 оноос Улаанбаатар хотын Цагдан сэргийлэх газрын эрүүгийн хэрэг эрэн сурвалжлах хэлтсийн дарга, 1990 оноос Эрүүгийн цагдаагийн газрын дарга, 1996 оноос Нийслэлийн цагдаагийн газрын дарга, 1999 оноос Улсын Ерөнхий прокурорын орлогчоор ажиллажээ.

Тэрбээр Монголын Цагдаагийн нэртэй чекистүүдийн нэг, хурандаа байсан төдийгүй прокурорын байгууллагын удирдлагад зургаан жил ажилласан юм.

## МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ БАТ-ОЧИРЫН ЦЭРЭНБАЛТАВ



Б.Цэрэнбалтав Сүхбаатар аймгийн Баяндэлгэр суманд төржээ.

Тэрбээр 1975 онд МУИС-ийн хуулийн ангийг төгсөж, 1975-1979 онд Улаанбаатар хотын прокурорын газар криминалист-прокурор, 1979-1988 онд Дорнод аймгийн прокурорын газарт туслах, орлогч прокурор, 1988-1989 онд Улсын прокурорын газарт тусгай хяналтын прокурор, 1989-1997 онд Сүхбаатар аймгийн прокурор, 1997-1999 онд БЗД-ийн прокурор, УЕП-ын туслах бөгөөд хэлтсийн дарга, 1999-2010 онд Улсын Ерөнхий прокурорын орлогч, 2012-2013 онд Гаалийн Ерөнхий газрын дэд дарга, 2013-2017 онд Өмгөөллийн “Эрхэм хуульч” нөхөрлөлийн гүйцэтгэх захирал, 2017 оноос Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүн (орон тооны бус)-ээр ажиллаж байна.

Түүний зүтгэлийг төрөөс үнэлж Монгол Улсын Гавьяат хуульч цолоор 2010 онд шагнажээ.

# 1999



**Орлогч прокуроруудын цугларалт,**
**1999 оны 12 сарын 13-17**

**Өвөр эгнээнд баруун гараас**
-С.Дамчаасүрэн Нийслэлийн прокурорын орлогч
-О.Нямаа УЕП-ын туслах
-Б.Доржготов Нийслэлийн прокурор
-М.Алтанхуяг Улсын Ерөнхий прокурор
Ц.Жамьянсэнгээ УЕП-ын орлогч
Д.Эрдэнэбалсүрэн УЕП-ын туслах
Т.Сүхбаатар УЕП-ын туслах
С.Баттөмөр УЕП-ын туслах
М.Жанчив Хан-Уул

**Дунд эгнээнд баруун гараас**
А.Батзориг Завхан
Ц.Дамдин Сонгинохайрхан
Д.Дашдооров Өмнөговь
Ц.Түмэн Сэлэнгэ
М.Чинбат Сүхбаатар
Д.Дарьбазар Баянхонгор
Ж.Эрдэнэбаатар Дархан-Уул
Б.Баасанцэрэн Орхон
Г.Бат-Очир Ховд
Ж.Цэрэндорж Хөвсгөл
Б.Лхагважав Увс

**Арын эгнээнд баруун гараас**
Ц.Батцэнгэл Дундговь
А.Загар Өвөрхангай
Б.Төмөрчөдөр Төв
Д.Пүрэвдорж Хэнтий
Е.Сагсай Баянзүрх
Т.Энхболд Дорнод
З.Болотбек Баян-Өлгий
П.Амгаланбат Говьсүмбэр
Г.Уламбаяр Архангай
Ц.Сэлэнгэ Говь-Алтай
Ц.Сувдаа Булган
Ж.Баярсүрэн Дорноговь
Ж.Балсанлхүндэв Тээвэр









# НАЙМДУГААР БҮЛЭГ: 2000-2009 ОН





# 2000

**1 сарын 31.** Улсын Ерөнхий прокурорын тушаалаар Прокурорын Мэргэжлийн зөвлөл, Ёс зүйн зөвлөлийг тус тус байгуулж, зөвлөлийн хуралдааны дүрмийг батлав.

**2 сарын 4.** УИХ тогтоол гарган прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санд өөрчлөлт оруулав.

**2 сарын 14.** Прокурорын байгууллага байгуулагдсаны 70 жилийн ой угтсан 120 хоногийн бүтээлч ажлыг дүгнэв.

**3 сарын 10.** Улсын Ерөнхий прокурорын тушаалаар Прокуроруудын хяналтын ажлын чиглэлийг шинэчлэн тогтоов.

**3 сарын 20.** Улсын Ерөнхий прокурорын тушаалаар захиргаа болон үйлчилгээний албан хаагчдын орон тоог шинэчлэн батлав.

**3 сарын 21.** Улсын Ерөнхий прокурорын тушаалаар нийт прокуроруудын ажлын сахилга хариуцлага, удирдлага зохион

## ГУРАВ ДАХЬ УДААГИЙН СОНГУУЛЬ

Монгол Улсын Их Хурлыг сонгох гурав дахь удаагийн сонгуулиар МАХН 72, МҮАН-МШАН-ын “Ардчилсан холбоо” эвсэл 1, ИЗН-НН 1, Эх орон-МАШСН 1, бие даан нэр дэвшигч 1 суудал тус тус авч МАХН парламентад үнэмлэхүй олонхи болжээ. 2000-2004 оны УИХ бүрэн эрхийнхээ хугацаанд нийт 140 хууль шинээр баталж, 443 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан, олон улсын 110 гэрээ, конвенцийг соёрхон баталж, 51 хууль хүчингүй болгожээ. УИХ-аас Монгол Улсын Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай зэрэг томоохон хуулийг шинээр баталсантай уялдуулан Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулж батлах шаардлага урган гарсан. Түүнчлэн энэ удаагийн парламент Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг баталгаатай хангах эрхэм зорилгын хүрээнд Хүний эрхийн Үндэсний хөтөлбөрийг баталж, Хүний эрхийн үндэсний комиссыг байгуулжээ.

## ХУУЛИЙН ТӨСЛҮҮД БОЛОВСРУУЛАВ

Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурор хамтарсан захирамж, тушаал гаргав.

Түүний дагуу “Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой багц хуулийн төсөл”-ийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдав.

Бүрэлдэхүүнд нь Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав, Авлигын хуулийн төсөлд Улсын Ерөнхий прокурорын орлогч Ц.Жамъянсэнгээ, Шүүхийн хуулийн төсөлд Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор Т.Сүхбаатар, Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн төслийн ажлын хэсэгт Улсын Ерөнхий Прокурорын газрын Шалган зааварлах хэлтсийн дарга Д.Эрдэнэбалсүрэн нар оролцож, ажиллажээ.

# 2000

## СҮХБААТАР АЙМГИЙН ПРОКУРОР ТЭРГҮҮЛЭВ

Прокурорын байгууллага байгуулагдсаны 70 жилийн ой угтсан 120 хоногийн бүтээлч ажилд 100 хувийн үнэлгээ авсан Сүхбаатар аймгийн прокурорын газар (аймгийн



100 хувийн үнэлгээ авч тэргүүн байрт орсон Сүхбаатар аймгийн прокурорын газрын хамт олон

прокурор нь Б.Чойжилсүрэн) 1 дүгээр байр эзэлж, 500.000 төгрөгөөр, Өвөрхангай аймгийн прокурорын газар (аймгийн прокурор нь Б.Жаргалсайхан) 2 дугаар байр эзлэн 400.000 төгрөг, 95 хувийн үнэлгээ авсан Нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын газар (ахлах прокурор нь Е.Сагсай) 3 дугаар байр эзэлж 300.000 төгрөгөөр тус тус шагнуулжээ.

## ТВ НЭВТРҮҮЛГИЙН МӨРӨӨР

УИХ-ын сонгуулийн өмнө “Эрдэнэт” үйлдвэрийн удирдлага өмч хөрөнгө шамшигдуулсан тухай телевизийн цуврал нэвтрүүлэг цацагдаж, олон нийтийн дунд дуулиан тарив. Энэ нэвтрүүлгийн баримт үнэн эсэхийг хянаж тогтоохыг Улсын Ерөнхий прокуророос чиглэл өгсний дагуу прокурорын байгууллагаас ажлын хэсэг томилжээ.

байгуулалт, дотоодын хяналт шалгалтыг сайжруулах, боловсон хүчинтэй холбогдолтой журмыг батлав.

7 сарын 31. Прокурорын байгууллагын 70 жилийн ойг тохиолдуулан Пунсалын Дайрийжавд Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээв.

9 сард. ӨАБНУ-ын Кейптаун хотноо болсон Олон улсын прокуроруудын холбооны 5 дугаар чуулга уулзалтад Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг, орлогч прокурор Б.Цэрэнбалтав тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

12 сарын 7. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг УИХ-аас батлав.

-Улсын Ерөнхий прокурорын туслах бөгөөд Хэрэг эрхлэх газрын даргаар С.Баттөмөрийг томилов.

# 2000

-Прокурор, ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах үүднээс Өмнөговь зэрэг 11 прокурорын газрын конторын барилгыг засч, төв аппаратын конторын тавилгыг үндсээр нь шинэчлэн, 6 прокурорын газрыг конторын барилга, шинэ машинтай болгов.

-ХБНГУ-ын Техник хамтын ажиллагааны нийгэмлэг, Ханнс Зайделийн сангийн тусламжаар авсан 17 компьютер, 5 лазер принтерийг бүрэн суурилуулж, төв аппаратыг төрийн мэдээллийн болон интернет сүлжээнд холбожээ.

-А.Загар Баянхонгор, Ж.Баатаржүрмэд Говьсүмбэр, Ш.Эрдэнэбилэг Дорноговь, Б.Төмөрчөдөр Өвөрхангай, Ж.Баярсүрэн Өмнөговь, Т.Баярсайхан Төв, Ц.Отгонсүх Ховд аймгийн, Л.Болд Чингэлтэй, Д.Эрдэнэчимэг Сүхбаатар дүүргийн ахлах прокуророор томилогдов.

## СУРГАГЧ БАГШ НАРЫГ БЭЛТГЭВ

Прокурорын байгууллагын боловсон хүчний хөтөлбөрийн дагуу Германы Техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн техник, санхүүгийн тусламжтайгаар төв аппаратад “Прокурорын сургалтын төв” байгуулж, багшлах бололцоотой залуу ажилтнууд Б.Жаргалсайхан, Д.Энхтөр, Э.Амарбат, Д.Булганцэцэг, С.Алиманцэцэг, Т.Энхболд, Ц.Батболд нарыг сонгон авч ажлаас нь бүрэн чөлөөлөн 9 сарын хугацаатай герман хэлний сургалтад хамруулжээ.

## УДИРДАХ АЖИЛТНЫХАА НӨӨЦӨД АНХААРАВ

Прокурорын байгууллагыг чадварлаг боловсон хүчнээр хангах, удирдах ажилтны нөөцийг судлаж бий болгох, ажилд оршиж байсан дутагдлыг арилгах талаар анхаарч, “Прокурорын байгууллагын боловсон хүчинтэй ажиллах журам”-ыг шинэчлэн боловсруулж Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Ерөнхий прокурорын 115 тоот тушаалаар батлан мөрдүүлэв. Энэ журмын дагуу прокурорын байгууллагын удирдах ажилтны нөөцийг судлах 15 асуудал бүхий тусгай судалгаа боловсруулан орон нутгийн прокурорын газруудад хүргүүлж, оны эцэст удирдах ажилтны нөөцийн бүртгэлд оруулах прокуроруудын тодорхойлолтыг авч, судлаж дүгнэлт хийсний үндсэн дээр удирдах ажилтны нөөцийн бүртгэл судалгаатай болжээ.

## БУСДЫГ ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ЦАГДАН ХОРИХ ЯВДАЛ БУУРАХГҮЙ БАЙНА

Прокурор үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх талаар хийсэн ажил, авсан арга хэмжээ зохих үр дүнгээ өгч буй ч цаашид прокурор хяналтын объектод бүрэн хэмжээгээр хүрч ажиллахын зэрэгцээ эрүүгийн хэрэгт бусдыг үндэслэлгүйгээр

албадан саатуулах, цагдан хорих болон, прокурорын яллах дүгнэлтээр шүүхэд шилжүүлсэн хэрэг мөрдөн байцаалтанд буцах явдал төдийлөн буурахгүй байгаад дүгнэлт хийж ажиллах шаардлагатайг прокурорын удирдлагууд анхааралдаа авсан байна.

## ХУВИЙН ХЭРЭГТ БАЯЖИЛТ ТОГТМОЛЖИВ

Прокурорын байгууллагад ажиллаж буй нийт 369 прокурорын хувийн хэрэгт тухайн прокурорыг ажилд томилсон, зэрэг дэв олгосон, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, шагнал урамшил, шаардлагатай бусад мэдээлэлийг бүрэн хавсаргах замаар нийт боловсон хүчний хувийн хэрэгт баяжилтыг тогтмол хийж иржээ.

## ТОВЧХОН...

-Тайлангийн хугацаанд эрх бүхий байгууллагаас мөрдөн байцаалт явуулсан болон хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн 21321 хэргээс прокурор давхардсан тоогоор 25691 хэргийг хянаж, 8730 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлж, 1504 хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэжээ.

-2000 онд анхан шатны шүүхээр эрүүгийн 10508, аймаг, нийслэлийн шүүхийн давж заалдах болон хяналтын шатаар 2358, УДШ-ийн давах болон хяналтын шатны хурлаар 466, бүгд 17654 хэрэг хэлэлцэгдснээс прокурор анхан шатны хуралд 100 хувь, бусад шатны хуралдаанд 88,6 хувьд нь оролцсон байна.

-2000 онд прокурорын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар эрх зүйн шинэчлэлт хийх, прокурор, ажилтнуудын ажил хэрэгч байдал, сахилга хариуцлагыг өндөржүүлэх болон тэдний сэтгэлгээ, ажлын арга барилыг шинэчлэх талаар сургалт, давтан сургалт явуулах чиглэлд бодитой алхмууд хийжээ.

# 2000

## МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ ПУНСАЛЫН ДАЙРИЙЖАВ



П.Дайрийжав Архангай аймгийн Цэнхэр суманд 1946 онд төржээ.

Тэрбээр МУИС-ийн Хуулийн сургуулийг дүүргэж, 1972-1974 онд Дархан хотын прокурорт туслах прокурор, 1974-2008 онд Улаанбаатар хотын прокурорын газарт хяналтын прокурор, орлогч прокурор, Улсын прокурорын газарт хяналтын прокуророор ажиллахдаа төр, нийгмийн нэрт зүтгэлтэн С.Зоригийн амь насыг хөнөөсөн онц ноцтой хэрэгт хяналт тавьж байлаа.

П.Дайрийжавт 2000 онд Монгол Улсын Гавьяат хуульч цол олгожээ.

# 2000

## БНСУ-ЫН ПРОКУРОРТОЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА ТОГТООВ

БНСУ-ын Ерөнхий прокурор Парк Сүүн Ёны манай Улсад хийсэн айлчлалын үеэр хоёр орны прокурорын байгууллага өөрийн эрх мэдлийн хүрээнд хамтын ажиллагааг бүхий л талаар хөгжүүлэхээр харилцан тохирч хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулав. Энэ хүрээнд Ерөнхий прокурорын орлогч тэргүүтэй төлөөлөгчид БНСУ-д айлчлан Сөүл хотноо Солонгосын прокурорын газраас зохион байгуулсан Олон Улсын хуралдаанд оролцож ажил төрлийн холбоо тогтоов.



БНСУ-ын Ерөнхий прокурор Парк Сүүн Ёны урилгаар тус улсад айлчилсан Улсын Ерөнхий прокурорын орлогч Ц.Жамьянсэнгээ БНСУ-ын Ерөнхий прокурорын орлогч Шин Сун Намын хамт, 2000 он




Улсын Ерөнхий прокурорын газрын хамт олон сар шинийн баярыг тохиолдуулан ахмадуудаа хүлээн авав, 2000 он

# 2000

## АКАДЕМИЧ СОДОВСҮРЭНГИЙН НАРАНГЭРЭЛ



С.Нарангэрэл Төв аймгийн Сэргэлэн суманд 1953 онд төржээ. Тэрбээр 1971-1975 онд МУИС, 1984-1988 онд Москва хотноо Бүх Холбоотын Институтэд суралцаж, улмаар Хууль зүйн шинжлэх ухааны доктор, ШУА-ийн гишүүн, академич, МУИС-ийн Эмирет Профессор цол хүртжээ. С.Нарангэрэл 1975-1985 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд багш, 1985-1988 онд Улаанбаатар хотын прокурорын орлогч, 1988-1990 онд Улсын прокурорын туслах, 1990-1991 онд Засгийн газрын дэргэдэх судалгааны төвд эрдэм шинжилгээний ахлах ажилтан, 1991-1992 онд Парламентын дэргэдэх академийн дэд захирал, 1992-1996 онд УИХ-ын гишүүн, 1996-1997 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд профессор, 1997-2000 онд Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Ерөнхийлөгч, 1999-2010 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, 2010 оноос МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессороор ажиллаж байна.

С.Нарангэрэл Монголын хуульч-эрдэмтдийн дотроос анх удаа 2000 онд ШУА-ийн жинхэнэ гишүүнээр сонгогдож, хууль зүйн шинжлэх ухааныг хүлээн зөвшөөрүүлж чадсан билээ.

Академич С.Нарангэрэлийн “Хууль зүйн англи-монгол-орос толь” (1994), “Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо” (2001), “Правовая система Монголия.., Москва” (2004), “Legal system of Mongolia., Japan, Nagoya University” (2004), “Эрх зүйн эх толь бичиг” (2007, 2008, 2011), “Монголчуудын зан суртахууны гарваль” (2010), “Хууль зүйн англи-монгол-эх толь” (2012), “Чингис хааны сүр хүч” (2013), “Чингис хааны ёс суртахуун эрх зүйн шастир” (2014), “Монголын эрх зүйн эх толь бичиг” (дөрөв дэх хэвлэл, 2015) зэрэг олон бүтээл нь нийтийн хүртээл болжээ. Түүний бичсэн бичсэн “Монгол улсын эрх зүйн тогтолцооны удиртгал” ном англи, орос, хятад, япон, герман хэлнээ орчуулагджээ. С.Нарангэрэлийн удирдлагаар 20 шахам хүн хууль зүйн шинжлэх ухааны болон боловсролын докторын зэрэг хамгаалжээ.



ӨАБНУ-ын Кейптаун хотноо болсон Олон улсын прокурорууудын холбооны ээлжит V хуралдаанд Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг тэргүүтэй төлөөлөгчид оролцов. 2000 он

# 2001

1 сарын 28. Монгол Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг БНСУ-ын Ерөнхий прокурор Парк Сүүн Ёнгийн урилгаар БНСУ-д албан ёсны айлчлал хийв. БНСУ-ын Прокурорын байгууллагаас Монгол улсын Ерөнхий прокурорын газарт 474.008.9 мянган вонны үнэ бүхий диктафон приставка видео камер зэрэг 163 нэр төрлийн техник хэрэгслэлийг бэлэглэжээ.

5 сард. Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран прокуроруудын ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшинг шалгаж, 318 прокурорыг хамруулснаас 92.2 хувь нь “Онц сайн” буюу хангалттай үнэлгээ авчээ.

5 сарын 17. УИХ-аас Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоол батлав.

6 сард. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль явагдаж, МАХН-аас нэр дэвшүүлсэн Н.Багабанди хоёр дахь удаагаа Монгол Улсын Төрийн тэргүүнээр сонгогдов.

## ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС БАЙГУУЛАГДАВ

Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг баталсны дагуу УИХ-ын 2001 оны 1 дүгээр тогтоолоор Хүний эрхийн Үндэсний комиссын даргаар прокурорын ууган ажилтны нэг, Хууль зүйн ухааны доктор С.Цэрэндорж, комиссын гишүүнээр Г.Далайжамц, Ж.Дашдорж нарыг тус тус томилсноор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс байгуулагдав. Тус комиссын гишүүдийн дараагийн томилгоонуудад прокуророор ажиллаж байсан Н.Ганбаяр, П.Оюунчимэг нар оржээ. Ийнхүү Хүний эрхийн Үндэсний комисст прокуроруудын нөлөө хүчтэй хэвээр байсаар байна.

## ХҮНИЙ НӨӨЦӨӨ СЭЛГЭН АЖИЛЛУУЛЖЭЭ

Улсын Ерөнхий прокурорын газар 2001 оны хавар нийслэл дүүргийнхээ 126 прокурорынхоо 33.3 хувийг “бужигнуулав”. Тэдний заримыг ажлаас халж, заримыг дэвшүүлж, шагнасны дотор УЕПГ-ын Мөрдөн байцаах ажилд хяналт тавих хэлтсийнхний 73 хувийг дүүрэгт шилжүүлжээ.

Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав энэ сэдвээр сэтгүүлчийн асуултад хариулахдаа “...Бид нийслэл, дүүргүүдийнхээ прокурорын байгууллагад шалгалт хийсэн. Шалгалт боловсон хүчний сахилга, хариуцлага, мэдлэг чадвар ёс зүйд үнэлэлт өгөх, ажлын шинэ нөхцөл байдалд нийцэж байгаа эсэхийг тогтоох, хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх зэрэг иж бүрэн дүгнэлт гаргах зорилготой байсан” хэмээжээ.

## ЭРХЗҮЙН ШИНЭЧЛЭЛ ГҮНЗГИЙРЭВ

2001 оноос эхэлсэн эрхзүйн шинэчлэл үргэлжилж, хуулийн багц төслүүд боловсруулах ажлын хэсгийнхэн жил тойрон ур ухааная уралдуулав. Өөрсдөө хэрэгжүүлэх хуулиуд тул ажлын хэсэг эрхзүйн чиглэлийн хуулиудын

# 2001

боловсруулалтад нягт, нямбай, болгоомжтой, бас шүүмжлэлтэй хандаж байжээ.

Эдгээр хуулийг шинэчлэн боловсруулах хамтарсан ажлын хэсэгт Ц.Жамъянсэнгээ, Т.Сүхбаатар, Д.Эрдэнэбалсүрэн нарын прокурор оролцсоноос гадна Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэхэд Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав голлож, Нийслэлийн прокурор Д.Даваадорж, хяналтын прокурор Е.Сагсай нар удирдлагад нь чухал үүрэг гүйцэтгэжээ.

## ЗАСГИЙН ГАЗРЫГ БУРУУГҮЙ ГЭЖ ЗАРЛАВ

Увс аймгийн Малчин сумын нутагт УИХ-ын гишүүн Ш.Отгонбилэг болон НҮБ-ын Гамшиг үнэлэх, зохицуулах багийн гишүүд амь насаа алдсан Ми-8 онгоцны осол гарч 1 дүгээр сарын 14-нд улс даяар гашуудал зарлав.

НҮБ-ын багт явсан япон иргэний ар гэрийнхэн НҮБ-ын ажилтнуудын аюулгүй байдлыг хангаагүй гэдэг үндэслэлээр Монгол Улсын Засгийн газрыг буруушаав. Энэ хэргийн буруутан хэн бэ гэдгийг тогтоох онгоцны ослын хэрэг мөрдөн байцаалтад хэд хэдэн удаа буцжээ.

Нисдэг тэрэг осолдсон хэрэг болон нислэг үйлдэхээс өмнөх үйл ажиллагааг прокурорын байгууллагын зүгээс шалгаж, Монгол Улсын Засгийн газар буруутай үйл ажиллагаа явуулсан гэх нотолгоо байхгүйг зарласан байна.

## ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛ

Прокуроруудын санаачлагаар байгуулагдсан төрийн бус байгууллага “Эрх чөлөө, эрх зүйт ёс” холбоо, УИХ-ын Тамгын газартай хамтран Австралийн Мельбурнийн их сургууль, АНУ-ын Вашингтоны их сургуулийн Ази, Номхон далайн орнуудын эрх зүйн судлалын төв зэрэг олон улсын нэр хүнд бүхий байгууллагын эрдэмтэн багш нарыг урьж “Хөгжиж буй болон шилжилтийн нөхцөл дэх орнуудын эрх зүйн шинэтгэл” сэдэвт олон улсын бага хурал амжилттай зохион байгуулав.

**6 сарын 7.** УИХ-аас Прокурорын албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл олгох журам батлах тухай тогтоол батлав.

**7 сард.** “Хөгжиж буй болон шилжилтийн нөхцөл дэх орнуудын эрх зүйн шинэтгэл” сэдэвт олон улсын Бага хурлыг “Эрх чөлөө, эрх зүйт ёс” холбоо ТББ зохион байгуулж, прокурор, ажилтнууд хамрагдав.

**9 сард.** Австрали улсын Сидней хотод хуралдсан Олон улсын Прокуроруудын Холбооны ээлжит 6 дугаар хуралдаанд Ерөнхий прокурор М.Алтанхуяг тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

**11 сард.** Улсын Ерөнхий прокурорын газарт хэвлэл мэдээллийн алба байгуулагдав.

**11 сард.** БНХАУ-ын Гуанжоуд хуралдсан Ази, Европын орнуудын Ерөнхий Прокуроруудын уулзалт хуралдаанд Ерөнхий прокурор М.Алтанхуяг тэргүүтэй төлөөлөгчид оролцож улс дамжсан гэмт хэрэгтэй тэмцэх арга замын талаар илтгэл тавьжээ.

# 2001

-Боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах сургалтын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор “Прокуроруудын сургалтын төв” байгуулав.

-“Прокурор 2001” вэб хуудсыг ашиглалтад оруулав.

-Б.Жаргалсайхан Тээврийн прокурор, М.Чинбат Сүхбаатар, Ц.Сэлэнгэ Дундговь, Б.Батхуяг Завхан, С.Цэрэнсамбуу Өвөрхангай, Ц.Өлзийбаяр Сэлэнгэ, Б.Баасанцэрэн Төв, Б.Пүрэвжав Ховд аймгийн, Г.Энхтүвшин Налайх, Б.Чойжилсүрэн Хан-Уул, Г.Бадамханд Сонгинохайрхан, Д.Пүрэвдорж Багануур, Г.Энхтүвшин Налайх дүүргийн, А.Ганзориг Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын прокурорын газрын ахлах прокуророор тус тус томилогдов.

## ГАДААД ХАРИЛЦАА ЭРЧИМЖИВ

Энэ онд БНСУ-ын Ерөнхий прокурор Пак Сүн Ёнгийн урилгаар Монгол Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг тус улсад албан ёсны айлчлал хийсэн бол Австрали улсын Сидней хотод 9 дүгээр сард хуралдсан Олон улсын прокуроруудын Холбооны ээлжит 6 дугаар хуралдаан, ХБНГУ-ын Бавари муж улсын хуулийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах 14 хоногийн сургалт, аялал, БНХАУ-ын Гуанжоу хотод 11 дүгээр сард хуралдсан Ази, Европын орнуудын Ерөнхий прокуроруудын уулзалт хуралдаанд прокурорын төлөөлөгчид оролцож улс дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх талаар улс орнууд, хуулийн байгууллагатай хамтран ажиллахаар тохиролцжээ.

## “ПРОКУРОР 2000” ПРОГРАММ

Прокурорын байгууллагын үйл ажиллагаа, хяналтын ажлын бүртгэл судалгаанд компьютерийг ашиглахад зориулан ГТХАН-ийн тусламжтайгаар боловсруулсан “Прокурор 2000” програмыг хийж, хэрэглэж эхлэв. Түүнчлэн Монгол Улсын эрх зүйн актын мэдээллийн сан, хуулийн программыг суурилуулснаар 4000 гаруй эрх зүйн акт, үүнээс бие даасан 242 хууль, Засгийн газрын 1458 тогтоол, Улсын Их Хурлын 400-аад тогтоол, Ерөнхийлөгчийн 100-гаад зарлиг, Улсын Дээд Шүүхийн 100 тогтоол зэргийг авах боломжтой болжээ.

## ТООНЫ ХЭЛЭЭР

-2001 онд улсын хэмжээгээр 16209 мөрдөн байцаалтын хэрэгт прокурор хяналт тавьж ажилласнаас 8442 хэрэгт нь яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн байна.

-2001 онд анхан шатны эрүүгийн шүүх хурлаар 10028, аймаг, нийслэлийн шүүхийн давах болон хяналтын шатны эрүүгийн шүүх хурлаар 2299, УДШ-ийн мөн шатанд 366 бүгд 12693 хэрэг хэлэлцэгдсэнээс прокурор давах болон хяналтын шатны 2561 хэргийн шүүх хуралд оролцсон байна.

# 2001

## ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ БОЛОВ

Хуулийн байгууллагуудын нэгдсэн вэб хуудаст прокурорын байгууллагын вэб хуудсыг боловсруулан суурилуулснаар олон нийт прокурорын байгууллагын тухай үнэн зөв мэдээллийг цаг алдалгүй түргэн шуурхай авах боломжтой болсон төдийгүй иргэдээс тус байгууллагад гаргасан санал хүсэлт, гомдлыг интернетээр авах, өгөх боломж бүрджээ.

## 31 МЯНГАН ХҮНИЙГ ЦАГААТГУУЛАВ

Прокурорын байгууллагаас улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах талаар сүүлийн 10 жилд хийсэн ажлын нэгдсэн судалгааг гаргаж 31 мянган хүнийг цагаатгасны Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст танилцуулжээ.

***Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс...***

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУШААЛ**

2001 оны 12 дугаар сарын 19-ны өдөр — Дугаар 377 — Улаанбаатар - Бага тойруу - 1 Утас: 327835

Зохион байгуулалтын өөрчлөлт хийх тухай

Прокурорын байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 11 дэх заалт, Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх зөвлөлийн хурлын 2001 оны 9 дүгээр сарын 28 ний өдрийн шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, хариуцах ажлын байдал зэргийн харгалзан Улсын Ерөнхий Прокурорын газрын Шалган зааварлах хэлтсийн нэрийг Бодлого төлөвлөлт, Гадаад харилцааны хэлтэс гэж өөрчилсүгэй.

2. Улсын Ерөнхий Прокурорын газрын Бодлого төлөвлөлт, Гадаад харилцааны хэлтсийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны чиг үүрэг ажилтнуудын ажил үүргийн хуваарийг хавсралт ёсоор шинэчлэн батлсугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Улсын Ерөнхий прокурорын 1999 оны 7 дугаар сарын 5 ний өдрийн 245, мөн оны 10 сарын 01 ний өдрийн 354 тоот тушаалын холбогдох заалтуудыг тус, тус хүчингүй болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ — М. АЛТАНХУЯГ

# 2002

**4 сард.** Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди прокурорын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж үүрэг даалгавар өгөв.

**5 сарын 21.** Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Хуульзүй, дотоод хэргийн сайдын хамтарсан захирамж, тушаалаар “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд холбогдох баримтын төрөлжсөн архивын ажлын заавар”-ыг батлав.

**7 сарын 4.** Прокурорын байгууллагын тухай хуулийг бусад хуулиудтай уялдуулан шинэчлэн найруулж УИХ батлав.

**8 сарын 30.** Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди “Прокурорын тангараг өргөх ёслолын журам” батлав.

**9 сарын 1.** Улсын Ерөнхий прокурорын дэргэд Мөрдөн байцаах алба шинээр байгуулагдаж ЭБШ хуулиар харьяалуулсан тусгай субьектүүдтэй холбоотой гэмт хэргийн тухай гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргүүдийг хүлээн авч шалгах, мөрдөн байцаалт явуулах үүргээ хуулийн хүрээнд эхэлжээ.

**9 сард.** ИБУИНВУ-д хуралдсан Олон Улсын Прокурорын холбооны ээлжит 7 дугаар хуралдаанд Ерөнхий прокурор М.Алтанхуяг тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

## Н.БАГАБАНДИ: “АРДЧИЛСАН ТӨРИЙН ХУУЛЬ САХИУЛАГЧИЙН ЁС ЗҮЙГ ЭРХЭМЛЭ”

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди прокурорын байгууллагын зарим нэгжийн үйл ажиллагаатай танилцахдаа “Эрхзүйн шинэ орчин нь прокурор бүрээс үйл ажиллагаа, арга барил, оюун сэтгэлгээний эрс шинэтгэлийг шаардаж



байгааг ухамсарлан өмнө нь хийж дадсан ажил, болоод байсан юм болох л байлгүй гэсэн уламжлалт сэтгэлгээнд хүлэгдэлгүйгээр өөрийгөө үргэлж хөгжүүлж, шинийг эрэлхийлж, хичээл зүтгэл гарган ажиллах, прокурорын үйл ажиллагаа, хяналтыг хэрэгжүүлэх, төр, нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах явцдаа иргэн төр хоёр адил тэнцүү эрхзүйн байдалд байдаг зарчмыг харгалзан үзээрэй. Хууль ёсыг сахиулахдаа хүмүүст хүн ёсоор хандан ардчилсан төрийн хууль сахиулагчийн ёсзүйг эрхэмлэн ажиллах нь чухал” хэмээн онцлон тэмдэглэж байв.

## ПРОКУРОРЫН ЭРХ ХЭМЖЭЭ, ХАРИУЦЛАГА НЭМЭГДЭВ

Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудыг шинэчлэн найруулж баталсантай

# 2002

холбогдуулан Прокурорын байгууллагын тухай хуулийг уялдуулах, нөгөө талаас нийгмийн хөгжлийн үйл явцтай холбоотойгоор прокурорын үйл ажиллагааны эрхзүйн үндсийг улам боловсронгуй болгох шаардлага үүссэнтэй холбоотойгоор УИХ-аас Прокурорын байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулж 7 дугаар сарын 04-ний өдөр эцэслэн батлав.

Энэ хуулиар “Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн” гэж тодорхойлон заажээ.

Үүний зэрэгцээ прокурорын байгууллагад улсын хэмжээний эрүүгийн хэргийн нэгдсэн тоо бүртгэл, Эрүүгийн хэргийн архив, Улсын Ерөнхий прокурорын дэргэд тусгай субъектүүдийн үйлдсэн эрүүгийн хэргийг шалгах Мөрдөн байцаах албыг тус тус шинээр байгуулж, төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд түүний ашиг сонирхлыг хамгаалан оролцох, прокурорын туслах ажилтны албыг бий болгож, тэдгээрээс боловсон хүчний нөөцийг бүрдүүлэх журам тогтоох, Мэргэжлийн зөвлөл байгуулах зэрэг зарчмын өөрчлөлтүүд хийгджээ.

## ШҮҮХИЙН ӨМНӨХ ШИЙДВЭРИЙГ ПРОКУРОР ГАРГАНА

Энэ үед цагдаагийн байгууллагын 1400 хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэдэг, хэргийг хэрэгсэхгүй болгодог, үүсгэхээс татгалздаг байв. Иймхүү прокуророос гадуур хавтгайруулсан шийдвэр гаргадаг, асуудал шийддэг байсныг засаж Эрүүгийн хэргийн дугаар олгох, эрүүгийн хэрэг үүсгэх зөвшөөрөл өгөх, хэрэг хэрэгсэхгүй болгох, сэргээх, түдгэлзүүлэх, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах эрх мэдлийг зөвхөн прокурор хэрэгжүүлж байхаар хуульд тусгажээ. Шүүхийн шатанд очсоныг шүүх шийднэ, шүүхийн өмнөх шийдвэрүүдийг прокурор гаргана гэсэн хоёр үе шаттайгаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгаж өгсөн.

10 сарын 8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Прокурорын ёс зүйн дүрэм, Прокурорын сахилгын дүрмийг тус тус батлав.

10 сарын 9. Төв, орон нутгийн прокурорын байгууллагын 24 газарт 370 гаруй прокурор анх удаа төрийн алтан соёмбот тугандаа тангараг өргөв.

-“Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх сангийн дэмжлэгээр 20 сая төгрөгийн 42 комьпютер авч Улсын Ерөнхий прокурорын газар, Дундговь, Дархан-Уул, Нийслэл, Сонгинохайрхан дүүргийн прокурорын газруудад хуваарилан өглөө.

-Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудыг УИХ баталж гаргав.

-”Прокурорын мэдээлэл” сэтгүүлийг улирал тутам эрхлэн гаргаж, prokuror.mn вэб хуудсаар дамжуулан үйл ажиллагааны мэдээллийг олон нийт болон прокуроруудад хүргэх болов.

-Хуулиуд шинэчлэгдсэнтэй холбогдуулан “Прокурорын ном” гарын авлагын хоёр дахь ботийг ХБНГУ-ын Техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран гаргав.

# 2002

-Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын чиг үүрэгт хамаарч байсан дотоод хяналт, Ерөнхий прокурорын бодлогын хэрэгжилтийг хангах үүрэгтэй хэлтсийг “Бодлого төлөвлөлт, гадаад харилцааны хэлтэс” нэртэй болгон өөрчлөв.

-ИБУИНВУ-д хуралдсан Олон улсын прокуроруудын холбооны хуралдаан, Тайланд улсын Бангкокт болсон ОУПХ-ны Ази Номхон далайн бүс нутгийн анхдугаар хуралдаан, Тайланд улсад хүний эрхийн чиглэлээр, Кыргызстан, Энэтхэгт авлигын гэмт хэргийн чиглэлээр тус тус зохион байгуулагдсан хурал семинарт прокурорууд оролцов.

-Д.Дарьбазар Булган, Ц.Батцэнгэл Говьсүмбэр аймгийн, Б.Батхуяг Баянгол, Х.Алтанзүрх Баянзүрх дүүргийн ахлах прокуророор тус тус томилогдов.

## ПРОКУРОРУУД АНХ ТАНГАРАГ ӨРГӨВ

Прокурорын байгууллагын тухай хуульд “Прокурор албан тушаалд томилогдохдоо Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулийг чанд сахиж, прокурорын байгууллагын нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, гадны нөлөөнд үл автах, хуулийг нэг мөр хэрэглэх зарчмыг гүнээ хүндэтгэн, албаны үүргээ үнэнч шударгаар биелүүлж, прокурорын ёс зүй, нэр хүндийг өндөрт өргөж явахаа тангараглая. Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал хуульд заасан



хариуцлагыг хүлээнэ” гэж заасны дагуу (Ерөнхийлөгчийн зарлигаар) Тангараг өргөх ёслолын журмыг баталжээ. Ёслолын ажиллагаа 10 дугаар сарын 8-ны өдөр орон даяар анх удаагаа болсон байна.

## ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ МӨРДӨН БАЙЦААХ АЛБЫГ БАЙГУУЛАВ

УИХ, Засгийн газрын 47, 179 дүгээр тогтоолоор Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг дарга, дэд дарга, 24 мөрдөн байцаагчийн орон тоотой байгуулж 9 дүгээр сараас эхлэн үйл ажиллагааг эхлүүлснээр тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн гэмт хэргийг бие даасан бүтэц, зохион байгуулалт бүхий мэргэжлийн тусгай

# 2002

байгууллага шалгах боломж бүрджээ.

Уг тогтоолын дагуу Улсын Ерөнхий прокурорын дэргэд Мөрдөн байцаах алба байгуулж, тус албанд ажиллах мөрдөн байцаагчдыг орон тоо, төсөв, эд хөрөнгө, техник хэрэгслийн хамт 2002 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Цагдаагийн байгууллагаас Улсын Ерөнхий прокурорын мэдэлд шилжүүлсэн байна. Прокурорын дэргэд Мөрдөн байцаах албыг байгуулснаар хуулийн байгууллагуудын хүрээнд хууль ёсыг хэлбэрэлтгүй чанд сахих хариуцлагын тогтолцоог бий болгов.

## ХЯНАЛТЫН ПРОКУРОРУУД ДЭВШИВ

Прокурорын байгууллагын тухай шинэ хууль, зарим чиг үүрэгт зарчмын өөрчлөлтүүд орсонтой холбогдуулж хяналт тус бүрийн чиглэлээр сүүлийн 3 жилд хийсэн ажлын дунджийг судлаж, прокуроруудыг зөв зохистой байршуулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, нягтруулах арга хэмжээг авчээ.

Булган, Говьсүмбэр, Ховд аймаг, Багануур дүүрэг зэрэг 4 прокурорын газарт ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хяналтын прокурорыг туслах прокурор, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих 51 прокурорыг хэрэг бүртгэлтийн ажиллагаанд хяналт тавих прокурор болгон чиг үүргийг нь өөрчилж, Нийслэлийн 7 дүүргийн прокурорын газарт орлогч, туслах прокурорыг шинээр томилж, Прокурорын байгууллагын бүтэц, орон тоо болон прокуроруудын хяналтын ажлын чиглэлийг шинэчилжээ.

Тухайлбал, хяналтын прокурор А.Дулмаа, М.Гантулга, Ш.Оюунбилэг, Д.Энхтөр нар дүүргийн прокурорын газруудад орлогч прокуророор, хяналтын прокурор Ц.Осоржамаа, Д.Мөнх-Очир, Н.Энхтуяа, С.Нансалмаа нарыг дүүргийн прокурорын газруудад хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих туслах прокуророор тус тус дэвшүүлэн томилж ажиллуулжээ.

## ЭРХЗҮЙН ШИНЭ ОРЧИНД АЖИЛЛАВ

Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Прокурорын байгууллагын тухай хууль зэрэг прокурорын хяналтын ажлын эрх зүйн хуулиуд шинээр батлагдсаны дагуу прокурорын хийх ажил үүрэг, хариуцлага нэмэгдэж, энэ хүрээнд прокурорын байгууллагын бүтэц, орон тоо, “Прокуроруудын хяналтын ажлын чиглэл”-ийг өөрчилж, Улсын Ерөнхий прокурорын тушаалаар тус тус баталсан байна.

## ДҮРЭМ ЖУРМАА ШИНЭЧЛЭВ

Шинээр батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан “Прокурорын ёс зүйн дүрэм”, “Прокурорын тангараг өргөх ёслолын журам”, “Прокурорын зэрэг дэв олгох дүрэм”, “Прокурорын байгууллагын бэлэгдэл, прокурорын энгэрийн тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журам”, “Прокурорын сахилгын дүрэм“ зэрэг дүрэм журмыг шинэчлэн боловсруулж Монгол Улсын Ерөнхийлөгчийн 148 дугаар зарлигаар батлуулжээ.

# 2002

## МЭРГЭЖЛИЙН ТҮВШИНГ ТОГТООВ

Энэ онд батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуультай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 148 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралтаар “Прокурорын ёс зүйн дүрэм”, хоёрдугаар хавсралтаар “Прокурорын сахилгын дүрэм”-ийг батлан гаргав. Ингэснээр прокуроруудын мэргэжлийн ур чадвар, ажил хэргийн болон ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн чухал алхам болжээ.

Прокурорын хяналтын цар хүрээ өссөн, хууль ёс сахиулах үүрэгтэй тусгай субьектүүдийг хянан шалгах албатай болсон тул прокуроруудын өөрсдөө ч ёсзүй, хариуцлагын өндөр чадамжтай байх нь зүй ёсных билээ.

## 4 ТЭРБУМЫН ХОХИРОЛ БАРАГДУУЛАВ

Прокуророос төрийн байгууллагыг төлөөлж нэхэмжлэгч, хариуцагчийн өмгөөлөгчөөр оролцсон 84 хэргийг шүүх шийдвэрлэхдээ 75 хэргийн 4 тэрбум 441 сая төгрөгийн хохирлыг прокурорын тайлбар хүсэлтийн дагуу барагдуулж шийдвэрлэсэн байна.

Шүүхэд төрийг төлөөлөх чиглэлээр прокуроруудын энэ онд бүх шатны шүүхийн эрүүгийн 11826 хуралдаанд оролцсоны дотор давж заалдах шатны шүүхийн нийт хуралдааны 98,1 хувьд нь оролцож дүгнэлт гаргасан нь өмнөх оныхоос өссөн байна. Анхан болон давах, хяналтын шатны шүүхээс 500 хэрэг нэмэлт мөрдөн байцаалтад буцсан нь өмнөх оныхоос мөн 9,6 хувиар өсчээ.

Аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн прокуророос 391 хэрэгт, Улсын Ерөнхий прокурорын газраас 40 хэрэгт эсэргүүцэл



Монгол Улсын Ерөнхийлөгч Нацагийн Баганбанди
прокурорын байгууллагын хамт олонтой

# 2002

бичиж нийт эсэргүүцлийн 61,7 хувь буюу 226 нь биелэгджээ. Шинээр батлагдан мөрдөгдөж буй Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар улсын яллагч давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд эсэргүүцэл бичих эрхтэй болсон юм. Энэ нь нэг талаас улсын яллагч шүүн таслах ажиллагааны явцад гарсан алдаа зөрчлийг цаг алдалгүй илрүүлж, зөвтгүүлэх боломжийг бий болгоход чиглэсэн эрх зүйн зохицуулалт болсон бөгөөд нөгөөтэйгүүр улсын яллагч эсэргүүцлийг хуульд заасан хугацаанд, үндэслэлтэй бичих явдал чухлаар тавигджээ.

## БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ ЯВДЛЫГ БАГАСГАВ

2002 оны эхний 8 сард 6105 хүнийг албадан саатуулж, 3005 хүнийг цагдан хорьсон бол сүүлийн 4 сард 159 хүнийг баривчилж, 182 хүнийг цагдан хорьж хөнгөн, хүндэвтэр хэрэгт үндэслэлгүйгээр баривчлах, цагдан хорих явдал эрс багассан байна.

## БУСДААСАА ИЛҮҮ САЙН АЖИЛЛАВ

Шинэ хуулиудыг хэрэгжүүлж, шинэ бүтэц зохион байгуулалтаар ажилласан 2002 оны сүүлийн 4 сарын хугацаанд эрүүгийн хэрэг бүртгэлтийн ажиллагаанд тавих хяналтын ажлын чанарын гол гол үзүүлэлтээр Нийслэл, дүүргийн прокурорын газрууд, Говь-Алтай, Баян-Өлгий, Говьсүмбэр, Орхон, Баянхонгор, Ховд, Тээврийн прокурорын газрууд бусдаасаа илүү сайн ажилласан байна.



Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди, Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг нар Тээврийн прокурорын газрын хамт олонтой, 2002 он

# 2003

**5 сарын 30.** УИХ-аас Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлав.

**9 сарын 3.** Улсын Ерөнхий прокурор, Цагдаагийн Ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Мөрдөн байцаах алба, цагдаагийн байгууллагын ажлын уялдааг сайжруулах, харилцан мэдээлэл солилцох журмыг батлан хэрэгжүүлжээ.

**10 сарын 28.** Улсын Ерөнхий прокурорын тушаалаар прокурорын ёс зүйг сахиулах, авлигаас урьдчилан сэргийлэх асуудал эрхлэх орон тооны бус зөвлөл байгуулж, даргаар нь Улсын Ерөнхий прокурорын туслах, Хэрэг эрхлэх газрын дарга С.Баттөмөр, гишүүдэд Нийслэлийн прокурор Д.Даваадорж, хяналтын прокурор Д.Чулуунбат нарыг томилж, хяналт тавихыг Улсын Ерөнхий прокурорын орлогч Ц.Жамъянсэнгээд хариуцуулжээ.

## БОЛОВСОН ХҮЧИНД ШАЛГУУР ТАВИВ



Урд эгнээнд зүүнээс Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав, Монгол Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх Г.Баясгалан, Ерөнхий прокурорын орлогч Ц.Жамьянсэнгээ нар УЕПГ-ын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга, прокурорууд, 2003 он

Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ батлав. Энэхүү хуульд Прокурорын байгууллагын тухай хуулийн 39.1, 45.1-ийн “Хууль зүйн бакалаврын боловсролтой” гэснийг “Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан” гэж өөрчилжээ.

Ингэснээр “Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан, мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвараар шаардлага хангасан, хуульчийн мэргэжлээр гурваас доошгүй, эсхүл прокурорын туслах ажилтнаар хоёроос доошгүй жил ажилласан, ял шийтгүүлж байгаагүй, хорин гурван нас хүрсэн Монгол Улсын иргэнийг прокуророор томилно” хэмээн хуульчлагдаж, прокурорын байгууллагын боловсон хүчинд өндөр шалгуур тавьжээ.

# 2003

## ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТӨВ АРХИВ

2002 онд батлагдсан Прокурорын байгууллагын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1-т “Улсын Ерөнхий прокурорын газарт Эрүүгийн хэргийн төв архив, сум, сум дундын прокурорын газраас бусад прокурорын газарт түүний салбар архив ажиллана”, УИХ-ын 2002 оны 47 дугаар тогтоолд “Эрүүгийн хэргийн улсын нэгдсэн архив, түүний салбар нэгжийн хэвийн ажиллагааг хангахад шаардагдах ажлын байр, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах арга хэмжээ авах” тухай тогтоолын дагуу бэлтгэл ажлыг хангасны дүнд Улсын Ерөнхий прокуророос “Эрүүгийн хэргийн улсын нэгдсэн архив, түүний салбар нэгжийн хэвийн ажиллагааг хангахад шаардагдах ажлын байр, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах арга хэмжээ авах” тушаал гаргав.



Эрүүгийн хэргийн төв архивын хамт олон, 2020 он

Тушаалаар Эрүүгийн хэргийн төв архивыг УЕПГ-ын, салбар архивын газруудыг аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурорын газруудад байгуулан ажиллуулав. Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Эрүүгийн хэргийн төв архивын эрхлэгчээр Д.Хуяг, Ж.Ичинхорлоо, н.Чинзориг, У.Сэлэнгэ, Л.Болд нар ажиллаж байсан бол 2018 оны 3 сараас хойш Ж.Чимгээ ажиллаж байна.

**11 сарын 13.** Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим хэсгийг УИХ-аас хүчингүй болгов.

-Тайваний шүүгч, прокуроруудын мэргэжил дээшлүүлэх институтэд прокуроруудыг мэргэжил дээшлүүлэв.

-Г.Бат-Очир Баянхонгор, Д.Энхтөр Говь-Алтай, Ш.Сүхбат Дархан-Уул, Л.Батчулуун Дорноговь, Ш.Эрдэнэбилэг Дорнод, Г.Ганбадрах Завхан аймгийн прокурорын газрын ахлах прокуророор, Д.Бат-Эрдэнэ Сүхбаатар, Ү.Содномцог Хан-Уул дүүргийн, Б.Мөнхбаяр Завхан аймгийн Тосонцэнгэл дэх, Ш.Батаа Өвөрхангай аймгийн Хархорин дахь сум дундын прокурорын газрын ахлах прокуророор томилогдов.

# 2003

## СУРГАЛТЫН ШИНЭ ЭХ ҮҮСВЭРҮҮД БИЙ БОЛГОВ

Хандивлагч байгууллагуудын тусламж-тайгаар сургалтын шинэ эх үүсвэрүүдийг бий болгож, дахин сургалтын дэд хороо байгуулав. Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу шинэ зууны прокурорууд-ыг давтан сургах эхлэл эндээс тавигдаж улмаар Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлсэн Хуульчдыг давтан сургах төсөл, АНУ-ын Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр, Хуульзүйн үндэсний хүрээлэн болон бусад төсөл, төрийн бус байгууллагуудтай хамтран явуулсан онол, арга зүйн төрөл бүрийн сургалт, түүнчлэн хуульчдаас сонгон шалгаруулах журмын тухай хуулийн дагуу заавал хамрагдвал зохих кредит цагийн сургалт зэрэг сургалтуудад прокурорууд-ыг хамруулжээ.

Түүнчлэн ОХУ, ХБНГУ, БНСУ, Тайвань, Энэтхэг, Тайланд, Египет, Япон зэрэг гадаадын 14 оронд зохион байгуулагдсан урт, богино хугацааны 40 орчим сургалтад 260 гаруй прокурорыг Улсын Ерөнхий прокурорын газраас хамруулж, мэдлэг боловсролыг нь дээшлүүлсэн байна.

## ЦАГААТГАХАД ПРОКУРОР ОРОЛЦОНО

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурорын 6 дугаар сарын 17-ны хамтарсан захирамж, тушаалаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэнийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд заасны дагуу садан төрлийн холбоо тогтоох, нөхөн олговор олгохтой холбоотой иргэний хэрэгт прокурорын байгууллагаас төлөөлөл оролцохоор болжээ.



Прокурорууд хоёр дахь жилдээ тангараг өргөх үеэр
БНМАУ-ын прокуророор ажиллаж байсан Ж.Авхиа хүрэлцэн ирэв.

# 2003




Олон Улсын Прокуроруудын холбооны Ази Номхон далайн бүсийн хуралдаанд Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг, Ерөнхий прокурорын туслах Ж.Оюунчимэг, Т.Сүхбаатар нар, 2003 он



90-ээд онд анхны шанг нь татсан Тайваний шүүгч, прокуроруудын мэргэжил дээшлүүлэх институтын сургалтад 2003 оноос эхлэн улс, нийслэл, дүүргийн прокурорууд жил бүр хамрагдаж байна. 2003 он

# 2003

**4 сарын 15.** Монгол Улсын прокурорын байгууллагын төлөөлөгчид ОХУ-ын Эрхүү мужийн прокурорын урилгаар прокурорын байгууллагын ажлын арга барил, туршлага солилцов.

**4 сарын 23.** Улсын Ерөнхий прокурорын 118 тоот тушаалаар Харуул, хамгаалалт, нууц хадгалалтыг сайжруулах, түүнд тавих хяналтын тухай журам гаргажээ.

**5 сарын 15.** "Мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас захиргааны зөрчлийн хэрэг буртгэлтийн ажиллагаа явуулах, түүнд прокурор хяналт тавих журам"-ыг Улсын Ерөнхий прокуророос батлан мөрдүүлэв.

**5 сарын 26.** Тайваний Шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтнуудын Мэргэжил дээшлүүлэх институтэд 15 прокурорыг сургав.

**6 сарын 8.** Улсын Ерөнхий прокурорын 154 тоот тушаалаар Эрүүгийн хэргийн хэрэг бүртгэлт, Мөрдөн байцаалтын хэргийн хамгаалалт, хадгалалт, хэргийн тухайд нийтэд мэдээлэх талаар дагаж мөрдөх журмыг батлав.

## ДӨРӨВ ДЭХ ПАРЛАМЕНТ

Монгол Улс дөрөв дэх удаагийн парламентын сонгуулиа зохион явуулав. Энэ удаагийн сонгуульд улс төрийн 7 нам, 3 нам эвсэл оролцсоноос МАХН 37, "Эх орон-Ардчилал" эвсэл 35, Бүгд найрамдах нам 1 суудал тус тус авч, бие даан нэр дэвшсэн 3 нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдов. Сонгуулийн дүнгээр "Зөвшилцлийн гэрээ"-ний дагуу хамтарсан Засгийн газар байгуулсан. Дөрөв дэх удаагийн Улсын Их Хурал нь өөрийн бүрэн эрхийн хугацаанд нийт 89 хууль батлан гаргаж, 336 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан, олон улсын 68 гэрээ, конвенцийг соёрхон баталж, 50 хууль, хуулийн зүйл, заалтууд хүчингүйд тооцсон тухай хууль баталжээ.

## М.АЛТАНХУЯГ: ХИЙ ДҮРЭМДЭЖ ӨРӨӨНД СУУХГҮЙ ШҮҮ!



Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг, Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав, Ц.Жамьянсэнгээ нар Тамгын газрын хамт олонтойгоо, 2003 он

Прокурорын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг тавьсан

# 2004

илтгэлдээ “Боловсон хүчнийг шилж сонгох, тэдгээртэй нэг бүрчлэн ажиллах, үйл ажиллагаанд нь өдөр тутмын хяналт тавих явдал шаардлагын хэмжээнд хүрч чадахгүй байгаагаас прокуророуд ажил, мэргэжлийн алдаа гаргах, ёс зүйгээ зөрчих явдал гарсаар байна. Энэ нь прокурорын байгууллагад ажиллах боловсон хүчнийг сонгохдоо тэдгээрийн ёс суртахуун, ажил хэргийн ур чадварын байдлыг бодитой үнэлээгүй, нөгөөтэйгүүр нэгжийн удирдлага, хамт олны зүгээс хүндээ чиглэсэн бодлого, үйл ажиллагаа хангалтгүй явуулж байгааг давхар нотолж буй хэрэг мөн.

Иймд прокурорын байгууллагаас баримтлах бодлогын цөм нь боловсон хүчний чадварыг нэмэгдүүлж, хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэгдэх болно. Энэхүү бодлогыг нэгжийн удирдлагууд хэрэгжүүлэх бөгөөд боловсон хүчинтэйгээ хэр ажилласнаас хяналтын ажлын эцсийн үр дүн шууд хамаарна. Өнөөдөр улсын хэмжээнд ажиллаж буй нийт прокуроруудын 20,9 хувь нь 1-3 жил, 33 хувь нь 5 жил хүртэл ажиллаж буй ажил, амьдралын туршлага багатай, ачааны хүндийг үүрч гарах хат суугаагүй ажилтнууд эзэлж байна. Тэдэнд үнэтэй зөвлөмж, прокурорын ажилд суралцах явдал юу юунаас илүү чухал байгаа бөгөөд чанд шаардлага ч зайлшгүй хэрэгтэй.

Иймд та бүхэн хоосон шаардлага тавьж, хий дүрэмдэж өрөөндөө суудаг хуучин арга барилаасаа татгалзаж, ялангуяа шинэ залуу боловсон хүчнийг хяналтын ажилд дадлагажуулан сургах ажлыг гардан зохион байгуулах шаардлагатай байна” хэмээжээ.

## ТООНЫ ХЭЛЭЭР

Прокурорын байгууллагын системийн хэмжээнд 2004 оны байдлаар нийт 359 прокурор, 19 прокурорын туслах ажилтан, 296 захиргааны болон үйлчилгээний ажилтан, ажилчид ажиллаж байв. Тухайн үед ажиллаж байсан нийт прокуроруудын 44,2 хувь нь эрэгтэйчүүд, 55,7 хувь нь эмэгтэйчүүд байснаас 61,8 хувь нь 25-40 насных, 37,3 хувь нь 40-60 насны хүмүүс байжээ.

2004 онд прокуророуд хэргийн газрын үзлэгт 2377 удаа, нүүрэлдүүлж байцаах, таньж олуулах, мэдүүлгийг газар дээр нь шалгах зэрэгт 1582 удаа оролцжээ.

2004 онд баривчлах, хорих ангид нийт 5961 ялтан ял эдэлж байв.

-Д.Чулуунбат Архангай, Д.Доной Сэлэнгэ, Ц.Насанбат Увс аймгийн, Б.Базарханд Сүхбаатар дүүргийн, Ш.Батаа Тосонцэнгэл сум дахь сум дундын, С.Дабааравдан Хархорин сум дахь сум дундын прокурорын газрын ахлах прокуророор томилогдов.

-Орхон аймгийн прокурор Б.Дашням Монгол Улсын Гавьяат хуульч цолоор шагнагджээ.

-ХЗДХ-ийн сайд, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан тушаалаар Эрүүгийн хэргийн архивын ажлын зааврыг батлан хэрэгжүүлэв.

-УЕП-ын 375 тоот тушаалаар “Авлигаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл”-ийг байгуулжээ.

-Архангай, Хэнтий, Ховд, Дархан-Уул аймгийн прокурорын газар, МБА, Эрүүгийн хэргийн төв архив зэрэг газруудын шуурхай албаны авто машиныг шинэчлэх асуудлыг Төрийн өмчийн хороонд тавьж шийдвэрлүүлжээ.

-Эрүүгийн хэргийн төв архивын үйл ажиллагааг жигдрүүлэх, архивын байрны стандартыг мөрдлөг болгов.

# 2004

## МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ БАДАМЫН ДАШНЯМ



Б.Дашням Говь-Алтай аймгийн Төгрөг суманд төржээ. Тэрбээр 1974 онд Хууль цаазны дунд сургууль, 1980 онд Эрхүүгийн Улсын их сургуулийг хуульч мэргэжлээр төгсчээ.

Б.Дашням нь 1980-1984 онд Улсын прокурорын газрын Ерөнхий хяналтын хэлтэст хяналтын прокурор, 1984-1988 онд Найрамдлын районы прокурор, 1988-2012 онд Эрдэнэт хот, Орхон аймгийн прокурорын газрын, 2012-2014 онд Дархан-Уул аймгийн прокурорын газрын ерөнхий прокуророор тус тус ажиллаж ирсэн байна.

Б.Дашням нь Эрдэнэт, Дархан хотуудын прокурорын байгууллагыг удирдах хугацаандаа тухайн байгууллагуудын аж ахуй, зохион байгуулалтыг бэхжүүлж, ажилтнуудын ажиллах ая тухтай нөхцлийг бүрдүүлж, шинэ залуу хуульчдад дадлага туршлага олгож мэргэшүүлэх ажилд жинтэй хувь нэмэр оруулсан учир Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Гавьяат хуульч цолоор 2004 онд шагнагджээ.

## ГАДААД ХАРИЛЦАА 2004 ОНД

ОХУ-ын Эрхүү мужийн прокурорын урилгаар 4 сарын 5-15-ны өдрүүдэд Нийслэлийн прокурор Д.Даваадорж, Нийслэлийн прокурорын туслах, шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Ж.Эрдэнэбаатар, Нийслэлийн прокурорын туслах, Тамгын хэлтсийн дарга Р.Оюунчимэг, Багануур дүүргийн прокурор Д.Пүрэвдорж, Налайх дүүргийн прокурор Г.Энхтүвшин нар очиж туршлага судлав.

Тайваний хуулийн байгууллагын ажилтнуудын Мэргэжил дээшлүүлэх институтын сургалтад УЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баттөмөр, Бодлого төлөвлөлт, гадаад харилцааны хэлтсийн дарга Ж.Оюунчимэг, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Ариунболд, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Т.Баярсайхан, Нийслэлийн прокурор Д.Даваадорж нарын прокурорын байгууллагын удирдах албан тушаалтнууд суралцжээ.

## БӨРТЭ ҮЙЛДВЭРТЭЙ ХАМТРАВ

Бүх прокуроруудыг нэг ээлжийн дүрэмт хувцасаар хангах санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлж, прокуроруудын хувцасны хэмжээг нэгдсэн журмаар авч цэргийн хувцасны үйлдвэрийн “Бөртэ” компанитай гэрээ байгуулж, дүрэмт хувцас хийлгэх ажлыг эхлүүлжээ.

# 2005

## ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯРЫН АНХНЫ ТОМИЛГОО

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд МАХН-аас Н.Энхбаяр, Эх орон-Ардчилал эвслээс М.Энхсайхан, Эх орон намаас Б.Эрдэнэбат, Бүгд найрамдах намаас Б.Жаргалсайхан нар дэвшин өрсөлдсөн. Сонгуулийн санал хураалт өндөрлөж дүн гарахад МАХН-аас нэр дэвшсэн Н.Энхбаяр илт давуу ялалт байгуулсан байв. Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөж, бүрэн эрхийн хугацаа эхэлсний дараа хийсэн анхны томилгоо нь Монгол Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуягийг улираан томилсон явдал байлаа.

## ЗОРИЛГО, ЗОРИЛТОО ТОДОРХОЙЛЖЭЭ

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын удирдлага бүрэн бүрэлдэхүүнээрээ томилогдож, тангаргаа өргөн, бүрэн эрхийн хугацаа нь эхэлж байгаатай холбогдуулан Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг, прокурорын орлогч Б.Цэрэнбалтав, Ч.Мөнхбат нар прокурорын байгууллагынхаа салбар газрын удирдлагууд, прокуроруудтай уулзалт хийжээ.

Уулзалтаар өнгөрсөн зургаан жилийн ололт амжилтыг бататгах, прокурорын давхар хяналтын системийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэх, удирдах ажилтны хувийн үлгэр жишээч, ажил хэрэгч, сахилга хариуцлагыг чангатган шинэ арга барилаар ажиллахад юуг анхаарах талаар тодорхой үүрэг чиглэл өгчээ. Прокурорын байгууллагын удирдлага, зохион байгуулалт, дотоод ажил, хяналт шалгалт, нэгж газруудын ажлыг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлтийг тогтоох, шинээр батлагдсан хуулиудыг төв орон нутагт нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, хяналтын ажлын арга барилыг сайжруулах зэрэг прокурорын байгууллагын өмнө тавигдсан томоохон зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахаар төлөвлөжээ.

**5 сарын 23.** Улсын Ерөнхий прокурорын 107 тоот тушаалаар эрүүгийн зарим хэргийн мөрдөн байцаах ажиллагаанд давхар хяналт тавих журмыг баталжээ.

**6 сарын 24.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд МАХН-аас нэр дэвшсэн Н.Энхбаяр ялалт байгуулав.

**8 сард.** БНХАУ-ын Ардын Дээд Прокурорын газрын Ерөнхий прокурорын орлогч Жан Жаньцү тэргүүтэй БНХАУ-ын прокурорын байгууллагын төлөөлөгчид Монгол Улсад айлчлав.

**9 сарын 15.** Улсын Ерөнхий прокурорын 179 тоот тушаалаар зохион байгуулалтын өөрчлөлт хийж 17 прокурорыг дэвшүүлэн зэрэг дэв олгов.

**12 сард.** БНХАУ-ын Ерөнхий прокурор Жиа Чунвангийн урилгаар Монгол Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д айлчилж хоёр орны прокурорын байгууллагын хооронд хамтран ажиллах тухай санамж бичигт гарын үсэг зуржээ.

# 2005

-М.Алтанхуягийг Монгол Улсын Ерөнхий прокуророор улираан томилов.

-Б.Цэрэнбалтавыг Улсын Ерөнхий прокурорын орлогчоор улираан, Ч.Мөнхбатыг Улсын Ерөнхий прокурорын орлогчоор шинээр томилов.

-Ц.Жамьянсэнгээ, Ш.Сүхбат нар дараалан Нийслэлийн прокуророор, Х.Жанибек Баян-Өлгий, С.Энхбат Булган, Ж.Баярсүрэн Дархан-Уул, Ш.Батаа Завхан, Ц.Хашбаатар Өмнөговь аймгийн, Ц.Дагвадорж Баянгол, Т.Баярсайхан Баянзүрх, М.Гантулга Чингэлтэй, Б.Баян-Очир Сүхбаатар дүүргийн прокуророор, Д.Энхбаяр Тосонцэнгэл сум дахь сум дундын прокурорын газрын ахлах прокуророор тус тус томилогдов.

## М.АЛТАНХУЯГ: ИЙМ ПРОКУРОРЫГ ЦААШИД АЖИЛЛУУЛАХ БОЛОМЖГҮЙ

Прокурорын төв орон нутгийн байгууллагын Удирдах ажилтны зөвлөгөөнд Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг илтгэл тавьжээ. Илтгэлдээ “Юуны өмнө хэрэг хянах, шийдвэрлэх явцдаа прокурор мэргэжлийн алдаа гаргасан эсэх, мөн ёс зүйгээ зөрчсөн үү гэдгийг анхааралтай хянаж ажиллах шаардлагатай. Өөрөөр хэлбэл хэргийн бүрдэл, процессийн асуудлаас гадна прокурорын хяналтын систем хэрхэн ажиллаж байгааг давхар хянаж байх нь чухал юм. Энэ үүргээ дээд болон зохих шатны прокурорууд зарим нөхцөлд орхигдуулж, хэргийг зөвхөн өнгөц талаас нь хянаж, бичсэн даалгаварт хуурtагдаж байна. Наад зах нь прокурор хэргийн түүвэр хийсэн эсэх, түүврээ ашиглан яллах дүгнэлт бичиж чадаж байгаа эсэх, даалгаврыг яаж бичиж байна гэдгээс прокурорын хяналтын механизм хэрхэн хэрэгжиж байгааг олж харах шаардлагатай.

Анхаарч ажиллавал зохих өөр нэг асуудал бол прокурорууд тодорхой хэргийн шийдвэр гаргах асуудлаар аливаа хэлбэрээр хөндлөнгөөс оролцох, бусдыг гуйх, нөлөөлөх гэж оролдох зохисгүй хандлага хэрхэвч гаргаж болохгүй. Ийм прокурорыг цаашид ажиллуулах боломжгүй юм” хэмээжээ.



Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуягийн урилгаар БНХАУ-ын Ерөнхий прокурорын орлогч Жан Жаньцү тэргүүтэй төлөөлөгчид айлчлав, 2005 он

# 2005

## ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЭЛЭЛЦЭХ ШҮҮХ ХУРАЛДААНД 100 ХУВЬ ОРОЛЦОВ

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналтын ажил прокурорын байгууллагын нүүр царайг илэрхийлдэг. 2005 онд хэрэг бүртгэх байгууллагууд хүлээн авсан нийт гомдол мэдээллээс 12391-д нь эрүүгийн хэрэг үүсгэж шалгасан байна. Прокурор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай ирүүлсэн 24700 гаруй материалыг хянаж, үүнээс 2379-д нь захиргааны шийтгэл оногдуулахаар даалгаж, үндэслэлгүйгээр татгалзсан 572 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, эрүүгийн хэрэг үүсгэсэн 109 тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Хэрэг бүртгэлт хийсэн нийт хэрэг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулвал 2,8 хувиар, шүүхэд шилжүүлсэн хэрэг 47,5 хувиар тус тус өссөн ба прокурор эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох оролцоо 36,7 хувиар нэмэгдэж, үүнээс заавал оролцох ажиллагаанд 100 хувь оролцсон, бичсэн нийт даалгаврын 45,5 хувийг ажиллагааных нь явцад бичсэн зэрэг ажлын нааштай үзүүлэлтүүд энэ онд гарчээ.

Түүнчлэн 2005 онд анхан шатны шүүхээр 7275 хэрэг, давах болон хяналтын шатны шүүх хурлаар 2500 гаруй хэрэг хэлэлцэгдсэн нь үүний өмнөх онтой харьцуулахад өссөн байна. Прокурор эрүүгийн хэргийг хэлэлцэх анхан шатны шүүх хуралдаанд 100 хувь, давах болон хяналтын шатны шүүх хуралдааны 98,5 хувьд нь оролцжээ.

## ПРОКУРОРЫН ХЯНАЛТ АЛДАГДАЖ БАЙГААГ АНХААРУУЛАВ

Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокуроруудад үүрэг, чиглэл өгчээ. Түүнд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчид болон тэдний ар гэр, өмгөөлөгчдийн зүгээс тавьсан гомдол, хүсэлтэд прокурорууд ихээхэн анхаарал, хүлээцтэй хандаж зөвхөн хэрэг хянах төдийгөөр хязгаарлах биш, гомдол, хүсэлтэд дурдсан асуудлыг нягтлан шалгасны дараа хариу өгч байвал зохино.

Үүний тулд мөрдөн байцаах байгууллагатай өдөр тутам мэдээлэл солилцож, тодорхой хэргүүдийг шийдвэрлэх талаар хамтран ярилцах, сургалт явуулах зэрэг ажлуудыг зохион байгуулах нь ажлыг үр дүнд хүргэх хөшүүрэг болно.

Цаг хугацаа алдалгүй хэргийн нотлох баримтыг хуулинд заасан нөхцөл журмаар цуглуулах, түүнийг бодитой байдлаар үнэлэх нь шүүхийн өмнө гэмт этгээдийн гэм бурууг нотлоход ихээхэн ач холбогдолтой. Гэтэл прокурорын тасралтгүй хяналт тавих зарчим алдагдан зарим талаар мөрдөн байцаах ажиллагаа ихэнхдээ прокурорын хяналтаас гадуур явагдаж, хүний эрх зөрчигдөх явдал гарсаар байна.

Мөрдөн байцаагч нарын зүгээс гаргаж байгаа алдаа зөрчлийг прокурорууд тухай бүрд нь илрүүлэн таслан зогсоож чаддаггүй, энэ талаар аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргүүдийн прокурорын ажил шаардлагаас ихээхэн хоцорч байгаа нь нууц биш бөгөөд Улсын Ерөнхий прокурорын газарт хэргийн оролцогчдоос жилдээ 1000 гаруй гомдол, хүсэлт ирж байна. Дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг аймаг, Нийслэл, Тээвэр,

# 2005

дүүргийн прокурорууд өөрсдөө биечлэн зохион байгуулдаггүй, хууль зөрчсөн асуудлыг өөрөө шалгадаггүй, орлогч, туслах прокуроруудад дамжуулдаг баримт байнга гарч байна. Яавч та бүхэн ийнхүү завсрын байдлаар ажиллаж болохгүй гэдгийг онцлон анхааруулж байна. Үе үеийн прокурорууд чин шударга ажиллаж, хууль ёсны манаанд нүд цавчихгүй зогсож ирснийг түүх гэрчлэх билээ.

Өндөр ёс зүйтэй, үнэний төлөө шударга ажиллах нь прокурорын эрхэм зорилго байх болно" хэмээн дурджээ.

## ADSL СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОВ

2005 онд прокурорын байгууллагыг видео проектор, компьютер зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган, зарим прокурорын газрыг бүрэн компьютержүүлэн дотоод сүлжээнд холбож, Улсын Ерөнхий прокурорын газрыг 24 цагийн 128 kb-ийн хурдтай ADSL интернетийн сүлжээнд холбожээ. Түүнчлэн прокуроруудыг нэг ээлжийн дүрэмт хувцсаар хангах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлжээ.

## ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ОЛОН УЛСАД

Дани улсын Копенгаген хотноо хуралдсан Олон Улсын Прокуроруудын холбооны ээлжит 10 дугаар хуралдаан, Тайландын Вант улсад болсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн асуудлаарх чуулган, БНХАУ-ын Бээжин хотноо болсон Авлигын эсрэг Ази Номхон далайн бүсийн 5 дугаар Бага хурал, БНХАУ-ын Шенжен хотноо хуралдсан Ази, Европын орнуудын Ерөнхий прокуроруудын дээд хэмжээний чуулга уулзалтад прокурорын байгууллагын төлөөлөгчид тус тус оролцов.

## ЧУЛУУНЫ МӨНХБАТ



Ч.Мөнхбат 1980 онд НАХЯ-ны цэргийн тусгай дунд сургууль, 1989 онд ЗХУ-ын ДЯЯ-ны дээд сургууль, 1994 онд Удирдлагын академийг тус тус төгсч, 1998 онд Шинэ Зеланд Улсын Вайкатогийн Их сургуульд төрийн бодлого, төрийн удирдлагын магистрын зэрэг хамгаалжээ.

Тэрбээр 1980-1984 онд Төв аймгийн Цагдаагийн хэлтэст төлөөлөгч, 1984-1994 онд Цагдаагийн Ерөнхий газарт ахлах байцаагч, тусгай хэлтсийн орлогч дарга, 1994-1995 онд Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн хэлтсийн дарга, 1998-1999 онд Удирдлагын Академийн магистр багш, 1999-2001 онд Дэлхийн банкны төслийн зохицуулагч, 2001-2003 онд Азийн хөгжлийн банкны хөтөлбөрийн захирал, 2003-2005 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Төрийн захиргааны шинэчлэлийн хөтөлбөрийн захирал, 2005 оны 11 сараас 2012 онд Улсын Ерөнхий прокурорын орлогчоор ажиллажээ.

# 2005

## ПРОКУРОР БАГШ НАР БЭЛТГЭГДЭВ

Хууль зүйн үндэсний төв, АНУ-ын Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөртэй хамтран прокурор багшаар бэлтгэгдсэн 28 прокурорыг компьютерийн тусгай программ ашиглан хичээл заах арга зүйн сургалт болон мэргэжлийн чиглэлээр гүнзгийрүүлсэн сургалтад хамруулав. Эдгээр прокурор багш нар 2005 оны 9 дүгээр сараас Хууль зүйн үндэсний төвийн багшийн зэрэглэлээр ажиллах болов.

## ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОСОН ХЭРГҮҮДИЙГ СУДЛАВ

2005 онд прокурор 4258 хэргийг хэрэгсэхгүй болгосны 72,0 хувь нь хохирогч, сэжигтэн, яллагдагчтай эвлэрсэн үндэслэлээр, 14,3 хувь нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон хэрэг зонхилж байв. Хэрэгсэхгүй болгосон нийт хэргийн 83,9 хувийг дээд шатны прокурор хянаж, 104 тогтоолыг хүчингүй болгож сэргээснээс 41 хэргийг шүүхэд шилжүүлж, 45 хэргийн бүрдлийг хангуулж хэрэгсэхгүй болгосон байна.

## ШҮҮХЭЭР ХЭЛЭЛЦЭГДСЭН ХЭРЭГ ӨСЧЭЭ

2005 онд анхан шатны шүүхээр 7275, давах болон хяналтын шатны шүүхээр 2556 хэрэг хэлэлцэгдсэн нь 2004 онд анхан шатны шүүх хурлаар хэлэлцэгдсэн хэргээс 453-аар, давах болон хяналтын шатны шүүх хурлаар хэлэлцэгдсэн хэргээс 128 хэргээр өссөн байна. Прокурор анхан шатны эрүүгийн шүүх хуралдаанд 100 хувь давах болон хяналтын шүүх хуралдааны 98,5 хувьд нь оролцсон байна.

## УИХ-ЫН ДАРГА ЦЭНДИЙН НЯМДОРЖ



Ц.Нямдорж Увс аймгийн Малчин суманд 1956 онд төржээ. Тэрбээр 1981 онд Ленинградын Улсын их сургууль төгсөж, 2009 онд Монгол Улсын Гавьяат хуульч цол хүртжээ. Ц.Нямдорж 1981-1988 онд Улсын ерөнхий прокурорын газарт хэлтсийн прокурор, хэлтэс, тасгийн дарга, 1988-1990 онд Цэргийн ерөнхий прокурорын нэгдүгээр орлогч, 1990-1992 онд Хууль зүйн тэргүүн дэд сайд, 1992-2000 онд УИХ-ын гишүүн, 2000-2004 онд Хууль зүй, дотоод хэргийн сайд, 2000-2005 онд УИХ-ын гишүүн, 2005-2007 онд УИХ-ын дарга, 2008-2012 онд Хууль зүй, дотоод хэргийн сайд, 2008-2016 онд УИХ-ын гишүүн, 2016-2017 онд УИХ-ын дэд дарга, 2017-2020 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллаж иржээ.

# 2005




"Хууль хяналтын байгууллагад ажиллагч эмэгтэйчүүдийн тулгамдсан асуудал" зөвлөгөөнд оролцсон прокурорууд, 2005 он




Тайваньд сургалтад суусан прокурорууд, 2005 он

# 2006

## ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ХЭРЭГ

Хаа сайгүй бороoны дараах мөөг шиг Хадгаламж зээлийн хоршоо байгуулагдаж хүмүүсийн мөнгийг богино хугацаанд хэд дахин өсгөж өгнө гэх шуугиан өвсөнд ассан түймэр мэт тархав. Богино хугацаанд мөнгөө өсгөх гэсэн хүмүүсийн дараалал Хадгаламж зээлийн хоршоодын үүдэнд бий болж, гэр байраа хүртэл зарж мөнгөө өсгөх гэсэн хүмүүс ч нэмэгдэж байлаа. Харамсалтай нь нийгэмд гаарсан энэ үзэгдэл гэмт хэргийн сэдэлтэйгээр асар их хэмжээний хохирол дагуулжээ. Анхнаасаа залилангийн шинжтэй байгуулагдсан Хадгаламж зээлийн хоршоодын тар танигдаж, хууртагдсан 8600 гаруй хохирогчид, 66 тэрбум төгрөгийн хохирол учруулсан, Хадгаламж зээлийн хоршооны 66 хүнд холбогдох хэрэгт хяналт тавьж, шүүхээр шийдвэрлүүлжээ.

Энэ хэргийг шалгах, мөрдөн байцаах хэлтсийг ЦЕГ-ын дэргэд шинээр байгуулсантай холбогдуулан Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэсгийг түр хугацаагаар байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор С.Дамчаасүрэнг, гишүүдэд Баянзүрх дүүргийн хяналтын прокурор Д.Мөнх-Очир, Чингэлтэй дүүргийн хяналтын прокурор М.Бадам, Тээврийн прокурорын газрын хяналтын прокурор Ц.Мөнхбат нарыг тус тус томилж, мөрдөн байцаалтын явц байдалтай өдөр тутам танилцаж, зохих заалт чиглэл өгч хяналт тавихыг Улсын Ерөнхий прокурорын туслах Л.Болдод үүрэг болгожээ. Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав энэ талаар “Иргэдэд учруулсан хохирлыг нь барагдуулахын тулд Хадгаламж зээлийн хоршоодын хэрэгт шалгагдаж буй нуугдмал хөрөнгийг илрүүлж, битүүмжлэх ажил хийгдэж, 37 тэрбум төгрөгийн нуугдмал хөрөнгийг илрүүлж битүүмжилсэн. Гэтэл хохирол нь 54 тэрбум төгрөг болсон. Хохирогч, хохирлын тоо нэмэгдэнэ гэсэн үг. Ийм учраас прокурорын байгууллага энэ асуудалд болгоомжтой хандаж байна” хэмээжээ.

## ГАДААД ХАРИЛЦАА ӨРГӨЖИВ

Монгол Улсын Прокурорын байгууллага нь 2006 онд Авлигатай тэмцэх байгууллагуудын Олон Улсын Холбооны санаачлагч гишүүн байгууллага болж, Еврожаст Олон улсын

**2 сард.** Монгол Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг тэргүүтэй 11 прокурор, ажилтнууд Австрали улсад туршлага судлав.

**3 сарын 14.** “Эрүүгийн хэргийн төв болон салбар архивын баримт ашиглуулах журам”, “Эрүүгийн хэргийн төв болон салбар архивт баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, хадгалах журам”-ыг тус тус УЕП-ын тушаалаар батлав.

**3 сарын 29.** Улсын Ерөнхий прокурорын 81 тоот тушаалаар Мэдээ, ажил дүгнэх үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулж ажиллуулжээ.

**3 сарын 30.** Малайз улсад зохиогдсон “Авлигын эсрэг Азийн бүсийн Бага хурал”-д Улсын Ерөнхий прокурорын орлогч Ч.Мөнхбат оролцов.

**6 сарын 15.** Хуулийн байгууллагуудын талаар авах арга хэмжээний тухай УИХ-ын 54 дүгээр тогтоол батлагдав.

**6 сарын 26.** Улсын Ерөнхий прокурорын 191 тоот тушаалаар “Өршөөлийн хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг Нийслэлийн прокурор Ш.Сүхбатаар ахлуулан байгуулав.

# 2006

**6 сарын 30.** Улсын Ерөнхий прокурорын 208 тоот тушаалаар “Прокурорын туслах ажилтны ажиллах журам”-ыг шинэчлэн батлах хэрэгжүүлжээ.

**6 сарын 30.** Эрүүгийн өнөөгийн нөхцөл байдал, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах асуудлаар Хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөнийг Улаанбаатар хот, нийт аймгуудад тус тус зохион байгуулав.

**7 сард.** БНХАУ-ын Фужиан мужийн прокурорын орлогч Ли Мин Рон тэргүүтэй төлөөлөгчид манай улсад зочлов.

**8 сарын 2.** Улсын Ерөнхий прокурорын 233 тоот тушаалаар “Прокурорын байгууллагын шагналын журам”, “Прокурорын тэргүүний ажилтан” цол, тэмдэг “Прокурорын хүндэт тэмдэг” тэдгээрийн үнэмлэх, жуух бичиг, өргөмжлөлийн зааврыг батлажээ.

**10/22.** БНХАУ-ын Ерөнхий прокурор Жиа Чунвангийн урилгаар Монгол Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг тэргүүтэй прокурорын байгууллагын төлөөлөгчид БНХАУ-д айлчлав.

байгууллагад өөрийн төлөөлөгчтэй болсноос гадна Азийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сан, АНУ-ын Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Ханс Зайделийн сан зэрэг төслийн болон олон улсын байгууллагуудтай үр ашигтай хамтран ажиллажээ. Түүнчлэн БНХАУ, Сингапур, Тайланд, ӨАБНУ, Австрали, АНУ, ОХУ, Франц, БНСУ, ХБНГУ, Япон зэрэг дэлхийн 20 гаруй оронд зохион байгуулагдсан бүс нутгийн болон олон улсын хуралдаан, уулзалт, семинарт прокурорын



Австрали улсын прокурорын байгууллагын туршлага судлах үеэр, 2006 он

байгууллагын төлөөлөгчид оролцож, Австрали, ХБНГУ, БНХАУ, БНСУ-ын прокурорын байгууллагын туршлага судлажээ. Сүүлийн 10 жилд гадаадад зохион байгуулагдсан 90 гаруй арга хэмжээнд давхардсан тоогоор 460 прокурор хамрагдсан байна.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫГ ХӨНӨӨСӨН ЖИГШҮҮРТ ХЭРЭГ

СЗХ-ны даргын амь насыг 6 дугаар сарын 15-нд хөнөөсөн онц ноцтой хэрэг гарч олныг цочирдуулав. Гэгээн цагаан өдөр, төрийн албан газарт гарсан энэ хэргийн мөрөөр хуулийн байгууллагууд нарийвчилсан шалгалт явуулж буруутай этгээдэд ял оноожээ. Олныг цочирдуулсан энэ хэрэг Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагаа ямар ноцтой түвшинд хүрснийг илчилсэн юм.

# 2006

## СУРГАЛТЫН АРГА БАРИЛАА ӨӨРЧЛӨВ

Сургалтуудыг тухайн прокурорын ажилласан жил, туршлагыг харгалзан анхан, дунд, дээд шатны гэж ангилсны гадна хяналтын ажлынх нь онцлогийг харгалзан сэдэвчилсэн сургалтуудыг зохион байгуулжээ.

Аймаг, орон нутгийн прокурорын газрууд дотооддоо нийт 3811 цагийн онол арга зүйн сургалтыг, түүнчлэн тусгай хөтөлбөрийн дагуу практик сургалтыг зохион байгуулжээ.

## ПРОКУРОР, АЖИЛТНУУД КОМПЬЮТЕРООР БҮРЭН ХАНГАГДАВ

АНУ-ын Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 2006 онд нийлүүлсэн 108 компьютер, сервер, принтер, сканнер зэрэг төхөөрөмжүүд нь прокурорын байгууллагын техникийн хүчин чадлыг сайжруулж, үйл ажиллагааны шуурхай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн томоохон хөрөнгө оруулалт болсон ба нийслэлд ажиллаж буй прокурор, ажилтнууд компьютероор иж бүрэн хангагджээ.

## СОНГОН ШАЛГАРУУЛАХ КОМИСС БАЙГУУЛАВ

Монгол Улсын Засгийн газрын тэтгэлгээр өндөр хөгжилтэй орны их, дээд сургуулийн магистрантурт суралцах прокурорыг сонгон шалгаруулах комиссын даргаар Улсын Ерөнхий прокурорын туслах, Хэрэг эрхлэх газрын дарга С.Баттөмөр, гишүүдээр Улсын Ерөнхий прокурорын туслах, Бодлого төлөвлөлт, гадаад харилцааны хэлтсийн дарга Ж.Оюунчимэг, Улсын Ерөнхий прокурорын туслах, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Ариунболд нарыг томилжээ.

**10 сарын 26.** Бээжин хотноо хуралдсан Авлигатай тэмцэх байгууллагуудын Олон Улсын Холбооны анхдугаар хуралдаанд Ерөнхий прокурор М.Алтанхуяг оролцож, Монгол улсын прокурорын байгууллага нь тус Холбооны “Санаачлагч-Гишүүн байгууллагын” гэрчилгээг гардан авав.

**12 сард.** Монгол улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтаваар ахлуулсан прокурорын байгууллагын төлөөлөгчид БНХАУ-ын Фужиан мужид харилцан айлчлав.Энэ онд нийтдээ 67 прокурор гадаад арга хэмжээнд хамрагджээ.

-Улсын Ерөнхий прокурорын тушаалаар “Шүүхээс эрүүгийн хэргийг прокурорт буцаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, улсын яллагч яллахаас татгалзсан шалтгаан, нөхцөлийг судлах, дүгнэлт хийх журам”-ыг батлав.

-Г.Ганхүү Говьсүмбэр, Б.Мянган Ховд, Б.Чинбат Хэнтий аймгийн прокуророор, Б.Пүрэвжав Баганаар дүүргийн ахлах прокуророор томилогдов.

# 2007

1 сарын 1. Өмнөх онд УИХ-аас батлагдсан Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолыг дагаж мөрдөж эхлэв.

2 сарын 1. Улсын Ерөнхий прокурорын 33 тоот тушаалаар Төрийн Хууль Цаазын шадар зөвлөх асан Ц.Жамъянсэнгээгийн нэрийг Улсын Ерөнхий прокурорын газрын "Хүндэт дэвтэр"-т бичиж алдрыг нь мөнхжүүлжээ.

2 сарын 8. Улсын Ерөнхий прокурорын 40 тоот тушаалаар Төрийн алтан соёмбот морин хуурыг Улсын Ерөнхий прокурорын газрын байранд залав.

3 сард. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр прокурорын байгууллагын үйл ажиллагаатай танилцав.

4 сарын 5. Улсын Ерөнхий прокурорын 101 тоот тушаалаар Нийслэл, дүүргийн прокурорын газруудын ажлыг шалгах ажлын хэсгийн ахлагчаар Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтавыг томилжээ.

## ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ЭРХ ЯМБА БАТАЛГААЖИВ

8 дугаар сард УИХ-аас баталсан "Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль"-д Улсын ерөнхий прокурорын эрх ямба, баталгаат хангамжийг хуульчилж өгчээ. Тухайлбал хуулийн 36.1-т "Улсын ерөнхий прокурор уналга, холбооны хэрэгслээр хангагдах, төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаанд тохируулан Улсын Их Хурлаас тогтоосон цалин, зайлшгүй шаардлагатай бусад хангамж авах буюу эдлэх, гадаадад байх, зорчих хугацаанд дипломат эрх ямба, дархан эрх эдлэнэ" хэмээн нэмж хуульчилсан байна. Түүнчлэн нийт прокуроруудад хамаатай "Прокурор тэтгэвэрт гарахад албан тушаалынх нь 36 хүртэл сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно" хэмээн хуульчилжээ.

## ПРОКУРОРУУД СУРГАЛТ, ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛД ОРОЛЦОВ

Кыргызстан улсын Бишкек хотноо 4 дүгээр сард зохион байгуулагдсан "Төв Ази дахь хар тамхины наймаатай тэмцэхэд хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэн, хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь" сэдэвт Олон улсын Бага хуралд Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор Д.Эрдэнэцэцэг, 9 дүгээр сард Индонез улсад зохиогдсон "Эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай" Азийн бүсийн бага хуралд Улсын Ерөнхий прокурорын туслах, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Б.Бат-Орших нар оролцжээ.

Түүнчлэн Тайваний Мэргэжил дээшлүүлэх институтэд Нийслэлийн прокурорын туслах, Тамгын хэлтсийн дарга Б.Дагвасүндэл, Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор Ц.Бурмаа, Ж.Ганцэцэг, Н.Энхтуяа, Баян-Өлгий аймгийн прокурор Х.Жанибек, Булган аймгийн прокурор С.Энхбат, Өмнөговь аймгийн прокурор Ц.Хашбаатар, Хэнтий аймгийн прокурор Б.Чинбат тэргүүтэй прокуророуд 5-6 дугаар сард суралцсан байна.

# 2007

## ПРОКУРОРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ ХУУЛЬЧЛАГДАВ

УИХ-аар Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулахдаа “Прокурорын ёс зүйн зөвлөл”-ийг нэг мөр хуульчилжээ. Тухайлбал Прокурорын байгууллагын хуулийн 42 дугаар зүйлд “Прокурор нь Прокурорын ёс зүйн дүрэм зөрчсөн тухай асуудлыг шалгах, дүгнэлт гаргах эрх бүхий Прокурорын ёс зүйн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-тэй байна. Зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд Зөвлөлийг Улсын Ерөнхий прокурорын орлогч даргална, Зөвлөл 11 гишүүнтэй байх ба зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна. Прокурорын ёс зүйн дүрэм зөрчсөн тухай асуудлыг Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Улсын Ерөнхий прокурор шийдвэрлэнэ. Прокурорын ёс зүйн дүрэм, Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална” хэмээн тодорхой зааж, хуульчилжээ.

## СӨҮЛИЙН КАЗИНОД 11 ТЭРБУМ ВОН ТӨЛСӨН БАРИМТЫГ ИРҮҮЛЭВ

“Хадгаламж” банкны ахлах нягтлан бодогч 1997-2007 оны нэгдүгээр сар хүртэл ажиллаж байхдаа хуурамч баримт үйлдэх замаар 14,2 тэрбум төгрөг завшиж, бусдад их хэмжээний хохирол учруулсан хэрэгт прокурорын байгууллагаас хяналт тавьж шийдүүлэв. Энэ хэргийг илрүүлэхийн тулд Солонгосын прокурорын байгууллагатай өмнө нь тогтоосон хамтран ажиллах гэрээний дагуу тусламж авч, прокурорууд Сөүл хотод томилогдон ажиллажээ. Улмаар Сөүл хотын прокурорын газраас нягтлан бодогчийг 30 гаруй удаа казинод тоглож, 11 тэрбум гаруй вон төлсөн баримтыг манай прокуроруудад хүлээлгэн өгсөн байна.

Дээрх хэрэгт УИХ-ын гурван гишүүн холбоотой байж болзошгүй гэсэн мэдээлэл шуугиан тарьж, үүний дагуу нэр бүхий гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг УИХ-д оруулж байжээ. Хадгаламж банкны гэх хэрэгт 25 хүн холбогдон шалгагдсанаас 12 хүн гэмт хэрэг үйлдсэн гэсэн үндэслэлээр шүүхэд шилжжээ.

5 сард. Тайваний Мэргэжил дээшлүүлэх Институтын сургалтад нийт 19 прокурор хамрагдаж, сүүлийн 5 жилд Тайваньд суралцсан прокурорын тоо 90-д хүрчээ.

8 сарын 2. Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ батлав.

10 сарын 30. Монгол Улсад Авлигатай тэмцэх газар шинээр байгуулагдсантай холбогдуулан, Улсын Ерөнхий прокурорын 292 дугаар тушаалаар Нийслэлийн прокурорын газрын Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийг мөрдөн байцаалтын ерөнхий харьяалалтай хэрэгт хяналт тавих 1 дүгээр алба, мөрдөн байцаалтын тусгай харьяалалтай хэрэгт хяналт тавих 2 дугаар алба болгон өөрчлөн зохион байгуулав.

10 сарын 31. “Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль хүчин төгөлдөр болж, “УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах албаны дүрэм”, албаны бүтцийг шинэчлэн батлав.

# 2007

11 сарын 22. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 264 дүгээр зарлигаар “Прокурорын мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам” батлагджээ.

11 сард. “Шинэ оноо хугацаа сунгасан болон оргосноос түдгэлзүүлсэн хэрэггүй угтая” сэдэвт 45 хоногийн нэгдсэн арга хэмжээг прокурорын байгууллагаас дотооддоо зарлав.

12 сарын 10. “Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгах, үнэлгээ өгөх аргачилсан заавар”-ыг батлав.

-Прокурорын байгууллагад ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авах иргэд, олон нийтэд эрхзүйн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий мэдээлэл лавлагааны төвийг Нийслэлийн прокурорын газрын дэргэд ажиллуулж эхлэв.

-Ц.Мөнхбат Сүхбаатар, Л.Батгэрэл Хөвсгөл аймгийн прокуророор, С.Гансэлэм Хархорин дахь сум дундын прокурорын газрын ахлах прокуророор томилогдов.

## ЦАГДАН ХОРИХ АНГИД ПРОКУРОРУУД “ЖИЖҮҮРЛЭНЭ”

Цагдан хорих байрыг Цагдаагийн байгууллагын харьяаллаас салгаж, ШШГЕГ-т шилжүүлсэнтэй холбогдуулан Цагдан хорих 461 дүгээр ангид 4 ээлжийн прокурор томилон ажиллуулж, Улсын Ерөнхий прокурорын 2007 оны 274 тоот тушаалаар “Цагдан хорих 461 дүгээр ангийн үйл ажиллагаанд хяналт тавих прокурорын ажиллах журам”, Улсын Ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар “Цагдан хорих байранд хоригдогсдын өрөө солих журам”-ыг тус тус батлан мөрдүүлэв. Ингэснээр хорих ангийн үйл ажиллагаатай холбоотой гомдол 60,2 хувиар, сахилгын зөрчил 46 хувиар буурчээ.

## УИХ-ЫН ДАРГА ДАНЗАНГИЙН ЛҮНДЭЭЖАНЦАН



Д.Лүндээжанцан Улаанбаатар хотод 1957 онд төржээ.

Тэрбээр 1980 онд МУИС төгсөж, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч цол хүртжээ. Д.Лүндээжанцан 1980-1985 онд МУИС-ийн багш, ХЗЭ-ийн хорооны дарга, 1985-1986 онд Улсын прокурорт хэлтсийн прокурор 1986-1989 онд Улсын прокурорын туслах, хэлтсийн дарга, 1989-1990 онд ШУА-ын Төр, эрх зүйн хүрээлэнд секторын эрхлэгч, 1990-1991 онд Хууль зүйн байнгын хорооны нарийн бичгийн дарга, 1990-1992 онд Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн, 1992-1996 онд УИХ-ын гишүүн, байнгын хорооны дарга, 1996-2000 онд УИХ-ын гишүүн, 2000-2004 онд УИХ-ын гишүүн, Байнгын хорооны дарга, 2004-2007 онд УИХ-ын дэд дарга, 2007-2008 онд УИХ-ын дарга, 2008-2020 онд УИХ-ын гишүүнээр 30 жил тасралтгүй ажиллажээ.

# 2008

## ТАВ ДАХЬ УДААГИЙН УИХ

Тав дахь удаагийн Улсын Их Хурлыг сонгох сонгууль явагдаж, МАХН-аас 46, АН-аас 27, ИЗН-аас нэг, Ногоон намаас 1, бие даан нэр дэвшигч 1 тус тус Улсын Их Хурлын гишүүнээр сонгогджээ. Энэхүү Их хурлын сонгуулийн санал хураалтын дүнтэй холбогдуулан олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал дэгдэж “Долдугаар сарын 1-ний” гэх тодотголтой бараан сүүдэр манай нийгмийг нөмрөн авч таван залуугийн амь нас эрсдэж, олон хүн эд хөрөнгө, эрүүл мэндээрээ хохирсон юм. Энэ УИХ бүрэн эрхийн хугацаандаа төрийн албаны сонирхлын зөрчлийн асуудлыг нухацтай авч үзэж тусгайлан хууль баталсны зэрэгцээ Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хуульд холбогдох заалтууд нэмсэн байна.

## МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ТЕХНИКИЙН ДЭВШЛИЙГ АШИГЛАВ

Орчин үеийн мэдээллийн технологи, техникийн дэвшлийг ашиглан прокурорын байгууллагын үйл ажиллагааны шуурхай байдлыг хангаж, прокурор, ажилтнуудын техниктэй харьцах, сүлжээний орчинд ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Прокурорын байгууллагад цахим шуудан ашиглан бичиг баримт явуулах, хүлээж авах журам”, “Төв орон нутгийн прокурорын газруудад мэдээллийн систем ашиглах, цахим мэдээлэл боловсруулах журам”, прокурорын газруудад хэрэглэгдэх албан ёсны и-мэйл хаягийн жагсаалтыг тус тус батлав. Журам батлагдсантай холбогдуулан цахим шууданг илгээх, хүлээн авах ажиллагааг төв, орон нутгийн прокурорын газруудад нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор интернет сүлжээгүй газруудыг интернетэд холбох, шаардлагатай техник төхөөрөмжөөр хангах зэрэг ажлыг энэ оны эхний улиралд багтаан хэрэгжүүлжээ.

1 сарын 16. Улсын Ерөнхий прокурорын 12 тоот тушаалаар “Прокурорын байгууллагын мэдээлэл лавлагааны цэгийн ажиллах журам”-ыг батлан, техник хэрэгслээр хангажээ.

1 сарын 30. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан тушаалаар “Баривчлах, цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам”-ыг баталж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан, Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав нарт даалгажээ.

2 сарын 15. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар Төв орон нутгийн прокурорын газруудад мэдээллийн систем ашиглах, цахим мэдээлэл боловсруулах журмыг баталжээ.

3 сарын 1. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар “Прокуророос эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах аргачилсан заавар”-ыг баталжээ.

# 2008

**3 сарын 4.** Улсын Ерөнхий прокурорын 51 тоот тушаалаар Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан Прокурорын хяналтын эрх зүйн баримт бичгийн загварыг баталж хэрэгжүүлжээ.

**3 сарын 20.** Эрүүгийн хэрэгт хураагдсан эд мөрийн баримт болон барьцаа, хохирол төлүүлэхээр авсан мөнгө, валют, үнэт цаас, үнэт эдлэл, битүүмжилсэн эд хөрөнгийг прокурорын байгууллагад хүлээн авах, хадгалах, шийдвэрлэх журмыг Улсын Ерөнхий прокурорын тушаалаар батлав.

**3 сарын 31.** “Төв, орон нутгийн прокурорын газрын ажлыг шалган туслах заавар”-ыг Улсын Ерөнхий прокурорын тушаалаар батлав.

**6 сарын 19.** Авлигатай тэмцэх газартай хамтран прокуроруудаас гаргаж буй зөрчил дутагдлын байдлыг судлан “Ёс зүйн зөрчил, хууль бус ажиллагаатай тэмцэх тухай” Улсын Ерөнхий прокурорын 146 тоот тушаал гарган мөрдүүлжээ.

## ЦАГДАН ХОРИХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ЧАНГАТГАВ

Өнгөрөгч онд нь Авлигатай тэмцэх газар шинээр байгуулагдсантай холбогдуулж Улсын Ерөнхий прокурорын 291 тоот тушаал гарав. Тушаалд Нийслэлийн прокурорын газрын Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийг мөрдөн байцаалтын ерөнхий харьяалалтай хэрэгт хяналт тавих 1 дүгээр алба, мөрдөн байцаалтын тусгай харьяалалтай хэрэгт хяналт тавих 2 дугаар алба болгон өөрчлөн зохион байгуулсан байна. Мөн УИХ-аас дөрвөн прокурорын орон тоог нэмж баталснаар Нийслэлийн прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн прокурорууд ШШГЕГ-ын харьяа хорих 461 дүгээр ангид өдөр бүр тогтмол томилогдон ажиллах үйл ажиллагааг үргэлжлүүлэв. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон журамд нийцэж, хууль зөрчсөн үйлдлийг илрүүлэн таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хангуулах, прокурорын хяналтыг байнга тасралтгүй явуулахад энэ шийдвэр чухал үүрэг гүйцэтгэжээ.

## ДОЛДУГААР САРЫН 1-НИЙ ҮЙМЭЭН ДЭГДЭВ

Сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөөгүйгээс нийтийг хамарсан эмх замбараагүй байдал долдугаар сарын 1-нд бий болж, МАХН (одоогийн МАН)-ын байр руу дайрч, галдан шатаасан, дээрэм тонуул хийсэн хэрэг гарч, чөлөөт телевизүүд шууд нэвтрүүлж байлаа. Энэ үед Улсын Ерөнхий прокурорын газрын удирдлагууд шөнөжин ажиллаж, нөхцөл байдлыг ажиглан мэдээлэл авч байв. Хууль зүйн сайд Ц.Мөнх-Оргил, Цагдаагийн Ерөнхий газрын даргын үүрэг гүйцэтгэгч, генерал Ч.Амарболд нар ч прокурорын байгууллагын удирдлагуудтай байнга утсаар холбогдож нөхцөл байдлын талаар зөвлөлдөж байжээ. Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд онц байдал тогтоосны дараа үймээн намжиж, өглөө нь Улсын Ерөнхий прокурор дүүргүүдийн прокуроруудыг дуудаж, ажлын хэсэг томилон, хэргийн газрын үзлэгт оролцох болон бусад үүрэг өгчээ.

# 2008

Хэргийн газрын үзлэгийн дүн байдлаас шалтгаалан Эргүүл хамгаалалтын газрын дарга, цагдаагийн хурандааг хорьж шалгах болсон ба даргыгаа хууль бусаар хорилоо гэсэн цагдаагийн алба хаагчид Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны байрыг бүсэлсэн байна. Үүссэн нөхцөл байдлын талаар прокурорын байгууллага, цагдаагийн байгууллагын удирдлагууд зөвшилцөж цагдаа нарын эсэргүүцэл зогсчээ.

Үймээн гарснаас хоёр хоногийн дараа Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтавтай уулзаж болж өнгөрсөн үймээний нөхцөл байдал, хянан шийдвэрлэж байгаа байдлын талаар мэдээлэл сонссон байна. Түүхэнд "Долдугаар сарын 01-ний хэрэг" хэмээн үлдсэн энэхүү үймээний улмаас эрдэнэт хүний амь хохирсноос гадна 270 гаруй иргэн, аж ахуйн нэгж 11 тэрбум төгрөгийн хохирол хүлээж, 400 гаруй хүний биед хүнд, хөнгөн гэмтэл учирчээ.

## "ЭРҮҮГИЙН ХЭРЭГТ ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСЭГ" БАЙГУУЛАВ

Нийслэлд олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэнтэй холбогдуулан "Эрүүгийн хэрэгт хяналт тавих ажлын хэсэг"-ийг Улсын Ерөнхий прокурорын туслах, МБАХТХэлтсийн дарга Л.Болдоор ахлуулан байгуулав. Ажлын хэсэгт Нийслэлийн прокурорын туслах, МБАХТ 1-р албаны дарга Ж.Мөнхжаргал, Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Ж.Отгонбаяр, Г.Гэрэлтуяа, Сүхбаатар дүүргийн прокурор Б.Баян-Очир, орлогч прокурор М.Дэлгэрнасан нар ажиллажээ.

## Б.ЦЭРЭНБАЛТАВ: ОРОЛЦСОН, ЦУГЛАСАН БҮХ УЛСЫГ ТОЛГОЙ ДАРААЛАН ШАЛГААГҮЙ

"Үймээний хэргийг Эрүүгийн хуульд заасан нийгмийн эмх замбараагүй байдлыг бий болгосон гэдэг зүйл ангиар зүйлчилсэн. Энэ нь нийгмийн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн бүлэгт багтдаг. Улс төрийн шинжтэй буюу төрийн эсрэг гэмт хэргийн

7 сарын 1. УИХ-ын сонгуулийн санал хураалтын дүнтэй холбоотойгоор олон нийтийг хамарсан үймээн дэгдэв.

8 сард. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Азийн сангийн 13 дугаар хуралдааныг Улсын Ерөнхий прокурорын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулав.

8 сарын 27. Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав Сингапурт зохиогдсон Олон улсын прокуроруудын холбооны 13 дугаар хуралд оролцов.

10 сард. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар "Мөрдөн байцаах албаны даргын дэргэдэх зөвлөлийн хуралдааны журам"-ыг батлав.

10 сарын 1. Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг, Улсын Ерөнхий прокурорын туслах Ж.Оюунчимэг, Нийслэлийн прокурор Ш.Сүхбат нар Унгар улсын Будапешт хотноо зохиогдсон Прокурорын байгууллагуудын олон улсын форумд оролцов.

# 2008

**11 сард.** УИХ-аас Нийслэлийн прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтэст дөрвөн прокурорын орон тоо нэмж батлав.

**11 сарын 22.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн 263 тоот зарлигаар “Прокурорын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүн”-ийг шинэчлэв.

-Д.Энхбаяр Өвөрхангай, М.Буяннэмэх Увс аймгийн, Ү.Содномцог Баянгол, С.Цэрэнсамбуу Баянзүрх, Г.Бадамханд Чингэлтэй, Х.Алтанзүрх Сүхбаатар, Б.Баян-Очир Хан-Уул, Т.Баярсайхан Сонгинохайрхан дүүргийн прокуророор, С.Батмөнх-Очир Тосонцэнгэл сум дахь сум дундын прокурорын газрын ахлах прокуророор томилогдов.

бүлэгт багтдаггүй. Үймээнд оролцож хууль бус үйлдэл хийсэн, газар дээрээ баригдсан, хулгай дээрэм хийсэн хүмүүсийг шалгасан. Түүнээс оролцсон, цугласан бүх улсыг толгой дараалан шалгаагүй. Нөгөө талаар ямар нэгэн хэлмэгдүүлэлт, улс төрийн зорилго хуулийн байгууллагад байхгүй.

Ямар нэгэн нам, эвсэл хүчний захиалгаар хуулийн байгууллага ажилладаггүй. Хуульд заасан үүргээ биелүүлж ажиллаж байгааг эрх мэдлээ хэтрүүлсэн гэж үзэж болохгүй. Олон түмний дунд хэлмэгдүүлж байна гэх мэт ташаа ойлголт төрүүлж турхирч байгаа нь хэрэг үйлдсэн хүмүүс хэргээс мултрах, ял завших оролдлого, башир арга юм. Цагдаагийн байгууллага нийгмийн хэв журам хамгаалах үүргээ гүйцэтгэсэн. Тэдний үйл ажиллагааг бүхэлд нь буруутгаж болохгүй. Зааг ялгаатай хандах ёстой. Цагдаагийн 10-аад ажилтан шалгагдаж байгаа.

*Улсын Ерөнхий прокурорын орлогч*
*Б.Цэрэнбалтавын 2008 оны 10 дугаар сарын 16-ны*
*“Өдрийн сонин”-д өгсөн ярилцлагаас*

## СУРГАЛТАД ХАМРАГДАХАД ЧӨЛӨӨ ОЛГОНО

Улсын Ерөнхий прокурорын 14 тоот тушаалаар Удирдлагын академи, магистрийн болон бусад сургалтад суралцуулах зорилгоор прокурор, ажилтнууд жилд нэг удаа ажлын 45 өдөр хүртэл хугацаагаар чөлөө олгож байх ба өөрийн хүсэлтээр хувийн зардлаар суралцах тохиолдолд цалингүй чөлөө олгохоор болжээ.

## ЯЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙГ ЗАВШЖЭЭ

Хорих 409 дүгээр ангийн тоосгоны үйлдвэрлэл дээр ажиллаж байгаа ялтны нэг цагийн хөдөлмөрийн хөлсийг 43 төгрөг 36 мөнгөөр тооцож өдөрт 8 цаг ажилласан ялтанд 347 төгрөг бодсон нь тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2006 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн А/53 тушаалаар батлагдсан “Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээ”-г

# 2008

зөрчсөн хууль бус үйл ажиллагаа явуулж байсныг илрүүлэн засуулжээ.

## МОНИТОРИНГИЙН ТОГТОЛЦОО ЭХЛЭВ

Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран “Прокурорын байгууллагад мониторингийн тогтолцоог нэвтрүүлэх” төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулан программ хангамжтай холбоотой урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж, нийт 126 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг төслийн санхүүжилтээр худалдан авч суурилуулан нэгж газруудад сургагч багш, менежерүүдийг бэлтгэв. Уг ажлын хэрэгжилтийг зохион байгуулах зорилго бүхий ажлын хэсгийг Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтаваар ахлуулан, гишүүдэд Улсын Ерөнхий прокурорын туслах Ж.Оюунчимэг, Б.Бат-Орших, Ц.Ариунболд, Д.Баянжаргал, Нийслэлийн прокурорын орлогч Х.Алтанзүрх, БЗД-ийн прокурор Т.Баярсайхан, СХД-ийн прокурор Г.Бадамханд, ЧД-ийн прокурор М.Гантулга, Улсын Ерөнхий прокурорын хяналтын прокурор Х.Батчимэг, Д.Булганцэцэг, Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Е.Сагсай, Улсын Ерөнхий прокурорын програмист Д.Бөхчулуун нарын бүрэлдэхүүнтэй томилсон Улсын Ерөнхий прокурорын 45 тоот тушаал гарсан байна.



“Прокурорын байгууллагад мониторингийн тогтолцоог нэвтрүүлэх” төслийн хүрээнд прокурорууд ХБНГУ-д, 2008 он



Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаяр прокурорын байгууллагын үйл ажиллагаатай танилцав, 2008 он

# 2008

## “ХОЁР НҮД”-НИЙ ЗАРЧИМ

Хүнд, онц хүнд эрүүгийн хэргийг хянаж шийдвэрлэхэд хоёр прокурор зэрэгцэн хяналт тавьж ажиллах “Хоёр нүд”-ний зарчмыг хэрэгжүүлэх талаар гаргасан зөвлөмжийг аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурорын газрууд хэрхэн хэрэгжүүлж, ямар үр дүнд хүрснийг судлан дүгнэжээ.

## ХУУЛИЙН ДАГУУ АЖИЛЛАХЫГ АТГ-ЫН УДИРДЛАГУУДАД АНХААРУУЛАВ

АТГ-т гомдол гаргагчийн нэр хаяг нь тодорхойгүй гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл хүлээн авч шалгадаг, зарим нэр хаяггүй гомдол, мэдээллийг “Санд хадгалав” гэх хуулинд байхгүй нэр томьёог бий болгон дараа дахин гомдол гарсан тохиолдолд шалгана гэж хадгалж байгаа зөрчлийг илрүүлж дээрх хууль зөрчсөн ажиллагааг зогсоож хуулийн дагуу ажиллахыг АТГ-ын удирдлагуудад анхааруулжээ.

## ХОРИГДОЛ ЯЛТАН Ч ХҮНИЙ ЭРХ ЭДЭЛНЭ

Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий ассамблейгээс батлагдсан “Хоригдолтой харилцах наад захын жишиг дүрэм”-д заасан нэг ялтанд 2.5 м.кв-аас доошгүй талбай ногдоно гэсэн шаардлагыг Дархан-Уул аймаг дахь чанга дэглэмтэй хорих 435 дугаар анги, Сэлэнгэ аймаг дахь хорих 433 дугаар анги, Баривчлах ял эдлүүлэх 431 дүгээр ангиуд хангахгүй 1.1-1.5 м.кв талбайд байрлуулж байсныг илрүүлжээ.



Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр УЕПГ, Нийслэл, дүүргийн прокуроруудын хамт, 2008 он

# 2009

## 280 МЯНГАН ХЭРГИЙН БҮРТГЭЛТЭЙ...

Прокурорын байгууллагад улсын хэмжээний эрүүгийн хэргийн нэгдсэн тоо бүртгэлийг төвлөрүүлж, Эрүүгийн хэргийн төв болон 22 салбар архивыг байгуулж, шаардагдах орон тоо, байр, техник хэрэгсэл тоног төхөөрөмжөөр хангаснаар эрүүгийн хэргийн бүртгэл хяналт, хадгалалт, хамгаалалтын горим, мэдээлэл лавлагааны үйлчилгээ сайжирч, 2009 оны байдлаар 280000 гаруй эрүүгийн хэргийг хүлээн авч нэгдсэн бүртгэлд оруулсан байна.

## ХЯМРАЛЫН ЖИЛД АЖИЛЛАХ НӨХЦӨЛӨӨ САЙЖРУУЛАВ

Дэлхийн эдийн засаг хямарч, дотоодод ч эдийн засгийн хувьд хүндрэлтэй байсан 2009 онд прокурорын байгууллага улсын төсвөөс 5719,1 сая төгрөгийн санхүүжилтийг батлуулан авсан нь 2000 онтой харьцуулахад 5,5 дахин, улсын төсвөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 15 дахин, прокурорын цалин 8,1 дахин нэмэгдсэн үзүүлэлт болж, прокуророуудын хараат бусаар ажиллах нөхцөлийг дээшлүүлэхэд чухал алхамд тооцогджээ.

Зөвхөн прокурорын байгууллагыг ажлын байраар хангах, орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн бодлогын үр дүнд 438,1 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж, давхардсан тоогоор 48 прокурорын газрын конторын барилгад урсгал болон их засвар хийж, 21 аймгийн прокурорын газрыг төрийн мэдлийн орон сууцтай, 10 прокурорын газрыг ажлын байртай болгосноор 2009 оны байдлаар нийт 39 нэгжийн 33 буюу 84,6 хувь нь өөрийн мэдлийн албан конторын байртай болсны дотор Нийслэл, Говь-Алтай, Баянхонгор, Увс аймгийн прокурорын газруудын контор, 500 гаруй сая төгрөгийн өртөг бүхий 20 машины дулаан гарашийг тус тус шинээр барьж ашиглалтад оруулсан байна.

**2 сард**. Нийслэлийн прокурорын газар шинэ байртай болов.

**3 сард.** Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг тэргүүтэй төлөөлөгчид Унгар Улсад айлчлав.

**3 сард**. Германы Техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Прокурорын байгууллагад мониторинг нэвтрүүлэх” төсөл үргэлжилж прокурорууд ХБНГУ-д туршлага судлаж, сургалтад хамрагдав.

**3 сарын 11**. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар Хэрэг эрхлэх газрын бүтцэд өөрчлөлт оруулж, Хэрэг эрхлэх газрын дэд даргаар Д.Энхтөрийг томилжээ.

**5 сарын 24.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Ц.Элбэгдорж ялалт байгуулав.

# 2009

12 сард. УИХ прокурорын байгууллагын орон тоог 25-аар нэмж баталжээ.

-Улсын Ерөнхий прокурорын туслах бөгөөд Хэрэг эрхлэх газрын даргаар Б.Жаргалсайханыг томилов.

-Нанзадын Сосорбарамыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Сүхбаатарын одонгоор шагнав.

-М.Батболд Архангай, М.Оюундэлгэр Булган, Г.Эрдэнэбаатар Говь-Алтай, Х.Цагаанхүү Дундговь, Б.Чинбат Сүхбаатар, Ц.Нямдорж Сэлэнгэ, С.Гансэлэм Ховд, С.Цэрэндалай Хөвсгөл аймгийн прокуророор, Г.Энхтүвшин Налайх дүүргийн, Д.Чулуунбат Тээврийн прокуророор, Н.Ганболд Хархорин сум дахь сум дундын прокурорын газрын ахлах прокуророор томилогдов.

## АРВАН ЖИЛИЙН ӨМНӨХТЭЙ ХАРЬЦУУЛАХАД...

2009 оны прокурорын хяналтын зарим гол үзүүлэлтийг 1999 оны үзүүлэлттэй харьцуулахад эрүүгийн хэрэг бүртгэх ажиллагаанд түдгэлзүүлсэн хэргийн тоо 63,8 хувиар, шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан хэргийн тоо 16,1 дахин, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүний тоо 12,8 хувиар, хорих ангиас оргосон ялтны тоо 44,3 хувь, өвчний болон бусад шалтгаанаар нас барсан ялтны тоо 15,1 хувь, хорихоос өөр төрлийн ялаас зайлсхийсэн ялтны тоо 12,3 хувь буурч, хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа жил тутам нэмэгдэж, яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн хэргийн тоо 8,4 дахин, давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох оролцоо 15 хувиар, эсэргүүцлийн биелэлт 7 хувиар тус тус өссөн байна.

## МОНИТОРИНГИЙН ТӨСЛИЙНХӨН ХБНГУ-Д

3 дугаар сард ХБНГУ-ын Мюнхен хотод Германы Техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж буй “Прокурорын байгууллагад мониторинг нэвтрүүлэх” төслийн баг айлчилж, прокурорын хяналтын чиг үүргийн менежментийн асуудал, цахим сүлжээний талаар туршлага судлав. Тэд доктор Ёхимский, Приллер нартай хамтран ажиллаж, үйл ажиллагааг газар дээр нь үзэж судлажээ. Энэхүү төсөл хэрэгжиж дууссанаар ХБНГУ-ын Засгийн газар Монголын прокурорын байгууллагад томоохон хөрөнгө оруулалт хийсэн юм.

## ХУГАЦАА СУНГАСАН ХЭРГҮҮДИЙГ ШИЙДВЭРЛЭВ

Нийслэл, дүүргийн прокурорт “Мөрдөн байцаалтын хугацаа сунган шалгагдаж байгаа эрүүгийн хэргүүдийг шийдвэрлэх” аяныг мөн оны 10 сарын 10-наас 11 сарын 25-ныг хүртэл зохион байгуулж, 673 эрүүгийн хэргээс 475, түдгэлзүүлсэн хэргүүдээс 1064-ийг сэргээснээс 873 хэргийг нь эцэслэн шийдвэрлэжээ.

# 2009



Тайваний шүүгч, прокуроруудын мэргэжил дээшлүүлэх институтын сургалтад хамрагдсан прокурорууд, 2009 он. Сургалтын үеэр




Нийслэлийн прокурорын газрын шинэ байрны нээлт. Баруун гараас
Нийслэлийн прокурор Ш.Сүхбат, УЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баттөмөр,
Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг, Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав,
Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Билэгт, генерал Д.Сандаг-Очир,
Улсын Ерөнхий прокурорын орлогч Ч.Мөнхбат нар, 2009 он











# ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: 2010-2020 ОН



# 2010

4 сарын 15. УАБЗ-өөс “Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхийг зөвлөмж болгов.

5 сарын 10. Монгол Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдөв.

5 сарын 10. Улсын Ерөнхий прокурорын орлогч Б.Цэрэнбалтав Улсын Ерөнхий прокурорын үүрэг гүйцэтгэгчээр томилов.

5 сарын 17. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Д.Дорлигжавыг Улсын Ерөнхий прокуророор томилов.

10 сард. Шанхайн Хамтын ажиллагааны байгууллагын гишүүн болон ажиглагч орнуудын Ерөнхий прокуророуудын хуралдаанд Улсын Ерөнхий прокурор Д.Дорлигжав оролцож, Улс дамжсан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх талаар илтгэл тавив.

10 сард. Улсын Ерөнхий прокурорын орлогчоор Ц.Бямбацогтыг томилов.

-Б.Бат-Орших Нийслэлийн прокуророор, Б.Баян-Очир Төв, Ц.Дагвадорж Баянхонгор аймгийн прокуророор, Ц.Ариунболд Хан-Уул, Д.Энхтөр Чингэлтэй, Г.Бат-Очир Сүхбаатар дүүргийн прокуророор тус тус томилогдов.

## ДУУЛИАНТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ҮРГЭЛЖЛЭВ

Олон нийтийг хамарсан үймээн, бусдын амь насанд халдсан “Долдугаар сарын 1-ний” гэх хэргийг 2010 онд ч хууль хяналтын байгууллагаас шалгасаар байв. Энэ хэрэгтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Энхбаярыг прокурорын байгууллагад дуудаж тайлбар авсан нь олны анхаарлыг ихэд татсан юм. Үймээний үеэр хүний амь нас хохирсон тул тухайн үеийн цагдаагийн удирдлагуудыг хэрэгт холбогдуулан шалгасан ба энэ хэргийг Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албанаас шалгажээ. Мөрдөн байцаалтаар цагдаагийн ажилтнууд галт зэвсгээр хүний амь нас хохироож, бусдын биед гэмтэл учруулсныг тогтоосон ба удирдлагуудыг үүрэгт ажилдаа хайнга, хариуцлагагүй хандсан үндэслэлээр мөрдөн шалгасан байна.

## 65 ПРОКУРОР МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХАРИУЦАВ

Энэ онд аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурорын газруудад мэдээлэл дүн шинжилгээ хариуцсан туслах прокурорын орон тоог шинээр бий болгож, нийт 65 прокурор энэхүү чиг үүрэгт ажлыг хариуцан гүйцэтгэсний зэрэгцээ харьяа прокурорын газруудад Захиргааны албыг шинээр байгуулж ажиллуулсан байна.

## ПРОГРАММ ХАНГАМЖ САЙЖРАВ

Төрийн архивуудад Мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд прокурорын байгууллагад 2010 оноос эхлэн техник тоног төхөөрөмж авч суурилуулан ашиглав. Тухайлбал 48 терабайтын хүчин чадалтай сервер, хадгалах төхөөрөмжтэй болж сүлжээний холболт, нууцлалын төхөөрөмжтэй цогц системтэй болов. Өгөгдлийн мэдээллийн нөөц хадгалалт хийгддэг, өндөр хурдтай сканнер, бусад шаардлагатай техник тоног төхөөрөмжүүдийг прокурорын байгууллагад ашиглаж эхлэв.

Ингэснээр бүртгэлийн программын архив, модулийн мэдээллийг боловсруулж, төрийн архивын үйл ажиллагааны үндсэн тоо бүртгэлүүдийг бүртгэхээс гадна, хийж гүйцэтгэсэн ажлын тоо мэдээг нэгтгэн гаргах, төв, салбар архивын ажилтнуудын гүйцэтгэж байгаа ажлыг хянаж зааварчилга өгөх боломжтой болжээ.

## ЕРӨНХИЙ ПРОКУРОР ӨӨРЧЛӨГДӨВ

Өмнөх онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар Ардчилсан намаас нэр дэвшиж ялалт байгуулсан Ц.Элбэгдорж хуулийн байгууллагуудын шинэчлэлийн асуудлаар хүчтэй дуугарч, халаа, сэлгээний асуудал эрчимтэй яригдаж эхлэв. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуяг өөрийн хүсэлтээр албан тушаалаасаа чөлөөлөгдөж, Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллаж байсан Д.Дорлигжав Улсын Ерөнхий прокуророор томилогдов.

## ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ АВЧЭЭ

Прокурорын байгууллагын хэмжээнд хийгдэх өөрчлөлт шинэчлэлийн нэг гол асуудал болох прокурор, ажилтнуудын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр бодлогын шинжтэй зарим арга хэмжээнүүдийг дотооддоо болон хуулийн бусад байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэв. Энэ арга хэмжээ дараа дараагийн жилүүдэд ч эрчимтэй үргэлжилсэн байдаг.

# 2010

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР ДАМБИЙН ДОРЛИГЖАВ



Монгол Улсын Ерөнхий прокуророор 2010-2014 онд ажилласан Д.Дорлигжав Увс аймгийн Зүүнговь суманд 1959 онд төржээ.

Тэрбээр 1975-1978 онд Ховд аймгийн ХАА-н техникум, 1980-1983 онд ЗХУ-ын Москва хотын “Цэргийн улс төрийн дээд сургууль”, 1983-1987 онд МУИС-ийг хуульч мэргэжлээр тус тус төгсчээ. Д.Дорлигжав 1978-1979 онд Увс аймгийн Зүүнговь суманд малын эмч, 1988-1989 онд СБД-ийн прокурорын газарт ажилтан, 1989-1990 онд МХЗЭ-ийн Төв Хороонд эрдэм шинжилгээний ажилтан, 1990-1992 онд Шадар сайд, 1996-1998 онд Батлан хамгаалахын сайд, 1998-2000 онд Эрдэнэт үйлдвэрийн Ерөнхий захирал, 2000-2003 онд АН-ын дарга, 2004-2006 онд Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайд, 2006-2008 онд АН-ын ЕНБД, 2009-2010 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, 2010-2014 онд Монгол Улсын Ерөнхий прокурор, 2014-2016 онд ХЗДХ-ийн сайдаар тус тус томилогдон ажиллажээ. Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх цолтой.

# 2010

## МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ ТҮМЭНГИЙН ЖАДАМБАА



Т.Жадамбаа Өмнөговь аймагт 1951 онд төржээ. Тэрбээр 1972-1976 онд МУИС-ийн хуулийн ангийг төгсч, 1978-1979 онд ЗХУ-ын Ленинград хот дахь мөрдөн байцаагч нарын мэргэжил дээшлүүлэх 3 сарын курст суралцжээ.

Т.Жадамбаа 1976-1982 онд Улаанбаатар хотын прокурорын мөрдөн байцаагч, криминалист прокурор, 1983-1984 онд Өмнөговь аймгийн прокурорын газарт хэсгийн прокурор, 1984-1986 онд хотын прокурорын газарт криминалист прокурор, 1986-1991 онд Октябрийн районы прокурорын туслах, 1991-1995 онд хотын прокурорын газарт хяналтын прокурор, 1995-1996 онд Увс аймгийн прокурор, 1996-2003 онд Өмнөговь аймгийн прокурорын туслах, орлогч, 2003 оноос Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокуророор ажиллаж байгаад 2010 онд Монгол Улсын гавьяат хуульч цолоор шагнагджээ. Т.Жадамбаа хэрэг материалыг хянаад бие дааж шийдвэр гаргах, гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг нотлох чадварыг сайн эзэмшсэн мөрдөн байцаагч, туршлагатай прокурор юм.

## ЦЭНДСҮРЭНГИЙН БЯМБАЦОГТ



Ц.Бямбацогт Увс аймгийн Баруун туруун сумын нутагт 1958 онд төржээ. Тэрбээр 1976-1981 онд ЗХУ-ын Ташкент хотын Их сургууль төгсчээ.

Ц.Бямбацогт 1970 оноос шүүх яамны хууль боловсруулах, системчлэх хэлтэст мэргэжилтэн, 1983-1986 онд Геологийн яаманд хуулийн зөвлөх, гадаад харилцааны мэргэжилтэн, 1986-1993 онд Сүхбаатар дүүргийн прокурорын газар хяналтын прокурор, 1993-1994 онд Нийслэл, Улсын Ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, 1995-1997 онд Баянгол дүүргийн прокурорын газрын ахлах прокурор, 1997-2002 онд Улсын Ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, 2002-2010 онд Иргэний Бүртгэл Мэдээллийн Улсын төв, Улсын бүртгэлийн газарт хяналт шалгалтын хэлтэс, газрын дарга, 2010-2017 онд Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчоор, 2017-2018 онд Улсын Ерөнхий прокурорын зөвлөхөөр ажиллажээ.

# 2010



Монгол Улсын Ерөнхий прокурор Д.Дорлигжав Бүгд найрамдах Франц улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд ноён Жан Поль Дюмоныг хүлээн авч уулзав. 2010 он



Прокурорын байгууллагын 80 жилийн ойн баярын үеэр. 2010 он

# 2011

2 сарын 25. Прокурорын байгууллагын боловсон хүчнийг сэлгэн ажиллуулах, дэвшүүлэн томилох үйл ажиллагаанд ил тод, шударга байдлыг хангах тухай журмыг Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталлаа.

5 сард. "Прокурорыг сэлгэн ажиллуулах, дэвшүүлэн томилох журам"-ыг Ерөнхий прокурорын тушаалаар батлан мөрдүүлэв.

6 сарын 23. Хуулийн байгууллагуудын ажилтнуудын сахилга, хариуцлага, дэг журмыг сайжруулах зорилгоор Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Хууль зүй Дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын хамтарсан захирамж, тушаал гаргажээ.

8 сарын 1. Прокурорын байгууллагын бүртгэл, мэдээллийн программын төслийн эхний үе шатыг ХБНГУ-ын Техникийн хамтын ажиллагааны газартай хамтран хэрэгжүүлж, бүртгэл мэдээллийн санг ашиглаж эхлэв.

## ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО

Улсын Ерөнхий прокурор, түүний орлогч нарын зүгээс прокурорын байгууллагын хяналтын шатны прокуроруудын үйл ажиллагаанд анхаарах шаардлагатай байгаа асуудлуудаар прокурорын байгууллагын удирдах ажилтнуудын зөвлөгөөнд илтгэл тавив. Тухайлбал, удирдамж болгон дагаж мөрдөж байгаа заавар, журам, Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон зарчимд нийцээгүй зөрчилдсөн, хариуцлагын тогтолцоо боловсронгуй бус зэргийг илтгэлдээ онцолжээ.

## ЗААВАР ЖУРМЫГ ШИНЭЧЛЭВ

Прокурорын хяналтын ажлын арга барилыг өөрчлөх бодит шаардлагыг харгалзан өмнө нь мөрдөгдөж байсан Улсын Ерөнхий Прокурорын тушаал, албан даалгаврыг Монгол Улсын ЭБШХууль болон бусад хуулийн заалтад нийцүүлэн "Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаа, түүнд тавих прокурорын хяналтын ажилд ЭБШХуулийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан заавар", "Шүүх хуралдаанд прокурор оролцоход мөрдөх аргачилсан заавар", "Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын ажлын заавар, аргачлал", "Эрүүгийн хэргийн төв болон салбар архивт баримт хүлээн авах, тоо бүртгэл хөтлөх, баримтын хадгалалт, хамгаалалт, ашиглалтын журам" зэрэг удирдлага зохион байгуулалтын шинжтэй 20 гаруй баримт бичиг, удирдамжийг шинээр боловсруулан гаргажээ. Өмнө нь мөрдөгдөж байсан 78 удирдамжийн баримт бичгийг хүчингүй болгосон байна.

## ДОТООД АЖЛЫН ӨДӨРТЭЙ БОЛОВ

Улсын Ерөнхий прокуророос тушаал гаргаж долоо хоногийн нэг өдрийг дотоод ажлын өдөр болгов. Энэхүү дотоод ажлын өдөр нь прокурорууд ажлаа дүгнэн ярилцах, тодорхой хэргүүдийг хянаж байгаа прокуророор мэдээлэл

# 2011

хийлгэх, тал бүрээс нь мэргэжлийн түвшинд мэтгэлцэх онолын болон практик арга барилыг нэгнээсээ суралцахад чиглэгджээ.

## ЭЦСИЙН ХАРИУЦЛАГЫГ ПРОКУРОР ХҮЛЭЭНЭ

Шүүхийн тухай багц хуулиуд шинээр батлагдсан тул Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг Улсын Ерөнхий Прокурорын тушаалаар байгуулжээ. Ажлын хэсэг прокурорын хяналтын ажилд дагаж мөрдөх 24 дэвтэр 1800 заалт бүхий аргачилсан заавар боловсруулжээ. Эрхзүйн ийм зохицуулалт хийснээр хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналтын арга хэлбэрийг дэлхийн нийтийн чиг хандлагад нийцүүлэн өөрчлөх, хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагааг прокурор идэвхигүй байдлаар хянах бус, хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагааг Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх Хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд прокурор удирдан чиглүүлдэг тогтолцоонд шилжлээ.

## АЛБАН ДААЛГАВАР, ТУШААЛУУДЫН МӨРӨӨР...

Прокурорын байгууллагаас хийж гүйцэтгэх ажлын чиг хандлагыг шинэчлэн тодорхойлох зорилгоор Монгол Улсын Ерөнхий Прокурорын 01 тоот албан даалгаврыг 2011 оны 3 дугаар сард гаргав. Албан даалгаврыг нийт нэгж ажилтнуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг дүгнэсэн байна.

Түүнчлэн Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий Шүүгч, Хууль зүйн сайдтай хамтран 2011 онд “Хуулийн байгууллагын ажилтнуудын сахилга хариуцлагыг сайжруулах тухай” “87/111/118” тоот захирамж, тушаал гаргаж мөрдүүлснээр хуулийн байгууллагуудын ажилтнууд хууль зөрчих, ажлын сахилга, хариуцлага алдах явдал буурсан байна. Улмаар Монгол Улсын Ерөнхий прокурорын 2011

10 сард. Прокурорын байгууллагын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу нийт прокуроруудаас мэргэжлийн түвшин тогтоох шалгалт авав.

-Бодлого төлөвлөлт, гадаад харилцааны хэлтсийг Дүн шинжилгээ, судалгаа, гадаад харилцааны хэлтэс нэртэй болгон өөрчлөв.

-“Мэдээллийн технологи, дүн шинжилгээний алба”-ыг УЕПГ-ын Тамгын хэлтсийн дэргэд байгуулав.

-Ү.Содномцог Дундговь, Т.Батсүх Баян-Өлгий, Ш.Эрдэнэбилэг Булган, Б.Очбадар Дорнод, Ш.Батаа Говьсүмбэр, Н.Доржсүрэн Завхан, А.Аварзэд Хөвсгөл, Б.Дашням Дархан-Уул, Д.Энхбаяр Хэнтий, Н.Батмөнх Өвөрхангай, П.Баасанжав Өмнөговь, Л.Бадралт Дорноговь, Б.Эрхэмбаатар Увс, Ж.Мөнхжаргал Орхон, П.Эрдэнэбат Говь-Алтай, Б.Жаргалсайхан Тээврийн, Ня.Энхтуяа Баянгол дүүргийн, Н.Найгалдорж Налайх дүүргийн прокуророор тус тус томилогдлоо.

# 2011

оны 94 тоот тушаалаар “Прокурорын байгууллагын албаны хариуцлагын тогтолцоог сайжруулах талаар дагаж мөрдөж ажиллах журам”, 46 тоот тушаалаар “Прокурорыг сэлгэн ажилуулах, дэвшүүлэн томилоход мөрдөх журам”-ыг тус тус баталжээ. Эдгээр тушаал, албан даалгаврын хэрэгжилтийг харьяа прокурорын газруудад шалгаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авчээ.

## ОЛОН УЛСЫН ПРОКУРОРЫН ХОЛБООНЫ ОНЦЛОХ ПРОКУРОР МОНГОЛООС ТОДРОВ

БНСУ-ын Сөүл хотод 2011 оны 6 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд болсон Олон Улсын прокуроруудын холбооны ээлжит хурлаас Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны дэд дарга Ц.Батболдыг “Оны онцлох прокурор”-оор тодруулжээ.



ОУПХ-ны 2011 оны Онцлох прокуророор шалгарсан Ц.Батболд шагнал гардан авах үеэр, 2011 он




Прокурорын байгууллагын удирдлагууд түүхт 80 жилийн ойн баярын үеэр, 2010 он

# 2012

## ОЛОН НАМЫН ТӨЛӨӨЛӨЛТЭЙ ПАРЛАМЕНТ

Зургаа дахь удаагийн Улсын Их Хурлын сонгууль 6 дугаар сарын 28-нд анх удаа холимог системээр явагдсан ба энэ сонгуулийн сурталчилгааны гол сэдэв нь авлига, хээл хахуультай тэмцэх байв. Сонгуулийн дүнгээр Ардчилсан намаас 34, МАН-аас 26, МАХН-МҮАН-ын "Шударга ёс" эвслээс 11, Иргэний зориг-Ногоон намаас 2, бие даан нэр дэвшсэн 3 хүн тус тус Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдов.

Энэ удаагийн парламентын онцлог нь УИХ-д гурван намын бүлэг байгуулагдаж, тэдгээрийг төлөөлсөн Улсын Их Хурлын гурван дэд даргатай, хамгийн олон намын төлөөлөлтэй, үр дүнд нь эвслийн Засгийн газрууд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэв.

## ХЭНТЭЙ Ч ХУВААЛЦАХГҮЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЁСТОЙ

Монгол Улс 2012 оны байдлаар олон улсын 265 гэрээнд нэгдэн оржээ. Олон улсын гэрээний заалтыг хэрэгжүүлэхэд прокурорын байгууллага чухал үүрэгтэй бөгөөд НҮБ-ын "Иргэний болон улс төрийн эрхийн талаарх Пакт", "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харилцах, шийтгэхийн эсрэг конвенци", "Үндэстэн дамнасан зохион байгуулалтай гэмт хэргийн эсрэг конвенци", "Мансууруулах бодисын тухай конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах тухай протокол" зэрэг гэрээ, конвенцийн заалтыг хэрэгжүүлж ажиллахыг Улсын Ерөнхий прокурор, орлогч прокуроруудын зүгээс нийт прокурор, ажилтнууддаа үүрэг болгожээ.

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой олон улсын конвенцийн заалтуудыг Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хяналт тавьж байгаа төрийн тусгай албан хаагч-прокурорууд хэнтэй ч хуваалцахгүйгээр хэрэгжүүлэх ёстой гэдгийг Улсын Ерөнхий прокурорын зүгээс онцолсон байна.

**3 сарын 7.** Прокурорын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ батлав.

**6 сарын 18.** Монгол Улсын Ерөнхий прокурорын газар болон БНТУ-ын Дээд шүүхийн Ерөнхий прокурорын газар хооронд санамж бичиг байгууллаа.

**9 сарын 7.** Монгол Улсын Их хурлын 26 дугаар тогтоолоор "Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай" тогтоолын хавсралтад нэмэлт оруулав.

-Казахстан Улсын Ерөнхий прокурорын газартай хамтран ажиллах тухай хэлэлцээр, БНХАУ-ын Ардын Дээд прокурорын газартай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зуржээ.

-Ханнс Зайделийн сангийн эрхзүйн боловсролын академитэй хамтран сургагч багш - прокурор бэлтгэх сургалтыг зохион байгуулав.

-БНТУ-ын Анкара хотын Хуульзүйн академид прокуроруудыг сургав.

-Б.Ганбаатар Ховд аймгийн прокуророор, С.Гансэлэм Өвөрхангай аймгийн прокуророор тус тус томилогдлоо.

# 2012

## ЕРӨНХИЙ ПРОКУРОР ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭД ЭСЭРГҮҮЦЭЛ БИЧНЭ

УИХ-аас Прокурорын байгууллагын тухай хуульд 3 дугаар сарын 7-нд өөрчлөлт оруулснаар “Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлээд гаргасан анхан шатны шүүхийн тогтоолд улсын яллагч давж заалдах болон хяналтын шатны шүүхэд эсэргүүцэл бичих эрхтэй. Харин давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл прокурор хяналтын шатны шүүхэд эсэргүүцэл бичнэ” гэснийг “...давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл Улсын Ерөнхий прокурор хяналтын шатны шүүхэд эсэргүүцэл бичнэ” хэмээн өөрчилжээ.

## БАГЦ ЦАГИЙН СУРГАЛТУУД ЗОХИОН БАЙГУУЛАВ

“Трансиперенси интернешнл“ ТББ-тай хамтран Англи улсаас 2 прокурорыг урьж “Авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн байцаах ажиллагаа, прокурорын хяналт”, Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн, БНСУ-ын Күүкмины Их сургуультай хамтран “Уул уурхай, байгаль орчны эсрэг гэмт хэрэгт тавих хяналт”, Олон Улсын Эрүүгийн Шүүхийн харьяа Матрихнетвок байгууллагын захирал профессор Морген Бергсмог урьж “Олон Улсын Эрүүгийн Шүүхээр шийдвэрлэж буй хэрэгт мөрдөн байцаалт, прокурорын ажиллагаа хэрхэн явагддаг тухай” сэдэвт багц цагийн сургалтуудыг зохион байгуулав. Сургалтад Нийслэл, Тээвэр, дүүрэг, зарим аймгийн прокурорын газрын прокурорууд, Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагчдыг хамруулжээ.


## УИХ-ЫН ДЭД ДАРГА ЛОГИЙН ЦОГ



Л.Цог Говь-Алтай аймгийн Шарга сумын уугуул. Тэрбээр 1977 онд ЗХУ-ын Эрхүүгийн Улсын Их Сургууль, 1988 онд ЗХУ-д Нийгмийн ухааны академи тус тус төгсчээ.

Тэрбээр 1977-1986 онд Улсын Прокурорын газарт хэлтсийн прокурор, хэлтсийн дарга, 1988-1990 онд МАХН-ын Төв хорооны дэргэдэх намын хянан шалгах хороонд байцаагч, 1990-1992 онд УБХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга, 1996-1999 онд Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, 1999 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд, 2012-2016 онд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож, улмаар УИХ-ын дэд даргаар сонгогдон ажиллажээ.

# 2012



“Эрүүгийн хэрэгт харилцан туслалцаа үзүүлэх, боловсон хүчнийг сургах, судалгаа, шинжилгээ хийх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх” Монгол Улсын Ерөнхий прокурорын газар болон ОХУ-ын Ерөнхий прокурорын газар хоорондын хэлэлцээрт Улсын Ерөнхий прокурор Д.Дорлигжав гарын үсэг зурав. 2012 он

## ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТӨВ АРХИВЫН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭВ

Улсын Ерөнхий прокуророос архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулахад анхаарч, архивыг зориулалтын байртай болгох, баримтыг тусгай шүүгээнд хадгалахыг дэмжиж 844,8 метр квадрат талбай бүхий 5 давхар архивын зориулалт бүхий байрны барилга угсралтын ажлыг 2012 оны 9 дүгээр сард эхлүүлжээ.

# 2013

1 сарын 1. Мониторингийн системийг бүх нэгжүүдэд нэвтрүүлэх ажлыг эхлүүлэв.

1 сарын 9. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн зарлигаар Ганбатын Эрдэнэбатыг Улсын Ерөнхий Прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөхөөр томиллоо.

2 сарын 5. Улсын Ерөнхий прокурорын 23 тоот тушаалаар Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын прокурорын газарт ажиллах прокуроруудыг томилж үйл ажиллагааг нь эхлүүлжээ.

3 сарын 6. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар мэдээлэл дүн шинжилгээ, бодлого төлөвлөлт хариуцсан прокуроруудын хийх ажлын чиглэлийг тодорхойлж, зөвлөгөөн, сургалтыг зохион байгуулжээ.

5 сарын 23. УИХ-ын 38 дугаар тогтоолоор “Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулжээ.

## ДҮҮРГИЙН 1, 2, 3, 4 ДҮГЭЭР ПРОКУРОРЫН ГАЗРУУДЫГ БАЙГУУЛАВ

Прокурорын байгууллагын удирдлагуудын зүгээс дүүргийн прокурорын газруудыг нэгтгэн үйл ажиллагаа явуулах шийдвэр гаргав. Үүний дагуу Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн прокурорын газрууд нэгтгэгдэн Дүүргийн 1 дүгээр прокурорын газар, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрууд нэгтгэгдэн Дүүргийн 2 дугаар прокурорын газар, Багануур дүүрэг, Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумдыг харьяалсан Дүүргийн 3 дугаар прокурорын газар, Багахангай дүүрэг, Төв аймгийн Баян, Баянжаргалан, Эрдэнэ сумдыг харьяалсан Дүүргийн 4 дүгээр прокурорын газрыг тус тус байгуулан ажиллуулав. Эдгээр прокурорын газруудад харьяалагдах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, нягтаршил, дэд бүтэц, орон зай, гэмт хэрэг, зөрчлийн гаралт зэргээс үүдэн прокурорын хяналтын ажлыг хэвийн явуулахад олон хүндрэл бэрхшээл учирч байсан тул хожим энэ шийдвэрийг эргэн харахаас аргагүйд хүрсэн.

## СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ТӨВИЙГ ДАХИН БАЙГУУЛАВ

Прокурорын мэргэжлийн ур чадвар, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор мэргэшүүлэх болон давтан сургалт



УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн нээлтийн ёслол, 2013 он

# 2013

явуулах, прокуроруудын сургалтын журмыг шинэчлэхэд анхаарч дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлсэний үр дүнд Улсын Ерөнхий прокурорын 2013 оны А/44 тоот тушаалаар сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх чиг үүрэг бүхий Сургалт, судалгааны төвийг 4 прокурор, 17 ажилтны орон тоотойгоор Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэд байгуулав.

## НЭГ НЬ ИРГЭНД ӨГӨХ ШИЙДВЭР, НӨГӨӨ НЬ ПРОКУРОРТ ӨГӨХ ДААЛГАВАР

Прокурорын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнөөр иргэдийн өргөдөл гомдлыг хянан хэлэлцэхийн зэрэгцээ шат шатны прокуроруудын алдаа гаргасан эсэхийг давхар хянах сэдвийг онцлон хэлэлцэв.

Энэ талаар Улсын Ерөнхий прокурор “Улсын Ерөнхий прокурорын газар хүртэл давж заалдаж ирж байгаа хүмүүсийн өргөдөл, гомдлыг хянахын хажуугаар тэр гомдол дотор аль шатны прокурор хэн гэгч ямар алдаа гаргав, түүнийг шат шатны прокурорууд яаж засав гэдгээр та бүхний үйл ажиллагааг тухай бүрт нь үнэлж, буруу зөвийг нь хэлж, шаардлагатай арга хэмжээг авах ийм журмыг бид хэвшүүлнэ. Тэгэхээр энэ зөвхөн Улсын Ерөнхий прокурорын газрын арга барил байх ёсгүй.

Жишээ нь Нийслэлийн Прокурорын газар ч гэсэн дүүргийн прокурорын үйл ажиллагаанд гомдол гаргаад ирж байгаа тохиолдолд гомдлыг хянахын хажуугаар, хянасан болон дээд шатны прокурор ямар алдаа гаргав гэдгийг заавал давхар дүгнэдэг байх ёстой.

Энэ бол хамгийн чухал арга зүйн даалгавар. Иргэний гомдлыг хуулийн хүрээнд хянахаас гадна доод шатны прокурорын алдааг заавал хянаж хоёр шийдвэр гаргадаг байх ёстой. Нэг нь иргэнд өгөх шийдвэр, нөгөө нь прокурорт өгөх арга хэмжээ эсвэл үүрэг даалгавар байх ёстой” хэмээн илтгэжээ.

-ОХУ-ын Ерөнхий прокурорын газартай хамтран ажиллах тухай хэлэлцээр, Холбооны Бүгд найрамдах Австри улсын Ерөнхий прокурорын газартай Харилцан ойлголцлын санамж бичигт тус тус гарын үсэг зуржээ.

-Улсын Ерөнхий прокурорын 2013 оны А/44 тоот тушаалаар Улсын Ерөнхий прокурорын газарт хэлтэс, алба, төвийг шинээр байгуулав.

-Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэд Сургалт, судалгааны төвийг байгуулав.

-“Видео хуралдааны танхим “шинээр байгуулж, харьяа прокурорын газруудтай шууд харилцах боломжийг бүрдүүлэв.

-Турк улсын Ерөнхий прокурор Хасан Эрбиль Улсын Ерөнхий прокурорын газарт зочлов.

-Е.Сагсай Сүхбаатар дүүргийн, Г.Бат-Очир Дархан-Уул, Г.Чагдар Сэлэнгэ, Т.Мөнхбаяр Увс, Б.Очбадар Сүхбаатар, Ц.Нямтайван Дорнод, С.Дававаравдан Өмнөговь, Б.Одхүү Баянхонгор, Н.Ганбаатар Говь-Алтай аймгийн прокуророор тус тус томилогдлоо.

# 2013

## “АНОД”-ЫН ГЭХ ДУУЛИАНТ ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЭВ

Өөрсдийн завшсан хадгаламж эзэмшигчдийн мөнгийг нөхөхийн тулд хууль бусаар хувьцаа гаргаж, 1200 иргэнийг залилсан Анод банкны удирдлагуудын хэрэг 2008 оноос эхлэн хуулийн байгууллагад шалгагдсаар нийт 122 тэрбум төгрөг, дөрвөн сая ам.долларын хохирол учруулсан болохыг прокуророос тогтоож шүүхэд шилжүүлжээ. Улмаар Анод банкны удирдлагуудыг шүүхээс гэм буруутайд тооцож, ял шийтгэл оноосон ба хувьцаа эзэмшигч 1200 хүний есөн тэрбум төгрөгийн хохирлыг төрөөс гаргуулахаар болсон аж.

## ХАРЬЯА ПРОКУРОРЫН ГАЗРУУДЫГ МОНИТОРИНГИЙН СИСТЕМД ХОЛБОЛОО

ХБНГУ-ын Олон улсын техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран мэдээлийн нэгдсэн сан бүхий “Прокурорын байгууллагын үйл ажиллагааны мониторингийн систем”-ийг 2013 оны 1 дүгээр сараас бүрэн ашиглалтад оруулсан бөгөөд улсын төсвөөс олгогдсон 2,7 тэрбум төгрөгөөр прокурорын байгууллагын нууцлалыг хангасан шилэн кабелийн сүлжээний дэд бүтцээр улсын хэмжээнд ажиллаж байгаа 40 прокурорын газрыг, сансрын хиймэл дагуулын тусламжтайгаар Ховд аймгийн Булган суман дахь прокурорын газрыг түс түс холбож, мэдээллийн шуурхай байдлыг хангах, эрүүгийн хэргийн мөрдөн шалгах болон шийдвэрлэлтэд тавих хяналтын шинэ тогтолцоог бий болголоо. Энэхүү бүртгэл хяналтын системийг ашиглаж, улсын хэмжээнд гарч байгаа бүх эрүүгийн хэргийн шийдвэрлэлтэд гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг хүлээн авсан үеэс нэгдсэн байдлаар хяналт тавих боломж бүрдлээ.

## ГАДААД СУРГАЛТАД ПРОКУРОРУУДАА ХАМРУУЛАВ

Гадаад сургалтын хүрээнд БНТУ-ын Анкара хотын эрх зүйн академид 55 прокурор, ОХУ-ын Москва хотын Ерөнхий прокурорын дэргэдэх академид 13 прокурор, БНКазакстан улсад туршлага судлуулахаар 2 прокурор, Тайваний Хууль эрх зүйн институтэд 20 прокурор, БНСУ-ын Эрх зүйн институтэд 12 прокурор, БНХАУ-ын Шандунг мужийн Жинан хотноо болсон “Авлигын эсрэг олон улсын холбоо”-ноос зохион байгуулсан олон улсын семинарт 4 прокурор, мөрдөн байцаагч түс түс хамрагджээ.


## 55 ДААЛГАВАР, ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭЖЭЭ

Улсын Ерөнхий прокурорын газар Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх чиглэлээр, Монгол Улсаас гадаадын улс орнуудтай байгуулсан “Иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ” хэлэлцээрүүдийн хүрээнд нийт 55 даалгавар, хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэжээ.

# 2013

## НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АЖИЛД АХИЦ ГАРАВ

Прокурор, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 2013 онд Улаанбаатар хотод 112 айлын орон сууцыг шинээр барьж ашиглалтад оруулжээ. Түүнчлэн Налайх дүүрэг, Төв аймаг болон бусад аймгуудад нийт 80 гаруй прокурор ажилтнуудад хувийн хэрэгцээнд нь зориулж газар олгуулах ажлыг зохион байгуулсан байна.



## ГАНБАТЫН ЭРДЭНЭБАТ



Г.Эрдэнэбат нь 1972 онд Улаанбаатар хотод төржээ. Тэрбээр 1994 онд Цагдаагийн дээд сургууль, 1997 онд БХИС-ийн Удирдлагын сургууль, 2000 онд ОХУ-ын Уралын хуулийн академийг тус тус дүүргэжээ.

Г.Эрдэнэбат 1994-1995 онд Хилийн цэргийн офицер, 1995-1997 онд БХИС-д багш, 1997-2000 онд ХЦУГ-ын Захиргаа удирдлагын газарт хуулийн зөвлөх, 2000-2009 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд багш, 2009-2010 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт Ерөнхийлөгчийн хуулийн асуудал хариуцсан туслах, 2010-2013 онд Улсын Ерөнхий прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, 2013-2019 онд Улсын Ерөнхий прокурорын орлогчоор томилогдон ажиллажээ.

# 2013



Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхий прокурорын газар хоорондын хэлэлцээрт Улсын Ерөнхий прокурор Д.Дорлигжав гарын үсэг зурав. 2013 он



Улсын Ерөнхий прокурор Д.Дорлигжав БНТУ-ын Ерөнхий прокурорт монгол дээл бэлэглэв, 2013 он



Улсын Ерөнхий прокурорын орлогч Ц.Бямбацогт БНТурк Улсын Ерөнхий прокурорын хамт Налайх дүүргийн прокурорын газрын ажилтай танилцав. 2013 он

# 2013




Мэдээлэл дүн шинжилгээ хариуцсан прокурорууд
ХБНГУ-ын багшийн хамт, 2013 он




Нийслэлийн прокурорын газрын прокурорууд
Хонконгийн Ерөнхий прокурор Кевин Зервосын хамт, 2013 он

# 2014

1 сарын 6. Улсын Ерөнхий прокурорын А/03 дугаар тушаалаар прокурорын байгууллагын мэдээлэл, мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах тухай журмыг баталжээ.

1 сарын 24. Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албыг УИХ-ын тогтоолоор АТГ-т шилжүүлэв

2 сарын 11. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар “Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс” байгуулж, аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурорын газрын бүтцийг шинэчлэн батлав.

5 сард. “Цэвэр агаар-Саруул ухаан“ сэдэвт явган аяллыг улсын хэмжээнд зохион байгуулж, 2200 орчим прокурор, ажилтнууд оролцов.

-Улсын Ерөнхий прокурорын газар, Бүгд Найрамдах Узбекстан Улсын Ерөнхий прокурорын газар хооронд хамтран ажиллах санамж бичиг байгуулав.

## ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУД НЭГДЭЖ АЖИЛЛАВ

Улсын Ерөнхий прокурорын санаачлагаар Шүүхийн Ерөнхий зөвлөл, Хууль зүйн сайдтай хамтран хуулийн байгууллагын ажилтнуудын сахилга хариуцлага, хуулийн төв байгууллагуудаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж, цаашид авах арга хэмжээний талаар холбогдох газруудад зөвлөмж өгчээ.

## Г.ЭРДЭНЭБАТ: ХУУЛЬ БОЛ НИЙГМИЙН ГЭРЭЭ

Гэмт хэргийн тухай болон Зөрчлийн тухай хуулиудын ажлын хэсэгт орсон Улсын Ерөнхий прокурорын орлогч Г.Эрдэнэбат “Одоогийн бидний нэршиж заншсан Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийг шинээр төрөлжүүлэн нэгтгэж боловсруулсан Гэмт хэргийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулиудыг хуучин хуулиудтайгаа харьцуулахад тоо хэмжээ, багтаамжийн хувьд нэлээд өргөссөн. Энэ хуулийн төслийг хэлэлцүүлэх явцдаа бид эн тэргүүнд нэг гол үзэл баримтлалыг хэрэгжүүлж чадсан. Хууль бол нийгмийн гэрээ байх ёстой. Өмнө нь энэ мэт нийгмийн том харилцааг зохицуулсан хууль дээр нийгмийн бүх хэсгийг хамарсан хэлэлцүүлэг явуулж байсангүй. Энэ удаа Гэмт хэргийн тухай хуулийг олон нийтээр жил дамнан хэлэлцүүллээ. Ингэж нийгмийн бүхий л хүрээний санал шүүмжийг авч байж Гэмт хэргийн тухай хуулийн үзэл баримтлал боловсрогдсон. Хуулийн төсөл дээр алдаатай, буруу гэж үзсэн зүйлээ маш идэвхтэй шүүмжилж, хэвлэл мэдээллээр байр сууриа илэрхийлж байсан тэр хүмүүс ч гэсэн үнэн хэрэгтээ “Ийм хууль байх ёсгүй” гэхээсээ илүү “Энэ хууль илүү сайжраасай” гэж л үзсэн хэрэг” хэмээн яриа өгчээ.

# 2014

## УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД АНХААРАВ

Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хяналтыг удирдан чиглүүлэх үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх чиглэлд анхаарч ажиллажээ. Энэ нь тус онд өрнөсөн прокурорын байгууллагын үйл ажиллагааны өөрчлөлт шинэчлэлийн гол цөм болсон байна. Тухайлбал, аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурорын газрууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлаж, энэ талаар иргэд олон нийтэд мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг хамтран шалгах, илэрсэн зөрчлийг арилгуулахаар мэдэгдэл бичих, уулзалт ярилцлага, өдөрлөг, сургалт явуулах, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг гаргах зэрэг олон төрлийн ажлыг төлөвлөн хэрэгжүүлжээ.

## ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭВ

2014 оны 4 дүгээр сард Монгол Улс, ОХУ-ын хил орчмын бүс нутгийн прокуроруудын анхдугаар уулзалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулав. БНТУ-ын Ерөнхий прокурор Хасан Ербил, Австрийн холбооны улсын Ерөнхий прокурор Эрнест Йоганн Фабриц, ОХУ-ын Ерөнхий прокурорын орлогч В.Я.Гринь нарыг Монгол Улсад урьж байгууллага хооронд хамтран ажиллах хэлэлцээрт гарын үсэг зурах, харилцан мэдээлэл солилцох, цаашид хамтран ажиллах чиглэлээ тогтоов. Монгол Улсын Ерөнхий прокурор Д.Дорлигжав ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНКуба Улс, Австрийн Холбооны Улс, Щвейцарь, БНФранц Улс, БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонг-Конгийн прокурорын газрын урилгаар ажлын айлчлал хийж мөнгө угаах, хүн худалдаалах, мансууруулах бодис, хар тамхитай холбоотой гэмт хэргүүдийг илрүүлэх, яриа хэлэлцээр хийжээ.

-Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалтын төвд ОХУ-ын Ерөнхий прокурор асан доктор, профессор Ю.И.Скуратов зочлов.

-Д.Энхтөр Дүүргийн 1 дүгээр прокурорын газрын, Б.Баян-Очир Дүүргийн 2 дүгээр прокурорын газрын, Б.Пүрэвжав Дүүргийн 3 дугаар (Багануур) прокурорын газрын, Н.Найгалдорж Дүүргийн 4 дүгээр (Налайх) прокурорын газрын, Ц.Дангаасүрэн Тээврийн, Ц.Мөнхбат Төв, Ц.Ариунболд Өвөрхангай, Ц.Амгаланбаатар Говьсүмбэр, Б.Ууганбаатар Хөвсгөл, Д.Жамбалсүрэн Архангай, Б.Эрхэмбаатар Булган, П.Батболд Дундговь, С.Алимаа Төв, С.Цэрэнсамбуу Дорноговь, Д.Доной Өмнөговь, П.Мөнхзул Дархан-Уул аймгийн прокуророор тус тус томилогдлоо.

# 2014



Улсын яллагчийн хавтсаа гардан авсан прокурорууд, 2014 он



Улсын Ерөнхий прокурор Д.Дорлигжав, Монгол Улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат, ОХУ-ын Ерөнхий прокурор асан, доктор, профессор Ю.И.Скуратов нар Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвд зочлов. 2014 он

# 2014

## МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД ЦЭРЭНДАШИЙН ОЮУНБААТАР



Ц.Оюунбаатар Өмнөговь аймгийн Манлай суманд 1956 онд төржээ. Тэрбээр 1977 онд Хууль цаазын дунд сургууль, 1984 онд Иванов хотын их сургууль, 1994 онд Москва хотын их сургуулийг хуульч, эдийн засагч мэргэжлээр тус тус төгсчээ.

Ц.Оюунбаатар 1977-1979 онд Дорноговь аймагт сум дундын прокурор, 1984-1986 онд Завхан аймгийн прокурорын орлогч, 1986-1990 онд Завхан аймгийн прокурор, 1990-1992 онд Улсын прокурорын ерөнхий хяналтын газрын дарга, 1992-2008 онд Удирдлагын академид ахлах багш, дэд профессор, 1999-2000 онд “Талх чихэр” ХК-ийн ерөнхий захирал, 2000-2004 онд УИХ-ын гишүүн, 2004-2008 онд Говийг хөгжүүлэх төрийн бус байгууллагуудын дарга, МАХН-ын Удирдах зөвлөлийн гишүүн, 2008-2010 онд Улсын татварын Ерөнхий газрын дарга, 2012-2016 онд УИХ-ын гишүүн, 2014-2016 онд Шадар сайдаар ажиллажээ.

## МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ АЮУШИЙН ЯДМАА



Аюушийн Ядмаа 1928 онд Завхан аймгийн Улаагчин сумын нутагт төржээ. Тэрбээр Багшийн дээд сургуульд элсэн суралцахын зэрэгцээ МУИС-ийн хуулийн ангид давхар сурч, улаан дипломтой төгсчээ.

А.Ядмаа 1965-1970 онд Увс аймгийн прокурор, 1970-1991 онд Улсын прокурорын Ерөнхий хяналт эрхэлсэн туслах бөгөөд коллегийн гишүүнээр ажилласан байна.

Түүний хөдөлмөрийг төрөөс өндрөөр үнэлж Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2014 оны арванхоёрдугаар сарын 23-ны өдрийн зарлигаар Монгол Улсын Гавьяат хуульч цол хүртээжээ.

Тэрбээр прокурорын ажилд залуу боловсон хүчнийг бэлтгэх, сургахад махран ажиллаж, өөрөө үлгэрлэн, “Яс Ядмаа” хэмээх алдрыг хүртсэн бөгөөд олон арван гарын авлага, материал бэлтгэсэн ахмад прокуроруудын нэг юм.

# 2015

**2 сарын 13.** Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн зарлигаар Улсын Ерөнхий прокуророор М.Энх-Амгаланг томилов.

**4 сарын 14.** Ц.Арвинбуудайг Улсын Ерөнхий прокурорын газрын Тамгын газрын даргаар томилов.

**5 сарын 5.** Улсын Ерөнхий прокурорын тушаалаар Сургалтын төвийн чиг үүргийг шинэчлэн баталсан бөгөөд Сургалт, судалгааны төв нэртэйгээр захирал, сургалтын менежер, сургагч багш - хяналтын прокурор 3, үйлчилгээний ажилтан 12, нийт 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагааг нь өргөжүүлэв.

**6 сарын 2.** Улсын Ерөнхий прокурорын тушаалаар прокурорын байгууллагын дэргэдэх Ахмадын холбоо байгуулагдав.

**6 сарын 4.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн 85 дугаар зарлигаар Прокурорын ёс зүйн зөвлөл, Мэргэжлийн зөвлөлийн ажиллах журамд нэмэлт оруулав.

## ДҮҮРГИЙГ ХУУЧИН ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЭВ

2013 онд байгуулагдсан Дүүргийн 1, 2, 3, 4 дүгээр прокурорын газруудын дээд шатны прокурор нь байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдоос гаргасан гомдол, хүсэлтийг хуульд заасан хугацаанд хянан үзэх, хуулийн хугацаанд хариу өгөх, түүнчлэн дэд бүтэц, газар нутгийн хол ойроос хамааран гомдол, хүсэлт гаргах, хариу авах ажиллагаанд нь сөргөөр нөлөөлж байсан тул бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарсан байна. Ингээд дээрх прокурорын газруудыг Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул, Налайх, Багахангай, Багануур дүүргийн прокурорын газар болгох, дүүргийнхээ нутаг дэвсгэрийг хариуцан, хуучин тогтолцоогоор нь ажиллуулах саналыг Улсын Ерөнхий прокурор танилцуулсны дагуу УИХ-ын 7 дугаар сарын 2-ны 65 дугаар тогтоолоор ёсоор болгон батлагджээ.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 07 сарын 02 өдөр Дугаар 65 Төрийн ордон, Улаанбаатар хот

Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай

Прокурорын байгууллагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймаг, нийслэлийн прокурорын газар, дагнасан прокурорын газар, дүүрэг, сум дундын прокурорын газрыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан "Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 1993 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 59 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД

ын архив
Бүртгэлийн №16
ХУУЛБАР ҮНЭН

# 2015

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР МАГВАННОРОВЫН ЭНХ-АМГАЛАН



Монгол Улсын Ерөнхий прокуророор 2015-2019 онд томилогдон ажилласан М.Энх-Амгалан Улаанбаатар хотод 1963 онд төржээ. Тэрбээр 1982-1987 онд ЗХУ-ын Мөрдөн байцаах дээд сургууль, 2003 онд ОХУ-ын МКСВУЗ-д хууль зүйн магистрын зэргийг хамгаалжээ.

М.Энх-Амгалан 1987-1988 онд Хөвсгөл аймгийн Цагдан сэргийлэх ангийн мөрдөн байцаагч, 1988-1991 онд Улаанбаатар төмөр замын Цагдан сэргийлэх ангийн мөрдөн байцаагч, 1991-2008 онд Улсын Мөрдөн байцаах газарт ахлах мөрдөн байцаагч, хэлтсийн дарга, газрын дарга, 2008-2012 онд Цагдаагийн Ерөнхий газарт дэд дарга, 2015-2019 онд Монгол Улсын Ерөнхий прокуророор томилогдон ажиллажээ. Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх цолтой.

## БИТҮҮМЖЛЭЛТ, ХОХИРОЛ ТӨЛҮҮЛЭЛТ НЭМЭГДЭВ

2015 онд 11391 хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн нь өмнөх оныхоос 21 хувиар буурчээ.

Түдгэлзүүлсэн хэргийн 11044 хэрэг буюу 97 хувийг яллагдагчаар татагдвал зохих этгээд тогтоогдоогүй, 208 хэрэг буюу 2 хувийг сэжигтэн, яллагдагч оргон зайлсан, эсхүл байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа үндэслэлээр, 119 хэрэг буюу 1 хувийг зайлшгүй шаардлагатай гэрч, хохирогч байхгүй үндэслэлээр тус тус түдгэлзүүлжээ.

Прокурор 13560 даалгавар бичсэнээс 8645 буюу 64 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байгаа хэрэгт бичсэн нь өмнөх оноос нийт бичсэн даалгавар 1.0 хувиар өсч, ажиллагааны явцад бичсэн даалгавар 2.0 хувиар буурсан байна. Прокурор эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд 12095 удаа, үүнээс хэргийн газрын үзлэгт 2814 удаа оролцсон байна. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад бусдын зөрчигдсөн эрхийг хамгаалах, хохирлыг төлүүлэх, торгох болон эд хөрөнгө хураах ялын биелэлтийг хангуулах зорилгоор 160986.04 сая төгрөгийн эд хөрөнгө битүүмжилж, 353224.15 сая төгрөгийн хохирол төлүүлэх арга хэмжээ авч ажиллажээ. Энэ нь өмнөх оноос битүүмжилсэн эд хөрөнгийн хэмжээ 14.5 дахин их, хохирол төлүүлэлт 2.5 дахин нэмэгджээ.

# 2015

6 сарын 4. Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Франц Улсын Шүүх яамны харьяа Магистратурын үндэсний сургуульстай “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулав.

6 сарын 8. Засгийн газраас жил бүрийн 8 дугаар сарын 14-ний өдрийг “Прокурорын албаны өдөр” болгон тэмдэглэж байх тухай тогтоол гаргав.

7 сарын 2. Улсын Их Хурлын 65 дугаар тогтоолоор Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэн батлагдав.

7 сарын 10. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Прокурорын байгууллагын бэлгэдэл, прокурорын дүрэмт хувцасны таних тэмдэг, загварыг шинэчлэн батлуулав.

8 сарын 14. Засгийн газрын тогтоолын дагуу прокурорын байгууллагын түүхт 85 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэв.

10 сарын 6. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар “Прокурорын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр” батлагдсан байна.

## УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАРТ ШИНЭ ХЭЛТСҮҮД БИЙ БОЛГОВ

Улсын Ерөнхий прокурорын А/22 дугаар тушаалаар Улсын Ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцэд зарим өөрчлөлт хийж, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн чиг үүргээс шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс прокурор оролцох чиг үүргийг салгаж, улсын яллагч нарыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийг, Прокурорын байгууллагын үйл ажиллагаа, удирдамжийн баримт бичгийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, цахим мэдээллийн систем, мэдээлэл дамжуулах сүлжээний ажиллагаа, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, харьяа прокурорын газруудын удирдлага, зохион байгуулалтын ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах чиг үүрэг бүхий Дүн шинжилгээ, судалгаа, хяналт шалгалтын хэлтсийг тус тус шинээр байгуулан ажиллуулав.

## Е.САГСАЙ: ДҮҮРЭГ ДУНДЫН ТОГТОЛЦОО ЗӨВ ГЭХЭД ЭРГЭЛЗДЭГ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан шүүх эрх мэдлийн шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд шүүхийн байгууллага, үйл ажиллагааны тухай иж бүрэн багц хууль батлагдаж тогтолцооны хувьд өөрчлөлт орсон. Тойрог дундын, дүүрэг дундын гэх мэтээр шүүх байгуулагдсан. Үүнийг дагаад прокурорын байгууллага тодорхой хугацаанд бүтэцдээ өөрчлөлт хийсэн. Дүүрэг дундын прокурорын байгууллага байгуулж үзсэн. Зарим аймаг, сумын прокурорыг өөр аймаг, суманд шилжүүлсэн. Хүссэн ч, эс хүссэн ч шүүхийн тогтолцоог прокурор дагахаас өөр арга байхгүй.

Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлт гарч аймаг дундын давж заалдах шатны, дүүрэг дундын шүүх байгуулсныг буруу гэж үзлээ. Үүнийг Үндсэн хуульд нийцүүлж буцаан засах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргасан. Үүний дагуу манай

# 2015

прокурорын байгууллага хуучин буюу Засаг захиргаа нутаг дэвсгэрийн зарчмаар ажилладаг бүтэц зохион байгуулалтдаа орсон. Одоо дүүрэг, аймаг болгон прокурорын газартай, сум дундын прокурорын газар нь хэдэн сумаа хариуцаад орон нутагт байна. Ер нь шүүх прокурор аль аль нь ойр, нутаг дэвсгэр нь тодорхой байж хүн амдаа үйлчлэх үйлчилгээ нь ойртвол тэр хэрээр үйлчилгээ сайжирна гэж ойлгодог. Жишээ нь, цагдаагийнхан л гэхэд нэг дүүрэгт хэд хэдэн Цагдаагийн хэлтэс байгуулаад хүн амтайгаа улам ойртоод байгаа шүү дээ. Энэ тохиолдолд шүүх прокурор хоёр нь гурван дүүргийн дунд нэг болоод холдоод байж болохгүй. Тиймээс миний хувьд шүүх эрх мэдлийн хүрээнд хийсэн тогтолцоо зөв байсан гэхэд эргэлздэг.

*Прокурор Е.Сагсайгийн дурдатгалаас*

## СҮХБААТАРЫН ОДОНТ ЕРӨӨЛТИЙН САГСАЙ



Е.Сагсай МУИС-ийг 1983 онд төгсчээ. Тэрбээр 1983-1993 онд Баян-Өлгий аймгийн прокурорын газарт туслах прокурор, орлогч прокурор, 1994-1999 онд УЕПГ-т хяналтын прокурор, газрын дарга, 1999-2002 онд Баянзүрх дүүргийн прокурорын газрын ахлах прокурор, 2003-2012 онд Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокурор, орлогч прокурор, 2013 онд Сүхбаатар дүүргийн прокурор, 2014-2017 онд УЕПГ-ын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, 2017 оноос МҮИС-ийн ХЗУС-д зөвлөх багшаар ажиллаж байна.

Эрүү, Эрүүгийн процесс, прокурорын хяналт, ял эдлүүлэх эрх зүй, гэмт хэргийн зүйлчлэлийн онолоор мэргэшсэн Е.Сагсай 2015 онд Сүхбаатарын одонгоор шагнагджээ.


-Алдрын танхимыг байгуулж, тохижуулав.

-Прокурорын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан Ерөөлтийн Сагсайг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Сүхбаатарын одонгоор шагнав.

-Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалан Нийслэлийн прокурорын газрын ажилтай танилцав.

-Б.Амгаланбаатар Нийслэлийн, Г.Бат-Очир Дүүргийн 1 дүгээр прокурорын газрын, Д.Отгонбаяр Дүүргийн 2 дугаар прокурорын газрын, Ня.Энхтуяа Баянгол, О.Алтангэрэл Баянзүрх, Г.Бат-Очир Сүхбаатар, Д.Отгонбаяр Сонгинохайрхан, Л.Бадралт Чингэлтэй, Б.Пүрэвжав Багануур, Н.Найгалдорж Налайх, Багахангай, Ү.Содномцог Хан-Уул дүүргийн, Т.Ууганбаатар Дорнод, Н.Ганболд Хөвсгөл, Г.Эрдэнэбаатар Орхон, Ж.Мөнхжаргал Сэлэнгэ, Ж.Уранцэцэг Баянхонгор аймгийн прокуророор тус тус томилогдлоо.

# 2015



Монгол Улсын Ерөнхий прокурорын газар Вьетнам Улсын Ардын Дээд прокурорын газар хоорондын хамтран ажиллах хөтөлбөрт гарын үсэг зурах ёслолын үеэр, 2015 он



БНСУ-ын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Эрх зүйн институтэд суралцсан прокурорууд, 2015 он



Прокурорын байгууллагын гурван үеийн уулзалтад оролцсон прокурорууд, 2015 он

# 2015

## МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ ЖИГЖИДИЙН ГОМБОДОРЖ



Ж.Гомбодорж Архангай аймгийн Хотонт суманд 1924 онд төржээ. Тэрбээр Хууль цаазын дунд сургууль, МУИС-ийн хуулийн ангийг төгсчээ.

Ж.Гомбодорж 1955 оноос Архангай аймгийн прокурорын газарт туслах прокурор, Дорноговь аймгийн прокурор, Улсын прокурорын газрын Шалган зааварлах хэлтсийн анхны даргаар томилогдож арав гаруй жил ажиллажээ.

Тэрбээр 1974-1988 онд Улаанбаатар хотын прокуророор ажиллаж нийслэл хотынхоо прокурорын нэр хүндтэй албыг хашсан байна. Прокурорын байгууллагын 85 жилийн ойгоор түүнд Монгол Улсын гавьяат хуульч цол олгожээ.


## ПРОКУРОРЫН АЛБАНЫ ӨДӨРТЭЙ БОЛОВ

Байгууллагынхаа түүхэн замнал, үе үеийн ахмадуудынхаа алдар гавьяа, ажил үйлсийг эргэн дурсах, мөнхжүүлэх, алдаршуулах, өнөөгийн прокурор, ажилтнуудад үлгэр дууриалал болгох, өвлүүлэх, прокурорын байгууллагыг хөгжүүлэх, бэхжүүлэхийн төлөө хүчин зүтгэж байсан ахмадууддаа хүндэтгэл үзүүлэх, ахмад, залуу үеийнхний холбоог бэхжүүлэх, тэдэнд байгууллагынхаа туулж өнгөрүүлсэн түүх, гавьяа, ажил үйлсээр омогших, бахархах сэтгэгдлийг үлдээх зорилгоор жил бүрийн 8 дугаар сарын 14-ний өдрийг “Прокурорын албаны өдөр” болгон тэмдэглэж байх зорилгоор Монгол Улсын Засгийн газарт асуудал оруулж, Засгийн газрын 6 дугаар сарын 8-ны өдрийн 221 дугаар тогтоолоор шийдвэрлүүлжээ.

## ТООНЫ ХЭЛЭЭР

Прокурорын байгууллага захиргааны зөрчлийн талаар иргэд, байгууллагаас гаргасан 168 гомдол, хүсэлт хүлээн авч, захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан 47446 материал хянаснаас үндэслэлгүйгээр захиргааны арга хэмжээ авсан 182 шийтгэврийг хүчингүй болгож, 441 шийтгэвэрт өөрчлөлт оруулжээ. Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаанд тавих хяналтын чиглэлээр 318 удаа шалгалт хийж, 3568 зөрчил илрүүлж, 236 хүний зөрчигдсөн эрхийг сэргээж, зөрчил гаргасан 49 албан тушаалтанд арга хэмжээ авахуулж, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар прокурорын 125 шаардлага бичсэн байна.

# 2015



Тайландын Вант Улсын Ерөнхий прокурор, Монгол Улсын Ерөнхий прокурорууд харилцан айлчлал хийж, хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав. 2015 он



УИХ-ын гишүүн Ц.Оюунбаатар прокурорын байгууллагын ахмадуудтай, 2015 он

# 2016

## СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР АМЬДРАЛД ХЭРЭГЖИВ

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн А/03 дугаар тушаалаар “Прокурорын сургалтын хөтөлбөр”-ийг баталжээ. Хөтөлбөрийн дагуу Сургалт, судалгааны төвөөс 2015-2017 онд прокурорын анхан шатны, үргэлжилсэн шатны, туслах ажилтны сургалтуудыг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж, 800 орчим прокурор, ажилтнуудыг хамруулжээ. Мөн Монголын Хуульчдын холбоотой хамтран 21 аймагт зохион байгуулсан сургалтад 526 хуульчийн гэрчилгээ бүхий прокурор, ажилтнуудыг хамруулж сертификат олгосон байна.

Анхан шатны сургалтаар шинэ залуу прокуроруудын мэргэжлийн ур чадвар, онол, практикийн мэдлэгийг дээшлүүлэх, чадавхижуулахад чиглэсэн “Төрийн албан хэрэг хөтлөлтийн чанар, стандарт, архивын үйл ажиллагаа”, “Шинэ төрлийн гэмт хэргийг хянах аргачлал, “Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн зүйлчлэл, хянах аргачлал”, “Шүүх, ДНК, криминалистик, санхүүгийн шинжилгээ”, “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрх”, “Төрийн албаны зарчим, албан хэрэг хөтлөлт”, “Илтгэх ур чадвар”, “Прокурор нотлох баримтад тулгуурлан мэтгэлцэх онцлог” зэрэг нийт 41 сэдвээр нийт 246 цагийн танхимын, 36 цагийн дадлага хичээл явуулж, сургалтыг дадлага туршлагатай прокуроруудболон хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын эрдэмтэн, судлаачдаар явуулсан нь үр өгөөжтэй болжээ.

## ЖАРАН ТЭРБУМЫН ГЭХ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАЖ ЭХЛЭВ

2016 оны УИХ-ын ээлжит сонгуулийн үеэр 60 тэрбумын гэх бичлэг цацагдаж, шуугиан тарив. Улс төрийн намын удирдах шатны хүмүүс төрийн албыг наймаалцаж, 60 тэрбум төгрөг босгосон гэх асуудлаар нэр бүхий хүмүүсээс хууль хяналтын байгууллагад ханджээ. Үүний дагуу УЕПГ-аас тухайн асуудалд эрүүгийн хэрэг нээж, АТГ, ЦЕГ, ТЕГ-ын хамтарсан ажлын хэсгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах

**1 сарын 4.** Улсын Ерөнхий прокурорын А/03 тоот тушаалаар “Прокурорын байгууллагын сургалтын хөтөлбөр” батлагджээ.

**1 сарын 20.** Улсын Ерөнхий прокурорын А/07 тушаалаар Аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын ажилд дүн шинжилгээ хийх аргачилсан заавар, шалгуур үзүүлэлтийг баталжээ.

**3 сарын 27.** Улсын Ерөнхий прокурорын орлогч Г.Эрдэнэбат, туслах прокурор Г.Ганзориг нар АНУ-ын Техас мужид айлчлав.

**4 сарын 4.** Улсын Ерөнхий прокурорын А/27 тоот тушаалаар “Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгах, дүгнэх журам”-ыг баталжээ.

**6 сарын 28.** “Монгол Улс дахь жендерт суурилсан хучирхийлэлтэй тэмцэх, хууль зүйн салбарын чадавхийг бэхжүүлэх” төслийг Улсын Ерөнхий прокурорын газар хамтран хэрэгжүүлжээ.

**10 сард.** Эрүүгийн хэргийн төв архивын барилга ашиглалтад орж, төв архивт хадгалагдаж байсан 90509 баримтыг нүүлгэн шилжүүлэв.

# 2016

**10 сарын 18.** Улсын Ерөнхий прокурорын туслах, Гадаад харилцаа эрх зүйн туслалцааны хэлтсийн дарга Г.Ганзориг Олон Улсын Эрх зүйн их хуралд оролцов.

**11 сарын 10.** Улсын Их Хурлын 65 дугаар тогтоолоор прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоов.

**12 сарын 2.** Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн, ажиглагч улс орнуудын Ерөнхий прокуроруудын 14 дэх удаагийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалан тэргүүтэй прокурорууд оролцлоо.

**12 сарын 28.** Улсын Ерөнхий прокурорын орлогч Ц.Бямбацогтыг үүрэгт ажлаас чөлөөлж, Нийслэлийн прокурор Б.Амгаланбаатарыг УЕП-ын орлогчоор томилов.

-УЕПГ-аас Завхан, Говь-Алтай, Архангай, Хөвсгөл, Дорноговь аймаг, Тээврийн прокурорын газруудад иж бүрэн шалган туслах ажлыг зохион байгуулж, дүнг Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

тогтоол гарч шалгасан байна. Энэ хэрэгт Нийслэлийн прокурорын газраас хяналт тавин ажилласан юм. Мөрдөн байцаалтын ажиллагаагаар АТГ-ын Урьдчилан сэргийлэх, Соён гэгээрүүлэх хэлтсээс гаргасан албан тушаалтнуудын судалгааг үндэслэн 2016 оны сонгуулийн үр дүнгээс хойш төрийн өндөр албан тушаалд болон яам, агентлаг, нийслэл, дүүрэг, аймгийн төрийн захиргааны байгууллагад мэргэжилтнээс дээгүүр албан тушаалд дэвшин томилогдсон хүмүүс болон Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Мэдээллийн технологийн төвийн программ хангамжийн IT инженерүүд, МАН-аас Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлсэн санхүүжилтийн талаарх тайлан, МАН-ын дарга М.Энхболд, Нийслэлийн МАН-ын дарга асан Ц.Сандуй, иргэн А.Ганбаатар, Г.Доржзодов гэхчлэн нийт 1500 орчим хүнээс тайлбар, мэдүүлэг авсан байна.

## М.ЭНХ-АМГАЛАН: ШҮҮХИЙН ШИНЭТГЭЛД ПРОКУРОРЫН ОРОЛЦОО ЧУХАЛ

Яг үнэндээ гэмт хэрэгтэй тэмцэх ажилд прокурорын үүрэг, эрэлт хэрэгцээ маш их болж байна. Яагаад гэвэл УИХ-аас гарч байгаа хуулиуд олон салаа утгатай, хэрэгжүүлэхэд их төвөгтэй, яг яаж хэрэгжүүлэх вэ гэдэг процесс нь заагдаагүй. Гэтэл хуулиа хэрэгжүүлэх шаардлагатай болоод байдаг. Хэрэгжүүлэгч талууд нь өөр өөрсдийнхөө утгаар тайлбарлаж, хэрэглэх гээд байдаг. Тэгэхээр иргэдийн маань эрх, эрх чөлөө эрсдэлд орчихоод байгаа юм. Ийм үед л прокурорын хариуцлага маш чухал байна. Прокурорын ажил юугаараа их амаргүй байдаг вэ гэхээр нэг талаас хуулийг нэг мөр хэрэгжүүлэгч нөгөө талаас хүний эрх, эрх чөлөөг хангагч байх ёстой. Эрх, эрх чөлөөг хамгаалж байна гээд хуулийн хариуцлагаас зугатаалгаад байж бас болохгүй. Мөн хуулийн хариуцлага ногдуулж байна гээд хүний эрх чөлөөг буруу аргаар хөндөөд байж болохгүй. Тэгэхээр нарийн торгон үзүүр дээр прокурор яваад байгаа юм л даа. Тиймээс тун амаргүй ажил. Би шүүхийн шинэтгэлд прокурорын оролцоо л чухал гэж боддог. Ямар ч сайн шүүх байгууллаа гэсэн хэрэглэж байгаа хуулийг нь оролцогч талууд өөр өөрийнхөөрөө тайлбарлаад байдаг.

*Хэвлэлд өгсөн ярилцлагаас*

# 2016

## БАЯРААГИЙН АМГАЛАНБААТАР



Б.Амгаланбаатар Улаанбаатар хотод 1972 онд төржээ. Тэрбээр 1990-1994 онд Цагдаагийн дээд сургууль, 2007-2008 онд МҮДСургууль, 2012-2013 онд Удирдлагын академид тус тус суралцан төгсчээ.

Б.Амгаланбаатар 1993-1997 онд Баянгол дүүргийн мөрдөн байцаах тасагт мөрдөн байцаагч, 1997-2002 онд ахлах мөрдөн байцаагч, 2002-2007 онд Сонгино хайрхан дүүргийн цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгийн дарга, 2007-2008 онд Улсын мөрдөн байцаах газарт хэлтсийн дарга, 2008-2012 онд ЦЕГ-т хэлтсийн дарга, 2012-2014 онд Чингэлтэй дүүргийн Цагдан сэргийлэх хэлтсийн дарга, 2014-2015 онд Нийслэлийн цагдаагийн газрын дэд дарга, 2015-2016 онд Нийслэлийн прокурор, 2016-2019 онд Улсын Ерөнхий прокурорын орлогчоор ажиллажээ.

## ТООНЫ ХЭЛЭЭР

Прокурорын байгууллага энэ онд гэмт хэргийн талаархи 99454 гомдол, мэдээлэлд хяналт тавьснаас 30 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэж, 66 хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэжээ. 2015 онтой харьцуулахад гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл 2617 буюу 2 хувь, эрүүгийн хэрэг үүсгэсэн хэрэг 1530 буюу 5 хувиар тус тус буурч, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан шийдвэр 150 буюу 0.2 хувиар өссөн байна. Түүнчлэн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан нийт 41408 эрүүгийн хэрэгт хяналт тавьж ажилласан нь 2015 оноос 4603 буюу 10 хувиар буурсан байна.

-Прокурорын байгууллагын тухай хуулийн дагуу прокуроруудын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж, шалгалтад хамрагдсан 396 прокурорт үнэлэлт өгөв.

-“Цахим нэгтгэл” төслийн хүрээнд шүүх, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудтай нэгдсэн сүлжээнд холбогдож, бүртгэлийн системийн нэгдсэн санг бүрдүүлэв.

-Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа анги, байгууллагын ажилтай танилцав.

-Олон улсын хуулийн конгресс-д Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн дарга Г.Ганзориг оролцож, илтгэл тавьжээ.

-Г.Эрдэнэбаяр Увс, Н.Ганбаатар Завхан, Б.Ганбаатар Говь-Алтай, Н.Доржсүрэн Ховд, Ш.Дамдинбазар Өвөрхангай, С.Гансэлэм Дундговь, Г.Лхагвасүрэн Булган аймгийн прокуророор, Ц.Ариунболд Налайх, Багахангай дүүргийн прокуророор тус тус томилогдлоо.

# 2016




“Прокурорын байгууллагын ил тод байдлыг дэмжих нь” төслийг хэрэгжүүлэхээр
Азийн сантай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав. 2016 он



2012 оны төгсгөлөөр шаваа тавьж, барилгын ажлаа эхлүүлсэн
Эрүүгийн хэргийн төв архивын барилга ашиглалтад оров.

# 2017

## ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ПРОКУРОРУУД СУРГАЛТАД ХАМРАГДАВ

Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх сургалт, судалгааны төвөөс 571.5 цагийн сургалтад 7901 прокурорын байгууллагын прокурор, ажилтнуудыг хамруулжээ. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд нийт 15 эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл, 16 удаагийн илтгэл хэлэлцүүлж, хуулийн төсөл боловсруулах, төсөлд санал өгөх зэрэг цаг үеийн шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Түүнчлэн Монгол Улсын Их хурлаас хэлэлцэгдэн батлагдсан Прокурорын тухай хуулийн хэлэлцүүлгийг ХЗДХЯ, Монголын Хуульчдын Холбоотой хамтран зохион байгуулжээ.

Олон Улсын хөгжлийн эрх зүйн байгууллага-IDLO, АНУ-ын Төрийн департаментийн дэргэдэх Олон улсын мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах Товчооны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх хууль зүйн салбарын чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд 6 сургагч багш бэлтгэж, Орхон, Дархан-Уул, Булган, Сэлэнгэ аймгийн хяналтын прокурор 25, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр бүх нэгжийн прокуроруудыг тус тус сургалтад хамруулжээ.

## ЗӨРЧЛИЙН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЛЭХЭД АЛБАН ТУШААЛТНУУД ДУРГҮЙ БАЙВ

Долдугаар сарын 1-нээс Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль хэрэгжиж эхлэв. Үүнтэй холбоотойгоор прокуророуд шинэ хуулиудыг зөв хэрэгжүүлэх асуудлаар сургалт явуулах, чиглэл, зөвлөмж өгөх, зааварлах асуудал байнга гарч байв.

Зөрчлийн хууль хэрэгжиж эхэлсний дараа эрх бүхий албан тушаалтнууд прокурорын хяналтад дуртай байсангүй. Зөрчил мөн эсэх, ямар баримтуудаар нотлогдож байгаа, шийтгэл нь хууль зүйн үндэслэлтэй эсэх зэрэгт хэн ч

**2 сарын 7.** Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалан Куба Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Раул Делгадо Консепсион, БНСУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд У Сун нарыг хүлээн авч уулзлаа.

**2 сарын 14.** УЕПГ-ын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн дарга Г.Ганзориг тэргүүтэй 20 прокурор Турк улсад сургалтад оролцов.

**3 сарын 6.** Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалт, судалгааны төв, БНХАУ-ын Ардын Дээд прокурорын газрын Прокуроруудын Үндэсний коллежийн хооронд харилцан ойлголцлын Санамж бичгийг үйлдлээ.

**5 сарын 9.** АНУ-ын Техасын их сургуулийн хуулийн сургуулийн профессор, шүүгч Жое Спурлок, шүүгч хуульч Мэттью Райт нарын сургалтад Архангай, Баянхонгор, Өвөрхангай болон Хархорин сум дахь сум дундын прокуророуд оролцжээ.

**6 сарын 9.** Монгол Улсын Их Хурлаас шинэчлэн найруулагдсан Прокурорын тухай хуулийг батлав.

# 2017

7 сарын 3. Монгол Улсын Их Хурлаар батлагдаж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдсөн шинэчлэн найруулагдсан Прокурорын тухай хуулийн эх бичвэрийг хүлээн авах ёслол болов.

9 сард. Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт прокурорын байгууллагын Сургалт, амралтын төв ашиглалтад оров

12 сарын 21. Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалан Бүгд Найрамдах Турк Улсад айлчлал хийлээ.

-Монгол Улсын Ерөнхийлөгчид Прокурорын байгууллагын үйл ажиллагааны талаар танилцуулга хүргүүлэв.

-Прокурорын байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, шат шатны прокуроруудтай үр дүнгийн гэрээ байгуулав.

-УЕПГ-аас харьяа газруудын ажлыг шалган туслах ажлын хүрээнд Нийслэл, Баянзүрх, Налайх-Багахангай дүүрэг, Сэлэнгэ, Ховд аймгийн прокурорын газруудад иж бүрэн шалган туслах ажлыг зохион байгуулж, дүнг Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

шүүмжлэлтэй ханддаггүй, иргэд маань ч өөрсдийнх нь эрхэнд хуулийн хүрээнд халдаж байгаа эсэхэд анхаарал хандуулдаггүй, танил талаараа дамжуулан торгуулийн хэмжээг жаахан багасгаад л боллоо гэж боддог “монгол зан”-гаараа хандаж ирсэн энэ харилцааг хуулийн хүрээнд явуулахыг шаардаад эхлэхээр албан тушаалтнууд дургүйцэж, прокурорын хяналтыг “ажлын садаа” гэж эсэргүүцэж байсан нь нууц биш.

Зөрчлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр прокуроруудын ажлын ачаалал маш их болжээ. Гэсэн ч олон жилийн түүхтэй, шаардлага өндөртэй, хариуцлага ихтэй, ажлаа амжуулаад сурчихсан хамт олон тул үүнд тэгтэл түүртээгүй.

## АМИА ХОРЛОХ ТОХИОЛДЛЫН АНХНЫ СУУРЬ СУДАЛГААГ ТАНИЛЦУУЛАВ




УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн захирал, хууль зүйн ухааны доктор М.Гантулга, хяналтын прокурор, хууль зүйн ухааны доктор Б.Өнөрмаа нар мэдээллийн үеэр, 2017 он

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын Сургалт, судалгааны төвөөс “Монгол улсын хүн амын дундах амиа хорлох тохиолдол”-ын нөхцөл шалтгаан, нийгэм эдийн засаг, гэр бүлийн нөлөөлөл, сэтгэл зүйн талаас тогтоох, тархалтыг газар зүйн байрлаар тодорхойлох, “бусдыг амиа хорлоход хүргэх” гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтад дүгнэлт хийх, шүүхээс дээрх төрлийн гэмт хэргийг шийдвэрлэж буй практиктийг судлах зорилгоор

# 2017

анхны суурь судалгааг хийжээ. Судалгааны дүнг танилцуулах хэвлэлийн хуралд Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалт, судалгааны төвийн захирал, хууль зүйн ухааны доктор М.Гантулга, Судалгааны багийн удирдагч, Сургалт, судалгааны төвийн, судлаач, хяналтын прокурор, Хууль зүйн ухааны доктор Б.Өнөрмаа оролцов. Монгол Улсад 2012-2016 онд амиа хорлосон тохиолдлыг судалсан судалгааны онцлог нь сүүлийн 5 жилд Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 95 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан бүх эрүүгийн хэргээс амиа хорлосон 2055 эрүүгийн хэрэг тус бүр дээр асуулт бөглөж үр дүнг нэгтгэсэн бөгөөд суурь судалгааны явцад гарсан үр дүнг бататгах зорилгоор санамсаргүй түүврийн аргаар 400 эрүүгийн хэрэг уншиж хэрэг тус бүр дээр дүгнэлт гаргасан байна.

## Г.ЭРДЭНЭБАТ: БИД ДЭЛХИЙН УЛСААС НЭГ ЗҮЙЛ ДЭЭР ХОЦОРЧ ЯВНА

АТГ байгуулагдсаны 10 жилийн ойгоор “Авлигын эсрэг үндэсний чуулган”-ыг зохион байгуулав. Чуулганд Улсын Ерөнхий прокурорын орлогч, төрийн хууль цаазын шадар зөвлөх Г.Эрдэнэбат “Авлигатай тэмцэх олон талт хамтын ажиллагаа” сэдвээр илтгэл тавив. Тэрээр “Алдагдсан хөрөнгийг эргүүлэн авахад учирдаг хамгийн том бэрхшээл бол Монгол Улсын хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын мэдээлэлгүй байдал. Өнгөцхөн жишээ хэлье, “Танай улсын аль нэг банкинд ийм хүний хөрөнгө байгаа сурагтай. Олж өгөөч” гэсэн хүсэлтийг манай улс явуулдаг. Гадаад улсаас нь “Аль банкны ямар дансанд хэдий хэмжээний хөрөнгө байгаа мэдээлэл хүсч байгаагаа тодорхой ирүүл. Тэгвэл бид биелүүлээд өгье” гэсэн хариу ирдэг. Бид гайхдаг. “Хаана нь байгааг бид яаж мэдэх вэ” гэж гайхдаг. Тэр улсаас нь хариу ирдэг, “Бид 127 банктай. Нэг хүний нэрээр хөрөнгө хайж чадахгүй ээ” гэж. Гэтэл бид дэлхийн улсаас нэг зүйл дээр хоцорч явна. Аль хэдийнэ дэлхийн улсуудын хууль сахиулах байгууллагууд хамтран мэдээлэл солилцдог болсон. Тэр мэдээлэлдээ тулгуурлан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх асуудал руугаа ордог жишиг рүү орчихсон байна. Өөрөөр хэлбэл, хууль сахиулах

-“E-prokurog” системийн хэрэглэгчдэд гарын авлага бэлтгэснээс гадна холбогдох хичээлүүдийг програмд оруулав.

-Шинээр хэрэгжиж эхэлсэн хуулиудад нийцүүлэн прокурорын цахим бүртгэлийн системийн шинэчлэлт хийв.

-Нийт прокурорууд шинэчлэгдэн батлагдсан тангарагаа өргөв.

-БНХАУ-ын Ардын Дээд прокурорын газрын Прокурорууудын Үндэсний коллеж хоорондын хамтын ажиллагааны санамж бичиг, Монголын Прокурорууудын Үндэсний холбоо, Тайваний Хууль зүйн академи хооронд хамтран ажиллах тухай санамж бичиг тус тус байгуулав.

-Д.Баярмагнай Нийслэлийн прокуророор, Ц.Мөнхбат Дархан-Уул, С.Батсүрэн Говьсүмбэр, Б.Одгэрэл Хэнтий, О.Мөнхбаатар Сүхбаатар аймгийн, Д.Булганцэцэг Чингэлтэй, Ц.Батболд Хан-Уул дүүргийн, Үүсодномцог Тээврийн, прокурорын газрын ерөнхий прокуророор тус тус томилогдлоо.

# 2017

байгууллагууд хоорондоо мэдээллээ солилцож, мөрдөж байгаа гэмт хэрэгтэйгээ холбоотой мэдээллийг олж авах талаараа хамтарч ажиллачихаад эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх шат руугаа ордог. Бид эрүүгийн хэрэгт эрх зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хөндөж тавихаасаа өмнө шаардлагатай мэдээллээ хууль сахиулах байгууллагын төвшинд солилцон авдаг дэг журам, арга барилдаа шилжих хэрэгтэй байна.

## ОРЛОГО БОЛГОХ УУ, ХҮЛЭЭЛГЭЖ ӨГӨХ ҮҮ...

Улсын Ерөнхий прокуророос холбогдох төрийн байгууллагуудад хүсэлт гаргав. Монгол Улсын нэгдэж орсон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцийн тавдугаар зүйлд, “Авлига бол үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг мөн” гэж тодорхойлсон байдаг. Түүнчлэн “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн замаар олдсон хөрөнгийг хэрэг шийдвэрлэж байгаа улс өөрийнхөө хуулийн дагуу шийднэ” гэж заасан. Өөрөөр хэлбэл, ямар улсад хөрөнгө байна, аль улс энэ гэмт хэргийг илрүүлнэ, тэр улс хурааж аваад өөрийн орлого болгодог аж. Монгол Улс энэ конвенцод 2002 онд элсч орсон. Харин НҮБ-ын өөр нэг конвенци болох Авлигын эсрэг конвенцид, “Алдагдсан хөрөнгийн өмчлөгч улс нь хөрөнгийг эргүүлж авах эрхтэй” тухай заасан байдаг аж.

Монгол Улсаас алдагдсан хөрөнгө АНУ ч юм уу өөр улсад илэрсэн бол Монгол Улсад эргүүлэн өгөх тухай заасан. Үүнтэй адил Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гэмт хэргийн шинжтэй хөрөнгө олдвол конвенцийн дагуу хүлээлгэн өгөх үүрэгтэй хэр нь мөн л элсэн орсон бас нэг конвенцийнхоо дагуу улсын орлого болгох эрхтэй аж. Ийнхүү элсэн орсон олон улсын конвенцуудын тодорхойгүй, зөрүүтэй заалтыг шийдвэр гаргах төвшинд асуудал шийдэж өгөхийг хүсчээ.

*Улсын Ерөнхий прокурорын орлогч Г.Эрдэнэбатын хэвлэлд өгсөн ярилцлагаас*

## МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ХЭРГҮҮДИЙН СУДАЛГААГ ГАРГАЖЭЭ

Нийслэлийн прокурорын газраас “Нийслэл, дүүргийн прокурорын газрын хяналтанд 2014, 2015, 2016 он, 2017 оны эхний 2 сарын байдлаар Эрүүгийн хуулийн 188, 192, 193, 194, 195, 196 дугаар зүйлд заагдсан Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, тухайн гэмт хэрэг үйлдэгдэн гарсан шалтгаан нөхцөл”-ийг судлажээ.

2014 оноос хойш сүүлийн 3 жилийн хугацаанд прокуророос нийт 339 эрүүгийн хэрэгт хяналт тавьж ажилласнаас шүүхээр 41 хувийг шийдвэрлүүлсэн бол шүүх 235 хүнд ял оноосны дийлэнх буюу 63 хувьд 1-13 жил хүртэл хугацаагаар хорих, 32 хувьд баривчлах, 1.2 хувьд нь торгох ял оногдуулсан байна.

Дээр дурдсан судалгааны мөрөөр Нийслэлийн прокурорын газраас төр захиргааны байгууллага, ерөнхий боловсролын болон Их, дээд сургуулийн оюутан, сурагчдад энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, яриа таниулгыг зохион явуулахаар сургалтын материал, гарын авлагыг боловсруулан ажиллав.

# 2017

## “ПРОКУРОР-2017”, “ТУСЛАХ АЖИЛТАН-2017”

“Прокурор-2017”, “Туслах ажилтан -2017” мэргэжлийн уралдааны 2 дугаар шатны шалгаруулалт 2017 оны 12 дугаар сарын 6-8-ны өдрүүдэд болов. Уралдааны 1 дүгээр шатны шалгаруулалт Улс, аймаг, Нийслэл, Тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газруудын прокурор, ажилтнуудын дунд зохион байгуулагдсан бөгөөд тус шатанд байгууллага хамт олноосоо шалгарсан нийт 31 прокурор, 32 туслах ажилтан 2 дугаар шатны уралдаанд оролцсон юм.

“Прокурор 2017” мэргэжлийн уралдааны тэргүүн байрт Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Т.Оргил-Очир, хоёрдугаар байрт Говь-Алтай аймгийн прокурорын газрын хяналтын прокурор Б.Батнасан, гуравдугаар байрт Сүхбаатар дүүргийн прокуроын газрын хяналтын прокурор Б.Мөнх-Од нар шалгарав. Тусгай байрт Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор У.Солонго, Орхон аймгийн прокурорын газрын хяналтын прокурор Б.Бүжинлхам, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын прокурорын газрын хяналтын прокурор Э.Энхбат нар тус тус шалгарлаа.



УЕПГ-ын дэргэдэх Зөвлөлийн гишүүд мэргэжлийн уралдаанд оролцогчдын хамтаар, 2017 он

## ОФФШОРЫН АСУУДЛААР ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСЭГ ТОМИЛОВ

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс “Монгол Улсын төрийн албанд ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа нэр бүхий 23 иргэн оффшор бүсэд данс эзэмшдэг болох нь тогтоогдсон, ХАСХОМ-ын мэдүүлэгтээ оффшор бүс дэх дансны талаарх мэдээллээ тусгаж мэдүүлээгүй, өөрийн хөрөнгө, орлого их хэмжээгээр нэмэгдсэнийг хууль ёсны болохыг тайлбарлаж чадаагүй” гэх хэрэгт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж эхэлсэн байна. УЕПГ-аас Авлигатай тэмцэх

# 2017

газрын Мөрдөн шалгах хэлтэс, Цагдаагийн Ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны мөрдөгчдийн хамтарсан ажлын хэсэг томилсон тогтоол гаргаж, дээрх хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг хамтран явуулахыг даалгасан байна.

## СОЁЛЫН ҮНЭТ ӨВӨӨ БУЦААН АВЛАА

БНСУ руу хууль бусаар гаргасан үлэг гүрвэлийн олдворуудыг буцааж авахаар болов. Улсын Ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтэс Эрүүгийн хэргийн талаарх Монгол Улсын байгуулсан хоёр талт гэрээ, олон улсын гэрээ конвенцийг хариуцан хэрэгжүүлэх чиг үүрэгтэй. БНСУ-тай 1999 онд байгуулсан Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний дагуу Улсын Ерөнхий прокурорын газраас үлэг гүрвэлийн ховор олдвор, соёлын үнэт өвийг Монгол Улсад гэмт хэргийн эд мөрийн баримтаар буцаан авах хүсэлтийг хоёр жилийн өмнөөс Солонгосын талд тавьсан аж.

БНСУ-ын Сөүл хотын Дээд прокурорын газарт Монгол Улсын соёлын үнэт өвийг буцаан олгох уулзалт болж, Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайд Б.Ганболд, Ерөнхий прокурорын орлогч Г.Эрдэнэбат тэргүүтэй албаны хүмүүс, БНСУ-ын Улсын Ерөнхий прокурорын орлогч, Соёлын яамны ажилтнууд, хэвлэл мэдээллийнхэн оролцсон байдаг. Уйгагүй яриа хэлцэл хийж, хоёр жил гаруй хөөцөлдсөний үр дүнд, Монгол Улсын төдийгүй дэлхийн соёлын өвд багтах туйлын ховор олдворыг улсдаа шилжүүлэн авсан юм.





Улсын Ерөнхий прокурорын орлогч Г.Эрдэнэбат, УЕПГ-ын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн дарга Г.Ганзориг нар үлэг гүрвэлийн араг ясыг Монгол Улсад буцаан олгох ёслолын ажиллагаанд, 2017 он

# 2017



2017 оны 9 дүгээр сард Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт
прокурорын байгууллагын Сургалт, амралтын төв ашиглалтад оров



Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалт, судалгааны төв, БНХАУ-ын Ардын Дээд
прокурорын газрын Прокуроруудын Үндэсний коллежийн хооронд харилцан ойлголцлын
Санамж бичиг байгууллаа. 2017 он

# 2018

1 сарын 3. Улсын Ерөнхий прокурорын А/03 тоот тушаалаар УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн дэргэд Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэнг байгуулав.

1 сарын 31. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын 8 тоот зарлигаар “Прокурорын зэрэг дэв тогтоох, олгох журам”-ыг батлав.

1 сарын 31. Прокурорын байгууллагын бэлгэдэл, далбаа, дүрэмт хувцас, энгэрийн тэмдгийн загварууд, хэрэглэх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын 9 тоот зарлигаар батлав.

3 сарын 5. УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран зохион байгуулсан Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаархи уулзалт, хэлэлцүүлэг болов.

4 сарын 10. БНХАУ-ын Худалдааны яам, Үндэсний засаг захиргааны академитай хамтран Бээжинд болсон сургалтад Улсын Ерөнхий прокурорын газар түүний харьяа Нийслэл, аймаг, дүүрэг, сум дундын прокурорын газрын 24 прокурор хамрагдав.

## ОЮУТОЛГОЙ, ТАВАНТОЛГОЙН ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЭХЛЭВ

“Оюутолгой компани гэрээний заалтыг зөрчиж эрчим хүчээ БНХАУ-аас импортолж, Монгол Улсад хохирол учруулсан байж болзошгүй” гэх мэдээллийн мөрөөр хэрэг бүртгэлтийн хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаанд нь прокурорын зүгээс хяналт тавьжээ. Тодруулбал “...Монгол Улсын Засгийн газар болон “Айвенхоу Майнз Монголия Инк” ХХК, “Айвенхоу майнз лимитед” компани, “Рио Тинтоинтернэшнл холдингс лимитед” компани хооронд 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний 7.3-т зааснаар “Хөрөнгө оруулагч нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлснээс хойш дөрвөн жилийн дотор Оюутолгой төслийн эрчим хүчний нийт хэрэгцээгээ Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эх үүсвэрээс сонгон хангана” гэж тусгажээ. Гэтэл Монгол Улсын Засгийн газар 2014 онд Монгол Улсаас эрчим хүч авах үүргээ заавал биелүүлэх шаардлагагүй гэдгийг хүлээн зөвшөөрч, улмаар “Оюутолгой” компани эрчим хүчээ БНХАУ-аас импортолжээ. Мөн 2015 онд Монгол Улсын сайдаар ажиллаж байсан М.Энхсайхантай холбогдох “Таван толгойн ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээ”, “Ухаа-Худаг-Гашуун-Сухайтын чиглэлд төмөр замын суурь бүтэц барих-ашиглах-шилжүүлэх концессын гэрээ”-ний төслүүдтэй хамаарал бүхий мэдээллүүдийн мөрөөр Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс мөрдөн шалгах ажиллагаа явуулж, Нийслэлийн прокурорын газраас хяналт тавин ажиллаж эхэлжээ.

## УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Нийслэлийн прокурорын газрын санаачлагаар Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга О.Алтангэрэл, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл, Дүн шинжилгээний

# 2018

төвийн дарга Б.Бат-Орших, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Э.Амарбат нарыг урьж, шинээр батлагдан гарсан Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн үзэл баримтлал сэдвээр уулзалт зохион байгуулав. Уулзалтад Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурорууд, түүний орлогч, ахлах прокурорууд болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ажил хариуцсан 69 прокурор хамрагдсан байна.

## ПРОКУРОРУУД ХБНГУ, ФРАНЦ УЛСАД АЖЛЫН АЙЛЧЛАЛ ХИЙВ

Европын холбооноос Монгол Улсад хэрэгжүүлж буй Хүний эрхийн сургалтын чиглэлээр прокурорын чадавхийг сайжруулах нь төслийн хүрээнд прокрорын байгууллагын төлөөлөл, сургагч багш нар ХБНГУ-ын Шүүхийн Академи болон Франц улсад байрлах Европын зөвлөлд ажлын айлчлал хийж, туршлага судлажээ.

Сургалтын багийг Улсын Ерөнхий прокурорын туслах, хууль цаазын тэргүүн зөвлөх, Гэмт хэрэг зөрчлийн бүртгэл, дүн шинжилгээний төвийн дарга Б.Бат-Орших болон тус төслийн зөвлөх М.Ичиноров нар ахалж, бүрэлдэхүүнд Улсын Ерөнхий прокурорын туслах, Мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга О.Алтангэрэл, Хан-Уул дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор Ж.Ариунаа, Ховд аймгийн прокурорын газрын ерөнхий прокурор М.Доржсүрэн, УЕПГ-ын Сургалт судалгааны төвийн сургагч багш, хяналтын прокурор Г.Оюунболд нар хамрагдсан байна.

## ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ СУДЛАХ ХҮРЭЭЛЭНТЭЙ БОЛОВ

Улсын Ерөнхий прокурорын 2018 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 тоот тушаалаар УЕПГ-ын Сургалт, судалгааны төвийн дэргэд Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах хүрээлэнг байгуулав.

**4 сарын 23.** Улсын Ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн хяналтын прокурор Г.Цэцэгмаа, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Д.Дашмаа нар Москва хотод болсон мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой сургалтад оролцов.

**4 сарын 27.** БНСУ-ын КОЙКА байгууллагаас хийсэн сургалтад Улсын Ерөнхий прокурорын газар Нийслэл, аймаг, дүүрэг, сум дундын прокурорын газрын 12 прокурор хамрагдав.

**5 сарын 10.** БНТУ-ын Ерөнхий прокурорын орлогч Халил Адигүзэл тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад ажлын айлчлал хийлээ.

**9 сарын 13.** Монгол Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалангийн урилгаар БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын прокурорын газрын Ерөнхий прокурор Ли Чи Лин тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчиллаа.

# 2018

9 сарын 26. ШХАБ-ы гишүүн болон ажиглагч улс орнуудын Ерөнхий прокуроруудын 16 дахь удаагийн чуулга уулзалтад Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалан, УЕПГ-ын Тамгын газрын дарга Ц.Арвинбуудай тэргүүтэй төлөөлөгчид оролцов.

-Ц.Батболд Баянзүрх, Ж.Ариунаа Хан-Уул, Д.Мөнхсайхан Хан-Уул, Ш.Эрдэнэбилэг Сонгинохайрхан, О.Мөнхбаатар Багануур дүүргийн, С.Батсүрэн Говьсүмбэр, Ш.Дамдинбазар Өвөрхангай, С.Ёндонсамбуу Дархан-Уул, У.Золжаргал Сүхбаатар, Н.Батмөнх Хөвсгөл аймгийн прокурорын газрын ерөнхий прокуророор тус тус томилогдлоо.

## ЭДИЙН ЗАСГИЙН ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШАЛГАЖ, ШИЙДВЭРЛЭХЭД...

Азийн Хөгжлийн банкны санхүүжилтаар “Эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгаж, шийдвэрлэхэд прокурорын чадавхийг сайжруулах нь” сэдэвт сургалтад Улсын Ерөнхий прокурорын газар, аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурорын газрын сургагч багш нарыг бэлтгэж, 90 гаруй прокурорыг сургалтанд хамруууллаа.

Сургагч багш нарт Канад Улсын Британиш Колумбын бүс хариуцсан зөвлөх, прокурор хатагтай Венди Кавана, АНУ-ын Тэмплийн Их сургуулийн хууль зүйн ухааны доктор, профессор Жонатан Липсон, Терроризмийг санхүүжүүлэх болон Мөнгө Угаах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн зөвлөх, сургагч багш Том Хансэн, Солонгос улсын доктор профессор, Татварын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн зөвлөх өмгөөлөгч Же Хэум Байк, Итали улсын профессор Жузеппе Ломбардо нараас гадна манай улсын эрдэмтэн, доктор, профессор, судлаач нар хичээл заажээ.

Эдийн засгийн гэмт хэргийг мөрдөн шалгаж, шийдвэрлэхэд прокурорын чадавхийг сайжруулах нь” сургалтын сургагч багш нар, 2018 он



# 2018

## ЕВРОПЫН ХОЛБООТОЙ ХАМТРАН АЖИЛЛАНА



Бага хуралд оролцсон прокурорын байгууллагын төлөөлөгчид

Европын Холбоо, Монгол Улсын Засгийн газар хамтран “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоо ба хүний эрхийн хэрэгжилт” сэдэвт Бага хурлыг ГХЯ-нд зохион байгуулав. Хуралд ХЗДХЯ, ГХЯ, УЕПГ, ХЭҮК-ын удирдах албаны хүмүүс, олон улсын болон үндэсний хүний эрхийн шинжээчдийн төлөөлөл оролцлоо.

Энэхүү хурлаас гарах тайлан, зөвлөмж нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд олон улсын хүний эрхийн стандартын дагуу хүний эрхийг хамгаалж, хангахад чухал нөлөө үзүүлэх төдийгүй Европын Холбоо, Монгол Улсын хүний эрхийн салбар дахь хамтын ажиллагаа, яриа хэлэлцээг гүнзгийрүүлэхэд чухал ач холбогдолтой гэж албаны хүмүүс үзсэн юм. Европын холбооноос хэрэгжүүлж буй төслийн хүрээнд прокурорын байгууллагын чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор тус байгууллагын мэргэжилтнүүдийг Европын Холбооны гишүүн улсад туршлага судлах сургалтад хамруулах, УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн хүний эрхийн сургалтын агуулга, технологийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой ажил хийгдэхээр төлөвлөсөн юм.

## ТОМООХОН ГЭМТ ХЭРГҮҮДИЙГ ШУУРХАЙ ШАЛГАЖ ШИЙДВЭРЛЭХИЙГ ҮҮРЭГДЭВ

УЕПГ-аас олны анхаарал татсан Монголбанкны Ерөнхийлөгч асанд холбогдох хэрэг, Үнэ тогтворжуулах хөтөлбөртэй холбоотой гэх хэрэг, Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл хөтөлбөртэй холбоотой гэх, Агаарын бохирдлыг бууруулахад чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүдтэй холбоотой гэх, Оюутолгойн гэрээ байгуулах үйл явцад албан тушаалтан албан тушаалаа урвуулан ашигласан байж болзошгүй хэрэг, 60 тэрбумын гэх хэрэг, АСЕМ-ийн үйл ажиллагаанд зарцуулагдсан төсөв, хөрөнгө нь хууль, тогтоомж зөрчсөн байж болзошгүй гэх, Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сантай холбоотой гэх, Оффшор бүсэд төрийн албан хаагч, түүнтэй хамаарал бүхий этгээд хөрөнгө байршуулсан гэх зэрэг хэргүүдийг шалгуулахаар АТГ, ЦЕГ-ын мөрдөгч нарын хамтарсан ажлыг хэсгийг байгуулж, ЦЕГ-аас 22 мөрдөгчийг татан ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авав.

# 2018

## М.ЭНХ-АМГАЛАН: “ШУДАРГА ЁС ЭНЭ ТАНХИМААС ЭХЛЭХ ЁСТОЙ”

2018 оны 11 дүгээр сарын 17-нд УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар УИХ-ын гишүүн Б-гийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцэх үеэр Монгол Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалан “2015-2016 оны үед үйлдэгдсэн хэрэг шалгагдаад байх юм. Тийм учраас хуулиа нарийн болгох хэрэгтэй. Дээр нь та нар дандаа “Хууль зүйн сайдаас асууж байна. Энэ хэрэг яагаад явахгүй байна” гэх юм. Үүнийг Хууль зүйн сайд мэдэхгүй, оролцох эрхгүй. Хууль зүйн сайд хэрэв гараа хөдөлгөөд эхэлбэл өөрөө эрүүгийн хариуцлага хүлээх асуудал үүсдэг юм. Хууль зүйн сайд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад ямар ч хамаагүй хүн шүү дээ.



Улсын Ерөнхий прокурор УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд

шүүх рүү шилжээд, буцаад мөрдөн байцаалтад шилжиж эргэж буцсаар одоо дахин шүүх рүү шилжих гэж байна. Цаад суурийг өөрчлөх нь миний асуудал биш. Та нарын асуудал. Өөрсдийн чинь баталж өгсөн хуулиар бүгдийг нь цагдаж хориод байх боломжгүй. Хуулиа өөрсдөө баталж өгчихөөд “Чи энийг аваачиж хорихгүй байна. Ард түмэн харж байхад зүгээр гадуур явуулаад байна” гэж хууль хэрэгжүүлдэг хүн рүү яриад

Би гурав дахь удаагаа асуудал оруулж ирж байна. Эхний хоёр дээр нь та нар татгалзсан хариу өгсөн. Шударга ёс гэдэг чинь энэ танхимаас эхлэх ёстой юм. Хаана байгаа юм тэр шударга ёс чинь. Хууль ёсыг дээдлэх ёстой гэсэн зарчимтай Их хурал чинь яагаад энэ хүмүүсийг журмынх нь дагуу шалгуулж болдоггүй юм” хэмээн хатуухан үг хэлэв.

# 2018



Монгол Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалан тэгүүтэй прокурорын байгууллагын төлөөлөгчид ОХУ-ын Ерөнхий прокурор Юрий Чайкагийн урилгаар Москва хотод ажлын айлчлал хийж, Байгаль нуур болон Сэлэнгэ мөрний ай сав, хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлаар уулзалт хийв. Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалан, ОХУ-ын Ерөнхий прокурорын орлогч В.Петров нар, 2018 он



Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Зөвлөлийн гишүүд, 2018 он

# 2018

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 01 сарын 31 өдөр Дугаар 09 Төрийн ордон, Улаанбаатар хот

Загвар, журам батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Прокурорын тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. "Прокурорын байгууллагын бэлгэдлийн загвар, түүнийг хэрэглэх журам"-ыг 1 дүгээр, "Прокурорын байгууллагын далбааны загвар, түүнийг хэрэглэх журам"-ыг 2 дугаар, "Прокурорын дүрэмт хувцасны загвар"-ыг 3 дугаар хавсралтаар, "Прокурорын дүрэмт хувцас хэрэглэх журам"-ыг 4 дүгээр, "Прокурорын энгэрийн тэмдэгний загвар, түүнийг хэрэглэх журам"-ыг 5 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Журам батлах тухай" (Прокурорын дүрэмт хувцасны загвар, Прокурорын зэрэг дэвийн ялгах тэмдгийн загвар, Прокурорын дүрэмт хувцасыг хэрэглэх журам) 1996 оны 26 дугаар зарлиг, "Дүрэм журам батлах тухай" 2002 оны 148 дугаар зарлигийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

ХУУЛБАР ҮНЭН:
Тамгын газрын дэд дарга

ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА

Г.Байгалмаа

# 2018

| Зэрэг дэв | Дүрэмт хувцасны | Зуны цамцны |
|---|---|---|
| Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх |  |  |
| Төрийн хууль цаазын шадар зөвлөх |  |  |

## Эрэгтэй, эмэгтэй прокурорын зэрэг дэв, мөрдэс

| | |
|---|---|
| Хууль цаазын тэргүүн зөвлөх |  |
| Хууль цаазын шадар зөвлөх |  |
| Хууль цаазын итгэмжит зөвлөх |  |
| Хууль цаазын ахлах зөвлөх |  |
| Хууль цаазын зөвлөх |  |
| Хууль цаазын дэд зөвлөх |  |

# 2019

1 сарын 16. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга прокурорын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд оролцов.

3 сарын 28. ҮАБЗ-ийн зөвлөмжийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж Ерөнхий прокурор М.Энх-Амгалан, Ерөнхий прокурорын орлогч Г.Эрдэнэбат нарыг албан тушаалаас нь чөлөөлөв.

4 сарын 5. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын зарлигаар Улсын Ерөнхий прокуророор Б.Жаргалсайханыг томилов.

4 сарын 18. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын зарлигаар М.Чинбат, С.Алиманцэцэг нарыг Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчоор томилов.

4 сарын 28. Улсын Ерөнхий прокурорын А/28 тоот тушаалаар Улсын Ерөнхий прокурорын газрын бүтцэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл байгуулав.

## НИЙГЭМД ШУДАРГА ЁСЫГ ТОГТООН БЭХЖҮҮЛЭХЭД МАНЛАЙЛНА

Нэгдүгээр сард төв, орон нутгийн прокурорын байгууллагын удирдах ажилтнуудын нэгдсэн сургалт, зөвлөгөөн Улсын Ерөнхий прокурорын газарт боллоо. Зөвлөгөөнд Монгол Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалан хэлсэн үгэндээ "...Өнгөрсөн он бол прокурорын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, үйл ажиллагааг зохицуулдаг Эрүүгийн болон Зөрчлийн хууль тогтоомжууд, тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, зааврууудын анхны бүтэн жил хэрэгжсэн он байснаараа онцлогтой. Энэ нь шинээр мөрдөгдсөн хууль тогтоомж, удирдамжийн баримт бичгүүдийн хэрэгжилттэй холбогдуулан бид үйл ажиллагаандаа үнэлэлт, дүгнэлт хийж, цаашид прокурорын хяналтын чанар, үр дүнг дээшлүүлэх, тэдгээрийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх хариуцлагатай жил байсныг илэрхийлж байна. Ард иргэд болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдоос нийгмийн шударга ёсны байдал, прокурорын байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан гаргаж буй гомдол, санал, хүсэлт зэргийг харгалзан прокурорын байгууллага 2019 оныг "Нийгэмд шударга ёсыг тогтоон бэхжүүлэхэд прокурорын байгууллагын манлайллын жил болгох" уриан дор 4 чиглэлээр зорилт дэвшүүлэн ажиллана" гэжээ.

## ЕРӨНХИЙЛӨГЧ БАРИМТ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨВ

Нэгдүгээр сарын 16-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Прокурорын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөний үеэр Улсын Ерөнхий прокурорт "Монгол Улсад ашиггүй байдлаар Тавантолгойн нүүрсний ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг Улсын Их Хурлаар батлуулах гэж байсан үйлдлийг шалгуулах тухай" гэмт хэргийн шинжтэй мэдээлэл, 178 хуудас баримтыг иргэний хувиар гардуулан өгөв. Улсын Ерөнхий прокурор уг гомдол мэдээллийг шалгуулахаар харьяаллын дагуу Нийслэлийн прокурорын газарт шилжүүллээ.

# 2019

## ҮАБЗ-ӨӨС ЗӨВЛӨМЖ ГАРГАВ

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн иргэдийн жагсаал, цуглаантай холбогдуулан үүсэн нөхцөл байдлын тухай хэлэлцсэний үндсэн дээр зөвлөмж гаргав. Зөвлөмжийн дагуу УИХ-аар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл тус тус батлагдав.

## ТОМООХОН ХЭРГҮҮДИЙГ ТАТАЖ ХЯНАХ АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАВ

Улсын Ерөнхий Прокурор Б.Жаргалсайхан 4 дүгээр сарын 9-ний өдрийн тушаалаараа ажлын хэсэг байгууллаа. Ажлын хэсгийн прокурорууд төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокурор, Авлигатай тэмцэх газар, Тагнуул, Цагдаагийн байгууллагын албан хаагч холбогдсон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд байгаа ээдрээтэй, хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлж, олны анхааралд орсон эрүүгийн хэргүүдийг татаж хянах болжээ. Хэргүүдийг хянаснаар мөрдөн шалгах ажиллагааг эрчимжүүлж, шуурхай шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээг авахаар болсон байна. Мөн хүний эрхийг хууль бусаар хязгаарлаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчил гаргуулахгүй байхад онцгойлон анхаарахыг даалгасан байна.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР БАНЗРАГЧИЙН ЖАРГАЛСАЙХАН



Улсын Ерөнхий прокуророор 2019 оноос томилогдон ажиллаж байгаа Б.Жаргалсайхан Өвөрхангай аймгийн Хайрхандулаан суманд төржээ. Тэрбээр 1988 онд МУИС-ийн Нийгмийн ухааны факультетын мөрдөн байцаагчийн ангийг төгсчээ.

Б.Жаргалсайхан 1988-1991 онд Өвөрхангай аймгийн прокурорын газарт хэсгийн прокурор, хяналтын прокурор, 1991-1996 онд туслах прокурор, орлогч прокурор, 1996-2000 онд аймгийн прокурор, 2000-2001 онд Улсын Ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, 2001-2009 онд Тээврийн прокурор, 2009-2010 онд Улсын Ерөнхий прокурорын газарт Хэрэг эрхлэх газрын дарга, 2011-2014 онд Тээврийн прокурор, 2014-2016 онд Улсын Ерөнхий прокурорын газарт Дотоод аюулгүй байдлын хэлтсийн дарга, 2016-2017 онд Улсын Ерөнхий прокурорын газарт Тамгын газрын орлогч дарга, 2017-2019 онд Улсын Ерөнхий прокурорын газарт Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, 2019 оны 4 дүгээр сараас Улсын Ерөнхий прокуророор томилогдон ажиллаж байна.

# 2019

5 сарын 10. “Мэргэжлийн ур чадвар, хариуцлагыг сайжруулах тухай” Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайханы 05 тоот Албан даалгаврыг Аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн болон сум дундын прокурорын газруудад хүргүүлэв.

6 сарын 3. Улсын Ерөнхий прокурорын А/42 тоот тушаалаар Улсын Ерөнхий прокурорын газрын бүтцэд “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл” байгуулав.

6 сарын 5. Олон улсын Парламентын холбооны Парламентчдын хүний эрхийн хорооны дарга Др.Александра Жерков тэргүүтэй төлөөлөгчдийг Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат хүлээн авч уулзав.

6 сарын 7. “Эрүү шүүлт тулгахаас урьдчилан сэргийлэх тухай” Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайханы 06 тоот Албан даалгаврыг аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн болон сум дундын прокурорын газруудад хүргүүлэв.

## ОХУ-ЫН ЦЭРГИЙН ЕРӨНХИЙ ПРОКУРОР В.Г.ПЕТРОВ АЙЛЧЛАВ

ОХУ-ын Цэргийн прокурорын газрын төлөөлөгчид Монгол Улсын Ерөнхий прокурорын урилгаар 2019 оны 6 дугаар сарын 24-27-нд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.

Айлчлалын бүрэлдэхүүнд ОХУ-ын Ерөнхий прокурорын орлогч, Цэргийн Ерөнхий прокурор В.Г.Петров тэргүүтэй төлөөлөгчид болох Цэргийн прокурорын газрын



Хоёрдугаар газрын дарга, хошууч генерал С.Н.Скребец, Гуравдугаар газрын дарга, хошууч генерал С.А.Зараев, Дөрөвдүгээр газрын дарга, хошууч генерал И.А.Шаболтанов, Төв аппаратын хэрэг эрхлэх газрын дарга, хурандаа И.В.Шарапова, Цэргийн Ерөнхий прокурорын туслах, хошууч А.С.Суворов нар хүрэлцэн ирсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий прокурортой тусгайлан ажил хэргийн уулзалт хийсэн юм. Энэ үеэр зочид, төлөөлөгчдийн ахлагч ОХУ-ын Ерөнхий прокурорын орлогч, Цэргийн Ерөнхий прокурор В.Г.Петров Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайханд ОХУ-ын Ерөнхий прокурор Юрий Чайкагийн мэндчилгээг хүргэж, хоёр орны прокурорын байгууллагын хамтын ажиллагааны чиглэлээр цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар саналаа хуваалцсан. ОХУ-ын Цэргийн прокурорын газрын төлөөлөгчдийн айлчлал 2019 оны 6 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл үргэлжилжээ.

# 2019

## ТӨСӨЛ ХЭРЭГЖИВ

Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг (ТИКА)-ийн санхүүжилтээр УЕПГ-ын Эрүүгийн хэргийн төв архивт хэрэгжсэн “Архивын шүүгээ нийлүүлэх төсөл”-ийн нээлт 7 дугаар сарын 29-ний өдөр болов.

Нээлтэд УИХ-ын гишүүн, УИХ дахь Монгол-Туркийн парламентын бүлгийн дарга Т.Аюурсайхан, Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Улсын Ерөнхий прокурорын



Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их хурлын дарга Мустафа Шэнтоп нар, 2019 он

газрын Хэрэг Эрхлэх газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Оюундэлгэр, Эрүүгийн хэргийн төв архивын эрхлэгч, ахлах прокурор Ж.Чимгээ, Бүгд Найрамдах Турк Улсын Үндэсний Их хурлын дарга Мустафа Шэнтоп, тус улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ахмет Язал, ТИКА-ийн Монгол дахь Хөтөлбөр зохицуулагч Эмрах Устаөмэр, Туркийн Үндэсний Их Хурлын дэд дарга Митхат Санжар болон бусад албаны төлөөлөгчид оролцжээ.

Төслийн хүрээнд Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг (ТИКА)-ийн бүцалтгүй тусламжаар Эрүүгийн хэргийн төв архивт 2019 оны 4 дүгээр сард 400 ширхэг зориулалтын шүүгээнүүдийг суурилуулж архивын сан хөмрөгийн багтаамж, хадгалалт хамгаалалтын орчин нөхцөл сайжирч, архивын үйл ажиллагааг хэвийн явуулах боломж бүрдсэн юм.

**6 сарын 24.** ОХУ-ын Ерөнхий прокурорын орлогч, Цэргийн ерөнхий прокурор В.Г.Петров Монгол Улсад айлчлав.

**6 сарын 28.** “Ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах тухай“ Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайханы 07 тоот Албан даалгаварыг аймаг, Нийслэл, Тээвэр, дүүргийн болон сум дундын прокурорын газруудад хүргүүлэв.

**7 сарын 24.** Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан тэргүүтэй прокурорын байгууллагын төлөөлөгчид ОХУ-ын Ерөнхий прокурор Юрий Чайкагийн урилгаар хойд хөршид айлчлал хийв.

**10 сарын 2.** Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын Ерөнхий прокуроруудын 17 дахь удаагийн уулзалтад оролцов.


# 2019

**11 сарын 24.** Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан тэргүүтэй прокурорын байгууллагын төлөөлөгчид БНХАУ-ын Ардын Дээд Прокурорын газрын Ерөнхий прокурорын урилгаар БНХАУ-д ажлын айлчлал хийлээ.

-Ш.Нямдорж Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокуророор, Ц.Арвинбуудай Тээврийн, С.Хишигжаргал Чингэлтэй, Д.Энхтөр Сүхбаатар, Т.Мөнхбаяр Сэлэнгэ, Н.Амарсанаа Баянхонгор, Н.Ганбат Өмнөговь, Н.Мөнхнаран Булган, Л.Батгэрэл Орхон аймгийн прокурорын газрын ерөнхий прокуророор тус тус томилогдлоо.

## ГЕРМАН ЗӨВЛӨХҮҮД УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАРТ АЖИЛЛАВ

Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төслийн зөвлөх ХБНГУ-ын Бавари мужийн Ердинг хотын шүүхийн орлогч дарга Штефан Приллер, тус хотын шүүхийн шүүгч Томас Линденгер нар Улсын Ерөнхий прокурорын газарт ажиллаж, хэлтсийн дарга нарт болон Нийслэл, Тээвэр, дүүрэг, Төв аймгийн прокурорын газрын



Штефан Приллер, Томас Линденгер нар УЕПГ-т, 2019 он

ерөнхий прокуроруудад, прокурорын байгууллагын мэдээлэл технологи хариуцсан ажилтнуудад Мэдээллийн технологийн нэгдсэн алба байгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ХБНГУ-д цахим хавтаст хэргийг нэвтрүүлсэн туршлага, түүнийг хэрэгжүүлэх арга зам, мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар танилцуулжээ.

## БҮТЭЦ, ОРОН ТОО ШИНЭЧЛЭГДЭВ

Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайханы А/28 тоот тушаалаар УЕПГ, аймаг, Нийслэл, дүүрэг, Тээвэр, сум дундын прокурорын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлажээ. Үүний хүрээнд УЕПГ-ын бүтцэд Төр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах алба, Олон нийтэй харилцах алба шинээр байгуулагджээ.

# 2019

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ МАКСИМЫН ЧИНБАТ



М.Чинбат Сүхбаатар аймгийн Наран суманд төржээ. Тэрбээр 1995 онд МУИС-ийн Хуульзүйн сургуулийг төгсчээ.

М.Чинбат 1995-1997 онд Сүхбаатар аймгийн прокурорын газарт хяналтын прокурор, 1997-2001 онд аймгийн прокурорын орлогч, 2001-2007 онд аймгийн прокурор, 2007-2014 онд Багануур дүүргийн прокурорын газарт туслах прокурор, дүүргийн прокурорын орлогч, 2014-2015 онд Дүүргийн 1 дүгээр прокурорын газарт Тамгын хэлтсийн дарга, 2015-2017 онд Баянгол дүүргийн прокурорын газарт хяналтын прокурор, туслах прокурор, Тамгын хэлтсийн дарга, 2017-2019 онд Чингэлтэй дүүргийн прокурорын газарт ахлах прокурор, 2019 оны 2-4 дүгээр сард Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор, 2019 оны 4 дүгээр сараас Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчоор томилогдон ажиллаж байна.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ СОДОНГИЙН АЛИМАНЦЭЦЭГ



С.Алиманцэцэг 1972 онд Улаанбаатар хотод төржээ. Тэрбээр 1993-1997 онд МУИС-ийн Хуульзүйн сургуулийн захиргааны эрх зүйн анги төгсч, 1997-1999 онд МУИС-д магистрийн зэрэг хамгаалжээ.

С.Алиманцэцэг 1997-2000 онд БГД-ийн прокурорын газарт хяналтын прокурор, 2000-2002 онд Нийслэлийн прокурорын газарт хяналтын прокурор, 2002-2005 онд БГД-ийн прокурорын газарт хяналтын прокурор, 2005-2010 онд УЕПГ-т хяналтын прокурор, 2010-2012 онд СБД-ийн прокурорын газарт хяналтын прокурор, 2012-2014 онд “МИАТ” Төрийн өмчит ХК-ийн хуулийн хэлтсийн дарга, 2014-2015 онд Нийслэлийн прокурорын газар болон дүүргийн нэгдүгээр прокурорын газарт хяналтын прокурор, 2015-2018 онд СБД-ийн прокурорын газарт ахлах прокурор, 2018 онд ЧД-ийн прокурорын газарт ахлах прокурор, 2019 оноос Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчоор ажиллаж байна.

# 2019

## ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭСРЭГ

УЕПГ, АНУ-ын ЭСЯ, Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн яам, Азийн сан хамтран шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын албан хаагчдад зориулан хэрэгжүүлсэн “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа-албан хаагчдыг чадавхижуулах нь” төслийн үр дүнг танилцуулах, хаалтын үйл ажиллагааг зохион байгууллаа.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд хохирогч төвтэй стратеги хэрэгжүүлэх, шүүх эрх мэдлийн болон хууль хяналтын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, албан хаагчдын энэ төрлийн гэмт хэргийн талаархи мэдлэгийг дээшлүүлэх зорилготой уг төсөл 2017 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлсэн бөгөөд 2 жил 5 сарын хугацаанд амжилттай хэрэгжжээ.

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСЛИЙГ ЭХЛҮҮЛЭВ

Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжих “Монгол Улс дахь авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн нээлт 10 дугаар сарын 18-нд болов. Нээлтийн үйл ажиллагаанд Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Улсын Ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор Д.Булганцэцэг, Бодлого төлөвлөлт, хууль эрх зүйн хэлтсийн ахлах прокурор Ж.Мөнхжаргал, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн ахлах прокурор О.Гэрэлтуяа, Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч Ц.Насанбат, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих 1 дүгээр хэлтсийн дарга А.Энхжаргал нар оролцжээ.



“Монгол Улс дахь авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн нээлтийн үйл ажиллагаанд оролцогсод, 2019 он

# 2019

## ЖДҮ-ИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ГЭХ ХЭРГҮҮДИЙГ ХААХ САНАЛЫГ ХҮЛЭЭН АВСАНГҮЙ

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2018 онд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл авсан нийт 214 аж ахуйн нэгжид эрх бүхий албан тушаалтан албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж давуу байдал бий болгосон байж болзошгүй хэрэгт АТГ мөрдөн шалгах ажиллагаа явуулж эхлэв. Төрийн өндөр албан тушаалтнууд нөлөөлсөн байж болзошгүй энэхүү хэргүүдийг хаах саналтай Нийслэлийн прокурорын газрын хяналтад ирүүлснийг хянаад, мөрдөгчийн саналыг хүлээж авахаас татгалзаж нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаажээ.

## ХОВД АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР ШИНЭ БАЙРТАЙ БОЛЛОО

Ховд аймгийн прокурорын газрын шинэ байрны нээлтийн арга хэмжээ 2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр боллоо. Тус аймгийн прокурорын газар нь 1932 онд байгуулагдсан ба үйл ажиллагаагаа 1957 онд ашиглалтанд орсон хуучин байранд явуулж байсан бол энэхүү шинэ байр ашиглалтад орсноор прокурор, ажилтнуудын ажиллах орчин, нөхцөл сайжирч, үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжоор хангагдлаа.



УИХ-ын гишүүн С.Бямбацогт, УЕПГ-ын Хэрэг Эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, Ховд аймгийн прокурорын газрын удирдлагууд, 2019 он

# 2019

## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮН ГУНГААГИЙН БАЯСГАЛАН



Г.Баясгалан Баянхонгор аймгийн Баянхонгор суманд төржээ. Тэрбээр 1986 онд Москвагийн Улсын Их Сургууль, 1998 онд Делигийн Их сургууль төгсчээ.

Тэрбээр 1986-1991 онд Баянхонгор аймгийн прокурорын газарт мөрдөн байцаагч, хэсгийн прокурор, туслах прокурор, 1991-1999 онд Улсын Ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, Ерөнхий прокурорын туслах бөгөөд хэлтсийн дарга, 1999-2000 онд ХЗЯ-нд газрын дарга, 2000-2001 онд ХЗДХЯ-ны ТНБД, 2001-2005 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хуулийн бодлогын зөвлөх, 2006-2012 онд ХЗДХЯ-ны ТНБД, 2016-2018 онд ХЗДХЯ-ны ТНБД, 2018-2019 онд Засгийн газрын ХЭГ-ын тэргүүн дэд дарга, 2019 оны 6 сарын 6-наас Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

## ЗӨВЛӨЛҮҮДИЙГ БАЙГУУЛАВ

Улсын Ерөнхий прокурорын тушаалаар Улсын Ерөнхий прокурорын газрын бүтцэд “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл”-ийг тус тус байгуулав. Улсын Ерөнхий прокурорын орлогч С.Алиманцэцэгээр ахлуулсан 10 гишүүний бүрэлдэхүүнтэй “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл”-ийн ажиллах журам, прокурор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох аргачилсан зааврыг Улсын Ерөнхий прокурорын А/51, А/52 дугаартай тушаалаар батлан, хэрэгжүүлсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр прокурорын байгууллагаас баримтлах бодлого чиглэлийг тодорхойлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж эхэлжээ.

Нийгмийн шаардлага, цаг үеийн нөхцөл байдлын улмаас нийт прокурорын байгууллагын хэмжээнд анх удаа бий болгосон “Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл”-ийг Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбатаар ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Зөвлөлийн зүгээс хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрхийг зөрчих, эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрд нь халдах зэргээр аливаа хэрэг, зөрчил гаргахгүй байх, энэ чиглэлээр тавих прокурорын хяналтыг сайжруулахад анхаарч ажиллаж эхэлжээ.

# 2019



Бүгд Найрамдах Азербайжан Улсын Ерөнхий прокурорын орлогч, Авлигын эсрэг газрын дарга Камран Алиев тэргүүтэй төлөөлөгчдийг Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан хүлээн авч уулзах үеэр, 2019 он




Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төслийн зөвлөх ХБНГУ-ын Бавари мужийн Ердинг хотын шүүхийн орлогч дарга Штефан Приллер, Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат нар, 2019 он

# 2019




“Ял тохиролцох онол, эрх зүйн зохицуулалт болон хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалтад оролцсон 30 прокурорт АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Майкл Клечески, Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан нар сертификат гардуулан өгөх үеэр, 2019 он



“Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, БНХАУ-ын Ардын Дээд прокурорын газар хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгуулав. 2019 он

# 2019




Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, ОХУ-ын Ерөнхий прокурор Юрий Чайка нар хамтран ажиллах хөтөлбөрт гарын үсэг зурав. 2019 он




Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан тэргүүтэй прокурорын байгууллагын төлөөлөгчид ОХУ-ын Ерөнхий прокурор Юрий Чайкагийн урилгаар хойд хөршид айлчлал хийв. 2019 он

# 2019



Монгол Улсад Прокурорын байгууллага үүсэн байгуулагдсаны 89 жилийн ой, “Прокурорын албаны өдөр”-ийг 2019 оны 8 дугаар сарын 17-ны өдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ арга хэмжээнд эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим, прокурор ажилтнуудыг шагнан урамшуулжээ.



# 2020

## ЭРХ МЭДЭЛ, АЛБАН ТУШААЛАА УРВУУЛАН АШИГЛАСАН ГЭХ ХЭРГҮҮДИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЭВ

Олны анхаарал татсан хэргүүдэд прокуророос яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлэв. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг хууль бусаар шилжүүлж, эрх мэдэл албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, бусдад давуу байдал олгосон үйлдэлтэй нэр бүхий УИХ-ын гишүүдэд холбогдох, мөн Зам тээврийн яамны сайдаар ажиллаж байсан нэр бүхий албан тушаалтнууд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, хахууль авсан, УИХ-ын гишүүд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан, ЖДҮХС-гаас хууль бусаар зээл олгож, бусдад болон өөртөө давуу байдал бий болгосон гэх хэргүүдэд яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн нь олны анхаарлыг татав.

## ИРГЭДИЙН ГОМДОЛТОЙ БИЕЧЛЭН ТАНИЛЦАНА

Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан иргэдээс прокурорын байгууллагад гаргасан гомдол, хүсэлтийг шуурхай шийдвэрлэх зорилгоор Улсын Ерөнхий прокурорын орлогч, Улсын Ерөнхий прокурорын газрын хэлтсийн дарга, ахлах прокурорууд Нийслэл, Тээвэр, дүүргийн прокурорын газруудад гаргасан гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэх явц байдалтай танилцах үүрэг өглөө. Танилцах ажил хариуцсан прокурорууд нь прокурорын газруудад ажиллаж гомдол, хүсэлт гаргасан иргэдтэй биечлэн уулзаж, санал, хүсэлтийг нь сонсох, шуурхай шийдвэрлүүлэх үүднээс холбогдох арга хэмжээг авч ажиллажээ. Харин аймаг, сум дундын прокурорын газарт тус прокурорын газрын ерөнхий прокурорууд танилцах ажлыг хариуцан хийж гүйцэтгэсэн байна.

**2 сарын 27.** Прокурорууд нэг өдрийн цалингаа Улсын Онцгой Комисст хандивлалаа.

**4 сарын 8.** УЕПГ-аас хэвлэлийн бага хурал зохион байгуулж, 1 дүгээр улиралд хийсэн ажил, Нийслэлийн прокурорын газраас хяналт тавьсан олны анхаарал татсан эрүүгийн хэргүүдийн шийдвэрлэлт, явц байдлын талаар сэтгүүлчдэд мэдээлэв.

**6 сарын 4.** Прокурор, ажилтны орон сууцны хорооллын шав тавих ёслолын ажиллагаа болов.

**6 сарын 17.** ОУПХ-ны Ерөнхийлөгч, ноён Хван Чеол Гьюгээс Олон Улсын Прокуроруудын Холбоо (ОУПХ) байгуулагдсаны 25 жилийн ойн баярын мэнд хүргэсэн албан захидал ирүүлэв.

**7 сарын 8.** 2020 оны эхний хагас жилд прокурорын байгууллагаас хийсэн ажил, Нийслэлийн прокурорын газраас хяналт тавьсан олны анхаарал татсан эрүүгийн хэргүүдийн шийдвэрлэлт, явц байдлын талаар сэтгүүлчдэд мэдээлэл өглөө.

-Ц.Нямтайван Төв аймгийн, Ч.Бямбажаргал Дундговь аймгийн, Б.Гантулга Ховд, Д.Галбадрах Увс, Ц.Дэнсмаа Завхан аймгийн ерөнхий прокуророор, О.Алтангэрэл Хан-Уул, Э.Амарбат Сүхбаатар, Д.Отгонбаяр Сонгинохайрхан, С.Гансэлэм Баянгол, Н.Энхтуяа Багануур дүүргийн ерөнхий прокуророор тус тус томилогдов.

# 2020

## КОРОНАВИРУСЫН ЭСРЭГ ЦАЛИНГАА ХАНДИВЛАВ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн шийдвэрээр улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хэрэгслүүдээр онцолсон юм. Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, УЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар нар прокуроруудын хандивыг Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой Комиссын дарга Ө.Энхтүвшинд гардуулан өгч, коронавирусын халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээнүүдийг шуурхай авч хэрэгжүүлэн ажиллаж байгаад талархал илэрхийлжээ.



Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, УЕПГ-ын ХЭГ-ын дарга Д.Цогтбаатар нар прокуроруудын нэг өдрийн цалинг УОК-т хандивлах үеэр, 2020 он

зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор УЕПГ, аймаг, Нийслэл, Тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрууд шинэ короновирусийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж эхлэв. Түүнчлэн улс орны өмнө тулгарч буй энэхүү сорилт, бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх үүднээс Монгол Улсын прокурорын байгууллагын нийт прокуроруудын нэг өдрийн цалингаа Улсын Онцгой Комисст хандивлалаа. Хандивын энэ арга хэмжээ нь төрийн байгууллагуудыг түүчээлсэн үйл явдал болж байгааг УОК-ын зүгээс болон хэвлэл мэдээллийн

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН СУРГАЛТ

Аймаг, нийслэлийн прокурорын газрын тамгын хэлтсийн дарга нар “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй”-н 5 хоногийн сургалтад хамрагдав. Энэхүү сургалтыг УЕПГ-ын Дотоод хяналт, шалгалтын хэлтсээс зохион байгуулсан бөгөөд ХЭГ-ын дарга Д.Цогтбаатар, ДХШХ-ийн дарга Д.Оюундэлгэр нар төгсөгчдөд сертификат гардуулжээ.

# 2020

## ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ИЖ БҮРЭН ТҮНШЛЭЛ

2020 оны дөрөвдүгээр сарын 2-нд АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Майкл Клечески болон Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан тэргүүтэй төрийн өндөр албан тушаалтнууд Монгол Улсад хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах, хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн “Хүүхэд хамгааллын иж бүрэн түншлэл” байгуулах гэрээнд гарын үсэг зурсан байна. Дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих энэхүү түншлэл нь Монгол Улсад хүүхдийн эсрэг хүн худалдаалах гэмт хэргийн бүх хэлбэртэй тэмцэхэд Засгийн газар, холбогдох яамд, Прокурорын байгууллага төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагуудын хүчин чармайлтыг нэмэгдүүлэх юм.

Тус түншлэлийг Монгол Улсын төрийн холбогдох байгууллагууд болон АНУ-ын ЭСЯ, хүний наймаатай тэмцэх дэлхий даяарх үйл ажиллагаанд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг АНУ-ын Төрийн департаментын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх газрын төлөөлөгчдийн олон сарын хугацаанд үргэлжилсэн өндөр түвшний хэлэлцүүлгийн үр дүнд байгуулсан байна.

## ГАРЫН АВЛАГА ГАРГАВ

Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалтын албанаас Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил тэр дундаа хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлуудаар албан хэрэгцээнд зориулсан



АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Майкл Клечески, Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан нар “Хүүхэд хамгааллын иж бүрэн түншлэл” байгуулах гэрээнд гарын үсэг зурах үеэр, 2020 он

# 2020

гарын авлага бэлтгэн гаргажээ.

Энэхүү гарын авлагад дээрх төрлийн гэмт хэрэг, зөрчлийг шалгах ажиллагаа, арга зүйн онцлог, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомжийг нэг мөр хэрэглэх талаар болон урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлууд зэрэг холбогдох олон асуудлуудыг тусгаснаараа онцлог болсон байна.

## ИЛТГЭЛИЙН УРАЛДААН ЯВАГДАВ

Монгол Улсад Прокурорын байгууллага үүсэн байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан “Прокурорын хяналтыг боловсронгуй болгох нь” эрдэм шинжилгээний шилдэг илтгэлийн уралдаан амжилттай болж өндөрлөлөө. Уралдаанд Дархан-Уул аймгийн прокурорын газрын ахлах прокурор Б.Сүрмандахын “Прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаанд гадаад орнуудын туршлагыг харьцуулан судлахуй” илтгэл тэргүүн байр эзэлсэн ба 2 дугаар байрт хүний эрхийн хамгаалагч, судлаач С.Асланбекийн “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа ба прокурорын хяналт”, 3 дугаар байрт МУИС-ийн докторант С.Номынбаясгалангийн “Прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцох эрх зүйн асуудал”, тусгай байрт өмгөөллийн “Кей и партнерс” ХХН-ийн өмгөөлөгч Ж.Батмөнхийн “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт прокурор хяналт тавих нь”, Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Д.Нямбатын “Прокурорын хяналтыг боловсронгуй болгох нь” сэдэвт илтгэлүүд тус тус шалгарлаа.

## ОЙН ЛОГО, ХҮНДЭТ ТЭМДГИЙН ЗАГВАР ШАЛГАРУУЛАВ

Монгол Улсад Прокурорын байгууллага үүсэн байгуулагдсаны 90 жилийн ой энэ онд тохиож байгаатай холбогдуулан зохион байгуулсан ойн лого болон “Прокурор-90 жил” хүндэт тэмдэгийн загвар шалгаруулах




УЕПГ, Нийслэлийн прокурорын газраас хяналт тавьж буй олны анхаарал татсан хэргүүдийн шийдвэрлэлт, явц байдлын талаар улирал бүрт сэтгүүлчдэд мэдээлэл хийж эхэллээ, 2020 он

# 2020

уралдаанд нийт 23 оролцогч бүтээлээ ирүүлжээ. Тэдгээрээс “Прокурор-90 жил” хүндэт тэмдэгийн шилдэг загвараар




Баянзүрх дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор Ц.Гантулгабат, Т.Мөнх-Амгалан нарын хамтын бүтээл шалгарч 1.000.000 төгрөгөөр, Прокурорын байгууллагын 90 жилийн ойн логоны шилдэг загвараар график дизайнер Б.Одбаатар, Л.Мөнхсоёл нарын бүтээл шалгарч тус бүр 500.000 төгрөгөөр шагнуулсан байна.

## ОУПХ 25, МОНГОЛЫН ПРОКУРОРУУДЫН ХОЛБОО 26 ЖИЛИЙН ОЙТОЙГОО ЗОЛГОВ

Монголын Прокуроруудын холбоо нь анх 1994 онд Монголын Прокуроруудын Үндэсний холбоо нэртэйгээр, 469 гишүүнтэй үүсгэн байгуулагдаж байсан бол өдгөө 730 гаруй гишүүнтэй, 32 салбар зөвлөлтэй үйл ажиллагаа явуулж байна.

2019 онд Монголын Прокуроруудын холбооны тэргүүнээр Улсын Ерөнхий прокурорын орлогч С.Алиманцэцэг сонгогдсон ба энэ онд холбооны дүрэм шинэчлэгдэн батлагдаж, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхой болгож, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийжээ.

Түүнчлэн “Холбооны хүндэт гишүүн”, “Шилдэг салбар зөвлөл”, “Прокурорын алдар” тэмдэг шагналыг олгох журмыг баталж, 2019 оны шилдэг салбар зөвлөлөөр Сэлэнгэ аймгийн прокурорын газрын салбар зөвлөл шалгарсан байна.

Монголын прокуроруудын холбоо 1996 онд Олон улсын прокуроруудын холбооны гишүүнээр элссэн цаг үеэс тус холбооноос зохион байгуулагдсан дэлхийн болон бүс нутгийн шинжтэй олон улсын чуулган, хурал, семинар, солилцооны хөтөлбөр зэрэг бүхий л үйл ажиллагаанд тасралтгүй идэвхтэй оролцож ирсэн.

2020 оны 6 дугаар сарын 6-нд Олон улсын прокуроруудын холбоо байгуулагдсаны 25 жилийн ой тохиосон билээ.



Монголын Прокуроруудын холбооны Удирдах зөвлөлийн гишүүд: зүүнээс П.Батболд, Э.Нарантуяа, Д.Эрдэнэбилэг, Ц.Ариунболд, С.Алиманцэцэг, Ц.Батболд, Ж.Болорпүрэв, Д.Дашмаа, Ц.Гантулгабат, 2020 он

# 2020

## “ПРОКУРОР-90” АЯНД СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ПРОКУРОРУУД ТЭРГҮҮЛЭВ

Орхон аймгийн прокурорын газар, 5 дугаар байрт Нийслэлийн прокурорын газар тус тус шалгарчээ.



“Прокурор-90” аянд түрүүлсэн Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын хамт олон. 2020 он

Прокурорын байгууллагын түүхт 90 жилийн ойг угтан Прокурорын байгууллагаас 2020 онд дэвшүүлсэн хяналтын ажлын чанар үр дүнг дээшлүүлэх “ПРОКУРОР-90” нэгдсэн аяныг улсын хэмжээнд 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс 6 дугаар сарын 12-ны өдрийн хооронд зохион байгууллаа.

Аяны хүрээнд прокурорын газрууд шийдвэрлэх боломжтой хэргийн судалгааг гаргаж, хяналтын харьяа байгууллагуудтай хамтарсан зөвлөгөөн хийх, сургалт зохион байгуулах зэргээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэн ажиллажээ. Ингээд аяныг дүгнэхэд нийлбэр дүнгээр Сонгинохайрхан дүүргийн прокурорын газар тэргүүлсэн байна. Удаах байранд Баянзүрх дүүргийн прокурорын газар, 3 дугаар байрт Төв аймгийн прокурорын газар, 4 дүгээр байрт

## ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ХИЙВ

Улсын Ерөнхий Прокурорын газраас 7 дугаар сарын 8-нд хэвлэлийн бага хурал зохион байгуулж, прокурорын байгууллагаас 2020 оны эхний хагас жилд хийсэн ажлын талаар сэтгүүлчдэд мэдээлэл өглөө.

Хэвлэлийн бага хуралд “Сонгуулийн хууль болон Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих зөрчлийн талаар”, “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих чиглэлээр хийсэн ажлын талаар”, “Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хийсэн ажлын талаар”, “Ял эдлүүлэх, баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс хамгаалах чиглэлээр хийсэн ажлын талаар” тус тус

# 2020

мэдээлэл хийж, сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өглөө. Мөн Улсын Ерөнхий прокурорын газрын Олон нийттэй харилцах албаны дарга, ахлах прокурор Д.Дашмаа мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлын талаар товч мэдээлэл хийв. Мөн Нийслэлийн прокурорын газрын орлогч прокурор Ц.Насанбат “2019 оны 5 дугаар сараас 2020 оны 7 дугаар сар хүртэл олны анхаарал татсан, улс төрд нөлөө бүхий этгээд яллагдагчаар татагдсан нийт 111 хүнд холбогдох 50 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсныг хянаж, яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлсэн. Үүнээс 36 яллагдагчид холбогдох 18 хэргийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн” тухай мэдээлэл өгсөн юм.

## ОРОН СУУЦНЫ ХОРООЛЛЫН ШАВ ТАВИВ

Прокурорын байгууллагын прокурор, ажилтны орон сууцны хорооллын шав тавих ёслолын ажиллагаа 2020 оны 6 дугаар сарын 4-ний өдөр боллоо. Прокурорын байгууллага нь түүхт 90 жилийн ойгоо угтаж прокурор, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн шинэ суурьшлын бүсэд 600 айлын орон сууцны хороолол босгохоор төлөвлөж, прокурор, ажилтнууддаа хөнгөлөлттэй үнээр хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлж эхэлсэн нь энэ юм.




Орон сууцны шав тавих ёслолын үеэр Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, 2020 он

Энэхүү төсөл хөтөлбөр нь 3 үе шаттайгаар хэрэгжих бөгөөд цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбай, авто машины нэгдсэн зогсоол, үйлчилгээний төв бүхий 16 давхар 8 блокоос бүрдэнэ. Орон сууцны хорооллын нэгдүгээр ээлжийн барилгыг 2021 оны 4 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар “Utam констракшн” ХХК гүйцэтгэгчээр ажиллаж байна.



Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Ерөнхий прокурорын орлогч С.Алиманцэцэг, М.Чинбат, УЕПГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, Гандантэгчинлэн хийдийн хамба лам Д.Чойжамц, Улс, Нийслэл, Тээвэр, дүүргийн прокуроруудын хамт орон сууцны шав тавих ёслолын үеэр, 2020 он


# 2020




Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Зөвлөлийн дарга, гишүүд, 2020 он

## ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ЦАХИМ ХЯНАЛТЫН СИСТЕМ

Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын цахим




мэдээллийн нэгдсэн сан www.e-justice.mn нээгдлээ. Энэхүү цахим мэдээллийн сан нь гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл гаргагч иргэн болон мөрдөх байгууллага, прокурор, шүүхийн шатанд шалгагдан, шүүгдэж байгаа иргэдэд тухайн хэргийн хүрээнд өөрт хамааралтай бодит мэдээллийг цаг тухайд хүргэх, хууль, эрх зүйн тусламж өгөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессыг таниулах зорилго бүхий иргэний портал систем юм. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын мэдээллийг иргэнд шуурхай хүргэх нь хуулийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой. Энэхүү цахим санг ашиглалтад оруулах ажлыг УЕПГ-ын Мэдээллийн технологийн албанаас удирдан гүйцэтгэжээ.

# 90 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАН 1040 КИЛОМЕТР ГҮЙВ

Хөнгөн атлетикийн олон улсын хэмжээний мастер, Говь-Алтай аймгийн прокурорын газрын ажилтан Б.Болдбаатар Монгол Улсад прокурорын байгууллага үүсч хөгжсөний 90 жилийн ой, Говь-Алтай аймаг болон тус аймгийн прокурорын газрыг үүсгэн байгуулсны 80 жилийн ойд зориулан Алтай хотын төв Жанчив талбайгаас Улаанбаатар хотын төв Сүхбаатарын талбай хүртэл 1040 км замыг 34 хоногт туулсан холын зайн түүхэн гүйлт хийлээ.



Б.Болдбаатарыг 7 дугаар сарын 16-нд Баянхонгор аймагт тус аймгийн прокурорын газрын хамт олон угтан авах үеэр

# БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУД ӨРНӨЖ БАЙНА

Прокурорын байгууллагаас прокурор, ажилтнуудын ажиллах нөхцөл боломжийг сайжруулах үүднээс сүүлийн жилүүдэд УЕПГ-ын Эрүүгийн хэргийн төв архивын барилга, Ховд, Баян-Өлгий, Дундговь, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн прокурорын газруудын албан контор, Дорноговь, Өмнөговь, Ховд, Завхан аймгуудын сум дундын прокурорын газруудын албан конторын барилгуудыг шинээр барьж ашиглалтад оруулаа. 2020 онд түүхт 90 жилийн ойгоо угтан прокурор, ажилтнуудын ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт “Прокурорын нэгдсэн барилга”, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Баянгол дүүргийн прокурорын газруудын “албан контор”-ын барилгуудыг шинээр барьж байгуулах, Нийслэлийн прокурорын газар, Сургалтын төвийн барилгуудын өргөтгөл, УЕПГ болон бусад 11 харьяа газар нэгжүүдийн барилгын их засвар, тохижилтын ажлуудыг хийж гүйцэтгэхээс гадна Хан-Уул, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт прокурор, ажилтны 600 айлын орон сууцны барилгын ажлыг эхлүүлээд байна.

# ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН АХМАДЫН ХОЛБОО

Прокурорын байгууллагын ахмадын холбоо нь өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад прокурор, ажилтнуудын нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдний нийгмийн хамгааллын баталгааг хангуулах, тэдэнд сэтгэл санааны болон эд материалын дэмжлэг туслалцаа үзүүлэх, ажил амьдралын нь арвин баялаг туршлага, өв уламжлалыг залгамжлуулах ажлыг зохион байгуулах зорилгоор Монгол Улсын Ерөнхий прокурорын 2015 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн А/64 дугаар тушаалаар байгуулагджээ. Тус холбооны тэргүүнээр ахмад прокурор Гэндэнгийн Бадамханд 2015 оноос томилогдон ажиллаж байна.

Прокурорын байгууллагын ахмадын холбоо нь дотроо Д.Эрдэнэчимэг даргатай УЕПГ-ын ахмадын хороо, М.Туяацэцэг даргатай Нийслэл, дүүрэг, тээврийн прокурорын газрын ахмадын хороо гэсэн хоёр салбартайгаас гадна орон нутгийн прокурорын газрын ахмадуудыг тухайн аймгийн прокурорын газрын тамгын газрын дарга хариуцан ажиллаж байна. Тус холбоонд 263 ахмад бүртгэлтэйгээс 140 нь прокурор, 123 нь ахмад ажилтан ажиллагсад байна.

Холбоо байгуулагдахаас өмнөх жилүүдэд 1995-2002 онд Ж.Авхиа, 2002-2012 онд Н.Сосорбарам Улсын Ерөнхий прокурорын газрын ахмадын хорооны даргаар, 2006-2011 онд ахмад прокурор Н.Буниа Нийслэл, дүүргийн прокурорын газрын ахмадын хорооны даргаар ажиллаж байжээ.

**Ахмад прокурорууд**

М.Алтанхуяг, Д.Алтанцэцэг, Г.Бадамханд, Т.Барамсай, Ш.Батаа, О.Баяраа, Л.Болд, Ц.Бүжинлхам, Ц.Бямбацогт, Б.Галдаа, Г.Ганзориг, Ц.Гийзэв, Ц.Дагвадорж, С.Дамчаасүрэн, Н.Дашжамц, А.Дулмаа, М.Дэлгэрнасан, З.Жигжидсүрэн, Р.Мөнхтариа, Б.Мягмарсүрэн, С.Нансалмаа, Л.Нарангуа, Ц.Оюунбаатар, Ш.Оюунбилэг, Пү.Оюунцэцэг, И.Пүрэвцогт, Е.Сагсай, Ц.Сайнгэрэл, Н.Сосорбарам, Т.Сүхбаатар, Д.Сэрдамба, Ц.Туул, Ж.Түвшинжаргал, Б.Цэрэнбалтав, Ж.Энхнасан, Ж.Эрдэнэбаатар, Д.Эрдэнэцэцэг, Даг. Эрдэнэчимэг, Х.Алтанзүрх, Б.Базарханд, Ж.Баярсүрэн, А.Бодьгэрэл, П.Зориг, Б.Намхай, О.Нямаа, Р.Оюунчимэг, Ж.Солонго, Д.Цэнгэлмаа, Н.Цэцэгмаа, Р.Бадмаа, А.Болорчимэг, Д.Мөнх-Очир, Б.Нямханд, М.Туяацэцэг, Ц.Цэрэннадмид, С.Цэцгээ, М.Алтанцэцэг, Ц.Дамдинсүрэн, Б.Дуламсүрэн, Г.Мижигсүрэн, П.Нархажид, М.Цэнд-Аюуш, Б.Чойжилсүрэн, М.Гантулга, Т.Даваажав, Д.Жаргалсайхан, С.Наранцэцэг, Ч.Нямсүрэн, Д.Пүрэвдорж, Б.Төмөрчөдөр, А.Ширэндэв, Ш.Эрдэнэцэцэг, Л.Адъяа, М.Бадам, Н.Батцэнгэл, Б.Гүнсэнхорлоо, А.Содномдаржаа, Т.Туул, П.Цэдэн, Ц.Цэрмаа, Б.Чулуунцэцэг, Ө.Алтантуяа, Б.Амарзэд, Ч.Баасанжав, Ц.Дамдин, Л.Долгор, Д.Нарангэрэл, Б.Отгончимэг, Ц.Оюунчимэг, Д.Цолмон, Р.Энхтуяа, М.Адъяа, П.Алимаа, Г.Ганчимэг, Д.Дамдинсүрэн, Ц.Осоржамаа, Пу.Оюунцэцэг, Д.Хаш-Эрдэнэ, Л.Цэндоо, Ш.Баатаржүрмэд, Г.Дашзэвэг, Н.Тэрбиш, Г.Энхтувшин, Л.Батчулуун, Б.Түвшинбаяр, Даш.Эрдэнэчимэг, С.Алтантуяа, С.Нармандал, Д.Рагчаабазар, Н.Цэвээнжав, Б.Пүрэвсүрэн, С.Наст, Г.Энхжаргал, Б.Даваадулам, С.Оюунцэцэг, М.Чулуун, Л.Цэрэндулам, С.Энхээ, Д.Оюунтуяа, Ж.Бямбажав, Б.Ванданцэрэн, Б.Дашням, Д.Чимэддулам, Д.Бат-Өлзий, Н.Олзод, Т.Жадамбаа, Г.Амарсайхан, Д.Баасанжав, С.Сүрэн, Н.Цэрэннадмид, С.Сувдаа, Д.Уранчимэг, Ш.Цэдэн, О.Дорж, Д.Жамбалдорж, Д.Лхагвадондог, Ц.Цэцэгмаа, Т.Цэвэг, Д.Оюунбилэг, Б.Түмэндэмбэрэл.

**Ахмад ажилтан, ажиллагсад**

Д.Буяндэлгэр, Д.Даваасүрэн, Ж.Дорж, Л.Дүгэрхүү, М.Жавзан, Г.Жаалдүү, Б.Мөнхбат, Д.Нарангэрэл, Д.Наранхүү, Т.Норжмаа, Ц.Тогтохбаяр, Л.Тулгаа, Ч.Уранчимэг, З.Цойнзон, О.Цэнд, С.Цээрэгзэн, Д.Чулуунцэцэг, Б.Эрдэнэдулам, Г.Галтхуяг, Х.Пүрэвхүү, Г.Туваанхүү, Ц.Цэрэндолгор, Ц.Цэцгээ, Б.Эрхэм-Очир, Б.Бадам, С.Нина, М.Шагдарсүрэн, Ж.Жавзан, Р.Лувсандорж, А.Нямаа, И.Оюунбадам, Д.Хаш-Эрдэнэ, Ж.Цэрэнханд, Ч.Батнасан, Баа.Ганбат, Р.Дэжидмаа, Р.Хоролжав, Л.Чунаг, Ло.Оюунчимэг, Л.Чимэдлхам, Ц.Мөнхтуяа, Д.Цогзолмаа, Д.Чадраа, З.Ширнэн, Бая.Ганбат, Г.Ганхуяг, Ж.Даваасүрэн, Н.Цогтдэлгэр, Ч.Цэцгээ, Л.Энхээ, Э.Мөнхөө, Ө.Пүрэвдорж, Л.Пүрэвсүрэн, П.Цогзолмаа, Ш.Цээнэнхүү, М.Энхцэцэг, М.Эрдэнэцэцэг, Н.Туул, Л.Самбуу, Ш.Цэрэнхажид, Б.Энхнайрамдал, М.Энхтуяа, А.Бямбаа, С.Гансүх, Д.Чимгээ, Ц.Наранчулуун, Ц.Отгонбаяр, М.Удвал, Д.Гармаа, Ш.Дэлгэрцэцэг, Т.Жанагаа, Д.Наранцэцэг, Б.Чойжилжав, А.Энхтуяа, Д.Бямбадагва, Б.Оролмаа, Л.Тунгалаг, Д.Алиахүү, Н.Маам, Б.Мягмар, Ш.Сүхбаатар, Б.Тогоон, Ж.Цэвэлмаа, Б.Янжиндулам, С.Гүр, Л.Тунгалаг, Ц.Шура, В.Аюушжав, С.Дайрийхүү, Б.Магсар, Б.Нэргүй, Р.Түмэндэлгэр, О.Авирмэд, Б.Баасанхүү, Л.Төмөрбаатар, Д.Цэрэннадмид, Л.Одсүрэн, А.Уртнасан, С.Хишигжаргал, Г.Бат-Эрдэнэ, Б.Бямба, Д.Дашдооров, Б.Эрдэнэбат, Н.Дашдондог, Н.Пүрэвээ, Д.Цагаан, Ц.Цээсүрэн, Н.Алтаннавч, Ш.Отгонболд, Лу.Оюунчимэг, Н.Цоморлиг, Л.Чулуунцэцэг, Г.Бямбасүрэн, Т.Даваадугар, Б.Наранцэцэг, Т.Наранцэцэг, Т.Оюунчимэг, Р.Чулуунбат, Д.Бат-Эрдэнэ, О.Долгор, С.Эрдэнэбаатар, Ё.Өлзийдэлгэр, Г.Урансайхан.



Ахмад прокурорууд түүхт 90 жилийн ойд зориулсан баримтат киноны зураг авалтын үеэр Д.Сүхбаатарын талбайд, 2020 он

# ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ЭМЭГТЭЙЧҮҮД




Зүүн талаас: Налайх, Багахангай дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор Х.Баярмаа, УЕПГ-ын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Д.Булганцэцэг, Дотоод хяналт шалгалтын хэлтсийн дарга М.Оюундэлгэр, Улсын Ерөнхий прокурорын орлогч С.Алиманцэцэг, Бодлого төлөвлөлт, хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.Баянжаргал, Багануур дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор Н.Энхтуяа, Чингэлтэй дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор С.Хишигжаргал нар, 2020 он

Өдгөө Прокурорын байгууллагад тангараг өргөж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэн ажиллаж байгаа нийт прокурорын 50 гаруй хувь нь буюу 282 эмэгтэй прокурор ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн прокурорын газрын ерөнхий прокуророор 1993-2001 он хүртэлх хугацаанд тасралтгүй 8 жил ажилласан ахмад прокурор Н.Цэрэннадмид прокурорын байгууллагын хоёр дахь эмэгтэй Аймгийн ерөнхий прокурор юм.

Өнөөдөр УЕП-ын орлогч С.Алиманцэцэг, туслах прокурор, Дотоод хяналт шалгалтын хэлтсийн дарга М.Оюундэлгэр, туслах прокурор, Бодлого төлөвлөлт хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.Баянжаргал, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Д.Булганцэцэг гээд нэр хүндтэй хуульч эрх зүйч эмэгтэйчүүд прокурорын байгууллагын өндөр дээд албан тушаалыг хашиж байна.

Чингэлтэйд С.Хишигжаргал, Налайх-Багахангайд Х.Баярмаа, Багануурт Н.Энхтуяа, Говьсүмбэрт Д.Мөнгөнцэцэг, Завханд Ц.Дэнсмаа гээд энэ цагийн хуульчдын тэргүүн эгнээнд бичигдэх эмэгтэй прокурорууд дүүрэг, аймгийн прокурорын газрын ерөнхий прокуророор ажиллаж байна.

Мөн Эрүүгийн хэргийн төв архивын удирдлагаар 2010-2014 онд Ж.Ичинхорлоо, 2015-2017 онд Ц.Сэлэнгэ, 2018 оноос Ж.Чимгээ, УЕП-ын газрын Олон нийттэй харилцах албаны даргаар Д.Дашмаа нар ажиллаж байна.

**Үе үеийн дээд шатны прокуророор ажиллаж байсан эмэгтэй прокурорууд:**

-УЕПГ-ын Бодлого төлөвлөлт, гадаад харилцааны хэлтсийн дарга Ж.Оюунчимэг 2002-2010 он

-УЕПГ-ын Хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга О.Нямаа 1999-2005 он, Д.Баянжаргал 2006-2010 он

-УЕПГ-ын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Ц.Бүжинлхам 1968 он, Е.Өнөрбаяр 1990-1994, М.Оюундэлгэр 2015-2018 он

-УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Л.Отгонбаяр 1984-1990 он

-Тээврийн прокурорын газрын ерөнхий прокурор Ц.Сарантуяа 1989-1991 он

-Баянхонгор аймгийн прокурорын газрын Ерөнхий прокурор Ж.Уранцэцэг 2014-2019 он

-Булган аймгийн прокурорын газрын Ерөнхий прокурор М.Оюундэлгэр 2009 он

-Дундговь аймгийн прокурорын газрын Ерөнхий прокурор Ц.Сэлэнгэ 2001-2009 он

-Орхон аймгийн прокурорын газрын Ерөнхий прокурор Ж.Мөнхжаргал 2011-2015 он

-Төв аймгийн прокурорын газрын Ерөнхий прокурор С.Алимаа 2014-2020 он

-Сэлэнгэ аймгийн прокурорын газрын Ерөнхий прокурор Н.Цэрэннадмид 1993-2001, Ж.Мөнхжаргал 2015-2019 он

-Хөвсгөл аймгийн прокурорын газрын Ерөнхий прокурор Н.Тэрбиш 1999-2007 он

-Говьсүмбэр аймгийн прокурорын газрын Ерөнхий прокурор С.Батсүрэн 2017-2019 он

-Октябрийн район, Баянгол дүүргийн прокурор Н.Буниа 1975-1996 он

-Найрамдлын районы прокурор (Баянзүрх дүүрэг) Д.Ханджав 1980-1983 он

-Багануур дүүргийн прокурорын газрын Ерөнхий прокурор Д.Пүрэвдорж 2001-2006 он

-Налайх дүүргийн прокурорын газрын Ерөнхий прокурор Г.Энхтүвшин 2001-2009 он

-Хан-Уул дүүргийн прокурорын газрын Ерөнхий прокурор О.Нямаа 1988-1991 он, Ж.Ариунаа 2018-2019 он

-Чингэлтэй дүүргийн прокурорын газрын Ерөнхий прокурор Д.Булганцэцэг 2017-2019 он

-Баянгол дүүргийн прокурорын газрын Ерөнхий прокурор Н.Энхтуяа 2011-2013, 2015-2020 он

-Сүхбаатар дүүргийн прокурорын газрын Ерөнхий прокурор Д.Эрдэнэчимэг 2000-2003 он

# МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР
Б.ЖАРГАЛСАЙХАН

ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ
М.ЧИНБАТ

ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ
С.АЛИМАНЦЭЦЭГ

## УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Хэрэг эрхлэх газрын дарга Д.Цогтбаатар, Хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албаны дарга Д.Баярмагнай, Олон нийттэй харилцах албаны дарга Д.Дашмаа, Тамгын хэлтсийн дарга Ш.Эрдэнэбилэг, хяналтын прокурор Э.Энхбат, Ж.Ичинхорлоо;**

- **Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ү.Содномцог**, ахлах прокурор Ж.Мөнхжаргал, хяналтын прокурор, Ц.Алдархишиг, Б.Энэрэл;

- **Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Ариунболд**, ахлах прокурор Ж.Уранцэцэг, хяналтын прокурор Ж.Ариунаа, М.Батхишиг, Ц.Батцэнгэл, Ш.Баярбилэг, М.Буяннэмэх, Д.Доной, Б.Мөнх-Од, Н.Найгалдорж, Н.Отгонцэцэг, Ц.Отгоннороов, И.Энхтуяа;

- **Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Д.Булганцэцэг**, ахлах прокурор, О.Мөнхбаатар, Д.Сарантуяа, хяналтын прокурор Ц.Бурмаа, Д.Дамдинсүрэн, А.Оюунгэрэл, О.Сарангэрэл, Ш.Одонсүрэн;

- **Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Д.Энхтөр**, ахлах прокурор Т.Баярсайхан, хяналтын прокурор Г.Бат-Очир, Т.Амарзаяа;

- **Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Дотоод хяналт шалгалтын хэлтсийн дарга М.Оюундэлгэр**, ахлах прокурор Д.Дагвасүрэн, хяналтын прокурор Б.Пүрэвжав, Г.Эрдэнэбаяр, Ё.Наранчимэг;

- **Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Бодлого төлөвлөлт, хууль эрх зүйн хэлтсийн дарга Д.Баянжаргал**, ахлах прокурор Н.Ганболд, хяналтын прокурор Д.Саруул, Н.Бадамцэцэг;

- **Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Хяналт шинжилгээ үнэлгээ, сургалтын хэлтсийн дарга Б.Бат-Орших**, ахлах прокурор М.Гантулга, З.Сансарзолбоо, хяналтын прокурор Г.Гэрэлтуяа, Ц.Мөнхбат, Ц.Сэлэнгэ, О.Чулуунбаатар, Г.Оюунбаяр, Г.Оюунболд, Б.Өнөрмаа;

- **Гадаад харилцаа эрх зүйн туслалцааны хэлтсийн дарга, ахлах прокурор Ж.Болорпүрэв**, хяналтын прокурор У.Эрдэнэтуяа, Ж.Сандагсүрэн;

- Тусгай хяналтын хэлтсийн ахлах прокурор М.Бамбадорж, Ж.Отгонбат;

- **Бүртгэл, мэдээллийн технологийн албаны дарга, ахлах прокурор Ц.Хашбаатар,** хяналтын прокурор Д.Бөхчулуун;

- Туслах ажилтан А.Ариунтуяа, У.Болормаа, Я.Болортуяа, Э.Булганчимэг, Б.Будхүү, Г.Гармаа, О.Ганбадрах, О.Дарханбаатар, Ж.Уганбаяр, Д.Ундармаа, О.Одгэрэл, Б.Мандухай, Б.Манлайбаатар, Н.Нандин-Эрдэнэ, Д.Түмэнжаргал;

- Захиргаа үйлчилгээний ажилтан М.Амаржаргал, Д.Болд-Эрдэнэ, Б.Дэлгэрсүрэн, Б.Ганчимэг, С.Нямцэвээн, Ц.Насанжаргал, Д.Занданхүү, Ц.Цолмон, Г.Цэрэнлхам, Э.Нарантуяа, Н.Эрдэнэбат, Ц.Өлзийдүүрэн, Б.Дүйнхэржав, Т.Майдар, Х.Отгонжаргал, Ю.Ариунзаяа, С.Шинэсар, Э.Батпүрэв, Д.Мөнххишиг, М.Манлайбаяр,

# БАЙГУУЛЛАГЫН ХАМТ ОЛОН

С.Чандансамбуу, Б.Сарангэрэл, Ж.Баярсайхан, Ц.Алминцэцэг, А.Ананд, М.Ариунбат, Х.Батноров, Н.Батчулуун, Т.Баярмаа, Н.Болдбаатар, Д.Болдбаатар, Х.Ганбаатар, М.Ганболд, Х.Гантулга, Б.Гантулга, Ц.Гантулга, Н.Ганхуяг, Г.Гэрэлзул, Б.Гүрсэнгээ, Б.Даваадалай, Ч.Оргил, Ө.Дамдинсүрэн, Ж.Лувсанцогзол, Ж.Мөнгөн, Б.Мөнгөн, Д.Сүхболд, Т.Мөнхбаатар, Э.Мөнх-Эрдэнэ, Б.Нарангэрэл, Д.Наранжаргал, Ц.Наранцэцэг, Ш.Отгонбаяр, Б.Оюунбаатар, Б.Пүрэвсүрэн, Ц.Шарав, Э.Сүхбаатар, Н.Тэгшдэлгэр, Э.Уртнасан, С.Цогтбаяр, Б.Түмэн-Өлзий, Н.Наранбаатар, Х.Эрдэнэ Н.Энхболд, Л.Энхжаргал, Д.Энхтайван, Д.Энхбаяр нар.

## НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Ш.Нямдорж,** ерөнхий прокурорын орлогч Ц.Насанбат, А.Цэрэнсодном, ахлах прокурор П.Батболд, Б.Дагвасүндэл, И.Хүдэрцэцэг, Д.Цэцэгбадам, А.Энхжаргал, Н.Энхтуяа, хяналтын прокурор Б.Батсайхан, Г.Батбаяр, Д.Батмөнх, Б.Бямбадагва, Р.Батнасан, Э.Бадрал, Б.Баярхүү, Ч.Бурмаа, Б.Бүжинлхам, П.Ганбаатар, Б.Ганбулган, Ц.Гансүлд, Ж.Ганцэцэг, О.Гэрэл, Б.Нинж, О.Доржмаа, А.Золзаяа, Д.Дэлгэрмаа, Х.Еркебулан, Г.Магнайжав, Ц.Сүхбат, Б.Мэндсайхан, С.Мөнхгэрэл, Ц.Мөнхжаргал, Ч.Мөнх-Эрдэнэ, Ш.Наранчимэг, Ч.Отгонсүрэн, Ц.Отгонсүх, М.Очбадрах, Д.Пүрэвдагва, Г.Сэндэнсүрэн, Э.Халиун, Ч.Хандаамаа, Л.Цогтхүү, Ц.Өлзийжаргал, Б.Энхбат, Д.Энх-Оргил, Г.Эрдэнэ, Д.Эрдэнэсувд;

Тамгын хэлтсийн дарга, ахлах прокурор Ш.Сүхбат, туслах ажилтан Г.Баясгалан, Г.Билгүүн, Б.Дөлгөөн, Б.Дэлгэрмаа Б.Мөнхтулга, Г.Нандин-Эрдэнэ, Д.Цэцэг-Эрдэнэ, Д.Рэгзэдмаа, Г.Шинэтуяа, Т.Эрдэнэтөр, Н.Энхтөр, захиргаа үйлчилгээний ажилтан Д.Алтантуяа, Г.Бямбажав, Г.Галтхуяг, Э.Ганжаргал, Б.Даваадэмбэрэл, Б.Лхамсүрэн, Д.Мягмарсүрэн, Ш.Нарангэрэл, Ш.Мөнхтуяа, Э.Намуун, А.Нандин-Эрдэнэ, Г.Нансалмаа, З.Уянга, Ц.Наранцэцэг, О.Нармандах, Х.Саранцэцэг, Б.Туул, Т.Цэндсүрэн, Т.Энхжаргал нар.

## ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Ц.Арвинбуудай**, ерөнхий прокурорын орлогч Х.Батчимэг, ахлах прокурор Д.Мөнхсайхан, Т.Серикжан, Ч.Энхтуяа, хяналтын прокурор Д.Агар, О.Баасанхүүг, Ч.Батбаатар, Б.Дэлгэрмаа, Б.Чинзориг, Э.Намуун, С.Оюунжаргал, Н.Уранбайгаль, Ц.Оюун-Эрдэнэ, Ж.Энхжаргал;

- Тамгын хэлтсийн дарга Б.Эрдэнэ-Очир, туслах ажилтан Ц.Баатарсүрэн, С.Сүрэнхорол, Н.Цэнгэлбаяр, Н.Энхтулга, С.Төгөлдөр, захиргаа үйлчилгээний ажилтан Б.Алтанцэцэг, П.Баяржаргал, Э.Буянжаргал, М.Мөнхчулуун, М.Мөнх-Эрдэнэ, Н.Очирбат, Ц.Оюунбилэг, С.Сүхбат, М.Ханджаргал, Д.Ядамцоо нар.

## БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор С.Гансэлэм**, ерөнхий прокурорын орлогч Б.Эрхэмбаяр, ахлах прокурор Т.Мандахнаран, Н.Мөнгөнсүх, Х.Саран, Л.Цэндсүрэн, Г.Чагдар, хяналтын прокурор Н.Анхбаяр, М.Анхбаяр, С.Батгэрэл, Б.Батнасан, А.Баясгалан, Г.Билгүүжин, Э.Болор-Эрдэнэ, Г.Ганхөлөг, А.Дүүрэнбилэг, Б.Жаргал, А.Марал, Н.Мөнхбат, Д.Мөнхцэцэг, Н.Мөнхцэцэг, Г.Намжил, Э.Номин-Эрдэнэ, М.Нямжав, Г.Онон, Т.Оюунжаргал, Б.Солонго, Д.Хонгорзул, Д.Үүлэн,

# МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН

С.Цэрэндорж, Н.Энхболд, Г.Эрдэмбаатар, С.Эрдэнэбаяр, Д.Эрдэнэчимэг;

- Тамгын хэлтсийн дарга Т.Болор, туслах ажилтан С.Ариунзул, Э.Баасанбаяр, С.Баатарсүх, Г.Ганцэцэг, Ц.Гэрэлчимэг, О.Даваахүү, Б.Өнөбат, Д.Дэлгэрсүрэн, Э.Уранчимэг, Э.Уганцэцэг, О.Эрхэмбаяр, Б.Өлзийжаргал, М.Амарзаяа, захиргаа үйлчилгээний ажилтан Г.Алтансувд, Э.Ариунзаяа, Г.Багажагай, Г.Баянцагаан, Д.Сугар, Ц.Билгүүн, Р.Даваасайхан, Ч.Дамдиндорж, Б.Оюунжаргал, Б.Золзаяа нар.

## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Ц.Батболд**, ерөнхий прокурорын орлогч А.Бямбацэемаа, ахлах прокурор П.Бадамгарав, Б.Батжаргал, Т.Жаргалсайхан, Г.Лхагвасүрэн, П.Мөнхцэцэг, У.Солонго, хяналтын прокурор А.Ариунаа, Э.Ариунболд, Д.Ариунжаргал, М.Ариунцэцэг, М.Батзаяа, Ю.Батсүх, О.Баярсайхан, П.Болормаа, Б.Болор-Эрдэнэ, Л.Галав, Б.Ганзориг, Ц.Гантулгабат, Ц.Ганцэцэг, Д.Ганчимэг, Э.Гэрэлмаа, Н.Гэрэлмаа, П.Даваасүрэн, Н.Дуламсүрэн, Т.Мөнх-Амгалан, П.Мөнхтуяа, Х.Ням-Эрдэнэ, Ж.Отгонбаяр, Б.Оюунцэцэг, А.Сайнбаяр, Я.Сансар, Б.Тулга, Ч.Түмэн-Өлзий, Б.Уранцэцэг, С.Уянга, Д.Уянга, Г.Цэрэнжамц, К.Чимгээ, С.Чимэдцэеэ, М.Эрдэнэзаяа;

- Тамгын хэлтсийн дарга Ж.Нямдэлгэр, туслах ажилтан Б.Дарханзориг, С.Минжин, Л.Наранхүү, З.Наранчимэг, О.Нүрмаа, Б.Оргилболд, П.Отгонбаатар, Б.Сарантуяа, Б.Саруул-Ирээдүй, Н.Халиунаа, М.Ханджав, Г.Чанцалдулам, Г.Тамир, З.Өлзийхүү, Б.Эрдэнэбаяр, захиргаа үйлчилгээний ажилтан Б.Бат-Эрдэнэ, Д.Батдаваа, А.Дамжин, Б.Доржсүрэн, Л.Минжин, Э.Мөнхсаруул, Д.Ням-Эрдэнэ, Ш.Одонням, Б.Сийлэгмаа, Б.Хонгорзул, Б.Хулан нар.

## СҮХБААТАР ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Э.Амарбат,** ерөнхий прокурорын орлогч С.Батсүрэн, ахлах прокурор Т.Жавхлантөгс, З.Оюундэлгэр, Б.Соёлсайхан, Б.Цоодол, Г.Цэцэгмаа, хяналтын прокурор Ц.Амгаланбаатар, Г.Баярмаа, С.Болорзул, Ц.Буянхишиг, П.Бямбасүрэн, Г.Ганбагана, Ц.Гэрэлбаатар, Д.Даваадорж, Н.Дамбадаржаа, Л.Мажигсүрэн, Б.Мөнгөншагай, Я.Мөнхзаяа, Д.Мөнхтогоо, И.Мөнхцэцэг, Ш.Насанжаргал, Н.Онон, М.Отгонбаатар, Э.Оюунтунгалаг, Г.Сундуй, Н.Түвшинбаяр, Г.Түвшинбаяр, Ш.Хосбаяр, Г.Цогтгэрэл, Т.Цэнд-Аюуш, Б.Цэцэгмаа, Ц.Шагдар, Ж.Энх-Амгалан, З.Энхжаргал, П.Эрдэнэбаатар, С.Эрдэнэтуяа;

- Тамгын хэлтсийн дарга Ч.Ганболд, туслах ажилтан Б.Азжаргал, Д.Аззаяа, Э.Анударь, Н.Анхцоож, Б.Ариунтөр, Ч.Батчимэг, Б.Билгүүн, Г.Булаг-Ундрал, Б.Доржханд, Г.Жаргалсайхан, Т.Төгөлдөр, захиргаа үйлчилгээний ажилтан З.Батболд, Т.Ганчимэг, Т.Дэлгэрмаа, Х.Нямсүрэн, А.Нямцэцэг, Д.Одгэрэл, С.Одончимэг, Н.Пүрэвжав, Т.Хосбаяр, Э.Хэрлэн нар.

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Д.Отгонбаяр**, ерөнхий прокурорын орлогч Б.Уганбаатар, ахлах прокурор Ч.Батбаяр, А.Дэлгэрмөнх, Түмөнхжаргал, Төмөнхжаргал, Б.Насанжаргал, М.Сүхчулуун, хяналтын прокурор М.Амарзаяа, Х.Анхцэцэг, Ц.Ариунтуяа, Р.Батсайхан, Т.Болор-Эрдэнэ, А.Ганзориг, Д.Ганчимэг, Б.Дэлгэрдалай, Г.Золзаяа, О.Мөнхцэцэг, Х.Нарангуа, Д.Нямбат, Х.Онолт, Т.Отгонтөгс, Ж.Отгончимэг, Р.Очирсүрэн, О.Пүрэвсүрэн,

# БАЙГУУЛЛАГЫН ХАМТ ОЛОН

М.Сансарсайхан, Ж.Сувданчимэг, А.Тунгалагтуяа, Д.Туяана, Н.Ундрах, Б.Ундрах, Д.Ууганцэцэг, Э.Чанцалням, Б.Чинбилиг, С.Энхням, Б.Энэрэл, Г.Яндаг;

- Тамгын хэлтсийн дарга Б.Солонго, туслах ажилтан Ш.Анужин, А.Батбаатар, М.Билгүүтэй, Б.Нямсүрэн, Ц.Сэргэлэнбаатар, Ш.Төгсбуян, Б.Уранбилэг, Г.Хурмандах, Ш.Цэрэнханд, Н.Энхбуян, А.Өсөхбаяр, Захиргаа үйлчилгээний ажилтан Д.Атарболд, Г.Ган-Эрдэнэ, Б.Ганчимэг, Ш.Доржнямбуу, Л.Отгончимэг, Б.Оюунчимэг, С.Пүрэвдорж, Н.Сарантуяа, Д.Шинжээравдан, Н.Энхгэрэл, М.Өлзийбаатар нар.

## ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор О.Алтангэрэл**, ерөнхий прокурорын орлогч Б.Чинбат, ахлах прокурор Б.Гипэлмаа, Х.Жанибек, Г.Мижиддорж, Н.Оюунцэцэг, Н.Оюунцэцэг, хяналтын прокурор Б.Алтанцэцэг, Ш.Алтацэцэг, П.Болормаа, Ц.Ганчимэг, Б.Гүнсэл, Т.Мижиддорж, Н.Нарангэрэл, Д.Нямсүрэн, Б.Одонтуяа, Ц.Отгонсүрэн, Н.Пүрэвтогтох, Б.Соёлмаа, С.Ууганбаяр, Б.Хурц, П.Энхболд, М.Энхтунгалаг, Х.Эрдэнэтуяа, Г.Эсэн;

- Тамгын хэлтсийн дарга З.Энхмаа, туслах ажилтан Г.Ган-Эрдэнэ, Э.Мандуул, М.Мөнхсүрэн, Б.Очгэрэл, Г.Ундрах, Н.Чингүн, Б.Үүрийнтуяа, захиргаа үйлчилгээний ажилтан Б.Батбаяр, Г.Баяржаргал, Л.Бөхгэрэл, Ж.Ганчимэг, О.Одончимэг, Т.Оюунчимэг, А.Оюунчимэг, Ө.Хорлоо, О.Хосбаатар, Г.Энхтуул, Г.Эрдэнэ-Оргил, Р.Өлзийтэгш нар.

## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор С.Хишигжаргал**, ерөнхий прокурорын орлогч Т.Оргил-Очир, ахлах прокурор Б.Байгалмаа, Ж.Бат-Эрдэнэ, П.Нямцэцэг, А.Оюунгэрэл, Д.Цогт-Эрдэнэ, хяналтын прокурор Н.Алтантүлхүүр, Г.Анармөнх, И.Ариунсанаа, О.Багшбаяр, Ц.Батбямба, Б.Баярчимэг, Н.Булганчимэг, Х.Даваадулам, П.Итгэл, Ц.Майбаяр, А.Нямсүрэн, Д.Оюунгэрэл, Б.Сод-Эрдэнэ, С.Солонго, Г.Ууганбаатар, Ц.Хулан, Б.Чимгээ, М.Энхбаатар, Р.Энх-Оюун, С.Энхтуул;

-Тамгын хэлтсийн дарга Х.Түвшинтөгс, туслах ажилтан Г.Ариунзул, Х.Билгүүн, З.Бат-Амгалан, Б.Бат-Эрдэнэ, С.Баярчимэг, Г.Пунсэлмаа, Б.Урангоо, захиргаа үйлчилгээний ажилтан Ж.Болдбаатар, Ж.Буянбат, Д.Ганболд, Л.Нарангоо, С.Отгонпагам, Т.Отгонцэцэг, Б.Туяа, Д.Цэдэвсүрэн, А.Цэрэнлхам, Н.Шүрээ, Б.Эрхэмжаргал нар.

## БАГАНУУР ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Н.Энхтуяа**, ерөнхий прокурорын орлогч Б.Одхүү, ахлах прокурор Н.Ихбаяр, хяналтын прокурор Б.Буяндэлгэр, Ж.Бүрэнжаргал, Н.Ганчимэг, Д.Дашцэрмаа, Тамгын хэлтсийн дарга Б.Нарангэрэл, туслах ажилтан С.Ганхүү, Э.Мөнх-Оргил, Т.Түмэнжаргал, Д.Нансалмаа, захиргаа үйлчилгээний ажилтан Г.Ариунбат, Г.Батболд, Ч.Батчимэг, Т.Баярмагнай, А.Ганчимэг, Л.Ганчимэг, З.Оюунбаатар, Ц.Өлзийбатнар.

# МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН

## НАЛАЙХ БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Х.Баярмаа**, ахлах прокурор Ж.Цэцэгмаа, хяналтын прокурор Д.Аянагүл, Ч.Пүрэвсүрэн, Ц.Цэрэнбалжир, С.Цэрэндалай, С.Энхмаа, тамгын хэлтсийн дарга О.Алтансүх, туслах ажилтан Б.Амгаланбуянт, Л.Анар-Эрдэнэ, Н.Одонтуяа, А.Аззаяа,захиргаа үйлчилгээний ажилтан С.Анхбаяр, Н.Дарьсүрэн, А.Мэндбаяр, Э.Отгонбаатар, Б.Уганбаяр, С.Цогтбаатар, Н.Цэгмэд, Ц.Эрдэнээ нар.

## АРХАНГАЙ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Д.Жамбалсүрэн**, ерөнхий прокурорын орлогч Ш.Наранчимэг, хяналтын прокурор С.Батсүх, С.Бичинхүү, Б.Буяндалай, Б.Мээпам, Ц.Сайнзаяа, Б.Сүхбаатар, Тамгын хэлтсийн дарга Ж.Ундармаа, туслах ажилтан Э.Гэрэлтуяа, Ц.Чингүүн, захиргаа үйлчилгээний ажилтан Н.Батбаяр, Б.Баянбат, С.Доржринчин, Т.Оюунбат, Б.Пүрэвдорж,Ч.Сарангуа, С.Цэцэглэн нар.

## БАЯН-ӨЛГИЙН АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Т.Батсүх**, ерөнхий прокурорын орлогч А.Турдыбек, ахлах прокурор А.Еркегүл, М.Отгонжаргал, хяналтын прокурор Б.Ботакез, М.Парида, Х.Өрен, Тамгын хэлтсийн дарга Р.Гүлбарим, туслах ажилтан М.Арманбек, Б.Зэлмэ, захиргаа үйлчилгээний ажилтан РАюбек, А.Бейбит, Б.Гүлбати, Б.Ермурат, М.Мягмар, З.Мягмарсүрэн, Б.Номин-Эрдэнэ, С.Нуржан, А.Сүлеймен нар.

## БАЯНХОНГОР АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Н.Амарсанаа,** ерөнхий прокурорын орлогч Б.Билэгсайхан, ахлах прокурор Д.Эрдэнэсоёл, хяналтын прокурор Б.Баторгил, Т.Баянмөнх, Э.Баянмөнх, В.Дэлгэрмаа, Г.Цогтмагнай, Тамгын хэлтсийн дарга Б.Төрболд, туслах ажилтан Ж.Баянжаргал, Э.Уламбаяр, захиргаа үйлчилгээний ажилтан Б.Баатархүү, Ч.Бодибямбаа, Д.Гантуяа, Д.Ганцэцэг, Ч.Нарандаваа, Д.Цэнд-Аюуш нар.

## БУЛГАН АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Н.Мөнхнаран**, ерөнхий прокурорын орлогч Н.Доржсүрэн, хяналтын прокурор Э.Гантулга, М.Сайнзаяа, Ц.Сувдаа, Д.Сүрэнхор, П.Шижиртуяа, Тамгын хэлтсийн дарга Б.Энх-Амгалан, туслах ажилтан А.Номин, З.Хүслэн захиргаа үйлчилгээний ажилтан С.Ариунаа, М.Ламчин, Б.Нэргүй, Ж.Тавхай, Д.Түвшинбаяр, А.Уранцэцэг, Д.Уганбаяр, Д.Энхбаяр нар.

## ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Б.Ганбаатар,** ерөнхий прокурорын орлогч Ц.Сайнхүү, хяналтын прокурор Д.Бат-Эрдэнэ, Х.Гүнжидмаа, А.Оргилбаяр, Б.Оюунцэцэг, Тамгын хэлтсийн дарга Б.Түвшинтөр, туслах Д.Батнасан, Д.Жамсран захиргаа үйлчилгээний ажилтан Н.Азжаргал, Ж.Алдармаа, О.Батбаясгалан, Г.Буяннэмэх, Х.Дэлгэрмаа, Д.Мөнхбаяр нар.

# БАЙГУУЛЛАГЫН ХАМТ ОЛОН

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Д.Мөнгөнцэцэг**, ерөнхий прокурорын орлогч Б.Мөнхдөл, хяналтын прокурор А.Аварзэд, Ш.Батсүх, Э.Нэргүй, Э.Нямбилэгт, Тамгын хэлтсийн дарга Ц.Төгөлдөр, туслах ажилтан Л.Номинчулуун, М.Сумьяа, захиргаа үйлчилгээний ажилтан Д.Ганбаатар, Б.Жавзан, Б.Лхамсүрэнжав, Л.Отгонбаяр, Б.Отгонцэцэг, Д.Самданбазар, У.Сэрод, М.Цолмон нар.

## ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор С.Ёндонсамбуу,** ерөнхий прокурорын орлогч У.Дэндэвдорж, ахлах прокурор Б.Сүрмандах, Э.Улаанаа, Д.Энхтуяа, хяналтын прокурор Б.Батсүх, Ч.Болормаа, Т.Дэлгэрмэнд, Ч.Мядагбадам, К.Нанжинханд, Д.Номин-Эрдэнэ, Г.Уянга, Ц.Цэенойдов, туслах ажилтан Б.Батжаргал, А.Эрдэнэдэлгэр, Б.Өнөрөө, захиргаа үйлчилгээний ажилтан Х.Алдарбаясгалан, Д.Баяржаргал, Ө.Баярмагнай, Б.Баярцэцэг, Н.Бурмаа, Б.Ганханд, Р.Нэргүй, З.Пүрэвдорж, Б.Уранцэцэг, Т.Хүрэлбаатар нар.

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор С.Цэрэнсамбуу,** ерөнхий прокурорын орлогч Д.Ширэндэв, ахлах прокурор Ж.Айжуу, Г.Ганцэцэг, хяналтын прокурор Э.Ариунболд, Д.Дэлгэрбаяр, Б.Мөнгөнтуяа, Ө.Мөнхнавч, Г.Энэрэл, туслах ажилтан Д.Ган-Эрдэнэ, Д.Зуунай, Ц.Цэрэндулам, захиргаа үйлчилгээний ажилтан Л.Амарсайхан, Б.Анхбаяр, Д.Батзангиа, Д.Одхүү, С.Гэрэлсайхан, Ж.Ижилболд, С.Лхагвадорж, Д.Наранцэцэг, Б.Энхжин нар.

## ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Д.Энхбаяр**, хяналтын прокурор Б.Догмиддорж, Г.Мөнхтүвшин, Л.Содбаяр, Э.Болор, туслах ажилтан Э.Батзолбоо, Г.Цогням, захиргаа үйлчилгээний ажилтан Т.Батням, Б.Баттулга, М.Болор, С.Гантуул, Д.Номинцэцэг, Б.Хүрэлшагай, Д.Цэнджаргал, Г.Чулуунзагас, С.Шинэбаяр нар.

## ДОРНОД АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Т.Ууганбаатар,** ерөнхий прокурорын орлогч Б.Арсланбаатар, ахлах прокурор Д.Нямдэлэг, С.Алтай, хяналтын прокурор А.Алтангэрэл, С.Ариунаа, Т.Батжаргал, Д.Ганчимэг, Ч.Мөнхзул, Б.Төрболд, Э.Хосбаяр, туслах ажилтан О.Мөрөн, Ө.Эрдэнэмөнх, О.Мөнхтуяа, захиргаа үйлчилгээний ажилтан Ж.Алтанжимс, Г.Наранцацралт, С.Номинчимэг, Б.Саранчимэг, Л.Төмөрболд, Т.Хишигжаргал, Х.Хотолбаяр нар.

## ДУНДГОВЬ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Ч.Бямбажаргал**, ерөнхий прокурорын орлогч Х.Мөнхбаатар, ахлах прокурор Д.Баянмөнх, хяналтын прокурор Б.Батцэцэг, М.Оюунбат, Г.Хаш-Эрдэнэ, М.Үрэлцэцэг, Тамгын хэлтсийн дарга Ц.Нэргүй, туслах ажилтан Б.Уртнасан, А.Энхжаргал, захиргаа үйлчилгээний ажилтан Д.Бат-Эрдэнэ, Ц.Баярсайхан, Г.Дэлгэрзаяа, Д.Мөнхтуяа, У.Намуунбайгаль,

# МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН

Д.Нэргүй, М.Сундуйжав, Ц.Цэрмаа, Д.Эрдэнэхуяг нар

## ЗАВХАН АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Ц.Дэнсмаа**, ерөнхий прокурорын орлогч Н.Цогтбаяр, ахлах прокурор Ц.Эрдэнэтуяа, хяналтын прокурор Н.Баасанжав, Д.Түвшинтөгс, Д.Шинэбал, Б.Эрхэмбаяр, Тамгын хэлтсийн даргаЧ. Дэлгэрмаа, туслах ажилтан Б.Бавуудорж, Э.Гантулга, захиргаа үйлчилгээний ажилтан П.Адилбиш, Б.Анхбаяр, Д.Ганбат, Ш.Жаргалсайхан, Т.Мөнхцэцэг, Ж.Оюунгэрэл, Б.Угтахболд, Б.Цэцэгмаа, Д.Энхтөр нар.

## ТОСОНЦЭНГЭЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Ч.Алтансүх,** хяналтын прокурор Б.Нямжав, Б.Сансарбаяр, Б.Чулуунхүү, туслах ажилтан Ш.Дорж-Очир, М.Мөнхтайван захиргаа үйлчилгээний ажилтан П.Бадамгарав, Н.Бархүү, Л.Жаргал, Э.Нямдорж, М.Оюунболд, П.Пүрэвсүрэн нар

## ОРХОН АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Л.Батгэрэл**,ерөнхий прокурорын орлогч Ц.Идэрмөнх, ахлах прокурор Б.Жавхлантуяа, Ц.Мөнхтуяа, Ч.Сэлэнгэ, хяналтын прокурор С.Батмөнх-Очир, Н.Дүүрэнжаргал, Ц.Лхамсүрэн, Л.Оюунтуяа, Б.Оюун-Эрдэнэ, Л.Энхтайван, Тамгын хэлтсийн дарга Г.Анх-Ирээдүй, туслах ажилтан Б.Долгорсүрэн, Ц.Пүрэвдорж, Г.Эрдэнэзул, захиргаа үйлчилгээний ажилтан С.Баасансүрэн, М.Байгальмаа, Э.Баттөр, Ч.Данбаяр, Н.Отгонбат, Д.Цогбадрах, Ш.Чагнаа, З.Энхжаргал, Б.Үржинням нар.

## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Ш.Дамдинбазар**, ерөнхий прокурорын орлогч Д.Цогбадрах, ахлах прокурор Д.Ганцэцэг, Ч.Энхжаргал, хяналтын прокурор А.Амарсанаа, У.Анхжаргал, Г.Цолмонгэрэл, Б.Энхбаяр, Тамгын хэлтсийн дарга Т.Ганбат, туслах ажилтан Б.Мөнхжаргал П.Нарантуяа, Т.Алтан-түлхүүр, захиргаа үйлчилгээний ажилтан Х.Адьяасүрэн, Ш.Батсайхан, Б.Баярхүү, Ц.Доржзовд, Л.Лхагвацэрэн нар.

## ХАРХОРИН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Ш.Баасандорж**, хяналтын прокурор Б.Амартүвшин, Б.Энх-Эрдэнэ, Н.Өнөрбаяр, Д.Алимаа, туслах ажилтан Б.Байгаль, Г.Тунгалаг, захиргаа үйлчилгээний ажилтан Д.Бадамцэцэг, Н.Батзориг, С.Бат-Орших, С.Гандолгор, Г.Гүн-Эгшиглэн, П.Жамъяансүрэн, М.Шаравдорж

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Н.Ганбат,** ерөнхий прокурорын орлогч Т.Нансалмаа, ахлах прокурор А.Амгалан, Д.Мөнхтуяа, хяналтын прокурор Л.Солонго, Ц.Ариунжаргал, Г.Ганбаяр, Тамгын хэлтсийн дарга Д.Уранчимэг, туслах ажилтан Ц.Ганхөлөг, С.Нармандах, Х.Галхүү, захиргаа үйлчилгээний ажилтан О.Бат-Отгон, Н.Батсуурь, Г.Баярсайхан, Б.Одгэрэл, Д.Оюунчимэг, Л.Солонго, У.Эрдэнэбат нар.

# БАЙГУУЛЛАГЫН ХАМТ ОЛОН

## ХАНБОГД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Б.Энхмэнд,** хяналтын прокурор Б.Амармөрөн, В.Төгсбаяр, О.Батнасан, туслах ажилтан О.Дэлгэр, С.Энхзул, захиргаа үйлчилгээний ажилтан А.Амарсанаа, Х.Ганцэцэг, Б.Диваажий, Э.Нансалмаа, Н.Нэргүй нар.

## СҮХБААТАР АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор У.Золжаргал**, ерөнхий прокурорын орлогч Л.Мөнхбаяр, ахлах прокурор Д.Баттулга, хяналтын прокурор Г.Лхагвасүрэн, Ц.Роза, С.Сугар, Д.Хорлоо, Тамгын хэлтсийн дарга Ц.Шүрэнцэцэг, туслах ажилтан Ц.Доржпүрэв, Х.Насанжаргал, захиргаа үйлчилгээний ажилтан Д.Баяртөгс, Ц.Ганболд, С.Нансалмаа, М.Отгонбат, Г.Ренчинсамбуу, Л.Туул, П.Төгсжаргал, Ц.Эрдэнэбаяр нар.

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Т.Мөнхбаяр,** ерөнхий прокурорын орлогч Б.Энхтулга, ахлах прокурор С.Батзул, Г.Энхмаа, хяналтын прокурор А.Ариунзаяа, В.Батдэлгэр, Т.Нансалмаа, А.Энхтуяа, Тамгын хэлтсийн дарга Н.Алтанчимэг, туслах ажилтан Г.Манилцэцэг, Г.Янжиндулам, Б.Ариунсайхан, Б.Мандалмаа, захиргаа үйлчилгээний ажилтан Б.Батцоож, Д.Ганзориг, Н.Ганхуяг, Ш.Дагважамц, С.Норовбадам, Ө.Саянжамц, Б.Цэцэгмаа, Н.Эрхэмбаатар нар.

## МАНДАЛ СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Б.Эрхэмбаатар**, хяналтын прокурор Я.Амарзаяа, О.Нандинцэцэг, Б.Тэгшбаяр, Н.Улсболд, Т.Солонго, туслах ажилтан Б.Хишигсувд, захиргаа үйлчилгээний ажилтан О.Гэрэлт-Од, Ч.Мөрөн, Д.Отгонбаяр, З.Сайханаа, Г.Энхцэцэг, Э.Эрдэнэчимэг, Д.Бат-Ирээдүй нар.

## САЙХАН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Н.Эрдэмбилэг**, хяналтын прокурорН.Бадам, Т.Дэлгэрсайхан, туслах ажилтан Э.Батгэрэл, Б.Лхамдэгд, Б.Энхжилзахиргаа үйлчилгээний ажилтан Д.Дашдорж, М.Мөнхтулга, О.Наранцацрал, Н.Уганбаяр, Ш.Шинэцэцэг нар.

## ТӨВ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Ц.Нямтайван**, ерөнхий прокурорын орлогч Б.Долгион, ахлах прокурор Э.Идэрбат, Д.Нэргүй, М.Хэрлэнчимэг, хяналтын прокурорА. Азжаргал, Э.Билгүүн, М.Гансувд, П.Даваасүрэн, Х.Оюунцэцэг, Ц.Сонинмөнх, Б.Сувд-Эрдэнэ, Л.Төгсжаргал, Т.Төмөртулга, Г.Энхбат, Тамгын хэлтсийн дарга Э.Уянга, туслах ажилтан Б.Энхбаяр, У.Маралмаа, Н.Саран, Э.Ундармаа, Э.Жаргалбаяр, захиргаа үйлчилгээний ажилтан Ш.Баянжаргал, П.Бэхбат, Р.Гэрэл-Эрдэнэ, Ч.Даваасүрэн, Г.Мөнхбаатар, Ч.Номин, Б.Отгонбаяр, Б.Цогтгэрэл, Ж.Энхцог нар.

## УВС АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Д.Галбадрах**, ерөнхий прокурорын орлогч Б.Баярмагнай, ахлах прокурор С.Нандинцэцэг, хяналтын прокурор А.Анхбаяр, Я.Дима, П.Удвал, Х.Энхтуул, Тамгын хэлтсийн дарга Д.Пүрэвчагчаа, туслах ажилтан Х.Төгөлдөр, Д.Сүрэнхорлоо, П.Насанбат, Ц.Нямжав, захиргаа үйлчилгээний ажилтан Б.Мөнхлхагва, О.Оюунчимэг , Б.Цогзолмаа, Э.Цэвээнгэрэл нар.

## ХОВД АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Б.Гантулга**, ерөнхий прокурорын орлогч Н.Бат-Эрдэнэ, ахлах прокурор Ш.Сувд-Эрдэнэ, хяналтын прокурор З.Алтансолонго, Б.Батцоож, Д.Дуламжав, Э.Уганзаяа, Тамгын хэлтсийн даргаД.Ганчимэг, туслах ажилтан Ц.Батзаяа, Л.Галбадрах, Б.Энхтулга, захиргаа үйлчилгээний ажилтан Я.Батболд, Д.Буянбат, Б.Лхагвадаш, Н.Төмөрхүү, Б.Төртогтох, А.Энхтүвшин нар

## БУЛГАН СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Б.Батбаяр**, хяналтын прокурор Б.Оюунцэцэг, Э.Алтанцэцэг, туслах ажилтан А.Дорждэрэм, Д.Минсэл, захиргаа үйлчилгээний ажилтан Б.Баатарцол, Д.Батбаяр, Д.Батболд, Ц.Батхишиг, Г.Мөнхзаяа, Д.Оюунхүү нар.

## ХӨВСГӨЛ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Н.Батмөнх**, ерөнхий прокурорын орлогч Г.Баяраа, ахлах прокурор Б.Болд, ахлах прокурор Л.Отгончимэг, хяналтын прокурор Д.Батзаяа, Ч.Батзориг, Г.Баянбилэг, М.Берикбол, Ц.Мөнхжаргал, Б.Наранмөнх, Тамгын хэлтсийн дарга Н.Гантулга, туслах ажилтан Б.Чулуунцэцэг, Г.Бат-Оргил, Ш.Баттөмөр, Ж.Дарьсүрэн, захиргаа үйлчилгээний ажилтан Б.Батзориг, Д.Лхагвасүрэн, Б.Солонго, Д.Шинэтуяа, Г.Өлзийсайхан нар.

## ХЭНТИЙ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Б.Одгэрэл**, ерөнхий прокурорын орлогч Ц.Бямбадорж, ахлах прокурор Д.Отгонтуяа, хяналтын прокурор Ж.Батбаатар, Т.Баярмаа, Б.Бямбасүрэн, М.Гэрэлбадрах, Г.Мөнхболд, М.Нарантуяа, Тамгын хэлтсийн даргаШ.Оюундалай, туслах ажилтан Т.Тунгалагтуяа, Д.Чулуунпүрэв, Э.Азжаргал, захиргаа үйлчилгээний ажилтан Б.Байгалмаа, Г.Баттулга, Д.Дэлгэрмөрөн, Д.Оюунболор, Г.Оюунгэрэл, Ш.Цогтбаатар нар.

## БОР-ӨНДӨР СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН ГАЗАР

- **Ерөнхий прокурор Б.Ичинхорол**, хяналтын прокурор М.Мэндбаяр, Н.Амаржаргал, туслах ажилтан Н.Амгалан, С.Бат-Орших, захиргаа үйлчилгээний ажилтан М.Эрдэнэтогтоол, Ш.Алтантуяа, Ц.Ариунтуяа, Д.Болор-Эрдэнэ, Б.Золбаяр, нар.

# МИНИЙ АМЬДРАЛЫН МАРТАГДАШГҮЙ ӨДРҮҮД

### Хэсгийн прокуророор томилогдов

Миний бие 1982 онд Хууль цаазны дунд сургууль төгсөөд Төв аймгийн прокурорт хэсгийн прокуророор томилогдон очиход Монгол Улсын ууган гавьяат хуульчдын нэг О.Лхамсүрэн, арвин туршлагатай ахмад прокурор З.Батсүх, С.Балжинням, мөрдөн хяналтын туслах прокурор Ж.Чойжанцан, хэсгийн прокурор Д.Нэргүй, Г.Дашзэвэг, мөрдөн байцаагч Ш.Гандарьяа, Б.Цэрэнсодном, нарийн бичгийн дарга Д.Лхагвадондог нарын ажилтнууд угтсан.

Аймгийн прокурорын орлогч З.Батсүх гуайн үүдний давчуухан өрөөнд хэсгийн прокурорууд сууж түүний шууд удирдлаганд ажиллана. МУИС-д суралцахаар одож буй Х.Мерейханаас миний бие төрийн сүлд бүхий хэсгийн прокурорын тамга, албан бланк, лацны тэмдэг, ширээ сандал, төмөр сейп, олон хавтас баримт материал хүлээн авч, Төв аймгийн баруун хойд Аргалант, Баянхангай, Лүн, Заамар, Угтаалцайдам, Цээл сумдыг хариуцсан 6 дугаар хэсгийн прокурор ажиллаж билээ. Тэр үед хэсгийн прокурорын ажлын онцлог нь гэмт хэрэг зөрчлүүдийг газар дээр нь шүүхтэйгээ хамт нүүдэллэн шийдвэрлэнэ. Миний хувьд ахмад туршлагатай шүүгч Д.Шараа, шинэ залуухан шүүгч Хүрэлбаатар, хуучин манай прокурорт мөрдөн байцаагч байсан өмгөөлөгч Г.Даш нартай хамтран сумандаа нүүдэллэн ажилладаг байв.

1982 оны 8 сард Ж.Чойжанцан прокурор аймгийн прокурорын ажлаа авч, 1983-1986 онуудад дээд мэргэжлийн олон хуульч Төв аймагт томилогдон ирэв. Орлогч прокуророор Д.Жамбалдорж, хэсгийн прокуророор Д.Лхагвадондог, Г.Будаев, Ж.Чимгээ, Л.Ганболд, С.Болдбаатар, мөрдөн байцаагчаар Ц.Туул, нарийн бичгийн дарга Д.Үдмандах, Г.Долгормаа нарын шижигнэсэн залуус ажиллаж байлаа. Тэр үед Төв аймгийн хэмжээнд ээдрээ төвөгтэй олон хэргүүд шил дараалан гарч ачаалал үлэмж ихэссэнээс Д.Догсом, Гүрбазар нарын туршлагатай прокурорууд төвөөс томилогдон ирэв.



### Мөрдөн байцаагчийн өрөө

Миний бие нэг жил хүрэхгүй хугацаанд хэсгийн прокурор хийгээд 1983 оны 4 дүгээр сард мөрдөн байцаагчаар томилогдсон. Тэр үед мөрдөн байцаагчийн өрөө нь тусгайлан доторлож тохижуулсан, зохих техник, тоног төхөөрөмжтэй, түүнээ суудал дээрээсээ шууд удирдан ажиллуулна. Ширээн дээр бичгийн болон тооны машин, магнитфон, микропон, фото зургийн аппарат, радио, телефон зэрэг зүйл байхаас гадна мөрдөн байцаагчийн цүнх, шугам, сампин зэрэг бичиг хэрэгслэлийг агуулсан шургуулга гарын дор байв. Сэжигтэн, яллагдагч суух тусгай сандал ширээтэй. Тэдгээр нь энгийн үед эвхэгддэг хананд байрлаастай. Гэрэл зургийг сандал дээр нь шууд авах тохиргоотой “Зенит” аппарат ширээн дээрээс байцаагдаж буй хүн рүү “ширтэх” нь сэтгэл зүйн хувьд тийм ч таатай бус. Өрөөний үүдэнд мөрдөн байцаалт явагдаж буйг илэрхийлсэн гэрэл анивчихын зэрэгцээ чанга яригчаар орох зөвшөөрөл өгдөг нь энгийн хүнд айж сүрдэм байж билээ. Гэхдээ энэ нь төрийн онцгой төлөөлөгч мөрдөн байцаагчийн нэр сүрийг өргөсөн зүйл байсан юм. Мөрдөн байцаагчийн цүнхэнд гэхэд хэргийн газрын үзлэгт оролцоход шаардагдах элдэв төрлийн бодис, ул мөр бэхжүүлэх багаж хэрэгслүүд гээд хэрэгтэй бүхэн байх.

### Хамт олны дэм хамгийн чухал

Манай аймгийн прокурорын газар 1984 онд Мал эмнэлгийн дэргэдэх хуучин байрнаасаа нүүж Холбооны байранд ороход миний бие сантехникч П.Базаргүрэвийн хамт мөрдөн байцаагчийн өрөөгөө нүүлгэж өдөр нь ажлаа хийгээд шөнө голдуу ажиллан хуучнаас нь дордуулахгүйгээр тохижуулсан юм. Ер нь тэр үед аймгийн прокурор Ж.Чойжанцан, орлогч прокурор Д.Жамбалдорж нар олон зүйлийг санаачлан хийсэн. Бидэнд ямар л үүрэг өгнө тэр бүхнийг чадахгүй, мэдэхгүй гэж цааргалдаг хүн байгаагүй. Д.Жамбалдорж прокурор зурсан юм шиг уран бичнэ. Тэр үеийн аймгийн прокурорын газрын өнгө зүс нь түүний гараас амилсан хаягнаас эхлээд самбар үзүүлэнгүүдээс харагдана. Бид үндсэн ажлаас гадна аймгаас зохиох ажил бүрт дайчлагдана. Авдар уулын ард гар шимээсгээр өвс хадацгааж, аймгийн төвийг тохижуулах субботникийн ажилд ханцуй шамлан орно. 1983 онд хавар, зунгүй өдөр нь субботник хийгээд оройжингоо хэрэг материалтайгаа ноцолдоно. Ийнхүү би 1986 оны 8 дугаар сар хүртэл аймгийн прокурорт чухал хэргийн мөрдөн байцаагчаар ажиллаад МУИС-д суралцахаар мордсон.

### Тэргүүн туршлагад тооцогдов

Энэ хугацаанд мөрдөн байцаалтын ажилд маань амжилт гарч 1985 онд болсон Мөрдөн байцаах ажилтны улсын 4 дүгээр зөвлөгөөнд төлөөлөгчөөр сонгогдож, мөрдөн байцаалтын ажлаараа улсад нэгдүгээр байранд шалгарч, Улсын прокурорын хүндэт самбарт зураг маань тавигдаж байлаа. Мөн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар хяналтын карт”, “Зурагт схемний эх загвар”-ыг санаачлан туршсан маань улсын хэмжээнд мөрдөж ажиллах тэргүүн туршлагад тооцогдон Улсын Ерөнхий прокурорын тушаал гарч байсан билээ. Энэ нь намайг удирдан залж, урам өгч байсан аймгийн прокурор О.Лхамсүрэн, Ж.Чойжанцан, орлогч прокурор З.Батсүх, Д.Жамбалдорж, мөрдөн хяналтын туслах прокурор О.Дорж, Г.Хужаа, мөрдөн байцаагч Ж.Чимгээ нарын болон манай хамт олны хөдөлмөрийн үр дүн байсан юмаа.

### Шилжилтийн хүнд үед шийдвэр гаргалцав

Төв аймгийн прокурорын газрын ажилч, хөдөлмөрч, алдар гавьяа дүүрэн хамт олны нэг эд эс болж 1980-аад онд ажилласан тэр дөрвөн жил бол миний цаашдаа өсч дэвших өндөр гишгүүрийн нэгэн том даваа, амьдралын том сургууль болсон юм. Энд олсон нэр хүнд, туршлагаараа хожим 1994-1996 онуудад Монгол Улсын Ерөнхий прокурорын туслах, Тамгын газрын даргаар, Ерөнхий прокурор Н.Ганбаяр болон өөрийн ууган дарга Ерөнхий прокурорын орлогч Ж.Чойжанцан, орлогч прокурор Ж.Энхнасан нарын удирдлага дор ажиллах завшаан надад тохиолдож билээ.

1990-ээд оны прокурорын байгууллагын шилжилтийн хүнд хэцүү үед түүний удирдах дээд байгууллагад ажиллах амаргүй ачааг нь үүрэлцэж, прокуроруудыг дүрэмт хувцас, цол зэрэг дэвтэй, төв, орон нутгийн прокурорын газрыг бэлэгдэл, унаа машинтай, дунд мэргэжлийн прокуроруудыг дээд мэргэжилтэй болгох ажлыг удирдлагын зааврааар зохион байгуулалцаж явлаа. Тэрчлэн Тайваньд прокуроруудыг мэргэжил дээшлүүлэх сургалтанд анх удаа хамруулж уг группийг ахлан явж байв. Миний энэхүү зүтгэлийг үнэлэн 1998 онд Улсын Ерөнхий прокурор Н.Ганбаяр “Прокурорын хүндэт ажилтан” цолоор шагнасан бөгөөд өдгөө ч өөрийгөө хурандаагийн дайтай “Хууль цаазын итгэмжит зөвлөх”-ийн зэрэг дэвтэй хуучин прокурорын нэг гэж бодном. Өөр нэгэн бахархал бол манайх гэр бүлээрээ прокурор айл. Миний хань Цэвээндоржийн Сайнгэрэл надтай хамт сургууль төгсөж, нийслэл, дүүрэг, Улсын прокурорын газарт хяналтын прокуророор олон жил ажилласан.

Ийнхүү ажил амьдралын маань амин холбоо прокурорын байгууллагын сайхан хамт олондоо сэтгэл сүслэн талархаж явдгаа үүгээр илэрхийлэхэд таатай байна.

*Ширчингийн Сүхбаатар*

# НОМ ЗҮЙ


-Хууль, дүрэм, тогтоолын эмхэтгэл. УБ 1947 он

-Ю.Цэдэнбал. МАХН-ын Төв Хорооноос Намын XII их хуралд тавьсан тайлан илтгэл ба түүнд гаргасан тогтоол . УБ 1954 он

-БНМАУ-ын Их, бага хурал. Үндсэн хууль тунхагууд УБ 1956 он

-МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ 1967 он

-МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд (1951-1970). III дэвтэр. УБ 1970 он

-БНМАУ-ын Үндсэн хуульд холбогдох актын эмхэтгэл, 1 дэвтэр. 1972 он

-МАХН-ын товч түүх. УБ 1985 он

-Монгол Улсын хууль. Эмхэтгэл. Дөрөвдүгээр боть

-Монгол Улсын Прокурорын байгууллагын түүхэн замнал-80 жил. УБ., 2010 он

-Монгол Улсын түүх 5 дугаар боть. УБ 2003 он

-ҮТАГ, Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн тогтоол хн 161-р тал

-ҮТАГ, Шүүх Явдлын Яамны архив хн-184-186 дугаар тал.

-ТЕГ-ын Тусгай архив, хн

-ҮТАГазар Ф-2Н4 Ардын СнЗ-ийн тогтоолуудаас

-ҮТАГ, УБХТ-ийн тогтоолууд

-ҮТАГ Улсын прокурорын тушаалаас.

-Б.Жамбалдорж. “Дардан бус замаар далаад жил”. УБ 1996 он

-Ц.Бүдханд. Прокурорын түүхэн замналаас-70 жил. УБ 2000 он. Редактор Ш.Сүхбаатар

-Б.Доржсүрэн. Төрийн нэрийн өмнөөс. УБ 2000 он

-Б.Чимид. Зохистой тогтолцоог баримжаалах нь эрх зүйн шинэтгэлийг үр нөлөөтэй хийх үндэс болох нь. Прокурорын ном. УБ 2001 он

-Гавьяат хуульч С.Батсүх гуайн дурсамж, УБ 2003 он

-Ж.Авхиа. Хос морьтой холын замд. УБ 2003 он

-Б.Жанчив. Д.Ёндондүйчир. УБ., 2007 он

-Б.Гантулга. Өвгөн прокурорын дурсамж. УБ 2007 он

-Б.Цэрэнбалтав, Б.Амарбаясгалан. Прокурорын хяналт. УБ 2009 он

-Н.Мөнхцэцэг, Б.Батхуяг. Нийслэлийн Прокурорын газар. УБ 2010 он

-Б.Өнөрмаа, У.Эрдэнэтуяа. Прокурорын байгууллагын түүхэн замнал, үйл ажиллагаа, цаашдын хөгжлийн чиг хандлага. УБ 2015 он

-Ш.Сүхбаатар. Эр хүн. УБ 1998 он

-Ш.Сүхбаатар. Монголын хуульч эрдэмтэд. УБ 2006

-Ш.Сүхбаатар. Төв аймгийн прокурорын түүхэн товчоон. УБ 2010 он

-Ш.Сүхбаатар. Төрийн тэргүүн шүүгч Гончигийн Иш. УБ 2017 он

-“Ардын эрх” сонин. 1992.02.10. №82/386/

# ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

*ШЯЯ - Шүүх явдлын яам*
*ДЯЯ - Дотоод явдлын яам*
*УБХ - Улсын Бага хурал*
*ДХГ - Дотоодыг хамгаалах газар*
*АИХ - Ардын Их хурал*
*МАХН - Монгол Ардын Хувьсгалт нам*
*НТХ - Намын Төв хороо*
*УТТ - Улс төрийн товчоо*
*СнЗ - Сайд нарын Зөвлөл*
*УАХГ - Улсыг Аюулаас хамгаалах газар*
*УАХЕГ - Улсыг Аюулаас хамгаалах Ерөнхий газар*
*УЦСЕГ - Улсын Цагдан сэргийлэх Ерөнхий газар*
*БНМАУ - Бүгд Найрамдах Монгол Ард Улс*
*УДШ - Улсын дээд шүүх*
*ЭБШХ - Эрүүгийн байцаан шийтгэх хууль*
*УЕПГ - Улсын Ерөнхий прокурорын газар*
*УЕП - Улсын Ерөнхий прокурор*
*УБТЗ - Улаанбаатар Төмөр зам*
*БЗД - Баянзүрх дүүрэг*
*СХД - Сонгинохайрхан дүүрэг*
*ХУД - Хан-уул дүүрэг*
*БГД - Баянгол дүүрэг*
*ЧД - Чингэлтэй дүүрэг*
*СБД - Сүхбаатар дүүрэг*
*ХЗЯ - Хууль зүйн яам*

# ГАРЧИГ


Мэндчилгээ 3
Өмнөтгөл 4
Прокуророос төрсөн алдартнууд 6
Прокурорын байгууллагаас төрсөн эрдэмтэд 8


## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: 1930-1939


1930 он 12
1931 он 15
1932 он 20
1933 он 24
1934 он 27
1935 он 30
1936 он 32
1937 он 34
1938 он 38
1939 он 42


## ХОЁРДУГААР БҮЛЭГ: 1940-1949


1940 он 48
1941 он 52
1942 он 54
1943 он 57
1944 он 60
1945 он 62
1946 он 68
1947 он 72
1948 он 76
1949 он 78

## ГУРАВДУГААР БҮЛЭГ: 1950-1959


1950 он 80
1951 он 83
1952 он 86
1953 он 88
1954 он 90
1955 он 92
1956 он 96
1957 он 98
1958 он 102
1959 он 104


## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: 1960-1969


1960 он 108
1961 он 112
1962 он 118
1963 он 122
1964 он 124
1965 он 126
1966 он 131
1967 он 136
1968 он 138
1969 он 139


## ТАВДУГААР БҮЛЭГ: 1970-1979


1970 он 144
1971 он 149
1972 он 153
1973 он 155
1974 он 158
1975 он 161
1976 он 163

1977 он 166
1978 он 170
1979 он 174

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ: 1980-1989

1980 он 180
1981 он 183
1982 он 185
1983 он 188
1984 он 192
1985 он 194
1986 он 197
1987 он 199
1988 он 202
1989 он 207

## ДОЛДУГААР БҮЛЭГ: 1990-1999

1990 он 212
1991 он 217
1992 он 220
1993 он 226
1994 он 232
1995 он 234
1996 он 237
1997 он 240
1998 он 242
1999 он 245

## НАЙМДУГААР БҮЛЭГ: 2000-2009


2000 он 250
2001 он 256
2002 он 260
2003 он 266
2004 он 271
2005 он 273
2006 он 279
2007 он 282
2008 он 285
2009 он 291


## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: 2010-2020


2010 он 296
2011 он 300
2012 он 303
2013 он 306
2014 он 312
2015 он 316
2016 он 323
2017 он 327
2018 он 334
2019 он 342
2020 он 355


## ХАВСРАЛТ БҮЛЭГ


Прокурорын байгууллагын ахмадын холбоо 364
Прокурорын байгууллагын эмэгтэйчүүд 366
Монгол Улсын прокурорын байгууллагын хамт олон 368
Миний амьдралын мартагдашгүй өдрүүд 377
Номзүй 379
Товчилсон үгсийн жагсаалт 380